
Дэлхийн Эдийн Засгийн Форум
Женев, Швейцарь 2005

Профессор Клаус Шваб
Дэлхийн Эдийн Засгийн Форум

Профессор Майкл Е. Портер
Харвардын Их Сургууль

Дэд захирлууд, Дэлхий дахины өрсөлдөх
чадварын тайлан

Августо Лопез-Карлос
Дэлхий дахины өрсөлдөх чадварын
тайлангийн редактор, Дэлхийн Эдийн
Засгийн Форум

Дэлхий дахины өрсөлдөх чадварын тайлан 2005-2006

Орчуулсан

Г. Батбаяр

Хянан тохиолдуулсан

Ц.Гомбосүрэн

Шинжээч □ □

Б. Сүвд □ □

МУИС-ийн ЭЗС-ийн профессор □ □

Б. Мөнхсоёл □ □

Нээлттэй Нийгэм Форумын менежер

DDC
377
Ш-33



НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

Хаяг: Жамьяан Гүний гудамж - 5/1, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар - 48, Монгол Улс

Утас: 976-11-313207

Факс: 976-11-324857

Вэб: www.forum.mn

Энэхүү номын монгол орчуулгыг Нээлттэй Нийгэм
Форумаас эрхлэн гаргасан ба монгол орчуулгын
зохиогчийн эрхийг Нээлттэй Нийгэм Форум эзэмшинэ.
© 2005

ISBN: 978-99929-56-02-X

Агуулга

Орчуулгын үг Нээлттэй Нийгэм Форум, ЭЗБШӨЧ төсөл	ii
---	----

Өмнөх үг Клаус Шваб	iii
------------------------	-----

Нэгдсэн хураангуй Августо Лопез-Карлос	vi
---	----

1-р бүлэг. Өрсөлдөх чадварын индексүүд 1

1.1 Эдийн засгийн өсөлтийг дэмжих бодлого, институциуд: Өрсөлдөх чадварын индексийн үр дүнгээс Августо Лопез-Кларос, Женнифер Бланке, Маргарета Дрзениек, Ирене Миа, Саадиа Захиди	3
---	---

1.2 Хөгжил дэвшлийн микро эдийн засгийн үндэс суурийг бий болгох нь: Бизнесийн өрсөлдөх чадварын индексээс олж мэдсэн зүйлс Майкл Е. Портер	49
--	----

2-р бүлэг. Өрсөлдөх чадварын тухай сонгож авсан асуудлууд 91

2.1 Засаглал, авилгал хоёрын тухай домог ба бодит байдал Даниел Кауфманн	93
---	----

2.2 Валютын ханшны өрсөлдөх чадварыг эргэн харахуй Кеннет Рогофф	117
---	-----

2.3 Байгаль орчин өрсөлдөөний нэг эх сурвалж болох нь Аллен Хаммонд	127
--	-----

3-р бүлэг. Тусгай сэдвүүд 137

3.1 Хөгжлийн асуудлаар зөвшилцөл байх ёстой юу? Жонн Уиллиамсон	139
--	-----

3.2 Бага орлоготой орнууд дахь насжилт: 2025 онд Николас Эберштадт	151
---	-----

3.3 Шинээр төрөн гарч буй зах зээлийн хямрал, түүний шийдлүүд: Арван жилийн туршлага Ноуриел Роубини, Брэд Сецер	171
--	-----

3.4 Даяаршил хөгжил цэцэглэлийн нэг арга болох нь Жагдиш Бхагвати	191
--	-----

4-р бүлэг. Сонгосон орнуудын өгөгдөл мэдээлэл 203

4.1 Бизнесийн удирдлагуудын санаа бодлын судалгаа: Улс орны өрсөлдөх чадварыг хэмжих зайлшгүй чухал хэрэгсэл болох нь Женнифер Бланке, Эмма Лоадес	205
---	-----

4.2 Сонгосон орнуудын мэдээлэл	219
--------------------------------	-----

4.3 Тоон үзүүлэлтийн хүснэгтүүд	261
Тоон үзүүлэлтийн хуудсыг хэрхэн ашиглах вэ?	263
Хүснэгтүүдийн индекс	265
Тоон үзүүлэлтүүд	267

Техникийн тайлбар ба эх сурвалжууд	330
------------------------------------	-----

Орчуулгын үг

НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ
ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ШИНЭТГЭЛ, ӨРСӨЛДӨХ ЧАДВАР ТӨСӨЛ

Дэлхийн Эдийн Засгийн Форумаас 2005 оны 10 дугаар сард хэвлэн гаргасан «Дэлхий Дахины Өрсөлдөх Чадварын Тайлан 2005-2006: Хөгжил Цэцэглэлтийг Бэхжүүлэх Бодлого»-ын зарим бүлгийг Монгол хэлнээ хөрвүүлэн танилцуулж буйдаа таатай байна.

АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн (АНУ-ын ОУХА) санхүүжилт бүхий Эдийн Засгийн Бодлогын Шинэтгэл, Өрсөлдөх Чадвар (ЭЗБШӨЧ) төсөл 2004 оны сүүлээр ДЭЗФ-ын Монгол Улс дахь Үндэсний Түнш байгууллагаар ажиллахаар болж, Монголын бизнесийн манлайлагчдын дунд судалгаа явуулсан юм. Энэ бүхний үр дүнд Монгол Улс ДЭЗФ-ын Өсөлтийн Өрсөлдөх Чадварын индексийн 2005-2006 оны жагсаалтад анх удаа багтсан бөгөөд Индекс т орсон нийт 117 орноос манай улс 96 дугаар байранд жагссан байна.

Энэхүү судалгааны Монголын талаарх үр дүнг ЭЗБШӨЧ, Нээлттэй Нийгэм Форум болон ДЭЗФ хамтран 2005 оны 10 дугаар сард олон нийтэд танилцуулсан бөгөөд 2006-2007 онд Форум дээрх байгууллагын Түнш байгууллагаар ажиллах болсныг мэдэгдсэн билээ. 2005-2006 оны өвөл Форум Хуман Фортис компанитай хамтран бизнесийн байгууллагын удирдлагуудаас Монгол Улсын өрсөлдөх чадварын талаарх санаа бодлыг нь тандах судалгааг явууллаа. Судалгааны үр дүн 2006 оны 10 дугаар сард гарах юм.

ДЭЗФ-аас эрхлэн гаргадаг Өсөлтийн өрсөлдөх чадварын индекс нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зэрэглэл бөгөөд Монгол Улсын өрсөлдөх чадварыг ижил төстэй улс орнуудтай харьцуулах боломж олгохын зэрэгцээ нэлээд хэдэн жилийн судалгааны үндсэн дээр тухайн улсын өрсөлдөх чадварын өсөлт, бууралт, тогтмол байдлын талаарх мэдээллийг бий болгох юм. Энэхүү жагсаалт нь Монголын хувьд өрсөлдөх чадвараа тодорхойлох, улмаар сайжруулахын тулд хийх өөрчлөлтийг хэрэгжүүлэх эхлэлийн цэг болон ашиглагдах учиртай.

Энэхүү тайлангийн талаарх мэдээллийг Монгол хэл дээр танилцуулах бололцоо олгож орчуулан хэвлэх эрхээр хангасан ДЭЗФ болон тайланг хэвлэсэн Макмиллан Паблшерс компанид Форум болон ЭЗБШӨЧ талархал

илэрхийлж байна. Дэлхий дахины өрсөлдөх чадварын тайлангийн сонгогдсон бүлгүүдийг анх удаа Монгол уншигчдад толилуулснаар бодлого боловсруулагчид болон сонирхсон хүмүүст өрсөлдөх чадварын талаарх баялаг мэдээллийг өгч, түүнийг хэмжих нарийн ялгаа, утга болон өрсөлдөх чадварыг улам бэхжүүлэх бодлогыг ойлгож мэдэх өргөн боломжийг олгож байна.

Энэ ном нь бизнесийн байгууллагын удирдлагууд болон Засгийн газрын бодлого боловсруулагчдад Монгол Улсын өрсөлдөх чадварыг сайжруулах, улмаар цаашид хийх бодлогын өөрчлөлтийн талаар нээлттэй ярилцлага, хамтын ажиллагааг амжилттай өрнүүлэхэд тус нэмэр болно гэдэгт бид гүнээ найдаж байна.

Өмнөх үг

КЛАУС ШВАБ

Гүйцэтгэх захирал, Дэлхийн Эдийн Засгийн Форум

Энэ жилийн *Дэлхий дахины өрсөлдөх чадварын тайланг* нийтэлсэн нь Олон улсын хамтын нийгэмлэгт тулгарч буй эдийн засгийн гол гол асуудлын заримыг нягтлан үзэх боломжийг олгож байна. 2005 онд дэлхийн эдийн засаг 4.25 орчим хувиар өсөх төлөвтэй байгаа нь дэлхийн худалдааны цар хүрээ түргэн хурдацтайгаар тэлж буй сүүлийн арван жилийн хугацаанд дэлхийн нийт бүтээгдэхүүн хамгийн өндөр өсөлттэй гарсан 2004 оны дүнгээс бараг нэг хувиар доогуур байна. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, дэлхийн нийт худалдааны өсөлт удааширч байгаа болон газрын тосны үнийн өсөлтийн сөрөг нөлөөг үл харгалзан ойрын төлөв байдлаас харахад наанадаж 2006 оны төгсгөл хүртэл баттай өсөлт гарах нь харагдаж байна.

Гэвч газрын тосны зах зээлд гарч буй өөрчлөлтүүд энэхүү харьцангуй таатай дүр зурагт эрсдэл учруулсаар байгаагийн зэрэгцээ иймэрхүү санаа зовоосон бусад зүйлс ч их байна. Эдгээрийн зарим нь тухайлбал, дэлхий нийтийн хэмжээний ихээхэн тэнцвэргүй харьцаа хэвээр оршсоор байгаа нь системийн чанартай эрсдэл учруулж байна. Тэдгээрийн болзошгүй үр нөлөөг үнэлэхэд хэцүү боловч хэрвээ хайхралгүй орхих юм бол дэлхий дахины ирээдүйн хөгжил цэцэглэлтэд аюул занал учруулах боломжтой гэдгийг хаа сайгүй хүлээн зөвшөөрч байгаа нь харагдаж байна. Бусад эрсдлийн хувьд арай явцуу хүрээнд тодорхойлогдож байгаа хэдий ч улам бүр нэгдэн нягтарч байгаа өнөөгийн дэлхий ертөнц дээр «дотоодын» ба «дэлхий нийтийн» асуудлуудын зааг ялгаа улам бүдгэрсээр байгаа билээ. Бид дэлхийн эдийн засгийн эерэг төлөв байдлыг муутган харуулахад «хэтэрхий жижигдэнэ» хэмээн эдгээр асуудлын заримыг орхигдуулж болохгүй. Ийм асуудлын нэг тод жишээ бол өргөн хүрээнд газар авч буй ядуурал ба түүний үр дагаварууд юм.

2004 онд АНУ-ын урсгал дансны алдагдал ДНБ-ний 6 орчим хувьтай тэнцэхүйц хэмжээтэй гарснаар тус улсын эдийн засгийн тогтвортой байдлын талаар болон улмаар валютын ханш, худалдаа, мөн төсвийн зохицуулалт хийснээр ирээдүйд үүрэх ачааллын тархалтад ямар нөлөө үзүүлэх талаар улам их яригдах болжээ. АНУ

дахь төсвийн бодлогыг чангатгах, Хятадын банкны системд хийгдэх томоохон шинэчлэлийн тусламжтайгаар Ази дахь валютын ханшийг илүү уян хатан болгох, Европ, Японд урт удаан хугацаанд уламжлал болж тогтсон хатуу чанд байдал, бүтцийн үр ашиг муутай байдлыг арилгах зэрэг арга хэмжээг ямар нэг байдлаар хослуулах нь уг асуудлыг шийдэх шийдлийн нэг хэсэг байх болно гэж зарим хүмүүс үзэж байна.

Дэлхийн худалдааны тогтолцооны хувьд дэлхий нийтийн хэмжээнд үүсээд байгаа худалдааны тэнцвэргүй байдлаас уршиглаж болзошгүй үр дагаврын талаар бид онцгой их санаа зовж байна. Баян, аж үйлдвэржсэн орнуудад өсөн нэмэгдэж буй хувиа хичээсэн протекционист үзэл хар толгойгоо хэдийнээ өндийлгөжээ. Өнгөрсөн хагас зуун жилийн турш эдийн засгийн өсөлтийн гол хөдөлгөгч хүчнүүдийн нэг нь олон улсын худалдааны өсөлт байсаар ирсэн бөгөөд хэрвээ протекционист үзэл даамжирвал дэлхийн эдийн засгийн хувьд сайн сайхан байдлаа томоор алдана гэсэн үг.

Эхний нэг тоогүй явдал бол худалдааны либералчлалын талаарх Дохагийн шатны яриа хэлэлцээ амжилттай дуусч чадахгүй сунжирсаар байгаа явдал юм. Энэ явдал нь аж үйлдвэржсэн орнуудын зүгээс Африкт үзүүлэх тусламжийнхаа цар хүрээг өргөжүүлэхээр хүчин чармайлтаа нэмэгдүүлж байгаатай давхцаж байна. Харин хөгжиж байгаа орнууд дахь ядууралтай тэмцэх хамгийн үр нөлөөтэй арга зам бол баян орнуудын зах зээлийг нээх, ялангуяа тэднийг бага орлоготой орнуудын хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспортод нээлттэй болгох явдал мөн гэдгийг өргөнөөр хүлээн зөвшөөрч байна. Жил тутам ойролцоогоор 300 тэрбум ам.долларын хэмжээнд хүрдэг ЭЗХАХБ-ын хөдөө аж ахуйн татаас нь тэдний үзэж байгаачлан «ирээдүйд чиглэсэн бодлого» биш төдийгүй ийм их хэмжээний хөрөнгө шилждэг орнуудын эдийн засгийн хүчин чадлынх нь нэг эх үүсвэр ч биш юм. Тэдгээр нь зах зээл болон олон улсын худалдааны өрсөлдөөнийг гажуудуулж, үнэн хэрэгтээ тэдний фермерүүдэд өгч буй нэг доллар тутмын дөнгөж 25 цент нь фермерүүдийн халаасанд орж байна. Тэдний бодлогоор явагдаж буй хэт их үйлдвэрлэл

нь хөдөө аж ахуйн зориулалттай газар нутаг, онгон байгалийн чанарт ноцтой сөрөг үр дагавар авчирч байгаагийн зэрэгцээ түүнээс ч дор зүйл нь тэдний гаргасан илүүдэл бүтээгдэхүүн хөгжиж байгаа орнуудын экспортлодог хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийг хямруулж байгаа явдал юм. Дохагийн яриа хэлэлцээг нураахгүй байх онцгой үүрэг хариуцлага АНУ, Япон, ЕХ болон Норвеги, Швейцарь зэрэг ЕХ-ны гишүүн бус орнуудад ноогдож байна

Хөдөө аж ахуйг санхүүжүүлэх илүү оновчтой систем буюу дэлхий нийтийн сайн сайхан байдалд хор хөнөөл багатай системд шилжих явдал бол өнөөдөр Европын улсуудын засгийн газарт тулгарч буй олон сорилтуудын зөвхөн нэг нь юм. ЕХ ч чухал шийдвэрлэх замын уулзвар дээр ирээд байна. Сүүлийн хэдэн арван жилийн турш эдийн засгийн интеграцилалын чиглэлд хийсэн сэтгэл хөдлөм алхамууд асар их амжилт олсон гэдэгт эргэлзэх зүйл бага билээ: Дэлхий дээр нэг хүнд ноогдох орлогоороо хамгийн өндөрт ордог 20 орны 12 нь ЕХ-ны гишүүн орнууд байна. Цаашилбал, өнгөрсөн жил 10 шинэ гишүүн нэгдэн орсон нь гайхалтай ололт бөгөөд хөгжлийн өөр өөр шатанд яваа улс үндэстнүүдийн эдийн засгийг ижилсүүлэх үүднээс хоршсон, институцижсэн бүтцийг бий болгоход шинэ сонин арга зам боллоо. Харин, ЕХ-ны түүхийг зохих ёсоор уншиж үзвэл ололт амжилтууд дагасан хямралууд, ухралтаар тэнцвэржсэн дэвшлүүд гарсан онцлог байдал харагдаж байна. Ийм ухралтуудын нэг бол саяхан Франц, Нидерландад явуулсан бүх нийтийн санал асуулгаар Европын Үндсэн хууль хэрэглэхээс татгалзсан явдал юм. Эхэндээ энэ нь интеграцийн механизмыг бэхжүүлэх тухай Европын төслийг ард олон, наанадаж ЕХ-г үндэслэгч эдгээр хоёр оронд дэмжиж байгаа эсэхэд эргэлзсэн асуултууд төрөхөд хүргэж байв. Гэвч энэ байдал аажмаар өөрчлөгдөж, ирээдүйн өөрчлөлтийн чиг хандлага ямар байх вэ, Европт эдийн засгийн шинэчлэлийн тэргүүлэх чиглэлүүд ямар байх ёстой вэ, Хятад, Энэтхэг болон шинээр төрөн гарч буй бусад зах зээл огцом хүчээ авч байгаагаас үүдсэн өрсөлдөөний сорилтуудыг ЕХ-ны гишүүн орнууд хэрхэн сөрөх вэ зэрэг амьд мэтгэлцээнээр солигдсон билээ. Энэ мэтгэлцээн нилээд хугацаа хожигдсон ч, мөн чанарын хувьд суурь ач холбогдолтой төдийгүй бүтээлч өөрчлөлтийн хүчирхэг хурдасгуур мөн гэдгийг бид мэдэрч байна.

Бодлого боловсруулагчид одоогоор эдгээр дэлхий нийтийн эрсдлүүдийг ухаалгаар удирдах арга замыг эрж олохын төлөө тэмцэхийн зэрэгцээ улам нарийн түвэгтэй болж буй эдийн засгийн орчин нөхцөлд эдийн засгаа

сайн ажиллуулах бэлтгэлийг хангасаар байна. Дэлхийн Эдийн Засгийн Форум байгууллагаас дэлхийн улс орнуудын эдийн засгийн нөхцөл байдлын нарийвчилсан үнэлгээг гаргах замаар энэхүү үйл явцад тус нэмэр болох үүргийг олон жил гүйцэтгэж ирлээ. *Дэлхий дахины өрсөлдөх чадварын тайлан* бол эдийн засгийн өсөлт ба хөгжил цэцэглэлтийн гол бүтэц бүрэлдэхүүний талаарх бидний ойлголтыг дээшлүүлэхэд чиглэсэн нэг хувь нэмэр мөн. Энэ нь аливаа эдийн засгийн хүчтэй ба сул талуудыг тодруулж өгснөөрөө эдийн засгийн бодлого ба институцийн шинэчлэлийг сайжруулан томъёолоход тус дөхөм болохуйц нэг чухал арга хэрэгслийг бодлого боловсруулагчид, бизнесийн тэргүүлэх зүтгэлтнүүдэд санал болгож байгаа юм.

Энэ оны эхээр уг чуулга уулзалтын Дэлхий Дахины Өрсөлдөх Чадварын Хөтөлбөрөөс холбогдох бүс нутгийн өрсөлдөх чадварын цуврал тайлангуудынхаа нэг хэсэг болгож хоёр дахь *Арабын Ертөнцийн Өрсөлдөх Чадварын Тайлан*-гаа хэвлэн гаргаснаар тус бүс нутагт тулгарч буй эдийн засгийн гол хүндрэл бэрхшээл, сорилтуудыг тогтоосон байна. Энэхүү Тайлан болон түүнийг гарсантай холбогдуулан хийсэн олон тооны семинарын нөлөөгөөр Арабын Бизнесийн Зөвлөлийн гишүүд санаачлан, холбогдох засгийн газрууд ба иргэний нийгмийн байгууллагуудтай хамтарч тус бүс нутгийн эдийн засгийн шинэчлэлийн үйл явцыг хурдасгах хурдасгуур болон ажиллах зорилготой Үндэсний Өрсөлдөх Чадварын Зөвлөлүүдийг олон оронд байгуулаад байна. Эрт, орой хэзээ нэгэн цагт дэлхийн өөр хаа нэгтээ ижил төрлийн байгууллагууд бий болоход эдгээр зөвлөлүүд ихээхэн урам зориг өгч болох юм.

Хөгжиж буй орнуудад чадавхийг бэхжүүлэх ач холбогдлын үүднээс бид дэлхийн хэмжээгээр тайланд хамрагдах орнуудынхаа тоог өргөжүүлж, түрүү жил 104 орныг хамруулж байсан бол энэ жилийн Дэлхий дахины өрсөлдөх чадварын тайлан-д 117 орныг хамруулаа. Африк тивээс илүү олон орныг хамруулах талаар онцгой анхаарсан бөгөөд түүнчлэн Төв Азийн бүс нутгийн ач холбогдол дэлхийн тавцанд нэмэгдэж байгааг харгалзан уг бүсээс хэд хэдэн орныг хамруулж байна. Дэлхийн эдийн засгийн ерөнхий дүр зургийг аль болох хамгийн өндөр нарийвчлалтайгаар зураглан харуулж байгаагаар илтгэх үүднээс бид ирэх жилүүдэд ч газар зүйн хувьд хамрах хүрээгээ үргэлжлүүлэн тэлэх болно.

Энэхүү *Дэлхий Дахины Өрсөлдөх Чадварын Тайлан*-г олон тооны хамтран зүтгэгч нарынхаа дэмжлэггүйгээр эмхлэн гаргаж чадахгүй байх байлаа. Харвардын бизнесийн сургуулийн

Стратеги ба өрсөлдөх чадварын хүрээлэнгийн захирал, профессор Майкл Е. Портерт бид талархаж байна, түүнчлэн бидэнтэй мэдлэг, туршлагаа хуваалцаж, энэ жилийн Тайланд хувь нэмрээ оруулсан нэрт зохиогч, эрдэмтэд та бүхэнд бид талархлаа илэрхийлж байна. Мөн тус Форумын ерөнхий эдийн засагч, Дэлхий дахины өрсөлдөх чадварын хөтөлбөрийн захирал Августо Лопез-Кларос, түүний багийн гишүүд Женнифер Бланкэ, Симоне Дроз, Маргарета Дрзениек, Керри Жэгги, Эмма Лоадес, Ирене Миа, Саадиа Захиди нарт талархал илэрхийлье. Энэхүү чухал үйл ажиллагаанд үнэлж баршгүй дэмжлэг үзүүлж энэхүү Тайланг гаргахад бидэнтэй түншилж ажилласан FedEx, Gallup International, USAID зэрэг байгууллагад баярлалаа. Мөн түүнчлэн манай Бизнесийн удирдлагуудын санаа бодлын судалгаанд оролцох цаг зав гаргасан дэлхийн эргэн тойронд буй бүх бизнесийн удирдах хүмүүст чин сэтгэлийн талархал илэрхийлж байгаагаа үүгээр уламжилж байна. Та бүхний оруулсан чухал хувь нэмэргүйгээр энэхүү Тайланг бэлтгэх боломжгүй байх байсан.

Нэгдсэн хураангуй

АВГУСТО ЛОПЕЗ-КАРЛОС, Дэлхийн Эдийн Засгийн Форум

Дэлхийн Эдийн Засгийн Форумгаас гаргасан өрсөлдөх чадварын тухай тодорхойлолт нь валютын ханшны өрсөлдөх чадварын тухай төсөөллөөс халин уг ойлголтыг бүтээмжтэй холбодог болжээ. Иймээс өрсөлдөх чадвар гэдэг бол аливаа улсын бүтээмжийн түвшинг, улмаар аливаа эдийн засгийн хүрч болох хөгжил цэцэглэлтийн түвшинг тодорхойлдог хүчин зүйлс, бодлогууд, институциудийн нэгдмэл цогц гэж тодорхойлж байна. Гэхдээ бүтээмж бол бас хөрөнгө оруулалтын өгөөжийн хувийн нэг гол хөтлөгч төдийгүй тухайн эдийн засгийн нийт өсөлтийн хувийг тодорхойлдог билээ. Иймд илүү өрсөлдөх чадвартай эдийн засаг дундаас урт хугацаанд илүү хурдан өсөх магадлалтай байдаг.

Өрсөлдөх чадварын чиглэлээр Дэлхийн Эдийн Засгийн Форумгаас хийж буй ажлын нилээд нь 100 гаруй улсын эдийн засаг дахь эрс ялгаатай өсөлтийн туршлагауудыг тодорхойлж буй цаад хүчин зүйлс, бодлогууд, институциудийг онцлон авч үзэхэд чиглэгдэж байна. Сүүлийн тавь гаруй жилийн турш, тухайлбал Аргентин, Гана болон Тайваны нэг хүнд ноогдох орлогын хувьсал хөгжил ялгаатай байгааг юугаар тайлбарлах вэ?

Магадгүй, харьцуулсан хөгжлийн чиглэлд цөөн хэдэн асуулт илүү хамаатай байдаг биз. Энэ чиглэлд тус Форумын хийж буй ажлаас наанадаж гурван гол зүйл ажиглагддаг: Нэгдүгээрт, чухал ач холбогдолтой хүчин зүйлс асар олон бөгөөд өргөн хүрээтэй байдаг. Мэдээж макро эдийн засгийн орчны чанарын асуудал шийдвэрлэх ач холбогдолтой: тогтвортой өсөлттэй боловч төрийн мөнгө *санхүүг буруугаар удирдаж* байгаа эсвэл алдаатай буюу зохисгүй валютын ханшны бодлого баримталж байгаа хэдэн орныг бид нэрлэж чадах вэ?

Гэтэл макроэдийн засгийн хянамгай удирдлага гэдэг бол зөвхөн улсын салбарын санаа зовох асуудал биш. Түүнчлэн хэн нэг нь заавал асуух ёстой асуултууд ч байдаг: Засгийн газар хувийн салбартай харилцахдаа хол хөндий зай барьж харьцаж байна уу эсвэл ойр дотно нөхөрсөгөөр харьцаж байна уу? Шүүхийн тогтолцоо шударга байж маргааныг үндэслэлтэй, шуурхай, ил тод, бага зардлаар шийдвэрлэж байна уу эсвэл тэнд хууль ёсыг худалдаж байна уу? Татварын орлогыг хүний нөөц, дэд бүтцийн бүтээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтад зарцуулах замаар эдийн засгийг буцаан сэлбэж байна уу, эсвэл хөрөнгийг үр ашиггүй төслүүдэд зарцуулж байна уу, эсвэл бүр түүнээс дор байдлаар ашиглан шамшигдуулж байна уу? Шаардлагагүй хүнд суртлын давхаргууд, хэрэгцээгүй олон дүрэм журмаас бүрдсэн зохицуулалтын орчин өрсөлдөх чадварыг бууруулж, ажил, гүйлгээ болон үйл

ажиллагааны өртөг зардлыг нэмэгдүүлж байна уу? Технологийн шинэ бүтээл, санаачилгуудыг хэр үр ашигтай авч ашиглаж байна вэ, тухайн улсын боловсролын тогтолцоог тогтмол шинэчлэн сайжруулах талаар анхаарал тавьж байна уу? Тухайн орон гадаад ертөнцтэй нээлттэй, өөртөө итгэлтэй байдлаар харьцаж байна уу, аль эсвэл айдас түгшүүртэй, эргэлзсэн байдлаар хандаж байна уу? Өмчийн эрх ба холбогдох институциудийн үүрэг роль ямар вэ?

Эдгээр асуултад өгөх хариулт улс орон бүрт харилцан адилгүй байхын зэрэгцээ тухайн эдийн засаг урьдчилан төсөөлөгдөхүйц, тогтвортой байдлаар өсч байгаа (жишээ нь, Тайвань), чадамжаа бүрэн ашиглаж чадахгүй байгаа (жишээ нь, Аргентин), эсвэл тогтворгүй байгаа бөгөөд үнэн хэрэгтээ нэг хүнд ноогдох орлого нь буурч байгаа (жишээ нь, Гана) эсэх талаар чухал утга агуулсан байна гэдэгт гайхах зүйлгүй.

Хоёрдугаарт, эдгээр хүчин зүйлс тухайн улсын хөгжлийн үе шатаас хамаарч харилцан адилгүй хэмжээнд асуудал үүсгэдэг. Финляндад төрийн санхүүгийн удирдлагын асуудал Энэтхэг, Турктэй харьцуулвал санаа бага зовоодог, учир нь дээрх хоёр орон бол төсвийн сахилга батгүй байдлын урт удаан жилийн түүхтэй улсууд юм. Нэг талаас, Европын олонтомоохон орныг ичээхэд хүргэж буй зүйл бол Финлянд улс одоогоор ирээдүйн тэтгэвэр тэтгэмжийн өр төлбөрийг барагдуулах хөрөнгө санхүүгийн илүүдэлтэйгээр хүн амын насжилттай тулгарч байгаа явдал юм. Нөгөө талаас, Энэтхэг, Турк хоёр улс төсвийн алдагдалтай ажиллаж байна. Гэхдээ Турк улс их хэмжээний улсын өр үүсч хуримтлагдахад хүргээд байсан төсвийн хариуцлагагүй бодлогоо орхих тал дээр сүүлийн үед гайхалтай дэвшил гаргаад байгааг энд дурдах ёстой. Финляндад тус улсын ирээдүйн өсөлтийн хэтийн төлөвд туйлын чухал голлох үүрэгтэй зүйл бол технологийн шинэчлэлийн хурдац байдаг. Нокиа компани Азийн өрсөлдөгч нараасаа технологийн хувьд давуу байдлаа хадгалж чадах эсэх нь инфляци бага зэрэг өсөх эсэхээс хамаагүй чухлаар Финландын нэг хүнд ноогдох орлогын ирээдүйн өсөлт хөгжлийг тодорхойлж байдаг.

Гуравдугаарт, эдгээр хүчин зүйлсийн ач холбогдол цаг хугацааны турш өөрчлөгдсөөр байгаа нь даяаршлын хүчний нөлөөгөөр улам бүр нэмэгдэж буй нэг чиг хандлага юм. Дэлхий дахины хэмжээгээр инфляци буурах хандлагатай байж дайны дараахь үеийн хамгийн доод түвшинд хүрээд байгаа нь АНУ-ын инфляци хоёр оронтой тоогоор хэмжигдэж байсан 1970, 80-аад оны үеийнх шиг тийм их санаа зовоосон зүйл биш болжээ. Гэвч капиталын шилжилт хөдөлгөөн ихсэж, санхүүгийн зах зээлүүд ороо

бусгаа байгаагаас улсынхаа мөнгө санхүүг сайн удирддаггүй улсуудын хувьд 2001 оны сүүлээр Аргентинд гарсан шиг эрсдэлтэй байдал нэмэгдэж байна. Сүүлийн жилүүдэд боловсрол, мэргэжлийн ур чадвар олж авах явдал, ажиллах хүчний сургалтын түвшин улам бүр чухлаар тавигдаж байна. Тээвэр, харилцаа холбооны зардал огцом буурснаар дэлхийн томоохон корпорациудын хувьд ур чадвар, ажиллах хүчний өртөг багатай байдлыг хослуулж, улс төр, нийгмийн тогтвортой байдалтай зөв уялдуулах боломжтой газрууд руу үйлдвэрлэлээ шилжүүлэхэд хялбар болоод байна. Энэ явдлыг сүүлийн арван жилд эдийн засаг нь Европын бусад хэсгийн дунджаас хоёр дахин илүү хурдтай өсч буй Төв болон Зүүн Европын улсуудын жишээ нотлон харуулж байна.

Өсөлтийн өрсөлдөх чадварын индекс

Дэлхийн Эдийн Засгийн Форумас үндэсний өрсөлдөх чадварыг хэмжиж Өрсөлдөх Чадварын *Тайлангууд* гаргаж эхэлснээс хойш хорь гаруй жил өнгөрөөд байна. Эдгээр он жилүүдэд бид аливаа улс орны иргэддээ хөгжил цэцэглэлтийг хангалттай өгч, дээшлүүлэх чадварт шийдвэрлэх үүрэгтэй тэрхүү бүтээмжийг чухам ямар хүчин зүйлс хөтөлж байгаа талаарх хамгийн сүүлийн үеийн үзэл бодлыг өөрсдийн хэрэглэх арга зүйдээ харгалзан үзэж байсан учраас өрсөлдөх чадварыг хэмжихэд ашиглаж байгаа тодорхой арга зүйн хувьд гарцаагүй хувьсан хөгжиж байв. 2001 оноос хойш манай арга зүй Дэлхийн Эдийн Засгийн Форумд зориулан Жеффрий Сакс, Жон МакАртур нарын боловсруулсан Өсөлтийн Өрсөлдөх Чадварын Индекс (ӨӨЧИ буюу GCI) хэмээх загварт тулгуурлаж байна.

ӨӨЧИ нь өрсөлдөх чадварыг хэмжих тоон хүрээг гаргах зорилготой хэд хэдэн нэмэлт ойлголтыг нэгтгэдэг. Энэ загварт аливаа орны өсөлтийн хувьсал хөгжлийг тайлбарлахад орох янз бүрийн хүчин зүйлсийг томъёолохдоо «гурван тулгуур» тогтоодог. Үүнд, *макро эдийн засгийн орчны чанар, тухайн улсын төрийн байгууллагуудын байдал*, мөн технологи ба шинийг санаачлахын ач холбогдлыг харгалзан *технологийн бэлэн байдлын түвшин* гэсэн гурван үзүүлэлтэд тулгуурлаж байна. ӨӨЧИ-д их, дээд сургуульд хамрагдалтын хувь, инфляцийн дүн, төрийн санхүүгийн байдал, хөдөлгөөнт холбоо, интернэт гэх мэтийн шинэ технологи нэвтрэлтийн түвшин зэрэг тогтсон тоон үзүүлэлтийг Дэлхийн Эдийн Засгийн Форумын Бизнесийн удирдлагын санаа бодлын судалгаагаар авсан тоон мэдээлэлтэй хослуулан ашиглаж байна. Энэхүү санал асуулгаар авсан тоон мэдээлэл нь голдуу тогтсон тоон үзүүлэлт

байдаггүй боловч эдийн засгийн өсөлтийг бий болгогч хүчин зүйлсийг зохих ёсоор ойлгоход гол үүрэгтэй зарим ойлголтыг олж мэдэхэд тусалдаг. Ийм ойлголтын жишээнд шүүхийн хараат бус байдал, институцичлэгдсэн авилгалын тархалт, эдийн засаг дахь төрийн үр ашиггүй оролцооны цар хүрээ гэх мэтийг оруулж болох юм.

Эдгээр янз бүрийн жижиг хэсгүүдийг өөр өөр дэд индексүүдэд нэгтгэн оруулсан бөгөөд дор бүрнээ өсөлтийн үйл явцын өөр өөр талыг (тухайлбал, гэрээ, эрх зүйн ач холбогдол, макро эдийн засгийн орчны тогтвортой байдал гэх мэт) харуулахын зэрэгцээ тэдгээрийг өрсөлдөх чадварын нийт «оноо»-нд нэгтгэн оруулдаг. Сакс, МакАртур нарын нэвтрүүлсэн хоёр дахь ойлголт бол технологийн асуудал ихээхэн нөлөөтэй ч тухайн орны хөгжлийн үе шатаас хамаарч улс орон бүрт харилцан адилгүй байдаг гэсэн үзэл санаа юм. Швейцарьд шинийг санаачлах асуудал гол байдаг бол гадаадаас технологи авч хэрэглэх, технологи шилжүүлэх асуудал Чилид харьцангуй чухал байж болно. Энэхүү ялгаа нь энэ хоёр улсыг хоёр тусдаа ангилалд ороход хүргэдэг бөгөөд тухайн улсад сүүлийн жилд бүртгэгдсэн нэг хүнд ноогдох АНУ-ын хэрэглээний патентын (шинэ бүтээлийн патент) тоонд нь тулгуурлан үндсэн шинийг санаачлагч ба үндсэн бус шинийг санаачлагч гэж нэрлэдэг. Хүснэгт 1-д буй үндсэн шинийг санаачлагчдын жагсаалтаас үзэхэд 2004 онд бүгдээрээ сая хүн ам тутамд дор хаяж 15 патент эзэмшиж байсан байна. Гурав дахь ойлголт бол аливаа улс үндэстний өрсөлдөх чадварыг тайлбарлаж буй хүчин зүйлс ач холбогдлын хувьд эдгээр хоёр ангиллын орнуудад харилцан адилгүй байдаг гэсэн үзэл санаа юм. Ийм учраас, макро эдийн засгийн тогтвортой байдал Туркт Шведийнхээс илүү чухал хүчин зүйл байх талтай. Энэхүү индексийг зохиоход ашигласан цаад жинхэнэ арга зүйг Бүлэг 1.1-д тодорхой дүрсэлсэн байгаа.

2005 оны өрсөлдөх чадварын зэрэглэл

Энэ жилийн ӨӨЧИ-ийн зэрэглэлийг Хүснэгт 1-д үзүүлэв. Финлянд улс уг зэрэглэлд тэргүүлэх байр сууриа хадгалсан хэвээр байна. Тус улс дэлхий дээр хамгийн шинийг санаачлагч бизнесийн орчны нэг гэдгээ хүчтэй харуулсан нь хөгжлийн дээд түвшинд явж байгаа энэ улсын хувьд бүтээмжийг дээшлүүлэхэд онцгой ач холбогдолтой юм. Энэ нь тус улсын макро эдийн засгийн маш эрүүл орчинтой хосолсон байдаг бол бусад олон аж үйлдвэржсэн орон энэ чиглэлээр тэмцээр байгаа билээ. Финландын засгийн газар төсвийн илүүдэлтэй ажиллаж, улмаар тус улсын

хүн амын насжилттай холбоотойгоор ирээдүйд хүлээх үүргээ биелүүлэх чадвартай байхыг зорьж байгаа нь бүр ч сэтгэл хөдлөм байна. Макро эдийн засгийн бодлогын энэхүү хандлага нь Финландын нийгэм дэх улс төрийн төлөвшилтийн түвшин бусадтай өрсөлдөхүйц хэмжээнд байгааг тод томруун харуулж байна. Цаашилбал, Финлянд улс дэлхийн хамгийн сайны нэгд тооцогдох институцийн орчинтой: тус улсын бизнесийн салбарынхан хуулиа дээдлэх уур амьсгалд үйл ажиллагаа явуулдаг, авилгал ер бусын доогуур түвшинд байдаг, нээлттэй, ил тод байдал хөгжсөн зэрэг нь бусад орон сайтар судалвал зохих үлгэр жишээ юм.

АНУ энэ зэрэглэлийн хоёрдугаарт орсон хүчирхэг амжилт нь тус улсын технологийн хувьд үргэлжлүүлэн ноёрхож буй байдал болон шинийг санаачлагчийн хувьд хэнийг ч урдаа гаргаагүй байдалтай нь холбоотой. Шинэ технологи авч хэрэглэхдээ идэвхтэй бөгөөд судалгаа, хөгжлийн ажилд ихээхэн хөрөнгө зарцуулдаг компаниуд АНУ-д бий. Гэвч тус улсын технологийн хувьд эрч хүчтэй байдлыг уг индексээр хэмждэг бусад чиглэлүүдэд, тухайлбал макро эдийн засгийн орчны тодорхой асуудлуудаар, тааруу үр дүн үзүүлсэн явдал хойш татсан байна. Энэ бол тухайн улсын макро эдийн засгийн тэнцвэргүй байдалд, ялангуяа төрийн мөнгө санхүүгийн чиглэлд тавих олон улсын анхаарал эрчимжиж байгаа өнөөгийн нөхцөлд гайхаад байх зүйл биш юм.

Сүүлийн жилүүдэд байгаа янзаараа Нордикийн бусад орон өрсөлдөх чадварын зэрэглэлд сайн хэвээр явна. Финлянд, АНУ хоёрын дараахь 3, 4 дүгээр байранд Швед, Дани хоёр тус тус дараалан орж байна. Тэдний араас Исланд, Норвеги улсууд 7, 9 дүгээр байранд тус тус ойрхон дагаж байгаа нь мөн л эхний аравт багтсан үзүүлэлт юм. Эдгээр орныг өрсөлдөх чадвар туйлын өндөртэй болгож буй хэд хэдэн нийтлэг онцлог чанар байдгийн дотор макро эдийн засгийн маш эрүүл саруул орчин, мөн ихээхэн ил тод, үр ашигтай төрийн институциуд ордог. Эдгээр орныг дэлхийн зах зээл дээр үр нөлөөтэй өрсөлдөхөд болон хүн амдаа дэлхийн хамгийн өндөрт орох амьжиргааны түвшний стандартад үйлчлэхэд нь тухайн орны харьцангуй өндөр татварын хувь саад болж байна гэдгийг нотлох баримт гараагүй байна.

Ерөнхий зэрэглэлийн хувьд Их Британи (13-рт), Герман (15-рт) улсууд харьцангуй нэр хүндтэй дээгүүр байр эзэлсэн хэвээр байна. Хоёр орон хоёулаа дэлхийн түвшинд хүрсэн төрийн институцидтэй хэдий ч Германы бизнесийн хамтын нийгэмлэгийнхэн тус улс өмчийн эрхийн орчин ба шүүхийн тогтолцооны үйл ажиллагаагаараа дэлхий дээр хэнийг ч

дагуулахгүй гэж үздэг байна. Нэн ялангуяа, энэ хоёр орон хоёулаа судалгаа, хөгжлийн ажилд зарцуулдаг хөрөнгө, эрдэм шинжилгээний болон бизнесийн байгууллагуудын хамтын ажиллагаа гэх мэт үзүүлэлтүүд, түүнчлэн янз бүрийн шинэ технологи ашиглалтыг харуулсан өргөн хүрээтэй үзүүлэлтээрээ өндөр оноо авсан байна. Герман улсын хувьд тус улсын бизнесийн салбарынхан богино хугацааны эдийн засгийн өсөлтийн төлвийн талаар гутранги бус үзэлтэй, улсын салбарын төсвийн алдагдал ихгүй байсан бол ӨӨЧИ-ийн ерөнхий дүнгээрээ арай дээгүүр байрт орохоор байв. Итали улсын (47-рт) үзүүлсэн амжилтыг Бүлэг 1.1-ийн тусгай хэсэгт дэлгэрэнгүй задлан шинжилсэн байгаа.

Саяхан ЕХ-д элссэн 10 орны дундаас Эстони улс бусдыгаа тэргүүлж 20 дугаар байрт орсон нь ЕХ-ны анхдагч 15 гишүүн хэд хэдэн чинээлэг орны урд орсон байна. Эстоний энэ байр бол 15 жил хүрэхгүй хугацаанд төвлөрсөн төлөвлөгөөний үр ашиггүй байдал, чадварлаг эдийн засагтай байдал хоёрын хоорондох ангальг туулж чадсан сэтгэл хөдлөм амжилт юм. Польш улс ЕХ-д шинээр элссэн орнуудаас сүүл мушгисан хэвээр байна. Гэхдээ сайн талаас нь тэмдэглэхэд, Польшийн байдалд зарим мэдэгдэхүйц дэвшил гарсан бөгөөд 2004 оныхоос 9 байраар урагшилж 51-т орсон байна. Энэ нь ЕХ-д шинээр элссэн олон оронд гарч буй чиг хандлагатай нийцэж байгаа бөгөөд эдгээр оронд өнгөрсөн жилийн өрсөлдөх чадварын түвшнээс илүү ахиц гарсан нь ихэвчлэн ЕХ-нд гишүүнээр элссэнээр хүртэж буй үр өгөөж болон тухайн засгийн газарт өгч байгаа эдийн засгийн шинэчлэлийн чиглэлд идэвхтэй байр суурь баримтлах урам зоригтой холбоотой байж болох юм.

Улс орнууд нь голдуу ганц, хоёр тэргүүлэгч орнуудынхаа ард бөөнөөр байрладаг бусад зарим бүс нутагтай адилгүйгээр Азийн улс орнууд уг индексийн бүхий л хэмжээнд тархан байрласан байгаа нь тэдний хөгжил болон өсөлтийн чадамж маш олон янзын түвшинд байгааг харуулж байна. Тус бүс нутагт тэргүүлэгчид нь алдарт Азийн барууд, тухайлбал Тайвань, Сингапур байх бөгөөд тэд 5, 6 дугаар байрыг тус тус эзэлжээ. Тэдгээрийн дараа нилээн хэдэн байрын ард ӨӨЧИ-д хамрагдсан дараагийн Азийн орон болох Япон 12 дугаарт орсон байна. Японы төсөв санхүүгийн байдал муудсан нь ийнхүү тус улсын эзлэх байранд сөргөөр нөлөөлжээ. Гэвч Япон улсын төсвийн сахилга батын хувьд дутагдалтай байдал нь технологийн талаар тус улсын хүрсэн гайхалтай амжилтаар нөхөж болох хэмжээнээс ч их байгаа юм. Судалгаа, хөгжлийн ажил, пүүс, компанийн түвшний технологийн шингээлт,

патент бүртгүүлэлт зэрэг үзүүлэлтээр туйлын өндөр зэрэглэл бүхий энэ орон энэ чиглэлд багахан оноо дутаж АНУ-ын дараа хоёрдугаарт орсон байна.

49, 50 дугаар байрыг тус тус эзэлсэн Хятад, Энэтхэг хоёр улс урьд жилүүдийнхээс илүү ойрхон байр эзэлсэн байна. Хятад улс гурван байраар ухарсан бол Энэтхэг улс таван байраар ахижээ. Хятадын эрх баригчид зээллэгийн өсөлтийг тогтоон барихыг оролдож байгаа бөгөөд эрэлт нэмэгдснээр 2004 онд инфляци хурдсахад хүрсэн байна. Энэтхэг улсын зэрэглэл дээшилсэн нь тус улс технологийн индексээр нилээд өндөр байр суурь эзэлж байгаатай холбоотой. Сүүлийн хэдэн жил тус улсын ур чадвар, технологи эрчимжсэн салбаруудад гадаадын шууд хөрөнгө оруулалт ихээр орох болсон нь тус улсын бизнесийн салбарынхны сэтгэл санааг өөд татахад нөлөөлсөн нь мэдээж юм. Харин Энэтхэгийн хувьд үлдэж байгаа санаа зовоосон асуудал нь төсвийн зохицуулалтад хийгдсэн бага зэргийн дэвшил, шинэ технологи нэвтрэлтийн доогуур түвшин, дээд боловсролд хамрагдалтын хувь доогуур байдал зэргээс үүдэлтэй. Эдгээрийн сүүлийн хоёр нь мөн Хятад улсын хувьд хүндрэлтэй асуудал юм. Хоёр улс хоёулаа институцийн хувьд сул дорой байгаагаар онцлон авч үзэхгүй бол дэлхийн хамгийн өрсөлдөх чадвартай орнуудын дээд давхаргад өгсөж орох үйл явц нь удаашрах магадлалтай юм. Бүлэг 1.1-ийн тусгай хэсэгт Энэтхэгийн нөхцөл байдлын дэлгэрэнгүй шинжилгээг оруулсан байгаа.

Өмнөх жилүүдийн нэг адил Чили улс 23 дугаар байр эзэлсэн нь Латин Америктаа хол тэргүүлж байна. Үнэн хэрэгтээ Чили улсын тус бүс нутгийн дараагийн хошуучлагч орноос тасарсан зай 2004 оронд 26 байр байсан бол 2005 онд 31 байр болж холдсон нь дэлхийн өөр аль ч бүс нутагт байхгүй онцлог юм. Тус улс гайхалтай чадварлаг макро эдийн засгийн удирдлагаа ил тод, үр ашигтай байдлын хувьд ЕХ-ны түвшинд хүрсэн төрийн институцидтэй хослуулсныхаа үр шимийг үргэлжлэн хүртсээр байна. Үнэн хэрэгтээ, ЕХ-ны 25 гишүүн орны дөнгөж найм нь л төрийн институциудийн дэд индексээр Чилиэс дээгүүр оноо авчээ.

Мексик улс ноднин жилийнхээс долоон байр ухарч 55-д орсноор тус бүс нутгийн хэмжээнд эзэлж байсан хоёрдугаар байраа Уругвайд алдсан бол Бразил улс 8 байр ухарч 65 дугаарт бичигдсэн байна. Бразил, Мексик хоёр хоёулаа төрийн институциудийн чанарыг илэрхийлсэн үзүүлэлтүүдээрээ хойш ухарчээ. Мексик улсад 2006 онд болох ерөнхийлөгчийн сонгуулиас үүдсэн улс төрийн тодорхойгүй байдал үүсч, түүнээс

улбаалсан бодлого боловсруулах үйл явцын зогсонги байдал нь бизнесийн салбарынханы сэтгэл санаанд муугаар нөлөөлсөн байна. Бразилд хээл хахуультай холбоотой дуулиан болон бусад хэрэг явдал өрнөсний улмаас эрх баригч намын эвсэл доройтож, улмаар тус улсын төрийн институциудийн хүчин чадалд таагүй нөлөө үзүүлж байгаа нь бизнесийнхэний итгэх итгэлд сөргөөр нөлөөлсөн байж болох юм.

2001 онд 62 дугаар байрт явж байсан Венесуэл улс уг зэрэглэлийн сүүл хэсэг рүү эрчимтэй уруудсаар байгаа бөгөөд өнгөрсөн оныхоос мөн л дөрвөн байр ухарч энэ жил ерөнхий дүнгээрээ 89 дүгээр байранд оржээ. Хэд хэдэн талаас нь авч үзэхэд Венесуэлийн энэ байдал нилээд онцлогтой байна: газрын тосны үнэ өндөр байх үеийн худалдааны асар их ашиг орлогыг үл харгалзан тус улсын засгийн газар эдийн засгаа олон жилийн турш төсвийн алдагдалтайгаар удирдаж, их хэмжээний үргүй зардал гаргаж байна. Тус улс инфляцийн үзүүлэлтээр дэлхийн хамгийн их инфляцитай улсын тоонд орж (115-д), өмчлөлийн эрхийн уур амьсгалын хувьд дэлхийн хамгийн муу, сүүл баригч орон (117-д) болсон байна.

Ойрхи Дорнод, Хойд Африкийн бүсээс Персийн булангийн жижиг улсууд ӨӨЧИ-ийн ерөнхий дүнгээр нилээд сайн явж байгаагийн дотор энэ жил тус бүс нутгаас уг индексд шинээр хамрагдаж буй Катар, Кувейт хоёр орж байна. Арабын Нэгдсэн Эмират, Катар хоёр 18, 19 дүгээр байрыг тус тус эзэлжээ. Ялангуяа энэ хоёр орон үнэхээр сайн үе шатандаа явж байна. Худалдааны таатай нөхцлийн дагуу олсон ашиг орлого эдгээр орны өсөлтийг дээшлүүлж өгөхийн зэрэгцээ институцийн шинэчлэлээ үргэлжлүүлэн хийж, макро эдийн засгийн удирдлагаа сайжруулж байгаа нь хэдийнээ өндөр түвшинд хүрээд байсан бизнесийн салбарынхны итгэх итгэлийг улам батжуулж өгсөн байна. Боломжийн чадварлаг болох нь нотлогдсон эрх баригчид газрын тосны өндөр үнээс олсон ашгаа дэмий үрэх бус, харин өр төлбөрөө багасгах, хөрөнгө оруулалт хийх, хуримтлал үүсгэхэд илүүтэй зориулж байна.

Африкийн Сахар орчмын дэд бүс нутгийн орнууд тийм ч их өрсөлдөх чадвартай бус боловч тус тивд харьцангуй амжилттай ажиллаж буй хэд хэдэн улс байгаагийн дотор Өмнөд Африк (42-т), Ботсвани (48-д), Мавритани (52-т) улсууд орж байна. Харин үнэхээр харамсалтай нэг жишээ нь Зимбабве бөгөөд энэ улс дэлхийн орнуудын өрсөлдөх чадварын зэрэглэлийн ёроол руу маш хурдтай доошилж байгаа нь түүний институцийн орчин доройтсоор байгаа, түүний дотор өмчлөлийн эрх огт байхгүй болж, эрх зүйт төр авилгалд идэгдсэн төдийгүй эдгээр болон бусад

хүчин зүйлс макро эдийн засгийн удирдлагад муугаар нөлөөлсөнтэй холбоотой. Макро эдийн засгийн орчны чанарын хувьд тус улс дэлхийн хамгийн муу орон (117-д) болоод байна. Хүснэгт 2-т энэ жилийн Тайлан-д хамрагдсан 117 орны зэрэглэлийг ӨӨЧИ-ийн бүрэлдэхүүнд орсон гурван гол индексээр задлан харуулав.

Бизнесийн өрсөлдөх чадварын индекс

Бизнесийн өрсөлдөх чадварын индекс (БӨЧИ) нь улс орнуудын эдийн засгийн бүтээмж, өрсөлдөх чадварын өнөөгийн тогтвортой түвшнийг тодорхойлдог микро эдийн засгийн цаад хүчин зүйлсэд голлон анхаардаг бөгөөд улмаар дээр дурдсан ӨӨЧИ-ийн алс хэтийг харсан макро эдийн засгийн хандлагад нэмэлт болж өгдөг. Аливаа баялаг үнэн хэрэгтээ тухайн эдийн засагт үйл ажиллагаа явуулж буй компаниудын түвшинд бий болдог учраас үндэсний өрсөлдөх чадварт микро эдийн засгийн хүчин зүйлс шийдвэрлэх үүрэгтэй гэсэн үзэл санаанд БӨЧИ тулгуурладаг. БӨЧИ нь аливаа эдийн засаг дахь бизнесийн микро эдийн засгийн орчинд нэн чухал үүрэгтэй хоёр чиглэлийг онцгойлон хэмждэг: Эдгээр нь компаниудын үйл ажиллагаа, стратегийн боловсронгуй байдал болон тэдний үйл ажиллагаагаа явуулж буй үндэсний бизнесийн ерөнхий орчны чанар хоёр юм.

Энэ жилийн БӨЧИ-ийн зэрэглэлийг Хүснэгт 3-т үзүүлэв. Хүснэгтийн эхний баганад ерөнхий зэрэглэл, дараагийн хоёр баганад компанийн үйл ажиллагаа ба стратеги, үндэсний бизнесийн орчны чанар гэсэн хоёр дэд индексийг тус тус харуулж байна.

АНУ суурь өрсөлдөх чадвараараа Финляндын өмнө орж тэргүүлсэн хэвээр байгаа бөгөөд энэ хоёр орон 1998 оноос хойш эхний нэг, хоёрдугаар байрыг эзэлсээр байна. 2005 онд АНУ мэдээлэл харилцааны дэд бүтэц, цахилгаан эрчим хүчний нийлүүлэлтийн чанар, ялангуяа боловсролын тогтолцооныхоо чанарыг бусдаасаа харьцангуй илүү сайжруулсны үр дүнд ийнхүү тэргүүлжээ.

Зэрэглэлээ хамгийн их ахиулсан өндөр орлоготой улсуудын тоонд ЕХ-нд элссэнтэй холбоотойгоор ялангуяа, гадаадын өмчлөлийг сайжруулсны улмаас Кипр улс (8 байр урагшилсан, тогтмол тооны орнууд бүхий түүвэрт хамаарах бүх зэрэглэлийн өөрчлөлтөөр), компаниудын удирдах зөвлөл илүү үр нөлөөтэй болсон, авилгал, хүнд суртлын гох дэгээ багассан, эрдэмтэд, инженерүүд сайтай болсон гэдгээрээ Бүгд Найрамдах Чех Улс (7 байр ахисан), хүнд сурталт элдэв хорионы цар хүрээ болон санхүүгийн зах зээлийн хүчин чадлын хэд хэдэн үзүүлэлт сайжирсан учраас Австри улс

Хүснэгт 1. Өсөлтийн өрсөлдөх чадварын индексийн зэрэглэл ба 2004 оны харьцуулалт

Улс	ӨВЧИ 2005 - Зэрэглэл	ӨВЧИ 2005 - Оноо	ӨВЧИ 2004 - Зэрэглэл	Улс	ӨВЧИ 2005 - Зэрэглэл	ӨВЧИ 2005 - Оноо	ӨВЧИ 2004 - Зэрэглэл
Финлянд	1	5.94	1	Намиби	63	3.72	52
АНУ	2	5.81	2	Коста Рика	64	3.72	50
Швед	3	5.65	3	Бразил	65	3.69	57
Дани	4	5.65	5	Турк	66	3.68	66
Тайвань	5	5.58	4	Румын	67	3.67	63
Сингапур	6	5.48	7	Перу	68	3.66	67
Исланд	7	5.48	10	Азербайжан	69	3.64	-
Швейцарь	8	5.46	8	Ямайк	70	3.64	65
Норвеги	9	5.40	6	Танзани	71	3.57	82
Австрали	10	5.21	14	Аргентин	72	3.56	74
Нидерланд	11	5.21	12	Панам	73	3.55	58
Япон	12	5.18	9	Индонези	74	3.53	69
Их Британи	13	5.11	11	Оросын Холбооны Улс	75	3.53	70
Канад	14	5.10	15	Марокко	76	3.49	56
Герман	15	5.10	13	Филиппин	77	3.47	76
Шинэ Зеланд	16	5.09	18	Алжир	78	3.46	71
БН Солонгос Улс	17	5.07	29	Армян	79	3.44	-
АН Эмирлат Улс	18	4.99	16	Серб ба Монтенегро	80	3.38	89
Катар	19	4.97	-	Вьетнам	81	3.37	77
Эстони	20	4.95	20	Молдав	82	3.37	-
Австри	21	4.95	17	Пакистан	83	3.33	91
Португал	22	4.91	24	Украин	84	3.30	86
Чили	23	4.91	22	Македон	85	3.26	84
Малайз	24	4.90	31	Гүрж	86	3.25	94
Люксембург	25	4.90	26	Уганда	87	3.24	79
Ирланд	26	4.86	30	Нигери	88	3.23	93
Израиль	27	4.84	19	Венесуэл	89	3.22	85
Гонконг	28	4.83	21	Мали	90	3.22	88
Испани	29	4.80	23	Мозамбик	91	3.19	92
Франц	30	4.78	27	Кени	92	3.19	78
Бельги	31	4.63	25	Гондурас	93	3.18	97
Словени	32	4.59	33	Гамби	94	3.18	75
Кувейт	33	4.58	-	Босни Герцеговин	95	3.17	81
Кипр	34	4.54	38	Монгол	96	3.16	-
Мальт	35	4.54	32	Гватемал	97	3.12	80
Тайланд	36	4.50	34	Шри Ланк	98	3.10	73
Бахрейн	37	4.48	28	Никарагуа	99	3.08	95
БН Чех Улс	38	4.42	40	Албани	100	3.07	-
Унгар	39	4.38	39	Болив	101	3.06	98
Тунис	40	4.32	42	БН Доминикан Улс	102	3.05	72
БН Словак Улс	41	4.31	43	Эквадор	103	3.01	90
Өмнөд Африк	42	4.31	41	Тажикстан	104	3.01	-
Литва	43	4.30	36	Малави	105	3.00	87
Латви	44	4.29	44	Этиоп	106	3.00	101
Иордан	45	4.28	35	Мадагскар	107	2.95	96
Грек	46	4.26	37	Зүүн Тимор	108	2.93	-
Итали	47	4.21	47	Зимбабве	109	2.89	99
Ботсвани	48	4.21	45	Бангладеш	110	2.86	102
Хятад	49	4.07	46	Камерун	111	2.84	-
Энэтхэг	50	4.04	55	Камбож	112	2.82	-
Польш	51	4.00	60	Парагвай	113	2.80	100
Мавритани	52	4.00	49	Бенин	114	2.74	-
Египет	53	3.96	62	Гайана	115	2.73	-
Уругвай	54	3.93	54	БН Киргиз Улс	116	2.62	-
Мексик	55	3.92	48	Чад	117	2.37	104
Эль Сальвадор	56	3.86	53				
Колумби	57	3.84	64				
Болгар	58	3.83	59				
Гана	59	3.82	68				
Тринадад Тобаго	60	3.81	51				
Казахстан	61	3.77	-				
Хорват	62	3.74	61				

Хүснэгт 2. Өсөлтийн өрсөлдөх чадварын индексийн бүрэлдэхүүн хэсгүүд

Өсөлтийн өрсөлдөх чадварын индекс (ӨӨЧИ)			Технологийн индекс		
Улс	ӨӨЧИ 2005 Байр	ӨӨЧИ 2005 Оноо	Улс	ӨӨЧИ 2005 Байр	ӨӨЧИ 2005 Оноо
Финлянд	1	5.94	Казахстан	61	3.77
АНУ	2	5.81	Хорват	62	3.74
Швед	3	5.65	Намиби	63	3.72
Дани	4	5.65	Коста Рика	64	3.72
Тайвань	5	5.58	Бразил	65	3.69
Сингапур	6	5.48	Турк	66	3.68
Исланд	7	5.48	Румын	67	3.67
Швейцарь	8	5.46	Перу	68	3.66
Норвеги	9	5.40	Азербайжан	69	3.64
Австрали	10	5.21	Ямайк	70	3.64
Нидерланд	11	5.21	Танзани	71	3.57
Япон	12	5.18	Аргентин	72	3.56
Их Британи	13	5.11	Панам	73	3.55
Канад	14	5.10	Индонези	74	3.53
Герман	15	5.10	ОХУ	75	3.53
Шинэ Зеланд	16	5.09	Марокко	76	3.49
БН Солонгос Улс	17	5.07	Филиппин	77	3.47
АН Эмират Улс	18	4.99	Алжир	78	3.46
Катар	19	4.97	Армян	79	3.44
Эстони	20	4.95	Серб ба Монтенегро	80	3.38
Австри	21	4.95	Вьетнам	81	3.37
Португал	22	4.91	Молдав	82	3.37
Чили	23	4.91	Пакистан	83	3.33
Малайз	24	4.90	Украин	84	3.30
Люксембург	25	4.90	Македон	85	3.26
Ирланд	26	4.86	Гүрж	86	3.25
Израиль	27	4.84	Уганда	87	3.24
Гонконг	28	4.83	Нигери	88	3.23
Испани	29	4.80	Венесуэл	89	3.22
Франц	30	4.78	Мали	90	3.22
Бельги	31	4.63	Мозамбик	91	3.19
Словени	32	4.59	Кени	92	3.19
Кувейт	33	4.58	Гондурас	93	3.18
Кипр	34	4.54	Гамби	94	3.18
Мальт	35	4.54	Босни Герцеговин	95	3.17
Тайланд	36	4.50	Монгол	96	3.16
Бахрейн	37	4.48	Гватемал	97	3.12
БН Чех Улс	38	4.42	Шри Ланк	98	3.10
Унгар	39	4.38	Никарагуа	99	3.08
Тунис	40	4.32	Албани	100	3.07
БН Словак Улс	41	4.31	Боливи	101	3.06
Өмнөд Африк	42	4.31	БН Доминикан Улс	102	3.05
Литва	43	4.30	Эквадор	103	3.01
Латви	44	4.29	Тажикстан	104	3.01
Иордан	45	4.28	Малави	105	3.00
Грек	46	4.26	Этиоп	106	3.00
Итали	47	4.21	Мадагскар	107	2.95
Ботсвани	48	4.21	Зүүн Тимор	108	2.93
Хятад	49	4.07	Зимбабве	109	2.89
Энэтхэг	50	4.04	Бангладеш	110	2.86
Польш	51	4.00	Камерун	111	2.84
Мавритани	52	4.00	Камбож	112	2.82
Египет	53	3.96	Парагвай	113	2.80
Уругвай	54	3.93	Бенин	114	2.74
Мексик	55	3.92	Гайана	115	2.73
Эль Сальвадор	56	3.86	БН Киргиз Улс	116	2.62
Колумби	57	3.84	Чад	117	2.37
Болгар	58	3.83			
Гана	59	3.82			
Тринадад Тобаго	60	3.81			
			АНУ	1	6.19
			Финлянд	2	6.02
			Тайвань	3	5.85
			Швед	4	5.78
			Дани	5	5.30
			Швейцарь	6	5.29
			БН Солонгос Улс	7	5.26
			Япон	8	5.24
			Исланд	9	5.16
			Сингапур	10	4.93
			Нидерланд	11	4.88
			Израиль	12	4.87
			Норвеги	13	4.87
			Австрали	14	4.82
			Канад	15	4.79
			Герман	16	4.78
			Их Британи	17	4.66
			Эстони	18	4.62
			Шинэ Зеланд	19	4.47
			Португал	20	4.39
			Австри	21	4.35
			БН Чех Улс	22	4.31
			Мальт	23	4.29
			Франц	24	4.26
			Малайз	25	4.22
			Гонконг	26	4.21
			Испани	27	4.21
			Бельги	28	4.18
			Люксембург	29	4.11
			Унгар	30	4.08
			Ирланд	31	4.07
			Словени	32	4.07
			АН Эмират Улс	33	4.04
			БН Словак Улс	34	3.99
			Чили	35	3.93
			Кипр	36	3.87
			Грек	37	3.85
			Латви	38	3.83
			Польш	39	3.77
			Катар	40	3.76
			Бахрейн	41	3.73
			Литва	42	3.70
			Тайланд	43	3.69
			Итали	44	3.68
			Ямайк	45	3.64
			Өмнөд Африк	46	3.62
			Мавритани	47	3.57
			Кувейт	48	3.56
			Румын	49	3.53
			Бразил	50	3.51
			Хорват	51	3.48
			Иордан	52	3.46
			Турк	53	3.45
			Филиппин	54	3.43
			Энэтхэг	55	3.42
			Коста Рика	56	3.39
			Мексик	57	3.39
			Египет	58	3.36
			Аргентин	59	3.35
			Тунис	60	3.35
			Болгар	61	3.31
			Тринадад Тобаго	62	3.25
			Уругвай	63	3.19
			Хятад	64	3.18
			Панам	65	3.17
			Индонези	66	3.13
			БН Доминикан Улс	67	3.13
			Серб ба Монтенегро	68	3.12
			Гана	69	3.11
			Эль Сальвадор	70	3.09
			Кени	71	3.04
			Венесуэл	72	3.03
			ОХУ	73	3.01
			Колумби	74	3.01
			Перу	75	3.01
			Ботсвани	76	2.99
			Казакстан	77	2.99
			Марокко	78	2.96
			Намиби	79	2.95
			Пакистан	80	2.94
			Монгол	81	2.93
			Уганда	82	2.93
			Мозамбик	83	2.91
			Гүрж	84	2.84
			Украин	85	2.82
			Танзани	86	2.81
			Азербайжан	87	2.79
			Шри Ланк	88	2.79
			Молдав	89	2.76
			Нигери	90	2.74
			Македон	91	2.73
			Вьетнам	92	2.72
			Албани	93	2.69
			Армян	94	2.69
			Гондурас	95	2.68
			Гватемал	96	2.67
			Гамби	97	2.65
			Зимбабве	98	2.62
			Босни Герцеговин	99	2.61
			Эквадор	100	2.61
			Бангладеш	101	2.60
			Никарагуа	102	2.52
			Мали	103	2.52
			Тажикстан	104	2.52
			Камбож	105	2.51
			Мадагскар	106	2.48
			Малави	107	2.46
			Болив	108	2.42
			Зүүн Тимор	109	2.42
			Камерун	110	2.36
			Парагвай	111	2.35
			Гаяна	112	2.34
			БН Киргиз Улс	113	2.34
			Алжир	114	2.29
			Этиоп	115	2.22
			Бенин	116	2.09
			Чад	117	1.80

Хүснэгт 2. Өсөлтийн өрсөлдөх чадварын индексийн бүрэлдэхүүн хэсгүүд (үргэлжлэл)

Төрийн институциудийн индекс

Улс	Байр	Оноо	Улс	Байр	Оноо
Шинэ Зеланд	1	6.35	Турк	61	4.25
Дани	2	6.35	Болгар	62	4.23
Исланд	3	6.33	Молдав	63	4.20
Сингапур	4	6.25	Польш	64	4.14
Финлянд	5	6.19	Ямайк	65	4.14
Норвеги	6	6.13	Армян	66	4.11
Люксембург	7	6.08	Азербайжан	67	4.09
Герман	8	6.04	Малави	68	4.08
Швейцарь	9	6.02	Серб ба Монтенегро	69	4.07
Австрали	10	6.01	Бразил	70	4.06
Австри	11	6.00	Мексик	71	4.03
Их Британи	12	5.98	Мали	72	4.00
Ирланд	13	5.93	Хорват	73	3.99
Япон	14	5.84	Аргентин	74	3.96
Португал	15	5.83	Панам	75	3.90
Нидерланд	16	5.83	Казахстан	76	3.89
Швед	17	5.82	Гамби	77	3.88
АНУ	18	5.77	Румын	78	3.84
Катар	19	5.75	Этиоп	79	3.79
Франц	20	5.72	Зимбабве	80	3.79
Канад	21	5.67	Алжир	81	3.77
Чили	22	5.58	Никарагуа	82	3.74
Гонконг	23	5.58	Тринадад Тобаго	83	3.73
АН Эмират Улс	24	5.52	Болив	84	3.71
Эстони	25	5.51	Марокко	85	3.69
Тайвань	26	5.47	Босни Герцеговин	86	3.67
Кипр	27	5.44	Гүрж	87	3.65
Бельги	28	5.38	Гондурас	88	3.61
Малайз	29	5.36	Индонези	89	3.58
Израиль	30	5.35	Украин	90	3.56
Иордан	31	5.28	ОХУ	91	3.55
Мальт	32	5.23	Мозамбик	92	3.54
Уругвай	33	5.19	Монгол	93	3.53
Унгар	34	5.15	Кени	94	3.50
Словени	35	5.14	Уганда	95	3.49
Испани	36	5.13	Македон	96	3.47
Кувейт	37	5.11	Вьетнам	97	3.43
Бахрейн	38	5.10	Нигери	98	3.43
Ботсвани	39	5.08	Мадагскар	99	3.39
Тунис	40	5.02	Шри Ланк	100	3.34
Тайланд	41	4.88	Тажикстан	101	3.33
БН Солонгос Улс	42	4.78	Албани	102	3.32
Грек	43	4.77	Пакистан	103	3.31
Литва	44	4.73	Филиппин	104	3.30
БН Словак Улс	45	4.73	БН Доминикан Улс	105	3.24
Итали	46	4.70	Венесуэл	106	3.23
Өмнөд Африк	47	4.63	Гватемал	107	3.22
БН Чех Улс	48	4.63	Зүүн Тимор	108	3.20
Колумби	49	4.55	Гайана	109	3.10
Латви	50	4.55	Бенин	110	3.06
Гана	51	4.54	Камерун	111	3.05
Энэтхэг	52	4.52	Парагвай	112	2.97
Египет	53	4.46	Эквадор	113	2.93
Эль Сальвадор	54	4.45	Камбож	114	2.90
Мавритани	55	4.41	БН Киргиз Улс	115	2.89
Хятад	56	4.41	Чад	116	2.64
Намиби	57	4.38	Бангладеш	117	2.55
Коста Рика	58	4.32			
Перу	59	4.27			
Танзани	60	4.25			

Макро эдийн засгийн орчны индекс

Улс	Байр	Оноо	Улс	Байр	Оноо
Сингапур	1	5.82	Колумби	61	3.95
Норвеги	2	5.76	Болгар	62	3.95
Дани	3	5.64	Унгар	63	3.91
Финлянд	4	5.52	Индонези	64	3.89
АН Эмират Улс	5	5.43	Намиби	65	3.84
Катар	6	5.40	Гана	66	3.82
Ирланд	7	5.38	Марокко	67	3.82
Гонконг	8	5.34	Хорват	68	3.76
Люксембург	9	5.30	Пакистан	69	3.74
Нидерланд	10	5.26	Перу	70	3.71
Исланд	11	5.24	Филиппин	71	3.69
Швед	12	5.24	Танзани	72	3.65
Швейцарь	13	5.23	Румын	73	3.65
Австрали	14	5.21	Панам	74	3.60
Чили	15	5.20	Македон	75	3.58
Канад	16	5.16	Нигери	76	3.54
Тайвань	17	5.15	Армян	77	3.53
Их Британи	18	5.13	Украин	78	3.52
Малайз	19	5.12	Бразил	79	3.50
Шинэ Зеланд	20	5.10	Эквадор	80	3.50
Кувейт	21	5.09	Гватемал	81	3.47
Австри	22	5.07	Коста Рика	82	3.44
АНУ	23	5.07	Бангладеш	83	3.43
Испани	24	5.07	Уругвай	84	3.40
БН Солонгос Улс	25	4.98	Венесуэл	85	3.39
Тайланд	26	4.94	Аргентин	86	3.37
Франц	27	4.90	Турк	87	3.34
Герман	28	4.81	Уганда	88	3.30
Бельги	29	4.76	Гондурас	89	3.25
Эстони	30	4.73	Гүрж	90	3.25
Өмнөд Африк	31	4.68	Босни Герцеговин	91	3.23
Бахрейн	32	4.62	Албани	92	3.20
Хятад	33	4.61	Зүүн Тимор	93	3.18
Тунис	34	4.59	Шри Ланк	94	3.17
Словени	35	4.57	Тажикстан	95	3.17
Ботсвани	36	4.55	Молдав	96	3.14
Португаль	37	4.51	Мали	97	3.13
Латви	38	4.48	Мозамбик	98	3.13
Литва	39	4.47	Ямайк	99	3.13
Тринадад Тобаго	40	4.44	Камерун	100	3.12
Казакстан	41	4.42	Бенин	101	3.08
Япон	42	4.40	Парагвай	102	3.07
Мексик	43	4.35	Болив	103	3.05
Алжир	44	4.33	Камбож	104	3.04
Кипр	45	4.33	Монгол	105	3.03
БН Чех Улс	46	4.31	Кени	106	3.01
Итали	47	4.26	Гамби	107	3.01
Израиль	48	4.25	Этиоп	108	2.99
БН Словак Улс	49	4.23	Мадагскар	109	2.98
Энэтхэг	50	4.17	Никарагуа	110	2.96
Грек	51	4.16	Серб ба Монтенегро	111	2.95
Иордан	52	4.10	БН Доминикан Улс	112	2.78
Польш	53	4.09	Гаяна	113	2.77
Мальт	54	4.09	Чад	114	2.67
Египет	55	4.07	БН Киргиз Улс	115	2.62
Азербайжан	56	4.05	Малави	116	2.47
Эль Сальвадор	57	4.03	Зимбабве	117	2.25
ОХУ	58	4.02			
Мавритани	59	4.01			
Вьетнам	60	3.96			

(6 байр ахисан), дотоодын өрсөлдөөний эрчим, эрдэмтэд, инженерүүдийн хангамж сайжирсан гэдгээрээ Сингапур улс (5 байр урагшилсан) тус тус орж байна.

Уг зэрэглэлээр хойш ухарч байгаа хөгжилтэй орнуудад Хонг Конг, Швед, Итали орж байна. Тухайлбал Хонг Конгт төрийн албан тушаалтнуудын тал тохой татах явдал нэмэгдэж байгаа, хүнд суртал ихэссэн зэргээс болж түүрүү жилийн эзэлсэн байр сууриа алдсан (9 байр доошилсон) байна. Мөн шүүхийн хараат бус байдлын тухайд санаа зовоох асуудал үүссэн, боловсролын чанарын талаархи нилээд олон арга хэмжээний үр өгөөж буурсны улмаас Швед улс (8 байраар) доошилсон байна. Итали улс үнэмлэхүй онооны хувьд сайжирсан хэдий ч БН Чех Улс, Кипр, Унгар, Тайланд зэрэг улсад гүйцэгдсэн бөгөөд дурдсан улсуудын үзүүлэлт хурдан сайжирсан байна.

Өрсөлдөх чадварын зэрэглэлээ ахиулж байгаа дунд орлоготой улсуудын тоонд Польш, Аргентин, Хорват, Ботсвани, Эль Сальвадор, Унгар, Босни Герцоговен орж байна. Польш бизнесийн орчны чанарын олон чиглэлээр эрчимтэй сайжруулалт хийж 5 байр урагшлахдаа монополийн эсрэг бодлогын үр нөлөөтэй байдал ба санхүүгийн зах зээлийн боловсронгуй байдлыг сайжруулах чиглэлд хамгийн мэдэгдэхүйц амжилт үзүүлсэн байна. Тус улс 2001 онд уналтад орохынхоо өмнө хүрч байсан түвшиндээ өнөөдөр эргэж хүрээд байна. Аргентин улс нэн ялангуяа шинийг санаачлах чадавхаа дээшлүүлэх талаар авсан арга хэмжээнүүдийнхээ үр дүнд, түүний хөрш Уругвай улс хүнд суртлыг багасгаж, цагдаагийн үйлчилгээний найдвартай байдлыг сайжруулснаараа тус тус 13, 10 байраар ахижээ. Гэхдээ энэ хоёр улс хоёулаа 2001, 2002 оны түвшиндээ хүрч чадаагүй хэвээр байна. Эцэст нь Хорват улс 12 байраар дээшилсэн бөгөөд бизнесийн орчны үнэлгээ дээшилсэн, ялангуяа гадаадын өмчлөлийн хязгаарлалтыг цөөлсөн, цагдаагийн үйлчилгээний найдвартай байдлыг сайжруулсан, дэд бүтцийн ерөнхий чанар сайжирсан зэрэг үзүүлэлтээр түүрүү жил алдсан байр сууриа эргэж олж авсан байна.

Өрсөлдөх чадварын зэрэглэлээр ухарч байгаа орнуудын тоонд Морокко, Намиби, БН Домникан Улс, Орос, Бразил, Румын, Хятад орж байна. Морокко улс томоохон ухралт хийсэн (29 байр доошилсон) бөгөөд ялангуяа хүнд суртал, гадаадын өмчлөлийн хязгаарлалт, авилгал зэрэг үзүүлэлтүүдээр доогуур үнэлгээ авсан нь үүнд нөлөөлсөн байна. Намиби улс 2002 онд ӨӨЧИ-д хамрагдан орсноос хойш тогтвортой байр суурь эзэлж байсныхаа дараа 19 байраар ухарсан нь

голдуу хүнд суртал, төрийн албан тушаалтнуудын тал тохой таталт, авилгалын үзүүлэлтээр доогуур үнэлгээ авсантай нь холбоотой. БН Домникан Улс доош буусан хандлагатай хэвээр (11 байр ухарсан) байна.

Бага орлоготой орнуудын дотроос Гана, Танзани, Пакистан хамгийн том ахиц гаргажээ. Гана улс голдуу нийтийн сургуулиудаа сайжруулж, авилгал багассаныхаа, Танзани, Пакистан хоёр улс ажил олгогч ба ажил эрхлэгчдийн хоорондын харилцаа сайжирсныхаа үр шимийг хүртжээ.

Бага орлоготой орнуудаас хамгийн их буурсан нь Гамби, Индонези хоёр байна. Индонезид өнгөрсөн жил засгийн газар солигдож, удахгүй хийгдэх сайжруулалтын талаар ихээхэн хүлээлт үүсч байсан үеэ бодвол тэр үед олж авсан бараг бүх байр сууриа алдаад байна. Энэхүү ухралтын гол шалтгаан нь биет дэд бүтэц болон санхүүгийн зах зээлийн хувьд маш доогуур үнэлгээ авсанд оршино.

Макро ба микро эдийн засгийн хүчин зүйлийн аль аль нь бүтээмжийг дээшлүүлэхэд шийдвэрлэх үүрэгтэй учраас БӨЧИ, ӨӨЧИ хоёр нь үндэсний өрсөлдөх чадварын хувьд бие биеэ нөхсөн нэмэлт дүр зургууд гаргаж өгдөг. Бүдүүвч зураг 1-д үзүүлсэнчлэн, энэ хоёр индексийн үр дүн корреляцийн хамаарал маш өндөртэй байгаад гайхах зүйлгүй юм.

Өрсөлдөх чадварын хамгийн сүүлийн үеийн судалгаа: Дэлхий дахины өрсөлдөх чадварын индекс

Өмнө авч үзсэн ӨӨЧИ бол өсөлтийн гол тодорхойлогч хүчнүүдийн шинжилгээнд зориулсан тоон хүрээг гаргах талаар тус Форумын тавьсан хүчин чармайлтуудын дүнд хийгдсэн нэг томоохон алхам юм. Өсөлтийн хувьсал өөрчлөлтөд нөлөөлж буй олон тооны хүчин зүйлсийг тусгасан нарийн түвэгтэй байх шаардлага болон олон улс орны хувьд тооцон гаргаж болохуйц бүтцийн хувьд хангалттай ил тод, хялбар дөхөм байх шаардлага хоёрын хоорондын ухаалаг харьцааг олох шаардлага энэхүү индексийг нэгтгэн гаргах үед гарч байлаа. Иймээс, ӨӨЧИ нь өсөлтийн үйл явцад чухал үүрэгтэй олон гол чиглэлд анхаарал хандуулж өгснөөрөө өөрийн зорилгыг биелүүлж байв. Нэн ялангуяа, өнгөрсөнтэй холбох чухал холбоог бий болгож байсан нь өрсөлдөх чадварын гол үзүүлэлтээ цаг хугацааны хувьд харьцуулан харж, дүгнэхийг хүсч буй орнуудад чухал ач холбогдолтой байв.

Харин бидний хувьд, институцийн болон бүтцийн хувьд нилээд их ялгаатай олон тооны улс орнуудын хувьсал хөгжлийг тайлбарлахдаа гол хүчин зүйлсийн харьцангуй ач холбогдол


Хүснэгт 3. Бизнесийн өрсөлдөх чадварын индекс

Улс	БӨЧИ-н зэрэглэл	Компаний үйл ажиллагаа ба стратегийн зэрэглэл	Үндэсний бизнесийн орчны чанарын зэрэглэл
АНУ	1	1	2
Финлянд	2	9	1
Герман	3	2	4
Дани	4	4	3
Сингапур	5	14	5
Их Британи	6	6	6
Швейцарь	7	5	7
Япон	8	3	10
Нидерланд	9	8	8
Австри	10	11	9
Франц	11	10	11
Швед	12	7	14
Канад	13	18	13
Тайвань	14	13	15
Австрали	15	23	12
Бельги	16	12	17
Исланд	17	15	18
Шинэ Зеланд	18	21	16
Ирланд	19	16	20
Гонконг	20	20	19
Норвеги	21	22	21
Израиль	22	19	22
Малайз	23	24	23
БН Солонгос Улс	24	17	24
Испани	25	25	26
Эстони	26	33	25
БН Чех Улс	27	29	27
Өмнөд Африк	28	26	30
Чили	29	31	29
Португал	30	39	28
Энэтхэг	31	30	31
Словени	32	27	35
АН Эмират Улс	33	36	33
Унгар	34	40	32
Тунис	35	46	34
Кипр	36	48	36
Тайланд	37	35	37
Итали	38	28	39
БН Словак Улс	39	47	38
Грек	40	42	40
Литва	41	41	41
Польш	42	43	46
Иордан	43	59	42
Катар	44	64	43
Гана	45	56	47
Мальт	46	61	44
Кувейт	47	63	45
Латви	48	51	48
Бразил	49	32	52
Коста Рика	50	34	53
Турк	51	38	51
Мавритани	52	45	49
Ямайк	53	54	54
Бахрейн	54	67	55
Ботсвани	55	76	50
Колумби	56	49	57
Хятад	57	53	58
Эль Сальвадор	58	57	56
Индонези	59	50	59
Мексик	60	55	62
Панам	61	37	68
Казахстан	62	72	60
Хорват	63	70	61

Улс	БӨЧИ-н зэрэглэл	Компаний үйл ажиллагаа ба стратегийн зэрэглэл	Үндэсний бизнесийн орчны чанарын зэрэглэл
Аргентин	64	52	64
Тринадад Тобаго	65	62	63
Пакистан	66	68	65
Румын	67	69	67
Кени	68	60	69
Филиппин	69	44	78
Уругвай	70	79	66
Египет	71	58	74
Шри Ланк	72	73	73
Намиби	73	75	72
ОХУ	74	77	70
Украин	75	71	76
Нигери	76	65	79
Азербайжан	77	74	80
Болгар	78	82	71
Марокко	79	80	75
Вьетнам	80	81	77
Перу	81	66	82
Танзани	82	93	81
Македон	83	89	83
Зимбабве	84	78	84
Уганда*	85	91	87
Серб ба Монтенегро	86	108	86
Мали*	87	109	85
Армян	88	87	90
Камерун*	89	84	92
Гамби	90	100	89
Малави	91	86	93
Венесуэл	92	85	97
Молдав	93	90	94
Босни Герцеговин	94	101	91
Алжир	95	111	88
Гүрж	96	94	95
Мадагскар	97	102	96
Мозамбик	98	97	99
Бенин*	99	106	98
Бангладеш	100	99	101
БН Доминикан Улс	101	88	103
Тажикстан	102	107	100
Гватемал	103	83	104
Монгол	104	98	102
Гондурас	105	95	105
Никарагуа	106	110	106
Эквадор	107	96	108
БН Киргиз Улс	108	92	111
Камбож	109	103	107
Гайана	110	105	109
Этиоп	111	113	110
Албани	112	104	113
Болив	113	115	112
Парагвай	114	112	114
Зүүн Тимор*	115	114	115
Чад*	116	116	116

* Эдгээр оронд хийсэн судалгааны тоон мэдээлэл тухайн улсын дотоодод ихээхэн зөрөөтэй байдаг. Иймээс эдгээр оронд ирээдүйд хийгдэх боловсролын хүчин чармайлт, түүвэрлэлтийн боловсронгуй байдлаар дамжуулан судалгааны хариултын баттай байдал сайжрах хүртэл эдгээр зэрэглэлийг болгоомжтой тайлбарлах хэрэгтэй.

График 1. Өсөлтийн ба Бизнесийн өрсөлдөх чадварын зэрэглэлүүд



ба дэлхий нийтийн эдийн засгийн мөн чанарт гарч буй өөрчлөлтүүдийг илүү сайн тусган харуулж чадах илүү өргөн хүрээтэй арга хэрэгсэл шаардлагатай болж байгаа нь улам бүр мэдрэгдэж байлаа.

Үүнд цөөхөн жишээ татахад л хангалттай. Бүтцийн сул талууд, хэд хэдэн чиглэлээр хийгдэж буй шинэчлэлүүдийн удаашралтай байдлын талаар авч хэлэлцэхгүйгээр ЕХ-ны 15 орны удаан өсөлттэй байдлын талаар утга учиртай задлан шинжилгээ хийх хэцүү билээ. Тухайлбал, хөдөлмөрийн зах зээлийн хатуу чанд байдал давамгайлсан байдал, эсвэл нэгдсэн нэг зах зээлийг бий болгоход шаардлагатай гол бүрэлдэхүүн хэсгүүдийг бүрдүүлэх талаар цаг алдаж байгаа явдал зэрэг нь Европын улсуудын эдийн засаг жинхэнэ нэгдсэн нэг том зах зээл болж өргөжин тэлсний хэмнэлтийн үр шимийг хүртэхэд саад болж байна. Гэтэл ӨӨЧИ-д хөдөлмөрийн зах зээлийн хатуу чанд байдлын асуудлыг хөнддөггүй төдийгүй янз бүрийн зах зээлийн үйл ажиллагааны үр ашигтай байдлын асуудлыг ч илүү өргөн дэлгэр авч үздэггүй билээ.

Африкийн орнуудын макро эдийн засгийн орчинг үнэлэхэд төрийн санхүүгийн удирдлага сайтай байх нь чухлын нэг адил, өнгөрсөн зууны сүүлийн 25 жилийн турш Африк тивийн ихэнх орон өсөлт муутай байсныг нийтийн эрүүл мэндийн асуудлаас салгаж ойлгох аргагүй. Мөн ДОХ өвчний халдвар болон бусад гоц халдварт

өвчний тархалтын бизнест үзүүлэх нөлөөг тооцохгүйгээр тус бүс нутаг дахь өрсөлдөх чадварын чиг хандлагыг шинжлэх нь зохисгүй юм. ӨӨЧИ-ийн хувьд эдгээр асуудлыг огт хөндөөгүй нь түүнийг анхлан зохиогчид Африкт болон дэлхийн бусад хэсгийн хөгжлийг ойлгоход эдгээрийг чухал биш гэж үзсэнийх бус, харин 2001 онд тус Форумас өрсөлдөх чадварын талаар хийсэн ажилд Африкийн орнууд хязгаартай хамрагдсан бөгөөд Европ, Латин Америкийн өсөлтийг тайлбарлахад онц чухал биш хүчин зүйлсийг оруулах зайлшгүй шалтгаан байгаагүйд оршино.

Аливаа орны ирээдүйн өсөлтийн чадамжийн үзүүлэлт гэдэг үүднээсээ боловсрол болон ажиллах хүчээ сургаж, мэргэжил мэдлэгийг нь дээшлүүлэх чадварын түвшин хоёр улам бүр ач холбогдолтой болсоор байна. Аливаа орны шинэ технологи шингээх чадвар, мөн олон улсын зах зээлд хүлээн зөвшөөрөгдөхүйц чанарын болон гүйцэтгэлийн шаардлага хангахуйц бүтээгдэхүүн, үйлчилгээ үйлдвэрлэх, үнэт зүйл бий болгох замаар дэлхийн бусад хэсэгтэй харилцах чадвар зэрэг нь тухайн улсын сургуулиудын чанар, математикийн болон шинжлэх ухааны сургалтад өгч буй тэргүүлэх ач холбогдол, нарийн мэргэжлийн судалгаа, сургалтын институцийн хангамж, хүртээмжтэй нягт уялдаатай байдаг. ӨӨЧИ энэ чиглэлийн зарим ойлголтыг багтаасан боловч түүнээс ч илүүг хийх илэрхий шаардлага байна гэдгийг бид мэдэрч байна.

Хүснэгт 4. Дэлхий дахины индексийн есөн тулгуур үзүүлэлтээр хошуучлагчид

Улс	Институцүүд	Дэд бүтэц	Макро эдийн засаг	Эрүүл мэнд ба бага боловсрол	Дээд боловсрол ба сургалт	Зах зээлийн үр ашигтай байдал	Технологийн бэлэн байдал	Бизнесийн боловсролгүй байдал	Шинийг санаачлалт
Сингапур	1	5	9	69	8	4	1	20	9
Дани	2	1	16	23	3	5	2	4	10
Чили	27	34	1	25	42	24	36	31	41
Япон	26	9	93	1	16	16	17	1	2
Финлянд	3	10	10	10	1	12	12	12	4
АНУ	16	8	62	47	2	1	5	3	1

Тус Форумын өрсөлдөх чадварын талаар хийж буй ажлыг цааш хөгжүүлэх, эдийн засгийн өсөлтийг тодорхойлогч хүчнүүдийг сайтар ойлгоход шийдвэрлэх үүрэгтэй илүү өргөн хүрээтэй багц хүчин зүйлсийг авч үзэх үүднээс бид Колумбийн Их Сургуулийн эдийн засгийн өсөлтийн асуудлаарх тэргүүлэх мэргэжилтэн профессор Хавер Сала-и-Мартинтай сүүлийн хоёр жилийн турш нягт хамтран ажиллаж байна. Бид түүрүү жилийн Тайландаа илүү өргөн хүрээтэй, шинэ өрсөлдөх чадварын индексийн эхний хувилбарыг гаргасан бөгөөд түүнийгээ *Дэлхий дахины өрсөлдөх чадварын индекс* гэж нэрлэсэн юм. Уг шинэ индекс нь өмнөх хэсэгт авч үзсэн Өсөлтийн өрсөлдөх чадварын индексд байхгүй олон чухал хүчин зүйлсийг хэмжиж, харьцуулах боломжийг бидэнд олгож байна.

Энэхүү шинэ Дэлхий дахины өрсөлдөх чадварын индекс нь өөр өөр есөн тулгуур үзүүлэлтээс бүрдэх бөгөөд дор бүрнээ үндэсний эдийн засгийн бүтээмж, өрсөлдөх чадварыг хөтлөхөд шийдвэрлэх үүрэгтэй юм. Эдгээр тулгуур үзүүлэлт нь өмнө нь ӨӨЧИ-д багтсан бүх элементийг төдийгүй дээр дурдсан бусад олон хүчин зүйлсийг багтаасан байгаа.

Өсөлтийн хүчин зүйлсийг илүү өргөн хүрээтэй авч үзэж гаргасан эдгээр тулгуур үзүүлэлтээс гадна өөр олон чухал өвөрмөц онцлог Дэлхий нийтийн өрсөлдөх чадварын индексд бий. Түүний нэг нь дэлхийн улс орнууд эдийн засгийн хөгжлийн өөр өөр шатанд явж байна гэсэн үзэл санааг анхнаас нь албан ёсоор оруулсан явдал юм. Аливаа орны өрсөлдөх чадварыг дээшлүүлэх тодорхой хүчин зүйлсийн харьцангуй ач холбогдол нь түүний хөгжлийн тодорхой үе шатнаас хамаарах функц юм. Өнөөдөр АНУ дахь бүтээмжийг юу хөтөлж байна вэ гэдэг нь Бразилд юу хөтөлж байгаагаас өөр байх нь зайлшгүй. Иймээс Дэлхий дахины өрсөлдөх чадварын индексд улс орнуудыг тус бүрдээ нарийн түвэгтэй байдлын тодорхой түвшин оруулсан хөгжлийн гурван тодорхой үе шатанд хуваан, тэдгээрийг *хүчин зүйлсэд чиглэсэн, үр ашигт чиглэсэн, шинийг санаачлалтад чиглэсэн* үе шатууд гэж нэрлэсэн. Уг индексийн тухай илүү дэлгэрэнгүйг Бүлэг 1.1-д танилцуулсан байгаа.

Дэлхий дахины өрсөлдөх чадварын индекс бол тус Форумын өрсөлдөх чадварын талаар хийсэн ажлын өргөжүүлсэн логик үргэлжлэл юм. Энэ нь өмнө нь авч үзэж байгаагүй ойлголтуудыг шинээр оруулж шинжилгээний цар хүрээг нэмэгдүүлэх замаар ӨӨЧИ-ийн давуу талуудад тулгуурласан болно. Өнгөрсөн жил *Дэлхий Дахины Өрсөлдөх Чадварын Тайлан 2004-2005-г* хэвлэн гаргахдаа зарлаж байсанчлан манай стратеги бол Дэлхий дахины өрсөлдөх чадварын индексийг шинжилгээнийхээ ажлын цөм болгох явдал юм. Энэхүү индексийн тулгуурласан цаад үзэл баримтлалын хүрээ болон арга зүйн үндэслэл хүчтэй бөгөөд өсөлтийн үйл явцыг зүй зохистой судлахад гол үүрэгтэй хүчин зүйлсийг илүү өргөн хамруулсан нь бас нэг анхаарал татам онцлог юм.

Өсөлтийн ба дэлхийн дахины индексүүд нилээд хэсэг хугацаанд хамт орших болно. Учир нь, өсөлтийн индекс өнгөрсөн үетэй холбох чухал холбоог гаргаж өгдөг бол дэлхий дахины индекс нь тус Форумын өрсөлдөх чадварын чиглэлээр хийж буй ажил улам гүнзгийрч байгааг харуулдаг. Гэхдээ Дэлхий дахины өрсөлдөх чадварын индекс нь манай өрсөлдөх чадварын үйл ажиллагааны задлан шинжилгээний үндсэн хэрэгсэл болох төлөвтэй байгаа бөгөөд 2006 онд энэхүү индексийн үр дүнгүүд голлох болно. Хүснэгт 4-д Дэлхий нийтийн өрсөлдөх чадварын индексийн есөн тулгуур үзүүлэлт бүрд хамрагдсан 117 орны дундаас хошуучлагчдыг үзүүлж байна.

Мөн судалгаанд хамрагдсан нийт 117 орон тус бүрийн онцлог мэдээллийг энэхүү *Тайлан*-д оруулж, тэдгээрийн индексийн оноонуудыг болон өрсөлдөөний харьцангуй давуу ба сул талуудыг нь харуулав. Тухайн улсын онцлогтой мэдээллээс гадна уг индексүүдийг тооцоход ашигласан янз бүрийн хувьсагчуудаар улс орнуудын зэрэглэлийг харуулсан нарийвчилсан мэдээлэл бүхий хүснэгтүүдийг оруулсан. *Тайлангийн* төгсгөл хэсэгт буй Хавсралтад тухайн орны онцлогтой болон хүснэгтэн мэдээллүүдийг хэрхэн унших тухай зааврыг мэдээллийн эх сурвалжуудын тухай техник тэмдэглэлүүд, тодорхой хувьсагчуудын иж бүрэн тодорхойлолтын хамт оруулсан байгаа.

Өрсөлдөх чадварын талаар сонгосон асуудлууд ба тусгай сэдвүүд

Өмнөх *Тайлангуудын* нэг адилаар энэ жилийн дугаар нь өрсөлдөх чадварын тодорхой асуудлууд болон хөгжлийн өргөн хүрээтэй сэдвүүдээр дагнан ажилладаг нэртэй эрдэмтэн, мэргэжилтнүүдийн зүгээс уг ажилд хэд хэдэн гарамгай хувь нэмэр оруулснаараа онцлогтой. Тэдний зарим нь Судалгаагаар олж авсан мэдээлэлд задлан шинжилгээ хийхэд анхаарч байхад нөгөө хэсэг нь тус Форумын индексүүдээр тодруулж гаргасан өрсөлдөх чадварын бүхий л талыг судлан шинжилж байна. Эдгээр нь бүгд тогтвортой өсөлт, хөгжлийн нөхцлүүдэд анхаарал хандуулсан төдийгүй бодлого боловсруулагчид, бизнес эрхлэгчид болон өргөн олон нийтэд зориулсан маш сайн ухааж ойлгохуйц унших материалууд болох юм. Мөн дор бүрнээ өрсөлдөх чадварын өөр өөр талыг хөндөн авч үзэж, Дэлхийн Эдийн Засгийн Форумд бидний хийж байгаа ажлын амин сүнс болсон гол асуудлуудыг нэг бүрчлэн гүн гүнзгий задлан шинжилж байна. Энэхүү тусгай судалгаанууд нь бизнестэй ихээхэн холбоотой бөгөөд тус *Тайланд* орсон өрсөлдөх чадварын индексүүд, улсын онцлогтой болон хүснэгтэн мэдээллүүдэд нэмэлт болж өгөх юм.

Засаглал ба авилгалын тухай

Сүүлийн жилүүдэд эрдэмтэд, тусламжийн газрууд, ТББ-ын хамтын нийгэмлэг болон засгийн газрууд өөрсдөө улам бүр буурьтай авч үзэж эхлээд байгаа ойлголтуудын талаар зонхилох зарим нэг буруу ташаа төсөөллүүдийн эсрэг тайлбарыг Даниел Кауфманны бичсэн «Засаглал ба авилгалын тухай домог болон бодит байдал» нэртэй бүлэгт өгч байна. Энэ тухай олон асуудал шийдвэрлэгдээгүй хэвээр үлдсэн бөгөөд зохиогч засаглал ба авилгалын тухай найман «домгийг» онцолж, тэдгээр нь дор бүрнээ яагаад буруу ташаа болохыг нь нэгбүрчлэн ойлгомжтойгоор тайлбарлаж өгснөөр эдгээр асуудлыг нарийвчлан судлахад маань тусалж байна.

Жишээлбэл, тэрээр *засаглал, авилгалын эсрэг ажиллагаа хоёр ижил утгатай* гэсэн 1 дүгээр домогт хариулт өгөхдөө засаглалын илүү өргөн цар хүрээнд анхаарал хандуулж, авилгал бол зөвхөн засгийн эрх баригчдад бус, хувийн салбарт ч хамаатай асуудал гэдгийг харуулжээ. Мөн 2 дугаар домог болох *засаглал, авилгал хоёрыг хэмжиж болохгүй* гэж ярьдаг хүмүүст хандан одоо байдаг болсон, мөн гүйцэтгэлийн хяналт шинжилгээнд өргөнөөр хэрэглэдэг болсон янз бүрийн, өргөн цар хүрээтэй сэтгэл хөдлөм, ойлгомжтой хэмжүүрүүдийн талаар дүрсэлжээ.

Кауфманн *засаглал ба авилгалын эсрэг үйл ажиллагааны ач холбогдлыг «хэтрүүлэг» гэж үзэн үл ойшоодог* хүмүүст зориулан хөгжилд засаглалын үзүүлэх үр нөлөөний тухай иж бүрэн судалгааны үр дүнгээс танилцуулж, илүү сайн засаглалын үр дүнд үүсдэг «хөгжлийн ноогдол ашиг»-ийн тухай тайлбарласан байна. Тэрээр тусламжийн төслүүдийн амжилт, бүтэлгүйдэлд засаглалын практикууд онцгой ач холбогдолтой гэдгийг тэмдэглээд, хандивлагчид хөгжлийн төслүүдийг ямар нэг байдлаар «тойруулан хашиж» түүний эргэн тойронд буй авилгалын орчноос тусгаарлаж болно гэдэг үзлийг няцаасан байна.

Энэ бүлэгт засаглалыг сайжруулж, авилгалыг багасгах талаар илүү зоримог арга хэрэглэхийг уриалсан дүгнэлт хийсэн байна. Кауфманн ил тод байдлын шинэчлэлийн талаар Дэлхийн Банкинд хийх шинэлэг ажлын тухай өөрийн саналд тулгуурлан, улс орнууд хэвлэл мэдээллийн эрх чөлөөг, цаашилбал хүйсийн тэгш байдлыг дээшлүүлэх талаар хэрэгжүүлж болох ихээхэн практик шинжтэй, тодорхой шинэчлэлүүд байгаагийн заримыг жагсаан харуулжээ.

Валютын ханшийг удирдах нь

Кеннет Рогоффийн бичсэн «Валютын ханшны өрсөлдөх чадварыг эргэн харахуй» гэдэг хэсэг бол аливаа улсын ерөнхий өрсөлдөх чадварт валютын ханшны бодлогын гүйцэтгэх үүргийн тухай мэтгэлцээнд оруулсан нэг сайшаалтай хувь нэмэр юм. Валютын ханшийг өрсөлдөх чадвартай байлгахын ач холбогдлыг «Вашингтоны зөвшилцөл»-д суулгаж өгсөн бөгөөд уг зөвшилцөл нь бодит ханшнаас илэрхий өндөр валютын ханш барихын эсрэг хатуу анхааруулга болдог. Гэвч хэн нэг нь хар зах (эсвэл «зэрэгцээ») зах зээлийн байдлыг зүгээр нэг хараад л аливаа улсын валютын ханш бодит ханшнаасаа илэрхий өндөр байна гэдгийг тэр дор нь мэдэрдэг цаг үе өнгөрсөн. Өнөөдөр валютын хөрвөх ханшийг дээрээс хатуу тогтоодог улс улам цөөрч, валютын ханш зах зээлийн хүчин зүйлсээс улам бүр хамаарах болжээ. Мөнгөний бодлого нь дор хаяж инфляцид үзүүлэх нөлөөгөөрөө дамжуулан валютын ханшны өөрчлөлтөд хариу үйлдэл үзүүлсээр байгаа боловч өнөөдөр иймэрхүү хөндлөнгийн оролцоонд зах зээлд тулгуурласан арга хэрэгслийг ашиглах магадлал ихтэй байна. Үүний үр дүнд, валютын ханшыг ихээхэн буруу ташаа тогтоосон хэргийг олж илрүүлэх ажиллагаа маш нарийссан бөгөөд үүнд голдуу аливаа орны макро эдийн засгийн ерөнхий байдлыг үнэлэх ажил хийгдэх ёстой болдог. Мөн улс орнууд худалдааны тэнцлээ ашигтай гаргахын тулд валютын бодит ханшаа аль болох

доогуур (өрсөлдөх чадвартай) байлгах ёстой гэсэн меркантилист үзэл цаг үргэлж төөрөгдүүлсэн хэвээр байна. Эдгээр анхааруулгаас гадна аливаа орны мөнгөн тэмдэгтийн худалдан авах бодит чадварыг үнэлэхийг хичээх, мөн олон улсын харьцуулалт хийхэд чиглэсэн бодит валютын ханшны индексүүдийг бий болгоход тулгарч буй практик сорилтуудын талаар дэлгэрэнгүй авч хэлэлцэх шаардлага чухал хэвээр байна гэж Рогофф үзжээ.

Бид байгаль орчныг өрсөлдөөнтэйгээр хамгаалж болох уу?

Аллен Хаммонд «Байгаль орчин өрсөлдөөний давуу талын нэг эх сурвалж болох нь» хэмээх сонирхолтой өгүүлэлдээ байгаль орчны зохицуулалтууд бизнест дарамт үзүүлэх боломжтой, тэр ч байтугай эрсдэл учруулдаг гэсэн санаа давамгайлж байгаагийн эсрэг сонирхолтой сөрөг няцаалтууд өгч байна. Байгаль орчны болон нийгмийн хөгжлийн асуудлуудыг шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, шинэ технологи, шинэ зах зээлийн боломжийн нэг эх сурвалж гэж ойлгох явдал улам бүр ихсэж байна хэмээн тэр тайлбарлажээ. Хаммонд байгаль орчин ба тогтвортой хөгжлийг өрсөлдөөний давуу талын эх сурвалжууд гэдэг талаас нь өргөн хүрээтэй тодорхойлж, олон тооны шинжилгээ, судалгаа, тайланг, түүний дотор 2005 оны Бизнесийн удирдлагын санаа бодлын судалгааны дүнгээс иш татан дүгнэжээ. Бизнесийн тэргүүлэх удирдагч нарын үзэл бодлоор эдийн засгийн хөгжил болон байгаль орчин ба нийгмийн хариуцлагын чиглэлийн үйл ажиллагааны хооронд боломжийн харилцан хамаарал байгааг уг судалгааны үр дүн харуулсан байна. Хэдийгээр энэ чиглэлээр ихээхэн сайжруулах шаардлагатай гэж хариулагчид үзсэн боловч байгаль орчны стандартад нийцүүлж ажиллах нь урт хугацааны өрсөлдөх чадварыг дээшлүүлдэг, цэвэр усны хомсдолтой байдал бизнесээ өргөжүүлэхэд саад болж байна, цэвэр үйлдвэрлэл явуулж, хог хаягдлыг багасгах нь компаний амжилтад чухал гэдэгтэй нийт бизнес эрхлэгчид, тэр ч байтугай бага орлоготой хариулагч нар хүртэл ихээхэн санал нэгтэй байсан байна. Уг бүтээлд судалгааны үр дүнгээс гадна дэлхий нийтийн байгаль орчны бэрхшээлтэй асуудлууд, тухайлбал голчлон цаг уурын өөрчлөлт ба экологийн системийн доройтолтой холбоотойгоор үүссэн, мөн дэлхий дахины нийгмийн ба тогтвортой хөгжлийн гол хүндрэлсорилтуудаас, тухайлбал голдуу ядуурлаас үүдсэн бизнесийн зарим таатай боломжуудыг авч үзжээ. Зохиогч цаг уурын бодлого дахь өрсөлдөх чадварын утга агуулгыг нилээд нарийвчлан

судалж, мөн эдгээр нь автомашины салбарт яаж илэрч байгааг харуулсан байна. Мөн тэрээр экосистемийн үйлчилгээний доройтлын талаарх сүүлийн үеийн түгшүүртэй тоон мэдээллүүдийн өрсөлдөөний утга агуулгыг болон үүний улмаас цэвэр ус, ой мод, загас, бусад ихээхэн хомсдож буй байгалийн нөөц баялгаас хамааралтай эдийн засгийн салбаруудад үзүүлэх үр нөлөөний талаар авч үзсэн байна. Эцэст нь тэрээр хувийн салбарынхан ядуурлыг бууруулахад туслах байдлаар бага орлоготой зах зээлд хэрхэн хүрч болох тухай зарим бодууштай санаа дэвшүүлсэн байна.

Вашингтоны зөвшилцөл

Жонн Уиллиамсоны гүнзгий агуулгатай өгүүлэлд «Хөгжлийн ямар нэг зөвшилцөл байх ёстой юу?» гэсэн асуулт дэвшүүлж байна. Тэрээр «Вашингтоны зөвшилцөл»-ийн түүхийг судалж, дэлхий нийтийн хөгжлийн ямар нэг зөвшилцөл байх боломжийн талаар эрэгцүүлэн, улмаар 1989 онд ихэнх Латин Америкийн орнуудад эдийн засгийн модернизаци хийхэд зайлшгүй шаардлагатай гэж өргөнөөр үзэж байсан арван тулгуур бодлогыг макро эдийн засгийн сахилга бат, микро эдийн засгийн либералчлал, даяаршил гэсэн гурван үндсэн сэдвийн хүрээнд нарийвчлан гаргаж өгсөн байна. Мөн энэ бүтээлд уг нэр томъёоны хоёр боломжит утга агуулгыг тодорхойлсон нь: (а) Вашингтоноос (ялангуяа, олон улсын санхүүгийн байгууллагуудаас) хөгжиж байгаа орнуудад «албан ёсоор» санал болгосон багц бодлогууд, (б) «неолиберализм» буюу «зах зээлийн фундаменталист үзэл» хоёр юм. Эхний боломжит утга нь анх хэрэглэгдэхдээ Уиллиамсоны анх санал болгосон утга агуулгад дөхөж очсон боловч 1990-ээд онд олон улсын санхүүгийн байгууллагууд урам зоригтойгоор хийсэн капиталын дансны либералчлал (маргаантай гэж тэр үздэг), валютын ханшны асуудлын хоёр талт шийдэл, мөн институцийн асуудал ба санхүүгийн тогтвортой байдалд улам бүр гол анхаарлаа хандуулж буй байдал (маш их хүсүүштэй гэж тэр үздэг) зэргээс болж утга нь өөрчлөгдсөн байна.

Зохиогчийн дэвшүүлсэн Вашингтоны зөвшилцлийн анхны хувилбарт нэгтгэж оруулсан ихэнх бодлого өнөөдөр учир холбогдолтой хэвээр байгаа боловч цаг хугацаа улиран өнгөрөхийн хэрээр Латин Америкийн өнөөгийн хэрэгцээ шаардлагыг хөндөн авч үзэхэд зориулсан аль ч бодлогын хэлэлцэх асуудалд хэд хэдэн нэмэлт асуудлыг анхааралдаа авах хэрэгтэй болж байна. Хямралын аюул (ба түүний хор хохирлыг)-ыг хамгийн бага болгох, эдийн засгийг либералчлах

хүчин чармайлтыг зогсоох бус үргэлжлүүлэх, зохих хүрээний бодлого ба институциудийг зүй ёсоор бий болгож бэхжүүлэх, мөн орлогын хуваарилалтыг сайжруулж, эдийн засгийн өсөлтийг хурдасгахад чиглэсэн макро эдийн засгийн бодлогын ач холбогдлыг өнөөгийн хэлэлцэх асуудлуудын дотор онцлон авч үзэх ёстой гэж тэр дүгнэжээ.

Хөгжиж буй ертөнцөд заналхийлж буй насжилт

Николас Эберштадтын иж бүрэн судалсан «Бага орлоготой орнууд дахь насжилт: 2025 он хүртэл харахуйд» хэмээх найруулалд бичигдсэн зүйлсийг үзээд уншигчид цочирдож болох юм. Зохиогч энэ бүтээлдээ ирэх арван жилүүдэд «гуравдагч ертөнцийн» ихэнх нь эрс хөгшрөлтөд орох төлөвтэй байгааг үнэмшилтэйгээр харуулсан байна. Хэдийгээр хүн амын насжилтын асуудал түүнд аль хэдийн автсан ЭЗХАХБ-ын орнуудын санааг зовоосон, үргэлжилсэн бодлогын шинжилгээний сэдэв болоод байгаа боловч дэлхийн бага орлоготой бүс нутгуудад энэ асуудал харьцангуй бага анхаарал татаж байсан билээ. Энэхүү үл ойшоосон байдал нь зөвхөн гайхал төрүүлээд зогсохгүй аюултай юм. Учир нь, зохиогчийн харуулж байгаачлан, ядуу орнуудад баян орнуудыг бодвол үүнээс үүсэх асуудлуудыг шийдэх боломж тун бага төдийгүй илт таагүй тусах тул тэд энэхүү хүн амын насжилтын ачааллыг амар хялбар дааж чадахгүй байж болох юм.

Эберштадт нилээд гүнзгий агуулгатай нарийн судалгаа хийж Хятад, Орос, Энэтхэг гурван орны эдийн засаг, соёлын өнөөгийн байдлыг тодорхойлж, тэдгээрийн өсөлт, нэг хүнд ноогдох орлого, нөхөн үржихүйн өсөлтийн хэв шинжийг Япон, АНУ болон Европын янз бүрийн орнуудынхтай харьцуулсан бөгөөд 2025 он гэхэд тэдгээр улсын хүн амын ихэнх хэсэг нь насжилтын харьцангуй ижил түвшинд яваа аль ч улсад байгаагүй хамаагүй бага түвшний орлоготойгоор энэ асуудалтай тулгарах шаардлагатай болно гэж тооцсон байна. Эберштадт «удаан хөдөлгөөнт хүн төрөлхтний эмгэнэл» гэсэн нэр томъёогоор Хятадын «гурван хүлээс» гэж нэрлэсэн зүйл буюу нөхөн үржлийн өсөлтийн доогуур хувь, «хөвгүүний хомсдол», дорой эрүүл мэнд гурвыг, Оросын жам ёсныхоос өндөр нас баралтын хувь, сүйрлийн аюул нүүрлэсэн эрүүл мэндийн асуудлуудыг, Энэтхэгт байдаггүй өндөр насны тэтгэвэр буюу тэтгэмж, боловсролын хангалтгүй бааз суурь зэргийг тодорхойлсон байна. Ийм орнуудын хувьд хэдийгээр дор бүрд нь харилцан адилгүй тусах боловч ерөнхийдөө насжилтийн нийгэм, эдийн засгийн үр дагавар хүнд ширүүн,

хүн амын насжилтын сөрөг нөлөөг багасгах боломж хязгаарлагдмал байж болох юм. Иймд насжилт нь эдгээр бүх орны урт хугацааны өсөлт, хөгжилтөд тулгарах нэг хүндрэл бэрхшээл болон гарчиржболно. Эберштадтын энэхүү сонирхолтой шинжилгээнд харуулсанчлан хүн амын ийм эрчимтэй, илэрхий насжилт нь дэлхийд шинээр төрөн гарч буй дээрх зах зээлүүдийн хувьд маш тэгш бус, ихээхэн тааламжгүй төдийгүй бараг бүхэлдээ үл ойшоогдомгүй урт хугацааны эрсдэл авчрах юм.

Зах зээлийн хямралуудаас авах сургамжууд

Ноуриел Рубини, Брэд Сетсер нар «Шинээр төрөн гарч буй зах зээлийн хямралууд ба хямралын шийдэл: Арван жилийн туршлага» бүтээлдээ сүүлийн арван жилд шинээр төрөн гарч буй зах зээлийн эдийн засагтай орнуудад үе үе давтагдаж буй ноцтой хямралуудыг нарийвчлан судалж шинжилжээ. Шинээр төрөн гарч буй томоохон эдийн засгууд капиталын урсгалын гэнэтийн хэлбэлзэлд эмзэг өртөмтгий байдаг бөгөөд улмаар ноцтой хямрал нүүрлэн, огцом уналтад орж байгаа нь нотлогджээ. Шинээр төрөн гарч буй зах зээлийн эдийн засагтай орнууд тасралтгүй, тогтвортой өсөлтөд хүрч чадах эсэх нь юун түүрүүнд тэдгээр эдийн засгийн капиталын урсгалын гэнэтийн хэлбэлзлээс өөрийгөө хамгаалах сайн макро эдийн засгийн болон өрийн бүтцийн бодлого баримталж ажиллах чадвараас хамаарч байна. Хүндрэлд орж буй орнуудихэвчлэн бодлогын томоохон алдаа дутагдалтай байдаг, тэр дутагдал нь зах зээлийн нөхцөл байдлын өөрчлөлтөд өртөмтгий байдаг бөгөөд зохиогчийн зүгээс бидэнд анхааруулсанчлан, шинээр төрөн гарсан зах зээлүүдийн хувьд өнөөгийн харьцангуй тааламжтай нөхцөл байдлууд удаан үргэлжлэхгүй ажээ. Шинээр төрөн гарсан эдийн засгууд байнгын хямралд үе үе орсоор байх болно гэдгийг дэлхийн санхүүгийн тогтолцооны эрүүл саруул байдалд санаа зовж байдаг ОУВС, Их 7 болон бусад бүтэц анхаарч, болзошгүй хямралыг зохих бодлого, институциудээр хангахад бэлэн байх ёстой. Зохиогчийн үзэж байгаагаар, өргөн хүрээтэй олон янзын хямралд хариу үйлчлэхэд шаардлагатай үндсэн хэрэгслүүд ерөнхийдөө бэлэн байгаа боловч хамгийн гол нь тэдгээр бэлэн хэрэгслийг илүү сайн ашиглах, тэдгээрийг өөр өөр төрлийн хямралд сайтар тохируулан хэрэглэх явдал чухал байна. Иймээс, бидэнд шинэ «хатуу арга» гэхээсээ илүү сайн «зөөлөн арга» хэрэгтэй байна.

Бие даасан засгийн газрууд, эсвэл энэ асуудлын хувьд, шинээр төрөн гарч буй голлох зах зээлийн эдийн засгуудын банкны тогтолцоо

нь тухайн улс өр төлөх чадвараа алдах замаар явах уу эсвэл голдуу эмх замбараагүй бүтцийн өөрчлөлт дагуулдаг замаар явах уу гэдгийг ОУВС-ийн зааваргүйгээр шийдэж чадна гэж төсөөлөх нь буруу гэж хоёр зохиогч мэтгэж байна. Иймээс, ОУВС-ийн санхүүгийн дэмжлэгийг зохих бодлогын зохицуулалттай хослуулах нь хямралыг шийдвэрлэх онц чухал нэг элемент хэвээр байна гэж тэд үзэж байна. Санхүүгийн хямралын мөн чанар нэг орноос нөгөөд харилцан адилгүй байдаг учраас зүгээр л өрийн бүтцийн өөрчлөлт хийхээс зайлсхийхийн тулд их хэмжээний онц байдлын санхүүжилт авах боломжийг бүх оронд олгох, эсвэл нөгөө талаас, бүх орны ийн хүртэх боломжийг үгүйсгэх нь ухаалаг хэрэг биш юм. Хэдийгээр ОУВС-ийн удирдлагаар хэрэгждэг их хэмжээний аврах багц зээл нь яг тохирох зөв нөхцөл байдалд үр дүнгээ өгч болох боловч тухайн хямралт орны хүндрэл хэт их өрнөөс биш, харин богино хугацааны өртэй атлаа харьцангуй бага нөөцтэйгээс голлон үүсч байгаа тохиолдолд амжилт олохгүй байх магадлал хамаагүй илүү байдаг гэж тэд хэлж байна. Өрийн түвшин илүү өндөр байгаа орнуудын хувьд ямар нэг хэлбэрийн өрийн бүтцийн өөрчлөлт хийхээс зайлсхийхийг оролдон ОУВС-ийн санхүүжилтийг ашиглах нь зөв арга биш, харин түүний оронд хямралын хүчийг сулруулахад ОУВС-ийн зээллэгийг ашиглах нь зөв байж болно.

Даяаршлын сайн сайхан нь юу байна?

Жагдиш Бхагвати «Даяаршил хөгжил цэцэглэлт авчрагч болох нь» бүтээлээрээ даяаршил хэрхэн улс үндэстнүүдийг улам хөгжин дэвжихэд хүргэж байгаа талаарх бидний ойлголтод сонирхол татам, гүнзгий агуулгатай хувь нэмэр оруулж байна. Бхагвати саяхан хэвлүүлсэн *Даяаршилыг хамгаалахуйд* хэмээх номондоо тулгуурлан, даяаршил хэрхэн хүйсийн тэгш байдлыг дээшлүүлж байгаа, ядуурлыг бууруулж, хүүхдийн хөдөлмөрийг багасгахад тусалж байгаа, илүү сайн засаглалыг дэмжин сурталчилж байгаа, эдийн засгуудад илүү чөлөөтэй худалдаа, өсөлтийн үр өгөөжийг хүртэх боломж олгож байгаа талаар жишээ гарган тайлбарласан байна. Тэрээр энэ асуудлыг хөндөхдөө даяаршлын эсрэг маргаануудын мөн чанар, тэдгээрийн гарал үүслийн талаар тайлбарлаж, дийлэнх даяаршлыг эсэргүүцсэн хөдөлгөөнүүдийг өдөөж буй капитализмын эсрэг, авилгалын эсрэг үзэл санаануудын цаана оршиж буй төөрөгдлүүдийг илчилж өгсөн байна. Тэрээр эдийн засгийн даяаршлыг соёлынхоос ялган авч үзэхдээ, түүнийг шүүмжлэгчдийн маргааныг эс тооцвол даяаршил бол хүнлэг үйл явц, түүний үр нөлөө

хорон муу биш, уян зөөлөн, энэ талаар санаа зовоход хүргэж буй нийгмийн асуудлууд ч үнэн хэрэгтээ даяаршлын үр дүнд хөгжин дэвшиж байгаа гэсэн өөрийн итгэл үнэмшлийг нухацтай дүрслэн харуулжээ.

Тэр өөрийн үзэл бодлыг хамгаалсан баттай нотлох баримтууд гаргаж тавьсан байна. Тухайлбал, Вьетнамын тариачин эцэг эхчүүд хэрхэн хүүхдүүдээ сургуульд явуулах замаар будааны экспортын либералчлалаас олсон нэмэлт орлогоо ашиглаж байгааг судалгаагаар харуулжээ. Хүйсийн тэгш байдлын сэдвийн хувьд тэрээр Харвардын судлаачдын хийсэн ажлаас иш татсан бөгөөд худалдаагаар дамжсан өрсөлдөөн нэмэгдсэн нь түүнд оролцогч салбаруудад ажиллаж буй эмэгтэйчүүдийн цалин хөлс нэмэгдэхэд хүргэсэн болохыг уг судлаачид тогтоосон байна. Худалдааг илүү чөлөөтэй болгохын эдийн засгийн үр өгөөжийн талаар авч үзэхдээ ядуу орнууд баян орнуудаас тэдэнд тавьж буй худалдааны саад тотгоруудыг багасгахыг шаардаж байхад тэдгээрт өөрсдийгөө хамгаалах бодлого баримтлахыг зөвлөх нь тун аюултай болохыг Бхагвати сануулаад, харилцан ашигтай солилцоо үл үүсдэг гамшигт түүхээс иш татсан байна. Эцэст нь, өсөлтийн тухай сэдвийн хувьд тэрээр *доош нэвчих* стратегийн эсрэг идэвхтэй, *дээш татах* стратеги дэвшүүлж, үүндээ сүүлийн хорин жилд тусгаарлалтын бодлогоо орхиж гадагшаа чиглэсэн худалдааны дэглэмд шилжээд байгаа бөгөөд улмаар ядуурлыг эрс бууруулсан Энэтхэг, Хятад хоёр улсын жишээг авч үзсэн байна. Бхагвати эдийн засгийн даяаршлыг нийгмийн бодлоготой хослуулж, улмаар өсөн нэмэгдсэн эдийн засгийн нөөц баялгийг ухаалгаар хуваарилан зарцуулахын ач холбогдлыг урнаар дүрслэн харуулахын зэрэгцээ даяаршлын «сайн нөлөөг хадгалах, алдаршуулах, дээшлүүлэх»-эд чиглэсэн бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүлэхийн хажуугаар түүний тохиолдлын чанартай сул талуудыг онцлон авч үзэж шийдвэрлэх шаардлагатайг цохон хэлсэн байна.

Өрсөлдөх чадварын индексүүд

1-р бүлэг

Эдийн засгийн өсөлтийг дэмжих бодлого, институциуд: Өрсөлдөх чадварын индексийн үр дүнгээс

Дэлхийн Эдийн Засгийн Форумын

АВГУСТО ЛОПЕЗ-КЛАРОС

ЖЕННИФЕР БЛАНКЕ

МАРГАРЕТА ДРЗЕНИЕК

ИРЕНЕ МИА

СААДИА ЗАХИДИ НАР


Өрсөлдөх чадвар гэж юу вэ, яагаад асуудал болоод байна вэ?

Өрсөлдөх чадвар гэдэг үг өөр өөр хүнд өөр өөр утгаар ойлгогддог. Олон хүний хувьд энэ нь валютын бодит ханшид хамаатай зүйл бөгөөд үүнийг тухайн улс ба дэлхийн үлдэх хэсэг хоорондын үнийн зөрүүгээр тохируулга хийсэн валютын нэрлэсэн ханш гэж тодорхойлдог. Давуу чанарын талаасаа авч үзвэл, валютын бодит ханш доогуур байна гэдэг бол бараа бүтээгдэхүүн нь дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвартай болж байгаагаараа экспортлогчдод сайн бол, энэ ханш өндөр байх нь импортын бараа бүтээгдэхүүн дотоодод үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнээс харьцангуй хямд болж байна гэсэн үг. Валютын бодит ханшны ач холбогдолд эргэлзэх зүйл байхгүй. Үнэн хэрэгтээ, энэхүү номын хаа нэгтээ¹, өрсөлдөх чадварыг үнэлэхэд валютын ханшны гүйцэтгэх үүргийг судалж үзээд, «Ямар ч сайн олон улсын макро эдийн засагчаас аливаа улсын макро эдийн засгийн ерөнхий байдлыг үнэлэхийн тулд ямар гол хувьсагчуудыг мэдэхийг хамгийн их хүсч байна вэ гэж асуугаад үз, тэгвэл валютын бодит ханшны үзүүлэлт голдуу уг жагсаалтын дээд тал хавьцаа байх болно»² гэж хэлсэн Кеннет Рогоффтой бид бүрэн дүүрэн санал нэг байна.

Бид Дэлхийн Эдийн Засгийн Форумд өрсөлдөх чадварын илүү өргөн хүрээтэй тодорхойлолт хэрэглэдэг бөгөөд тэр нь валютын ханшны өрсөлдөх чадварын тухай үзлээс хальж, бүтээмжийн тухай ойлголттой холбосон тодорхойлолт байдаг. Өрсөлдөх чадвар гэдэг бол аливаа улсын бүтээмжийн түвшинг, улмаар аливаа эдийн засгийн хүрч болох хөгжил цэцэглэлтийн түвшинг тодорхойлдог хүчин зүйлс, бодлого, институциудийн нэгдмэл цогц гэж бид үздэг. Хавер Сала-и-Мартины дэвшүүлсэнчлэн: «илүү өрсөлдөх чадвартай эдийн засгууд иргэдийнхээ орлогыг улам өндөр түвшинд хүргэж чадах хандлагатай байдаг». Гэхдээ бас бүтээмж бол аливаа эдийн засаг дахь хөрөнгө оруулалтын өгөөжийн хувийн гол хөтлөгч бөгөөд эргээд тухайн эдийн засгийн нийт өсөлтийн хувийг ямар ч эргэлзээгүй тодорхойлдог билээ. Иймд илүү өрсөлдөх чадвартай эдийн засаг дундаас урт хугацаанд илүү хурдан өсөх магадлалтай байдаг.

Өрсөлдөх чадварын чиглэлээр Дэлхийн Эдийн Засгийн Форумаас хийж буй ажлын нилээд нь дэлхийн 100 гаруй улсын эдийн

График 1. Нэг хүнд ноогдох ДНБ, олон улсын доллараар



Эх сурвалж: Хестон нар, 2002; Олон Улсын Валютын Сан, 2005

засгийн өсөлтийн туршлага эрс ялгаатай байгаагийн цаана түүнийг тодорхойлж буй хүчин зүйлс, бодлого, институциудийг илрүүлэн гаргахад чиглэгдэж байна. Сүүлийн тавь гаруй жилийн турш, тухайлбал Аргентин, Гана, Тайваны нэг хүнд ноогдох орлогын өсөлт хөгжил ялгаатай байгааг юугаар тайлбарлах вэ? (График 1).

Магадгүй, харьцуулсан хөгжлийн чиглэлд цөөхөн асуулт илүү хамаатай байдаг биз. Энэ чиглэлд тус Форумын хийж буй ажлаас наанадаж гурван гол зүйл ажиглагддаг: Нэгдүгээрт, энд холбогддог хүчин зүйлс асар олон бөгөөд асар өргөн хүрээг хамарч тархсан байдаг. Мэдээж макро эдийн засгийн орчны чанарын асуудал амин чухал- төрийн мөнгө санхүүг *буруугаар удирдаж* эсвэл дээр дурдсан шиг алдаатай буюу зохисгүй валютын ханшны бодлого баримталж тогтвортой өсөлт харуулж чадаж байгаа улс орны жишээ бидэнд олон байхгүй.

Гэтэл макро эдийн засгийн хянуур удирдлагаас гадуурх төрийн хэвшлийн гүйцэтгэх үүргийн бусад тал бас ийм байдаг. Түүнчлэн заавал асуух ёстой асуултууд байдаг: Засгийн газар хувийн салбартай харилцахдаа хол хөндий зай барьж байна уу эсвэл нөхөрсөг дотно харьцаж байна уу? Шүүхийн тогтолцоо шударга байж маргааныг үндэслэлтэй, шуурхай, ил тод, бага зардлаар шийдвэрлэж байна уу эсвэл тэнд «шударга ёс» наймааны хэрэгсэл

болсон байна уу? Татварын орлогыг хүний нөөц, дэд бүтцийн бүтээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтад зарцуулах замаар эдийн засгийг буцаан сэлбэж байна уу, эсвэл хөрөнгийг үр ашиггүй төслүүдэд зарцуулж байна уу, эсвэл бүр түүнээс ч дор байдлаар ашиглан шамшигдуулж байна уу? Шаардлагагүй хүнд суртлын давхаргууд, хэрэгцээгүй зохицуулалтаас бүрдсэн зохицуулалтын орчин ажил гүйлгээ болон үйл ажиллагааны өртөг зардлыг нэмэгдүүлж өрсөлдөх чадварыг бууруулж байна уу? Технологийн шинэ бүтээл, санаачилгуудыг хэр үр ашигтай авч ашиглаж байна вэ, тухайн улсын боловсролын тогтолцооны чанарт хангалттай анхаарал тавьж байна уу? Тухайн орон гадаад ертөнцтэй нээлттэй, өөртөө итгэлтэй байдлаар харьцаж байна уу, аль эсвэл айдас түгшүүртэй, эргэлзсэн байдлаар хандаж байна уу?

Илүү ерөнхийлбөл, өмчийн эрх ба институциудийн үүрэг юу вэ? Тэдгээрийн хөгжлийн үйл явцад гүйцэтгэх гол ач холбогдлын тухай Асемоглу (2001) нэгэн хүчтэй жишээ гаргасан байдаг нь: «Илүү сайн 'институциуд'-тэй, илүү өмчийн эрхтэй, гажуудал багатай бодлоготой орнууд биет болон хүний капиталд илүү их хөрөнгө оруулж, илүү өндөр орлогын түвшинд хүрэхийн тулд эдгээр хүчин зүйлсээ улам үр ашигтай ашиглах болно» гэсэн байдаг. Дээрх асуултуудад өгөх

хариулт улс орон бүрт харилцан адилгүй байхын зэрэгцээ уг хариултууд нь тухайн эдийн засаг урьдчилан төсөөлөгдөхүйц, тогтвортой байдлаар өсч байгаа эсэх (жишээ нь, Тайвань), чадамжаа бүрэн ашиглаж чадахгүй байгаа эсэх (жишээ нь, Аргентин), эсвэл бүр тогтворгүй байгаа буюу үнэн хэрэгтээ нэг хүнд ноогдох орлого нь буурч байгаа эсэх (тухайлбал, Гана) талаар чухал утга агуулсан байна гэдэгт гайхах зүйлгүй. Энэ гурван орны өсөлтийн туршлагыг График 1-д үзүүлэв.

Хоёрдугаарт, эдгээр хүчин зүйлс тухайн улсын хөгжлийн үе шатаас хамаарч харилцан адилгүй хэмжээнд асуудал үүсгэдэг. Финляндад төрийнсанхүүгийнудирдлагынасуудалЭнэтхэг, Турктэй харьцуулбал бага санаа зовоодог, учир нь дээрх хоёр орон бол төсвийн сахилга батгүй байдлын урт удаан жилийн түүхтэй улсууд. Финлянд улс одоогоор ирээдүйд үүсэх тэтгэвэр тэтгэмжийн өр төлбөрийг барагдуулах нөөцийн илүүдэлтэйгээр хүн амын насжилтын асуудалтай тулгарч байгаа нь Европын олон томоохон орныг ичээхэд хүргэж байна. Энэтхэг, Турк хоёр улс төсвийн алдагдалтай ажиллаж байна. Гэхдээ Турк улс их хэмжээний улсын өр үүсч хуримтлагдахад хүргэсэн төсвийн хариуцлагагүй бодлогоо орхих тал дээр сүүлийн хоёр жил гайхалтай ахиц гаргаад байна. Харин Финляндад, технологийн шинэчлэлийн хурдац тус улсын ирээдүйн өсөлтийн хэгийн төлөвт туйлын чухал голлох үүрэгтэй байдаг. Нокиа компани Ази дахь өрсөлдөгч нараасаа технологийн хувьд давуу байдлаа хадгалж чадах эсэх нь инфляци бага зэрэг өсөх эсэх тухай асуудлаас хамаагүй чухлаар Финляндын нэг хүнд ноогдох орлогын ирээдүйн хувьсал хөгжлийг тодорхойлж байдаг.

Гуравдугаарт, эдгээр хүчин зүйлсийн ач холбогдол цаг хугацааны явцад өөрчлөгдсөөр байгаа нь даяаршлын хүчин зүйлийн нөлөөгөөр улам бүр өсөн нэмэгдэж буй нэг чиг хандлага юм. Дэлхий дахины хэмжээгээр инфляци буурах хандлагатай байж дайны дараахь үеийн хамгийн доод түвшинд хүрээд байгаа нь АНУ-ын инфляци хоёр оронтой тоогоор хэмжигдэж байсан 1970, 80-аад оны үеийнх шиг тийм ч их санаа зовоосон зүйл биш болжээ. Гэвч капиталын шилжилт хөдөлгөөн ихсэж, санхүүгийн зах зээл ороо бусгаа байгаагаас улсынхаа мөнгө санхүүг сайн удирддаггүй улсуудын хувьд 2001 оны сүүлээр Аргентинд гарсан шиг эрсдэлтэй байдал нэмэгдэж байна. Сүүлийн жилүүдэд тээвэр, харилцаа холбооны зардал огцом буурснаар

дэлхийн томоохон корпорациудын хувьд ур чадвар, ажиллах хүчний өртөг багатай байдлыг улс төр, нийгмийн тогтвортой байдалтай зөв уялдуулах боломжтой тийм газрууд руу үйлдвэрлэлээ шилжүүлэхэд хялбар болоод байгаа учраас боловсрол, мэргэжлийн ур чадвар олж авах явдал, ажиллах хүчний сургалтын түвшин зэрэг асуудал улам бүр чухлаар тавигдаж байна. Энэ явдлыг сүүлийн арван жилд эдийн засаг нь Европын бусад хэсгийн дунджаас хоёр дахин илүү хурдтай өсч буй Төв болон Зүүн Европын улсуудын жишээ нотлон харуулж байна.

Өсөлтийн өрсөлдөх чадварын индекс

Дэлхийн Эдийн Засгийн Форум 1979 оноос хойш үндэсний өрсөлдөх чадварыг хэмжиж *Өрсөлдөх Чадварын Тайлангууд* гаргаж байна. Энэ хугацаанд бид аливаа улс орны иргэддээ хөгжил цэцэглэлтийг хангалттай өгч, дээшлүүлэх чадварт шийдвэрлэх үүрэгтэй тэрхүү бүтээмжийг чухам ямар хүчин зүйлс хөтөлж байгаа талаарх хамгийн сүүлийн үеийн үзэл бодлыг анхаарч үзэж байсан учраас өрсөлдөх чадварыг хэмжихэд ашиглаж байсан тодорхой арга зүйн хувьд гарцаагүй хувьсан хөгжиж байв. 2001 оноос хойш манай арга зүй Дэлхийн Эдийн Засгийн Форумд зориулан Жеффрий Сакс, Жон МакАртур нарын боловсруулсан Өсөлтийн Өрсөлдөх Чадварын Индекс (ӨӨЧИ буюу GCI) хэмээх загварт тулгуурлаж байна.

ӨӨЧИ нь өрсөлдөх чадварыг хэмжих тоон хүрээг гаргах зорилготой хэд хэдэн нэмэлт ойлголтыг нэгтгэдэг. Энэ загварт аливаа орны өсөлтийн хувьсал хөгжлийг тайлбарлахад орох янз бүрийн хүчин зүйлсийг томъёолохдоо «гурван тулгуур»-ыг тогтоодог. Үүнд, макро эдийн засгийн орчны чанар, тухайн улсын төрийн байгууллагуудын байдал, түүнчлэн технологи ба шинийг санаачлахын ач холбогдлыг харгалзан технологийн бэлэн байдлын түвшин гэсэн гурван үзүүлэлтийг авч үзсэн. ӨӨЧИ-дих, дээд сургуульд хамрагдалтын хувь, инфляцийн дүн, төрийн санхүүгийн байдал, хөдөлгөөнт холбоо, интернэт гэх мэтийн шинэ технологи нэвтрэлтийн түвшин зэрэг тогтсон тоон мэдээллийг Дэлхийн Эдийн Засгийн Форумын Бизнесийн удирдлагын санаа бодлын судалгаагаар (Судалгаа) авсан тоон мэдээлэлтэй хослуулан ашиглаж байна. Энэхүү судалгаагаар авсан тоон мэдээлэл нь голдуу тогтсон тоон мэдээлэл байдаггүй боловч эдийн

засгийн өсөлтийг бий болгогч хүчин зүйлсийг зохих ёсоор ойлгоход гол үүрэгтэй зарим ойлголтуудын талаар олж мэдэхэд тусалдаг. Ийм ойлголтуудын жишээнд шүүхийн хараат бус байдал, институцичлэгдсэн авилгалын тархалт, эдийн засаг дахь төрийн үр ашиггүй оролцооны цар хүрээ гэх мэтийг оруулж болох юм.

Эдгээр янз бүрийн жижиг хэсгийг өөр өөр дэд индексэд нэгтгэн оруулсан бөгөөд дор бүрнээ өсөлтийн үйл явцын өөр өөр талыг (тухайлбал, гэрээ, эрх зүйн ач холбогдол, макро эдийн засгийн орчны тогтвортой байдал гэх мэт) харуулахын зэрэгцээ тэдгээрийг өрсөлдөх чадварын нийт «оноо»-нд нэгтгэн оруулдаг. Сакс, МакАртур нарын нэвтрүүлсэн хоёр дахь ойлголт бол технологийн асуудал ихээхэн нөлөөтэй ч, тухайн орны хөгжлийн үе шатнаас хамаарч улс орон бүрт харилцан адилгүй байдаг гэсэн үзэл санаа юм. Швейцарьд шинийг санаачлалтын асуудал гол байдаг бол гадаадаас технологи авч хэрэглэх, технологи шилжүүлэх асуудал Чилид харьцангуй чухал байж болох юм. Энэхүү ялгаа нь энэ хоёр улсыг

тухайн улсад сүүлийн жилд бүртгэгдсэн нэг хүнд ноогдох АНУ-ын хэрэглээний патентын (шинэ бүтээлийн патент) тоонд нь тулгуурлан үндсэн шинийг санаачлагч ба үндсэн бус шинийг санаачлагч гэж нэрлэдэг хоёр тусдаа ангилалд ороход хүргэдэг байна. 2004 онд бүгд сая хүн ам тутамд дор хаяж 15 патент эзэмшиж байсан үндсэн шинийг санаачлагчдын жагсаалтыг Хүснэгт 1-д үзүүлэв. Гурав дахь ойлголт бол аливаа улс үндэстний өрсөлдөх чадварыг тайлбарлаж буй хүчин зүйлсийн ач холбогдол эдгээр хоёр ангилалын орнуудад харилцан адилгүй байдаг гэсэн үзэл санаа юм. Ийм учраас, Туркт макро эдийн засгийн тогтвортой байдлын асуудал Шведийнхээс илүү чухал хүчин зүйл байх талтай. Энэхүү индексийг зохиоход ашигласан жинхэнэ суурь арга зүйг энэхүү бүлгийн төгсгөлд буй Хавсралт А-д тодорхой харуулсан байгаа.

Өсөлтийн Өрсөлдөх Чадварын Индексийн зэрэглэл 2005-2006

Европ ба Америкийн Нэгдсэн Улс

Финлянд улс уг зэрэглэлд тэргүүлэх байр сууриа хадгалсан хэвээр байна. Тус улс дэлхий дээр хамгийн шинийг санаачлагч бизнесийн орчны нэг гэдгээ хүчтэй харуулсан нь хөгжлийн дээд түвшинд явж байгаа энэ улсын хувьд бүтээмжийг дээшлүүлэхэд онцгой ач холбогдолтой юм. Энэ нь түүний макро эдийн засгийн маш эрүүл орчинтой хосолсон байдаг бол бусад олон аж үйлдвэржсэн орон энэ чиглэлд тэмцээр байгаа билээ. Финландын засгийн газар төсвийн илүүдэлтэй ажиллахад бэлэн байж, улмаар тус улсын хүн амын насжилттай холбоотойгоор ирээдүйд хүлээх үүргээ биелүүлэх чадвартай байхыг зорьж байгаа нь бүр ч сэтгэл хөдлөм байна. Макро эдийн засгийн бодлогын энэхүү хандлага нь Финландын нийгэм дэх улс төрийн төлөвшилтийн түвшин бусадтай өрсөлдөхүйц хэмжээнд байгааг тод томруун харуулж байна. Цаашилбал, Финлянд улс дэлхийн хамгийн сайны нэгд тооцогдох институцийн орчинтой: тус улсын бизнесийн салбарынхан хуулиа дээдлэх уур амьсгалд үйл ажиллагаа явуулдаг, авилгал ер бусын доогуур түвшинд байдаг, нээлттэй, ил тод байдал хөгжсөн зэрэг нь бусад орон сайтар судлавал зохих үлгэр жишээ юм.

АНУ энэ зэрэглэлийн хоёрдугаарт орсон нь тус улсын технологийн хувьд үргэлжлүүлэн ноёрхож буй байдал болон шинийг санаачлагчдын хувьд хэнийг ч урдаа гаргаагүй байдалтай нь

Хүснэгт 1. Үндсэн технологи-шинийг санаачлагч эдийн засгууд, 2004 он

Улс	Нэг сая хүн ам тутамд олгосон АНУ-ын хэрэглээний патентын жилийн дундаж	Эзэлсэн байр
Америкийн Нэгдсэн Улс	283.7	1
Япон	276.6	2
Тайвань	263.9	3
Швейцарь	177.4	4
Финлянд	176.5	5
Израиль	155.8	6
Швед	144.9	7
Герман	130.7	8
Канад	106.4	9
Сингапур	104.4	10
БН Солонгос Улс	92.3	11
Люксембург	88.0	12
Нидерланд	78.6	13
Дани	76.7	14
Австри	66.7	15
Исланд	66.7	16
Бельги	59.4	17
Их Британи	58.1	18
Франц	56.0	19
Норвеги	52.8	20
Австрали	47.9	21
Ирланд	46.5	22
Гонконг	43.8	23
Шинэ Зеланд	36.4	24
Итали	27.9	25

Эх сурвалж: АНУ-ын Патент, барааны тэмдгийн газар

Хүснэгт 2. Өсөлтийн өрсөлдөх чадварын индексийн зэрэглэл ба 2004 оны харьцуулалт

Улс	ӨВЧИ 2005 - Зэрэглэл	ӨВЧИ 2005 - Оноо	ӨВЧИ 2004 - Зэрэглэл	Улс	ӨВЧИ 2005 - Зэрэглэл	ӨВЧИ 2005 - Оноо	ӨВЧИ 2004 - Зэрэглэл
Финлянд	1	5.94	1	Намиби	63	3.72	52
Америкийн Нэгдсэн Улс	2	5.81	2	Коста Рика	64	3.72	50
Швед	3	5.65	3	Бразил	65	3.69	57
Дани	4	5.65	5	Турк	66	3.68	66
Тайвань	5	5.58	4	Румын	67	3.67	63
Сингапур	6	5.48	7	Перу	68	3.66	67
Исланд	7	5.48	10	Азербайжан	69	3.64	-
Швейцарь	8	5.46	8	Ямайк	70	3.64	65
Норвеги	9	5.40	6	Танзани	71	3.57	82
Австрали	10	5.21	14	Аргентин	72	3.56	74
Нидерланд	11	5.21	12	Панам	73	3.55	58
Япон	12	5.18	9	Индонези	74	3.53	69
Их Британи	13	5.11	11	Оросын Холбооны Улс	75	3.53	70
Канад	14	5.10	15	Марокко	76	3.49	56
Герман	15	5.10	13	Филиппин	77	3.47	76
Шинэ Зеланд	16	5.09	18	Алжир	78	3.46	71
БН Солонгос Улс	17	5.07	29	Армян	79	3.44	-
Арабын Нэгдсэн Эмират	18	4.99	16	Серб ба Монтенегро	80	3.38	89
Катар	19	4.97	-	Вьетнам	81	3.37	77
Эстони	20	4.95	20	Молдав	82	3.37	-
Австри	21	4.95	17	Пакистан	83	3.33	91
Португал	22	4.91	24	Украин	84	3.30	86
Чили	23	4.91	22	Македон	85	3.26	84
Малайз	24	4.90	31	Гүрж	86	3.25	94
Люксембург	25	4.90	26	Уганда	87	3.24	79
Ирланд	26	4.86	30	Нигери	88	3.23	93
Израиль	27	4.84	19	Венесуэл	89	3.22	85
Гонконг	28	4.83	21	Мали	90	3.22	88
Испани	29	4.80	23	Мозамбик	91	3.19	92
Франц	30	4.78	27	Кени	92	3.19	78
Бельги	31	4.63	25	Гондурас	93	3.18	97
Словени	32	4.59	33	Гамби	94	3.18	75
Кувейт	33	4.58	-	Босни Герцеговин	95	3.17	81
Кипр	34	4.54	38	Монгол	96	3.16	-
Мальт	35	4.54	32	Гватемал	97	3.12	80
Тайланд	36	4.50	34	Шри Ланк	98	3.10	73
Бахрейн	37	4.48	28	Никарагуа	99	3.08	95
БН Чех Улс	38	4.42	40	Албани	100	3.07	-
Унгар	39	4.38	39	Болив	101	3.06	98
Тунис	40	4.32	42	БН Доминикан Улс	102	3.05	72
БН Словак Улс	41	4.31	43	Эквадор	103	3.01	90
Өмнөд Африк	42	4.31	41	Тажикстан	104	3.01	-
Литва	43	4.30	36	Малави	105	3.00	87
Латви	44	4.29	44	Этиоп	106	3.00	101
Иордан	45	4.28	35	Мадагскар	107	2.95	96
Грек	46	4.26	37	Зүүн Тимор	108	2.93	-
Итали	47	4.21	47	Зимбабве	109	2.89	99
Ботсвани	48	4.21	45	Бангладеш	110	2.86	102
Хятад	49	4.07	46	Камерун	111	2.84	-
Энэтхэг	50	4.04	55	Камбож	112	2.82	-
Польш	51	4.00	60	Парагвай	113	2.80	100
Мавритани	52	4.00	49	Бенин	114	2.74	-
Египет	53	3.96	62	Гайана	115	2.73	-
Уругвай	54	3.93	54	БН Киргиз Улс	116	2.62	-
Мексик	55	3.92	48	Чад	117	2.37	104
Эль Сальвадор	56	3.86	53				
Колумби	57	3.84	64				
Болгар	58	3.83	59				
Гана	59	3.82	68				
Тринадад Тобаго	60	3.81	51				
Казахстан	61	3.77	-				
Хорват	62	3.74	61				

Хүснэгт 3. Өсөлтийн өрсөлдөх чадварын индексийн бүрэлдэхүүн хэсгүүд

Өсөлтийн өрсөлдөх чадварын индекс (ӨӨЧИ)

Улс	ӨӨЧИ 2005 Байр	ӨӨЧИ 2005 Оноо
Финлянд	1	5.94
АНУ	2	5.81
Швед	3	5.65
Дани	4	5.65
Тайвань	5	5.58
Сингапур	6	5.48
Исланд	7	5.48
Швейцарь	8	5.46
Норвеги	9	5.40
Австрали	10	5.21
Нидерланд	11	5.21
Япон	12	5.18
Их Британи	13	5.11
Канад	14	5.10
Герман	15	5.10
Шинэ Зеланд	16	5.09
БН Солонгос Улс	17	5.07
АН Эмират Улс	18	4.99
Катар	19	4.97
Эстони	20	4.95
Австри	21	4.95
Португал	22	4.91
Чили	23	4.91
Малайз	24	4.90
Люксембург	25	4.90
Ирланд	26	4.86
Израиль	27	4.84
Гонконг	28	4.83
Испани	29	4.80
Франц	30	4.78
Бельги	31	4.63
Словени	32	4.59
Кувейт	33	4.58
Кипр	34	4.54
Мальт	35	4.54
Тайланд	36	4.50
Бахрейн	37	4.48
БН Чех Улс	38	4.42
Унгар	39	4.38
Тунис	40	4.32
БН Словак Улс	41	4.31
Өмнөд Африк	42	4.31
Литва	43	4.30
Латви	44	4.29
Иордан	45	4.28
Грек	46	4.26
Итали	47	4.21
Ботсвани	48	4.21
Хятад	49	4.07
Энэтхэг	50	4.04
Польш	51	4.00
Мавритани	52	4.00
Египет	53	3.96
Уругвай	54	3.93
Мексик	55	3.92
Эль Сальвадор	56	3.86
Колумби	57	3.84
Болгар	58	3.83
Гана	59	3.82
Тринадад Тобаго	60	3.81

Технологийн индекс

Улс	Байр	Оноо
АНУ	1	6.19
Финлянд	2	6.02
Тайвань	3	5.85
Швед	4	5.78
Дани	5	5.30
Швейцарь	6	5.29
БН Солонгос Улс	7	5.26
Япон	8	5.24
Исланд	9	5.16
Сингапур	10	4.93
Нидерланд	11	4.88
Израиль	12	4.87
Норвеги	13	4.87
Австрали	14	4.82
Канад	15	4.79
Герман	16	4.78
Их Британи	17	4.66
Эстони	18	4.62
Шинэ Зеланд	19	4.47
Португал	20	4.39
Австри	21	4.35
БН Чех Улс	22	4.31
Мальт	23	4.29
Франц	24	4.26
Малайз	25	4.22
Гонконг	26	4.21
Испани	27	4.21
Бельги	28	4.18
Люксембург	29	4.11
Унгар	30	4.08
Ирланд	31	4.07
Словени	32	4.07
АН Эмират Улс	33	4.04
БН Словак Улс	34	3.99
Чили	35	3.93
Кипр	36	3.87
Грек	37	3.85
Латви	38	3.83
Польш	39	3.77
Катар	40	3.76
Бахрейн	41	3.73
Литва	42	3.70
Тайланд	43	3.69
Итали	44	3.68
Ямаик	45	3.64
Өмнөд Африк	46	3.62
Мавритани	47	3.57
Кувейт	48	3.56
Румын	49	3.53
Бразил	50	3.51
Хорват	51	3.48
Иордан	52	3.46
Турк	53	3.45
Филиппин	54	3.43
Энэтхэг	55	3.42
Коста Рика	56	3.39
Мексик	57	3.39
Египет	58	3.36
Аргентин	59	3.35
Тунис	60	3.35

Төрийн институциудийн индекс

Улс	Байр	Оноо
Шинэ Зеланд	1	6.35
Дани	2	6.35
Исланд	3	6.33
Сингапур	4	6.25
Финлянд	5	6.19
Норвеги	6	6.13
Люксембург	7	6.08
Герман	8	6.04
Швейцарь	9	6.02
Австрали	10	6.01
Австри	11	6.00
Их Британи	12	5.98
Ирланд	13	5.93
Япон	14	5.84
Португал	15	5.83
Нидерланд	16	5.83
Швед	17	5.82
АНУ	18	5.77
Катар	19	5.75
Франц	20	5.72
Канад	21	5.67
Чили	22	5.58
Гонконг	23	5.58
АН Эмират Улс	24	5.52
Эстони	25	5.51
Тайвань	26	5.47
Кипр	27	5.44
Бельги	28	5.38
Малайз	29	5.36
Израиль	30	5.35
Иордан	31	5.28
Мальт	32	5.23
Уругвай	33	5.19
Унгар	34	5.15
Словени	35	5.14
Испани	36	5.13
Кувейт	37	5.11
Бахрейн	38	5.10
Ботсвани	39	5.08
Тунис	40	5.02
Тайланд	41	4.88
БН Солонгос Улс	42	4.78
Грек	43	4.77
Литва	44	4.73
БН Словак Улс	45	4.73
Итали	46	4.70
Өмнөд Африк	47	4.63
БН Чех Улс	48	4.63
Колумби	49	4.55
Латви	50	4.55
Гана	51	4.54
Энэтхэг	52	4.52
Египет	53	4.46
Эль Сальвадор	54	4.45
Мавритани	55	4.41
Хятад	56	4.41
Намби	57	4.38
Коста Рика	58	4.32
Перу	59	4.27
Танзани	60	4.25

Макро эдийн засгийн орчны индекс

Улс	Байр	Оноо
Сингапур	1	5.82
Норвеги	2	5.76
Дани	3	5.64
Финлянд	4	5.52
АН Эмират Улс	5	5.43
Катар	6	5.40
Ирланд	7	5.38
Гонконг	8	5.34
Люксембург	9	5.30
Нидерланд	10	5.26
Исланд	11	5.24
Швед	12	5.24
Швейцарь	13	5.23
Австрали	14	5.21
Чили	15	5.20
Канад	16	5.16
Тайвань	17	5.15
Их Британи	18	5.13
Малайз	19	5.12
Шинэ Зеланд	20	5.10
Кувейт	21	5.09
Австри	22	5.07
АНУ	23	5.07
Испани	24	5.07
БН Солонгос Улс	25	4.98
Тайланд	26	4.94
Франц	27	4.90
Герман	28	4.81
Бельги	29	4.76
Эстони	30	4.73
Өмнөд Африк	31	4.68
Бахрейн	32	4.62
Хятад	33	4.61
Тунис	34	4.59
Словени	35	4.57
Ботсвани	36	4.55
Португал	37	4.51
Латви	38	4.48
Литва	39	4.47
Тринадад Тобаго	40	4.44
Казакстан	41	4.42
Япон	42	4.40
Мексик	43	4.35
Алжир	44	4.33
Кипр	45	4.33
БН Чех Улс	46	4.31
Итали	47	4.26
Израиль	48	4.25
БН Словак Улс	49	4.23
Энэтхэг	50	4.17
Грек	51	4.16
Иордан	52	4.10
Польш	53	4.09
Мальт	54	4.09
Египет	55	4.07
Азербайжан	56	4.05
Эль Сальвадор	57	4.03
ОХУ	58	4.02
Мавритани	59	4.01
Вьетнам	60	3.96

Хүснэгт 3. Өсөлтийн өрсөлдөх чадварын индексийн бүрэлдэхүүн хэсгүүд /үргэлжлэл/

Өсөлтийн өрсөлдөх чадварын индекс (ӨӨЧИ)

Улс	ӨӨЧИ 2005 Байр	ӨӨЧИ 2005 Оноо
Казакстан	61	3.77
Хорват	62	3.74
Намиби	63	3.72
Коста Рика	64	3.72
Бразил	65	3.69
Турк	66	3.68
Румын	67	3.67
Перу	68	3.66
Азербайжан	69	3.64
Ямайк	70	3.64
Танзани	71	3.57
Аргентин	72	3.56
Панам	73	3.55
Индонези	74	3.53
ОХУ	75	3.53
Марокко	76	3.49
Филиппин	77	3.47
Алжир	78	3.46
Армян	79	3.44
Серб ба Монтенегро	80	3.38
Вьетнам	81	3.37
Молдав	82	3.37
Пакистан	83	3.33
Украин	84	3.30
Македон	85	3.26
Гүрж	86	3.25
Уганда	87	3.24
Нигери	88	3.23
Венесуэл	89	3.22
Мали	90	3.22
Мозамбик	91	3.19
Кени	92	3.19
Гондурас	93	3.18
Гамби	94	3.18
Босни Герцеговин	95	3.17
Монгол	96	3.16
Гватемал	97	3.12
Шри Ланк	98	3.10
Никарагуа	99	3.08
Албани	100	3.07
Болив	101	3.06
БН Доминикан Улс	102	3.05
Эквадор	103	3.01
Тажикстан	104	3.01
Малави	105	3.00
Этиоп	106	3.00
Мадагскар	107	2.95
Зүүн Тимор	108	2.93
Зимбабве	109	2.89
Бангладеш	110	2.86
Камерун	111	2.84
Камбож	112	2.82
Парагвай	113	2.80
Бенин	114	2.74
Гайана	115	2.73
БН Киргиз Улс	116	2.62
Чад	117	2.37

Технологийн индекс

Улс	Байр	Оноо
Болгар	61	3.31
Тринадад Тобаго	62	3.25
Уругвай	63	3.19
Хятад	64	3.18
Панам	65	3.17
Индонези	66	3.13
БН Доминикан Улс	67	3.13
Серб ба Монтенегро	68	3.12
Гана	69	3.11
Эль Сальвадор	70	3.09
Кени	71	3.04
Венесуэл	72	3.03
ОХУ	73	3.01
Колумби	74	3.01
Перу	75	3.01
Ботсвани	76	2.99
Казакстан	77	2.99
Марокко	78	2.96
Намиби	79	2.95
Пакистан	80	2.94
Монгол	81	2.93
Уганда	82	2.93
Мозамбик	83	2.91
Гүрж	84	2.84
Украин	85	2.82
Танзани	86	2.81
Азербайжан	87	2.79
Шри Ланк	88	2.79
Молдав	89	2.76
Нигери	90	2.74
Македон	91	2.73
Вьетнам	92	2.72
Албани	93	2.69
Армян	94	2.69
Гондурас	95	2.68
Гватемал	96	2.67
Гамби	97	2.65
Зимбабве	98	2.62
Босни Герцеговин	99	2.61
Эквадор	100	2.61
Бангладеш	101	2.60
Никарагуа	102	2.52
Мали	103	2.52
Тажикстан	104	2.52
Камбож	105	2.51
Мадагскар	106	2.48
Малави	107	2.46
Болив	108	2.42
Зүүн Тимор	109	2.42
Камерун	110	2.36
Парагвай	111	2.35
Гайана	112	2.34
БН Киргиз Улс	113	2.34
Алжир	114	2.29
Этиоп	115	2.22
Бенин	116	2.09
Чад	117	1.80

Төрийн институциудийн индекс

Улс	Байр	Оноо
Турк	61	4.25
Болгар	62	4.23
Молдав	63	4.20
Польш	64	4.14
Ямайк	65	4.14
Армян	66	4.11
Азербайжан	67	4.09
Малави	68	4.08
Серб ба Монтенегро	69	4.07
Бразил	70	4.06
Мексик	71	4.03
Мали	72	4.00
Хорват	73	3.99
Аргентин	74	3.96
Панам	75	3.90
Казакстан	76	3.89
Гамби	77	3.88
Румын	78	3.84
Этиоп	79	3.79
Зимбабве	80	3.79
Алжир	81	3.77
Никарагуа	82	3.74
Тринадад Тобаго	83	3.73
Болив	84	3.71
Марокко	85	3.69
Босни Герцеговин	86	3.67
Гүрж	87	3.65
Гондурас	88	3.61
Индонези	89	3.58
Украин	90	3.56
ОХУ	91	3.55
Мозамбик	92	3.54
Монгол	93	3.53
Кени	94	3.50
Уганда	95	3.49
Македон	96	3.47
Вьетнам	97	3.43
Нигери	98	3.43
Мадагскар	99	3.39
Шри Ланк	100	3.34
Тажикстан	101	3.33
Албани	102	3.32
Пакистан	103	3.31
Филиппин	104	3.30
БН Доминикан Улс	105	3.24
Венесуэл	106	3.23
Гватемал	107	3.22
Зүүн Тимор	108	3.20
Гайана	109	3.10
Бенин	110	3.06
Камерун	111	3.05
Парагвай	112	2.97
Эквадор	113	2.93
Камбож	114	2.90
БН Киргиз Улс	115	2.89
Чад	116	2.64
Бангладеш	117	2.55

Макро эдийн засгийн орчны индекс

Улс	Байр	Оноо
Колумби	61	3.95
Болгар	62	3.95
Унгар	63	3.91
Индонези	64	3.89
Намиби	65	3.84
Гана	66	3.82
Марокко	67	3.82
Хорват	68	3.76
Пакистан	69	3.74
Перу	70	3.71
Филиппин	71	3.69
Танзани	72	3.65
Румын	73	3.65
Панам	74	3.60
Македон	75	3.58
Нигери	76	3.54
Армян	77	3.53
Украин	78	3.52
Бразил	79	3.50
Эквадор	80	3.50
Гватемал	81	3.47
Коста Рика	82	3.44
Бангладеш	83	3.43
Уругвай	84	3.40
Венесуэл	85	3.39
Аргентин	86	3.37
Турк	87	3.34
Уганда	88	3.30
Гондурас	89	3.25
Гүрж	90	3.25
Босни Герцеговин	91	3.23
Албани	92	3.20
Зүүн Тимор	93	3.18
Шри Ланк	94	3.17
Тажикстан	95	3.17
Молдав	96	3.14
Мали	97	3.13
Мозамбик	98	3.13
Ямайк	99	3.13
Камерун	100	3.12
Бенин	101	3.08
Парагвай	102	3.07
Болив	103	3.05
Камбож	104	3.04
Монгол	105	3.03
Кени	106	3.01
Гамби	107	3.01
Этиоп	108	2.99
Мадагскар	109	2.98
Никарагуа	110	2.96
Серб ба Монтенегро	111	2.95
БН Доминикан Улс	112	2.78
Гайана	113	2.77
Чад	114	2.67
БН Киргиз Улс	115	2.62
Малави	116	2.47
Зимбабве	117	2.25

Хүснэгт 4. Технологийн индексийн бүрэлдэхүүн хэсгүүд

Улс	Технологийн индекс		Шинийг санаачлалтын индекс		МХТ-ийн дэд индекс		Тех. шилжүүлгийн дэд индекс	
	Байр	Оноо	Байр	Оноо	Байр	Оноо	Байр	Оноо
Албани	93	2.69	94	1.75	91	1.91	66	4.05
Алжир	114	2.29	84	2.01	110	1.80	89	3.03
Аргентин	59	3.35	34	3.18	59	2.51	39	4.54
Армян	94	2.69	71	2.21	97	1.88	70	3.92
Австрали	14	4.82	15	4.36	9	5.27	-	-
Австри	21	4.35	21	3.97	18	4.74	-	-
Азербайжан	87	2.79	81	2.05	78	2.21	72	3.81
Бахрейн	41	3.73	52	2.45	42	3.08	19	5.01
Бангладеш	101	2.60	105	1.61	112	1.73	59	4.10
Бельги	28	4.18	19	4.20	26	4.17	-	-
Бенин	116	2.09	113	1.44	104	1.82	91	2.66
Болив	108	2.42	59	2.38	106	1.81	86	3.25
Босни Герцеговин	99	2.61	82	2.02	76	2.22	84	3.33
Ботсвани	76	2.99	98	1.69	75	2.23	46	4.44
Бразил	50	3.51	68	2.25	52	2.70	18	5.02
Болгар	61	3.31	50	2.47	48	2.91	58	4.12
Камбож	105	2.51	110	1.49	113	1.67	68	3.97
Камерун	110	2.36	106	1.61	107	1.81	85	3.33
Канад	15	4.79	11	4.69	16	4.89	-	-
Чад	117	1.80	117	1.30	117	1.39	92	2.52
Чили	35	3.93	38	2.86	37	3.37	17	5.04
Хятад	64	3.18	75	2.15	60	2.48	43	4.47
Колумби	74	3.01	67	2.26	71	2.28	53	4.24
Коста Рика	56	3.39	72	2.20	58	2.52	22	4.95
Хорват	51	3.48	48	2.54	40	3.19	56	4.18
Кипр	36	3.87	51	2.46	29	3.88	50	4.32
БН Чех Улс	22	4.31	39	2.80	31	3.75	2	5.57
Дани	5	5.30	10	4.70	1	5.90	-	-
БН Доминикан Улс	67	3.13	55	2.42	65	2.35	47	4.40
Зүүн Тимор	109	2.42	103	1.62	115	1.58	74	3.80
Эквадор	100	2.61	87	1.88	95	1.89	73	3.81
Египет	58	3.36	64	2.36	68	2.33	14	5.07
Эль Сальвадор	70	3.09	85	2.00	66	2.34	45	4.46
Эстони	18	4.62	27	3.51	21	4.56	15	5.07
Этиоп	115	2.22	116	1.36	116	1.50	83	3.47
Финлянд	2	6.02	2	6.43	5	5.61	-	-
Франц	24	4.26	20	4.05	22	4.46	-	-
Гамби	97	2.65	112	1.45	93	1.90	65	4.05
Гүрж	84	2.84	60	2.38	87	2.03	62	4.08
Герман	16	4.78	9	4.92	20	4.63	-	-
Гана	69	3.11	96	1.71	82	2.08	21	4.95
Грек	37	3.85	24	3.54	38	3.36	35	4.62
Гватемал	96	2.67	95	1.72	100	1.84	61	4.09
Гайана	112	2.34	111	1.48	94	1.90	88	3.22
Гондурас	95	2.68	90	1.80	101	1.84	60	4.09
Гонконг	26	4.21	32	3.19	10	5.23	-	-
Унгар	30	4.08	36	3.10	35	3.46	8	5.24
Исланд	9	5.16	14	4.45	2	5.88	-	-
Энэтхэг	55	3.42	76	2.13	67	2.33	6	5.32
Индонези	66	3.13	80	2.05	85	2.04	23	4.95
Ирланд	31	4.07	22	3.82	24	4.33	-	-
Израиль	12	4.87	6	5.38	23	4.37	-	-
Итали	44	3.68	30	3.38	28	3.98	-	-
Ямайк	45	3.64	78	2.11	46	2.97	16	5.05
Япон	8	5.24	5	5.74	17	4.75	-	-
Иордан	52	3.46	47	2.57	53	2.66	31	4.82
Казакстан	77	2.99	41	2.79	74	2.24	64	4.05
Кени	71	3.04	97	1.70	108	1.81	12	5.14
БН Солонгос Улс	7	5.26	8	5.29	11	5.23	-	-
Кувейт	48	3.56	69	2.23	45	3.01	33	4.73
БН Киргиз Улс	113	2.34	63	2.36	90	1.91	90	2.91
Латви	38	3.83	25	3.52	39	3.36	36	4.57

Хүснэгт 4. Технологийн индексийн бүрэлдэхүүн хэсгүүд /үргэлжлэл/

Улс	Технологийн индекс		Шинийг санаачлалтын индекс		МХТ-ийн дэд индекс		Тех. шилжүүлгийн дэд индекс	
	Байр	Оноо	Байр	Оноо	Байр	Оноо	Байр	Оноо
Литва	42	3.70	26	3.51	41	3.15	41	4.48
Люксембург	29	4.11	37	3.03	13	5.19	-	-
Македон	91	2.73	77	2.11	70	2.29	82	3.51
Мадагаскар	106	2.48	108	1.54	102	1.83	77	3.66
Малави	107	2.46	115	1.42	114	1.66	71	3.88
Малайз	25	4.22	40	2.80	33	3.56	1	5.57
Мали	103	2.52	109	1.53	88	1.98	80	3.57
Мальт	23	4.29	58	2.40	25	4.32	26	4.89
Мавритани	47	3.57	79	2.07	47	2.93	25	4.93
Мексик	57	3.39	73	2.20	57	2.57	57	4.88
Молдав	89	2.76	74	2.19	72	2.27	78	3.59
Монгол	81	2.93	53	2.44	71	2.08	55	4.23
Марокко	78	2.96	93	1.77	83	2.07	38	4.54
Мозамбик	83	2.91	114	1.43	105	1.81	28	4.87
Намиби	79	2.95	91	1.79	80	2.11	42	4.47
Нидерланд	11	4.88	17	4.33	7	5.43	-	-
Шинэ Зеланд	19	4.47	18	4.22	19	4.71	-	-
Никарагуа	102	2.52	86	1.89	109	1.80	75	3.69
Нигери	90	2.74	99	1.69	103	1.83	51	4.30
Норвеги	13	4.87	12	4.62	14	5.12	-	-
Пакистан	80	2.94	100	1.65	77	2.21	49	4.35
Панам	65	3.17	42	2.75	73	2.24	37	4.54
Парагвай	111	2.35	83	2.01	111	1.77	87	3.24
Перу	75	3.01	62	2.36	84	2.07	40	4.49
Филиппин	54	3.43	65	2.34	63	2.42	11	5.15
Польш	39	3.77	31	3.22	43	3.03	24	4.94
Португал	20	4.39	35	3.15	30	3.84	3	5.55
Катар	40	3.76	70	2.22	44	3.02	7	5.25
Румын	49	3.53	54	2.44	50	2.71	20	4.97
Оросын Холбооны Улс	73	3.01	29	3.41	62	2.43	76	3.66
Серб ба Монтенегро	68	3.12	61	2.37	64	2.36	48	4.37
Сингапур	10	4.93	13	4.47	8	5.40	-	-
БН Словак Улс	34	3.99	46	2.62	36	3.41	9	5.21
Словени	32	4.07	23	3.60	27	4.06	54	4.23
Өмнөд Африк	46	3.62	66	2.27	55	2.63	4	5.39
Испани	27	4.21	28	3.44	32	3.74	13	5.09
Шри Ланк	88	2.29	101	1.65	89	1.94	52	4.30
Швед	4	5.78	4	5.89	4	5.66	-	-
Швейцарь	6	5.29	7	5.37	12	5.21	-	-
Тайвань	3	5.85	3	6.19	6	5.51	-	-
Тажикстан	104	2.52	89	1.85	92	1.91	81	3.56
Танзани	86	2.81	107	1.54	96	1.89	44	4.46
Тайланд	43	3.69	43	2.72	51	2.70	5	5.33
Тринадад Тобаго	62	3.25	92	1.77	61	2.43	30	4.84
Тунис	60	3.35	57	2.41	56	2.61	34	4.64
Турк	53	3.45	56	2.42	54	2.66	29	4.85
Уганда	82	2.93	104	1.62	98	1.84	32	4.82
Украин	85	2.82	33	3.19	79	2.17	79	3.57
Арабын Нэгдсэн Эмират	33	4.04	44	2.67	34	3.53	10	5.16
Их Британи	17	4.66	16	4.35	15	4.98	-	-
Америкийн Нэгдсэн Улс	1	6.19	1	6.66	3	5.72	-	-
Уругвай	63	3.19	49	2.50	49	2.71	63	4.07
Венесуэл	72	3.03	45	2.67	69	2.30	57	4.13
Вьетнам	92	2.72	88	1.87	86	2.04	69	3.92
Зимбабве	98	2.62	102	1.64	99	1.84	67	3.98

Хүснэгт 5. Төрийн институцийн индексийн бүрэлдэхүүн хэсгүүд

Улс	Төрийн институцийн индекс		Гэрээ, эрх зүйн дэд индекс		Авилгалын дэд индекс	
	Байр	Оноо	Байр	Оноо	Байр	Оноо
Албани	102	3.32	108	2.80	93	3.84
Алжир	81	3.77	67	3.66	91	3.87
Аргентин	74	3.96	100	2.98	57	4.94
Армян	66	4.11	72	3.51	61	4.70
Австрали	10	6.01	10	5.67	10	6.35
Австри	11	6.00	13	5.61	9	6.39
Азербайжан	67	4.09	61	3.75	72	4.44
Бахрейн	38	5.10	39	4.54	34	5.65
Бангладеш	117	2.55	104	2.88	117	2.22
Бельги	28	5.38	23	5.11	35	5.65
Бенин	110	3.06	95	3.12	113	3.00
Болив	84	3.71	97	3.05	75	4.36
Босни Герцеговин	86	3.67	101	2.97	74	4.36
Ботсвани	39	5.08	30	4.93	48	5.23
Бразил	70	4.06	77	3.42	62	4.70
Болгар	62	4.23	103	2.90	38	5.57
Камбож	114	2.90	102	2.91	115	2.89
Камерун	111	3.05	91	3.15	114	2.95
Канад	21	5.67	24	5.09	17	6.24
Чад	116	2.64	113	2.54	116	2.73
Чили	22	5.58	34	4.88	13	6.29
Хятад	56	4.41	62	3.74	50	5.08
Колумби	49	4.55	83	3.32	30	5.79
Коста Рика	58	4.32	49	4.16	68	4.48
Хорват	73	3.99	80	3.33	65	4.66
Кипр	27	5.44	25	5.09	31	5.78
БН Чех Улс	48	4.63	50	4.11	49	5.15
Дани	2	6.35	1	6.17	4	6.54
БН Доминикан Улс	105	3.24	106	2.85	99	3.63
Зүүн Тимор	108	3.20	96	3.06	107	3.34
Эквадор	113	2.93	115	2.30	101	3.56
Египет	53	4.46	45	4.37	67	4.55
Эль Сальвадор	54	4.45	70	3.56	44	5.33
Эстони	25	5.51	35	4.87	21	6.16
Этиоп	79	3.79	75	3.47	84	4.12
Финлянд	5	6.19	3	5.90	5	6.49
Франц	20	5.72	18	5.30	22	6.15
Гамби	77	3.88	55	4.05	97	3.71
Гүрж	87	3.65	84	3.25	87	4.04
Герман	8	6.04	6	5.88	20	6.19
Гана	51	4.54	36	4.79	77	4.29
Грек	43	4.77	40	4.53	54	5.00
Гватемал	107	3.22	114	2.47	89	3.97
Гаяна	109	3.10	110	2.74	105	3.45
Гондурас	88	3.61	107	2.82	73	4.40
Гонконг	23	5.58	22	5.16	26	5.99
Унгар	34	5.15	43	4.43	29	5.86
Исланд	3	6.33	4	5.89	1	6.78
Энэтхэг	52	4.52	37	4.78	78	4.26
Индонези	89	3.58	66	3.66	103	3.49
Ирланд	13	5.93	11	5.63	18	6.24
Израиль	30	5.35	27	5.03	33	5.66
Итали	46	4.70	68	3.66	32	5.74
Ямайк	65	4.14	74	3.47	58	4.81
Япон	14	5.84	21	5.24	8	6.44
Иордан	31	5.28	26	5.05	40	5.51
Казакстан	76	3.89	71	3.56	81	4.23
Кени	94	3.50	90	3.19	94	3.81
БН Солонгос Улс	42	4.78	41	4.53	52	5.04
Кувейт	37	5.11	31	4.91	45	5.31
БН Киргиз Улс	115	2.89	112	2.71	112	3.07
Латви	50	4.55	52	4.09	53	5.00

Хүснэгт 5. Төрийн институцийн индексийн бүрэлдэхүүн хэсгүүд /үргэлжлэл/

Улс	Төрийн институцийн индекс		Гэрээ, эрх зүйн дэд индекс		Авилгалын дэд индекс	
	Байр	Оноо	Байр	Оноо	Байр	Оноо
Литва	44	4.73	58	3.83	36	5.63
Люксембург	7	6.08	9	5.71	7	6.45
Македон	96	3.47	111	2.73	82	4.21
Мадагскар	99	3.39	88	3.23	100	3.56
Малави	68	4.08	56	3.95	83	4.21
Малайз	29	5.36	17	5.30	43	5.42
Мали	72	4.00	51	4.09	90	3.90
Мальт	32	5.23	29	4.95	41	5.51
Мавритани	55	4.41	53	4.07	59	4.76
Мексик	71	4.03	79	3.35	60	4.71
Молдав	63	4.20	93	3.12	47	5.28
Монгол	93	3.53	81	3.32	96	3.73
Марокко	85	3.69	60	3.76	98	3.63
Мозамбик	92	3.54	86	3.23	92	3.85
Намиби	57	4.38	54	4.06	63	4.69
Нидерланд	16	5.83	14	5.53	23	6.12
Шинэ Зеланд	1	6.35	2	5.97	2	6.74
Никарагуа	82	3.74	98	3.03	70	4.45
Нигери	98	3.43	69	3.59	109	3.27
Норвеги	6	6.13	7	5.80	6	6.45
Пакистан	103	3.31	87	3.23	106	3.39
Панам	75	3.90	63	3.72	86	4.08
Парагвай	112	2.97	117	2.17	95	3.77
Перу	59	4.27	99	2.98	39	5.55
Филиппин	104	3.30	82	3.32	108	3.28
Польш	64	4.14	65	3.68	66	4.61
Португал	15	5.83	19	5.46	19	6.20
Катар	19	5.75	15	5.52	27	5.98
Румын	78	3.84	85	3.25	71	4.44
Оросын Холбооны Улс	91	3.55	109	2.78	76	4.33
Серб ба Монтенегро	69	4.07	92	3.14	55	5.00
Сингапур	4	6.25	5	5.88	3	6.62
БН Словак Улс	45	4.73	57	3.85	37	5.61
Словени	35	5.14	48	4.28	25	6.01
Өмнөд Африк	47	4.63	46	4.31	56	4.96
Испани	36	5.13	47	4.30	28	5.95
Шри Ланк	100	3.34	89	3.21	104	3.48
Швед	17	5.82	19	5.30	11	6.34
Швейцарь	9	6.02	8	5.79	15	6.26
Тайвань	26	5.47	33	4.88	24	6.07
Тажикстан	101	3.33	76	3.46	110	3.20
Танзани	60	4.25	44	4.40	85	4.09
Тайланд	41	4.88	42	4.48	46	5.28
Тринадад Тобаго	83	3.73	78	3.41	88	4.04
Тунис	40	5.02	28	4.99	51	5.04
Турк	61	4.25	59	3.82	64	4.68
Уганда	95	3.49	73	3.48	102	3.51
Украин	90	3.56	105	2.87	79	4.26
Арабын Нэгдсэн Эмират	25	5.52	38	4.78	16	6.25
Их Британи	12	5.98	12	5.62	12	6.33
Америкийн Нэгдсэн Улс	18	5.77	20	5.27	14	6.27
Уругвай	33	5.19	32	4.91	42	5.48
Венесуэл	106	3.23	116	2.22	80	4.25
Вьетнам	97	3.43	64	3.71	111	3.16
Зимбабве	80	3.79	94	3.12	69	4.46

Хүснэгт 6. Макро эдийн засгийн орчны индексийн бүрэлдэхүүн хэсгүүд

Улс	Макро эдийн засгийн орчны индекс		Макро эдийн засгийн тогтвортой байдлын дэд индекс		Засгийн газрын үргүй зардал		Улсын зээлжих зэрэглэл	
	Байр	Оноо	Байр	Оноо	Байр	Оноо	Байр	Оноо
Албани	92	3.20	85	4.10	95	2.57	96	2.02
Алжир	44	4.33	12	5.30	51	3.30	68	3.44
Аргентин	86	3.37	50	4.59	91	2.61	107	1.68
Армян	77	3.53	55	4.52	63	3.12	98	1.97
Австрали	14	5.21	25	5.05	16	4.34	18	6.39
Австри	22	5.07	38	4.73	22	4.07	12	6.76
Азербайжан	56	4.05	18	5.13	57	3.19	78	2.74
Бахрейн	32	4.62	20	5.11	36	3.68	47	4.58
Бангладеш	83	3.43	67	4.36	85	2.68	86	2.30
Бельги	29	4.76	52	4.56	50	3.33	16	6.61
Бенин	101	3.08	92	4.03	104	2.33	101	1.92
Болив	103	3.05	105	3.69	97	2.51	87	2.29
Босни Герцеговин	91	3.23	70	4.30	110	2.14	89	2.17
Ботсвани	36	4.55	53	4.56	15	4.37	43	4.70
Бразил	79	3.50	81	4.14	111	2.13	62	3.58
Болгар	62	3.95	51	4.59	89	2.65	56	3.96
Камбож	104	3.04	100	3.78	70	2.94	107	1.68
Камерун	100	3.12	87	4.09	102	2.36	100	1.94
Канад	16	5.16	23	5.07	33	3.76	13	6.74
Чад	114	2.67	110	3.56	114	1.80	104	1.73
Чили	15	5.20	3	5.66	19	4.23	32	5.25
Хятад	33	4.61	27	5.02	44	3.45	37	4.96
Колумби	61	3.95	48	4.61	66	3.02	65	3.55
Коста Рика	82	3.44	109	3.62	83	2.69	60	3.85
Хорват	68	3.76	90	4.05	74	2.84	55	4.10
Кипр	45	4.33	76	4.21	30	3.83	36	5.05
БН Чех Улс	46	4.31	44	4.64	78	2.80	34	5.15
Дани	3	5.64	11	5.31	4	5.12	8	6.83
БН Доминикан Улс	112	2.78	108	3.63	115	1.72	92	2.14
Зүүн Тимор	93	3.18	93	4.03	61	3.15	113	1.51
Эквадор	80	3.50	33	4.84	113	1.95	84	2.35
Египет	55	4.07	59	4.47	34	3.75	64	3.57
Эль Сальвадор	57	4.03	63	4.42	35	3.71	62	3.58
Эстони	30	4.73	14	5.27	43	3.45	38	4.93
Этиоп	108	2.99	106	3.66	59	3.16	114	1.50
Финлянд	4	5.52	13	5.30	10	4.61	4	6.87
Франц	27	4.90	61	4.43	29	3.88	7	6.84
Гамби	107	3.01	113	3.45	45	3.43	106	1.69
Гүрж	90	3.25	74	4.23	69	2.96	111	1.58
Герман	28	4.81	65	4.38	37	3.67	10	6.81
Гана	66	3.82	66	4.37	21	4.18	83	2.37
Грек	51	4.16	96	3.91	60	3.15	25	5.68
Гватемал	81	3.47	73	4.24	106	2.30	72	3.11
Гаяна	113	2.77	115	3.13	86	2.67	92	2.14
Гондурас	89	3.25	84	4.11	94	2.59	88	2.22
Гонконг	8	5.34	6	5.55	11	4.60	26	5.66
Унгар	63	3.91	95	3.93	73	2.88	40	4.90
Исланд	11	5.24	21	5.10	6	4.97	23	5.80
Энэтхэг	50	4.17	41	4.68	63	3.12	53	4.20
Индонези	64	3.89	56	5.51	40	3.58	75	2.94
Ирланд	7	5.38	7	5.47	28	3.89	14	6.68
Израиль	48	4.25	62	4.42	41	3.50	44	4.68
Итали	47	4.26	89	4.08	87	2.66	20	6.22
Ямайк	99	3.13	107	3.63	88	2.66	80	2.59
Япон	42	4.40	78	4.19	68	2.96	19	6.28
Иордан	52	4.10	57	4.50	23	4.03	70	3.39
Казакстан	41	4.42	24	5.06	39	3.60	57	3.95
Кени	106	3.01	99	3.81	105	2.32	94	2.10
БН Солонгос Улс	25	4.98	8	5.38	32	3.77	28	5.39
Кувейт	21	5.09	1	5.72	38	3.63	31	5.26
БН Киргиз Улс	115	2.62	114	3.25	107	2.30	109	1.67
Латви	38	4.48	28	5.00	49	3.34	48	4.57

Хүснэгт 6. Макро эдийн засгийн орчны индексийн бүрэлдэхүүн хэсгүүд /үргэлжлэл/

Улс	Макро эдийн засгийн орчны индекс		Макро эдийн засгийн тогтвортой байдлын дэд индекс		Засгийн газрын үргүй зардал		Улсын зээлжих зэрэглэл	
	Байр	Оноо	Байр	Оноо	Байр	Оноо	Байр	Оноо
Литва	39	4.47	29	4.91	46	3.41	46	4.63
Люксембург	9	5.30	26	5.04	18	4.25	3	6.88
Македон	75	3.58	46	4.62	84	2.69	81	2.40
Мадагаскар	109	2.98	112	3.50	47	3.37	112	1.56
Малави	116	2.47	117	2.83	92	2.60	110	1.62
Малайз	19	5.12	19	5.12	2	5.13	35	5.12
Мали	97	3.13	104	3.73	56	3.21	102	1.87
Мальт	54	4.09	80	4.15	79	2.77	30	5.28
Мавритани	59	4.10	86	4.09	41	3.50	51	4.35
Мексик	43	4.35	36	4.76	55	3.22	45	4.65
Молдав	96	3.14	75	4.22	80	2.75	115	1.39
Монгол	105	3.03	94	3.96	109	2.22	97	1.98
Марокко	67	3.82	88	4.09	54	3.23	58	3.87
Мозамбик	98	3.13	102	3.76	72	2.91	95	2.08
Намиби	65	3.84	71	4.30	52	3.24	66	3.51
Нидерланд	10	5.26	39	4.69	9	4.81	9	6.82
Шинэ Зеланд	20	5.10	22	5.09	25	4.02	21	6.18
Никарагуа	110	2.96	97	3.88	101	2.38	105	1.72
Нигери	76	3.54	45	4.64	81	2.74	91	2.14
Норвеги	2	5.76	5	5.61	8	4.86	2	6.94
Пакистан	69	3.74	49	4.61	48	3.35	82	2.39
Панам	74	3.60	91	4.03	99	2.45	59	3.86
Парагвай	102	3.07	79	4.16	117	1.62	85	2.34
Перу	70	3.71	54	4.53	103	2.34	67	3.45
Филиппин	71	3.69	58	4.49	100	2.44	71	3.35
Польш	53	4.09	68	4.33	77	2.80	39	4.92
Португал	37	4.51	64	4.40	58	3.17	22	6.08
Катар	6	5.40	4	5.66	3	5.13	33	5.17
Румын	73	3.65	83	4.13	90	2.64	61	3.70
Оросын Холбооны Улс	58	4.02	42	4.65	93	2.59	54	4.19
Серб ба Монтенегро	111	2.95	101	3.77	108	2.28	98	1.97
Сингапур	1	5.82	10	5.36	1	5.90	15	6.64
БН Словак Улс	49	4.23	40	4.69	82	2.70	41	4.82
Словени	35	4.57	35	4.78	62	3.15	27	5.55
Өмнөд Африк	31	4.68	30	4.90	14	4.41	49	4.53
Испани	24	5.07	31	4.87	24	4.02	17	6.51
Шри Ланк	94	3.17	103	3.75	98	2.47	79	2.70
Швед	12	5.24	16	5.20	31	3.77	11	6.79
Швейцарь	13	5.23	37	4.76	13	4.43	1	7.00
Тайвань	17	5.15	17	5.15	12	4.53	24	5.76
Тажикстан	95	3.17	72	4.28	71	2.91	116	1.19
Танзани	72	3.65	77	4.21	26	4.02	89	2.17
Тайланд	26	4.94	9	5.37	17	4.32	42	4.70
Тринадад Тобаго	40	4.44	15	5.23	75	2.83	50	4.48
Тунис	34	4.59	43	4.65	7	4.86	52	4.20
Турк	87	3.34	111	3.56	76	2.82	69	3.41
Уганда	88	3.30	82	4.13	65	3.08	102	1.87
Украин	78	3.52	69	4.31	96	2.54	76	2.92
Арабын Нэгдсэн Эмират	5	5.43	2	5.70	5	5.00	29	5.32
Их Британи	18	5.13	32	4.86	27	3.94	4	6.87
Америкийн Нэгдсэн Улс	23	5.07	47	4.61	20	4.21	6	6.85
Уругвай	84	3.40	98	3.85	67	2.99	77	2.92
Венесуэл	85	3.39	60	4.46	116	1.71	74	2.95
Вьетнам	60	3.96	34	4.80	52	3.24	73	3.01
Зимбабве	117	2.25	116	3.00	112	2.00	117	1.00

Хайрцаг 1. Итали улс хэтэрхий доогуур байр эзлэв үү?

Өсөлтийн өрсөлдөх чадварын индексэд Итали улсын зэрэглэл буурах хандлагатай байж, 2001 онд 26 дугаар байранд байсан бол 2004, 2005 онуудад хоёуланд нь 47 дугаар байр эзэлжээ. ЕХ-ны 25 орноос ганцхан Польш л түүнээс доогуур байрт буюу 51 дүгээрт бичигдсэн байна. Ийнхүү Итали улсын өрсөлдөөний байр суурь эрс буурч байгааг тайлбарлах хүчин зүйлсийг нягтлан шалгах нь зүйтэй.

Нэгдүгээрт, макро эдийн засгийн талаас авч үзвэл Италийн улсын салбарын дансны үзүүлэлтүүд нилээд тогтвортой муудаж байна. 1990-ээд оны үед тус улс еврогийн бүсэд гишүүнээр шалгарах хүчин чармайлт тавьсны үр дүнд төсвийг хяналтдаа оруулах талаар мэдэгдэхүйц ахиц дэвшил гаргажээ. Үнэхээр ч 2000 он гэхэд төсвийн алдагдал хэдэн арван жилийн хугацаанд анх удаа ДНБ-ий 1 хувиас доогуур гараад байв. Гэвч ОУВС-гаас гаргасан сүүлийн үеийн тоон мэдээллээс үзэхэд түүнээс хойш тус улс ихээхэн (улам өссөөр байгаа) төсвийн алдагдал хүлээж ирсэн бөгөөд цаашид сайжрах ирээдүй муутай буюу 2006 онд хүлээх алдагдал (ДНБ-ий 4.3%) нь 2005 оны түвшнээс ч их гарах төлөвтэй байна. Сүүлийн арван жилийн эхэн үед аль хэдийн ДНБ-ээсээ 100% хэтрээд байсан улсын өрийн түвшин нь улам бүр өндөрсөөр байна. Италийн өсөлтийн үйл явц туйлын удаан байж, хурдаа огцом саах хандлагатай болжээ. 1980-1990 онд ДНБ нь дунджаар 2.3 хувиар өсч байснаас хойш 1991-2000 онд 1.3 хувь болон удааширч, улмаар 2001-2005 онд 1.1 хувь болж унасан байна. Энэ байдал нь бизнесийн салбарынханы сэтгэл санаанд нилээд муугаар нөлөөлсөнд гайхах зүйлгүй. Ялангуяа хувийн салбарынхан богино хугацааны хэтийн төлвийг хэрхэн үзэж байгааг хэмждэг манай Судалгааны үзүүлэлт болох «үхрэлтын тухай хүлээлт» хэмээх үзүүлэлтээр Итали улс онцгой доогуур байрт буюу энэ жилийн зэрэглэлээр дэлхийд 110-т оржээ.

Хоёрдугаарт, технологийн талаас авч үзвэл Итали улс дэлхийд 44 дүгээрт орж байгаа нь энэ зэрэглэлд ЕХ-нд багтдаг Их 7-гийн туншүүд болох Герман 16-д, Их Британи 17-д, Франц 24-т орсныг тооцвол нилээн доогуур үзүүлэлт юм. ӨӨЧИ-ийн технологийн индексэд олон тооны хатуу тогтсон тоон үзүүлэлтүүд (хувийн компьютер ашиглалт, интернетэд холбогдсон байдал, утсан харилцааны тогтмол шугам, шинэ санаачлагын хэмжүүр болох патент бүртгүүлэлт, аливаа орны ирээдүйн шинэ санаачлагын чадамжийг харуулах тэргүүлэх үзүүлэлт болох их, дээд сургуульд хамрагдалтын түвшин) ордог бөгөөд энэ үзүүлэлтээр Итали улсын эзэлсэн байр нь тус улсын хөгжлийн түвшин, нэг хүнд ноогдох орлогын түвшинтэй харьцуулахад барагтай үзүүлэлт юм. Тухайлбал, Италид хувийн компьютерийн ашиглалт Өмнөд Солонгос, Тайвань, Эстони, Ирланд,

Словени, Кипр, Мальт, Словак зэрэг орныхоос доогуур байна. Патент бүртгүүлэлтийн хувиар Итали улс Израиль, Өмнөд Солонгос, Ирланд, Хонг Конг, Шинэ Зеландаас доогуур яваа бөгөөд үнэн хэрэгтээ ӨӨЧИ-д тодорхойлсон 25 «үндсэн шинийг санаачлагч»-дын дунд сүүл барьж байна.

Дээрх үнэлгээнүүд нь дийлэнхдээ хатуу тогтсон тоон хувьсагчуудад тулгуурласны (иймээс зүгээр нэг бизнесийн салбарынханы субъектив үзэл бодлыг тусгасан гэдэг шүүмжлэлээс ангид) зэрэгцээ ӨӨЧИ-д ашигласан төрийн институциудийн үзүүлэлтээр Итали улс хамгийн сул дорой байгаа нь тухайлбал гэрээ, эрх зүйн орчны ерөнхий байдлын хувьд тус улс 68 дугаарт орсон доогуур байр эзэлснээр харагдаж байна. Нэн ялангуяа санаа зовоосон асуудал бол шүүхийн системийн хараат бус байдал дутагддаг (59-т), засгийн газар гэрээний болон бодлогын шийдвэр гаргахдаа холбоо харилцаа сайтай компаниудаа илүүд үздэг гэсэн ойлголт байдаг (72-т), Италийн бизнест зохион байгуулалттай гэмт хэргийн зүгээс учруулдаг зардал өндөр байдаг (103-т) явдал юм. Хэдийгээр эдгээр ойлголтод субъектив байдлын түвшин оролцдогт эргэлзэх зүйлгүй боловч бас заавал андуу ташаа байх албагүй. 2005 оны турш олон улсын тэргүүлэх хэвлэлүүдээр Италийн эдийн засгийн тухай хэд хэдэн таагүй шинжилгээний дүн гарч байсан. Тухайлбал, Экономист¹ сэтгүүлд гарсан нэг өгүүлэлд Италийн корпорацийн засаглалын тогтолцоон дахь хурц тод дутагдалууд болон «улс төрийн сүлбээ, тал тохой татах байдлыг» харуулах өргөн хүрээтэй нотлох баримт байгаа тухай бичжээ. Үнэндээ өнгөрсөн жилийн турш гарсан олон дуулиант хэргүүд хүмүүсийн итгэх итгэлд сөргөөр нөлөөлсөн биз. Файнаншиал Таймс ч Экономист сэтгүүлийн нэрлэсэн «ер бусын тууль» гэгчид анхаарал хандуулсан нь Италийн зарим банкны хувьцааг Европын хаа нэгтээ байдаг банкууд худалдан авахыг оролдсон бөгөөд үүнд Италийн Төв Банкаас² хүчтэй эсэргүүцэл илэрхийлсэн тухай байлаа.

Эдгээр тодорхой хүчин зүйлсээс гадна, амжилт олохын тулд бага зардалд тулгуурлахыг шаарддаг, олон улсын өрсөлдөөнд улам бүр нэрвэгдэж байгаа, боловсруулалтын нэмэгдэл багатай үйлдвэрлэлийн салбаруудад (сүлжмэл эдлэл, хувцас, гутал, цагаан хэрэгсэл гэх мэт) хэт их найддаг нь Итали улсын өрсөлдөх чадварыг хойш татаж байна. Мөн еврог авч хэрэглэх болсноор бага өртөгтэй бааз сууриа хэвээр хадгалах нэг арга зам болсон валютын ханшаа бууруулах боломжоо үүрд алдсан байна. Цаашилбал Италийн ажилчид дэлхий дээр хамгийн цалин сайтай, хамгийн их хамгаалагдсан ажилчдын тоонд ордог учраас Италийн компаниуд ажиллах хүчний энэхүү өндөр зардлыг даван туулах шаардлагатай болсон байна.³

Хайрцаг 1. Итали улс хэтэрхий доогуур байр эзлэв үү? /үргэлжлэл/

Дэлхий Дахины Өрсөлдөх Чадварын Индексэд Итали улс 38 дугаар байр эзэлсэн нь зарим талаар ӨӨЧИ-ийнхээс арай дээр үзүүлэлт бөгөөд энэ нь тус улс эрүүл мэнд, бага боловсролын үзүүлэлтээр өндөр оноо авсан, мөн бизнесийн боловсронгуй байдлаар түүнээс бага гэлтгүй өндөр үнэлгээ авсантай нь холбоотой. Энэ бүхнийг харгалзвал Итали улс хэтэрхий доогуур зэрэглэлд байна гэж бид үзэхгүй байна. Нөгөө талаас, Дэлхийн Эдийн Засгийн Форумын индексүүд Итали улсын өрсөлдөх чадварын алдаа дутагдлыг нилээн сайн илэрхийлж чадсан юм шиг санагдаж байна. Өрсөлдөх чадварын ямар хэмжүүр ашигласныг эс харгалзан, хэрвээ Итали улсын өрсөлдөх чадварын зэрэглэлийг дээшлүүлбэ гэвэл ялангуяа төсвийн бодлого, институцийн орчныг бэхжүүлэх чиглэлд хүнд сорилтууд хүлээж байгаа нь тодорхой байна.

Тайлбар

- 1 The Economist /Экономист/ сэтгүүлийн 2005 оны дугаарт гарсан "Европын жинхэнэ өвчтэй хүн" нийтлэлийг үзнэ үү.
- 2 The London Financial Times /Лондон Файнаншиал Таймс/ сэтгүүлийн зарим дугаар, 2005 оны 2-6 дугаар сар
- 3 Энэ нь Итали улс еврог орхиж, төсвийн алдагдал ДНБ-ний 10%-тай тэнцүү, тэнгэрт тулсан өндөр хүүгийн хувьтай, тогтворгүй лир хэрэглэж байсан үедээ эргэж ор гэсэн үг биш юм. Харин тус улсын засгийн газар үйлдвэрлэлийн салбарын бүтээмж болон шинийг санаачлах чадамжаа дээшлүүлэхэд чиглэсэн бүтцийн болон микро эдийн засгийн шинэчлэлд анхаарлаа хандуулсан нь хамаагүй дээр байх болно. Бодлого боловсруулалт, хэрэгжүүлэлтийн хувьд Итали улс Аргентинаас илүү Финлянд шиг байхыг зорих ёстой.

холбоотой. Шинэ технологи авч хэрэглэхдээ идэвхтэй, мөн судалгаа, хөгжлийн ажилд ихээхэн хөрөнгө хүч зарцуулдаг компаниуд АНУ-д бий. Дээд боловсролд хамрагдалтын дэлхийн хамгийн өндөр хувьтай нь хосолсон энэ орчин шинийг санаачлалтын хүчирхэг соёл бүхий эдийн засгийн бааз суурийг бий болгож байна. Гэвч тус улсын авсан маш өндөр ерөнхий үнэлгээний үндэс болж буй технологийн хувьд үгүйсгэхийн аргагүй эрч хүчтэй байдлыг уг индексээр хэмждэг бусад чиглэлд нилээд тааруу амжилт үзүүлсэн явдал хойш татсан байна. Тус улсын институцийн орчин өрсөлдөөний нэг давуу тал биш болохыг ӨӨЧИ харуулж байна. ӨӨЧИ-д ашиглагддаг гэрээ, эрх зүйн үзүүлэлтээр л гэхэд АНУ 20 дугаар байр эзэлж харьцангуй доогуур үнэлгээ авсан бөгөөд ялангуяа тус улсын засгийн газар бодлогыг ерөнхийлөн боловсруулахдаа хувийн салбартай илүү ойр дотно харилцаж чадахгүй байгаа талаар бизнесийн салбарынханы зүгээс санаа зовниж байгаатай холбоотой. Харин тус улсын хамгийн том сул тал бол макро эдийн засгийн орчны тогтвортой байдлын асуудал бөгөөд энэ үзүүлэлтээр ерөнхийдөө доогуур буюу 47 дугаар байрт орсон байна. Энэ бол тус улсын макро эдийн засгийн тэнцвэргүй байдлын талаар, ялангуяа төрийн мөнгө санхүүгийн чиглэлд тавих олон улсын анхаарал эрчимжиж байгаа өнөөгийн нөхцөлд гайхаад байх зүйл биш юм. Олон Улсын Валютын Сангаас гаргасан хамгийн сүүлийн үеийн тоон мэдээллээр, АНУ 2005 онд ДНБ-ийхээ 4 хувиас давсан төсвийн алдагдалтай ажиллаж байгаа нь дөрөв дэх жилдээ дараалан үргэлжилж байгаа бөгөөд 2006 онд ч үүнтэй төстэй алдагдалтай ажиллах төлөвтэй байна. Мөн 2010 он хүртэл төсвийн нэмэлт зохицуулалт олигтой хийгдэхгүй байж магадгүй байна. Түүнчлэн үндэсний хуримтлалын хувь маш доогуур байх, төрийн өрийн түвшин нэмэгдэх зэрэг тодорхой сул талууд ажиглагдахаар байна. Ийнхүү макро эдийн засгийн гол үзүүлэлтүүдийн сул талууд нь ирэх жилүүдийн АНУ-ын өрсөлдөх чадварын ерөнхий зэрэглэлд төдийгүй дэлхийн нийт эдийн засагт үл хайхарч боломгүй эрсдэл учруулж, эрх баригчдын зүгээс ноцтой анхаарал шаардаж байгааг манай шинжилгээнүүд харуулж байна.

Сүүлийн жилүүдийн нэг адил Нордикийн бусад орон ч өрсөлдөх чадварын зэрэглэлд сайн хэвээр явна. Финлянд, АНУ хоёрын дараахь 3, 4 дүгээр байрт Швед, Дани хоёр тус тус дараалан орж байна. Тэдний араас

Хайрцаг 2. Энэтхэгийн өрсөлдөх чадварын зэрэглэлийг дээшлүүлэхэд юу хэрэгтэй вэ?

Энэ жилийн Өсөлтийн Өрсөлдөх Чадварын Индексээр Энэтхэг улс өнгөрсөн жилтэй харьцуулахад таван байр ахиж 50 дугаарт оржээ. Сүүлийн үед тус улсын гаргаж байгаа эдийн засгийн амжилтад эргэлзэх зүйлгүй нь өнгөрсөн цөөн хэдэн жилд ДНБ-ий өсөлт нь 7-гоос илүү хувьтай байгаагаар харагдаж байгаа бөгөөд улмаар ядуурлын гаралт бодитойгоор буурах боломж дагуулж байна¹.

Одоогоор тавигдаж байгаа гол асуулт бол Энэтхэг улс ирэх арван жилд өсөлтийн байдлаа үнэхээр хадгалж, хурдасгаж чадах эсэх тухай юм. Хятад улс их хэмжээний хотжилтын үйл явц өрнүүлж, түүнийхээ үр өгөөжийг хүртсэн шиг Энэтхэг улс ч үүнтэй төстэй өсөлтийг дэмжих «бүтцийн» онцлог буюу хүн ам зүйн тааламжтай нөхцөлтэй гэдэг нь маргаангүй. Ирэх хорин жилд тус улсад ажиллах насны хүн амын эзлэх хувь огцом өсөх болно. Харин үүний үр дүнг хүртэхийн тулд Энэтхэг улс залуучуудынхаа, ялангуяа ядуусынхаа бүтээмжийг дээшлүүлэх үүднээс боловсролд хөрөнгө зарцуулах, боловсролын байгууллагуудынхаа чанарыг дээшлүүлэх замаар асар олон залуучуудыг ажиллах хүчнийхээ эгнээнд оруулах арга замыг хайж олох шаардлагатай болно.

Мөн сүүлийн жилүүдэд Энэтхэгийн бизнесийн орчны чанарт болон хувийн салбарынх нь боловсронгуй байдлын түвшинд нилээд сайжралт гараад байна. Хэрэв бид үйлдвэрлэлийн үйл ажиллагааны боловсронгуй байдал, компаниудын судалгаа, хөгжлийн ажилд зарцуулж буй хөрөнгийн түвшин, гадаадын технологийн лицензжилт зонхилсон байдал, санхүүгийн зах зээлийн боловсронгуй байдал, худалдаанд илүү мэдрэмжтэй хандахтай холбоотой эдийн засгийн нээлттэй байдал зэргийг нь харах юм бол Энэтхэг улс сүүлийн арван жилд мэдэгдэхүйц ахиц дэвшил гаргасан байгаа. Энэ хугацаанд өсөлтийн байдал илүү дээрдсэн нь бодлогын хүрээ ба институцийн орчинд гарсан сайжралтаар харагдаж байгаад эргэлзэх зүйлгүй.

Гэхдээ өсөлтийн хурдыг нэмэгдүүлсе, тухайлбал 8 хувь хүргэе гэж үзвэл хэд хэдэн гол сул талаа анхаарч авч үзэх шаарлагатай. Үүнд:

- Бүх шатны боловсролын сегментүүдийн хэмжээгээр *бичиг үсэггүй байдал өндөр, сургуульд хамрагдалтын түвшин* харьцангуй доогуур байна. Энэ шаардлага нэн ялангуяа бага, дунд боловсролын түвшинд хойшлуулшгүйгээр тавигдаж байгаа боловч их, дээд сургуульд хамрагдалтын хувь олон улсын стандартаар доогуур түвшинд (*Дэлхий Дахины Өрсөлдөх Чадварын тайлан*-д Энэтхэг улс энэ үзүүлэлтээрээ 117 орны 91-т орсон) байна. Ялангуяа охидын боловсролыг дээшлүүлэх шаадлагын хүрээ маш өргөн байна.

Энэтхэг улс ядуу залуусаа боловсруулан, сургалтад хамруулж, тэдэнд хэрэгцээтэй үр чадвар бүхий ажиллах хүчний эгнээнд нэгдэн орох боломж олгох, ялангуяа харьцангуй давуу талын чадамж бүхий салбаруудад олноор оруулах шаардлагатай байна. Харилцаа холбооны зардал бүүрснаар хөгжиж байгаа ертөнцөд үйл ажиллагаагаа шилжүүлэх үйл явц өргөжсөөр байгаатай холбогдон ирэх жилүүдэд дэлхийн хэмжээгээр гадны санхүүжилтийн эрэлт нэмэгдэнэ гэсэн хүлээлт хаа сайгүй байна. Энэтхэгийн хувьд эдгээр таатай боломжуудыг бүрэн ашиглаж чадахын тулд (ялангуяа гадаад санхүүжилтийн зах зээлийн тэргүүн эгнээнд байж) ажиллах хүчнийхээ үр чадвар, сургалтын түвшинг дээшлүүлэх шаардлагатай болно.

- *Хүнд суртлын дүрэм журам, хэт их зохицуулалтын хүрээ* Энэтхэгт ноцтой асуудал болсон хэвээр байна. «Өөрийгөө зовоосон өвчин» гэж тодорхойлж болох засгийн газрын хөндлөнгийн оролцоо, хяналтын соёл өргөн дэлгэрсэн байдаг нь бизнесийн зардлыг нэмэгдүүлж, жижиг, дунд үйлдвэрийн хөгжлийг боомилж байна. Өөрөөр хэлбэл, хөгжиж байгаа орнууд бизнесийнхэнд хүндрэл учруулахаас өөр ямар ч мэдэгдэхүйц үнэ цэнэгүй, өчүүхэн зүйлсийг өөрсдөө хийж байна гэсэн үг. Энэтхэг улс сүүлийн арван жилд энэ чиглэлээр ахиц дэвшил гаргаад байгаа боловч хараахан хангалттай бус байна.
- *Дэд бүтцийн* салбарт илэрхий хэрэгцээ шаардлага их байгааг тус улсын засгийн газар тогтоогоод байна: Энэтхэгийн зам харгуй, усан боомтууд, нисэх буудлууд, цахилгаан станцууд засвар хийх шаардлагатай өрөвдөлтэй байдалд байна. Утсан харилцааны дэд бүтцийг сайжруулах талаар зарим нэг дэвшил гарсан боловч хувийн салбарын хөгжлийг тогтвортой байлгах, гадаадын шууд хөрөнгө оруулалтын дотогш урсгалыг илүү өндөр түвшинд хүргэхийн тулд энэ чиглэлд ихээхэн хөрөнгө оруулалт хийх зайлшгүй шаардлагатай байна. Ирэх арван жилийн хугацаанд тус улсын засгийн газар 150 тэрбум ам.долларын гадаадын шууд хөрөнгө оруулалт татан оруулахыг хүсч байгаа ч үүнийг дан ганц Энэтхэгийн том бөгөөд өсөн нэмэгдэж буй зах зээлд дулдуйдан хэрэгжүүлэх боломж бага байна. Хөрөнгө оруулалтын найрсаг орчин бий болгохын тулд дэд бүтцийнхээ чанарыг сайжруулах шаардлагатай болно. Эдгээр төлөвлөгөө бүрэн хэрэгжих эсэх нь төрийн мөнгө санхүүг ихээхэн сайжруулах ажилтай нягт уялдаатай юм.
- Энэтхэг улсад *төсвийн алдагдлын* ноцтой асуудал бий. Тухайлбал, сүүлийн хэдэн жил ДНБ-ийхээ 10 орчим хувьтай тэнцэх алдагдалтай ажиллаж байгаа нь

Хайрцаг 2. Энэтхэгийн өрсөлдөх чадварын зэрэглэлийг дээшлүүлэхэд юу хэрэгтэй вэ? /үргэлжлэл/

дэлхийд хамгийн өндөрт орох үзүүлэлт бөгөөд *Дэлхий дахины өрсөлдөх чадварын индекс*-д ганцхан Турк улс л тус улсаас доогуур оноо авсан байна. Энэ асуудал хэд хэдэн талтай. Нэгдүгээрт, Энэтхэгийн улсын нийт өрийн түвшин ДНБ-ийхээ 83 хувьтай тэнцэж байгаа нь шинээр төрөн гарсан зах зээлүүдийн стандарттай төдийгүй хөгжилтэй орнуудын стандарттай харьцуулахад нэгэнт маш өндөр түвшинд хүрсэн байна. Хоёрдугаарт, Энэтхэгийн төсвийн орлогын бааз суурь тун явцуу хүрээтэй учраас орлого ба өрийн харьцаа нь дэлхийн хамгийн өндөрт орж байна. Энэтхэг улс ДНБ-ийхээ дөнгөж 19 хувь орчимтой тэнцэх төсвийн орлого олдог бөгөөд энэ үзүүлэлт хөгжиж байгаа орнуудын дунджаар ДНБ-ий 26 хувь орчим, харин өргөн хүрээтэй нийгмийн хамгааллын сүлжээ бүхий аж үйлдвэржсэн орнуудад түүнээс ч илүү өндөр байдаг байна.

Тус улсын засгийн газар дунд хугацаанд төсвийн зохицуулалтын зарим нэг арга хэмжээ авах оролдлого хийж, 2003 онд Төсвийн хариуцлагатай байдал ба удирдлагын тухай хууль (ТХБУХ) батлуулсан бөгөөд 2009 он хүртэл төсвийн алдагдлыг бууруулах төлөвлөгөө дэвшүүлсэн байна. Гэвч энэ хуулинд зарим нэг алдаа дутагдал байна. Нэгдүгээрт, төсвийн алдагдлын асуудлын бараг тал нь үнэн хэрэгтээ муж улсуудтай холбоотой байхад уг хууль зөвхөн төв засгийн газарт хамаатай байна. Хоёрдугаарт, ТХБУХ-д заасан төсвийн зохицуулалтын шугамыг дагаагүй тохиолдолд хүлээлгэх ямар нэг шийтгэл буюу хориг арга хэмжээ байхгүй байна.

Энэ бүхэн яагаад чухал байна вэ? Үүнд олон шалтгаан бий. Нэгдүгээрт, их хэмжээний улсын өр рупийгээр нэрлэгдсэн байгаа. Энэ нь тус улсыг валютын ханшны эрсдлээс холдуулж байгаа учраас зах зээлүүдийн хувьд эерэг зүйл мэт харагдана. Харин уг өрийн хэмжээ маш том учраас засгийн газрын кассчины үүргийг банкны систем голлон гүйцэтгэнэ гэсэн үг. Энэ нь банкнуудын хувьд ашигтай бөгөөд аюулгүй бизнес учраас тэд уг хадгаламжийг өсч хөгжихийн тулд санхүүжилт хэрэгтэй байгаа жижиг, дунд үйлдвэр зэрэг хувийн бүтээлч салбарт дамжуулан зуучлах талаар нэг их санаа зовоод байх шаардлагагүй болох юм. Түүнчлэн тэд үнийн эрсдлийн дотоод чадавхийг цаашид хөгжүүлэх талаар санаа зовоод байх шаардлагагүй. Тэр тохиолдолд засгийн газар гэсэн маш том, найдвартай үйлчлүүлэгч байхад юунд нь санаа зовох юм бэ? Өрхийн хуримтлалаас үүссэн хадгаламжийг хувийн салбарын бүтээлч хөрөнгө оруулалтад чиглүүлж, санхүүгийн салбараа хөгжүүлэхгүйгээр Энэтхэг улс тогтвортой бааз сууринд тулгуурлан 8 хувийн өсөлтөд хүрэх магадлал багатай. Засгийн газар хадгаламжийн талаарх хүсэл

сонирхолоо хазаарлахгүй л бол тэр болтол ийм өсөлт гарахгүй. Цаашилбал банкуудын тайлан балансад их хэмжээний засгийн газрын үнэт цаас сууж өгсөн бөгөөд эдгээр нь хүүгийн хувийн эрсдэлд төдийгүй хөрөнгийн боломжит алдагдалд эмзэг өртөмтгий байна.

Эцэст нь Энэтхэгийн өсөлт сайтай байдал нь илүү өндөр татвар эсвэл бага зарцуулалтын хэлбэрээр, эсвэл тэдгээрийн зарим хослолын хэлбэрээр төсвийн зохицуулалт хийх тохиромжтой нөхцлөөр хангаж байх шиг байна. Улс төр, эдийн засгийн хэллэгээр бол өсч байгаа эдийн засаг бүсээ чангалахыг зөөлөж өгдөг. Нөгөө нэг хувилбар нь эдийн засгийн уналт буюу хямралын үед үүнийг хийх явдал байдаг боловч илүү хэцүү байдаг уламжлалтай. Олон намын ардчилсан тогтолцоотой үед, ялангуяа Энэтхэг шиг их хэмжээний ядууралтай байгаа орны хувьд төсвийн сахилга батыг чангалахад ямагт хэцүү байдаг. Төсвийн алдагдал эдийн засгийг хойш татдаг нь эргэлзээгүй боловч алдагдал хамаагүй бага байх нь эдийн засгийн өсөлтийн болон орлогын илүү өндөр түвшинтэй холбоотой байж, засгийн газрын зүгээс нийгмийн тулгамдсан асуудлуудад хариу үйлчлэх чадварыг дээшлүүлж өгдөг. Иймээс нөгөө талаас төсвийн сахилга бат дутагдах нь ядуучуудын эсрэг арга хэмжээ болж, өсөлтийг бууруулах замаар хүссэн үр нөлөөний эсрэг үйлчилдэг.

Дэлхийн өсөлтийн хөдөлгөгч хүч болох чадамж Энэтхэгийн эдийн засагт бий. Энэ чадамжаа бүрэн ашиглахын тулд эрх баригчид болон бизнесийн салбарынхан хүчээ нэгтгэж, олон чухал сорилтыг авч үзэх шаардлагатай: тус улсын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, биет дэд бүтцийн чанарыг сайжруулах, хэрэгцээгүй хэт их зохицуулалтын ажлын дарамтыг багасгах, төрийн мөнгө санхүүг илүү тогтвортой замд оруулах зэрэгт онцгой анхаарах шаардлагатай. Урт хугацаанд ДНБ-ий бодит өсөлтийг 8 хувьд байлгах нь сайн эдийн засгийн бодлогын ямагт төвд нь байдаг ядуурлыг бууруулах асуудалд үр өгөөжөө өгөх болно. Эдгээр сорилтыг даван туулаад ирэхэд Энэтхэг улс яагаад дэлхийн хамгийн өрсөлдөх чадвартай эдийн засгийн тоонд орж чадахгүй байна гэх шалтгаан байхгүй болно.

Тайлбар

- 1 1990-2004 онуудад Энэтхэгийн ДНБ-ий жилийн дундаж бодит өсөлт Хятадын 9 хувийн үзүүлэлттэй харьцуулахад 5.7 хувь орчим байв. Иймээс энэ хугацаанд Энэтхэгийн ДНБ хоёр дахин, харин Хятадынх гурав дахин нэмэгджээ. Хятад улс Энэтхэгийг бодвол нялхсын эндэглэл хамаагүй бага, хүн амын дундаж наслалт өндөртэй, бичиг үсэггүй байдлын хувь бага байдаг гайхах зүйлгүй.

Исланд, Норвеги улсууд 7, 9 дүгээр байрт тус тус ойрхон дагаж яваа нь мөн л эхний аравт багтсан үзүүлэлт юм. Эдгээр орныг өрсөлдөх чадвар туйлын өндөртэй болгож буй хэд хэдэн нийтлэг онцлог чанар байдгийн дотор макро эдийн засгийн маш эрүүл саруул орчин, төрийн институциуд нь ихээхэн ил тод, үр ашигтай байж улсын төсвийн зарцуулалтын тэргүүлэх чиглэлүүдийн талаар нийгмийн хүрээнд санал нэгдсэн байдаг явдал юм. Нордикийн орнуудын бизнесийн салбарынханаас татварын хувь өндөр байх нь бэрхшээлтэй асуудлуудын нэг гэж үздэг эсэх талаар асуухад, эдгээр орнуудыг дэлхийн зах зээл дээр үр нөлөөтэй өрсөлдөхөд болон бараг дэлхийн хамгийн өндөрт орохуйц амьжиргааны түвшинтэй тус тусын хүн амдаа үйлчлэхэд энэ асуудал сөргөөр нөлөөлж байна гэсэн нотлох баримт гараагүй байна. Үнэн хэрэгтээ, энэхүү өндөр түвшний засгийн газрын орлогыг дэлхийн түвшинд хүрсэн боловсролын тогтолцоо, аюулгүй байдлын өргөн хүрээтэй сүлжээ, өндөр урам зориг, ур чадвартай ажиллах хүчинтэй болоход зарцуулдаг байна.

Ерөнхий зэрэглэлийн хувьд **Их Британи** (13-рт), **Герман** (15-рт) харьцангуй нэр хүндтэй дээгүүр байр эзэлсээр байна. Хоёр орон хоёулаа дэлхийн түвшинд хүрсэн төрийн институцитэй хэдий ч Германы бизнесийн салбарынхан тус улс өмчийн эрхийн орчин ба шүүхийн тогтолцооны үйл ажиллагаагаараа дэлхий дээр хэнийг ч дагуулахгүй гэж үздэг нь Их Британы бизнесийн салбарынханы өгсөн үнэлгээнээс арай илүү өөдрөг байна. Мөн технологийн дэд индексээр хоёулаа тун ойролцоо зэрэглэлтэй (тус тус 17, 16-р байрт) байгаагаас нэн ялангуяа судалгаа, хөгжлийн ажилд зарцуулдаг хөрөнгө, эрдэм шинжилгээний болон бизнесийн байгууллагуудын хамтын ажиллагаа, мэдээлэл харилцааны технологийн салбарын эрх зүйн суурь хүрээ гэх мэт үзүүлэлтүүд, түүнчлэн янз бүрийн шинэ технологийн ашиглалтыг харуулсан өргөн хүрээтэй үзүүлэлтээрээ өндөр оноо авсан байна. Хоёр улс хоёулаа шинийг санаачлах чадавхаа маш сайн хөгжүүлсэн бөгөөд АНУ-ын патент бүртгэлийн хэмжээсээр авч үзвэл Герман улс илүү эрч хүчтэй байна. Герман улсын хувьд богино хугацааны эдийн засгийн өсөлтийн төлөв байдлын талаар тус улсын бизнесийн салбарынхан гутранги бус байсан, улсын салбарын төсвийн алдагдал их биш байсан бол ӨӨЧИ-ийн ерөнхий дүнгээрээ дээгүүр байрт орохоор байв. Энэ үзүүлэлтээр тус улс судалгаанд хамрагдсан дэлхийн 117 орны 87-рт бичигдсэн бөгөөд улмаар уг макро

эдийн засгийн орчны дэд индекс тус улсын оноог баллажээ. Их Британи, Герман хоёрын үзүүлсэн энэхүү амжилтын түвшинд Франц улс ойртож чадсангүй. Франц улс Германы нэг адил их хэмжээний төсвийн алдагдалтай ажиллаж байгаа (наанадаж 2002 оноос хойш) бөгөөд харьцангуй удаан өсөлттэй байгаа нь тус улсын бизнесийн салбарынханы сэтгэл санаанд муугаар нөлөөлсөн байж болох юм. Тус улс макро эдийн засгийн орчны хувьд 27 дугаар байр эзэлж түүрүү жилийнхээс хоёр байр ухарсан юм. Гэвч энэ нь ӨӨЧИ-ийн энэ хэсэгт илүү өндөр оноо бүхий Кувейт, Катар гэсэн хоёр улс уг индексэд нэмэгдэж орсонтой холбоотой юм. Харин, төрийн институциудын чанар гэх мэт өрсөлдөөний уур амьсгалын бусад талыг үнэлэхэд Францын бизнесийнхэн нилээд хатуу чиг шугам баримталж байна. Шүүхийн үйл ажиллагаа ба хараат бус байдал, өмчийн эрхийн орчин, засгийн газрын албан тушаалтнууд хувийн салбарынхантай харилцахдаа тэгш шударга байх асуудал зэргийг нь харах юм бол Франц улс зөвхөн Германд төдийгүй Финлянд, Дани, Шинэ Зеланд, Швейцарь, зэрэг ЕХ-ны гишүүн бус орнуудад ноогдож байна зэрэг бусад оронд байдаг стандартуудыг хангадаггүй гэж үзжээ. Нэг нааштай зүйл бол, бид удахгүй Дэлхий Дахины Өрсөлдөх Чадварын Индексэд (дор үзнэ) шилжихэд, одоогоор ӨӨЧИ-д ороогүй олон тооны ойлголтоор, тухайлбал, компаниудын боловсронгуй ажиллагаа, мөн нийтийн эрүүл мэндийн онц сайн түвшин зэрэг хүний хүчин зүйлд тавьж буй хүчтэй анхаарал халамжийн үзүүлэлтээрээ Франц өндөр үнэлгээ авч ирэх жилүүдэд зэрэглэлээ ахиулах боломжтой байна⁷.

Саяхан ЕХ-д элссэн 10 орны дундаас Эстони улс бусдыгаа тэргүүлж 20 дугаар байр эзэлсэн нь ЕХ-ны анхдагч 15 гишүүн хэд хэдэн чинээлэг орны урд орсон хэрэг юм. Эстонийн энэ байр бол олон шалтгаанаар сэтгэл хөдлөм амжилт бөгөөд магадгүй хамгийн чухал нь 15 жил хүрэхгүй хугацаанд төвлөрсөн төлөвлөгөөний үр ашиггүй байдал, чадварлаг эдийн засагтай байдал хоёрын хоорондох ангальг туулж чадсан явдал юм. Тус улс ерөнхийдөө макро эдийн засгийн орчны тогтвортой байдлын үзүүлэлтээр 14 дүгээр, технологийн чиглэлд 18 дугаар байр тус тус эзэлсэн нь Шинэ Зеланд, Португал хоёроос арай урдхан орсон амжилт болжээ. ЕХ-нд шинээр элссэн орнуудаас хамгийн муу амжилт үзүүлсэн нь Польш улс хэвээр бөгөөд тус улсын институцийн болон макро эдийн засгийн орчинд ноцтой

дутагдал оршиж байна. Түүнчлэн төрийн мөнгө санхүүгийн байдал тааруу, мөн эдийн засаг дахь хувийн салбарын гүйцэтгэх үүргийн гол элементүүдийг харуулдаг олон чиглэлд барагтай оноонууд авсанд анхаарах нь зүйтэй байна. Гэхдээ сайнаар тэмдэглэхэд, Польшийн байдалд зарим нэг ахиц дэвшил гарсан бөгөөд түүрүү жил 60-рт орж байсан бол 9 байр урагшилж 51-т орсон байна. Энэ нь ЕХ-нд шинээр элсэн орсон олон оронд гарч буй чиг хандлагатай нийцэж байгаа бөгөөд эдгээр оронд өнгөрсөн жилийн өрсөлдөх чадварын түвшнээс илүү ахиц гарсан нь ихэвчлэн ЕХ-нд гишүүнээр элссэнээр хүртэж буй ерөнхий үр өгөөж болон тухайн улсын засгийн газарт эдийн засгийн шинэчлэлийн чиглэлд идэвхтэй байр суурь баримтлах урам зориг өгч байгаатай холбоотой байж болох талтай.

Ази тив

Тухайн бүс нутгийн улс орнууд нь голдуу ганц, хоёр тэргүүлэгч орнуудынхаа ард нэг дор бөөнөөр байрладаг зарим бүс нутагтай адилгүй нь Азийн улс орнууд уг индексийн бүхий л хүрээнд тархан байрласан байдаг бөгөөд энэ нь тэдний хөгжил болон өсөлтийн чадамж маш олон янзын түвшинд байгааг харуулж байна. Тус бүс нутагт тэргүүлэгчид нь алдарт Азийн барууд, тухайлбал **Тайвань, Сингапур** байх бөгөөд тэд 5, 6 дугаар байрыг тус тус эзэлжээ. Тэдгээрийн дараа нилээн хэдэн байрын ард ӨӨЧИ-д хамрагдсан дараагийн Азийн орон болох Япон улс 12 дугаарт орсон байна. Дээрх тэргүүлэгч улсууд ба Япон улсын хоорондын зай өнгөрсөн жилээс эхлэн нэмэгдэж байгаа нь Япон улсын макро эдийн засгийн байдал харьцангуй сул байгаатай холбоотой гэдгийг бид энд тэмдэглэмээр байна. Үнэн хэрэгтээ Япон улс төсвийн алдагдлаараа (113-т) болон улсын өрийн түвшнээрээ (114-т) дэлхийд хамгийн муу зэрэглэлтэй орнуудын тоонд орж байна. Тийнхүү Японы төсвийн сахилга батын хувьд ийнхүү дутагдалтай байдал нь технологийн талаар тус улсын хүрсэн сэтгэл хөдлөм амжилтаар нөхөж чадах хэмжээнээс ч их байгаа юм. Судалгаа, хөгжлийн ажил, пүүс, компаний түвшний технологийн шингээлт, патент бүртгүүлэлт зэрэг үзүүлэлтээр туйлын өндөр зэрэглэл бүхий энэ орон энэ чиглэлд багахан оноо дутаж АНУ-ын дараа хоёрдугаарт орсон байна.

Гонконг бусад Азийн баруудаас харьцангуй доогуур байр эзэлж 28 дугаарт бичигдсэн нь

түүрүү жилийн амжилтаасаа долоон байраар ухарсан байна. Тус улсын энэ сулралтад төрийн институцийн чанар муудсан гэдэг ойлголт гол буруутай бөгөөд энэхүү дэд индексээр 9 дүгээр байраас 14 байраар ухарч 23 дугаарт оржээ. Энэ нь эргээд тус улсын гэрээ, эрх зүйн болон авилгалын дэд индексүүдэд нилээд өөрчлөлт гарсны үр дүн юм. ӨӨЧИ-ийн индексийн төрийн институцийн хэсгийн бараг бүхий л бүрэлдэхүүн хэсгүүдээр Хонг Конгийн байдал доройтсон бөгөөд шүүхийн хараат бус байдлаар 14-өөс бууж 25 дугаар байрт, өмчийн эрхээр 3 дугаар байраас 15 дугаар байрт, тал тохой татах байдлаар 10 дугаар байраас 32 дугаар байр руу тус тус урууджээ. Мөн хууль бус төлбөрөөр (авилгал) эзэлсэн байр нь түүрүү жилийн амжилтаасаа нилээд доошилсон байна. Эдгээр үр дүн нь өнгөрсөн жилээс хойш Хонг Конгийн институцийн орчин мэдэгдэхүйц муудсаныг харуулж байгаа.

49, 50 дугаар байрыг тус тус эзэлсэн **Хятад, Энэтхэг** хоёр улс бие биетэйгээ урд жилүүдийнхээс ч илүү ойртож ирсэн байна. Хятад улс гурван байраар ухарсан бол Энэтхэг улс таван байраар ахижээ. Хятад улсын эзлэх байр доошилсон нь энэ жил уг индексэд түүнээс дээгүүр зэрэглэлтэй хоёр шинэ орон нэмэгдсэнтэй холбоотой. Түүнчлэн Хятад улс макро эдийн засгийн орчны хувьд өмнөхөөсөө арай доогуур үнэлгээ авсан байна. Хятадын эрх баригчид зээллэгийн өсөлтийг тогтоон барихыг оролдож байгаа (Зээл авах боломжийн үзүүлэлтээр Хятадын зэрэглэл нилээд буурсан) бөгөөд эрэлтийн хүч нэмэгдсэнээр 2004 онд инфляци хурдсахад хүрсэн байна. Энэтхэг улсын зэрэглэл дээшилсэн нь тус улс технологийн индексээр нилээд дээгүүр байр эзэлж байгаатай холбоотой. Сүүлийн хэдэн жил тус улсын ур чадвар шаардсан, технологи эрчимжсэн салбаруудад гадаадын шууд хөрөнгө оруулалт ихээр орох болсон нь тус улсын бизнесийн салбарынханы сэтгэл санааг өөд татахад нөлөөлсөн нь мэдээж юм. Харин Энэтхэг улсад үлдэх санаа зовоосон асуудлууд нь төсвийн шинэчлэлд ахиц дэвшил бага гарсан (тус улс дэлхийн хамгийн их төсвийн алдагдалтай орны нэг буюу 117 орны 116-т орж байна), шинэ технологи нэвтрэлтийн түвшин доогуур (хөдөлгөөнт холбоо, хувийн компьютер, интернэтийн ашиглалт), дээд боловсролд хамрагдалтын хувь доогуур байгаа зэргээс үүдэлтэй. (Энэтхэг дэх өрсөлдөх чадварын асуудлуудын тухай илүү дэлгэрэнгүйг Хайрцаг 2-оос үзнэ үү) Эдгээрийн сүүлийн хоёр

нь мөн Хятад улсын хувьд хүндрэлтэй асуудал юм. Сүүлийн жилүүдэд Хятад, Энэтхэг хоёр улс хоёулаа маш сайн өсөлттэй явж ирсэн. Аль алиных нь хувьд нөөцийн хуваарилалтад гарч байсан ихээхэн гажуудлыг арилгасны үр дүнд үр ашгийн хожоо гарсан (ялангуяа Хятадад), мөн илүү нээлттэй, сайн бодлого баримтлах болсон нь бүтээмж ихээхэн дээшлэхэд хүргэсэн байна. Цаашибал Хятадад хэд хэдэн бүтцийн өөрчлөлтүүд, түүний дотор хотжилтийн үйл явц асар ихээр хийгдсний үр өгөөжийг тус улсын эдийн засаг хүртэж, улмаар энэ нь ДНБ-ний өсөлтөд багагүй хувийг эзэлсээр байна⁸. Гэвч хоёр улс хоёулаа институцийн сул дорой байдлын асуудалд ороод байгаа бөгөөд үүнийгээ онцлон авч үзэхгүй бол тэдний хувьд дэлхийн хамгийн өрсөлдөх чадвартай орнуудын дээд давхаргад өгсөж орох үйл явц нь удаашрах магадлалтай юм.

Энэ жилийн зэрэглэлд **Бүгд Найрамдах Солонгос улс** 12 байр ахисан сэтгэл хөдлөм амжилт үзүүлсэн нь энэ жилийн жагсаалтад орсон нийт 117 орны дотроос хамгийн чухал бөгөөд хамгийн томоохон сайжралтын нэгд орох нь мэдээж юм. Энэ нь, нэг талаас тус улс 2003 оны зээлийн картын хямралаас гарсантай нь холбоотой. Уг хямралаас тус улсын макро эдийн засгийн орчинд үзүүлсэн нөлөө нь өнгөрсөн жилийн зэрэглэлд 11 байраар ухрахад хүргэж байсан ч түүний мөрөөр өнгөрсөн жилийн турш хийсэн сайжруулалт нь өмнөх байр сууриа дахин олж авах боломж олгожээ.

Энэ жилийн зэрэглэлд анх удаа Төв Азийн гурван орны эдийн засгийг хамруулсан. Макро эдийн засгийн дэд индексээрээ харьцангуй хүчтэй **Казакстан** улс 61 дүгээр байрт орсон бол түүний хөрш **Тажикстан**, **БН Киргиз** улсууд жагсаалтын хамгийн доод хэсэгт буюу тус тус 104, 106 дугаар байрыг эзэлжээ. Мөн энэ жилийн зэрэглэлд **Монгол** (96-т), **Зүүн Тимор** (108-т), **Камбож** (112-т), **Азербайжан** (69-д) зэрэг хэд хэдэн Азийн орнууд нэмэгдэж ороод байна. Эдгээр оронд хийгдэх шинэчлэлийн асуудлууд нилээд хүнд төдийгүй өргөн хүрээг хамарсан байх юм. Нэн ялангуяа Төв Азийн орнуудын хувьд хувийн хэвшилтэй харилцах харилцаанд засгийн газрын (голдуу хүнд сурталтай) гүйцэтгэх үүрэгтэй холбоотой анхаарвал зохих олон чухал асуудал байдаг. Түүнчлэн өөр нэг санаа зовоосон асуудал бол авилгал өргөн хүрээтэй газар авсан явдал юм.

Латин Америк

Өмнөх жилүүдийн нэг адил **Чили** улс 23 дугаар байр эзэлсэн нь Латин Америктаа хол тэргүүлж байна. Үнэн хэрэгтээ Чили улсын тус бүс нутгийн дараагийн хошуучлагч орноос тасарсан зай 2004 оронд 26 байр байсан бол 2005 онд 31 байр болж холдсон нь дэлхийн өөр аль ч бүс нутагт байхгүй онцлог юм. Тус улс гайхалтай чадварлаг макро эдийн засгийн удирдлагаа (Дор үзүүлсэн Дэлхий Нийтийн Өрсөлдөх Чадварын Индексийн тухай хэсгийг үзнэ үү, тэнд уг индексийн макро эдийн засгийн тулгуур үзүүлэлтээр Чили улс дэлхийд 1 дүгээрт орсон байгаа) ил тод, үр ашигтай байдлын хувьд ЕХ-ны түвшинд хүрсэн төрийн институциудтэй хослуулсныхаа үр шимийг үргэлжлүүлэн хүртсээр байна. Үнэн хэрэгтээ, ЕХ-ны 25 гишүүн орны дөнгөж найм нь л төрийн институциудийн дэд индексээр Чилиэс өндөр оноо авчээ. Чили улс 2005 онд 6.1 хувийн өсөлттэй гарахаар харагдаж байгаа нь ОУВС-гаас гаргасан хамгийн сүүлийн урьдчилсан тооцоогоор Латин Америктаа хамгийн өндөр өсөлт бөгөөд удахгүй болох ерөнхийлөгчийн сонгууль нь энэхүү сэтгэл хөдлөм амжилтад муугаар нөлөөлөхгүй байх талтай. Үнэндээ сүүлийн арван таван жилд Чили улсын гаргасан амжилтын нэг өвөрмөц онцлог бол улс төрийн мөчлөгөөс үл хамааран сайн бодлого тууштай баримталж байгаад оршино.

Мексик улс ноднин жилийнхээс долоон байр ухарч 55-д орсноор тус бүс нутгийн хэмжээнд эзэлж байсан хоёрдугаар байраа **Уругвай** улсад алдсан бол **Бразил** улс 8 байр ухарч 65 дугаарт бичигдсэн байна. Мексик, Бразил улсууд хоёулаа төрийн институциудийн чанарыг илэрхийлсэн үзүүлэлтүүдээрээ томоохон ухралт хийжээ. Мексик улсад 2006 онд болох ерөнхийлөгчийн сонгуулийг угтсан улс төрийн тодорхойгүй байдал үүсч, түүнээс улбаалсан бодлого боловсруулах үйл явцын зогсонги байдал бизнесийн салбарынханы сэтгэл санаанд муугаар нөлөөлсөн нь төрийн институциудийн индексэд тус улс 71 дүгээр байр эзлэхэд хүргэсэн байна. Мөн Мексикт гэмт хэрэг гаралтын түвшин өндөр хэвээр байгаа бөгөөд МХТ-ийн чиглэлд авсан зэрэглэл нь аажмаар муудсаар байгаа нь технологийн илүү боловсронгуй дэд бүтэцтэй улсууд уг индексийн тооцоонд шинээр орох болсонтой болон дэлхийн бусад хэсэгт (ялангуяа Азид) энэ чиглэлд илүү хурдацтай ахиц дэвшил гарч байгаатай холбоотой юм. Бразилд хээл

хахуультай холбоотой дуулиан болон бусад үйл явдал өрнөсний улмаас эрх баригч намын эвсэл доройтож, улмаар тус улсын төрийн институциудийн хүчин чадалд таагүй нөлөө үзүүлж байгаа нь бизнесийн салбарынханы итгэх итгэлд сөргөөр нөлөөлсөн байж болох юм. Энэ нь Бразил улс шүүхийн хараат бус байдал (72-т), засгийн газрын үргүй зардал (энэ үзүүлэлтээр 111-т орсон), төрийн албан тушаалтнуудын шийдвэрт тал тохой татах байдал (69-т) зэрэг үзүүлэлтээр тааруу амжилт үзүүлснээр харагдаж байна.

Аргентин улс өнгөрсөн жил ерөнхийдөө сайжирч, хэдийгээр шинэ орнууд нэмэгдэн орж, тэдний зарим нь Аргентиний урдуур орсон ч, 74 дүгээр байрнаас 72 дугаар байранд орж ахисан байна. Ялангуяа, тус улсын макро эдийн засгийн байдал 94 дүгээр байрнаас 86 дугаар байрт орж дээшилснийг тэмдэглүүштэй бөгөөд энэ нь инфляцийн түвшин буурсан, хүүгийн хувь нэлэнхүйдээ багассан, улсын өрийн хэмжээг амжилттай өөрчлөн шинэчилж чадсантай нь нэг талаар холбоотой.

2001 онд 62 дугаар байрт явж байсан **Венесуэл** улс уг зэрэглэлийн сүүл хэсэг рүү эрчимтэй уруудсаар байгаа бөгөөд өнгөрсөн оныхоос мөн л дөрвөн байр ухарч энэ жил ерөнхий дүнгээрээ 89 дүгээр байранд оржээ. Хэд хэдэн талаас нь авч үзэхэд Венесуэлийн энэ байдал нилээд онцлогтой байна. Газрын тосны үнэ өндөр байх үеийн худалдааны асар их ашиг орлогыг үл харгалзан тус улсын засгийн газар эдийн засгаа олон жилийн турш төсвийн алдагдалтайгаар удирдаж, их хэмжээний үргүй зардал гаргаж байна. Тус улс инфляцийн үзүүлэлтээр дэлхийн хамгийн их инфляцитай улсын тоонд орж (115-д), өмчлөлийн эрхийн уур амьсгалын хувьд дэлхийн хамгийн муу, сүүл баригч орон (117-д) болсон байна. Венесуэл улс гэрээ, эрх зүйн дэд индексийн бусад бүхий л үзүүлэлтээр, түүний дотор шүүхийн хараат бус байдал (114-т), засгийн газрын албан тушаалтнуудын шийдвэрт тал тохой татах байдал (116-т), зохион байгуулалттай гэмт хэргийн байдлаар (104-т) сулдорой байна. Мөн энэхүү тааламжгүй орчинд тус улс технологийн олон янзын үзүүлэлтээр хойш сууж байна. Тухайлбал интернет ашиглалт, хувийн компьютер, суурин утсан холбооны нэвтрэлтийн үзүүлэлтүүд бүгд доогуур, мөн судалгаа, хөгжлийн ажилд зарцуулах хөрөнгө, гадаадын шууд хөрөнгө оруулалт, технологийн шилжүүлэлт гэх мэт тус улсын ирээдүйн өсөлтийн чадамжид чухал үүрэгтэй бусад үзүүлэлт төдийгүй засгийн

газраас МХТ-ийг хөхиүлэн дэмжихэд өгч буй тэргүүлэх ач холбогдлын хувьд тааруу байна. Эцэст нь энэ жилийн зэрэглэлд шинээр нэмэгдэж орсон **Гайана** улс Латин Америк, Карибийн бүс нутагтаа сүүлийн байр эзлэхийн зэрэгцээ ерөнхий дүнгээрээ 117 орны 115-д буюу сүүлээсээ гуравт явж байна.

Ойрхи Дорнод ба Хойд Африк

Ойрхи Дорнод ба Хойд Африкийн бүс нутагт ӨӨЧИ-ийн зэрэглэлд Персийн булангийн жижиг улсууд нилээд сайн явж байгаагийн дотор энэ жилээс эхлэн уг индексэд орж байгаа хоёр шинэ орон болох Катар, Кувейт хоёр байна. **Арабын Нэгдсэн Эмират** (АНЭ), **Катар** улсууд тус тус 18, 19 дүгээр байрыг эзэлжээ. Эдгээр улс онцгой сайн үе шатандаа явж байна. Худалдааны таатай нөхцлөөс олж буй олз ашиг нь өсөлтийн хурдыг нэмэгдүүлж, улмаар институцийн үргэлжилсэн шинэчлэл, макро эдийн засгийн удирдлагын сайжралтаас үүдэн нэгэнт өндөр түвшинд хүрээд байсан бизнесийн салбарынханы итгэх итгэлийг батжуулж байна. Эрх баригчид нь газрын тосны өндөр үнээс олж буй олз ашгаа дэмий үрэх бус, харин энэ хөрөнгийг өрийг бууруулах, хөрөнгө оруулах, хуримтлуулахад илүүтэй ашиглах тал дээр боломжийн чадварлаг болох нь нотлогдоод байна. Иймээс тэдний өрсөлдөх чадвар нилээд өндөр байна. Эдгээр улсын араас **Кувейт**, **Бахрейн** улсууд тус тус 33, 37 дугаар байрт харьцангуй ойрхон дагаж байна. Харин **Тунис**, **Иордан** улсууд зарим талаар арай доогуур буюу 40, 45 дугаар байрт явж байна. Тус бүс нутгийн хамгийн доогуур зэрэглэлтэйд 76-т жагссан **Морокко**, 78-т жагссан **Алжир** улсууд орж байна.

Эдгээр зэрэглэлийн янз бүрийн байдал нь тус бүс нутагт хөгжлийн ялгаатай байдал өндөр түвшинд байгаатай нийцэж байна. Эдгээр орон газрын тосны салбарт бараг бүрэн найдсан эдийн засгаас эхлээд илүү олон салбарт төрөлжүүлсэн эдийн засаг хүртэл туйлын өөр өөр орлогын түвшин, бүтээлч бүтэцтэй байна⁹.

2004 оныхтой харьцуулахад тус бүс нутгийн өрсөлдөх чадварын байдал нилээд урам хугарам дүнтэй гарчээ. Тунисаас бусад өнгөрсөн жил уг индексэд хамрагдсан бүх улсын зэрэглэл буурсан байна. Үүний хамгийн онцгой жишээ бол 20 байраар ухарсан Морокко байна. Энэ нь тус улсын макро эдийн засгийн орчин ба төрийн институциуд нилээд их суларч байгаатай холбоотой гэж үзэж болно.

Тус улсын зэрэглэл макро эдийн засгийн орчны дэд индексэд 21 байраар (46-аас 67-д), үүнтэй адилаар гэрээ, эрх зүйн дэд индексэд 20 байраар (40-өөс 60-д) тус тус огцом доошилсон байна. Энэ үүднээсээ авч үзвэл өсөн нэмэгдэж буй их хэмжээний улсын төсвийн алдагдал, улсын өрийг бодитойгоор бууруулах, төсвийн зарцуулалтад илүү их анхаарал хандуулахад чиглэсэн макро эдийн засгийн шинэчлэл хийх нь бодлого боловсруулагчдын нэн тэргүүнд анхаарах асуудал юм. Мөн тухайн улсын эрх зүйт төрийн хүрээг сайжруулах асуудалд хойшлуулшгүй анхаарал тавих шаардлагатай.

ОДХА-ийн бүс нутаг дахь бодлого боловсруулагчдад тулгарч буй бэрхшээл, сорилтууд үнэхээр ноцтой байна: тухайлбал, ихэнх орны зүгээс авч буй дэмжих алхамууд, бүтцийн шинэчлэлүүдийг эс тооцвол тус бүс нутаг дэлхийд хамгийн өндөр буюу 15 хувийн ажилгүйдлийн түвшинтэй бөгөөд ажил эрхлэж буй хүн амын тоо 2000 онд 104 сая байсан бол 2020 он гэхэд 185 сая болж өсөх төлөвтэй байгаа¹⁰, мөн эрчим хүчний салбараас хэтэрхий хамааралтай байдал, дэлхийн бусад бүс нутгийн өрсөлдөөн нэмэгдэж байгаа зэрэг ноцтой асуудлууд байна. Ийм учраас үйлдвэрлэлийг олон салбарт төрөлжүүлж, худалдааг нэмэгдүүлэх, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах үүднээс микро болон макро эдийн засгийн талаас их зүйл хийх шаардлагатай байна. **Египет** улс өсөлтөнд тулгарч буй саад тотгоруудыг олж тогтоох талаар засгийн газартай хамтран ажиллах Үндэсний Өрсөлдөх Чадварын Зөвлөл байгуулах санаачлага гаргасан нь ихээхэн сайшаалтай байна¹¹.

Африкийн Сахар орчмын дэд бүс нутаг

Африкийн Сахар орчмын дэд бүс нутгийн орнууд тийм ч их өрсөлдөх чадвартай бус боловч тус бүс нутагт харьцангуй амжилттай ажиллаж буй хэд хэдэн жишээ бий. Үүнд **Өмнөд Африк** (42-т), **Ботсвани** (48-д), **Мавритани** (52-т), **Гана** (59-т) улсууд орж байна. Гана улс 2004 оноос хойш 9 байраар ахиж, өрсөлдөх чадвараа сайжруулсан нь бүр ч илт байна. Өнгөрсөн жил **Танзани** улсад нилээд сайжралт гарч ерөнхий зэрэглэлээрээ 11 байр урагшилсан байна. Нөгөө талаас, ерөнхийдөө харьцангуй сайн амжилт үзүүлж байсан **Намиби** улс өнгөрсөн жилийнхээс 11 байр ухарсан бөгөөд үүний нэг адил **Мадагаскар**, **Зимбабве** улсууд тус тус 11, 10 байр алдсан нь таамаглал ёсоор

боллоо. Ялангуяа **Зимбабве** улсын жишээ үнэхээр харамсалтай бөгөөд тус улс дэлхийн орнуудын өрсөлдөх чадварын зэрэглэлийн ёроол руу маш хурдтай уруудаж байгаа нь тус улсын институцийн орчин доройтсоор байгаа, түүний дотор өмчлөлийн эрх үгүй болж, эрх зүйт төр авилгалд идэгдсэн төдийгүй эдгээр болон бусад хүчин зүйлс макро эдийн засгийн удирдлагад муугаар нөлөөлсөнтэй холбоотой. Макро эдийн засгийн орчны чанарын хувьд тус улс дэлхийн хамгийн муу орон (117-д) болоод байна.

Африкийн Сахар орчмын дэд бүсийн дийлэнх орнууд өрсөлдөх чадварын хувьд дэлхийн бусад орнуудаас хоцорч үлдээд байгаагийн дотор тус бүс нутгаас уг индексэд шинээр хамрагдаж байгаа **Камерун**, **Бенин** улсууд орж байна. Ерөнхий индексэд хамгийн сүүлийн байр эзэлсэн 13 орны долоо нь энэ бүс нутгийнх байна. Эдгээрт **Малави** (105-д), **Этиоп** (106-т), **Мадагаскар** (107-т), **Зимбабве** (109-д), **Камерун** (111-т), **Бенин** (114-т), **Чад** (117-т) улсууд орж байна. Иймд Африкийн Сахар орчмын дэд бүс нутаг нь гадаад худалдаа, хөрөнгө оруулалт, нэг хүнд ноогдох орлогын хувьд тогтворгүй, дэлхийн хамгийн буурай хөгжилтэй бүс нутаг болохыг ӨӨЧИ-ийн зэрэглэл нотолж байна. Үнэн хэрэгтээ 2004 оны Мянганы Хөгжлийн Зорилтуудад (МХЗ) гарч буй ахиц дэвшлийн тухай тайланд, олон улсын худалдааны тогтолцоог илүү чөлөөтэй, шударга болгож, гадаадын хөгжлийн тусламжийн хэмжээг ихээхэн нэмэгдүүлсний үр шимийг хүртэж чадахгүй л бол Африкийн Сахар орчмын дэд бүс нутаг 2005 он гэхэд МХЗ-ын ихэнх зорилгуудыг, ялангуяа туйлын өлсгөлөн, ядуурлын байдлыг арилгах талаар тавьсан зорилгуудыг хангаж чадахгүй хэмээн урьдчилан таамагласан байна. Их 8-ын орнуудын зүгээс Африкийн голдуу 18 орны 40 тэрбум ам.долларын өрийг тэглэх шийдвэр саяхан гаргасан нь мэдээж зөв чиглэлд хийгдэж байгаа алхам боловч, Африкийн орнууд өөрсдөө макро эдийн засгийн үзүүлэлтүүдээ сайжруулах, ардчилсан практик, институциуд нэвтрүүлэх замаар эрх зүйт төрийг бэхжүүлж, төрийн хууль ёсыг дээшлүүлэхэд чиглэсэн засаглалын практикууд авч хэрэглэх талаар дотооддоо нилээд их хүчин чармайлт тавих ёстой.

Өрсөлдөх чадварын хамгийн сүүлийн үеийн судалгаа: Шинэ Дэлхий дахины өрсөлдөх чадварын индекс

Дээр (болон Хавсралт А-д) харуулсан Өсөлтийн өрсөлдөх чадварын индекс бол өсөлтийн шийдвэрлэгч хүчин зүйлүүдийн шинжилгээнд зориулсан тоон хүрээг гаргах талаар тус Форумын тавьсан хүчин чармайлтуудын дүнд хийгдсэн нэг томоохон алхам байлаа. Өсөлтийн хувьсал өөрчлөлтөд нөлөөлж буй олон тооны хүчин зүйлсийг тусгасан нарийн түвэгтэй байх шаардлага болон олон улс орны хувьд тооцон гаргаж болохуйц бүтцийн хувьд хангалттай ил тод, хялбар дөхөм байх шаардлага хоёрын хоорондын ухаалаг харьцааг олох шаардлага энэхүү индексийг нэгтгэн гаргах үед гарч байлаа. Иймээс ӨӨЧИ нь өсөлтийн үйл явцад чухал үүрэгтэй олон гол чиглэлд анхаарал хандуулж өгснөөрөө өөрийн зорилгыг биелүүлж байв. Нэн ялангуяа өнгөрсөнтэй холбох чухал холбоог бий болгож байсан нь өрсөлдөх чадварын гол үзүүлэлтээ цаг хугацааны хувьд харьцуулан харж, дүгнэхийг хүсч буй орнуудад чухал ач холбогдолтой байв.

Харин бидний хувьд институцийн болон бүтцийн нилээд их ялгаатай олон тооны улс орны хувьсал хөгжлийг тайлбарлахдаа гол хүчин зүйлсийн харьцангуй ач холбогдол ба дэлхий дахины эдийн засгийн мөн чанарт гарч буй өөрчлөлтүүдийг илүү сайн тусган харуулж чадах илүү өргөн хүрээтэй арга хэрэгсэл шаардлагатай болж байгаа нь улам бүр мэдрэгдэж байлаа.

Үүнд цөөхөн жишээ татахад л хангалттай. Бүтцийн сул талууд мөн хэд хэдэн чиглэлээр хийгдэж буй шинэчлэлүүдийн удаашралтай байдлын талаар авч хэлэлцэхгүйгээр ЕХ-ны 15 орны өсөлт удаан байгаа талаар утга төгөлдөр задлан шинжилгээ хийх хэцүү билээ. Тухайлбал, хөдөлмөрийн зах зээлд хатуу чанд байдал давамгайлсан байдал эсвэл нэгдсэн нэг зах зээлийг бий болгоход шаардлагатай гол бүрэлдэхүүн хэсгүүдийг бүрдүүлэх талаар цаг алдаж байгаа явдал зэрэг нь Европын улсуудын эдийн засаг АНУ-ынх шиг жинхэнэ нэгдсэн нэг том зах зээл болж өргөжин тэлэхээс үүдэх хэмнэлтийн үр шимийг хүртэхэд саад болж байна. Гэтэл ӨӨЧИ-д хөдөлмөрийн зах зээлийн хатуу чанд байдлын асуудлыг хөнддөггүй төдийгүй янз бүрийн зах зээлүүд салангид ажилласны үр ашгийн тухай асуудлыг ч илүү өргөн хүрээтэй авч үздэггүй билээ. Мөн ӨӨЧИ-ийн хүрээнд санхүүгийн институциудийн

боловсронгүй байдал, хөрөнгө зуучлах чадвар, хүнд суртлын хэрэгцээгүй зохицуулалтууд, дотоодын эдийн засагт хангалттай хэмжээний өрсөлдөөн байгаа эсэх тухай асуудлууд ордоггүй.

Африкийн орнуудын макро эдийн засгийн орчинг үнэлэхэд төрийн санхүүгийн удирдлага сайтай байх нь чухлын нэг адил өнгөрсөн зууны сүүлийн 25 жилийн турш Африк тивийн ихэнх орон өсөлт муутай байсныг нийтийн эрүүл мэндийн асуудлаас салгаж ойлгох аргагүй. Мөн ДОХ өвчний халдвар болон бусад гоц халдварт өвчнүүдийн тархалтын бизнест үзүүлэх нөлөөг тооцохгүйгээр тус бүс нутаг дахь өрсөлдөх чадварын чиг хандлагыг шинжлэх нь зохисгүй. ӨӨЧИ-ийн хувьд эдгээр асуудлаар огт дурдаагүй нь түүнийг анхлан зохиогчид Африкт болон дэлхийн бусад хэсгийн хөгжлийг ойлгоход эдгээрийг чухал биш гэж үзсэнийх бус¹², харин 2001 онд тус Форумас өрсөлдөх чадварын талаар хийсэн ажилд Африкийн орнууд хязгаартай хамрагдсан болон Европ, Латин Америкийн өсөлтийг тайлбарлахад онц чухал биш хүчин зүйлсийг оруулах зайлшгүй шалтгаан байгаагүйд оршино.

Аливаа орны ирээдүйн өсөлтийн чадамжийн үзүүлэлт гэдэг үүднээсээ боловсрол ба ажиллах хүчээ сургаж, мэргэжил мэдлэгийг нь дээшлүүлэх чадварын түвшин хоёр улам бүр ач холбогдолтой болсоор байна. Аливаа орны шинэ технологи шингээх чадвар, мөн олон улсын зах зээлд хүлээн зөвшөөрөгдөхүйц чанарын болон гүйцэтгэлийн шаардлага хангахуйц бүтээгдэхүүн, үйлчилгээ үйлдвэрлэх, үнэт зүйл бий болгох замаар дэлхийн бусад хэсэгтэй харилцах чадвар зэрэг нь тухайн улсын сургуулиудын чанар, математикийн болон шинжлэх ухааны сургалтад өгч буй тэргүүлэх ач холбогдол, нарийн мэргэжлийн сургалт, судалгааны хүрээлэн, төвүүдийн хангамж, хүртээмжтэй нягт уялдаатай байдаг. ӨӨЧИ энэ чиглэлийн зарим ойлголтыг багтаасан боловч түүнээс ч илүүг хийх илэрхий шаардлага байна гэдгийг бид мэдэрч байна.

Эдийн засгийн өсөлтийг тодорхойлогч хүчнүүдийг сайтар ойлгоход шийдвэрлэх үүрэгтэй илүү өргөн хүрээтэй багц хүчин зүйлсийг авч үзэх үүднээс тус Форумын өрсөлдөх чадварын талаар хийж буй ажлыг цааш хөгжүүлэх сонирхолын үндсэн дээр бид Колумбийн Их Сургуулийн эдийн засгийн өсөлтийн үйл явцын талаар тэргүүлэх мэргэжилтэн болох профессор Хавер Сала-и-Мартинтай сүүлийн хоёр жилийн турш нягт хамтран ажиллаж байна. Бид түрүү

жилийн Тайландаа илүү өргөн хүрээтэй, шинэ өрсөлдөх чадварын индексийн эхний хувилбарыг гаргасан бөгөөд түүнийгээ *Дэлхий Дахины Өрсөлдөх Чадварын Индекс* гэж нэрлэсэн юм. Уг шинэ индекс нь өмнөх хэсэгт авч үзсэн Өсөлтийн Өрсөлдөх Чадварын Индексэд байхгүй олон чухал хүчин зүйлсийг хэмжиж, харьцуулах боломжийг бидэнд олгож байна. Дэлхий дахины ӨЧИ нь «эдийн засгийн хөгжлийн дунд хугацааны тогтвортой түвшинг тогтоодог багц институци, бодлого, хүчин зүйлс»-ийг хэмжих зорилготой юм¹³.

Энэхүү шинэ Дэлхий дахины ӨЧИ нь есөн өөр тулгуур үзүүлэлтэд суурилах бөгөөд тэдгээр нь дор бүрнээ үндэсний эдийн засгийн бүтээмж, өрсөлдөх чадварыг хөтлөхөд шийдвэрлэх үүрэгтэй юм. Эдгээр тулгуур нь өмнө нь ӨӨЧИ-д багтсан бүх элементийг төдийгүй дээр дурдсан бусад олон хүчин зүйлсийг багтаасан байгаа. Эдгээр тулгуур үзүүлэлтийг энд товч танилцуулах нь зүйтэй бөгөөд уг индексийн боловсруулалтын тухай дэлгэрэнгүй мэдээллийг энэ бүлгийн төгсгөлд байгаа Хавсралт Б-д болон Техникийн тайлбар гэсэн хэсэгт (Хавсралт В) оруулсан байгаа.

Тулгуур 1. Институциуд

Аливаа эдийн засаг дахь институцийн орчин бол өсөлтийн үйл явц явагдах нөхцлийг бүрдүүлэх үндэс суурь байдаг. Аливаа улсын төрийн ба хувийн институцийн чанар нь тухайн эдийн засгийн гол оролцогчдийн харилцан үйлчлэх хүрээг бий болгож байдаг. Ялангуяа улсын салбартай холбоотойгоор авч үзвэл, хувийн өмчийн орчны хүчин чадал, засгийн газраас санхүүгийн хомс нөөцийг үр ашигтай ашиглаж байгаа байдал, улсын салбарын ажилтнуудын улсын сайн сайхан байдал, хувийн ашиг хонжоо хоёрыг сайтар ялгах цар хүрээ, гэмт хэргийн тархалт, түүний бизнесийн зардалд үзүүлэх нөлөө зэрэг хүчин зүйлс бүгд шийдвэрлэх ач холбогдолтой. Өмчийн эрхийг муухан тодорхойлсон эдийн засагт бизнесийг үр ашигтай эрхлэх боломжгүй нь тодорхой бөгөөд өмч (материаллаг ба оюуны) эзэмшигчдийн өмчийн эрх баталгаажуулахгүй бол тэд цаашид хөрөнгө оруулах сонирхолгүй байхын зэрэгцээ зах зээлд шинээр орж ирэгсэд албан ёсны эдийн засагт нэгдэн орох сонирхол багатай, харин түүний оронд зүсээ хувилган, татварын эрх бүхий байгууллагын хараанаас мултарч «албан бус салбарын» гадаад хүрээнд багтах нь дээр гэж үзэх болно.¹⁴ Засгийн газрын үйл ажиллагаанд

ил тод байдал дутагдах, авилгал илрэх нь бизнесийн итгэх итгэлийг алдагдуулж, нөөц баялагийн буруу хуваарилалтад хүргэн, улмаар нийгэм бүхэлдээ сайн сайхан байдлаа ихээхэн алдахад хүрч болно. Засгийн газрын албан тушаалтнууд шийдвэр гаргахдаа тал тохой татах байдал, шүүхийн тогтолцооны үйл ажиллагаанд хошуу дүрэх явдал нь бизнесийн зардлыг нэмэгдүүлэх замаар үр ашиггүй байдалд хүргэж, өмчийн эрхийг сулруулан, зарга маргааныг шийдвэрлэхэд саад болдог. Эдгээр илүү далд шинжтэй хүчин зүйлсээс гадна засгийн газрын өөрийн бий болгосон хэт их зохицуулалт, хэрэгцээгүй хүнд суртал гэх мэт үргүй зардал үүсгэдэг, нүдэнд илүү ил харагдах үр ашиггүй байдлууд байдаг. Эцэст нь терроризм, зохион байгуулалттай гэмт хэрэг, хүчирхийлэл зэргээс үүдсэн, ялангуяа найдвартай цагдан сэргийлэх үйлчилгээ дутагдалтай байдалтай хосолсон, нэмэлт зардлууд үүсдэг аюултай орчин байх нь бизнесийг сүйрүүлдэг.

Харин, «сайн засаглал» гэдэг бол зөвхөн төрийн салбарт хэрэглэдэг ойлголт биш юм. Хувийн институциудийн чанар, ил тод байдал ч мөн эдийн засгийн үр ашигт шийдвэрлэх үүрэгтэй. Бизнесийн үйл ажиллагаа шударгаар явагдах, менежерүүд нь засгийн газар, бусад компаниуд болон олон нийттэй харилцахдаа ёс зүйн чанд дүрэм баримтлах нь эдийн засагт маш тустай. Мэдээллийг цагт нь авч байх боломжоор хангах үүднээс тогтсон стандартууд, аудит, нягтлан бодох бүртгэлийн практикууд ашиглан бизнес эрхлэхэд, нэн ялангуяа санхүүгийн салбарт, хувийн салбарын ил тод байдал чухал шаардлагатай¹⁵.

Тулгуур 2. Дэд бүтэц

Чанар сайтай дэд бүтэцтэй байх нь тухайн эдийн засгийн үр ашигтай ажиллагааг хангахад шийдвэрлэх үүрэгтэйн зэрэгцээ эдийн засгийн үйл ажиллагааны байрлалыг болон яваандаа хөгжүүлж болох төсөл, салбаруудын төрлийг тодорхойлогч чухал хүчин зүйл болдог. Чанар сайтай дэд бүтэц нь бүс нутаг хоорондын нягт харилцан ажиллагааг хөнгөвчилж, үндэсний зах зээлийн дотоод интеграц болон бусад орон, бүс нутгуудтай тогтоох хэлхээ холбоог хөхиүлэн дэмждэг.

Чанартай төмөр зам, усан боомт, агаарын тээвэр гэх мэт бараа бүтээгдэхүүн, хүмүүс, үйлчилгээг тээвэрлэх үр нөлөөтэй хэлбэрүүд нь бизнес эхлэн эрхлэгчдэд бараа бүтээгдэхүүнээ зах зээлд аюулгүй, зардал багатай, цагт нь хүргэх

боломж олгохын зэрэгцээ ажилчдад тухайн улсын хаана хамгийн тохиромжтой ажил байна тэнд очиж ажиллах боломж олгодгоороо амин чухал ач холбогдолтой юм. Улс орны эдийн засаг бизнесийн болон үйлдвэрлэлийн үйл ажиллагаа саадгүй явуулах нөхцлөөр хангах үүднээс ямар нэг тасалдал, хомсдолгүйгээр цахилгаан эрчим хүч найдвартай нийлүүлэх чадвартай байх ёстой. Эцэст нь мэдээллийн хурдан шуурхай, чөлөөт урсгалыг бий болгосон баттай, өргөн хүрээтэй харилцаа холбооны сүлжээтэй байх нь эдийн засгийн нийт үр ашгийг дээшлүүлэхэд амин чухал төдийгүй эдийн засгийн оролцогчид шийдвэр гаргахдаа бүхий л бэлэн байгаа холбогдох мэдээллийг харгалзан үздэг байх нөхцлөөр хангаж тусалдаг.

Тулгуур 3. Макро эдийн засаг

Макро эдийн засгийн тогтвортой байдал бол тогтвортой өсөлтийн нэг онц чухал бүрэлдэхүүн хэсэг хэмээн хүлээн зөвшөөрдөг цаг иржээ¹⁶. Төсвийн дарамт эсвэл үнийн тогтвортой байдлын ач холбогдлыг зохих ёсоор анхаарахгүйгээр тогтвортой бааз суурин дээр өсч хөгжсөн улс орны жишээг олж гаргана гэдэг бол хэцүү даалгавар юм. Төсвийн сахилга батгүй байдал нь яваандаа улсын өрийн түвшинг нэмэгдүүлж, засгийн газрийн зүгээс нийтийн эрүүл мэнд, дэд бүтэц, боловсрол гэх мэт хойшлуулшгүй хэрэгцээгээ хангах чадварт хүнд дарамт учруулдаг бөгөөд өнөөг хүртэл төсвийн сахилга батгүй байдлын доройтуулагч нөлөөнөөс болж хэтэрхий олон орон зовж шаналж байгаа учраас төрийн мөнгө санхүүг зөв удирдах явдал онцгой ач холбогдолтой. Нөгөө талаас, улсын салбарын хөрөнгийг хянамгай, ил тод, үр ашигтай удирдаж ирсэн засгийн газар тухайн улсын өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд шийдвэрлэх үүрэгтэй чиглэлүүдэд нөөц баялгаа зөв хуваарилж чадаж байна. Энэхүү тулгуурт авч үзсэн макро эдийн засгийн үзүүлэлтүүд нь Өсөлтийн өрсөлдөх чадварын индексэд орсон үзүүлэлтүүдтэй сайтар зохицсон, гэхдээ илүү оновчтой байдлаар хийгдсэн байгаа.

Тулгуур 4. Эрүүл мэнд ба бага боловсрол

Ажиллах хүч эрүүл байх нь аливаа орны өрсөлдөх чадвар, бүтээмжид амин чухал байдаг. Өвчтэй ажилчид чадамжаа бүрэн ашиглан ажиллаж чадахгүй төдийгүй хөдөлмөрийн бүтээмж багатай байна. Мөн тэд байнга ажлаасаа чөлөөлөгдөх буюу үр ашгийн доогуур

түвшинд ажилладаг учраас эрүүл мэндээр сул дорой байх нь бизнест нилээд өртөг зардал учруулдаг. Бүр онцгой тохиолдол гарч нэг ажилтан нас барлаа гэхэд шинээр ажилтан сонгон авч сургах явдал мөн л үнэтэй тусна. Африк дахь ДОХ өвчний халдвар шиг голдуу ажиллах насны хүн амд нөлөөлдөг бүр айхтар өвчний жишээнд бол богино хугацаанд мэргэжлийн чадварлаг ажилтнуудын хомсдол гарах бөгөөд урт хугацаанд ч бас эцэг, эхээсээ өнчирсэн хүүхдүүд гэр бүлээ тэжээхийн тулд аргагүйн эрхэнд ажил хөдөлмөр эрхлэхэд хүрэх, мөн түүнээс болж боловсрол бага эзэмшихэд хүрэх нь бараг гарцаагүй болно. Ажиллах хүчний эрүүл мэндийг эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтүүдээр хэмждэг бөгөөд үүнд дундаж наслалт, нялхсын эндэгдэл, түүнчлэн хумхаа, сүрьеэ, ДОХ гэсэн дэлхийн гурван гол өвчний халдварын тархалт ба бизнест учруулах зардлын үзүүлэлт ордог.

Мөн энэ тулгуурт эрүүл мэндээс гадна хүн амын бага боловсролын түвшинг харгалзан үздэг бөгөөд дээр дурдсанчлан энэ асуудал өнөөгийн эдийн засагт улам бүр чухлаар тавигдаж байна. Суурь боловсрол нь ажилчин хүн бүрийн үр өгөөжийг нэмэгдүүлж, улмаар эдийн засгийн бүтээмжийг дээшлүүлдэг. Түүнээс гадна, албан боловсрол бага эзэмшсэн ажиллах хүчин зөвхөн үндсэн гар ажиллагаануудыг гүйцэтгэж чадах бөгөөд илүү боловсронгуй үйлдвэрлэлийн үйл явц, арга техникт дасан зохицоход хамаагүй хэцүү байгаа нь ажиглагддаг. Мөн мэдлэг боловсролтой захиргааны ажилтан хомсдолтой байх нь бизнесийн нийт амжилтад сөрөг нөлөө үзүүлдэг. Иймээс, суурь боловсрол дутагдах нь бизнесийн хөгжилд дарамт учруулдаг бөгөөд улмаар аж ахуйн нэгжүүд илүү боловсронгуй, үнэлэмж сайтай бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үнэ цэнийн хувьд шат ахихад хэцүү болдог.

Тулгуур 5. Дээд боловсрол ба мэргэжлийн сургалт

Аливаа эдийн засгийн хүрээнд бэлтгэн гаргаж буй дээд боловсролын чанар, тоо хэмжээ нь үйлдвэрлэл, маркетинг, менежмент, судалгаа, хөгжлийн ажил гэх мэт чиглэлээр илүү нарийн түвэгтэй үүрэг гүйцэтгэх мэргэжлийн ажилтан бэлтгэн гаргах үүднээсээ өрсөлдөх чадварт шийдвэрлэх үүрэгтэй байдаг¹⁶. Илүү ерөнхий утгаараа бол, түргэн хурдацтай өөрчлөгдөн даяаршиж байгаа дэлхий ертөнц дээр шаардагдаж буй технологийн дасан зохицолт нь маш сайн боловсорсон авъяаслаг ажиллах хүчний томоохон сан шаардах болжээ.

Албан боловсролоос гадна аливаа эдийн засгийн хүний нөөцийг хөгжүүлэн сайжруулахад улам бүр чухал болоод байгаа нэг арга бол ажлын байран дээрх сургалт болоод байна. Ажилтнуудынхаа ур чадварын түвшинг тасралтгүй дээшлүүлж, сайжруулж байдаг компаниуд хувьсан өөрчлөгдөж буй орчинд дасан зохицож, өрсөлдөөний давуу талаа хадгалан, нийт эдийн засгийн бүтээмжид илүү хувь нэмэр оруулах магадлалтай. Байнга шинэчлэгдэн сайжирч буй үйлдвэрлэлийн үйл явцтай хөл нийлүүлэх, маркетингийн шинэ арга барил нэвтрүүлэх, эсвэл шинэ зах зээлд нэвтрэх нь тусгай мэргэжлийн ур чадвар шаарддаг бөгөөд аж ахуйн нэгжүүд ажилтнуудаа сургалтад хамруулах, энэ ажилдаа тухайн улсад буй мэргэжлийн сургалтын зохих байгууллагуудын туслалцааг авах замаар үүнд хүрч болно.

Тулгуур 6. Зах зээлийн үр ашигтай байдал

Тухайн эдийн засгийн үйл ажиллагаан дахь янз бүрийн хүчин зүйлсийн зах зээлийн үр ашигтай байдал нь эдийн засгийн хүчин зүйлсийг хамгийн сайн ашиглахад чиглэсэн зохистой хуваарилалтаар хангадаг учраас түүний цаана орших бүтээмж, өрсөлдөх чадварт шийдвэрлэх үүрэгтэй байдаг. Дэлхий дахины өрсөлдөх чадварын индексэд *бараа бүтээгдэхүүний зах зээл, хөдөлмөрийн зах зээл, санхүүгийн зах зээл* гэсэн зах зээлийн гурван амин чухал төрлийн үр ашигтай байдлыг хэмжиж байна.

Бараа бүтээгдэхүүний үр ашигтай зах зээл бүхий орнууд өгөгдсөн эрэлт, нийлүүлэлтийн нөхцөлд тохирсон зөв зохистой бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлдвэрлэн гаргах байр суурьтай байдаг төдийгүй тухайн эдийн засагт эдгээр бараа бүтээгдэхүүн хамгийн үр нөлөөтэй борлогдох нөхцлийг хангаж өгсөн байдаг. Дотоодод болон гадаадад аль алинд нь эрүүл саруул зах зээлийн өрсөлдөөн байх нь зах зээлд эрэлт хэрэгцээтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэж өрсөлдөөнд ялж гарах чадвартай, хамгийн үр ашигтай компаниуд тунаж үлдэх нөхцлийг хангаснаар зах зээлийн үр ашигтай байдал, улмаар бизнесийн бүтээмжийг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой байдаг. Мөн бараа бүтээгдэхүүний арилжаанд аль болох хамгийн тааламжтай орчныг бүрдүүлэхийн тулд засгийн газрын хөндлөнгийн оролцооноос бизнесийн үйл ажиллагаанд учруулах саад тотгор хамгийн бага байх ёстой. Жишээлбэл, татварын ачаалал их, гажуудалтай байх эсвэл эрх зүйн хүрээ үр

ашиггүй байх нь бизнесийн хувьд маргааныг хараат бусаар, шуурхай шийдвэрлэх боломж үл олгож, өрсөлдөх чадварт саад учруулдаг.

Хөдөлмөрийн зах зээлийн үр ашигтай байдал нь бүтээмж, өрсөлдөх чадварыг дээшлүүлдэг. Аливаа бүтээмж сайтай эдийн засаг ажилчдыг хамгийн сайн ашиглахуйцаар зөв зохистой хуваарилж, ажилдаа хүч чадлаа дайчлан ажиллах урам зориг өгдөг. Хөдөлмөрийн зах зээл уян хатан байж, ажилчид эдийн засгийн нэг үйл ажиллагаанаас нөгөөд түргэн шилжих, нийгмийн хагарал үүсгэхгүйгээр цалин хөлсний хэлбэлзэлтэй байх боломжоор хангах ёстой. Мөн хөдөлмөрийн үр ашигтай зах зээл нь ажилчдын урам зориг, хүчин чармайлт хоёрын хооронд тодорхой харилцан хамаарал үүсгэхийн зэрэгцээ эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хооронд бизнесийн харилцааны эрх тэгш байдлаар хангаж өгөх ёстой.

Эцэст нь, санхүүгийн үр ашигтай зах зээл бүхий эдийн засгууд хөрөнгө оруулалтыг дээд зэргээр ашиглахад зориулж тухайн эдийн засаг дахь санхүүгийн нөөцийг хамгийн үр нөлөөтэй хуваарилж чаддаг. Бүтээмжид хамгийн шийдвэрлэх үүрэгтэй зүйл бол бизнесийн хөрөнгө оруулалт бөгөөд улмаар сайн банкны салбарын зээл, сайтар зохицуулсан үнэт цаасны арилжаа, үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалт зэрэг эх үүсвэрээс хувийн салбарын хөрөнгө оруулалтад зориулсан капитал бий болгож чадахуйц санхүүгийн боловсронгуй зах зээлүүдтэй байхыг улс орны эдийн засаг шаарддаг.

Тулгуур 7. Технологийн бэлэн байдал

Өнөөгийн мэдлэгт тулгуурласан дэлхий нийтийн эдийн засагт улам бүр гол болж байгаа нэг элемент бол технологи бөгөөд аливаа орны үйлдвэрлэн гаргаж, улмаар экспортлож буй бараа бүтээгдэхүүний нэр төрөл, чанар, үнэд нөлөөлж байна. Энэ утгаараа, аливаа улс өсөлтийн болон бүтээмжийн түвшинээ тогтвортой барих чадварын түвшин нь түүний технологийн бэлэн байдлаас төдийгүй дотооддоо боловсруулсан эсвэл импортлосон шинэ технологийн үр шимийг хүртэж чадах эсэх болон хэр хэмжээгээр хүртэж чадахаас улам ихээр хамаардаг болоод байна¹⁷.

Технологийн бэлэн байдал нь аливаа орны технологийн чадавхийг хөнгөвчилж, бий болгож байгаа хүчин зүйлстэй онцгой холбоотой. Үүнд: технологи ерөнхийдөө бэлэн байгаа байдал, мэдээлэл, харилцааны технологийн (МХТ)

нэвтрэлтийн хурд зэрэг үзүүлэлт орох бөгөөд эдгээрийг аливаа улсын технологийн ерөнхий бэлэн байдлын шийдвэрлэх үзүүлэлтүүд гэж үздэг. МХТ-ийн хүртээмжтэй байдал нь зөвхөн үр нөлөөтэй, шуурхай харилцааны систем бий болгоход төдийгүй арилжааны гүйлгээнд зориулсан үр ашигтай дэд бүтцээр хангахад чухал үүрэгтэй.

Тулгуур 7 нь Тулгуур 9-ийгөө дэмжиж, эргээд Тулгуур 9 (Шинийг санаачлалт) нь технологийн бэлэн байдлаа дэмжин нөхөж байдаг. Эдгээр нь хоёулаа үндэсний нийт эдийн засаг дахь технологийн ач холбогдлыг тодотгож өгдөг бөгөөд Тулгуур 7 нь анхны эх сурвалжаас нь үл хамааран тухайн улсад технологийн нөөц байгаа эсэхийг авч үздэг бол Тулгуур 9 нь аливаа улс орны шинийг санаачлах чадамж буюу дотооддоо шинэ технологи бий болгох чадавхийг онцлон авч үздэг.

Тулгуур 8. Бизнесийн боловсронгуй байдал

Бизнесийн боловсронгуй байдал нь бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэлийн илүү үр ашигтай байдалд хүргэдэг бөгөөд тэр нь эргээд бүтээмжийг дээшлүүлж, улмаар үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлдэг. Аливаа улсын бизнесийн ерөнхий сүлжээнүүдийн чанар төдийгүй хувь компаниудын үйл ажиллагаа ба стратегийн чанар бол бизнесийн боловсронгуй байдлын асуудлууд юм¹⁸. Энэхүү тулгуур нь нэн ялангуяа шинийг санаачлалтад чиглэсэн хөгжлийн шатанд яваа (энэ талаар дор үзнэ үү) эдийн засгийн хувьд чухал ач холбогдолтой.

Аливаа улсын бизнесийн сүлжээний болон дагалдах үйлдвэрлэлийн салбаруудын чанарыг бид дотоодын нийлүүлэгчдийн тоо, чанарын тухай Судалгааны үзүүлэлтүүд ашиглан тодорхойлдог бөгөөд энэ нь олон янзын шалтгаанаар чухал ач холбогдолтой байдаг. Компаниуд болон нийлүүлэгчид газар зүйн хувьд ойрхон бүлэглэлүүдэд («багцуудад») орж харилцан холбогдсноор үр ашиг дээшилдэг бөгөөд шинийг санаачлах асар их боломж бий болж, шинэ аж ахуйнууд орж ирэхэд учрах саад тотгорыг багасгаж өгдөг. Мөн хувь компаниудын үйл ажиллагаа ба стратеги (нэрийн бараа гаргах, маркетинг хийх, үнэт зүйлсийн хэлхээ үүсгэх, нарийн хийцтэй, давтагдашгүй бүтээгдэхүүн үйлдвэрлэх) бүгд л орчин үеийн, боловсронгуй бизнесийн үйл ажиллагааг бий болгодог.

Тулгуур 9. Шинийг санаачлалт

Амжиргааны түвшинг дээшлүүлэх нэг үндсэн нөхцөл бол үйлдвэрлэлийн бага зардалд тулгуурласан хөшүүн зогсонги байдал бус, харин технологи ба ур чадвар эрчимжсэн салбаруудад тулгуурласан үндэсний өрсөлдөөний давуу талын давшингүй хөгжил юм. Иймээс улс орнууд хөгжихийн хэрээр тэдний өрсөлдөх чадвар шинийг санаачлах чадамж өсөн нэмэгдэж буй хэмжээнээс нь хамаардаг байна. Өмнөх найман тулгуурт авч үзсэн үзүүлэлтийн үзүүлэх үр нөлөө аажмаар буурсаар байдаг бол хар ухаанаар бодсон ч аливаа шинэ санааны боломжит тоонд хязгаар байдаггүй билээ.

Ялангуяа мэдлэгийн тэргүүн эгнээнд нэгэнт ажиллаж байгаа буюу түүнтэй ойр яваа орнууд, мөн гаднаас гарвалтай технологи авч ашиглаад бүтээмжийн тогтвортой, тасралтгүй өсөлтийг хангаж чадахаа больсон орнуудын хувьд шинийг санаачлах авъяас чадвар онцгой чухал. Эдгээр орон судалгаа, хөгжлийн ажилд гол анхаарлаа хандуулж, мэдлэг ба шинэ бүтээгдэхүүнийг дотооддоо бий болгоход анхаарах ёстой¹⁹.

Аливаа орны шинийг санаачлах чадвар нь улсын ба хувийн салбаруудын хамтын, гар нийлсэн хүчин чармайлтын дэмжлэгтэй зохистой, тааламжтай орчин бүрдсэн эсэхээс хамаардаг. Шинжлэх ухааны сайн чанарын судалгааны хүрээлэнгүүд, ур чадвар өндөртэй ажиллах хүчин, түүний дотор эрдэмтэд, инженерүүд, хувийн компаниудын судалгаа, хөгжлийн ажилд зарцуулах хөрөнгийн хангалттай түвшин, түүнчлэн судалгаа, хөгжлийн ажлыг үнэ цэнэд хүргэх оюуны өмчийн хамгаалалтгүйгээр ийм орчин бүрдэж чадахгүй. Мөн их, дээд сургуулиуд ба судалгаа, хөгжлийн компаниудын идэвхтэй хамтын ажиллагаанаас бүрдсэн хувийн ба улсын салбарын хамтын хүч шинийг санаачлахад амин чухал үүрэгтэй.

Аливаа эдийн засгийн бүтээлч чадамжийг дээшлүүлэхэд шийдвэрлэх үүрэгтэй институцийн болон макро, микро эдийн засгийн өргөн хүрээтэй хүчин зүйлсийг хамарсан эдгээр 9 тулгуурыг ашигласнаар Дэлхийн дахины ӨЧИ нь Өсөлтийн өрсөлдөх чадварын индексийг орлохуйц хангалттай өргөн хүрээтэй, хамгийн орчин үеийн, боловсронгуй өрсөлдөх чадварын индекс байж, Дэлхийн Эдийн Засгийн Форум ба бидний ажлыг хэрэглэгчдийн хооронд улам их яриа хэлэлцүүлэг өрнөх боломж олгоно гэдэгт бид итгэлтэй байна.

Хөгжлийн үе шат ба шилжилт

Өсөлтийн хүчин зүйлсийн илүү өргөн хүрээг авч үзсэн дээрх тулгууруудаас гадна Дэлхий дахины ӨЧИ-д бусад олон чухал ялгарах онцлог бий. Түүний нэг нь дэлхийн улс орнууд эдийн засгийн хөгжлийн өөр өөр шатанд явж байна гэсэн үзэл санааг анхнаас нь албан ёсоор оруулсан явдал юм. Аливаа орны өрсөлдөх чадварыг дээшлүүлэх тодорхой хүчин зүйлсийн харьцангуй ач холбогдол нь түүний хөгжлийн тодорхой үе шатнаас хамаарах функц юм. Өнөөдөр АНУ дахь бүтээмжийг юу хөтөлж байна вэ гэдэг нь Бразилд юу хөтөлж байгаагаас өөр байх нь зайлшгүй. Иймээс Дэлхий Дахины Өрсөлдөх Чадварын Индексэд улс орнуудыг тус бүрдээ нарийн түвэгтэй байдлын тодорхой түвшин оруулсан хөгжлийн гурван тодорхой үе шатанд хуваан, тэдгээрийг *хүчин зүйлсэд чиглэсэн, үр ашигт чиглэсэн, шинийг санаачлалтад чиглэсэн* үе шатууд гэж нэрлэсэн юм.

Хүчин зүйлсэд чиглэсэн эхний шатанд улс орнууд ерөнхийдөө үнийн доогуур түвшнээр өрсөлддөг. Тэд хямд ажиллах хүч болон бэлэн байгаа байгалийн нөөц баялгаа ашиглан өргөн хэрэглээний бараа буюу энгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Хөгжлийн энэ шатанд өрсөлдөх чадварын гол бүрэлдэхүүн хэсгүүд нь хүчтэй улсын ба хувийн институциуд (тулгуур 1), хангалттай дэд бүтэц (тулгуур 2), макро эдийн засгийн эрүүл орчин (тулгуур 3), дор хаяж бага боловсрол эзэмшсэн эрүүл ажиллах хүчин (тулгуур 4) байна.

Улс орнууд үр ашигт чиглэсэн үе шат буюу хоёрдугаар шатанд шилжихийн хэрээр илүү үр ашигтай үйлдвэрлэлийн практикийг хөгжүүлэх нь чухал болж ирдэг. Энэ шатанд өрсөлдөх чадварыг үнийн доогуур түвшин бус, бүтээгдэхүүний чанар хөтөлдөг бөгөөд ажиллах хүчнээ илүү дэвшилтэт үйлдвэрлэлийн үйл явцад бэлтгэхэд чиглэсэн дээд боловсрол ба мэргэжлийн сургалтын хөтөлбөрүүд (тулгуур 5), үр ашгийн улам өндөр түвшинд ажилладаг бараа бүтээгдэхүүн, хөдөлмөр, санхүүгийн зах зээл (тулгуур 6), мөн дэлхийн эргэн тойронд шинээр нээсэн хамгийн сүүлийн үеийн технологийг авч ашиглах боломж (тулгуур 7) зэргээс бүтээгдэхүүний чанар хамаарах болно.

Шинийг санаачлалтад чиглэсэн гурав дахь үе шатанд улс орнууд зөвхөн үр ашигтай ажилласнаараа өрсөлдөж чадахаа болино. Хөгжлийн энэхүү дээд шатанд компаниуд шинэ, өөр бүтээгдэхүүн үйлдвэрлэж,

хамгийн боловсронгуй үйлдвэрлэлийн үйл явцыг ашиглах (тулгуур 8) замаар шинийг санаачлалтаараа (тулгуур 9) өрсөлдөх ёстой.

Иймд эдгээр есөн тулгуур нь бүх улс оронд янз бүрийн түвшинд хамаатайн зэрэгцээ тус бүрийнх нь үндэсний өрсөлдөх чадварт ач холбогдолтой байдал нь аливаа орны хөгжлийн тодорхой үе шатнаас хамаардаг байна. Энэ байдлыг харгалзан эдгээр тулгуурыг гурван дэд индексэд хуваасан бөгөөд дор бүрнээ хөгжлийн тодорхой үе шатанд шийдвэрлэх үүрэгтэй байна. Үндсэн шаардлагын дэд индексэд хүчин зүйлсэд чиглэсэн хөгжлийн үе шатанд яваа орнуудад хамгийн чухал тулгууруудыг нэгтгэн оруулав. Үр ашгийг дээшлүүлэгчийн дэд индексэд үр ашигт чиглэсэн хөгжлийн үе шатанд яваа орнуудад шийдвэрлэх үүрэгтэй тулгууруудыг оруулав. Шинийг санаачлалт ба боловсронгуй байдлын хүчин зүйлийн дэд индексэд шинийг санаачлалтад чиглэсэн хөгжлийн шатандаа яваа орнуудад шийдвэрлэх үүрэгтэй бүх тулгуурыг оруулсан болно. Эдгээр гурван дэд индекс нь дараахь бүтэцтэй байна.

Үндсэн шаардлагуудын дэд индекс (Үе шат 1. хүчин зүйлсэд чиглэсэн)

- Институциуд (тулгуур 1)
- Дэд бүтэц (тулгуур 2)
- Макро эдийн засаг (тулгуур 3)
- Эрүүл мэнд ба бага боловсрол (тулгуур 4)

Үр ашгийг дээшлүүлэгчийн дэд индекс (Үе шат 2. үр ашигт чиглэсэн)

- Дээд боловсрол ба мэргэжлийн сургалт (тулгуур 5)
- Зах зээлийн үр ашигтай байдал (тулгуур 6)
- Технологийн бэлэн байдал (тулгуур 7)

Шинийг санаачлалт ба боловсронгуй байдлын хүчин зүйлсийн дэд индекс (Үе шат 3. шинийг санаачлалтад чиглэсэн)

- Бизнесийн боловсронгуй байдал (тулгуур 8)
- Шинийг санаачлалт (тулгуур 9)

Дэлхий дахины ӨЧИ нь тухайн орны хөгжлийн үе шатнаас хамаарч дэд индекс бүрт өөр өөр хувийн жин өгөх замаар хөгжлийн үе шатны тухай ойлголтыг хэрэгжүүлж байна. Бүр тодорхой хэлбэл, уг индекс нь аливаа орны хөгжлийн тодорхой үе шатанд хамгийн чухал байгаа тулгууруудад илүү хувийн жин өгч байна гэсэн үг.

Хөгжлийн өөр өөр үе шатанд яваа орнуудад зориулан дэд индекс бүр өгсөн тодорхой хувийн жинг Хүснэгт 7-д харуулав. Уг хүснэгтээс үзэхэд хүчин зүйлсэд тулгуурласан орнуудын хувьд үндсэн шаардлагад хамгийн их хувийн жин (50 хувь) өгч, үр ашиг дээшлүүлэгчид нилээд их хувийн жин (40 хувь), шинийг санаачлалт ба боловсронгуй байдлын хүчин зүйлсэд дөнгөж 10 хувийн хувийн жин өгсөн байна. Үр ашигт чиглэсэн үе шатанд яваа орнуудын хувьд үндсэн шаардлага ба үр ашиг дээшлүүлэгчийн эзлэх хувийн жинг эсрэгээр нь сольж, шинийг санаачлалтын хүчин зүйлсэд мөн л бага хувь ноогдуулсан байна. Эцэст нь шинийг санаачлалтад чиглэсэн үе шатанд яваа орнуудын хувьд эхний хоёр дэд индексэд нилээд их хувийн жин оноож, шинийг санаачлалт ба боловсронгуй байдлын хүчин зүйлсийн дэд индексэд илүү өндөр хувийн жин өгсөн байна. Энэ нь энэхүү хөгжлийн өндөр үе шатанд бүтээмж ба өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд хамгийн их хамаатай нь эдгээр хүчин зүйлс байдгийг тусгасан болно.

Мэдээж улс орнууд хөгжлийн нэг үе шатнаас нөгөөд гэнэт үсрэн орно гэж байхгүй бөгөөд харин уг тэнхлэгийн дагуу дамжин шилжиж байдаг. Иймээс бид олон орон хоёр үе шатны дундах шилжилтийн шатанд явж байгааг харгалзсан юм. Эдгээр орны хувьд, хөгжлийн нэг үе шатнаас дараагийн үе шат руу аажмаар шилжиж байгааг харуулах үүднээс улс орон хөгжих тусам тулгууруудын хувийн жин зугуухан өөрчлөгдөж байх юм. Үе шатуудын хооронд шилжиж буй энэ төрлийн шилжилтийг энэхүү загварт нэвтрүүлсэн нь уг индексийн нэг чухал онцлог шинж болж байна. Өөрөөр хэлбэл, Дэлхий дахины ӨЧИ нь тухайн улсын хөгжлийн тодорхой үе шатанд өрсөлдөх чадварт нь илүү чухал болж байгаа чиглэлүүдэд илүү их хувийн жин өгөх замаар хөгжлийн дараагийн шатанд орох хараахан бэлтгэлгүй байгаа орнуудыг «шийтгэж» байна гэсэн үг.

Хүснэгт 7. Хөгжлийн үе шат бүрийн гурван үндсэн бүлэг тулгуурт өгсөн хувийн жингүүд

Хувийн жин	Үндсэн шаардлага	Үр ашиг дээшлүүлэгч	Шинийг санаачлалт ба боловсронгуй байдлын хүчин зүйлс
Хүчин зүйлсэд чиглэсэн үе шат	50%	40%	10%
Үр ашигт чиглэсэн үе шат	40%	50%	10%
Шинийг санаачлалтад чиглэсэн үе шат	30%	40%	30%

Улс орнуудыг дараахь үе шатуудад хуваан оруулав. Хүчин зүйлст чиглэсэн үе шатанд 2.000 ам.доллараас доош хэмжээний нэг хүнд ноогдох ДНБ-тэй орнуудыг оруулж байна. Үр ашигт чиглэсэн үе шатанд нэг хүнд ноогдох ДНБ нь 3.000-9.000 ам.долларын хооронд байгаа орнуудыг оруулав. Харин нэг хүнд ноогдох ДНБ нь 17.000 ам.доллараас дээш орнуудыг шинийг санаачлалтад чиглэсэн үе шатанд оруулж байна. Шилжилтийн үед яваа орнууд эдгээр үе шатуудын хооронд явж байна. Хүснэгт 8-д энэхүү *Тайланд* хамрагдсан 117 орныг хөгжлийн өөр өөр үе шатуудад хэрхэн хуваарилан оруулсныг харуулав.

Орлогын түвшингүүдийг үе шатуудын хооронд зааглах шалгуур болгон сонгож авсны учир нь, зохиогчдын тайлбарласанчлан, «хүчин зүйлст чиглэсэн эдийн засаг нь үнийн доогуур түвшнээр өрсөлддөг. Бидцалинхөлсний доогуур түвшинг орлогын доогуур түвшинтэй холбож өгсөн бөгөөд тийм ч учраас нэг хүнд ноогдох орлого нь 2000 ам. доллараас доогуур орнуудыг энэ ангилалд оруулсан юм»²⁰. Мөн үүнтэй адилхан үндэслэл 2 ба 3 дугаар шатуудад яваа орнуудад хамаатай: нэг хүнд ноогдох ДНБ өсч байгаа нь цалин хөлс өсч байгаатай холбоотой бөгөөд энэ нь улс орнуудыг хөгжлийн илүү өндөр үе шатуудад татан оруулснаар тэд илүү нарийн түвэгтэй хүчин зүйлсэд тулгуурлан бүтээмжээ дээшлүүлэх ёстой болно. Хүснэгт 9-12-т Дэлхий дахины өрсөлдөх чадварын индексийн 2005 оны үр дүнг харуулав.

Дэлхий дахины өрсөлдөх чадварын есөн тулгуур үзүүлэлтээр хошуучлагч орнууд

Хүснэгт 13-т Дэлхий дахины өрсөлдөх чадварын индексийн есөн тулгуур үзүүлэлт тус бүрээр эхний байр эзэлсэн орнуудыг харуулж байна. Сингапур, Япон, АНУ гурав эхний хоёр тулгуур үзүүлэлтээр тэргүүлэгч гурван орон гэдгээрээ алдартай. Мөн дараагийн гурван тулгуурт Дани, Чили, Финлянд гурав эхний байр эзэлсэн байна.

Институцийн болон технологийн бэлэн байдлын тулгуур үзүүлэлтээр Сингапур улс нэгдүгээр байр эзэлж байна. Сингапур улс институцийн тулгуурын хоёр дэд индексийн хоёуланд нь сайн амжилт үзүүлсэний зэрэгцээ ялангуяа төрийн институцийн дэд индексэд 117 орноос шалгарч эхний байрт оржээ. Энэ дэд индекс таван бүрэлдэхүүн хэсгээс бүтэх бөгөөд Сингапур улс тавууланд нь гайхалтай сайн амжилт үзүүлжээ: өмчийн эрх (6), ёс зүй

Хүснэгт 8. Хөгжлийн үе шат бүрт яваа улсуудын жагсаалт

Үе шат 1	1-с 2-т шилжиж яваа	Үе шат 2	2-с 3-т шилжиж яваа	Үе шат 3
2000 ам. \$-оос бага орлоготой	2000-3000 ам. \$-ын орлоготой	3000-9000 ам. \$-ын орлоготой	9000-17000 ам. \$-ын орлоготой	17000 ам. \$-оос их орлоготой
Армян Азербайжан Бангладеш Бенин Болив Босни Герцеговин Камбож Камерун Чад Хятад Зүүн Тимор Египет Этиоп Гамби Гүрж Гана Гайана Гондурас Энэтхэг Индонези Иордан Кени БН Киргиз Улс Мадагскар Малави Мали Молдав Монгол Марокко Мозамбик Никарагуа Нигери Пакистан Парагвай Филиппин Шри Ланк Тажикстан Танзани Уганда Украин Вьетнам Зимбабве	Албани Алжир Колумби БН Доминикан Улс Эквадор Эль Сальвадор Гватемал Казакстан Македон Намиби Перу Серб ба Монтенегро Тайланд Тунис	Аргентин Ботсвани Бразил Болгар Чили Коста Рика Хорват Эстони Ямайк Латви Литва Малайз Мавритани Мексик Панам Польш Румын Орос БН Словак Улс Өмнөд Африк Турк Уругвай Венесуэл	Бахрейн БН Чех Улс Унгар Солонгос Мальт Португал Тайвань Тринадад Тобаго	Австрали Австри Бельги Канад Кипр Дани Финлянд Франц Герман Грек Гонконг Исланд Ирланд Израиль Итали Япон Кувейт Люксембург Нидерланд Шинэ Зеланд Норвеги Катар Сингапур Испани Швед Швейцарь АН Эмират Улс Их Британи АНУ

ба авилгал (1), зохисгүй нөлөөлөл (9), засгийн газрын үр ашиггүй байдал: хэт их зохицуулалт, хүнд суртал, үргүй зардал (1), аюулгүй байдал (6). Энд улс төрчдийн санхүүгийн үнэнч шударга байдалд итгэх олон нийтийн итгэл өндөр түвшинд байдаг, захиргааны зохицуулалтыг дагаж мөрдөх нь бизнест хэрэгцээгүй дарамт үүсгэдэггүй, зах зээлээр хангагддаггүй зайлшгүй шаардлагатай бүтээгдэхүүн үйлчилгээг засгийн газрын зардлаар хангадаг, засгийн газрын шийдвэр төвийг сахисан, цагдаагийн үйлчилгээ найдвартай байдаг нь тодорхой бөгөөд энэ бүх онцлогууд нь Сингапур улсыг дэлхийн

хэмжээнд хамгийн сайн институциудтэй орон болгож байна. Технологийн бэлэн байдлын тулгуур үзүүлэлтээр Сингапур улс нэгдүгээр байр эзэлсэн нь одоо байгаа технологийн дэд бүтэц (интернет ба хувийн компьютер нэвтрэлтийн ихээхэн хувь), компаниудын технологи шингээлтийн өндөр түвшин, гадаадын шууд хөрөнгө оруулалтаар шинэ технологи авч хэрэглэхдээ мэргэжсэн байдал, маш өндөр хөгжсөн МХТ-ийн зохицуулалтын орчин зэрэгтэй нь холбоотой. Энэхүү зэрэглэл нь тус Форумас гаргадаг *Дэлхийн Дахины Мэдээллийн Технологийн Тайлан 2004-2005*

ба түүнд агуулагдсан Сүлжээлэгдсэн бэлэн байдлын индексэд Сингапур улс нэгдүгээр байр эзэлсэнтэй бүрэн нийцэж байгаа юм.

Эрүүл мэнд ба бага боловсролын болон бизнесийн боловсронгуй байдлын тулгууруудад Япон улс нэгдүгээр байр эзэлж байна. Япон улсад ДОХ өвчний халдварын түвшин маш доогуур, хүн амын дундаж наслалт өндөр, нялхсын эндэгдэл маш бага түвшинд байдаг. Түүнчлэн Японд ажилчдын өвчлөлийн бизнест үзүүлэх нөлөө маш бага байдаг. Энэ нь Япон улсыг хүний үндсэн капиталын чанараар дэлхийд тэргүүлэгч орон болгож байна. Мөн Япон улс бизнесийн боловсронгуй байдлын тулгуур үзүүлэлтээр нэгдүгээр байр эзэлдэг. Япон улс хамгийн шилдэг бизнесийн сүлжээтэй (өндөр чанартай дотоодын нийлүүлэгч асар олон байдаг) төдийгүй хувь компаний үйл ажиллагаа, стратегиараа хамгийн шилдгүүдийн тоонд ордог. Үүнд олон улсын түгээлт, маркетингэд тавьдаг дотоодын хяналт (2), нарийн хийцтэй, өндөр үнэ өртөг шингээсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл (1), өндөр чанартай үйлдвэрлэлийн үйл явц (1) зэрэг хүчин зүйлс ордог.

Зах зээлийн үр ашигтай байдал ба шинийг санаачлалтын тулгууруудад Америкийн Нэгдсэн Улс нэгдүгээр байр эзэлсэн байна. Зах зээлийн үр ашигтай байдал нь гурван дэд индексээс (бараа бүтээгдэхүүний зах зээл, хөдөлмөрийн зах зээл, санхүүгийн зах зээл) бүрдэх бөгөөд АНУ бараа бүтээгдэхүүний болон санхүүгийн зах зээлийн хоёуланд нь нэгдүгээр байр, хөдөлмөрийн зах зээлээр хоёрдугаар байрт оржээ. Бараа бүтээгдэхүүний зах зээлийн хувьд гажуудлын түвшин АНУ-д нилээд доогуур байдаг бөгөөд дотоодын ба гадаадын өрсөлдөөний маш хүчтэй орчинтой. Хөрөнгө оруулалтын капиталын бэлэн байдал, банкны зээл авахад хялбар байдал, маш боловсронгуй хөрөнгийн зах зээл, дотоодын хөрөнгийн зах зээл дээр хувьцаа гаргах замаар мөнгөн сан бүрдүүлэхэд хялбар байдал зэрэг нь бүгд л АНУ яагаад санхүүгийн зах зээлийн дэд индексэд тэргүүн байр эзэлснийг тайлбарлаж байна. Эцэст нь цалин хөлс тогтоох үйл явц, ажилчдыг ажилд авах, ажлаас халахад уян хатан байдал, хамаатан саднаа илүүд үзэх явдал бараг байхгүй байдал, ажилчдын цалин хөлс ба бүтээмж хоёр хоорондоо хүчтэй хамааралтай байдаг зэрэг нь бүгд АНУ-ын хөдөлмөрийн зах зээлийн үр ашигтай, уян хатан байдлыг дээшлүүлж өгдөг. Мөн АНУ шинийг санаачлалтын тулгуур үзүүлэлтээр тэргүүн байр эзэлдэг. Энэ нь уг индексэд орсон

бараг бүх хувьсагчид АНУ хамгийн өндөр зэрэглэлтэй байдагтай холбоотой: тухайлбал, шинжлэх ухааны судалгааны хүрээлэнгүүд (1), компаниудын судалгаа, хөгжлийн ажилд зарцуулж буй хөрөнгө (1), бизнесийн салбар ба их дээд сургуулиудын хоорондын судалгаа, хөгжлийн ажлын хамтын ажиллагаа (1), оюуны өмчийн хамгаалалт (1), засгийн газрын дэвшилтэт технологийн бүтээгдэхүүнээр хангалт (8), эрдэмтэд, инженерүүдийн бэлэн байдал (13), шинийг санаачлах чадавхи (4), бүртгүүлсэн патентын тоо (1) зэргээрээ дээгүүр байр эзэлжээ. АНУ өөрийн хамгийн ойр өрсөлдөгч Япон улсаас илт түрүүлж явна.

Дэд бүтцийн тулгуур үзүүлэлтээр Дани улс тэргүүн байр эзэлжээ. Дани улс дэлхий дээр хамгийн өндөр чанартай ерөнхий дэд бүтэцтэй байгаад сайн чанарын зам, усан боомт, телефон утас, агаарын тээвэр, эрчим хүчний хангамжтай нь бүгд нөлөөлсөн байна. Харин макро эдийн засгийн тулгуурт Чили улс нэгдүгээрт бичигджээ: тус улсын эрх баригчид төрийн мөнгө санхүүг бахадмаар хянамгай, тууштай удирдаж байгаа бөгөөд тус улсын хүчтэй өсөлтийн байдлаас үүдэн улсын өрийн түвшин огцом буурах хандлагатай байж (2004 онд ДНБ-ний 12 хувьтай тэнцэж байсан), засгийн газар нь бүтээмжийг дээшлүүлэгч чиглэлүүдэд хөрөнгө оруулах, мөн ядуурлын гаралтыг бууруулахад сэтгэл хөдлөм ахиц дэвшил гаргах боломж олгосон байна. Инфляцийн хувьд онц сайн амжилттай байгаа тус улсын мөнгөний бодлого баригчид нөгөө талаар боловсронгуй болсон санхүүгийн салбараа үр ашигтай удирдан зохицуулах тал дээр нилээд их анхаарал хандуулж байна. Эцэст нь, Дэлхийн дахины өрсөлдөх чадварын индексэд хоёрдугаар байр эзэлсэн Финлянд улс дээд боловсрол ба мэргэжлийн сургалтын тулгуур үзүүлэлтээр тэргүүн байр эзэлсэн бөгөөд дээд боловсролд хамрагдалтын түвшин нь дэлхийд хамгийн өндөр (87.5 хувь), түүнчлэн математикийн болон шинжлэх ухааны боловсролын чанар өндөртэй, менежментийн маш сайн сургуулиудтай, ажил эрхлэгчдийн сургалт, хөгжлийн түвшин маш өндөртэй байна.

Хүснэгт 9: Дэлхий Дахины Өрсөлдөх Чадварын Индекс 2005

ГУРВАН ДЭД ИНДЕКС

Улс	ЕРӨНХИЙ ИНДЕКС		Үндсэн шаардлага		Үр ашиг дээшлүүлэгч		Шинийг санаачлалтын хүчин зүйлс	
	Байр	Оноо	Байр	Оноо	Байр	Оноо	Байр	Оноо
Америкийн Нэгдсэн Улс	1	5.85	18	5.61	1	5.85	1	6.07
Финлянд	2	5.73	2	6.05	5	5.54	5	5.68
Дани	3	5.73	1	6.15	3	5.60	7	5.47
Швейцарь	4	5.67	6	5.91	7	5.44	4	5.73
Сингапур	5	5.67	3	6.05	2	5.70	14	5.24
Герман	6	5.56	8	5.79	19	5.16	3	5.86
Швед	7	5.55	7	5.80	9	5.40	6	5.50
Тайвань	8	5.52	19	5.60	6	5.50	8	5.44
Их Британи	9	5.51	17	5.63	4	5.56	11	5.33
Япон	10	5.50	25	5.43	17	5.19	2	5.98
Нидерланд	11	5.39	9	5.77	16	5.21	12	5.26
Франц	12	5.39	16	5.65	18	5.18	9	5.41
Канад	13	5.39	11	5.73	11	5.32	16	5.14
Гонконг	14	5.35	4	5.98	12	5.29	21	4.80
Австри	15	5.34	14	5.67	21	5.15	13	5.25
Исланд	16	5.34	13	5.68	10	5.34	18	4.99
Норвеги	17	5.31	5	5.94	15	5.22	20	4.81
Австрали	18	5.31	12	5.71	8	5.43	23	4.75
БН Солонгос Улс	19	5.28	20	5.58	20	5.16	17	5.06
Бельги	20	5.23	21	5.53	23	5.04	15	5.19
Ирланд	21	5.22	22	5.52	14	5.23	19	4.91
Шинэ Зеланд	22	5.22	15	5.66	13	5.24	22	4.75
Израйль	23	5.22	31	5.18	22	5.11	10	5.40
Люксембург	24	5.04	10	5.77	26	4.76	24	4.69
Малайз	25	5.03	26	5.42	25	4.79	25	4.67
Эстони	26	5.03	29	5.30	24	5.00	34	4.05
Чили	27	4.84	24	5.46	31	4.49	32	4.09
Испани	28	4.80	28	5.33	27	4.68	28	4.41
БН Чех Улс	29	4.76	37	5.03	28	4.64	27	4.44
Словен	30	4.62	32	5.14	29	4.52	31	4.20
Португал	31	4.60	30	5.29	32	4.47	35	4.04
Арабын Нэгдсэн Эмират	32	4.59	23	5.51	33	4.42	42	3.90
Тайланд	33	4.59	34	5.10	41	4.22	38	4.01
Литви	34	4.51	43	4.84	35	4.36	40	3.94
Унгар	35	4.50	49	4.68	30	4.50	39	3.98
БН Словак Улс	36	4.48	47	4.74	34	4.40	43	3.88
Тунис	37	4.48	33	5.13	48	4.02	33	4.08
Итали	38	4.47	44	4.79	36	4.35	30	4.32
Латви	39	4.46	41	4.84	37	4.33	62	3.57
Өмнөд Африк	40	4.43	46	4.77	43	4.17	29	4.32
Кипр	41	4.40	36	5.05	40	4.26	41	3.93
Иордан	42	4.38	40	4.89	49	3.92	50	3.73
Польш	43	4.38	57	4.60	38	4.30	45	3.87
Мальт	44	4.34	39	4.94	39	4.29	70	3.47
Энэтхэг	45	4.32	65	4.47	46	4.09	26	4.48
Катар	46	4.31	27	5.34	45	4.13	67	3.52
Грек	47	4.28	42	4.84	42	4.19	47	3.84
Хятад	48	4.26	45	4.79	62	3.70	48	3.83
Кувейт	49	4.24	35	5.05	44	4.13	61	3.58
Бахрейн	50	4.19	38	5.00	47	4.08	83	3.30
Казакстан	51	4.17	51	4.66	56	3.83	58	3.59
Египт	52	4.10	53	4.64	68	3.59	71	3.47
Оросын Холбооны Улс	53	4.10	60	4.53	53	3.87	66	3.53
Аргентин	54	4.09	62	4.52	57	3.81	52	3.72
Мавритани	55	4.08	64	4.51	58	3.78	46	3.85
Коста Рика	56	4.08	73	4.32	50	3.90	37	4.01
Бразил	57	4.08	77	4.32	51	3.89	36	4.03
Колумби	58	4.07	63	4.52	67	3.63	49	3.74
Мексик	59	4.07	55	4.61	61	3.73	57	3.60
Эль Сальвадор	60	4.05	50	4.67	73	3.53	73	3.45

Хүснэгт 9: Дэлхий Дахины Өрсөлдөх Чадварын Индекс 2005 /үргэлжлэл/

ГУРВАН ДЭД ИНДЕКС

Улс	ЕРӨНХИЙ ИНДЕКС		Үндсэн шаардлага		Үр ашиг дээшлүүлэгч		Шинийг санаачлалтын хүчин зүйлс	
	Байр	Оноо	Байр	Оноо	Байр	Оноо	Байр	Оноо
Болгар	61	4.04	58	4.54	59	3.78	74	3.39
Азербайжан	62	4.04	48	4.71	79	3.33	64	3.55
Ямайк	63	4.03	72	4.33	52	3.87	59	3.59
Хорват	64	4.01	67	4.46	60	3.75	65	3.54
Панам	65	4.00	59	4.54	65	3.64	54	3.68
Тринадад Тобаго	66	3.99	56	4.60	66	3.63	69	3.49
Румын	67	3.98	76	4.32	55	3.84	76	3.37
Украйн	68	3.97	74	4.32	64	3.64	60	3.59
Индонези	69	3.96	71	4.38	74	3.52	55	3.63
Уругвай	70	3.95	54	4.61	71	3.53	75	3.39
Турк	71	3.94	89	4.05	54	3.86	44	3.88
Ботсвани	72	3.94	61	4.53	69	3.58	77	3.37
Филиппин	73	3.93	81	4.20	63	3.67	56	3.61
Вьетнам	74	3.91	68	4.43	77	3.39	79	3.36
Македон	75	3.84	69	4.42	81	3.32	81	3.31
Марокко	76	3.83	70	4.38	84	3.27	78	3.37
Перу	77	3.83	82	4.20	70	3.57	82	3.31
Гана	78	3.82	86	4.07	72	3.53	53	3.70
Намиби	79	3.80	66	4.46	86	3.25	89	3.15
Шри Ланк	80	3.77	84	4.13	78	3.37	68	3.52
Армян	81	3.75	80	4.20	82	3.29	80	3.35
Алжир	82	3.75	52	4.66	94	3.02	97	3.01
Нигери	83	3.74	78	4.26	90	3.17	72	3.46
Венесуэл	84	3.71	79	4.23	76	3.42	92	3.11
Серб Монтенегро	85	3.67	92	3.98	75	3.43	85	3.19
Гүрж	86	3.61	88	4.05	88	3.23	103	2.94
Эквадор	87	3.59	75	4.32	104	2.93	101	2.94
Босни Герцеговин	88	3.58	87	4.06	91	3.14	98	2.97
Молдав	89	3.58	93	3.98	89	3.22	96	3.05
Монгол	90	3.57	98	3.89	80	3.33	105	2.89
БН Доминикан Улс	91	3.56	97	3.91	85	3.26	93	3.10
Тажикстан	92	3.53	85	4.11	99	2.96	102	3.94
Кени	93	3.52	108	3.67	83	3.29	51	3.72
Пакистан	94	3.51	105	3.70	87	3.25	63	3.57
Гватемал	95	3.50	90	4.05	103	2.93	94	3.08
Никарагуа	96	3.48	91	4.02	97	2.99	107	2.79
Гондурас	97	3.47	83	4.14	110	2.77	104	2.93
Бангладеш	98	3.45	95	3.92	100	2.95	90	3.13
Камерун	99	3.42	101	3.84	101	2.94	84	3.29
Албани	100	3.40	96	3.91	95	3.02	112	2.64
Болив	101	3.39	99	3.89	98	2.97	114	2.57
Парагвай	102	3.36	94	3.96	107	2.80	115	2.56
Уганда	103	3.36	107	3.67	96	3.00	86	3.18
БН Киргиз Улс	104	3.35	106	3.69	92	3.08	109	2.75
Танзани	105	3.35	103	3.75	105	2.90	88	3.16
Бенин	106	3.33	100	3.88	111	2.73	100	2.94
Мадагскар	107	3.30	102	3.75	109	2.79	95	3.07
Гайана	108	3.27	111	3.64	102	2.93	110	2.75
Гамби	109	3.26	110	3.64	106	2.90	108	2.78
Зимбабве	110	3.25	113	3.43	93	3.05	87	3.17
Камбож	111	3.20	104	3.71	114	2.71	113	2.61
Мозамбик	112	3.17	112	3.61	113	2.71	106	2.86
Зүүн Тимор	113	3.09	109	3.66	105	2.55	117	2.39
Малави	114	3.08	114	3.31	108	2.80	99	2.97
Мали	115	2.94	116	3.08	112	2.72	91	3.13
Этиоп	116	2.85	115	3.19	116	2.48	111	2.67
Чад	117	2.65	117	3.03	117	2.22	116	2.50

Хүснэгт 10: Дэлхий Дахины Өрсөлдөх Чадварын Индекс: Үндсэн шаардлага

Улс	Үндсэн шаардлага		1.Институциуд		2. Дэд бүтэц		3. Макро эдийн засаг		4. Эрүүл мэнд ба бага боловсрол	
	Байр	Оноо	Байр	Оноо	Байр	Оноо	Байр	Оноо	Байр	Оноо
Албани	96	3.91	107	2.94	116	1.77	85	4.10	36	6.83
Алжир	52	4.66	74	3.42	80	2.88	3	5.69	66	6.63
Аргентин	62	4.52	98	3.08	63	3.53	46	4.67	41	6.81
Армян	80	4.20	77	3.40	95	2.57	70	4.31	75	6.52
Австрали	12	5.71	8	5.38	19	5.42	27	5.08	3	6.97
Австри	14	5.67	9	5.38	18	5.47	33	4.89	13	6.95
Азербайжан	48	4.71	67	3.61	51	3.73	12	5.44	92	6.05
Бахрейн	38	5.00	45	4.18	42	4.10	28	5.06	63	6.64
Бангладеш	95	3.92	108	2.90	101	2.38	68	4.35	94	6.03
Бельги	21	5.53	29	4.70	13	5.74	40	4.74	20	6.93
Бенин	100	3.88	101	3.04	110	2.09	60	4.41	95	6.00
Болив	99	3.89	112	2.81	98	2.49	94	3.89	82	6.37
Босни Герцеговин	87	4.06	106	2.94	100	2.40	52	4.54	84	6.36
Ботсвани	61	4.53	31	4.59	60	3.57	41	4.72	106	5.24
Бразил	77	4.32	79	3.38	70	3.20	91	3.97	52	6.72
Болгар	58	4.54	95	3.12	59	3.61	47	4.65	42	6.80
Камбож	104	3.71	105	2.94	103	2.32	100	3.73	99	5.84
Камерун	101	3.84	91	3.14	114	1.97	74	4.26	97	5.97
Канад	11	5.73	21	4.96	11	5.91	25	5.10	8	6.96
Чад	117	3.03	115	2.56	117	1.55	96	3.82	113	4.17
Чили	24	5.46	27	4.76	34	4.40	1	5.78	25	6.91
Хятад	45	4.79	60	3.72	65	3.44	13	5.33	61	6.65
Колумби	63	4.52	69	3.57	71	3.19	51	4.54	48	6.76
Коста Рика	73	4.32	59	3.74	73	3.16	109	3.51	28	6.89
Хорват	67	4.46	72	3.44	54	3.67	86	4.10	67	6.62
Кипр	36	5.05	30	4.65	30	4.59	81	4.20	49	6.75
БН Чех Улс	37	5.03	52	3.83	28	4.82	49	4.59	27	6.90
Дани	1	6.15	2	5.91	1	6.48	16	5.29	23	6.91
БН Доминикан Улс	97	3.91	111	2.83	94	2.58	107	3.59	65	6.63
Зүүн Тимор	109	3.66	102	3.02	115	1.84	78	4.21	103	5.56
Эквадор	75	4.32	114	2.60	84	2.74	19	5.22	51	6.72
Египет	53	4.64	49	3.91	55	3.66	50	4.57	79	6.42
Эль Сальвадор	50	4.67	57	3.75	52	3.72	59	4.46	46	6.77
Эстони	29	5.30	32	4.58	31	4.59	18	5.24	40	6.81
Этиоп	115	3.19	80	3.36	105	2.31	101	3.71	116	3.36
Финлянд	2	6.05	3	5.77	10	6.02	10	5.46	10	6.95
Франц	16	5.65	20	4.96	3	6.28	61	4.40	6	6.96
Гамби	110	3.64	58	3.74	91	2.62	111	3.27	112	4.95
Гүрж	88	4.05	82	3.32	83	2.76	87	4.07	91	6.06
Герман	8	5.79	11	5.33	2	6.44	54	4.49	24	6.91
Гана	86	4.07	34	4.51	74	3.14	90	4.06	112	4.57
Грек	42	4.84	44	4.19	33	4.49	99	3.74	17	6.94
Гватемал	90	4.05	113	2.69	93	2.60	64	4.36	73	6.55
Гайана	111	3.64	110	2.83	109	2.11	113	3.14	78	6.47
Гондурас	83	4.14	103	2.97	82	2.77	82	4.20	62	6.65
Гонконг	4	5.98	17	5.19	6	6.17	6	5.64	19	6.93
Унгар	49	4.68	43	4.19	45	4.02	105	3.64	33	6.85
Исланд	13	5.68	4	5.70	21	5.37	43	4.70	12	6.95
Энэтхэг	65	4.47	41	4.25	69	3.21	88	4.06	87	6.33
Индонези	71	4.38	65	3.62	75	3.12	63	4.39	80	6.41
Ирланд	22	5.52	14	5.27	32	4.58	15	5.31	21	6.93
Израйль	31	5.18	33	4.57	27	4.86	67	4.35	7	6.96
Итали	44	4.79	55	3.77	39	4.18	76	4.23	5	6.97
Ямайк	72	4.33	68	3.59	56	3.64	112	3.25	35	6.83
Япон	25	5.43	26	4.78	9	6.02	93	3.93	1	6.98
Иордан	40	4.89	28	4.71	49	3.89	75	4.25	53	6.70
Казакстан	51	4.66	64	3.65	62	3.54	26	5.10	83	6.37
Кени	108	3.67	90	3.20	89	2.63	104	3.69	107	5.16
БН Солонгос Улс	20	5.58	38	4.39	20	5.39	5	5.65	30	6.87
Кувейт	35	5.05	39	4.35	43	4.09	2	5.77	96	5.99
БН Киргиз Улс	106	3.69	109	2.85	106	2.31	115	3.03	71	6.58
Латви	41	4.84	48	3.92	38	4.19	32	4.91	86	6.35

Хүснэгт 10: Дэлхий Дахины Өрсөлдөх Чадварын Индекс: Үндсэн шаардлага /үргэлжлэл/

Улс	Үндсэн шаардлага		1.Институциуд		2. Дэд бүтэц		3. Макро эдийн засаг		4. Эрүүл мэнд ба бага боловсрол	
	Байр	Оноо	Байр	Оноо	Байр	Оноо	Байр	Оноо	Байр	Оноо
Литви	43	4.84	54	3.80	44	4.09	37	4.78	57	6.68
Люксембург	10	5.77	12	5.32	16	5.54	14	5.33	29	6.88
Македон	69	4.42	100	3.06	79	2.93	22	5.14	72	6.56
Мадагскар	102	3.75	84	3.30	104	2.32	110	3.45	98	5.94
Малави	114	3.31	62	3.69	112	2.04	117	2.39	108	5.14
Малайз	26	5.42	15	5.22	22	5.24	31	4.93	88	6.29
Мали	116	3.08	61	3.72	111	2.07	97	3.80	117	2.72
Мальт	39	4.94	35	4.45	41	4.10	73	4.27	16	6.94
Мавритани	64	4.51	53	3.83	46	3.97	89	4.06	89	6.18
Мексик	55	4.61	73	3.44	67	3.32	34	4.85	37	6.83
Молдав	93	3.98	94	3.12	78	2.94	80	4.21	102	5.65
Монгол	98	3.89	96	3.10	107	2.28	102	3.70	76	6.50
Марокко	70	4.38	70	3.53	68	3.26	79	4.21	74	6.54
Мозамбик	112	3.61	85	3.27	96	2.51	108	3.55	109	5.09
Намиби	66	4.46	50	3.87	40	4.15	57	4.46	104	5.35
Нидерланд	9	5.77	13	5.27	7	6.12	39	4.75	14	6.94
Шинэ Зеланд	15	5.66	7	5.47	23	5.07	21	5.17	18	6.93
Никарагуа	91	4.02	97	3.08	102	2.36	92	3.97	56	6.68
Нигери	78	4.26	76	3.40	92	2.61	20	5.20	100	5.82
Норвеги	5	5.94	5	5.54	14	5.60	4	5.67	9	6.96
Пакистан	105	3.70	75	3.41	76	3.07	69	4.32	115	4.01
Панам	59	4.54	71	3.51	61	3.55	72	4.28	39	6.82
Парагвай	94	3.96	117	2.37	108	2.21	56	4.48	44	6.80
Перу	82	4.20	99	3.06	88	2.64	55	4.48	68	6.60
Филиппин	81	4.20	89	3.21	90	2.62	58	4.46	77	6.49
Польш	57	4.60	66	3.61	50	3.80	83	4.14	38	6.83
Португал	30	5.29	23	4.86	26	4.88	53	4.53	26	6.90
Катар	27	5.34	19	5.04	47	3.96	8	5.58	45	6.78
Румын	76	4.32	83	3.32	66	3.43	95	3.88	64	6.64
Оросын Холбооны Улс	60	4.53	104	2.94	53	3.71	36	4.81	60	6.65
Серб ба Монтенегро	92	3.98	93	3.12	97	2.50	106	3.64	58	6.67
Сингапур	3	6.05	1	5.92	5	6.19	9	5.48	69	6.60
БН Словак Улс	47	4.74	51	3.84	48	3.91	66	4.35	31	6.86
Словен	32	5.14	46	4.13	29	4.69	35	4.84	22	6.92
Өмнөд Африк	46	4.77	36	4.42	35	4.33	48	4.61	101	5.73
Испани	28	5.33	37	4.40	25	4.95	29	5.01	11	6.95
Шри Ланк	84	4.13	88	3.22	81	2.87	103	3.70	50	6.72
Швед	7	5.80	18	5.09	12	5.85	17	5.28	2	6.98
Швейцарь	6	5.91	6	5.51	4	6.20	30	4.97	4	6.97
Тайвань	19	5.60	22	4.88	15	5.55	23	5.13	32	6.85
Тажикстан	85	4.11	81	3.32	99	2.45	71	4.29	81	6.39
Танзани	103	3.75	47	4.01	86	2.67	84	4.14	114	4.16
Тайланд	34	5.10	40	4.35	37	4.22	11	5.45	85	6.36
Тринадад Тобаго	56	4.60	78	3.39	72	3.19	24	5.13	55	6.69
Тунис	33	5.13	25	4.80	36	4.28	38	4.78	59	6.65
Турк	89	4.05	56	3.76	64	3.44	116	2.98	93	6.03
Уганда	107	3.67	87	3.24	113	1.98	77	4.22	105	5.25
Украйн	74	4.32	92	3.13	58	3.63	65	4.36	90	6.16
АН Эмират Улс	23	5.51	24	4.83	24	4.97	7	5.63	70	6.59
Их Британи	17	5.63	10	5.35	17	5.52	42	4.72	15	6.94
АНУ	18	5.61	16	5.21	8	6.06	62	4.39	47	6.77
Уругвай	54	4.61	42	4.20	57	3.63	98	3.76	34	6.84
Венесуэл	79	4.23	116	2.47	77	2.96	45	4.68	43	6.80
Вьетнам	68	4.43	63	3.66	85	2.69	44	4.69	54	6.69
Зимбабве	113	3.43	86	3.25	87	2.65	114	3.04	111	4.76

Хүснэгт 11: Дэлхий Дахины Өрсөлдөх Чадварын Индекс: Үр ашиг дээшлүүлэгч

Улс	Үр ашиг дээшлүүлэгч		5. Дээд боловсрол ба мэргэжлийн сургалт		6. Зах зээлийн үр ашигтай байдал		7. Технологийн бэлэн байдал	
	Байр	Оноо	Байр	Оноо	Байр	Оноо	Байр	Оноо
Албани	95	3.02	93	3.19	100	3.43	98	2.44
Алжир	94	3.02	87	3.35	101	3.42	107	2.29
Аргентин	57	3.81	35	4.68	84	3.65	62	3.11
Армян	82	3.29	67	3.80	93	3.52	91	2.56
Австрали	8	5.43	9	5.66	11	5.21	10	5.41
Австри	21	5.15	17	5.46	18	4.97	21	5.04
Азербайжан	79	3.33	78	3.62	87	3.60	79	2.77
Бахрейн	47	4.08	72	3.74	37	4.49	38	4.02
Бангладеш	100	2.95	103	2.68	76	3.85	106	2.31
Бельги	23	5.04	4	5.75	30	4.70	25	4.66
Бенин	111	2.73	106	2.65	98	3.46	114	2.09
Болив	98	2.97	84	3.43	113	3.21	111	2.26
Босни Герцеговин	91	3.14	81	3.57	91	3.53	105	2.33
Ботсвани	69	3.58	83	3.52	43	4.30	72	2.92
Бразил	51	3.89	50	4.19	55	4.14	51	3.35
Болгар	59	3.78	45	4.30	78	3.84	58	3.18
Камбож	114	2.71	112	2.44	103	3.40	108	2.28
Камерун	101	2.94	99	3.01	90	3.53	110	2.27
Канад	11	5.32	11	5.65	6	5.27	22	5.03
Чад	117	2.22	117	1.94	117	2.92	117	1.79
Чили	31	4.49	42	4.45	24	4.86	36	4.16
Хятад	62	3.70	69	3.76	47	4.26	65	3.08
Колумби	67	3.63	64	3.83	53	4.19	75	2.86
Коста Рика	50	3.90	56	4.08	66	4.04	47	3.58
Хорват	60	3.75	54	4.10	77	3.85	54	3.31
Кипр	40	4.26	39	4.53	51	4.21	37	4.05
БН Чех Улс	28	4.64	27	4.96	39	4.40	27	4.56
Дани	3	5.60	3	5.82	5	5.31	2	5.69
БН Доминикан Улс	85	3.26	94	3.18	96	3.49	63	3.10
Зүүн Тимор	115	2.55	115	2.34	116	3.02	109	2.27
Эквадор	104	2.93	98	3.04	112	3.23	93	2.51
Египет	68	3.59	66	3.82	68	3.99	70	2.95
Эль Сальвадор	73	3.53	86	3.38	50	4.21	69	2.99
Эстони	24	5.00	23	5.18	26	4.78	20	5.04
Этиоп	116	2.48	116	2.25	114	3.15	116	2.03
Финлянд	5	5.54	1	6.13	12	5.10	12	5.40
Франц	18	5.18	5	5.75	20	4.91	24	4.86
Гамби	106	2.90	108	2.62	86	3.61	96	2.46
Гүрж	88	3.23	80	3.60	83	3.69	100	2.41
Герман	19	5.16	15	5.48	22	4.90	16	5.11
Гана	72	3.53	85	3.42	44	4.30	73	2.87
Грек	42	4.19	32	4.78	48	4.21	46	3.59
Гватемал	103	2.93	102	2.79	107	3.36	83	2.64
Гайана	102	2.93	95	3.16	105	3.39	112	2.25
Гондурас	110	2.77	107	2.63	111	3.24	95	2.46
Гонконг	12	5.29	31	4.78	3	5.62	7	5.47
Унгар	30	4.50	30	4.79	36	4.54	35	4.17
Исланд	10	5.34	22	5.39	15	5.01	4	5.61
Энэтхэг	46	4.09	46	4.28	27	4.77	57	3.22
Индонези	74	3.52	76	3.65	61	4.08	77	2.82
Ирланд	14	5.23	21	5.40	13	5.08	13	5.20
Израиль	22	5.11	20	5.41	21	4.90	23	5.00
Итали	36	4.35	33	4.69	59	4.10	33	4.26
Ямайк	52	3.87	71	3.75	54	4.15	42	3.71
Япон	17	5.19	16	5.46	16	5.00	17	5.09
Иордан	49	3.92	48	4.21	46	4.26	55	3.28
Казакстан	56	3.83	52	4.17	52	4.20	61	3.12
Кени	83	3.29	90	3.23	75	3.86	78	2.79
БН Солонгос Улс	20	5.16	19	5.44	32	4.65	11	5.40
Кувейт	44	4.13	60	3.93	28	4.76	41	3.71
БН Киргиз Улс	92	3.08	75	3.69	92	3.52	115	2.03
Латви	37	4.33	29	4.87	49	4.21	39	3.91

Хүснэгт 11: Дэлхий Дахины Өрсөлдөх Чадварын Индекс: Үр ашиг дээшлүүлэгч /үргэлжлэл/

Улс	Үр ашиг дээшлүүлэгч		5. Дээд боловсрол ба мэргэжлийн сургалт		6. Зах зээлийн үр ашигтай байдал		7. Технологийн бэлэн байдал	
	Байр	Оноо	Байр	Оноо	Байр	Оноо	Байр	Оноо
Литва	35	4.36	25	5.02	40	4.38	43	3.69
Люксембург	26	4.76	51	4.19	19	4.92	14	5.17
Македон	81	3.32	62	3.91	97	3.47	88	2.58
Мадагскар	109	2.79	110	2.52	94	3.50	103	2.36
Малави	108	2.80	109	2.60	85	3.64	113	2.18
Малайз	25	4.79	36	4.63	9	5.22	28	4.51
Мали	112	2.72	113	2.39	102	3.42	102	2.36
Мальт	39	4.29	49	4.19	60	4.08	26	4.60
Мавритани	58	3.78	63	3.91	71	3.93	48	3.52
Мексик	61	3.73	68	3.79	62	4.08	53	3.32
Молдав	89	3.22	82	3.55	89	3.56	92	2.55
Монгол	80	3.33	65	3.83	88	3.59	90	2.56
Марокко	84	3.27	89	3.24	80	3.80	80	2.76
Мозамбик	113	2.71	111	2.44	110	3.25	97	2.44
Намиби	86	3.25	100	3.01	79	3.83	71	2.92
Нидерланд	16	5.21	13	5.55	14	5.03	18	5.05
Шинэ Зеланд	13	5.24	18	5.46	10	5.22	19	5.05
Никарагуа	97	2.99	91	3.20	108	3.34	99	2.42
Нигери	90	3.17	96	3.08	70	3.95	94	2.47
Норвеги	15	5.22	14	5.54	17	5.00	15	5.12
Пакистан	87	3.25	104	2.68	41	4.34	82	2.73
Панам	65	3.64	70	3.75	63	4.06	64	3.10
Парагвай	107	2.80	101	2.99	115	3.08	104	2.35
Перу	70	3.57	74	3.70	69	3.98	68	3.03
Филиппин	63	3.67	61	3.92	64	4.05	67	3.06
Польш	38	4.30	28	4.92	42	4.33	45	3.65
Португал	32	4.47	37	4.61	34	4.57	34	4.21
Катар	45	4.13	59	3.94	35	4.54	40	3.91
Румын	55	3.84	44	4.33	74	3.87	52	3.32
Оросын Холбооны Улс	53	3.87	34	4.69	65	4.04	74	2.87
Серб ба Монтенегро	75	3.43	58	4.00	99	3.46	76	2.84
Сингапур	2	5.70	8	5.68	4	5.59	1	5.82
БН Словак Улс	34	4.40	40	4.47	38	4.42	32	4.29
Словени	29	4.52	24	5.08	58	4.11	31	4.38
Өмнөд Африк	43	4.17	47	4.22	33	4.63	44	3.66
Испани	27	4.68	26	5.00	31	4.67	30	4.38
Шри Ланк	78	3.37	79	3.61	72	3.89	85	2.61
Швед	9	5.40	7	5.69	25	4.85	3	5.67
Швейцарь	7	5.44	10	5.65	7	5.23	8	5.43
Тайвань	6	5.50	6	5.69	8	5.22	6	5.59
Тажикстан	99	2.96	97	3.06	104	3.40	101	2.41
Танзани	105	2.90	114	2.36	81	3.77	89	2.57
Тайланд	41	4.22	43	4.45	29	4.72	49	3.50
Тринадад Тобаго	66	3.63	73	3.71	67	4.04	59	3.14
Тунис	48	4.02	38	4.53	45	4.27	56	3.27
Турк	54	3.86	55	4.10	57	4.11	50	3.38
Уганда	96	3.00	105	2.67	82	3.74	86	2.60
Украин	64	3.64	41	4.46	73	3.87	87	2.58
Арабын Нэгдсэн Эмират	33	4.42	57	4.00	23	4.87	29	4.39
Их Британи	4	5.56	12	5.63	2	5.64	9	5.42
Америкийн Нэгдсэн Улс	1	5.85	2	6.04	1	5.91	5	5.61
Уругвай	71	3.53	53	4.15	106	3.38	66	3.07
Венесуэл	76	3.42	77	3.63	95	3.49	60	3.13
Вьетнам	77	3.39	88	3.32	56	4.12	81	2.74
Зимбабве	93	3.05	92	3.19	109	3.34	84	2.62

Хүснэгт 12: Дэлхий Дахины Өрсөлдөх Чадварын Индекс: Шинийг санаачлалтын хүчин зүйлс

Улс	Шинийг санаачлалтын хүчин зүйлс		8. Бизнесийн боловсронгуй байдал		9. Шинийг санаачлалт	
	Байр	Оноо	Байр	Оноо	Байр	Оноо
Албани	112	2.64	107	3.14	115	2.14
Алжир	97	3.01	102	3.24	90	2.78
Аргентин	52	3.72	50	4.25	56	3.18
Армян	80	3.35	81	3.69	73	3.01
Австрали	23	4.75	24	5.18	22	4.31
Австри	13	5.25	5	5.85	17	4.65
Азербайжан	64	3.55	71	3.89	53	3.21
Бахрейн	83	3.3	62	4.03	102	2.57
Бангладеш	90	3.13	86	3.59	98	2.68
Бельги	15	5.19	10	5.74	18	4.64
Бенин	100	2.94	105	3.19	95	2.69
Болив	114	2.57	116	2.9	112	2.24
Босни Герцеговин	98	2.97	94	3.36	101	2.59
Ботсвани	77	3.37	84	3.6	61	3.15
Бразил	36	4.03	33	4.63	39	3.42
Болгар	74	3.39	79	3.76	72	3.01
Камбож	113	2.61	115	2.91	110	2.32
Камерун	84	3.29	87	3.56	70	3.03
Канад	16	5.14	17	5.35	12	4.92
Чад	116	2.5	114	2.92	116	2.09
Чили	32	4.09	31	4.77	41	3.41
Хятад	48	3.83	58	4.11	35	3.56
Колумби	49	3.74	48	4.31	58	3.16
Коста Рика	37	4.01	38	4.54	37	3.49
Хорват	65	3.54	67	3.98	64	3.1
Кипр	41	3.93	35	4.58	50	3.28
БН Чех Улс	27	4.44	29	4.92	26	3.95
Дани	7	5.47	4	5.88	10	5.06
БН Доминикан Улс	93	3.1	80	3.74	107	2.45
Зүүн Тимор	117	2.39	117	2.61	114	2.17
Эквадор	101	2.94	91	3.41	106	2.47
Египет	71	3.47	74	3.87	66	3.07
Эль Сальвадор	73	3.45	51	4.21	96	2.68
Эстони	34	4.05	40	4.51	34	3.59
Этиоп	111	2.67	113	2.92	108	2.42
Финлянд	5	5.68	12	5.7	4	5.66
Франц	9	5.41	6	5.83	11	4.98
Гамби	108	2.78	103	3.22	109	2.35
Гүрж	103	2.94	106	3.16	93	2.72
Герман	3	5.86	2	6.23	5	5.49
Гана	53	3.7	65	3.99	40	3.42
Грек	47	3.84	47	4.32	45	3.36
Гватемал	94	3.08	83	3.64	103	2.52
Гайана	110	2.75	104	3.22	111	2.29
Гондурас	104	2.93	93	3.37	105	2.48
Гонконг	21	4.8	14	5.4	24	4.2
Унгар	39	3.98	49	4.28	32	3.69
Исланд	18	4.99	21	5.29	16	4.68
Энэтхэг	26	4.48	27	5.02	27	3.94
Индонези	55	3.63	70	3.93	47	3.32
Ирланд	19	4.91	15	5.39	19	4.44
Израиль	10	5.4	18	5.34	6	5.47
Итали	30	4.32	25	5.12	36	3.52
Ямайк	59	3.59	66	3.98	55	3.2
Япон	2	5.98	1	6.28	2	5.68
Иордан	50	3.73	60	4.04	42	3.41
Казакстан	58	3.59	63	4.03	59	3.16
Кени	51	3.72	55	4.15	48	3.29
БН Солонгос Улс	17	5.06	19	5.31	15	4.81
Кувейт	61	3.58	53	4.19	78	2.97
БН Киргиз Улс	109	2.75	100	3.28	113	2.23
Латви	62	3.57	54	4.16	74	2.99

Хүснэгт 12: Дэлхий Дахины Өрсөлдөх Чадварын Индекс: Шинийг санаачлалтын хүчин зүйлс /үргэлжлэл/

Улс	Шинийг санаачлалтын хүчин зүйлс		8. Бизнесийн боловсронгуй байдал		9. Шинийг санаачлалт	
	Байр	Оноо	Байр	Оноо	Байр	Оноо
Литва	40	3.94	37	4.55	46	3.34
Люксембург	24	4.69	16	5.38	25	4
Македон	81	3.31	82	3.67	82	2.94
Мадагаскар	95	3.07	99	3.3	87	2.83
Малави	99	2.97	95	3.34	100	2.6
Малайз	25	4.67	28	4.98	21	4.37
Мали	91	3.13	98	3.31	81	2.95
Мальт	70	3.47	59	4.09	85	2.86
Мавритани	46	3.85	36	4.57	63	3.12
Мексик	57	3.6	56	4.13	67	3.07
Молдав	96	3.05	97	3.33	92	2.76
Монгол	105	2.89	112	2.99	89	2.79
Марокко	78	3.37	75	3.85	84	2.88
Мозамбик	106	2.86	111	3.04	97	2.68
Намиби	89	3.15	85	3.59	94	2.71
Нидерланд	12	5.26	11	5.71	14	4.81
Шинэ Зеланд	22	4.75	22	5.24	23	4.25
Никарагуа	107	2.79	110	3.06	104	2.51
Нигери	72	3.46	72	3.88	68	3.05
Норвеги	20	4.81	23	5.23	20	4.39
Пакистан	63	3.57	57	4.12	71	3.02
Панам	54	3.68	52	4.21	62	3.15
Парагвай	115	2.56	109	3.11	117	2.02
Перу	82	3.31	69	3.97	99	2.64
Филиппин	56	3.61	43	4.36	86	2.85
Польш	45	3.87	45	4.34	44	3.4
Португал	35	4.04	46	4.33	29	3.75
Катар	67	3.52	73	3.88	60	3.15
Румын	76	3.37	78	3.76	75	2.98
Оросын Холбооны Улс	66	3.53	77	3.78	49	3.29
Серб ба Монтенегро	85	3.19	90	3.41	79	2.96
Сингапур	14	5.24	20	5.3	9	5.18
БН Словак Улс	43	3.88	44	4.35	43	3.4
Словени	31	4.2	32	4.74	33	3.65
Өмнөд Африк	29	4.32	30	4.8	28	3.85
Испани	28	4.41	26	5.11	31	3.71
Шри Ланк	68	3.52	64	3.99	69	3.04
Швед	6	5.5	9	5.75	8	5.25
Швейцарь	4	5.73	7	5.8	3	5.66
Тайвань	8	5.44	13	5.52	7	5.37
Тажикстан	102	2.94	108	3.12	91	2.77
Танзани	88	3.16	96	3.34	77	2.98
Тайланд	38	4.01	39	4.52	38	2.49
Тринадад Тобаго	69	3.49	61	4.04	80	2.95
Тунис	33	4.08	42	4.45	30	3.72
Турк	44	3.88	41	4.51	51	3.24
Уганда	86	3.18	101	3.28	65	3.08
Украин	60	3.59	68	3.97	54	3.21
Арабын Нэгдсэн Эмират	42	3.9	34	4.59	52	3.22
Их Британи	11	5.33	8	5.77	13	4.88
Америкийн Нэгдсэн Улс	1	6.07	3	6.17	1	5.98
Уругвай	75	3.39	76	3.79	76	2.98
Венесуэл	92	3.11	92	3.39	88	2.83
Вьетнам	79	3.36	88	3.55	57	3.18
Зимбабве	87	3.17	89	3.43	83	2.9

Хүснэгт 13: Дэлхий Дахины Өрсөлдөх Чадварын Индексийн есөн тулгуур үзүүлэлтээр хошуучлагчид

Улс	Институцүүд	Дэд бүтэц	Макро эдийн засаг	Эрүүл мэнд ба бага боловсрол	Дээд боловсрол ба сургалт	Зах зээлийн үр ашигтай байдал	Технологийн бэлэн байдал	Бизнесийн боловсронгуй байдал	Шинийг санаачлалт
Сингапур	1	5	9	69	8	4	1	20	9
Дани	2	1	16	23	3	5	2	4	10
Чили	27	34	1	25	42	24	36	31	41
Япон	26	9	93	1	16	16	17	1	2
Финлянд	3	10	10	10	1	12	12	12	4
АНУ	16	8	62	47	2	1	5	3	1

Дүгнэлт

Энэ бүлэгт 2001 оноос хойш тус Форумтай холбоотой явж ирсэн үзүүлэлт болох Өсөлтийн өрсөлдөх чадварын индексийн 2005 оны үр дүнгүүдийг дэлгэрэнгүй үзүүлж байна. Энэ индекс нь тус Форумын зүгээс өсөлтийг тодорхойлогч хүчнүүдийг илүү сайн ойлгоход онцгой чухал гэж үзсэн өргөн хүрээтэй хүчин зүйлсийг авч үзэн, улмаар өрсөлдөх чадварын чиглэлээр хийж буй ажлаа системчлэх хүчин чармайлтад гарсан нэг томоохон алхам юм.

Дэлхий дахины өрсөлдөх чадварын индекс бол тус Форумын өрсөлдөх чадварын талаар хийсэн ажлыг өргөжүүлсэн логик үргэлжлэл нь юм. Энэ нь бараа бүтээгдэхүүн, хөдөлмөр, санхүүгийн зах зээлийн үйл ажиллагаатай холбоотой үр ашгийн хожооны үүрэг, аливаа улсын дэд бүтцийн чанар, нийтийн эрүүл мэнд ба хүний нөөцийн мэдлэг чадварын байдал, компаниудын боловсронгуй байдлын түвшин гэх мэт өмнө нь авч үзэж байгаагүй ойлголтуудыг шинээр оруулж шинжилгээнийхээ цар хүрээг нэмэгдүүлэх замаар өмнө нь Сакс, МакАртур нарын хийсэн ажлын давуу талуудад тулгуурласан болно. Өнгөрсөн жил *Дэлхий Дахины Өрсөлдөх Чадварын Тайлан 2004-2005*-ыг хэвлэн гаргахдаа зарлаж байсанчлан манай стратеги бол Дэлхий дахины өрсөлдөх чадварын индексийг шинжилгээнийхээ ажлын цөм болгох явдал юм. Энэхүү индексийн тулгуурласан цаад үзэл баримтлалын хүрээ болон арга зүйн үндэслэл хүчтэй бөгөөд өсөлтийн үйл явцыг зүй зохистой судлахад гол үүрэгтэй хүчин зүйлсийг илүү өргөнөөр хамруулсан нь бас нэг анхаарал татам онцлог юм. Өсөлтийн ба Дэлхий дахины индексүүд нилээд хэсэг хугацаанд хамт орших болно. Учир нь, өсөлтийн индекс өнгөрсөн үетэй холбох чухал холбоог гаргаж өгдөг бол дэлхий дахины индекс нь тус Форумын өрсөлдөх чадварын чиглэлээр хийж буй ажил улам гүнзгийрч байгааг харуулдаг. Гэхдээ Дэлхий

дахины өрсөлдөх чадварын индекс нь манай өрсөлдөх чадварын үйл ажиллагааны задлан шинжилгээний үндсэн хэрэгсэл болох төлөвтэй байгаа бөгөөд 2006 онд энэхүү индексийн үр дүнгүүд голлох болно.

Тайлбар

- 1 Энэ номын Бүлэг 2.2-д буй Рогоффийн “Валютын ханшны өрсөлдөх чадварыг эргэн харахуй” хэмээх өгүүллийг үзнэ үү.
- 2 Үнэн хэрэгтээ өнгөрсөн арван жилд шинээр гарсан зах зээлийн хямралуудын тухай аливаа шинжилгээнд валютын ханш гол үүрэг гүйцэтгэсэн гэдгээс илүүтэйгээр түүний ач холбогдлыг илэрхийлэх зүйл цөөн байдаг. Валютын ханшны тогтворгүй бодлого, бусад бүтцийн болон институцийн хүчин зүйлс нийлээд бүтээгдэхүүн ба орлогын ихээхэн уналтад хүргэсний цөөн жишээнд Зүүн Азиас эхлээд Орос, Турк, Аргентинийг дурдаж болно. Нөгөө талаас Хятадын үйлдвэрлэлийн салбарын ашигт ажиллагааг дээшлүүлэхэд валютын ханшны гүйцэтгэсэн гол үүргийг харгалзахгүйгээр Хятад улсын өнгөрсөн арван жилд гаргасан сэтгэл хөдлөм өсөлтийн амжилтыг шинжлэнэ гэдэг хэцүү.
- 3 *Дэлхий дахины өрсөлдөх чадварын тайлан 2004-2005* оны Бүлэг 2.2-н 51 дүгээр хуудсыг үзнэ үү.
- 4 Асеомглу нар, 2001, хуудас 1369
- 5 МакАртур, Закс нар, 2002.
- 6 Олон Улсын Ил тод Байдлын байгууллага Транспаренси Интернэшнлийн судалгаагаар дэлхий дээр хамгийн бага авилгатай орон бол Финлянд улс байна. www.transparency.org/surveys хаягаар үзнэ үү.
- 7 Даниел Пинто “Франц парадокс” гэсэн нэгэн сонирхолтой тэмдэглэлдээ: “Төр засгийн албан тушаалтнууд, эвлэл холбоод болон Францын хүн амын дийлэнх нь капитализмын эртний хувилбараа хамгаалан тэмцэж хашгирдаг байтал Францын компаниуд автомашины үйлдвэрлэлээс эрчим хүч, хүнс, банкны салбар хүртэл хэд хэдэн өрсөлдөөн ихтэй салбаруудад дэлхийд тэргүүлэх байр суурь эзлэн, даяаршлын эхний эгнээнд чимээгүйхэн алхацгааж байна” гэжээ.
- 8 Хөдөлмөрийн бүтээмж бараг тэг байдаг хөдөөгийн тариачид хот газрууд руу шилжиж албан ёсны статистик тооцоонд ихээр хамрагдах болсон нь сүүлийн 20 жилийн амжилттай өсөлтөд гол үүрэг гүйцэтгэж байна.
- 9 Нэг хүнд ноогдох орлогын түвшин Египетэд 1.049 ам.доллар байгаагаас эхлээд Катар 46.641 ам.доллар хүртэл маш олон янз байна (Олон Улсын Валютын Сан).
- 10 Дэлхийн Банк (2003)-г үзнэ үү.
- 11 Тус бүс нутгийн сул ба давуу талуудын тухай илүү дэлгэрэнгүй шинжилгээг Дэлхийн Эдийн Засгийн Форумын *Арабын Ертенцийн Өрсөлдөх Чадварын Тайлан 2005*-аас үзнэ үү.
- 12 Үнэндээ *Ядуурлын төгсгөл* (2005) номыг зохиогч Жеффрий Сакс тэдний талаар харамсалтай бөгөөд урнаар илэрхийлсэн байгаа.
- 13 Сала-и-Мартин, Артади нар, 2004, хуудас 52.

- 14 Энэ талаар болон холбогдох асуудлуудын талаар де Сотогийн (2000) бичсэн гайхалтай бүтээлийг үзнэ үү.
- 15 Кауфманн, Вишванат нар (2001)-ийг үзнэ үү
- 16 Тухайлбал, Фишер (1993)-н бүтээлийг үзнэ үү
- 17 Лукас (2001), Кремер (2001) нарын бүтээлийг үзнэ үү.
- 18 Технологийн тархалтын зарим асуудлуудын талаар Басу, Уейл нар (2001)-ын бүтээлийг үзнэ үү.
- 19 Дэлгэрэнгүй хэлэлцүүлгийг Портер (2004)-ийн бүтээлийг үзнэ үү.
- 20 Хөгжил ба эдийн засгийн өсөлтөд шинийг санаачлалтын гүйцэтгэх үүргийн талаар Гроссман, Хелпман нар (1991), Кругман (1979), Ромер (1987, 1990), Барро, Сала-и-Мартин нар (1995), Шумпетер (2004) нарын бүтээлийг үзнэ үү.
- 21 Сала-и-Мартин, Артади нар, 2004, хуудас 72.

Лавлах материалууд

- Acemoglu, D., Johnson, and J.A.Robinson. 2001. "The Colonial Origins of Comparative Development: An Empirical Investigation." /Харьцуулсан хөгжлийн колонийн үеийн гарал үүсэл: Туршилт судалгаа/. *The American Economic Review* /Америкийн эдийн засгийн тойм/. December. 1369-1401.
- Barro, J. And X.Sala-i-Martin. 1995. *Economic Growth* /Эдийн засгийн өсөлт/. Cambridge: MIT Press.
- Basu, S. And D.Weil. 1998. "Appropriate Technology and Growth." /Зохистой технологи ба өсөлт/. *Quarterly Journal of Economics* /Улирал тутмын эдийн засгийн сэтгүүл/ 113 (4): 1025-1054.
- The Economist /Эдийн засагч сэтгүүл/. 2005. "The Real Sick Man of Europe." /Европын жинхэнэ өвчтэй хүн/ 21 May.
- Fisher, S. 1993. "The Role of Macroeconomic Factors in Growth." /Өсөлтөд макро эдийн засгийн хүчин зүйлсийн гүйцэтгэх үүрэг/ *Journal of Monetary Economics* /Мөнгөний эдийн засгийн сэтгүүл/ 32 (3):1176-1196.
- Grossman, G. and E.Helpman. 1991. *Innovation and Growth in the Global Economy* /Дэлхийн эдийн засаг дахь шинийг санаачлалт ба өсөлт/. Cambridge: MIT Press.
- Heston, A. R.Summers, and B.Aten. 2002. Penn World Table Version 6.1. Center for International Comparisons at the University of Pennsylvania (CICUP) /Пенсилваний Их Сургуулийн Олон Улсын Харьцуулалтын Төв/. 10 дугаар сар.
- International Monetary Fund /Олон Улсын Валютын Сан/. 2005. *World Economic Outlook Database* /Дэлхийн эдийн засгийн тоймын мэдээллийн сан/. 4 дүгээр сар.
- Kaufman, G. and T.Vishwanath. 2001. "Toward Transparency: New Approaches and their Application to Financial Markets." /Ил тод байдлын төлөө: Санхүүгийн зах зээлд зориулсан шинэ аргууд ба тэдгээрийн хэрэглээ/, *World Bank Observer* /Дэлхийн Банкны Ажиглагч/ 16 (1). Хавар.
- Kremer, M. 1993. "The O-Ring Theory of Economic Development." /Эдийн засгийн хөгжлийн тухай бөгжний онол/ *Quarterly Journal of Economics* /Улирал тутмын эдийн засгийн сэтгүүл/ 108 (3):551-75.
- Krugman,P. 1979. "A Model of Innovation, Technological Transfer and the World Distribution of Income." /Шинийг санаачлалт, технологийн шилжүүлэлт, дэлхийн орлогын тархалт/, *Journal of Political Economy* /Улс төр-эдийн засгийн сэтгүүл/ 87 (2): 253-66.
- The London Financial Times* /Лондон Файнаншиал Таймс/. 2005. янз бүрийн дугаар. 2-6 дугаар сар.
- Lucas, R. Jr. 1988. "On the Mechanics of Economic Development." /Эдийн засгийн хөгжлийн механикийн тухай/ *Journal of Monetary Economics* /Мөнгөний эдийн засгийн сэтгүүл/ 21: 3-42.
- Organization for Economic Cooperation and Development /Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллага/. 2005. *Economic Outlook* /Эдийн засгийн тойм/ 77: Statistical Annex Tables. 5 дугаар сар.
- Pinto, D. 2005. "Autistic Governments, Smart Companies." /Учирцаа олоогүй засгийн газрууд ба ухаалаг компаниуд/ *The International Herald Tribune* /Интернэшнл Хералд Трибун сонин/. 7 дугаар сарын 27.
- United States Patent and Trademark Office /АНУ-ын Патент, барааны тэмдгийн газар/. 2005. Patent Counts by Country/State and Year /Патентийн тоо, улс, муж, жилээр/. 4 дүгээр сар.
- Porter, M. 2004. "Building Microeconomic Foundations of Prosperity: Findings from the Business Competitiveness Index." /Хөгжлийн микро эдийн засгийн суурийг тавих нь: Бизнесийн өрсөлдөх чадварын индексээс олж мэдсэн зүйлс/, *The Global Competitiveness Report 2004-2005* /Дэлхий нийтийн өрсөлдөх чадварын тайлан 2004-2005/. Hampshire Palgrave Macmillan.
- McArthur, J.W. and Sachs, J.D. 2002. "The Growth Competitiveness Index: Measuring Technological Advancement and the Stages of Development." /Өсөлтийн өрсөлдөх чадварын индекс: Технологийн дэвшил ба хөгжлийн үе шатуудыг хэмжих нь/. *The Global Competitiveness Report 2001-2002* /Дэлхий дахины өрсөлдөх чадварын тайлан 2001-2002/. New York: Oxford University Press, 28-51.
- Romer, P. 1987. "Growth Based on Increasing Returns due to Specialization." /Төрөлжүүлсний үр дүнд өсөн нэмэгдэж байгаа үр өгөөжид тулгуурласан өсөлт/. *American Economic Review* /Америкийн эдийн засгийн тойм/ 77 (2): 56-62.
- . 1990. "Endogenous Technological Change." /Дотооддоо хийх технологийн өөрчлөлт/. *Journal of Political Economy* /Улс төр-эдийн засгийн сэтгүүл/ 98 (5): 71-102.
- Sachs, J. 2005. *The End of Poverty* /Ядуурлын төгсгөл/. New York: Penguin Press.
- Sala-i-Martin, X. And E.V.Artadi, 2004. *The Global Competitiveness Report 2004-2005* /Дэлхий дахины өрсөлдөх чадварын тайлан 2004-2005/. Hampshire: Palgrave Macmillan. 51-80.
- Schumpeter, J.A. 1934. *The Theory of Economic Development* /Эдийн засгийн хөгжлийн онол/. Cambridge MA: Harvard University Press.
- de Soto, H. 2000. *The Mystery of Capital: Why Capitalism Triumphs in the West and Fails Everywhere Else* /Капитализмын оньсого: Баруунд яагаад капитализм ялаад, бусад газарт унаад байна вэ/. New York: Basic Books.
- Transparency International /Олон улсын ил тод байдлын байгууллага/, www.transparency.org/survey хаягаар онлайн байгаа.
- World Bank /Дэлхийн Банк/. 2003. *Jobs, Growth and Governance in the Middle East and North Africa: Unlocking the Potential for Prosperity* /Ойрхи Дорнод, Хойд Африк дахь ажлын байр, өсөлт ба засаглал: Хөгжлийн чадамжийг нээх нь/. New York.
- World Economic Forum /Дэлхийн Эдийн Засгийн Форум/. 2004. *The Global Competitiveness Report 2004-2005* /Дэлхий дахины өрсөлдөх чадварын тайлан 2004-2005/. Hampshire: Palgrave Macmillan.
- . 2005. *Global Information Technology Report 2004-2005* /Дэлхий дахины мэдээллийн технологийн тайлан/. New York: Palgrave Macmillan.
- . 2005. *The Arab World Competitiveness Report 2005* /Арабын ертөнцийн өрсөлдөх чадварын тайлан 2005/. New York: Palgrave Macmillan.

Хавсралт А: Өсөлтийн өрсөлдөх чадварын индексийн бүрэлдэхүүн

Өсөлтийн өрсөлдөх чадварын индекс нь гурван бүрэлдэхүүн хэсэг индексээс бүрдэнэ: технологийн индекс, төрийн институцийн индекс, макро эдийн засгийн орчны индекс. Эдгээр индексийг «тогтсон тоон үзүүлэлт» болон «Судалгааны тоон үзүүлэлт»-ийн хоёуланд нь тулгуурлан тооцсон байна.

Энэхүү бүлэгт тайлбарласанчлан, нийт улс орныг үндсэн шинийг санаачлагч ба үндсэн бус шинийг санаачлагч хэмээх хоёр хэсэгт хуваасан байгаа. Нэг сая хүн амд ноогдох бүртгүүлсэн АНУ-ын патентын тоо нь 15-аас дээш орныг үндсэн шинийг санаачлагч орон, бусад бүх орныг үндсэн бус шинийг санаачлагч орон гэнэ.

Үндсэн шинийг санаачлагч орнуудын хувьд бид шинийг санаачлалт ба технологийн гүйцэтгэх үүрэгт нэмэлт анхаарал тавьсан байгаа. Үндсэн шинийг санаачлагчдын жигнэлтийг дараахь байдлаар хийж гүйцэтгэв:

Үндсэн шинийг санаачлагчдын
Өсөлтийн өрсөлдөх чадварын индекс = $\frac{1}{2}$ технологийн индекс
+ $\frac{1}{4}$ төрийн институцийн индекс индекс
+ $\frac{1}{4}$ макро эдийн засгийн орчны индекс

Үндсэн бус шинийг санаачлагч орнуудын хувьд бид Өсөлтийн өрсөлдөх чадварын индексийг гурван бүрэлдэхүүн хэсэг индексийн энгийн дунджаар тооцоолсон.

Үндсэн бус шинийг санаачлагчдын
Өсөлтийн өрсөлдөх чадварын индекс = $\frac{1}{3}$ технологийн индекс засгийн орчны
+ $\frac{1}{3}$ төрийн институцийн индекс
+ $\frac{1}{3}$ макро эдийн индекс

Технологийн индексийн бүрэлдэхүүн хэсгүүд

Үндсэн ба үндсэн бус шинийг санаачлагчдын технологийн индексийг дараахь байдлаар тооцов:

Үндсэн шинийг санаачлагчдын технологийн индекс = $\frac{1}{2}$ шинийг санаачлалтын дэд индекс
+ $\frac{1}{2}$ мэдээлэл харилцааны технологийн дэд индекс

Үндсэн бус шинийг санаачлагчдын технологийн индекс = $\frac{1}{8}$ шинэ санаачилалтын дэд индекс
+ $\frac{3}{8}$ технологи шилжүүлэлтийн дэд индекс
+ $\frac{1}{2}$ мэдээлэл, харилцааны технологийн дэд индекс

Шинийг санаачлалтын дэд индекс

Шинийг санаачлалтын дэд индекс = $\frac{1}{4}$ Судалгааны тоон үзүүлэлт
+ $\frac{3}{4}$ тогтсон тоон үзүүлэлт

Шинийг санаачлалтын тухай Судалгааны асуултууд

- 3.01 Танай орны технологийн байр суурь дэлхийд тэргүүлэгч орнуудынхтай харьцуулахад ямар вэ?
- 3.02 Танай улсын компаниуд технологи шингээх чадваргүй юу эсвэл энэ тал дээр идэвхтэй юу?
- 3.06 Танай улсын компаниуд бусад орнуудынхтай харьцуулахад Судалгаа, хөгжлийн ажилд хэр их хөрөнгө зарцуулдаг вэ?
- 3.07 Судалгаа, хөгжлийн ажлын талаарх бизнесийн байгууллагууд ба их дээд сургуулиудын хамтын ажиллагаа хэр өргөн хүрээтэй вэ?

Шинийг санаачлалтын тогтсон тоон үзүүлэлтүүд

- 3.17 Нэг сая хүн ам тутамд ноогдох АНУ-ын хэрэглээний патентын тоо
- 4.17 Дээд боловсролд хамрагдалтын нийт хувь

Технологи шилжүүлэлтийн дэд индекс

Технологи шилжүүлэлтийн дэд индекс = технологи шилжүүлтийн тухай Судалгааны хоёр асуултын жигнээгүй дундаж

- 3.04 Танай улсад орж буй гадаадын шууд хөрөнгө оруулалт шинэ технологийн нэг чухал эх үүсвэр мөн үү?
- 3.03 Танай улсад шинэ технологи олж авах нэг нийтлэг хэрэгсэл бол гадаадын технологийн лиценз авах явдал мөн үү?

Мэдээлэл, харилцааны технологийн (МХТ) дэд индекс

Мэдээлэл, харилцааны технологийн дэд индекс = $\frac{1}{3}$ мэдээлэл харилцааны технологийн тухай Судалгааны тоон үзүүлэлт
+ $\frac{2}{3}$ мэдээлэл харилцааны технологийн тогтсон тоон үзүүлэлт

Мэдээлэл, харилцааны технологийн тухай Судалгааны асуултууд

- 3.11 Сургуулиуд интернэтэд орох боломж ямар байдаг вэ?
- 3.12 Танай улсын интернэтийн үйлчилгээ үзүүлэгчдийн дунд өндөр чанартай, тасралтгүй, бага үнээр үйлчилгээ үзүүлэхэд чиглэсэн хангалттай өрсөлдөөн байдаг үү?
- 3.13 МХТ танай засгийн газрын ерөнхий тэргүүлэх чиглэл мөн үү?
- 3.14 МХТ-ийн ашиглалтыг дэмжин хөгжүүлэхэд засгийн газрын хөтөлбөрүүд амжилттай хэрэгждэг үү?
- 3.15 МХТ-той холбоотой хуулиуд (электрон худалдаа, дижитал гарын үсэг, хэрэглэгчийн хамгаалалт) сайн боловсрогдсон, хэрэгжилт сайтай байдаг үү?

Хавсралт А: Өсөлтийн өрсөлдөх чадварын индексийн бүрэлдэхүүн /үргэлжлэл/**Мэдээлэл, харилцааны технологийн тогтсон тоон үзүүлэлтүүд**

- 3.18 100 хүн тутамд ноогдох гар утас хэрэглэгчдийн тоо
- 3.19 10.000 хүн тутамд ноогдох интернэт ашиглагчдын тоо
- 3.20 10.000 хүн тутамд ноогдох интернэт үйлчилгээний байруудын тоо
- 5.08 100 хүн тутамд ноогдох телефон утасны үндсэн шугамын тоо
- 3.21 100 хүн тутамд ноогдох хувийн компьютерийн тоо

Төрийн институцийн индексийн бүрэлдэхүүн хэсгүүд

Төрийн институцийн индекс = $1/2$ гэрээ, эрх зүйн дэд индекс
+ $1/2$ авилгалын дэд индекс

Гэрээ эрх зүйн дэд индекс

- 6.01 Танай улсын шүүх байгууллага засгийн газрын гишүүн, иргэд, пүүс компаниудын улс төрийн нөлөөнөөс хараат бус байдаг уу?
- 6.03 Санхүүгийн хөрөнгө болон эд хөрөнгийг хуулиар тодорхой зааглан, сайтар хамгаалдаг уу?
- 6.08 Улсын гэрээт ажил гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтад оролцогчдоод засгийн газар төвийг сахисан байдлаар ханддаг уу?
- 6.16 Зохион байгуулалттай гэмт хэргийн зүгээс бизнест ноцтой хохирол учруулдаг уу?

Авилгалын дэд индекс

- 6.19 Экспорт, импортын зөвшөөрөлтэй холбоотой хээл хахууль өгөх явдал хэр нийтлэг вэ?
- 6.20 Нийтийн аж ахуйн үйлчилгээтэй холбоотой хээл хахууль өгөх явдал хэр нийтлэг вэ?
- 6.21 Жил тутмын татвар төлөлттэй холбоотой хээл хахууль өгөх явдал хэр нийтлэг вэ?

Макро эдийн засгийн индексийн бүрэлдэхүүн хэсгүүд

Макро эдийн засгийн орчны индекс = $1/2$ макро эдийн засгийн тогтвортой байдлын дэд индекс
+ $1/4$ орны зээлжих зэрэглэл
+ $1/4$ засгийн газрын үргүй зардал

Макро эдийн засгийн тогтвортой байдлын дэд индекс

Макро эдийн засгийн тогтвортой байдлын дэд индекс = $5/7$ макро эдийн засгийн тогтвортой байдлын тогтсон тоон үзүүлэлт
+ $2/7$ макро эдийн засгийн тогтвортой байдлын тухай Судалгааны тоон үзүүлэлт

Макро эдийн засгийн тогтвортой байдлын тухай Судалгааны асуултууд

- 2.01 Ирэх жил танай улсын эдийн засагт ухралт гарч болзошгүй юу?
- 2.07 Танай компаний зээл авах боломж өнгөрсөн жилтэй харьцуулахад хялбар болж байна уу эсвэл хэцүү болж байна уу?

Макро эдийн засгийн тогтвортой байдлын тогтсон тоон үзүүлэлт

- 2.13 Улсын төсвийн ашиг/алдагдал
- 2.14 Үндэсний хуримтлалын хувь
- 2.16 Инфляци
- 2.15 Хүчин төгөлдөр үйлчилж буй бодит валютын ханш
- 2.17 Зээл өгөх буюу авах үеийн хүүгийн хувийн тархалт
- 2.20 Засгийн газрын өр

2.21 Хөрөнгө оруулагчдын байгууллагаас тогтоосон тухайн орны зээлжих зэрэглэл**Засгийн газрын үргүй зардлын үзүүлэлт**

- 6.06 Танай орны улсын зардлын бүтэц үрэлгэн байна уу, эсвэл зах зээлээс хангагддаггүй боловч зайлшгүй шаардлагатай бүтээгдэхүүн, үйлчилгээгээр хангахад зарцуулагдаж байна уу?

Хавсралт Б: Дэлхий дахины өрсөлдөх чадварын индексийн бүрэлдэхүүн

Энэхүү хавсралтад Дэлхий дахины өрсөлдөх чадварын индексийн бүтцийг дэлгэрэнгүй үзүүлж байна. Уг индексд ашигласан бүх Судалгааны болон тогтсон тоон мэдээллүүдийн тухай илүү дэлгэрэнгүйг энэхүү Тайлангийн өгөгдлийн хүснэгтүүд гэсэн хэсгээс үзэж болно.

1-р тулгуур: Институциуд

А. Төрийн институциуд

1. Өмчийн эрх
 - 6.03 Өмчийн эрх
2. Ёс зүй ба авилгал
 - 6.24 Төрийн мөнгө санхүүг шамшигдуулалт
 - 6.26 Олон нийтийн зүгээс улс төрчдөд итгэх итгэл
3. Зохисгүй нөлөөлөл
 - 6.01 Шүүхийн хараат бус байдал
 - 6.08 Төр засгийн албан тушаалтнуудын шийдвэр гаргахдаа тал тохой татах байдал
4. Засгийн газрын үр ашиггүй байдал (хэт их дүрэм журам, хүнд суртал, үргүй зардал)
 - 6.06 Засгийн газрын үргүй зардал
 - 6.07 Төрийн зохицуулалтын дарамт
5. Аюулгүй байдал
 - 2.02 Терроризмаас бизнест учруулах зардал
 - 6.14 Цагдаагийн үйлчилгээний найдвартай байдал
 - 6.15 Гэмт хэрэг, хүчирхийллээс бизнест учруулах зардал
 - 6.16 Зохион байгуулалттай гэмт хэрэг

Б. Хувийн институциуд

1. Корпорацийн ёс зүй
 - 8.04 Пүүс компаниудын ёс зүйн харилцаа
2. Корпорацийн хариуцлагатай байдал
 - 8.16 Корпорацийн удирдах зөвлөлийн үр ашигтай ажиллагаа
 - 8.21 Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийн хамгаалалт
 - 8.23 Аудитын болон тайлагналын стандартуудын давуу тал

2-р тулгуур: Дэд бүтэц

- 5.01 Дэд бүтцийн ерөнхий чанар
- 5.02 Төмөр замын дэд бүтцийн хөгжил
- 5.03 Боомтын дэд бүтцийн чанар
- 5.04 Агаарын тээврийн дэд бүтцийн чанар
- 5.05 Цахилгаан, эрчим хүчний нийлүүлэлтийн чанар
- 5.08 Телефон утасны шугамууд (тогтсон тоо)

3-р тулгуур: Макро эдийн засаг

- 2.13 Улсын төсвийн ашиг/алдагдал (тогтсон тоон үзүүлэлт)
- 2.14 Үндэсний хуримтлалын хувь (тогтсон тоон үзүүлэлт)
- 2.16 Инфляци (тогтсон тоон үзүүлэлт)

- 2.17 Хүүгийн хувийн тархалт (тогтсон тоон үзүүлэлт)
- 2.20 Засгийн газрын өр ба ДНБ-ий харьцаа (тогтсон тоон үзүүлэлт)
- 2.15 Хүчин төгөлдөр үйлчилж буй бодит валютын ханш (тогтсон тоон үзүүлэлт)

4-р тулгуур: Эрүүл мэнд ба бага боловсрол

А. Эрүүл мэнд

- 4.04 Хумхаа өвчний бизнест үзүүлэх дунд хугацааны үр нөлөө
- 4.05 Сүрьеэ өвчний бизнест үзүүлэх дунд хугацааны үр нөлөө
- 4.06 ДОХ өвчний бизнест үзүүлэх дунд хугацааны үр нөлөө
- 4.10 Нялхсын эндэгдэл (тогтсон тоон үзүүлэлт)
- 4.11 Дундаж наслалт (тогтсон тоон үзүүлэлт)
- 4.12 Сүрьеэ өвчний халдвар тархалт (тогтсон тоон үзүүлэлт)
- 4.13 Хумхаа өвчний халдвар тархалт (тогтсон тоон үзүүлэлт)
- 4.14 ДОХ өвчний халдвар тархалт (тогтсон тоон үзүүлэлт)

Б. Бага боловсрол

- 4.15 Нийт бага боловсролд хамрагдал (тогтсон тоон үзүүлэлт)

5-р тулгуур: Дээд боловсрол ба мэргэжлийн сургалт

А. Боловсролын тоон үзүүлэлт

- 4.16 Нийт дунд боловсролд хамрагдал (тогтсон тоон үзүүлэлт)
- 4.17 Нийт дээд боловсролд хамрагдал (тогтсон тоон үзүүлэлт)

Б. Боловсролын тогтолцооны чанар

- 4.01 Боловсролын тогтолцооны чанар
- 4.03 Математик ба шинжлэх ухааны боловсролын чанар
- 8.15 Менежментийн сургуулиудын чанар

В. Ажлын байран дээрх сургалт

- 7.09 Нарийн мэргэжлийн судалгаа, сургалтын үйлчилгээ дотооддоо байгаа байдал
- 8.11 Ажилтнуудад зориулсан сургалтын цар хүрээ

6-р тулгуур: Зах зээлийн үр ашигтай байдал

А. Бараа бүтээгдэхүүний зах зээл : гажуудал, өрсөлдөөн, хэмжээ

1. Гажуудал
 - 2.12 Хөдөө аж ахуйн бодлогын зардал
 - 6.12 Эрх зүйн хүрээний үр ашигтай байдал
 - 6.11 Татвар ноогдуулалтын цар хүрээ ба үр нөлөө
 - 7.10 Бизнес эхлэн эрхлэхэд шаардлагатай дүрэм журмын тоо (тогтсон тоон үзүүлэлт)
 - 7.11 Бизнес эхлэн эрхлэхэд шаардагдах хугацаа (тогтсон тоон үзүүлэлт)

Хавсралт Б: Дэлхий дахины өрсөлдөх чадварын индексийн бүрэлдэхүүн /үргэлжлэл/**2. Өрсөлдөөн****Дотоод өрсөлдөөн**

- 7.01 Дотоодын өрсөлдөөний эрчим
- 7.02 Монополийн эсрэг бодлогын үр нөлөөтэй байдал

Гадаад өрсөлдөөн

- 2.19 Импорт (тогтсон тоон үзүүлэлт)
- 2.09 Худалдааны саад тотгорын тархалт
- 8.22 Гадаадын өмчлөлд тавих хязгаарлалт

3. Хэмжээ**Дотоодын зах зээл**

ДНБ-экспорт+импорт (тогтсон тоон үзүүлэлт)

Гадаадын зах зээл (экспорт)

- 2.18 Экспорт (тогтсон тоон үзүүлэлт)

Б. Хөдөлмөрийн зах зээл: уян хатан ба үр ашигтай байдал**1. Уян хатан байдал**

- 8.17 Ажилд авах ба ажлаас халах практик
- 8.18 Цалин хөлс тогтоолтын уян хатан байдал
- 8.19 Хөдөлмөрийн буюу ажил олгогчийн харилцаан дахь хамтын ажиллагаа

2. Үр ашигтай байдал

- 8.14 Мэргэжлийн удирдлагад найдах байдал
- 8.20 Цалин хөлс ба бүтээмж
- 4.08 Оюуны дайжилт
- 4.09 Хувийн салбар дахь эмэгтэйчүүдийн ажил эрхлэлт

В. Санхүүгийн зах зээл: боловсронгуй байдал ба нээлттэй байдал

- 2.03 Санхүүгийн зах зээлийн боловсронгуй байдал
- 2.05 Зээл авахад хялбар дөхөм байдал
- 2.06 Хөрөнгө оруулалтын капиталын бэлэн байдал
- 2.04 Банкуудын сайн ажиллагаа
- 2.08 Дотоодын хөрөнгийн зах зээлд хүрэх боломж

7-р тулгуур: Технологийн бэлэн байдал

- 3.01 Технологийн бэлэн байдал
- 3.02 Пүүс, компаний түвшний технологи шингээх чадвар
- 3.15 МХТ-той холбоотой хуулиуд
- 3.04 ГШХО ба технологи шилжүүлэлт
- 3.18 Гар утас (тогтсон тоон үзүүлэлт)
- 3.19 Интернэт ашиглагчид (тогтсон тоон үзүүлэлт)
- 3.21 Хувийн компьютер (тогтсон тоон үзүүлэлт)

8-р тулгуур: Бизнесийн боловсронгуй байдал**А. Үйлдвэрлэлийн сүлжээ ба дэмжих салбарууд**

- 7.05 Дотоодын нийлүүлэгчдийн тоо
- 7.06 Дотоодын нийлүүлэгчдийн чанар

Б. Пүүс, компаний үйл ажиллагаа, стратегийн боловсронгуй байдал

- 8.05 Үйлдвэрлэлийн үйл явцын боловсронгуй байдал
- 8.06 Маркетингийн цар хүрээ
- 8.08 Олон улсын түгээлт, борлуулалтад тавих хяналт
- 8.18 Эрх мэдлийг төлөөлөхөд бэлэн байдал
- 8.01 Өрсөлдөөний давуу талын мөн чанар
- 8.02 Үнэт зүйлсийн гинжин холбоотой байдал

9-р тулгуур: Шинийг санаачлалт

- 3.06 Компаниудын судалгаа, хөгжлийн ажилд зарцуулж буй хөрөнгө
- 3.07 Их, дээд сургуулийн буюу үйлдвэрлэлийн судалгааны хамтын ажиллагаа
- 3.08 Засгийн газраас дэвшилтэт технологийн бүтээгдэхүүнээр хангалт
- 3.09 Эрдэмтэд, инженерүүдийн бэлэн байдал
- 3.17 Хэрэглээний патентууд (тогтсон тоон үзүүлэлт)
- 6.04 Оюуны өмчийн хамгаалалт
- 8.03 Шинийг санаачлах чадавхи

Хавсралт В: Өрсөлдөх чадварын индексүүдийг боловсруулсан тухай техникийн тайлбар

Тогтсон тоон үзүүлэлт ба Судалгааны тоон өгөгдлүүдийг нэгтгэсэн байдал

Судалгааны тоон үзүүлэлт гэдэг нь Бизнесийн удирдлагын санаа бодлын судалгаанд өгсөн хариултуудад хамаарах бөгөөд 1-7 хүртэлх тоогоор илэрхийлэгдсэн байгаа. Харин тогтсон тоон өгөгдлүүдийг цуглуулж авсан янз бүрийн эх сурвалжийг энэхүү Тайлангийн төгсгөлд буй Техникийн тайлбар ба эх сурвалжууд гэсэн хэсэгт харуулсан байгаа. Эдгээр Өрсөлдөх чадварын индексүүдийг тооцоолоход ашигласан бүх тоон өгөгдлүүдийг уг Тайлангийн тоон өгөгдлийн хүснэгтүүдээс олж үзэж болно.

Тогтсон тоон үзүүлэлт бүрийг 1-7 хүртэлх хэмжээст оруулж хувиргах стандарт томъёо нь:

$$6 \times \frac{(\text{тухайн орны тоон утга-түүврийн хамгийн доод утга})}{(\text{түүврийн хамгийн дээд утга} - \text{хамгийн доод утга})} + 1$$

Түүврийн хамгийн дээд ба доод утга нь нийт түүврийн тоон утгуудын хамгийн их ба хамгийн бага утга юм.

Зарим хувьсагчийн хувьд илүү өндөр утгатай нь муу үр дүнтэй байгааг харуулна. Жишээлбэл, төсвийн алдагдлын хувьд их байх тусам муу байна. Энэ тохиолдолд бид шинээр гарсан хувьсагчийн утгыг нь 8-аас хасч, тухайн цувралын утгыг «эсрэг эргүүлж» байгаа.

Зарим тохиолдолд тухайн тоон өгөгдлийн хүрэнээс хэт гадуур гарсан утгыг харгалзан үзэж зохих тохируулга хийсэн байгаа.

Бид инфляцид яаж ханддаг вэ

Инфляци үүнээс доогуур байвал эдийн засгийн чухал тодорхойлогч болно гэсэн тодорхой босго түвшний тухай нэгдсэн ойлголт ном, сурах бичгүүдэд харахан байхгүй боловч инфляци, дефляци өндөр байх нь хоёулаа тухайн эдийн засагт чухал шийдвэрлэх үүрэгтэй гэдэг санааг гаргахын тулд инфляцийг дараахь байдлаар U хэлбэрт оруулан загварчилсан байгаа: инфляци 0-3 хувьтай байгаа орнуудын хувьд авч болох дээд оноо буюу 7 оноо өгч байна. Энэ хүрэнээс гарсан инфляци, дефляци хоёрын хоёуланд нь сөрөг оноо өгч байна. Эдгээр утгаас холдох тусам шугаман өсөлтийн хэлбэрээр оноо нь улам буурч байх юм. Инфляцид хандах энэхүү хандлагыг бид Өсөлтийн ба Дэлхий дахины өрсөлдөх чадварын индексэд аль алинд нь ашигласан байгаа.

Өвчний нөлөөг бид хэрхэн хэмждэг вэ

Дэлхий дахины өрсөлдөх чадварын индексийн 4 дүгээр тулгуурын хүрээнд авч үзсэн өвчний өрсөлдөх чадварт үзүүлэх нөлөө нь зөвхөн тэдгээр өвчний гаралтаас төдийгүй бизнесийн хувьд хэр өртөгтэй тусч байгаагаас хамаарч байна. Иймээс халдварт өвчний эдийн засгийн үр нөлөөг тооцохдоо тухайн өвчний (хумхаа, сүрьеэ, ДОХ)

гаралтын тухай тогтсон тоон өгөгдлийг эдгээр өвчний бизнест учруулах өртөг зардлын тухай Судалгааны асуулттай хослуулан хэрэглэж байна.

Эдгээрийг ингэж нэгтгэхийн тулд юуны өмнө улс орон бүрийн өвчний тархалтын байдлыг дэлхий дээрх хамгийн өндөр тархалтын үзүүлэлттэй харьцуулсан харьцааг гаргадаг. Дараа нь, энэхүү харьцааны эсрэг харьцааг гаргаж (утга нь бага байх тусам «сайн» гэдэг үүднээс) Судалгааны дунджаар үржүүлнэ. Ингээд гарсан үр дүнг 1-7 хүртэлх хэмжээст шилжүүлэх юм. Халдварт өвчний тархалт тэг түвшинд байгаа орнуудын хувьд Судалгааны тоон үзүүлэлт хэд гарсныг үл харгалзан 7 гэсэн оноо өгч байгааг анхаараарай.

Дотоод, гадаадын өрсөлдөөнийг бид хэрхэн хэмждэг вэ

Дэлхий дахины өрсөлдөх чадварын индексийн 6 дугаар тулгуурын бараа бүтээгдэхүүний зах зээлийн үр ашигтай байдлын дэд индексийн хүрээнд орсон өрсөлдөөн хэмээх бүрэлдэхүүн хэсэгт тодорхой хэлбэрээр жигнэлт хийсэн байгаа. Судалгааны тоон үзүүлэлтэд дотоодын болон гадаадын зах зээл дээр өрсөлдөөнийг гажуудуулж буй хүрээг тус тус харуулж байна. Харин эдгээр гажуудлын харьцангуй ач холбогдол нь дотоод ба гадаад өрсөлдөөнийг харьцуулсан харьцангуй хэмжээнээс хамаарна. Энэхүү харилцан хамаарлыг гаргахын тулд уг харьцангуй ач холбогдлыг илэрхийлэх хоёр шинэ хувьсагч бий болголоо. Үүнд дотоод өрсөлдөөн нь хэрэглээ (C), хөрөнгө оруулалт (I), засгийн газрын зарцуулалт (G), экспорт (X) дөрвийн нийлбэртэй тэнцүү, гадаад өрсөлдөөн нь импорттой (M) тэнцүү байна. Иймд бид дотоод өрсөлдөөнтэй холбоотой Судалгааны асуултуудад $(C+I+G+X)/(C+I+G+X+M)$ гэсэн хувийн жин, гадаад өрсөлдөөнтэй холбоотойд нь $M/(C+I+G+X+M)$ гэсэн хувийн жин оногдуулж байна.

Зах зээлийн хэмжээг бид хэрхэн хэмждэг вэ

Дэлхий дахины өрсөлдөх чадварын индексийн 6 дугаар тулгуурын бараа бүтээгдэхүүний зах зээлийн үр ашигтай байдлын дэд индексийн хүрээнд орсон хэмжээ хэмээх бүрэлдэхүүн хэсэг нь дотоодын пүүс, компаниудын нэвтэрсэн зах зээлийн хэмжээг хэмждэг. Энэ нь дотоодын зах зээлийн хэмжээ ба гадаадын зах зээлийн хэмжээ (экспорт) гэсэн хоёр бүрэлдэхүүн хэсэгтэй. Дотоодын зэх зээл нь хэрэглээ (C), хөрөнгө оруулалт (I), засгийн газрын зарцуулалт (G) гурвын нийлбэртэй тэнцүү хэмжээтэй байна. Хэдийгээр эдгээр гурван макро бүрэлдэхүүн хэсгийн тоон үзүүлэлт бидэнд дутагддаг боловч бидэнд экспорт (X), импорт (M), ДНБ-ий үзүүлэлтүүд бий. Тодорхойлолт ёсоор, $ДНБ=C+I+G+(X-M)$ байдаг. Иймд бид дотоодын зах зээлийн хэмжээг $ДНБ+M-X$ гэж тооцож байна.

Хөгжил дэвшлийн микро эдийн засгийн үндэс суурийг бий болгох нь: Бизнесийн өрсөлдөх чадварын индексээс олж мэдсэн зүйлс¹

Майкл Е. Портер, Харвардын Их Сургууль

Оршил

Улам бүр нээлттэй болж нэгдэн нягтарч байгаа дэлхийн эдийн засагт өндөр хөгжилтэй болон хөгжиж байгаа орнуудын гол санаа зовоосон асуудлын нэг нь өрсөлдөх чадвар болоод байна. Хэдийгээр түүний ач холбогдол хүлээн зөвшөөрөгдсөн ч өрсөлдөх чадвар гэдэг ойлголтыг буруугаар ойлгох явдал олонтаа байдаг. Бидэнд өрсөлдөх чадварыг бодитойгоор тодорхойлж, аливаа улс үндэстний амьжиргааны түвшинтэй холбоотойг нь харуулж, түүний шалтгаануудыг ойлгох ойлголтын хүрээг гарган, олон орныг хамарсан түүвэрлэлтээр өрсөлдөх чадварыг нь харьцуулан харуулж байна.

Энэ ойлголтын хүрээнд тулгуурлан гаргасан Бизнесийн өрсөлдөх чадварын индекс (БӨЧИ) нь олон улс орны суурь өрсөлдөх чадварыг харьцуулсан байдлаар хэмжихэд чиглэсэн тоон үзүүлэлтээр баялаг арга юм. Энэ жилийн БӨЧИ-д 116 орныг хамруулсан нь өнгөрсөн жилийнхээс 13 орноор нэмэгдсэн байна². Бидний зорилго бол улс орнуудыг өрсөлдөх чадварын зэрэглэлээр нь жагсааж, тус бүрийнх нь өрсөлдөөний давуу ба сул талуудыг тогтоохын зэрэгцээ дэлхийн эдийн засаг дахь өрсөлдөх чадварын чиг хандлагыг гарган, өрсөлдөх чадварын эх сурвалжууд ба эдийн засгийн хөгжлийн үйл явцын талаарх үндсэн мэдлэгээ тэлэх явдал юм.

Өрсөлдөх чадвар ба эдийн засгийн хөгжлийн тухай ихэнх хэлэлцүүлгүүд аливаа эдийн засгийн амжилтын түлхүүр болсон макро эдийн засгийн, улс төрийн, хууль эрх зүйн, нийгмийн нөхцөл байдлуудад чиглэсээр байна. Төсөв мөнгөний сайн бодлогууд, хууль эрх зүйн итгэл хүлээсэн, үр ашигтай тогтолцоо, тогтвортой ардчилсан институциуд, нийгмийн байдалд гарч буй ахиц дэвшлүүд бүгд л эрүүл саруул эдийн засагтай болоход ихээхэн хувь нэмэр оруулдаг. Харин энэхүү өргөн хүрээтэй нөхцөл байдал нь зайлшгүй шаардлагатай боловч хангалттай бус хэмжээнд байна. Эдгээр нь баялгийг бий болгох боломж олгодгоос биш, өөрсдөө баялгийг бий болгодоггүй. Үнэндээ баялаг бол аливаа үндэстний компаниудын авьяас чадвар (дотоодын болон үндэстэн дамнасан компаниудын салбаруудын аль аль нь), тэдгээр компаниудын өрсөлдөж буй микро эдийн засгийн бизнесийн орчны чанар хоёрт үндэслэсэн микро эдийн засгийн түвшинд бий болдог. Аливаа улс үндэстний компаниудын чадвар дээшлээгүй тохиолдолд макро эдийн

засгийн, улс төрийн, хууль эрх зүйн болон нийгмийн шинэчлэлүүд хөгжил дэвшилд үр өгөөжөө бүрэн өгөхгүй.

Бид 1998 оноос эхлэн олон орныг хамруулан өрсөлдөх чадвар ба хөгжил дэвшлийн микро эдийн засгийн бааз суурийг статистикийн хувьд судлаж шинжлэх хүчин чармайлт тавьж эхэлсэн. Энэ ажил маань ихэнх эдийн засгийн өсөлтийн шинжилгээнд нийтлэг байдаг өргөн хүрээтэй, нэгдмэл чанартай хувьсагчуудын шинжилгээнээс хальж, улс орон ба компаниудыг өөрсдийнх нь өрсөлдөөний давуу болон сул талуудыг нарийвчлан ойлгохуйц хүрээгээр хангах зорилготой юм. Түүнчлэн хэмжүүр бүрийн статистик ач холбогдлыг нягтлан шалгаж, хувьсагч бүрийн оруулах хувь нэмрийг жигнэх статистик арга техник хэрэглэх замаар аль болох нарийн чанд байхыг зорьж байна.

Бизнесийн өрсөлдөх чадварын индекс нь аливаа улс үндэстний хөгжил дэвшлийн үндсүүдийг судлан шинжлэхийг эрмэлзсэн бөгөөд ингэхдээ худалдан авах чадвараар тохируулсан нэг хүнд ноогдох ДНБ-ий түвшингээр хэмжсэн болно. Өнөөгийн хөгжил дэвшил тогтвортой байх эсэхэд болон нэг хүнд ноогдох ДНБ-ийг ирээдүйд илүү өндөр түвшинд хүргэхийн тулд зайлшгүй авч үзэх ёстой тодорхой чиглэлүүдэд бидний гол анхаарал чиглэгдэнэ. Өнөөгийн нэг хүнд ноогдох ДНБ-ий тогтвортой түвшин болон нэг хүнд ноогдох ДНБ-ий өсөлтийн хурд хоёр урт хугацаанд хоорондоо холбоотой байх боловч дор бүрнээ өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой бодлогын хэлэлцэх асуудал шаарддаг. Мөн бид өмнөх тайлангуудын үзэл баримтлалын хүрээ ба статистик аргуудыг дагасан бөгөөд олж мэдсэн зүйлс нь ч өмнө нь гаргаж байсан Микро эдийн засгийн өрсөлдөх чадварын индексийн үр дүнгүүдтэй харьцуулж болохоор байгаа болно.

Энд хийгдсэн шинжилгээнүүд нь одоо байгаа хамгийн сайн тоон үзүүлэлтүүд, эконометрикийн аргуудыг ашиглаж байгаагаараа прагматик шинжтэй боловч тэдгээр үзүүлэлт ба аргуудын аль аль нь төгс хэмжээнд хүрэх болоогүй байна. Бид бас цаг хугацааны хувьд хязгаарладмал хүрээний тоон үзүүлэлт өгөгдсөнтэй холбоотойгоор шалтгаант холбоосын чиглэлийг тогтоох сорилттой тулгарч байна. Гэхдээ шалтгаант холбоосыг шалгах тодорхой сорилт хийж үзэх боломжгүй байсан ч гэсэн хөгжил дэвшлийн микро эдийн засгийн хамаарлуудыг ойлгох

явдал үнэхээр чухал хэвээр байна. Нэг хүнд ноогдох ДНБ өсөх тусам микро эдийн засгийн зарим нөхцлүүд сайжрах жам ёсны хандлага байж болох юм. Гэвч орлогын ижил төстэй түвшинтэй орнуудад хүртэл асар их зөрүүтэй байдал ажиглагдаж байгаа нь энэхүү сайжралт автоматаар хийгдэх хүртэл хол байгааг харуулж байна. Статистик шинжтэй бэрхшээл сорилтуудыг эс тооцвол статистик талаас олж мэдсэн зүйлс маань ерөнхийдөө *Дэлхий дахины өрсөлдөх чадварын тайлан 2004-2005* (ДНӨЧТ)-тай болон өмнөх *Тайлангуудтай* харьцуулахад гайхалтай тогтвортой бөгөөд эрүүл саруул гарч байна.

Улс орнуудын нэг хүнд ноогдох ДНБ-ий түвшний хазайлтын 80 хувийг Бизнесийн өрсөлдөх чадварын индексээр тайлбарлаж байна³. Маш олон тогтворгүй, доогуур орлоготой орнууд байгааг болон үндэсний орлогын тоон үзүүлэлтүүдэд салшгүй дутагдалууд байгааг харгалзвал энэ бол гайхалтай өндөр түвшин юм. Мөн л эдгээр олж мэдсэн зүйлс маань эдийн засгийн хөгжил дэвшилд микро эдийн засгийн өрсөлдөх чадвар шийдвэрлэх ач холбогдолтойг харуулж байна.

Хөгжиж байгаа орнуудад гарч буй микро эдийн засгийн уналтууд нь макро эдийн засгийн болон нийгмийн хөтөлбөрүүдийг дахин дахин үгүйсгэж байна. Улс орнууд дэлхийн хөрөнгийн зах зээлд оролцох болсноор макро эдийн засгийн тогтворжуулалт болон санхүүгийн шинэчлэлээр дамжуулан өсөлтийн эх булгийг инженерчилж болох бөгөөд ингэснээр капиталын үер буулгаж, хөгжил дэвшлийн хоосон зэрэглээ үүсгэдэг. Харин микро эдийн засгийн сайжруулалт хийхгүй бол экспорт, ажлын байр хоёр биелэлээ олж чадахгүй, цалин хөлс хэлбэлзэж, хөрөнгө оруулалтын өгөөж урам хугарам хэмжээнд хүрснээс болж өсөлт алга болох болно. Ийм мөчлөгөөс үүдсэн урам хугаралт ба хүнд бэрх байдал нь эргээд даяаршлын эсрэг хариу цохилтын цөм болон үлдэж байна. Түүнчлэн өндөр хөгжилтэй орнуудын хүрээнд макро болон нийгмийн чиглэлд хангалтай дэвшил гаргаад байгаа орнуудад дутагдаж байдаг холбоос бол микро эдийн засгийн өрсөлдөх чадвар байдаг.

Иймээс өрсөлдөх чадвар гэдэг бол аливаа орны тогтвортой барьж чадах хөгжил дэвшлийн түвшний үндсэн тодорхойлогч мөн. Макро эдийн засгийн шилжилт, улс төрийн хөгжил, эрдэс баялгийн үнийн хэлбэлзэл, худалдаа ба гадаадын хөрөнгө оруулалтын огцом өсөлтүүд тодорхой хугацааны турш нэг хүнд ноогдох

ДНБ-ий өсөлтөд хүргэж чаддаг бол жинхэнэ хөгжил дэвшлийн цорын ганц найдвартай үндэс суурь бол аливаа улс үндэстний эдийн засгийн бүтээмжийн чадамж юм. Богино хугацаанд «амжилт»-ын эх булгийг инженерчлэх шалтгаан ба боломжуудыг байнга эрэлхийлэх шаардлагыг эс тооцвол, төрийн бодлогын гол анхаарал өрсөлдөх чадварт чиглэх ёстой. Үүний нэг адилаар үндэстний удирдагч нар богино хугацааны олз ашгийн төлөө өрсөлдөх чадвараа дордуулж байхын оронд хүнд хэцүү цаг үед ч гэсэн өрсөлдөх чадварынхаа төлөө тууштай зүтгэдэг байх ёстой.

Өрсөлдөх чадвар ба түүний шалтгаанууд

Өрсөлдөх чадвар гэж юу вэ ?

Өрсөлдөх чадварын ач холбогдлыг өргөнөөр хүлээн зөвшөөрдөг атал өрсөлдөх чадвар гэдэг ойлголт сайн ойлгогдоггүй хэвээр байна. Өрсөлдөх чадварын тухай хамгийн энгийн мэдрэгддэг тодорхойлолт бол аливаа улсын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний дэлхийн зах зээлд эзлэх хувь юм. Энэ нь өрсөлдөөнийг нэг нь хожиж нөгөө нь хожигддог тэг нийлбэртэй тоглоом болгон хувиргадаг бөгөөд нэг улсын хожил нөгөө улсын алдагдлаар бий болж байна гэсэн үг. Өрсөлдөх чадварын тухай энэ үзлийг зах зээлийн үр дүнд хөндлөнгөөс оролцож аль нэг үндэстний тусын тулд өөрчлөн гуйвуулах (үүнийг стратегийн үйлдвэрлэлийн бодлого гэж нэрлэдэг) явдлыг зөвтгөхөд ашигладаг. Түүнчлэн энэ нь татаас олгох, дотоодын цалин хөлсийг бага байлгах, үндэстний валютын ханшийг бууруулах зэрэг экспортыг өргөжүүлэхэд чиглэсэн бодлогуудыг дэмжиж байдаг. Үнэн хэрэгтээ цалин хөлсний түвшинг бага байлгах, эсвэл валютын ханшаа бууруулах нь «аливаа үндэстнийг улам өрсөлдөх чадвартай болгодог» гэж ярих явдал ч олон байна.

Харамсалтай нь өрсөлдөх чадварын тухай дээрх зөн совингийн чанартай үзэл нь гүнзгий алдаа байдаг. Цалин хөлсний түвшинг доогуур байлгах хэрэгцээ нь өрсөлдөх чадвар дутагдаж байгааг харуулах бөгөөд хөгжил дэвшлийг хойш татаж байдаг. Янз бүрийн татаасууд ч үндэстний орлогыг барж, тухайн улс үндэстэн нөөц баялгаа хамгийн бүтээлч байдлаар ашиглах сонголтыг гажуудуулдаг. Валютын ханшийг бууруулах нь дэлхийн зах зээлд борлуулах бүтээгдэхүүн, үйлчилгээг хямдруулж, гаднаас худалдан авах бүтээгдэхүүн, үйлчилгээний өртөг зардлыг

нэмэгдүүлснээр үндэстний төлбөрийн тэнцлийг алдагдуулдаг. Ингэснээр бага цалин, хямд валютад тулгуурласан экспорт нь амьжиргааны түвшинг хүссэн хэмжээнд тэтгэж чаддаггүй.

Өрсөлдөх чадварыг ойлгохын тулд хамгийн түрүүнд хөгжил дэвшлийн цаад эх сурвалжийг нь ойлгох ёстой. Аливаа үндэстний амьжиргааны түвшинг түүний эдийн засгийн бүтээмжээр тодорхойлдог бөгөөд энэ бүтээмжийг тухайн улсын хүний, капиталын, байгалийн нөөц баялгийн нэг нэгж тутмаас үйлдвэрлэн гаргаж буй бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ цэнээр хэмждэг. Бүтээмж нь аливаа үндэстний үйлдвэрлэн гаргасан бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ цэнээс буюу тэдний нээлттэй зах дээр тэргүүлж чадах үнээс хамаарахын зэрэгцээ тэдгээрийг хэр үр ашигтай үйлдвэрлэн гаргаж чадахаас хамаардаг.

Тэгвэл жинхэнэ өрсөлдөх чадвар бүтээмжээр хэмжигддэг байна. Бүтээмж нь аливаа үндэстэн өндөр цалин хөлстэй, хүчтэй валюттай, хөрөнгө капиталын өгөөж өндөртэй байж, улмаар түүгээрээ амьжиргааны өндөр түвшинг хангах боломжийг олгодог. Гол зорилго бол бүтээмж болохоос экспорт биш юм. Зөвхөн аливаа үндэстэн дундаж үйлдвэрлэлээс илүү бүтээмжтэйгээр үйлдвэрлэж чадах бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ экспортыг нэмэгдүүлж байгаа тохиолдолд л үндэстний бүтээмж өсөх болно. Түүнчлэн, тухайн оронд үйл ажиллагаа явуулж буй пүүс компаниуд дотоодын эсвэл гадаадын өмчлөлтэй байхаас үл хамааран бүтээмж гол зорилго байх юм. Хамгийн их асуудал үүсгэдэг зүйл бол өмчлөл биш, харин тухайн улсад явагдаж байгаа бизнесийн үйл ажиллагааны мөн чанар ба бүтээмж байдаг. Эцэст нь, цэвэр дотоодын үйлдвэрлэлтэй байх нь өрсөлдөх чадварын хувьд учир дутагдалтай. Учир нь тэдний бүтээмж дан ганц цалин хөлсний хэмжээг тогтоогоод зогсохгүй тухайн орны амьжиргааны өртөгт болон бизнес эрхлэх зардалд ихээхэн нөлөө үзүүлдэгт оршино. Зөвхөн худалдаа арилжаанд оролцдог салбар гэлтгүй бүхий л эдийн засгийн салбарын бүтээмж тэр чигтээ амьжиргааны түвшинд нөлөөлж байдаг.


Дэлхийн эдийн засаг бол тэг нийлбэртэй тоглоом биш. Олон улс үндэстэн бүтээмжээ дээшлүүлж чадах юм бол хөгжил дэвшлээ сайжруулж чадна. Тэгвэл эдийн засгийн хөгжлийн гол сорилт бол бүтээмжийн түргэн хурдацтай, тогтвортой өсөлтийг хангах нөхцлүүдийг хэрхэн бий болгох вэ гэдэг асуудал болж байна.

Аливаа эдийн засаг байгаа хүн хүчний нөөцөө дайчлах чадвараас бүтээмж хамаардаг. Тухайн эдийн засагт байгаа бүх боломжит ажил эрхлэгчид тутмаас бий болж байгаа бодит ДНБ-ээр хэмжигддэг эдийн засгийн нийт бүтээмж нь нийт хөгжил дэвшлийг тодорхойлж байдаг. Бодитойгоор ажиллаж буй ажилчдын бүтээмжийн асуудал бол үүнийг зөвхөн нэг хэсэг юм. Европын зарим орны эдийн засагт ажилласан нэг цагт ноогдох бүтээмжийн түвшин өндөр гэж мэдээлдэг ч, ажилгүйдэл өндөр, өвчний улмаас авсан чөлөө их, ажлын цаг хязгаарлагдмал байгаа нь нэг хүнд ноогдох үндэсний орлогыг сулруулж байдаг⁴. Ийнхүү ажиллах хүчийг дутуу ашиглаж байгаань нилээд хэмжээгээр сайн дурын шинжтэй бус боловч ажил эрхлэлтийн өөр боломжит хувилбарууд дутагдаж байгааг харуулж байна⁵. Нийт эдийн засгийн хэмжээний бүтээмж ба ажиллагсадын бүтээмжийн хоорондын зөрөөтэй байдал нь голдуу хөдөлмөрийн зах зээлийн үр ашиггүй байдал эсвэл хүчин зүйлсийн орцын зах зээлүүд дэх бусад гажуудуулагч нөлөөнөөс үүдэлтэй байдаг.

Бүтээмжийн микро эдийн засгийн үндэс сууриуд

Улс төр, эрх зүй, нийгмийн тогтвортой институциуд ба макро эдийн засгийн сайн бодлогууд нь бүтээмжийн болон үндэсний хөгжил дэвшлийн чадамжийг бий болгож байдаг. Гэвч баялаг бол үнэндээ микро эдийн засгийн түвшинд буюу пүүс компаниудын зүгээс үр ашигтай аргаар үнэ цэнэтэй бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болгох чадвараар бүтээгддэг. Аливаа улс үндэстэн зөвхөн энэ замаар л цалин хөлсний өндөр түвшингээ болон тогтвортой хөрөнгө оруулалтыг дэмжихэд шаардлагатай капиталын өгөөжийн хүссэн түвшингээ барьж чадна (Бүдүүвч 1-ийг үзнэ үү). Төр засаг ч биш,

Бүдүүвч 1: Өрсөлдөх чадварыг тодорхойлогч хүчнүүд



нийгмийн институциуд ч биш, зөвхөн пүүс компаниуд л баялгийг бүтээж чаддаг.

Бүтээмжийн микро эдийн засгийн үндэс суурь нь харилцан уялдаатай хоёр зүйлд тулгуурладаг: (1) тухайн улсад ажиллаж буй дотоодын компаниуд буюу гадаадын компаний салбаруудын өрсөлдөөний боловсронгуй байдал (бүтээмж), (2) тэдний үйл ажиллагаа явуулж буй микро эдийн засгийн бизнесийн орчны чанар.

Бүдүүвч 2: Компаний боловсронгуй байдал ба эдийн засгийн хөгжил

Бага орлоготой орнууд	Дунд орлоготой орнууд	Өндөр орлоготой орнууд
<ul style="list-style-type: none"> Хямд орцоос давсан өрсөлдөөний давуу тал Үйлдвэрлэлийн үйл явцын боловсронгуй байдал Өргөн хүрээтэй үнэт зүйлсийн гинжин хэлхээ Мэргэжлийн удирдлагад найдах байдал 	<ul style="list-style-type: none"> Бүс нутгийн борлуулалтын цар хүрээ Олон улсын түгээлт борлуулалтын хяналт Нэрийн бүтээгдэхүүний төрөлжүүлэлтийн цар хүрээ Компаниудын судалгаа, хөгжлийн ажилд зарцуулах хөрөнгө Гадаадын технологийн лиценжилт зонхилсон байдал Ажилтнуудад зориулсан сургалтын цар хүрээ 	<ul style="list-style-type: none"> Шинийг санаачлах чадвар Олон улсын зах зээлийн өргөн хүрээ Идэвх санаачилгыг урамжуулах хүрээ Эрх мэдлийг төлөөлүүлэхэд бэлэн байдал

Аливаа улсын бүтээмжийг эцсийн эцэст түүний компаниудын бүтээмжээр тодорхойлдог. Тэнд ажиллаж байгаа компаниуд, дотоодын пүүс компаниуд ч бай, гадаадын компаний салбарууд ч бай, өрсөлдөх чадваргүй л бол эдийн засаг нь өрсөлдөх чадвартай байж чадахгүй. Тэгвэл эдийн засгийн бодлого компаниудын үйл ажиллагаа явуулах бүтээмжид нөлөө үзүүлдэг бол хөгжил дэвшилд нөлөө үзүүлж байна гэсэн үг. Компаниудын боловсронгуй байдал, бүтээмж хоёр нь үндэсний бизнесийн орчны чанартай тун нарийн харилцан уялдаатай байдаг. Компаниудын стратеги, үйл ажиллагааны практикууд хэдийчинээ бүтээмжтэй байх тусам төдийчинээ өндөр үр чадвартай хүмүүс, сайн мэдээлэл, үр ашигтай засаглалын үйл ажиллагаа, сайжруулсан дэд бүтэц, сайн нийлүүлэгчид, дэвшилтэт судалгааны хүрээлэнгүүд, эрчимтэй өрсөлдөөний дарамт шахалт гэх мэт олон зүйл шаарддаг.

Компаниудын өрсөлдөх чадвар, байршлуудын өрсөлдөх чадвар хоёр бол өөр боловч харилцан уялдаатай ойлголтууд юм. Байршлууд нь бизнесийн байршлын нэг адилаар бүтээмжид тулгуурлан өрсөлддөг. Мөн компаниуд бүтээмжийн хувьд өрсөлдөх чадвартаа тулгуурлан өрсөлддөг боловч байршлуудын хооронд сонголт хийж болно. Иймээс аливаа компаний өрсөлдөх чадвар нь дотоод авьяас чадвараасаа гадна байршлын сонголтынхоо үр дүнгээс хамаарч байдаг⁶.

Аливаа улс үндэстэн эдийн засгийн хөгжлөө амжилтанд хүргэе гэвэл компаниуд нь өрсөлдөх арга замаа сайжруулах ёстой. Илүү өргөнөөр хэлвэл, компаниуд өөрт заяасан давуу талдаа (ажиллах хүчний бага зардал, байгалийн нөөц баялаг гэх мэт харьцангуй давуу талууд) тулгуурлан өрсөлддөгөө өөрчилж, үр ашигтай, өвөрмөц бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн үйл явцаас бүрдсэн өрсөлдөөний давуу тал бий болгох явдалд шилжих ёстой. Компаниуд гадны түгээлтийн сувгуудыг татан оруулдагаа больж, өөрийн сувгууд бий болгох зарчимд шилжих ёстой. Эдийн засгийн амжилттай хөгжилд хүрэхийн тулд компаниудын стратеги, үйл ажиллагааны практикт шаардлагатай эдгээр болон бусад шилжилтүүдийн талаар Бүдүүвч 2-т үзүүлэв.


Хөгжлийн илүү өндөр түвшинд хүрэхэд бүтээмжийн түвшин ч мөн илүү өндөр болох шаардлагатай учраас хөгжлийн өмнөх шатанд байсан өрсөлдөөний давуу талууд дараагийн шатанд ормогц сул тал болон хувирдаг. Бага болон дунд орлоготой орнуудад гаднаас их хэмжээгээр технологийн эрх авах явдал үр дүнгээ өгдөг боловч тэд дотооддоо бий болгосон технологийн хөгжилд зам тавьж өгөх ёстой болдог. Өмнөх аргууд нь ашигтай байсан, хуучин зуршилдаа гүнзгий автсан учраас бизнесийн салбарынхан зайлшгүй өөрчлөлтүүдийг эсэргүүцэх явдал олон байдаг.

Өрсөлдөөний илүү боловсронгуй аргад шилжих явдал нь микро эдийн засгийн бизнесийн орчинд давхар хийгдэх өөрчлөлтөөс хамаардаг. Энэхүү бизнесийн орчныг харилцан уялдаатай дараахь дөрвөн чиглэлийн хүрээнд ойлгож болно: эдгээр нь хүчин зүйлсийн (орцын) нөхцөл байдлын чанар, пүүс компаний стратеги ба өрсөлдөөний хам нөхцөл байдал, дотоодын эрэлтийн нөхцөл байдлын чанар, холбогдох болон дэмжих үйлдвэрлэлийн салбарууд байгаа байдал дөрөв юм. Тэдгээрийн график дүрслэлээс (Бүдүүвч 3-ыг хар) үүдэн дээрх дөрвөн чиглэлийг нийлээд нэг ромбо гэж үзэж болно.

Бүдүүвч 3: Микро эдийн засгийн бизнесийн орчин



Бүдүүвч 4: Кэйрнсийн (Австрали) аялал жуулчлалын бүлэглэл



Уг ромбын хүрэнээс харахад өрсөлдөх чадварт бараг бүх зүйл хамаатай байна. Сургууль, зам харилцаа, санхүүгийн зах зээл, үйлчлүүлэгчийн боловсронгуй байдлын асуудал зэрэг аливаа улс үндэстний нөхцөл байдлын бусад олон асуудал холбогдож байгаагийн олонх нь тухайн улс үндэстний институциуд, хүмүүс, соёлоос гүн гүнзгий үүдэлтэй байна. Өрсөлдөх чадвар бий болгочихдог дан ганц бодлого эсвэл нэг томоохон алхам гэж байхгүй, тухайн чиглэл бүрт олон тооны сайжруулалт хийж, зайлшгүй урт удаан хугацаа зарцуулж байж үр дүнд хүрэх учраас энэ бүхэн нь өрсөлдөх чадварыг сайжруулах асуудлыг нэг онцгой сорилт болгож байдаг. Үүнд төр засаг төдийгүй их дээд ба дунд сургуулиуд, бусад нийгмийн институци зэрэг олон оролцогчид ямар нэг үүрэг гүйцэтгэдэг. Өрсөлдөх чадварыг дээшлүүлэх асуудал бол ойрын зайн гүйлт биш, холын зайн марафон юм. Өрсөлдөх чадварыг дээшлүүлэх хөдөлгөгч хүчийг хэрхэн тогтвортой бий болгох вэ гэдэг асуудал улс орнуудын өмнө тулгарч буй хамгийн томоохон сорилтуудын нэг болоод байна.

Үндэсний, мужийн, орон нутгийн гээд газар зүйн олон түвшин өрсөлдөх чадварыг нөхөн бий болгож байдаг⁷. Зөвхөн өөр өөр улсын хооронд ч биш, тухайн нэг улсын дотоод эдийн засгийн байдалд ч анхаарал татам ялгаанууд байдаг. Муж, томоохон хот суурин байтугай жижиг хотуудын эдийн засгийн стратегийн амин чухал эрэлт хэрэгцээ бол өрсөлдөх

чадварын сэтгэлгээ, практикийн хувьд хамгийн чухал шинэ чиглэлүүдийн нэгийг барьж авах явдал байдаг.

Мөн хөрш орнууд ч үндэсний бүтээмжийг нөхөжөгч болно. Хөрш орнуудын хооронд эдийн засгийн хамтын ажиллагаа, зохицуулалтыг хөгжүүлэх нь худалдааг өргөжүүлж, бизнесийн орчныг сайжруулах нэг чухал хэрэгсэл мөн.

Бизнесийн орчны олон чиглэлээр төр засаг нөлөө үзүүлж байдаг учраас эдийн засгийн хөгжилд төр засаг зайлшгүй чухал үүрэгтэй. Жишээлбэл, дотоодын эрэлтийн нарийн түвэгтэй байдалд төр засгийн зохицуулалтын стандартууд, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хуулиуд, засгийн газрын худалдан авах практик, импортод нээлттэй байдал зэрэг олон хүчин зүйл нөлөөлдөг. Төр засгийн олон яам, агентлаг төдийгүй орон нутаг, муж, хотын түвшний төрийн байгууллагууд өрсөлдөх чадварт хөндлөнгөөс оролцож байдаг. Иймээс төр засаг ямар нэг үүрэг гүйцэтгэх эсэх тухай асуулт биш, харин ямар үүрэг гүйцэтгэх ёстой вэ, бодлогыг төр засгийн янз бүрийн бүрэлдэхүүн хэсгийн хэмжээнд хэрхэн уялдуулан зохицуулах вэ гэсэн асуулт тавигдах ёстой. Олон орон төр засгийн зохисгүй үүргийг хязгаарлахыг хичээхийн зэрэгцээ түүний эерэг үүргийг орхигдуулж байна. Төр засгаас зүй зохистой дүрэм журам тогтоож, урам зориг өгөхийн зэрэгцээ бүтээлч эдийн засагт чиглэсэн улсын хөрөнгө оруулалт хийдэг байх ёстой.

Бүлэглэлүүд ба эдийн засгийн хөгжил

Бүлэглэлүүд гэдэг бол харилцан холбоотой компаниуд, нийлүүлэгчид, үйлчилгээ үзүүлэгчид, тодорхой нэг чиглэлээр холбоотой байгууллагууд зэрэг нийтлэг зүйл, бие биеэ дэмжих байдлаараа холбогдсон газар зүйн хувьд ойр дөт бүлгүүд юм. Энэтхэгийн програм хангамж, Германы өндөр чанартай автомашины гэх мэтийн бүлэглэлүүд нь голдуу улсынхаа тодорхой нэг бүс нутагт, заримдаа ганц жижиг хотод төвлөрөн ажиллах явдал олон байдаг. Бүлэглэлүүд нь бүтээмжийг дээшлүүлэх, бизнесийн орчныг сайжруулахад чиглэсэн үйл явцуудын жам ёсны илрэл байдаг.

Бүлэглэлүүд нь өргөн хүрээтэй гурван арга замаар өрсөлдөх чадварт нөлөөлж байдаг: Нэгдүгээрт, ямар нэг бүлэглэл оршин байх нь түүнийг бүрдүүлэгч пүүс компаниуд ба салбаруудын бүтээмжийг дээшлүүлж өгдөг. Өөр газраас эх үүсвэр олж авах шаардлагатай салангид компаниудыг бодвол ямар нэг бүлэглэлд байгаа пүүс компаниуд төрөлжсөн нийлүүлэгчид, ажиллагсад, мэдээлэл, сургалт олж авах талаар илүү үр ашигтай байдаг. Асар өргөн хүрээтэй бэлэн орц, машин техник, ур чадвар, мэдлэг нэг дор байх нь алслагдмал нийлүүлэгчидтэй босоо нэгдэл, харилцаанд орохоосчилүүгээрүрашигтай, уянхатанбайдлыг хөхиүлэн дэмжиж байдаг. Хоёрдугаарт, ямар нэг бүлэглэл оршин байх нь шинийг санаачлах чадавхийг болон бүтээмжийн өсөлтийг нэмэгдүүлж байдаг. Ямар нэг бүлэглэлийн хүрээнд шинийг санаачлах таатай боломж илүү хялбар бий болдог гэж үзэх нь олонтаа бөгөөд шинэ санаачлагыг хэрэгжүүлэх хөрөнгө, ур чадвар, капитал бэлэн байдаг. Гуравдугаарт, бүлэглэлүүд нь шинийг санаачлахыг дэмжиж, бүлэглэлээ тэлсэн шинэ бизнесүүд төрөн гарах урам зориг өгч, тийм бололцоог бүрдүүлж байдаг. Хэрэв туршлагатай ажилчидтай, дотооддоо байгаа шаардлагатай бүхий л орц, төрөлжсөн үйлчилгээг авах боломжтой байвал ямар нэг бүлэглэлд ороход тавигдах бэрхшээл саад бүр ч бага байдаг.

Бүлэглэлүүдийн бүтээмжийн үр өгөөжийг амьралын ухаан, мэдээллийн технологи гэх мэт мэдлэгийн нягтрал ихтэй салбаруудад төдийгүй эдийн засгийн бараг бүх хэсгүүд хүртэж байдаг. Үүний сайн жишээ бол аялал жуулчлал юм. Баруун Хойд Австралийн Кэйрнсийн аялал жуулчлалын бүлэглэлд өндөр зэрэглэлийн зочид буудал, ресторанууд, жуулчны хөтөч нар болон жуулчдад маш сайхан аялалыг санал

болгоход чухал үүрэгтэй олон тооны дэмжих үйл ажиллагаа байдаггүй сэн бол зөвхөн Грийт Барриер Рийф, халуун орны ширэнгэн ой зэрэг байгалийн үзэсгэлэнт газруудад ойр байдал нь аялал жуулчлалын бусад өрсөлдөгч газруудаас илүү давуу тал болж чадахгүй байх байлаа⁸. (Бүдүүвч 4-г үзнэ үү)

Үндэсний эдийн засгууд ч худалдаалагддаг бүтээгдэхүүнд нь харьцангуй их хувь эзэлдэг тодорхой төрлийн бүлэглэлүүдийг төрөлжүүлэн хөгжүүлэх хандлагатай байна. Эдийн засгийн энэ төрлийн төрөлжилт тухайн улсын дотоод дахь бүс нутгуудад явагдах нь бүр ч илт ажиглагдаж байна.

Тухайн улсын эдийн засгийн хөгжлийн байдлаас хамаарч бүлэглэлүүдийн шинж чанар, хамрах хүрээ янз бүр байна. Хөгжиж байгаа орнууд дахь бүлэглэлүүдэд олон тооны дэмжих салбар, институци голдуу дутагдаж байна. Пүүс компаниуд нь хямд ажиллах хүч, дотоодын байгалийн баялагтаа тулгуурлан өрсөлддөг бөгөөд импортын түүхий эд, машин техник, технологиос ихээхэн хамааралтай байдаг. Энд дотоодын төрөлжсөн тусгай дэд бүтэц ба институциуд байхгүй буюу үр ашиггүй байдаг. Ийм бүлэглэлийн пүүс компаниуд харьцангуй дэвшилтэт бус үйл ажиллагаа явуулдаг.

Эдийн засаг хөгжиж дэвшихийн хэрээр бүлэглэлүүд хөгжиж үйл ажиллагаагаа гүнзгийрүүлэн, төрөлжсөн орц, эд анги, машин техник, үйлчилгээ нийлүүлэгчидтэй болоод зогсохгүй төрөлжсөн дэд бүтэц, төрөлжсөн сургалт, боловсрол, мэдээлэл, судалгаа, техник дэмжлэгээр хангадаг байгууллагуудтай болдог.

Дэлхий дээр тодорхой нэг чиглэлээр ажилладаг цорын ганц бүлэглэл байх нь ховор, харин боловсронгуй байдал ба төрөлжилтийн өөр өөр түвшин бүхий олон тооны бүлэглэл өөр өөр газарт байх нь бий. Тодорхой нэг чиглэлд гэвэл, хагас дамжуулагчийн үйлдвэрлэлээр Силикон Валий, Япон гэх мэт цөөн тооны бүлэглэл л жинхэнэ шинийг санаачлалтын төвүүд болох хандлагатай байна. Эдгээр шинийг санаачлалтын төв заримдаа тодорхой нэг зах зээлийн сегментийг дагнан төрөлждөг бөгөөд үүний нэг жишээ бол микро процессорын үйлдвэрлэлээр ер бусын хүчирхэг Силикон Валийгийн бүлэглэл юм. Бусад газрын хувьд үйлдвэрлэлийн төвүүд байж болох юм. Мөн бүс нутгийн хэмжээнд угсралт, үйлчилгээ явуулдаг бусад бүлэглэл байж болно. Орчин үеийн эдийн засагт гарч буй нэг чухал чиг хандлага бол бүлэглэлүүд тодорхой нэг сегмент юмуу эсвэл үнэт зүйлийн

гинжин хэлхээний тодорхой давхаргуудаар илүү нарийн мэргэшин төрөлжиж байгаа юм шиг санагдаж байгаа явдал юм.

Хамгийн дэвшилтэт бүлэглэлүүдэд багтсан пүүс компаниуд эрсдлийг багасгах, бага зардалтай орц олж авах, эсвэл тодорхой бүс нутгийн зах зээлд илүү сайн үйлчлэх үүднээс зарим үйл ажиллагаагаа задлаж, бусад газарт салбараа байгуулах буюу бүлэглэлээ тэлэх явдал олон байдаг. Жишээлбэл, Интел компани зарим угсралтын болон туршилтын ажлаа, мөн зарим нарийн дамжуулагчийнхаа үйлдвэрлэлийг АНУ-ын бус байрлалуудад нүүлгэн шилжүүлж, бүс нутгийн бүлэглэлүүд үүсгээд байна. Бусад олон чиглэлд иймэрхүү хөгжил гарч байгааг ажиглаж болно, тухайлбал бизнесийн үйлчилгээ, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг ажиллах хүчний хямд өртөгтэй газрууд руу нүүлгэн шилжүүлж байна. Эдгээр үйл ажиллагааг буурай хөгжилтэй орнуудад газар зүйн хувьд тараан байрлуулахын оронд шинээртөрөнгөрчбуйбүлэглэлүүдтэйзэрэгцэн байрлах нь дээр гэж компаниуд үзэх болжээ. Үүний жишээг Энэтхэгийн Банглов дахь гадны санхүүжилттэй бизнесийн үйлчилгээнүүд, Румыны Тимисоара дахь нэхмэлийн үйлдвэрлэлээс харж болно⁹. Даяаршлын цаад утга бол бүлэглэлийн эзэмшлийг бус, харин тэдний дэлхийн хэмжээнд тархах газар зүйн хэв маягийг шинэчлэн зохицуулна гэсэн үг болохыг эдгээр жишээ харуулж байна. Үнэн хэрэгтээ, бүс нутгууд янз бүрийн газрын улам ширүүн өрсөлдөөний дарамт шахалтад автаж дотроо улам бүр төрөлжихийн хэрээр бүлэглэлүүд бүр ч чухал ач холбогдолтой болж байгааг илтгэх нотлох баримтууд нэмэгдсээр байна. Зөвхөн бүлэглэлүүдийн хэмжээнд бус, тэдний дотоодод төрөлжилт явагдаж, нийт үнэ цэнийг бий болгоход янз бүрийн байрлал дор бүрдээ өөр өөрийн үүргийг гүйцэтгэдэг болоод байна.

Аливаа эдийн засагт тулгарч байгаа сорилт бол салангид пүүс компаниудаас нэг хэсэг бүлэглэлд шилжих, улмаар бүлэглэлийн боловсронгуй байдлыг дээшлүүлэн илүү дэвшилтэт үйл ажиллагаанд оруулах явдал юм.

Өрсөлдөөнт хөгжлийн үе шатууд

Эдийн засгийн амжилттай хөгжил гэдэг бол дэс дараалсан сайжруулалтын үйл явц бөгөөд аливаа улсын пүүс компаниуд улам бүр боловсронгуй, бүтээлч байдлаар өрсөлдөхийг дэмжин урамшуулдаг хэмжээнд хүртэл үндэсний

Бүдүүвч 5: Өрсөлдөөнт хөгжлийн үе шатууд



Эх сурвалж: Портер (1990)

бизнесийн орчин хувьсан хөгждөг. Хөгжлийн өөр өөр түвшинд яваа улс үндэстнүүд ч өөр өөрийн өвөрмөц сорилтуудтай тулгарч байдаг.

Улс үндэстнүүд хөгжихийн хэрээр тэд өрсөлдөөний давуу тал ба өрсөлдөх хэлбэрийн хувьд хөгжин дэвшдэг¹⁰ (Бүдүүвч 5-ыг үзнэ үү). *Хүчин зүйлсэд чиглэсэн үе шатанд* ажиллах хүчний хямд өртөг, боловсруулаагүй байгалийн баялаг зэрэг үндсэн хүчин зүйлсийн нөхцөл байдлууд өрсөлдөөний давуу тал ба экспортын зонхилох эх сурвалж болдог. Пүүс компаниуд нь өргөн хэрэглээний бараа юмуу бусад илүү өндөр хөгжилтэй орнуудад зохион бүтээсэн харьцангуй энгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Импорт, нийлүүлэлтийн гэрээ, гадаадын шууд хөрөнгө оруулалтаар дамжуулан, мөн даган дуурайх байдлаар технологийг өөрийн болгодог. Энэ үе шатанд компаниуд үнээр өрсөлддөг бөгөөд хэрэглэгчдэд шууд хүрч ажиллах боломж дутагддаг. Тэд угсралт, хүний хөдөлмөр ихээр шаарддаг үйлдвэрлэл, эрдэс баялгийн олборлолт зэрэгт голлон анхаарч үнэт зүйлийн гинжин хэлхээнд хязгаарлагдмал үүрэгтэйгээр оролцдог. Хүчин зүйлсэд чиглэсэн эдийн засаг нь дэлхийн эдийн засгийн мөчлөг, өргөн хэрэглээний барааны үнэ, валютын ханшны хэлбэлзэлд туйлын эмзэг өртөмтгий байдаг.

Хөрөнгө оруулалтад чиглэсэн үе шатанд өрсөлдөөний давуу талын гол эх сурвалж нь стандарт бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэлийн үр ашигтай байдал байдаг. Үр ашигтай дэд бүтцэд хийх их хэмжээний хөрөнгө оруулалт, бизнест тааламжтай ханддаг төр засгийн удирдлага, хөрөнгө оруулалтын хүчтэй сонирхол, капиталын хүртээмж сайтай байдал зэрэг нь бүтээмжийг ихээхэн дээшлүүлэх боломж олгодог. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ нь илүү боловсронгуй болох боловч технологи, зохион бүтээлтийн хувьд гаднаас ихээр авсан хэвээр байна. Лицензийн эрх, хамтарсан үйлдвэр, гадаадын шууд хөрөнгө

оруулалт, даган дуурайлтын аргуудаар технологи олж авна. Гэхдээ, энэ шатанд яваа улсууд гадны технологийг өөрийн болгож аваад зогсохгүй түүнийг сайжруулах чадвараа хөгжүүлж эхэлдэг. Компаниуд Жинхэнэ Тоног Төхөөрөмж Үйлдвэрлэгч (ЖТТҮ)-ийн хэрэглэгчид болон эцсийн хэрэглэгчдийн аль алинд нь үйлчилнэ. Пүүс компаниуд үнэт зүйлийн гинжин хэлхээнд хамрагдах чадвараа улам өргөжүүлэн тэлнэ. Хөрөнгө оруулалтад чиглэсэн эдийн засаг нь үйлдвэрлэлд болон гадны санхүүжилттэй үйлчилгээний экспортод гол анхаарлаа төвлөрүүлдэг. Түүнчлэн ийм эдийн засаг нь санхүүгийн хямрал, салбарын чанартай эрэлтээс үүдсэн гадны цочролуудад өртөмтгий байна.

Шинийг санаачлалтад чиглэсэн үе шатанд өрсөлдөөний давуу талын зонхилох эх сурвалж нь хамгийн дэвшилтэт арга техник ашиглан дэлхийн технологийн тэргүүн эгнээнд хүрсэн шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээ үйлдвэрлэн гаргах чадвар байдаг. Үндэсний бизнесийн орчны бүхий л чиглэлд давуу байдлаар төдийгүй гүнзгий хөгжсөн бүлэглэлүүдээр тодорхойлогдоно. Шинэ санаачлагыг дэмжих институциуд төдийгүй шинийг санаачлах урам зориг өндөр хөгжсөн байна. Компаниуд цар хүрээний хувьд голдуу дэлхий нийтийг хамарсан давтагдашгүй стратегиэр өрсөлдөнө. Шинийг санаачлалтад чиглэсэн эдийн засаг нь тухайн эдийн засагтаа өндөр хувь нэмэр оруулах бөгөөд гадны цочролуудад уян хатан байдаг.

Эдийн засгийн хөгжлийг харилцан хамаарал бүхий микро эдийн засгийн чадавхийг бэхжүүлэх, компаний стратегийг өөрчлөх, урам зоригийг сэргээх, өрсөлдөөнийг нэмэгдүүлэхэд чиглэсэн дэс дараатай үйл явц гэж үзэх нь эдийн засгийн бодлогод чухал ач холбогдолтой. Микро эдийн засгийн бизнесийн орчны нэг хэсгийн үзүүлэх нөлөө нөгөө хэсгийнхээ байдлаас хамаарч байдаг. Аль нэг чухал чиглэлд сайжруулалт дутагдах нь бүтээмжийн өсөлт саарч, хөгжил зогсоход хүргэж болно. Түүнээс ч дор нь энэ байдал эдийн засгийн шинэчлэлийн үйл явцыг бүхэлд нь дордуулж болно. Тухайлбал, компаниуд хямд ажиллах хүчээр өрсөлдсөөр байгаа учраас шинээр коллеж төгссөн боловсрол сайтай залуус зохих ажлаа олж чадахгүй байгаа үед бизнесийн салбарыг эсэргүүцэн тэмцэх явдал үүсдэг.

Мөн энэхүү шинжилгээнд яагаад улс орнууд хөгжлийн шинэ шатанд шилжин ороход тийм

их хэцүү байдгийг авч үзэж эхлэнэ. Иймэрхүү шилжилтийн цэгүүд нь өрсөлдөөний харилцан хамаарал бүхий олон асуудлаар ихээхэн шилжилт хийхийг шаарддаг.

Институциуд ба тэдгээрийн эдийн засгийн хөгжилд гүйцэтгэх үүрэг

Өрсөлдөх чадварт засгийн газар чухал үүрэгтэй боловч дан ганц засгийн газар өрсөлдөөнт эдийн засаг бий болгох чадвар улам бүр багассаар байна. Өрсөлдөх чадвар, эдийн засгийн хөгжилд үүрэг гүйцэтгэдэг үндэсний болон орон нутгийн өөр олон институци байдаг. Өрсөлдөөнд мэдлэг, технологи хоёр улам бүр гол болохын хэрээр их дээд болон дунд сургуулиудын нөлөө ч нэмэгдсээр байна. Тэд зөвхөн эрдэм боловсрол, судалгааны чадавхийг дээшлүүлээд зогсохгүй хувийн салбартай илүү нягт холбоотой ажиллах ёстой болоод байна.

Мөн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, эдийн засгийн бодлого тодорхойлоход хувийн салбар нэг амин чухал оролцогч болоод байна. Хувийн салбар нь бизнесийн орчны нэг хэрэглэгч болоод зогсохгүй түүнийг бүрдүүлэхэд өөрийн гэсэн үүрэг гүйцэтгэж чаддаг, гүйцэтгэх ч ёстой байдаг. Хувь компаниуд сургалтын хөтөлбөрүүд бий болгох, нийлүүлэгчдийн сонирхолыг татах, эсвэл өөрийн стандарт тогтоох зэрэг алхам хийж түүнийхээ үр шимийг зөвхөн өөрсдөө хүртээд зогсохгүй өрсөлдөөний ерөнхий орчныг сайжруулж байдаг. Түүнчлэн, худалдааны холбоод, худалдааны танхимууд гэх мэт салбарын хамтын байгууллагууд дэд бүтцийг сайжруулах, сургалт явуулах, экспортын зах зээл хөгжүүлэх зэрэг голдуу орхигдоод байдаг чиглэлүүдэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Чанарын гэрчилгээний хөтөлбөрүүд, үйлдвэрлэлийн туслалцааны төвүүд гэх мэт хувь компаниудын чадавхийг дээшлүүлэхэд чиглэсэн хамтын хүчин чармайлт ч улам бүр нэрд гарч байна. Мөн хувийн компаниуд өрсөлдөх чадварын үйл ажиллагаанд оролцох нь засгийн газар солигдсон ч хөгжил дэвшлийг тогтвортой байлгахад зайлшгүй шаардлагатай анхаарлыг тасралтгүй тавих, улс төрийн зүтгэлтнүүдийн тавьдаг харьцангуй богино хугацааны анхаарал халамжийн хүрээг тэлж өгөх ач холбогдолтой.

Эцэст нь бидний зүгээс *хамтын ажиллагааны институциуд* (ХАИ) гэж нэрлэсэн өрсөлдөх чадварт чухал үүрэгтэй бүхэл бүтэн институцийн давхарга байдаг боловч тэднийг эдийн засгийн хөгжлийн сэтгэлгээнд ихээхэн орхигдуулсаар ирсэн билээ¹¹. Засгийн газрын

байгууллага биш, боловсролын байгууллага ч биш, пүүс компани ч биш ийм байгууллагууд, тухайлбал, худалдааны холбоод, бизнес эхлэн эрхлэгчдийн сүлжээ, стандарт тогтоогч агентлагууд, чанарын төвүүд, технологийн сүлжээнүүд зэрэг бусад олон байгууллагууд нийтлэг байдаг. Тэд нэн ялангуяа өндөр хөгжилтэй орнуудад түгээмэл байдаг боловч хөгжиж буй орнуудад ч шийдвэрлэх үүрэгтэй. ХАИ нь дээр дурдсан ромбын бүрэлдэхүүн хэсгүүдийг холбоход төдийгүй өндөр хөгжилтэй ба хөгжиж буй орнуудын аль алинд үр ашигтай хамтын ажиллагаа өрнүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэдэг¹².

Макро болон микро эдийн засгийн бодлогын уялдаа холбоо

Уламжлал ёсоор макро эдийн засгийн тогтворжуулалт, зах зээлийн нээлттэй байдалд хандуулдаг гол анхаарал яагаад хангалтгүй байгааг манай шинжилгээ тодорхой болгож өгнө. Тухайлбал, хөрөнгө оруулалтын хэлбэрүүд зохисгүй, хөрөнгө оруулалтыг үр ашигтай болгоход чиглэсэн компаний ур чадвар, дэмжих салбарууд байхгүй, мөн зах зээлийн сахилга бат сахихад шаардлагатай өрсөлдөөний хүчтэй дарамт шахалт, хангалттай корпорацийн засаглал байхгүй тохиолдолд их хэмжээний капиталын хөрөнгө оруулалт бий болгоход чиглэсэн макро эдийн засгийн бодлого баримтлаад ч бүтээмжийг дээшлүүлэгч болж чадахгүй. Төсөв, мөнгөний сайн бодлого, валютын ханшны болон бусад үнийн хямралыг гэтэлгэх бодлого нь бүтээмжид учрах саад тотгоруудыг арилгах боловч үнэхээр бүтээмжийг дээшлүүлье гэвэл микро эдийн засгийн үндэс суурийг тавьж өгөх ёстой.

Гадаад өрийн зохистой түвшин микро эдийн засгийн нөхцөл байдлаас хамаардаг. Гадаадын капиталыг яг хаана хөрөнгө оруулах вэ гэдгээс болон түүний ашиглалт, удирдлагыг тойрсон микро эдийн засгийн үндэс сууриас гадаад өрийн түвшний зохистой байдал хамаардаг. Өрийн ерөнхий түвшинг зохицуулах явдал бол түүний микро эдийн засгийн бааз суурийг сайжруулахаас олон талаар ач холбогдол багатай. АНУ-ын эдийн засагт макро эдийн засгийн тэнцвэргүй байдал ноцтойгоор оршин байгаа ч тус улсын эдийн засгийн уян хатан байдал нь түүний микро эдийн засгийн хувьд сэтгэл хөдлөм хүч чадалтай холбоотой байж ч болох юм.

Аливаа улс үндэстний микро эдийн

засгийн нөхцөл байдлаас үүдэн компаниудад ур чадварын эрэлт бий болоогүй байхад улсаас хүний нөөцийг хөгжүүлэхэд их хэмжээний хөрөнгө зараад нэмэргүй. Компаниуд үр ашгаа дээшлүүлж чадаагүй, дотоодын өрсөлдөөний шахалтад ороогүй байхад өмч хувьчлал хөгжил дэвшилд хүч нэмэхгүй. Макро эдийн засгийн түвшинд сайн бодлого баримталж, улам өндөр бүтээмжтэй эдийн засаг бий болгоё гэвэл микро эдийн засгийн сайжруулалтуудыг зэрэгцүүлэн хийж байх ёстой.

Өнөөгийн олон улсын эдийн засгийн бодлого, шийдвэрийн гол чиглэл болсон худалдааны гэрээ хэлэлцээр болон зах зээлийг нээлттэй болгох бусад арга хэмжээний үр нөлөө ч микро эдийн засгийн бодлогоос хамаарч байдаг. Зах зээлийг нээлттэй болгох нь сайн зүйл, гэвч түүний хөгжилд өгөх үр өгөөж нь микро эдийн засгийн ахиц дэвшлээс хамаардаг. Хэрэв дотоодын бизнесийн орчин улам бүр үр ашигтай болохгүй, дотоодын компаниуд бүтээмж, боловсронгуй байдлаа дээшлүүлэхгүй бол зах зээлийг нээлттэй болгомгоц импорт ихээр нэмэгдэж, харин экспортын өсөлт, гадаадын хөрөнгө оруулалтыг татах явдал туйлын удаашралтай байх болно. Энэхүү сургамж нь нэн ялангуяа Төв Америкийн Чөлөөт Худалдааны Бүс (ТАЧХБ) гэх мэт эдийн засгийн хөгжлийн огт өөр өөр шатанд яваа орнуудын хооронд байгуулсан худалдааны гэрээнд чухал ач холбогдолтой. Ийм чөлөөт худалдааны бүсийн бага буурай хөгжилтэй орнуудад микро эдийн засгийн сайжруулалт хийж, илүү өндөр хөгжилтэй орнуудад нь үр ашигтай бүтцийн зохицуулалт хийх нь өндөр чадамж бүхий эдийн засгийн үр өгөөж гарахад шийдвэрлэх үүрэгтэй. Зах зээлийг нээлттэй болгох арга хэмжээ авч дуусахаас өмнө микро эдийн засгийн бизнесийн орчны сайжруулалтыг хийж эхлэх шаардлагатай.

Мөн микро эдийн засгийн шинэчлэлд ихээхэн анхаарал тавих явдал ч үр шимээ өгөх болно. Макро эдийн засгийн шинэчлэл нь хүүгийн хувь ба үнийн түвшинг нэмэгдүүлэх замаар болон төсвийн зарцуулалтыг багасгах замаар богино ба дунд хугацаанд зайлшгүй хүндрэл бэрхшээл үүсгэдэг бол микро түвшний шинэчлэл нь иргэдэд бодитой бөгөөд нүдэнд харагдахуйц үр ашиг өгч чаддаг. Жишээлбэл, дотоодын бизнесийн бүлгүүд, монополиудыг задалснаар хоолхүнс, орон байр, цахилгаан эрчим хүч, утсан холбоо болон бусад амьжиргааны өртөгт холбоотой зарлагыг бууруулж өгдөг. Зохицуулалтын шинэчлэл нь маш хурдан үр

ашиггүй байдлыг багасгаж, байгаль орчныг бохирдлыг бууруулан, бүтээгдэхүүний чанарыг сайжруулж, аюултай практикуудыг арилгаж эхэлдэг байж болно. Боловсрол, сургалтын чанарыг сайжруулах нь хүүхдэд ирээдүйд илүү сайхан амьдрах итгэл өгдөг учраас энэ чиглэлд зоримог алхам хийх нь онцгой чухал. Хэрвээ бизнес өөрөө шинэчлэгдэж, өрсөлдөөний хүнд бэрх сорилтуудтай тулгарч байгааг иргэд олж харах юм бол тэд өөрсдөө хувийн сайн сайхнаа золиослон амьдрахад бэлэн байж, шинэчлэлийн эсрэг сонирхолын бүлгүүдтэй нэгдэх магадлал бага байна. Эдийн засгийн бодитой өөрчлөлт хийх улс төрийн хүсэл зориг, олон нийтийн дэмжлэг ч дээшлэх болно.

Өрсөлдөх чадварын зэрэглэл тогтоох нь

Өрсөлдөх чадварын хэмжүүрүүд

Энэхүү Бизнесийн өрсөлдөх чадварын индекс (БӨЧИ) нь үндсэндээ Хүснэгт 1-д харуулсан 116 орны 10961 бизнесийн дээд шатны удирдагч нараас авсан Судалгааны хэмжүүрүүдээс бүрдэж байна¹³. Өнгөрсөн жилийнхтэй харьцуулвал шинээр 15 улс (Албани, Армян, Бенин, Камбож, Камерун, Зүүн Тимор, Гайана, Казахстан, Кувейт, БН Киргиз Улс, Молдав, Монгол, Катар, Тажикстан) нэмэгдэж 2 улс (Ангол, Замби) хасагдсан байгаа.

Үндэсний бүтээмжийг бүрдүүлдэг асар олон тооны, маш олон янзын нөлөөлөгч хүч байдаг учраас өрсөлдөх чадварыг хэмжих явдал бол хүнд сорилт байдаг. Зөвхөн нарийвчилсан судалгаагаар л олон орных хэмжээнд өрсөлдөөний орчин ба компанийн практикийг нягт нямбай нэгтгэн хэмжиж чадна. Уг Судалгааны асуултууд аливаа улс үндэстний байгаа нөхцөл байдлыг дүрслэн харуулахыг зорьсон бөгөөд ингэхдээ Судалгаанд оролцогчдын хувьд ч утга учиртай байлгахыг зорьсон юм. Жишээлбэл, бид улсын сургуулиудын чанарын тухай асуултуудыг хэсэг бүлэг жирийн хүмүүст хандаж тавьсан. Яагаад гэвэл, энэ нь хариулагчдын хувьд олон улсын хэмжээнд харьцуулан хэлэх илүү боломжтой зүйл юм. Сургуулиудын чанар хэмээх урсгал хэмжүүр нь үндсэн ур чадварын нөөцтэй ихээхэн хамааралтай байх юм.

Дэлхийн Банкнаас сүүлийн хэдэн жилийн турш засаглал ба зохицуулалтын нөхцлүүдийн тухай харьцуулж болохуйц тоо баримтыг өргөн хүрээтэй олон орныг хамруулан системтэйгээр цуглуулж авахаар ажиллаж байна¹⁴. Авилгал, зохицуулалтын чанар, эрх зүйт төрийн

талаарх Дэлхийн Банкны тоо баримтууд нь манай Судалгааны зарим чиглэлтэй давхцаж байгаа юм¹⁵. Манай судалгааны асуултууд Дэлхийн Банкныхтай холбоотой боловч ихэвчлэн өөр шинж чанартай байдаг, гэхдээ манай үзүүлэлтүүд болон Дэлхийн Банкны тоо баримтуудын хоорондын корреляцийн хамаарал тогтмол 80-аас дээш хувьтай гарч байгаа. Мөн Дэлхийн Банк «Бизнес эрхлэх нь» нэртэй мэдээллийн сантай бөгөөд үүндээ бизнес эхлэн эрхлэхэд шаардлагатай захиргааны журмууд, бизнесийг зээл авах боломжоор хангадаг зээлийн бүртгэлийн үр нөлөөтэй тогтолцоо байгаа байдал, дампуурлын журмын зохион байгуулалт гэх мэт зүйлийг хамруулдаг. Харин энэ мэдээлэл ба манай судалгааны тоон үзүүлэлтүүдийн хоорондын корреляцийн хамаарал харьцангуй бага байна. Өөр өөр онцлог шинжийг нь хэмжиж байгаа учраас (жишээ нь, манай судалгаанд зээл авах боломжийг, харин Дэлхийн Банкны тоон үзүүлэлтэд барьцааны хөрөнгө бүрдүүлэх зардлыг хэмждэг) ийнхүү ялгаатай байгаад гайхах зүйлгүй юм. Судалгааны тоон үзүүлэлтүүд маань бүх улс оронд байдаг бөгөөд Судалгааны асуултууд маань өрсөлдөх чадварт хамгийн их учир холбогдолтой үндэсний нөхцөл байдлыг гаргахад чиглэсэн учраас бид дийлэнхдээ Судалгааны тоон үзүүлэлтүүддээ найддаг.

Патентийн эрх авалтын хувь, интернэт нэвтрэлт, гар утас нэвтрэлт зэрэгт тоон хэмжүүрүүд ашигласан байгаа. Гэвч бидний хэмждэг бусад бүх хэмжээсийн хувьд зүгээр л тоон үзүүлэлт нь огт байхгүй байх явдал нилээн олон оронд тохиолдож байлаа. Уг судалгаа нь зөвхөн олон тооны давтагдашгүй хэмжүүрийг санал болгоод зогсохгүй энд хамрагдсан эдийн засгууд дахь бодит оролцогч бүрийн мэдээлэлтэйгээр хийж буй дүгнэлтийг авч үзэж байгаа юм. Уг судалгаанд оролцож хариулагчид эцсийн дүндээ эдийн засгийн үйл ажиллагааг тодорхойлж буй шийдвэр гаргагчийн байр сууринаас хандаж байгаа учраас тэдний хариулт дор бүрдээ чухал ач холбогдолтой. Хариулагчдын өгч буй дүгнэлтэд тухайн улсын эдийн засгийн ерөнхий уур амьсгал нөлөөлсөн эсэхийг бид шалгаж үзсэн бөгөөд аливаа улсын бодит өсөлтийн хувь буюу өсөлтийн хувьд гарч буй өөрчлөлт ба Судалгааны асуултуудад хариулсан хариултуудын дундаж түвшинд гарч буй өөрчлөлтийн хооронд ямар нэг чухал хамаарал олдоогүй юм.

Өнгөрсөн жилтэй харьцуулвал, бид уг

судалгаанд хариулахад шаардагдах цагийг багасгах, хариулагчдын тоог нэмэгдүүлэх, улмаар илүү олон бизнесийн удирдагч нарыг оролцуулах зорилгоор судалгааны асуултынхаа тоог 67-гоос 57 болгож цөөлсөн. Ингэж цөөлснөөр ерөнхий зэрэглэлүүдэд үзүүлэх нөлөө бага байна¹⁶.

Өнгөрсөн жилийн нэг адилаар бид Судалгааны тоон үзүүлэлтүүдийнхээ нийцтэй байдлыг шалгасан нь статистик тооцоонд ашигласан түүврээ аль болох хүчин төгөлдөр байлгах, зэрэглэл нь баттай бус байж болох зарим онцлог орныг олж тогтоох зорилготой байлаа. Судалгааны асуулт бүрийн хувьд бид аль нэг орны хэмжээнд өгсөн хариултын стандарт хазайлтыг нийт улс орны өгсөн хариултын стандарт хазайлттай харьцуулж үзсэн байгаа. Судалгааны олон асуултад улсын хэмжээгээр өгсөн хариултууд нь их зааг ялгаатай байгаа орнуудын хувьд уг ялгааны боломжит шалтгаануудыг тайлбарлалгүйгээр дан ганц тухайн улсын дунжийг тайлбарлахад хэцүү юм¹⁷. Цаашилбал, бид тухайн улсад үйл ажиллагаа явуулж буй гадаадын компаний удирдлагуудын хариултыг тухайн улсын хэмжээнд санал нэгтэй байгаа хүрээнд шинжилж үзсэн байгаа. Эдгээр хариулагчид нь тухайн улс бусад орнуудтай харьцуулахад хэр зэрэг байгааг хамгийн сайн илтгэн харуулна гэдэгт итгэж байна.

Энэ жил судалгаанд хамрагдсан 116 орноос 110 нь манай тоон үзүүлэлтийн нийцтэй байдлын шалгалтад тэнцсэн байгаа¹⁸. Бидний нийт 116 орны зэрэглэлийг тогтооход ашигласан загварын тооцоог эдгээр 110 оронд мөн адил хэрэглэсэн. Харин тоон үзүүлэлтийн чанарын хувьд асуудалтай байгаа 6 орны зэрэглэлийг анхаарал болгоомжтой тайлбарлах ёстой.

Регрессийн тооцоонд ашигласан 110 орныг хамарсан түүврийн хувьд болон уг Индексийн загварын тооцооны хувьд дунджаар нэг улсаас 93-аас илүү хариулагчтай байсан нь өнгөрсөн жилийн дундаж 80-аас нилээд нэмэгдсэн байна. Нэг улсын хэмжээний санал нэгтэй байдлын түвшин ч анхаарал татам байна. Бүх хэмжүүрийн хувьд улсын хэмжээний зөрөөтэй байдлаас үүдсэн ялгааны хувь хэмжээ статистик ач холбогдолтой гарсан байна. Хүлээлт ёсоор, нийт бизнесийн орчны үзүүлэлтүүдийн хувьд улсын хэмжээний санал нэгтэй байдал илүү өндөр байсан бол тухайн улсын доторх компаниуд ба бүлэглэлүүдийн хувьд санал зөрөөтэй байгаа хэмжүүрийн хувьд санал нэгтэй байдал доогуур түвшинд байна. Иймд тухайн

улсын дундаж үзүүлэлтүүд нь өрсөлдөөний нөхцөл байдал дахь улс орнуудын ялгаатай байдлыг зөвөөр гаргахын зэрэгцээ нэг улсаас тун цөөхөн хариулт авсан тохиолдолд үүсч болохоор байсан нэг талыг барьж туйлширсан үзлийг хязгаарлаж байгаа юм.

БӨЧИ-ийг боловсруулахад ашигласан үр дүнгийн хувьсагч нь валютын худалдан авах чадвараар (ВХАЧ) тохируулсан 2004 оны нэг хүнд ноогдох ДНБ-ий түвшин юм. Нэг хүнд ноогдох ДНБ бол үндэсний бүтээмжийг хэмждэг хамгийн өргөн хүрээтэй хэмжүүр бөгөөд цаг хугацааны хувьд аливаа улс үндэстний амьжиргааны түвшинтэй нягт уялдаатай байдаг. Энэ үзүүлэлт бүх улс орны хэмжээнд байдаг бөгөөд микро эдийн засгийн өрсөлдөх чадварын ганц сайн, нэгдсэн хэмжүүр юм¹⁹. Нэг хүнд ноогдох ДНБ нь дунд болон урт хугацааны турш аливаа улсын бүтцийн үндэс суурийг тусган харуулж байдаг. Гэвч бас байгалийн гамшиг, макро эдийн засгийн цочрол, экспортын тодорхой салбарууд дахь үнийн өөрчлөлт гэх мэт олон тооны түр зуурын бөгөөд гэнэтийн хүчин зүйлс энэ үзүүлэлтэд нөлөөлж байдаг. Микро эдийн засгийн үндэс сууриудаар тайлбарлаж болох нэг хүнд ноогдох ДНБ-ий хазайлтын хувь хэмжээг бүх улс орны хэмжээгээр гаргана гэдэг өөрөө сонирхолтой зүйл юм.

Хөгжлийн өөр өөр түвшинд яваа улс орнуудын өрсөлдөх чадварын эх сурвалжуудын ялгааг судлаж шинжлэхийн тулд бид улс орнуудыг орлогын хэмжээнд нь тулгуурлаж гурван бүлэгт хуваасан. Бага, дунд, өндөр орлогтой орнуудыг зааглах ямар нэг хүлээн зөвшөөрөгдсөн ангилал байхгүй бөгөөд орлогын зааг ялгааг статистикийн хувьд тодорхойлох хүчин чармайлт нь тоон өгөгдлийн хязгаарлалтуудад орж байдаг. Харин үүний оронд бид прагматик байдлаар хандаж, орлогын зааглах цэгүүд ашиглан улс орнуудыг хуваасан нь тэдний хүсэл тэмүүлэл, өрсөлдөөний байр суурийг харгалзан заагласан логик ангилал болсон бөгөөд утга төгөлдөр статистик сорилтууд хийх боломжтой байхын тулд бүлэг бүрт хангалттай тооны орнууд орох нөхцлийг бүрдүүлсэн болно. Бид мөн орлогын бүлгийг жилээс жилд тогтвортой байлгахыг оролдож байна. Бид бага ба дунд орлогыг зааглах цэгийг 2004 оны нэг хүнд ноогдох ДНБ-ий (ВХАЧ) 4.000 ам.долларын түвшинд, дунд ба өндөр орлогыг зааглах цэгийг 2004 оны нэг хүнд ноогдох ДНБ-ий (ВХАЧ) 17.000 ам.долларын түвшинд тогтоож байгаа нь өнгөрсөн жилийнхтэй адил түвшинд байна.

Энд нийт 28 бага орлоготой улс (шинээр долоон улс нэмэгдсэн, өмнө нь бага орлоготой улсад орж байсан гурван орон дунд орлогын бүлэгт шилжин орсон байна), 48 дунд орлоготой улс (шинээр нэмэгдсэн дөрвөн улсаас гадна өмнө нь бага орлоготой улс байсан гурван орон нэмэгдэж орж ирсэн, харин өмнө нь дунд орлоготой улс байсан нэг орон өндөр орлогын бүлэгт шилжин орж эндээс хасагдсан байна), 34 өндөр орлоготой улс (шинээр нэг улс нэмэгдсэн, бас өмнө нь дунд орлоготой байсан нэг улс нэмэгдэж орж ирсэн) байна. Бидний төсөөлж байсанчлан, эдгээр бүлгийн хувьсагчуудад үзүүлж буй нөлөөний хэв маяг нилээд ялгаатай байгааг удахгүй харуулах болно.

Өрсөлдөх чадварын эх сурвалжууд

Бид өрсөлдөх чадварын ерөнхий индексийг гаргахын тулд нэг хүнд ноогдох ДНБ бүхий ойлголтын хүрээнд дэвшүүлсэн микро эдийн засгийн өрсөлдөх чадварын хэмжүүр бүрийнхээ статистик хамаарлыг юуны өмнө шалгаж үзсэн. Хувьсагчуудаа ерөнхийд нь компаний үйл ажиллагаа ба стратегийн боловсронгуй байдлыг хэмжих хувьсагчууд, үндэсний бизнесийн орчны чанарыг хэмжих хувьсагчууд гэсэн хоёр бүлэгт хуваан авч үзсэн. Хавсралт А-д Судалгааны асуултууд болон бэлэн байгаа тоон хэмжүүрүүдийн иж бүрэн жагсаалтыг харуулсан байгаа. Тухайн индексийг бий болгохын тулд цөөн тооны хэмжүүр авч үзэх нь статистикийн хувьд хангалттай гэж үзэв. Харин улс орон бүрийн давуу ба сул талуудын нарийвчилсан хэв шинж өөрөө тун сонирхолтой байдаг.

Хавсралт Б-д бүх хувьсагч ба нэг хүнд ноогдох ДНБ-ий хоорондын хоёр хувьсагчийн регрессийг харуулав. Уг хүснэгтэд бүх улс орон буюу бүлэг орны хэмжээгээр өгсөн хариултын дундаж, стандарт хазайлт, регрессийн хамаарлын налалтын өнцөг, тухайн хамаарлын статистик ач холбогдлын үзүүлэлт, мөн тохируулсан R^2 үзүүлэлтийг (тухайн хувьсагчаар тайлбарлагдах нэг хүнд ноогдох ДНБ-ий ялгааны хувь хэмжээг эрх чөлөөний статистик түвшингээр тохируулсан үзүүлэлт) оруулсан байгаа²⁰. Улс орнуудын нийт түүврийн хэмжээгээр авч үзсэн бүх хувьсагчууд статистикийн хувьд өндөр ач холбогдолтой гарсан байна²¹. Хоёр хувьсагчийн регрессээр тогтоосон загварыг бүхэлд нь төлөөлүүлэх гээгүй боловч тухайн хувьсагчууд улс орнуудын хэмжээгээр нэг хүнд ноогдох ДНБ-ий түвшинтэй утга төгөлдөр хамааралтай байгаа эсэхийг шалгах

нэг сорилт болох юм. Мөн нэг хүнд ноогдох ДНБ-тэй харьцуулсан хоёр хувьсагчийн корреляци нь шалтгаант холбоосыг зайлшгүй илэрхийлэх албагүй боловч микро эдийн засгийн хувьсагчууд ба хөгжил дэвшлийн хооронд ямар нэг чухал уялдаа холбоо огт байхгүй гэсэн таамаглалыг няцааж байгаа юм. Сонирхолтой нь хоёр хувьсагчийн регрессээр үзэхэд, ДНБ-д эзлэх үндэсний хуримтлалын хувь, хөрөнгө оруулалтын түвшин зэрэг макро эдийн засгийн алдартай хувьсагчуудын аль аль нь нэг хүнд ноогдох ДНБ-ий түвшинтэй ач холбогдолтой хэмжээнд холбоотой биш буюу түүний улс орнуудын хэмжээний вариацийн дөнгөж өчүүхэн хувьтай холбоотой байгаа нь харагдлаа²². Эдгээр олж мэдсэн зүйлс маань өмнө авч үзсэн *Дэлхий дахины өрсөлдөх чадварын тайлан*-гийн үр дүнтэй маш сайн тохирч байна.

Компаний хувьсагчдын дотроос үйлдвэрлэлийн үйл явцын боловсронгуй байдал, өрсөлдөөний давуу талын мөн чанар, ажилтнуудад зориулсан сургалтын цар хүрээ зэрэг үзүүлэлт нэг хүнд ноогдох ДНБ-ий үзүүлэлттэй хамгийн хүчтэй харилцан хамааралтай байна. Хямд орц эсвэл цорын ганц давтагдашгүй бүтээгдэхүүн, үйл явцад тулгуурласан аль нь ч бай, аливаа улсын компаниудын өрсөлдөөний давуу талын мөн чанарын үзүүлэлт өөрөө нэг хүнд ноогдох ДНБ-ий өөрчлөлтийн 69 хувийг тайлбарлаж байгаа нь гайхамшигтай байна.

Бизнесийн орчны дөрвөн бүрэлдэхүүн хэсэг дөрвүүлээ чухал болох нь нотлогдсон бөгөөд хувьсагч бүрийн үзүүлэх нөлөө өнгөрсөн жилийнхээс нилээд тогтвортой байв. Нөлөөлөгч хүчин зүйлсийн тоонд харилцаа холбооны хүртээмж (гар утас, интернет ашиглалт), улсын сургуулиудын чанар, дэд бүтцийн ерөнхий чанар, цахилгаан эрчим хүчний хангамжийн чанар, санхүүгийн зах зээлүүдийн чанар (зээл авахад хялбар дөхөм байдал, үйлдвэрлэлийн капиталын бэлэн байдал, санхүүгийн зах зээлийн боловсронгуй байдал) зэрэг үзүүлэлт орж байна.

Дотоодын эрэлтийн нөхцөл байдлын дотроос эрэлт хэрэгцээтэй зохицуулалтын стандартууд байгаа байдал, байгаль орчны хатуу зохицуулалтууд, мэдээллийн технологитой холбоотой хуулиудын чанар зэрэг үзүүлэлт нэг хүнд ноогдох ДНБ-ий өөрчлөлттэй хүчтэй хамааралтай байна. Эдгээр үр дүн нь дотоодын эрэлт ба дотоодын зах зээлийн нөхцөл байдал дэлхий дахины эдийн засагт ач холбогдол

Хүснэгт 1: Бизнесийн өрсөлдөх чадварын индексийн (БӨЧИ) зэрэглэл /үргэлжлэл/

Улс	БӨЧИ-н зэрэглэл								Компаний үйл ажиллагаа ба стратегийн зэрэглэл								Үндэсний бизнесийн орчны чанарын зэрэглэл								2004 оны нэг хүнд ноогдох ДНБ (ВХАЧ тооцсон)
	2005	2004	2003	2002	2001	2000	1999	1998	2005	2004	2003	2002	2001	2000	1999	1998	2005	2004	2003	2002	2001	2000	1999	1998	
Хорват	63	72	62	52	-	-	-	70	72	65	53	-	-	-	61	70	58	54	-	-	-	-	11,568		
Аргентин	64	74	69	65	54	45	40	34	52	68	63	57	53	45	39	30	64	78	73	68	53	44	40	34	12,468
Тринадад Тобаго	65	59	53	44	31	-	-	-	62	55	54	44	27	-	-	-	63	62	53	44	38	-	-	-	12,794
Пакистан	66	73	75	-	-	-	-	-	68	67	81	-	-	-	-	-	65	75	70	-	-	-	-	-	2,404
Румын	67	56	76	67	61	-	-	-	69	61	84	69	63	-	-	-	67	57	71	64	60	-	-	-	7,641
Кени	68	63	67	-	-	-	-	-	60	56	61	-	-	-	-	-	69	63	72	-	-	-	-	-	1,075
Филиппин	69	70	65	61	53	46	44	45	44	50	48	49	45	43	34	41	78	77	74	67	54	46	46	45	4,561
Уругвай	70	77	71	62	45	-	-	-	79	80	77	63	48	-	-	-	66	76	68	61	45	-	-	-	9,107
Египет	71	66	58	-	44	39	43	40	58	57	55	-	36	44	49	47	74	68	62	-	48	39	42	35	4,072
Шри Ланк	72	68	57	47	58	-	-	-	73	69	52	52	58	-	-	-	73	67	59	43	56	-	-	-	3,882
Намиби	73	51	55	51	-	-	-	-	75	63	64	58	-	-	-	-	72	51	52	49	-	-	-	-	6,449
ОХУ	74	61	66	58	56	52	55	46	77	62	69	62	54	33	42	45	70	60	64	56	55	53	55	47	10,179
Украин	75	69	73	69	59	56	56	52	71	64	72	66	62	52	50	51	76	71	77	69	57	56	56	52	6,554
Нигери	76	81	80	71	66	-	-	-	65	76	73	71	61	-	-	-	79	80	80	71	68	-	-	-	1,120
Азербайжан	77	-	-	-	-	-	-	-	74	-	-	-	-	-	-	-	80	-	-	-	-	-	-	-	3,968
Болгар	78	75	77	68	68	55	54	-	82	86	85	72	70	54	52	-	71	72	75	63	65	54	54	-	8,500
Марокко	79	46	49	48	-	-	-	-	80	45	49	50	-	-	-	-	75	45	49	46	-	-	-	-	4,227
Вьетнам	80	79	50	60	62	53	50	43	81	81	53	67	64	50	41	36	77	79	48	58	62	52	49	43	2,570
Перу	81	76	81	66	63	49	46	47	66	77	83	65	65	53	56	49	82	74	78	66	63	51	44	46	5,298
Танзани	82	90	68	-	-	-	-	-	93	92	68	-	-	-	-	-	81	87	67	-	-	-	-	-	673
Македон	83	83	82	-	-	-	-	-	89	84	79	-	-	-	-	-	83	82	83	-	-	-	-	-	7,237
Зимбабве	84	82	78	70	65	50	45	48	78	79	70	68	60	56	54	46	84	84	81	70	67	49	45	48	2,309
Уганда	85	-	-	-	-	-	-	-	91	-	-	-	-	-	-	-	87	-	-	-	-	-	-	-	1,728
Серб ба Монтенегро	86	85	79	-	-	-	-	-	108	87	75	-	-	-	-	-	86	81	79	-	-	-	-	-	4,858
Мали	87	-	-	-	-	-	-	-	109	-	-	-	-	-	-	-	85	-	-	-	-	-	-	-	1,024
Армян	88	-	-	-	-	-	-	-	87	-	-	-	-	-	-	-	90	-	-	-	-	-	-	-	3,806
Камерун	89	-	-	-	-	-	-	-	84	-	-	-	-	-	-	-	92	-	-	-	-	-	-	-	2,176
Гамби	90	67	70	-	-	-	-	-	100	70	80	-	-	-	-	-	89	66	66	-	-	-	-	-	1,903
Малави	91	84	72	-	-	-	-	-	86	83	71	-	-	-	-	-	93	85	76	-	-	-	-	-	569
Венесуэл	92	88	85	72	67	54	51	50	85	82	74	73	67	49	53	44	97	91	87	72	66	55	51	50	5,571
Молдав	93	-	-	-	-	-	-	-	90	-	-	-	-	-	-	-	94	-	-	-	-	-	-	-	2,119
Босни Герцеговин	94	93	-	-	-	-	-	-	101	96	-	-	-	-	-	-	91	92	-	-	-	-	-	-	5,504
Алжир	95	89	88	-	-	-	-	-	111	93	93	-	-	-	-	-	88	86	86	-	-	-	-	-	6,722
Гүрж	96	92	-	-	-	-	-	-	94	83	-	-	-	-	-	-	95	93	-	-	-	-	-	-	2,774
Мадагскар	97	87	90	-	-	-	-	-	102	88	88	-	-	-	-	-	96	88	90	-	-	-	-	-	854
Мозамбик	98	96	93	-	-	-	-	-	97	94	90	-	-	-	-	-	99	98	95	-	-	-	-	-	1,247
Бенин	99	-	-	-	-	-	-	-	106	-	-	-	-	-	-	-	98	-	-	-	-	-	-	-	1,094
Бангладеш	100	95	91	74	73	-	-	-	99	97	91	76	72	-	-	-	101	94	91	74	73	-	-	-	1,875
БН Доминикан Улс	101	80	61	41	60	-	-	-	88	74	57	30	59	-	-	-	103	83	63	53	61	-	-	-	6,761
Тажикстан	102	-	-	-	-	-	-	-	107	-	-	-	-	-	-	-	100	-	-	-	-	-	-	-	1,246
Гватемал	103	86	86	73	69	-	-	-	83	78	76	70	69	-	-	-	104	90	88	73	69	-	-	-	4,009
Монгол	104	-	-	-	-	-	-	-	98	-	-	-	-	-	-	-	102	-	-	-	-	-	-	-	1,918
Гондурас	105	97	95	78	74	-	-	-	95	91	89	78	74	-	-	-	105	100	96	79	75	-	-	-	2,682
Никарагуа	106	100	94	75	71	-	-	-	110	100	92	75	73	-	-	-	106	99	93	76	70	-	-	-	2,677
Эквадор	107	94	89	77	72	57	57	-	96	90	87	74	71	55	57	-	108	95	92	77	72	58	57	-	3,819
БН Киргиз Улс	108	-	-	-	-	-	-	-	92	-	-	-	-	-	-	-	111	-	-	-	-	-	-	-	1,934
Камбож	109	-	-	-	-	-	-	-	103	-	-	-	-	-	-	-	107	-	-	-	-	-	-	-	2,074
Гайана	110	-	-	-	-	-	-	-	105	-	-	-	-	-	-	-	109	-	-	-	-	-	-	-	4,579
Этиоп	111	99	96	-	-	-	-	-	113	101	96	-	-	-	-	-	110	97	94	-	-	-	-	-	814
Албани	112	-	-	-	-	-	-	-	104	-	-	-	-	-	-	-	113	-	-	-	-	-	-	-	4,937
Болив	113	101	98	79	75	58	58	-	115	99	97	79	75	58	58	-	112	101	97	78	74	57	58	-	2,902
Парагвай	114	98	97	76	70	-	-	-	112	98	95	77	68	-	-	-	114	96	98	75	71	-	-	-	4,553
Зүүн Тимор	115	-	-	-	-	-	-	-	114	-	-	-	-	-	-	-	115	-	-	-	-	-	-	-	байхгүй
Чад	116	-	-	-	-	-	-	-	116	-	-	-	-	-	-	-	116	-	-	-	-	-	-	-	1,555

Тэмдэглэл:

Ирланд улсын хувьд УНО-ийн үзүүлэлтийг ашиглав.

Тод налууугаар бичсэн орнууд тоон үзүүлэлтийн нийцтэй байдлын сорилтод тэнцээгүй бөгөөд цаашдын шинжилгээнд оруулаагүй болно.

багатай гэсэн тогтсон ойлголтыг няцааж байна.

Бүлэглэлүүдийн холбоо сүлбээ, ялангуяа дотоодын нийлүүлэгчдийн чанар, дотоодын төрөлжсөн сургалт, судалгааны газрууд байгаа байдал зэрэг нь ач холбогдолтойгоо нотлон харуулахын зэрэгцээ өрсөлдөх чадварт бүлэглэлүүдийн гүйцэтгэх үүргийг онцлон харуулж байна. Эцэст нь, дотоодын өрсөлдөөн өрнүүлэх сонирхол, түүнийг удирдах дүрэм журам үндэсний бүтээмжтэй хүчтэй холбоотой нь харагдаж байна. Мөн тодорхой хэмжээнд нөлөөлөх чадвартай хувьсагчуудын тоонд оюуны өмчийн үр нөлөөтэй хамгаалалт, хууль бус буюу шударга бус үйл ажиллагаа (авилгал) байхгүй байдал, монополийн эсрэг бодлогын үр нөлөөтэй байдал зэрэг үзүүлэлт орж байна. Дотоодын өрсөлдөөний эрчимтэй байдал нэг хүнд ноогдох ДНБ-ий үзүүлэлттэй бөгөөд эерэг хамааралтай байсан төдийгүй улс орнуудын хэмжээний нэг хүнд ноогдох ДНБ-ий өөрчлөлтийн 50 хувийг дангаараа тайлбарлаж байна. Сүүлийн үеийн бусад судалгаанд харуулсанчлан²³, дотоодын өрсөлдөөн хүчтэй нөлөөтэй байгаа нь үндэсний аваргууд бий болгохыг дэмжихийн тулд дотоодын өрсөлдөөнийг хазаарлах хэрэгтэй гэсэн мэтгэлцээнд хариу болж байна.

Зарим хувьсагчийн хувьд шалтгаант холбоос аль аль чиглэлд үйлчилж болно гэдгийг хүлээн зөвшөөрөх нь чухал боловч үндэслэл муутай эсрэг шалтгаант холбоос үүсгэхээс зайлсхийх байдлаар Судалгааны асуултуудын үг хэллэгийг гаргасан байгаа. Тухайлбал эрдэмтэд, инженерүүдийн чанар эсвэл худалдан авагчдын боловсронгуй байдал зэрэг үзүүлэлт нь зарим талаар нэг хүнд ноогдох ДНБ өндөр байх шалтгаан бус, харин уг үзүүлэлт өндөр байсны үр дүн байж болох юм. Иймэрхүү шалтгаан холбоосын асуудал макро эдийн засгийн болон эдийн засгийн өсөлтийн шинжилгээнд ч мөн адил гарч болохыг анхаараарай. Микро эдийн засгийн нөхцөл байдлаас нэг хүнд ноогдох ДНБ-д үзүүлэх нөлөөний шалтгаант холбоосын тухай зарим нотолгоог бид энэхүү бүлэгтээ мөн оруулах болно.

Өрсөлдөх чадвар ба эдийн засгийн хөгжил

Өмнө нь ярьж байсанчлан, компанийн зохих стратеги, үйл ажиллагааны практик, түүнчлэн бизнесийн орчны тодорхой элементүүдийн үзүүлэх нөлөө хөгжлийн өөр өөр түвшинд яваа орнуудын хувьд харилцан адилгүй байх болно.

Мөн дээр дурдсанчлан, өрсөлдөөнд хөгжлийн огт өөр үе шатанд шилжин орох шилжилтийн үйл явц өөрөө онцгой хүнд сорилт байдаг.

Эдгээр асуудлыг авч үзэх үүднээс нэг хүнд ноогдох ДНБ-ий түвшинд тулгуурласан гурван бүлэг улс оронд микро эдийн засгийн өрсөлдөх чадварын үзүүлэлтүүд хэрхэн нөлөө үзүүлж байгааг судлалаа. Сонгож авсан хувьсагчууд маань нийт түүврийн хэмжээгээр статистикийн хувьд ач холбогдолтой байсан бөгөөд өөр бүлгийн орнууд хоорондоо хүчтэй ялгарч байсны зэрэгцээ урьдаас төсөөлж байсанчлан, хувьсагч бүрийн хувьд тухайн бүлэг бүрт үзүүлэх нөлөө харилцан адилгүй гарч байна. Бага орлогтой орнуудын хувьд зарим хувьсагчууд хараахан ач холбогдолтой бус байна. Бусад хувьсагчийн хувьд аливаа орны хүрэх ёстой босго хэмжээний хүрээнд үйлчилсэн атлаа энэ босгоос цааш орлогын өөрчлөлтийг тайлбарлаж чадахаа больж байна.

Хавсралт Б-ийн баруун талд орлогын дэд бүлгүүдийн регрессийг харуулав. Бид судалгааны хариултуудын дунджийн ялгаа, налалтын өнцгийн ялгаа, түүнчлэн хувьсагч бүрийн статистик ач холбогдлын хэв шинжийг судалсан бөгөөд ингэхдээ дэд бүлэг бүрийн түүврийн хэмжээний хязгаарлалтуудыг болон дэд бүлгүүдийн статистик хүчин чадал буурахад түүнээс хамаарах үр дүнгийн хувьсагчийн вариаци улам бүр хязгаарлагдмал болдгийг урьдаас анхаарч харгалзсан байгаа.

Бага болон өндөр орлоготой орнуудыг харьцуулахад бүх хувьсагчийн хувьд судалгааны хариултуудын дундаж ихсэж байгаа нь анзаарагдаж байна. Энэ нь эдийн засгийн хөгжил бол бизнесийн орчин ба компанийн зан байдлын олон асуудлын хүрээнд хийгдэх сайжруулалттай холбоотой болохыг нотолж байна. Харин тодорхой хувьсагчуудын харьцангуй ач холбогдол, сайжруулалтын зам мөрийн хувьд орлогын бүлгүүдийн хооронд онцгой ялгаатай байна.

Бага орлоготой орнууд

Хүчин зүйлсэд чиглэсэн хөгжлийн шатанд яваа бага орлоготой улсуудын хувьд дан ганц хямд ажиллах хүч эсвэл байгалийн баялагт тулгуурласан өрсөлдөөнөөс цааш гарах чадвар маш чухал болохыг регрессүүдэд тусган харуулсан байна. Үйлдвэрлэлийн үйл явцын боловсронгуй байдал, үнэт зүйлсийн гинжин хэлхээнд орсон байдал гэх мэт компанийн онцлог шинжүүд ч нэг хүнд ноогдох ДНБ-тэй хүчтэй хамааралтай байна. Бизнесийн орчныг тойрсон

асар их хүндрэл бэрхшээл тэдэнд учирдагтай холбоотойгоор компаний үйл ажиллагааны бусад хэмжээс ач холбогдол багатай болох нь нотлогдож байна.

Регрессийн дүнгээс үзэхэд, бага орлоготой улсуудад бизнесийн орчныг сайжруулахад чиглэсэн тэргүүлэх чиглэлүүд нь дэд бүтцийн чанарын сул талуудаа сайжруулах (цахилгаан эрчим хүч, харилцаа холбоо, тээврийн сүлжээ гэх мэт), сургуулиудын чанарыг сайжруулах явдал байна. Хөгжлийн энэ шатанд зохицуулалтын стандартыг шинэчлэх гэх мэт бизнесийн орчны илүү нарийн түвэгтэй хэмжээсүүд хараахан тэргүүлэх чиглэл болж чадахгүй байна.

Дунд орлоготой орнууд

Хөрөнгө оруулалтад чиглэсэн хөгжлийн шатанд яваа дунд орлоготой орнуудын хувьд гол тулгамдсан асуудлууд бол орцын ашиглалтын талаар амжилттай хөгжиж, хүчин зүйлсийн орцын нөөц бүрдүүлэхэд хөрөнгө оруулж байгаа хөгжилтэй орнуудын загварт тулгуурлан бүтээмжээ дээшлүүлэх явдал юм. Компаний үйл ажиллагааны чиглэл дотроос үйлдвэрлэлийн үйл явцын боловсронгуй байдлыг үргэлжлүүлэн дээшлүүлэх, мэргэжлийн удирдлагыг сайжруулах асуудал бизнесийн хамгийн чухал хүчин зүйлс бөгөөд амжилттай хөгжиж буй дунд орлоготой орнуудыг амжилт багатайгаас нь ялгах гол шалгуур болж байна. Мөн дунд орлоготой орнуудын хувьд маркетингийн чанарыг сайжруулах, ажилтнуудын сургалтад хөрөнгө оруулах, экспортын бааз сууриа өргөжүүлэх явдал бизнесийн чухал тэргүүлэх чиглэл болохыг судалгааны тоон үзүүлэлтүүд харуулж байна.

Тоон үзүүлэлтээс үзэхэд бизнесийн орчны хувьд дунд орлоготой улсууд улсын сургуулиудын чанарыг цаашид сайжруулахын зэрэгцээ харилцаа холбооны дэд бүтцийн чанарыг дээшлүүлэх, интернэтийн ашиглалтыг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Эдгээр тэргүүлэх чиглэлд бага орлоготой үе шатанд ч хэдийн чухлаар тавигдах болжээ. Мөн манай шинжилгээний үр дүнгээс үзэхэд, өмнөх шатанд холбогдол багатай байсан бизнесийн орчны шинэ тулгамдсан асуудлууд болох их дээд сургууль ба үйлдвэрлэлийн салбарын хоорондын судалгаа шинжилгээний хамтын ажиллагааг сайжруулах, судалгааны хүрээлэнгүүдийн чанарыг дээшлүүлэх, шүүхийн системийг бэхжүүлэх зэрэг асуудал нь дунд орлоготой орнуудын амжилтад чухал

ялгаа үүсгэгч хүчин зүйлс болоод байна. Мөн дунд орлоготой орнуудын түвшинд бүтээгдэхүүний чанарыг сайжруулах шахалт үзүүлэхэд дотоодын эрэлтийн нөхцөл байдлыг, тухайлбал байгаль орчны болон хэрэглэгчийн эрх ашгийн хамгаалалтын илүү чанга хуулиуд гаргах замаар, сайжруулах явдал шаардлагатай байна. Бүлэглэл бий болгож хөгжүүлэх явдлыг бүхий л талаар бэхжүүлэх нь дунд орлоготой орнуудын түвшинд чухал ач холбогдолтой болж байгаа бөгөөд ялангуяа нийлүүлэгчдийн бааз суурийг өргөтгөх, төрөлжсөн судалгаа, сургалтын хүрээлэнгүүдийн хангамжийг сайжруулах асуудал чухал байна. Эцэст нь, дунд орлоготой орнуудын хувьд өрсөлдөөнийг нэмэгдүүлэх асуудал, түүний дотор тарифийн болон тарифийн бус саад бэрхшээлийг арилгаж либеральчлах, монополийн эсрэг бодлогыг бэхжүүлэх, бизнесийн хяналттайгаар зах зээлийг нээлттэй болгох явдал онц чухал байна.

Өндөр орлоготой орнууд

Өндөр орлоготой орны хувьд амжилт үзүүлэхийн тулд чанарын болон үр ашгийн сайжруулалтыг өөр байршлыг ашиглан олж авах явдал хангалтгүй болжээ. Гол бэрхшээл бол шинийг санаачлалтад чиглэсэн үе шатанд шилжих асуудал юм. Шинэ санаачлагын өндөр түвшинд хүрнэ гэдэг бол зөвхөн компаниудын судалгаа, хөгжлийн ажилд зарцуулах хөрөнгийн асуудал биш болох нь манай регрессээс харагдаж байна. Энэ нь бас ажлын уян хатан зохион байгуулалт, эрх мэдлийн төлөөлүүлэлтийг маркетингийн боловсронгуй байдал, дэвшилтэт үйлдвэрлэлийн үйл явцтай хослуулан ашиглаж, технологийн дэвшлийг шинэ сонин бүтээгдэхүүн үйлчилгээ болгон хувиргах чадвартай нягт холбоотой. Судалгаа шинжилгээтэй холбоотой хүрээлэнгүүдийн чанар, судалгааны хүрээлэнгүүдтэй хамтран ажиллахад хялбар дөхөм байдал нь хамгийн амжилттай яваа өндөр хөгжилтэй орнуудын чухал давуу талууд болж байна.

Бүх өндөр орлоготой орнууд бизнесийн орчны олон асуудлаар давуу талтай болоод байна. Гэхдээ хамгийн өндөр амжилт үзүүлсэн өндөр орлоготой орнуудыг тус бүлгийн арай сул орнуудаас нь ялгах бизнесийн орчны зарим чиглэлүүдийг, тухайлбал хүнд суртлын хэт их зохицуулалт, корпорацийн засаглалын чанар, хөдөлмөрийн зах зээлийн уян хатан байдал болон гадаадын хөрөнгө оруулалт ба дотоодын өрсөлдөөнд учирч буй бусад саад тотгоруудыг

олж тогтоогоод байна. Зохицуулалтын хатуу чанд байдал, улсын салбарын байгууллагуудын үр ашгийг үргэлжлүүлэн сайжруулах явдал ч өндөр орлоготой орнуудын амжилтад чухал хэвээр байна. Амжилттай хөгжиж яваа өндөр орлоготой орнуудын бусад ялгарах онцлогт санхүүгийн зах зээлийн чанар (ялангуяа үнэт цаасны болон үйлдвэрлэлийн капитал олж авах боломж), бүлэглэлийн хөгжлийн гүн гүнзгий байдал (ялангуяа, дотоодын нийлүүлэгчдийн сайжралт), менежментийн боловсрол ба бизнестэй холбоотой судалгааны чанар зэрэг үзүүлэлт орж байна.

Дэлхийн эдийн засаг дахь өрсөлдөх чадварын чиг хандлагууд

Бидэнд 1998 оноос хойшхи зарим хэмжүүрийн тоон үзүүлэлтүүд байгаа учраас, өрсөлдөх чадварын эрч хүч цаг хугацааны хувьд хэрхэн өөрчлөгдөж байгааг шинжилж үзэхэд сонирхолтой байдаг (Хүснэгт 2-ыг үзнэ үү). 1998-2001 оны хугацаанд бүх асуултад өгсөн хариултуудын дундаж (асуултуудын бүтэц, улс орнуудын түүврийг тогтмол байлгахад) өндөр орлоготой орнуудад хамгийн хүчтэй өссөн бол дунд ба бага орлоготой орнуудад арай бага хэмжээгээр өссөн байна. 2001 онд эдийн засгийн хүндрэлийн үе эхэлснээр бүх орлогын бүлгийн орнуудын хариултын дундаж бараг ижилхэн үнэмлэхүй дүнгээр буурч, бага ба дунд орлоготой орнуудын хувьд 1998 оны хариултын үнэмлэхүй түвшнээс ч буурсан юм. 2002-2005 онд бүх орлогын бүлгүүдийн хариултын дундаж өссөн байна. Гэхдээ бага орлоготой орнууд хамгийн их (үнэмлэхүй ба харьцангуй дүнгийн аль алианаар), дараа нь дунд орлоготой орнууд, түүний дараа өндөр орлоготой орнууд сайжирсан дүн гарсан байна.

1998-2005 оны үеийг бүхэлд нь авч үзэх юм бол, бага орлоготой орнууд хүчин зүйлсийн нөхцөл байдлын чиглэлээс бусад үзүүлэлтээр дунд орлоготой орнуудаас хоцорсон зайгаа багасгаж чадсан байна. Мөн дунд орлоготой орнууд өндөр орлоготой орнуудтай харьцуулахад ялангуяа компаний үйл ажиллагаа, стратегийн чиглэлд байр сууриа алдсан байна. Манай тоон үзүүлэлтүүдээс үзэхэд, дунд орлоготой эдийн засгийн нөхцлийг бүрдүүлэх боломж олон орны хувьд ойрхон байна, харин өндөр орлоготой эдийн засгийн үндэс суурийг тавих асуудал хамаагүй хүнд хэцүү байгаа мэт харагдаж байна.

Өрсөлдөх чадварын зэрэглэл тогтоох нь


Ерөнхий Бизнесийн өрсөлдөх чадварын индексийг (БӨЧИ) бий болгохын тулд бид компаний үйл ажиллагаа, стратегийн боловсронгуй байдал ба үндэсний бизнесийн орчны чанарыг хэмжих дэд индексүүдийг тооцон гаргасан. Уг хоёр дэд индексийг жигнэсэн дунджийг бид БӨЧИ гэж тодорхойлсон юм. Хувийн жингүүдийг дэд индексүүд ба нэг хүнд ноогдох ДНБ-ий олон хувьсагчийн регрессийн коэффициентээр тодорхойлсон бөгөөд ингэхдээ жилээс жилд гарах өөрчлөлтийг тэгшгэх үүднээс 2002-2005 оны тоон үзүүлэлтийг нэгтгэсэн үзүүлэлт ашигласан. Энэхүү ажиллагааны дүнд үндэсний бизнесийн орчинд 0.8, компаний үйл ажиллагаа, стратегид 0.2 гэсэн хувийн жин тус тус өгсөн нь өмнөх жилийнхтэй ойролцоо байна. Бизнесийн орчны хүчин зүйлсийн бүлэг нь компаний хүчин зүйлсээ бодвол улс орнуудын өрсөлдөх чадварын зөрүүтэй байдлыг илүү ялган харуулж байгаа нь эндээс харагдаж байна. Магадгүй энэ нь, компаниуд голдуу олон газар үйл ажиллагаагаа явуулж, улмаар тэргүүн туршлага дэлгэрэхэд хялбар болдогтой холбож үзвэл гайхах зүйл биш байж болох юм. Түүнчлэн компаниудын тэргүүн туршлагыг дэлгэрүүлэх бусад механизм байхын зэрэгцээ дотоодын улс төрд ч бизнесийн орчны нөхцлүүдийг улам бүр анхаардаг болоод байна.

Бизнесийн орчны дэд индекс ба компаний үйл ажиллагааны дэд индексийн хоорондын корреляцийн хамаарал эерэг байгаа нь өрсөлдөх чадварын энэ хоёр чиглэлд хийсэн сайжруулалтууд хамт явагдаж байгааг харуулж байна. Харин бид бизнесийн орчны болон компаний үйл ажиллагаа, стратегийн дэд индексүүдийн нэг хүнд ноогдох ДНБ-ий регрессд харилцан хамаарлын нөхцөл оруулахад эерэг бөгөөд ач холбогдолтой хамааралтай байгаа нь нотлогдож байна. Энэ нь, дотоодын компаний үйл ажиллагаа, стратегийн боловсронгуй байдал дээшлэхэд хөгжил дэвшилд чиглэсэн илүү сайн бизнесийн орчны үр өгөөж дээшилж байна, мөн бизнесийн орчин сайжрахад компаний боловсронгуй байдал дээшилж байна гэсэн үг. Бизнесийн орчин, компаний боловсронгуй байдлаа хоёуланг нь зэрэг сайжруулж буй орнууд хамаагүй их үр шим хүртэж байхад тэдгээрийг тэнцвэргүй хөгжүүлсэн орнууд хамаагүй их зардал гаргаж байна.

Хүснэгт 2: Цаг хугацааны туршид өгсөн дундаж хариултууд (үлс орнууд ба асуултуудын тогтмол түүврээр)

	Бага орлоготой орнууд				Дунд орлоготой орнууд				Өндөр орлоготой орнууд			
	1998	2001	2002	2005	1998	2001	2002	2005	1998	2001	2002	2005
I. КОМПАНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА БА СТРАТЕГИ												
Олон улсын зах зээлийн хамрах хүрээ	4.54	3.57	3.42	3.84	4.90	5.41	3.70	4.15	5.33	5.41	5.29	5.49
Шинийг санаачлах чадавхи	3.34	3.07	2.82	3.28	3.54	4.86	3.14	3.40	4.98	4.86	4.82	5.03
Олон улсын түгээлтийн хяналт	3.64	3.57	3.37	3.84	3.94	4.71	3.77	4.09	4.99	4.71	4.64	4.84
Хэрэглэгчид хандсан байдлын түвшин	3.91	4.51	4.03	4.34	4.20	5.54	4.35	4.65	5.08	5.54	5.42	5.56
Маркетингийн цар хүрээ	3.46	3.91	3.77	4.19	4.05	5.65	4.27	4.62	4.89	5.65	5.45	5.62
Бүс нутгийн борлуулалтын цар хүрээ	3.76	4.48	4.31	4.47	4.46	5.83	4.63	4.92	5.34	5.83	5.68	5.72
Ажилтнуудад зориулсан сургалтын цар хүрээ	3.54	3.70	3.45	3.81	3.74	5.20	3.66	3.82	4.8	5.20	5.08	5.15
Өрсөлдөөний давуу талын мөн чанар	2.37	2.67	2.52	2.83	2.98	5.16	3.08	3.07	4.9	5.16	4.89	5.15
Гадаадын технологийн лицензийн эрх зонхилох байдал	4.61	5.02	4.85	4.35	4.67	5.29	4.70	4.56	5.08	5.29	5.03	5.21
Үйлдвэрлэлийн үйл явцын боловсронгуй байдал	3.41	3.72	2.82	3.17	3.99	5.73	3.53	3.82	5.41	5.73	5.34	5.45
Мэргэжлийн удирдлагад найдах байдал	3.65	4.36	4.43	4.66	3.80	5.44	4.46	4.64	4.7	5.44	5.64	5.63
Үнэт зүйлийн гинжин хэлхээ байгаа байдал	4.49	3.29	3.06	3.43	4.76	5.17	3.33	3.64	5.42	5.17	5.25	5.45
II. ҮНДЭСНИЙ БИЗНЕСИЙН ОРЧИН												
A. ХУЧИН ЗҮЙЛСИЙН (ОРЦЫН) НӨХЦӨЛ БАЙДАЛ												
1. Биет дэд бүтэц												
Дэд бүтцийн ерөнхий чанар	2.95	2.75	3.02	3.06	3.20	5.74	3.63	3.72	4.88	5.74	5.66	5.68
Төмөр замын дэд бүтцийн хөгжил	3.60	3.54	3.34	3.09	2.60	5.00	2.98	2.94	4.49	5.00	4.85	4.92
Боомтын дэд бүтцийн чанар	3.15	2.90	2.69	2.87	3.42	5.56	3.60	3.57	5.14	5.56	5.44	5.43
Агаарын тээврийн дэд бүтцийн чанар	3.90	3.73	3.96	3.86	4.04	5.95	4.39	4.53	5.67	5.95	5.80	5.87
Телефон, факсын дэд бүтцийн чанар	4.57	4.17	4.43	4.84	5.24	6.54	5.48	5.79	6.51	6.54	6.58	6.55
2. Захиргааны дэд бүтэц												
Цагдаагийн үйлчилгээний найдвартай байдал	3.93	3.47	3.24	3.90	3.37	5.79	3.73	3.79	5.57	5.79	5.57	5.50
Шүүхийн хараат бус байдал	4.94	3.60	3.22	3.51	4.02	5.78	3.43	3.38	5.79	5.78	5.50	5.35
Эрх зүйн хүрээний үр ашигтай байдал	4.46	4.00	3.19	3.46	4.17	5.75	3.36	3.50	5.53	5.75	5.27	5.17
Хүнд суртлын зохицуулалтуудын цар хүрээ	2.93	5.75	4.91	5.27	3.60	6.26	5.37	5.27	4.24	6.26	5.69	5.72
3. Хүний нөөц												
Менежментийн сургуулиудын чанар	3.85	3.91	3.87	4.03	4.17	5.37	4.27	4.46	4.92	5.37	5.20	5.33
Улсын сургуулиудын чанар	3.76	2.83	2.65	2.92	3.88	5.65	3.33	3.41	5.11	5.65	5.49	5.40
Математик, шинжлэх ухааны боловсролын чанар	3.85	3.91	3.87	4.03	4.17	5.37	4.27	4.46	4.92	5.37	5.20	5.33
4. Технологийн дэд бүтэц												
Шинжлэх ухааны судалгааны хүрээлэнгүүдийн чанар	3.09	4.21	4.02	3.95	3.46	5.53	3.94	3.88	4.83	5.53	5.14	5.13
ИДС ба үйлдвэрлэлийн судалгааны хамтын ажиллагаа	3.12	3.52	3.24	3.06	3.36	4.88	3.33	3.30	4.59	4.88	4.56	4.46
5. Капиталын зах зээл												
Санхүүгийн зах зээлийн боловсронгуй байдал	2.72	3.33	3.40	3.86	3.37	5.37	3.80	4.27	4.81	5.37	5.18	5.57
Үйлдвэрлэлийн капиталын бэлэн байдал	3.49	2.89	2.87	3.37	3.30	4.61	2.75	3.02	4.30	4.61	4.31	4.52
Дотоодын хөрөнгийн зах зээлд нэвтрэх боломж	4.74	5.19	5.08	5.69	4.55	5.95	4.31	4.98	5.67	5.95	5.64	5.91
Б. ЭРЭЛТИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ												
Худалдан авагчдын боловсронгуй байдал	3.84	3.99	3.82	4.34	3.93	5.33	3.67	4.09	5.50	5.33	5.31	5.51
В. ХОЛБОГДОХ БА ДЭМЖИХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРУУД												
Дотоодын нийлүүлэгчдийн чанар	3.54	4.15	4.09	4.10	3.95	5.57	5.26	4.55	5.31	5.57	5.55	5.70
Дотоодын нийлүүлэгчдийн тоо хэмжээ	4.42	4.94	4.78	4.74	4.71	5.63	4.63	4.98	5.69	5.63	5.45	5.67
Г. КОМПАНИЙ СТРАТЕГИ БА ӨРСӨЛДӨӨНИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ												
1. Урамшуулал												
Төрийн албан тушаалтнуудын шийдвэрт тал тохой татах байдал	2.93	2.73	2.62	3.03	3.14	4.35	2.95	2.88	3.88	4.35	4.22	4.17
Компаниудын удирдах зөвлөлийн үр ашигтай байдал	3.46	3.75	3.63	4.51	3.82	4.73	3.89	4.64	4.44	4.73	4.50	5.25
Оюуны өмчийн хамгаалалт	3.34	2.58	2.78	3.27	3.76	5.52	3.40	3.48	5.49	5.52	5.37	5.37
2. Өрсөлдөөн												
Дотоодын өрсөлдөөний эрчим	4.78	5.02	4.64	4.66	4.88	5.62	4.73	4.97	5.36	5.62	5.30	5.58
Монополийн эсрэг бодлогын үр нөлөө	3.47	3.48	3.55	3.65	3.89	5.34	3.82	4.10	5.00	5.34	5.07	5.36
Худалдааны саад тотгорууд зонхилох байдал	3.32	4.28	4.61	3.98	4.37	6.18	4.99	4.54	5.69	6.18	6.10	5.38

Бүдүүвч 7: БӨЧИ-ийн зэрэглэл ба оноо, улсаар



БӨЧИ-ийн зэрэглэл

Хүснэгт 3: Судалгааны хариултууд ба БӨЧИ-ийн онооны өөрчлөлтийн задаргаа

	Өөрчлөлт		Өөрчлөлт		ҮБӨ-ны ромбын бүрэлдэхүүн хэсгүүдийн өөрчлөлт				
	БӨЧИ байр	БӨЧИ оноо	КҮАС оноо	ҮБӨ оноо	ХЗНБ дундаж оноо	ЭНБ дундаж оноо	ХДҮС дундаж оноо	КСӨНБ дундаж оноо	Орлогын бүлэг
ҮНЭМЛЭХҮЙ									
Бүх 110 орон	бхгүй	0.132	0.026	0.106	0.054	0.015	0.013	0.024	
Өндөр орлоготой	бхгүй	0.161	0.031	0.130	0.067	0.018	0.012	0.034	
Дунд орлоготой	бхгүй	0.092	0.021	0.072	0.036	0.011	0.010	0.015	
Бага орлоготой	бхгүй	0.174	0.028	0.145	0.074	0.020	0.022	0.030	
ОРЛОГЫН БҮЛЭГТЭЙ ХАРЬЦАНГҮЙ									
Гана	19	0.291	0.052	0.238	0.175	0.029	0.022	0.012	Бага
Польш	14	0.449	0.038	0.411	0.181	0.039	0.027	0.163	Дунд
Аргентин	10	0.280	0.048	0.232	0.089	0.040	0.042	0.062	Дунд
Ботсвани	9	0.061	0.009	0.052	0.051	-0.008	-0.013	0.022	Дунд
Хорват	9	0.206	0.031	0.175	0.074	0.030	0.003	0.068	Дунд
Эль Сальвадор	9	0.164	0.024	0.141	0.064	0.031	0.011	0.034	Дунд
Танзани	9	0.245	0.015	0.230	0.110	0.030	0.027	0.061	Бага
Кипр	8	0.215	0.043	0.172	0.042	0.043	0.031	0.056	Өндөр
БН Чех Улс	7	0.285	0.039	0.246	0.091	0.032	0.018	0.104	Өндөр
Унгар	7	0.249	0.053	0.195	0.078	0.020	0.007	0.091	Дунд
Пакистан	7	0.239	-0.004	0.243	0.130	-0.002	0.013	0.101	Бага
Уругвай	7	0.134	0.015	0.119	0.065	-0.001	0.018	0.037	Дунд
Австри	6	0.150	0.053	0.097	0.024	0.010	0.008	0.056	Өндөр
Босни Герцеговин	5	0.114	0.040	0.074	0.048	-0.014	-0.005	0.046	Дунд
Сингапур	5	0.103	0.005	0.098	0.035	0.003	0.018	0.042	Өндөр
Колумби	4	0.127	0.028	0.099	0.038	0.010	-0.008	0.059	Дунд
Мальт	4	-0.007	-0.013	0.006	-0.016	0.003	0.002	0.017	Өндөр
Мозамбик	4	0.130	0.028	0.103	0.021	0.028	0.021	0.033	Бага
Дани	3	0.027	0.031	-0.004	-0.021	0.009	0.014	-0.007	Өндөр
Ирланд	3	0.232	0.056	0.176	0.079	0.008	0.005	0.084	Өндөр
Никарагуа	3	0.033	0.021	0.012	0.017	-0.007	0.002	0.000	Бага
Тайвань	3	0.070	0.010	0.060	0.060	0.015	-0.010	-0.005	Өндөр
Бангладеш	2	0.106	0.043	0.063	0.046	0.008	0.016	-0.006	Бага
Канад	2	0.007	-0.008	0.015	0.019	0.004	0.000	-0.008	Өндөр
Гүрж	2	0.038	-0.001	0.039	-0.005	0.003	-0.005	0.045	Бага
Исланд	2	-0.051	0.026	-0.076	-0.014	0.003	-0.022	-0.044	Өндөр
Ямайк	2	0.047	0.005	0.042	0.022	-0.015	-0.015	0.049	Дунд
Латви	2	0.050	0.005	0.045	0.024	0.011	-0.011	0.021	Дунд
Мавритани	2	0.122	0.039	0.083	0.017	0.013	0.023	0.029	Дунд
Филлиппин	2	0.168	0.040	0.128	0.025	0.027	0.040	0.035	Дунд
Португал	2	0.126	0.004	0.122	0.074	0.018	-0.006	0.035	Өндөр
Турк	2	0.195	0.036	0.159	0.077	0.030	0.011	0.040	Дунд
Венесуэл	2	-0.022	-0.023	0.001	-0.028	0.024	-0.004	0.009	Дунд
Алжир	1	-0.086	-0.052	-0.033	-0.008	0.004	0.002	-0.032	Дунд
Болив	1	-0.105	-0.035	-0.069	-0.032	-0.009	-0.004	-0.024	Бага
Эстони	1	-0.009	-0.001	-0.007	-0.009	-0.015	0.009	0.008	Дунд
Франц	1	0.031	-0.010	0.042	-0.011	0.003	0.013	0.037	Өндөр
Гондурас	1	0.085	0.009	0.076	0.054	0.004	0.009	0.008	Бага
Македон	1	-0.006	-0.019	0.013	0.071	-0.023	0.005	-0.039	Дунд
Панам	1	0.025	0.106	-0.081	-0.038	-0.013	0.015	-0.045	Дунд
Серб ба Монтенегро	1	-0.071	-0.067	-0.003	-0.056	0.032	0.015	0.006	Дунд
Испани	1	0.057	0.020	0.037	0.032	0.013	0.000	-0.008	Өндөр
Вьетнам	1	0.064	-0.005	0.069	0.052	0.013	0.012	-0.008	Бага
Болгар	0	0.032	0.006	0.026	0.046	0.002	0.002	-0.024	Дунд
Этиоп	0	-0.134	-0.012	-0.122	-0.058	-0.023	-0.027	-0.015	Бага
Финлянд	0	-0.104	-0.049	-0.055	-0.013	-0.022	-0.005	-0.015	Өндөр
Герман	0	-0.004	-0.017	0.013	0.018	-0.016	-0.001	0.011	Өндөр
Грек	0	-0.049	0.000	-0.050	-0.030	-0.007	-0.017	0.004	Өндөр
Япон	0	-0.048	-0.012	-0.036	0.003	-0.021	0.008	-0.027	Өндөр
БН Солонгос Улс	0	0.274	0.040	0.234	0.136	0.014	0.007	0.077	Өндөр
Малайз	0	0.288	0.072	0.216	0.115	0.032	0.008	0.061	Дунд
Нидерланд	0	-0.121	-0.047	-0.073	-0.039	-0.006	-0.004	-0.025	Өндөр
Шинэ Зеланд	0	-0.066	-0.007	-0.058	-0.051	0.004	-0.002	-0.010	Өндөр
БН Словак Улс	0	0.099	-0.019	0.028	-0.009	0.013	-0.006	0.030	Дунд
Тайланд	0	0.173	0.010	0.164	0.081	0.021	-0.003	0.065	Дунд

Хүснэгт 3: Судалгааны хариултууд ба БӨЧИ-ийн онооны өөрчлөлтийн задаргаа

	Өөрчлөлт		Өөрчлөлт		ҮБӨ-ны ромбын бүрэлдэхүүн хэсгүүдийн өөрчлөлт				
	БӨЧИ байр	БӨЧИ оноо	КҮАС оноо	ҮБӨ оноо	ХЗНБ дундаж оноо	ЭНБ дундаж оноо	ХДҮС дундаж оноо	КСӨНБ дундаж оноо	Орлогын бүлэг
	ОРЛОГЫН БҮЛЭГТЭЙ ХАРЬЦАНГУЙ								
Их Британи	0	-0.093	-0.005	-0.089	-0.024	-0.020	-0.001	-0.044	Өндөр
Америкийн Нэгдсэн Улс	0	0.030	0.011	0.020	0.028	0.003	-0.005	-0.007	Өндөр
Чили	-1	0.101	0.026	0.076	0.051	0.013	0.017	-0.005	Дунд
Коста Рика	-1	-0.058	0.012	-0.070	-0.042	0.005	-0.001	-0.031	Дунд
Израиль	-1	0.041	0.015	0.026	0.022	0.023	-0.001	-0.019	Өндөр
Иордан	-1	-0.058	-0.002	-0.057	-0.023	-0.015	-0.009	-0.009	Дунд
Малави	-1	-0.175	-0.020	-0.156	-0.100	-0.033	-0.006	-0.017	Бага
Норвеги	-1	-0.202	0.012	-0.214	-0.130	-0.018	0.004	-0.070	Өндөр
Зимбабве	-1	-0.026	0.002	-0.028	-0.007	0.028	-0.038	-0.011	Бага
Австрали	-2	-0.155	-0.051	-0.104	-0.043	-0.031	-0.008	-0.022	Өндөр
Бельги	-2	-0.077	-0.011	-0.066	0.008	-0.023	-0.016	-0.034	Өндөр
Энэтхэг	-2	0.100	0.029	0.072	0.020	0.016	-0.011	0.047	Бага
Кени	-2	-0.140	-0.016	-0.125	-0.090	0.019	0.009	-0.062	Бага
Перу	-2	0.067	0.050	0.018	-0.018	0.028	-0.005	0.013	Дунд
Словени	-2	-0.004	0.004	-0.008	-0.021	-0.003	0.013	0.003	Өндөр
Шри Ланк	-2	-0.110	-0.013	-0.097	-0.044	-0.008	0.026	-0.071	Бага
Швейцарь	-2	-0.152	-0.046	-0.106	0.010	-0.017	-0.016	-0.082	Өндөр
Мадагскар	-3	-0.175	-0.042	-0.134	-0.053	-0.027	-0.022	-0.031	Бага
Мексик	-3	-0.052	-0.021	-0.031	0.003	0.006	-0.011	-0.029	Дунд
Парагвай	-3	-0.214	-0.038	-0.177	-0.091	-0.016	-0.015	-0.055	Дунд
Өмнөд Африк	-3	-0.075	-0.003	-0.072	-0.025	-0.007	-0.004	-0.037	Дунд
Тринадад Тобаго	-3	-0.056	-0.026	-0.031	-0.044	-0.007	0.008	0.012	Дунд
Тунис	-3	-0.051	-0.001	-0.050	-0.014	-0.010	-0.023	-0.004	Дунд
Эквадор	-4	-0.131	0.007	-0.138	-0.055	-0.012	-0.022	-0.049	Бага
Итали	-4	0.077	0.017	0.059	0.004	0.029	-0.012	0.039	Өндөр
Украин	-4	0.029	-0.008	0.037	0.036	0.004	-0.025	0.022	Дунд
Литва	-5	-0.097	-0.015	-0.082	-0.021	-0.016	-0.008	-0.037	Дунд
Хятад	-8	-0.191	-0.045	-0.146	-0.062	-0.020	-0.017	-0.048	Дунд
Гватемал	-8	-0.196	-0.037	-0.159	-0.063	-0.016	-0.009	-0.070	Дунд
Румын	-8	-0.152	-0.021	-0.131	-0.059	-0.028	-0.004	-0.040	Дунд
Швед	-8	-0.347	-0.065	-0.282	-0.178	-0.035	-0.011	-0.059	Өндөр
Бразил	-9	-0.218	-0.023	-0.196	-0.117	-0.015	-0.016	-0.047	Дунд
Гонконг	-9	-0.244	-0.045	-0.199	-0.094	-0.021	-0.005	-0.079	Өндөр
Оросын Холбооны Улс	-9	-0.146	-0.047	-0.100	-0.032	-0.016	-0.018	-0.033	Дунд
БН Доминикан Улс	-12	-0.367	-0.063	-0.305	-0.122	-0.048	-0.024	-0.111	Дунд
Индонези	-13	-0.335	-0.059	-0.276	-0.181	-0.059	-0.023	-0.013	Бага
Намиби	-18	-0.347	-0.035	-0.312	-0.119	-0.048	0.007	-0.152	Дунд
Марокко	-27	-0.618	-0.126	-0.492	-0.257	-0.083	-0.016	-0.135	Дунд

Тайлбар: ХЗНБ = Хүчин зүйлсийн нөхцөл байдал, ЭНБ = Эрэлтийн нөхцөл байдал, ХДҮС = Холбогдох ба дэмжих үйлдвэрлэлийн салбарууд, КСӨНБ = Компаний стратеги ба өрсөлдөөний нөхцөл байдал

Бүдүүвч 6-д уг загварыг бий болгоход ашигласан 110 орны түүвэрт хамрагдсан улс бүрийн БӨЧИ-ийг оны нэг хүнд ноогдох ДНБ-ий худалдан авах чадварын түвшингээр тохируулсан 2004 оны үзүүлэлттэй харьцуулан дүрсэлсэн байна. Энд регрессийн шугамыг уг шугамаас дээш, доош 95 хувийн итгэлцэлтэй урьдчилан таамаглагдах бүсэд оршиж буй бүлэг улсуудын хамт дүрсэлсэн байна²⁴. Энэхүү урьдчилан таамаглагдах бүсээс гадуур гарсан тавхан орон байгаа нь Норвеги, Катар, Энэтхэг, Малайз, Итали улсууд байна. *Олон янзын бүлэг улсуудын хэмжээгээр тооцон гаргасан нэг хүнд ноогдох ДНБ-ий вариацийн 80 хувийг БӨЧИ-ийн ялгаагаар тайлбарлаж байгаа нь гайхамшигтай үр дүн юм.*

Уг регрестт БӨЧИ ба нэг хүнд ноогдох ДНБ-ий хооронд шугаман бус хамааралтай байх боломжийг бид олгож байна. Үүнд хамгийн сайн тохирох нь полином хэлбэр болох нь батлагдсан бөгөөд өндөр орлоготой орнуудад БӨЧИ сайжирсанаас нэг хүнд ноогдох ДНБ-д үзүүлэх нөлөө бага орлоготой орнуудынхаас хамаагүй их байгааг харуулж байна. Үүнийг хэд хэдэн эерэг байдлаар тайлбарлаж болно: Нэгдүгээрт, микро эдийн засгийн нөхцлүүдэд гарсан сайжралтууд эргээд эерэг үр нөлөө үзүүлнэ гэж төсөөлж болох юм. Өөрөөр хэлбэл, хэрвээ бизнесийн орчны бусад хэсгүүд хүчтэй байх юм бол уг орчны нэг хэсэгт гарсан сайжралт илүү их үр нөлөөтэй байна гэсэн үг. Энэ нь өмнө дурдсан бизнесийн орчин, компаний боловсронгуй байдал хоёр эерэг харилцан хамааралтай гэдэг дүгнэлттэй нийцэж байгаа юм. Хоёрдугаарт, бага орлоготой орнууд тодорхой хэмжээний микро эдийн засгийн сайжралтаас харьцангуй бага хэмжээний бүтээмжийн үр өгөөж хүртэж болох бөгөөд энэ нь тэдгээр улсын макро эдийн засаг, улс төр, хууль эрх зүй, нийгмийн нөхцөл байдлууд дахь сул талтай холбоотой.

Бид өөрсдийн загварыг улс орон бүрийн тоон үзүүлэлтийн хамт ашиглаж Бизнесийн өрсөлдөх чадварын индексийн оноог улс орон бүрээр тооцоолон гаргасан бөгөөд түүнийхээ дагуу улс орнуудын зэрэглэлийг тогтоож, байр эзлүүлсэн. Хүснэгт 1-д 2005 оны БӨЧИ-ийн ерөнхий зэрэглэлийг өмнөх жилүүдийн байгаа зэрэглэлүүдийн хамтаар үзүүлэв. Энд мөн дэд индекс тус бүрийн зэрэглэлийг оруулсан байгаа. БӨЧИ-ийн онооны үнэмлэхүй утгад өчүүхэн жижиг ялгаа гарахад уг зэрэглэлд өөрчлөлт орох учраас бид бас Бүдүүвч 7-д уг зэрэглэлд эзэлсэн байр ба БӨЧИ-ийн онооны хамаарлыг графикаар үзүүлэв. БӨЧИ-ийн оноо нь уг

зэрэглэлийн ихэнх хэсгийн эзлэх байрыг даган өөрчлөгдөж байна. Харин дунд орлоготойгоос өндөр орлоготой оронд шилжих 20-25 дугаар байрны хооронд БӨЧИ-ийн онооны ялгаа хамгийн их байна. Иймээс энд байгаа зэрэглэлээ өөрчлөхийг хүссэн орнуудын хувьд, хариултын дундажид илүү их өөрчлөлт хийх шаардлагатай байна. Хүснэгт 3-т БӨЧИ-ийн онооны өөрчлөлтийг улс бүрээр гаргасан илүү дэлгэрэнгүй мэдээллийг харуулав. Уншигч хэрвээ аль нэг улсын өрсөлдөөний давуу ба сул талуудын нарийвчилсан дүрслэлийг үзье гэвэл улс орон бүрийн онцлогтой мэдээллийн хэсэгт хандана уу.

АНУ суурь өрсөлдөх чадвараараа Финландын өмнө орж тэргүүлсэн хэвээр байгаа бөгөөд энэ хоёр орон 1998 оноос хойш эхний хоёр байрыг ээлжлэн эзэлсээр байна. 2005 онд АНУ мэдээлэл харилцааны дэд бүтэц, цахилгаан эрчим хүчний хангамжийн чанар, ялангуяа боловсролын тогтолцооны чанарын үзүүлэлтээ бусдаасаа харьцангуй илүү сайжруулсны үр дүнг ийнхүү хүртжээ. Зэрэглэлээ хамгийн их ахиулсан өндөр орлоготой улсуудын тоонд ЕХ-нд элссэнтэй холбоотойгоор гадаадын өмчлөлийн асуудлаа онцгой сайжруулсан гэдэг үүднээсээ Кипр улс (8 байр урагшилсан, тогтмол тооны орнууд бүхий түүвэрт хамаарах бүх зэрэглэлийн өөрчлөлтөөр), компаниудын удирдах зөвлөл илүү үр нөлөөтэй болсон, авилгал, хүнд суртлын дүрэм журам багассан, эрдэмтэд, инженерүүдийн хангамж сайтай болсон гэдгээрээ Бүгд Найрамдах Чех Улс (7 байр ахисан), хүнд суртлын зохицуулалтын цар хүрээ болон санхүүгийн зах зээлийн хүчин чадлын хэд хэдэн үзүүлэлт сайжирсан учраас Австри улс (6 байр ахисан)²⁵, дотоодын өрсөлдөөний эрчим, эрдэмтэд, инженерүүдийн хангамж сайжирсан гэдгээрээ Сингапур улс (5 байр урагшилсан) тус тус орж байна.

Уг зэрэглэлд *хойш ухарч* байгаа өндөр орлоготой орнуудад Гонконг, Швед, Итали улсууд орж байна. Тухайлбал Гонконгт ялангуяа төрийн албан тушаалтнуудын тал тохой татах асуудал улам их санаа зовоож байгаа, хүнд суртал өсөн нэмэгдэж байгаагаас тус муж түрүү жилийн эзэлсэн байр сууриа алдсан (9 байр доошилсон) байна. Мөн шүүхийн хараат бус байдлын асуудал үүссэн, боловсролын чанарын олон янзын арга хэмжээний хувьд доройтсон гэдэг үүднээс Швед улс (8 байраар) хойш ухарсан байна. Итали улс БӨЧИ-ийн үнэмлэхүй онооны хувьд сайжирсан хэдий ч БН Чех Улс, Кипр, Унгар, Тайланд зэрэг улсуудад

гүйцэгдсэн бөгөөд дээрх улсууд түүнээс ч илүү хурдан сайжирсан байна,

Өрсөлдөх чадварын зэрэглэлээ ахиулж байгаа дунд орлоготой улсуудын тоонд Польш, Аргентин, Хорват, Ботсвани, Эль Сальвадор, Унгар, Босни Герцоговен орж байна. Польш улс бизнесийн орчны чанарын олон чиглэлээр эрчимтэй сайжруулалт хийж 5 байр урагшлахдаа монополийн эсрэг бодлогын үр нөлөөтэй байдал ба санхүүгийн зах зээлийн боловсронгуй байдлыг сайжруулах чиглэлд хамгийн мэдэгдэхүйц амжилт үзүүлсэн байна. Тус улс 2001 онд уналтад орохынхоо өмнө хүрч байсан түвшиндээ өнөөдөр эргэж хүрээд байна. Аргентин улс нэн ялангуяа шинийг санаачлах чадавхиа дээшлүүлэх талаар авсан арга хэмжээнийхээ үр дүнд, түүний хөрш Уругвай улс хүнд суртлыг багасгаж, цагдаагийн үйлчилгээний найдвартай байдлыг сайжруулснаараа тус тус 13, 10 байраар ахижээ. Гэхдээ энэ хоёр улс хоёулаа 2001-2002 оны түвшиндээ хүрч чадаагүй хэвээр байна. Эцэст нь, Хорват улс 12 байраар дээшилсэн бөгөөд бизнесийн орчны үнэлгээ дээшлэсэн, ялангуяа гадаадын өмчлөлийн хязгаарлалтыг цөөлсөн, цагдаагийн үйлчилгээний найдвартай байдлыг сайжруулсан, дэд бүтцийн ерөнхий чанар сайжирсан зэрэг үзүүлэлтээр түрүү жил алдсан байр сууриа эргэж олж авсан байна.

Өрсөлдөх чадварын зэрэглэлд ухарч байгаа орнуудын тоонд Марокко, Намиби, БН Доминикан Улс, Орос, Бразил, Румын, Хятад улсууд орж байна. Марокко улс томоохон ухралт хийсэн (29 байр доошилсон) бөгөөд ялангуяа хүнд суртал, гадаадын өмчлөлийн хязгаарлалт, авилгал зэрэг үзүүлэлтээр доогуур үнэлгээ авсан нь үүнд нөлөөлсөн байна. Намиби улс 2002 онд ӨЧИ-д хамрагдан орсноос хойш тогтвортой байр суурь эзэлж байсныхаа дараа 19 байраар ухарсан нь голдуу хүнд суртал, төрийн албан тушаалтнуудын тал тохой таталт, авилгалын үзүүлэлтээр доогуур үнэлгээ авсантай нь холбоотой. БН Доминикан Улс доош буусан хандлагатай хэвээр (11 байр ухарсан) байна.

Бага орлоготой орнуудын дотроос Гана, Танзани, Пакистан улсууд хамгийн том ахиц гаргажээ. Гана улс голдуу улсын сургуулиудаа сайжруулж, авилгал багассаныхаа, Танзани, Пакистан хоёр улс ажил олгогч ба ажил эрхлэгчдийн хоорондын харилцааг сайжруулсныхаа үр шимийг хүртжээ.

Бага орлоготой орнуудаас хамгийн их буурсан нь Гамби, Индонези хоёр байна.

Индонезид өнгөрсөн жил засгийн газар солигдож, удахгүй хийгдэх сайжруулалтын талаар ихээхэн хүлээлт үүсч байсан үеэ бодвол тэр үед олж авсан бараг бүх байр сууриа алдаад байна. Энэхүү ухралтын гол шалтгаан нь биет дэд бүтэц болон санхүүгийн зах зээлийн хувьд огцом доогуур үнэлгээ авсанд оршино.

Компаний өрсөлдөх чадвар ба бизнесийн орчны чанар

Улс орнуудын өрсөлдөөний байр суурийг илүү гүнзгий ойлгохын тулд компаний боловсронгуй байдал ба микро эдийн засгийн бизнесийн орчны дэд индексүүдийг хэвшүүлж харьцуулсан байдлаар Бүдүүвч 8-д үзүүлэв. Энд 45 хэмийн шугамтай ойр байрласан орнуудын хувьд, өмнө дурдаж байсанчлан өрсөлдөх чадварын хоёр талууд эерэг харилцан хамааралтай байна. Энэхүү шугамаас дээш байрласан орнуудад компаний боловсронгуй байдал нь бизнесийн орчны байдлаасаа илүү өндөр хөгжсөн байна. Харин уг шугамаас доор байгаа орнуудын хувьд бизнесийн орчин нь компаниудаасаа илүү хөгжсөн гэсэн үг.

Компаний хөгжил нь бизнесийн орчноосоо түрүүлж яваа орнуудын тоонд Япон, Солонгос, Итали, Герман, Швед гэх мэт өндөр орлоготой орнууд, Филиппин, Панам, Бразил, Коста Рика зэрэг дунд орлоготой орнууд, БН Киргиз Улс, Кени, Эквадор гэх мэт бага орлоготой орнууд орж байна. Эдгээр орны бүтээмжийн үндэс суурийг сайжруулахад төрийн бодлогын ихээхэн өөрчлөлт хийх зайлшгүй шаардлагатай. Бизнесийн орчин сайжраагүй тохиолдолд *компаниуд үйл ажиллагаагаа гадагш шилжүүлэх буюу тухайн орноос гадуур шинэ хөрөнгө оруулалт хийх сонирхолтой* байна. Япон улс бизнесийн орчны байдал болон компаниудын боловсронгуй байдлын хооронд хамгийн их зөрүүтэй өндөр хөгжилтэй орон хэвээр байна. Японы корпорацийн хөрөнгө оруулалтууд тус орноос гадагш дайжиж байгаа учраас энэхүү сул тал нь Японы эдийн засгийн өсөлтөд ноцтой үр дагавар учруулж байна²⁶.

Бизнесийн орчны зэрэглэл нь компаний боловсронгуй байдлын өнөөгийн түвшнээс түрүүлж яваа орнуудад Португал, Катар, Австрали зэрэг өндөр орлоготой орнууд, Алжир, Серб, Тунис, Ботсвани, Кувейт, Эстони зэрэг дунд орлоготой орнууд, Танзани, Болив, Этиоп, Гана зэрэг бага орлоготой орнууд орж байна. Эдгээр оронд байгалийн баялгийн олборлолт (тухайлбал, Катар, Австрали хоёр), ЖТТ

үйлдвэрлэлд тулгуурлан ажилласаар байгаа тэргүүлэх компаниуд эсвэл ажиллах хүчний бага зардалд тулгуурлан эрчимтэй өрсөлддөг гадаадын үндэстэн дамнасан корпорациудын салбарууд (Тунис, Кипр, Португал) олон байна. Эстони, Гана гэх мэт зарим оронд бизнесийн орчны чиглэлд эрчимтэй сайжруулалт хийсэн атал түүнийг нь өрсөлдөөний уламжлалт хэлбэрүүддээ тулгуурласан хэвээр байгаа дотоодын компаниуд хараахан дагаж хөгжиж чадахгүй байгаа учраас нэг хэсэг зөрөөтэй байдал үүсч байна. Эдгээр орны хувьд шинээр бизнес эрхлэлт, стартегийн сэтгэлгээ, удирдлагын практик, бизнесийн боловсрол зэргийг сайжруулахад чиглэсэн хүчин чармайлт өндөр ач холбогдолтой тэргүүлэх чиглэл болж байна.


Улс орнуудын давуулан биелүүлсэн ба дутуу биелүүлсэн байдал

Цаашлаад бид аливаа нэг орны микро эдийн засгийн (бизнесийн) өрсөлдөх чадварыг нэг хүнд ноогдох орлогын өнөөгийн түвшинтэй нь харьцуулж үзэх замаар тухайн орны хөгжил дэвшлийн замнал ба тогтвортой байдлын тухайн ойлголттой болох юм. Хүснэгт 4-т улс орнуудыг нэг хүнд ноогдох бодит ДНБ ба өгөгдсөн микро эдийн засгийн өрсөлдөх чадварын түвшинд хүлээгдэж буй ДНБ хоёрын үнэмлэхүй зөрөөнийх нь дарааллаар жагсаан харуулав. Энд нэг хүнд ноогдох ДНБ-ий бодит түвшин нь *хүлээгдэж буй* түвшнээсээ дээгүүр байгаа орнуудыг давуулан биелүүлэгчид, доогуур байгаа орнуудыг *дутуу биелүүлэгчид* гэж томъёоллоо.

Давуулан биелүүлсэн гэдгийг голдуу аюултай шинж тэмдэг гэж үздэг. Яагаад гэвэл, энэ нь аливаа нэг орны хөгжил дэвшлийн хүрсэн түвшин түүний микро эдийн засгийн үндэс суурьтай харьцуулахад тогтвортой бус байгааг харуулдаг. Тухайлбал өнөөгийн хөгжил дэвшлийн түвшин нь гадаадын капиталын эсвэл гадаадын зээл тусламжийн хий хоосон урсгалаас үүссэн байж болно.

Дутуу биелүүлсэн гэдэг нь мөн түр зуурын чанартай, тухайлбал бизнесийн орчинд гарсан сайжруулалт компаний үйл ажиллагаанд бүрэн тусгагдаагүй байж болно. Гэхдээ бас дутуу гүйцэтгэл гэдэг нь аливаа улс улс төрийн тогтвортой байдал эсвэл байрлал муутайгаас болж хөгжлийн чадамжаа бүрэн ашиглах тал дээр бүтцийн хүндрэл бэрхшээлтэй тулгарч байгаагийн шинж байж болно.

Бүдүүвч 8: Компануд ба микро эдийн засгийн бизнесийн орчны харьцангуй хөгжилт



Хүснэгт 4: Нэг хүнд ноогдох ДНБ-ий өнөөгийн түвшин ба өрсөлдөх чадварын харьцуулалт

	Өндөр орлоготой орнууд	Дунд орлоготой орнууд	Бага орлоготой орнууд
	ДУТУУ БИЕЛҮҮЛЭГСЭД		
Өрсөлдөх чадвар (БӨЧИ-ээр хэмжих) нь нэг хүнд ноогдох илүү өндөр орлогыг дэмжихүйц	Герман Финлянд Сингапур Шинэ Зеланд Их Британи Тайвань Израиль	Малайз Иордан Тунис Өмнөд Африк Тайланд Чили Ямаик Эль Сальвадор Хятад Египет Эстони Турк Филиппин Бразил Колумби Марокко	Энэтхэг Гана Кени Нигери Индонези Пакистан Танзани Вьетнам Малави Шри Ланк Зимбабве Азербайжан Мадагаскар Мозамбик Гамби Тажикстан Молдав
	ДУНДЫГ БАРИГЧИД		
Өрсөлдөх чадвар (БӨЧИ-ээр хэмжих) ба нэг хүнд ноогдох орлого нь тэнцвэртэй	Япон БН Солонгос Улс Швед Швейцарь БН Чех Улс Австри	Коста Рика Намиби Украин Румын Унгар Литва Польш Серб ба Монтенегро Латви Ботсвани Гватемал Мексик	Этиоп Армян БН Киргиз Улс Камбож Гондурас Никарагуа
	ДАВУУЛАН БИЕЛҮҮЛЭГСЭД		
Нэг хүнд ноогдох орлого нь өрсөлдөх чадвараасаа (БӨЧИ-ээр хэмжих) харьцангуй өндөр	Австрали Португал Бельги Америкийн Нэгдсэн Улс Словени Испани Гонконг Канад Кипр Ирланд Исланд Грек Мальт Арабын Нэгдсэн Эмират Бахрейн Итали Норвеги Катар	Венесуэл Уругвай Босни Герцеговин Мавритани Болгар БН Словак Улс Македон Гайана Алжир Оросын Холбооны Улс Хорват Албани Парагвай БН Доминикан Улс Аргентин Кувейт Тринадад Тобаго	Болив Эквадор

Улс төрийн нөхцөл байдал

Манай үзэл баримтлалын хүрээнээс үзэхэд аливаа орны улс төр, төр засаг, нийгмийн нөхцөл байдал өрсөлдөөний чадамжид нөлөөлдөг байна. Энэ хамаарлыг судлахын тулд бид түрүү жил Кауфман нарын (2005) тодорхойсон тоон үзүүлэлтүүдийг ашигласан. Манай загварын нэг хүнд ноогдох ДНБ-ий бодит ба урьдчилан таамагласан түвшний зөрүүг тайлбарлахад Кауфманы «дуу хоолой ба хариуцлагатай байдал», «засгийн газрын үр нөлөөтэй байдал» гэсэн хоёр үзүүлэлт ач холбогдолтой байгааг бид олж тогтоосон²⁷. Хүснэгт 5-д БӨЧИ-ийн оноо ба нэг хүнд ноогдох ДНБ-ий хяналтын хувьсагчуудын хамтын регрессийн үр дүнг үзүүлэв. Улс төрийн байдал ба засаглал сайтай байгаагийнхаа үр шимийг хамгийн их хүртэж байгаа орнуудад Швейцарь, Дани, Финлянд, Шинэ Зеланд, Нидерланд, Норвеги улсууд орж байна. Харин засаглал муутайгаас болж нэг хүнд ноогдох ДНБ-ий үнэмлэхүй хэмжээний хувьд хохирч байгаа орнуудад Зимбабве, Этиоп, БН Киргиз Улс, Нигери, Камбож улсууд орж байна.

Байрлал

Аливаа орны газар зүйн байрлал өрсөлдөх чадварын өгөгдсөн түвшинд хөгжил дэвшилд хүрэх чадварт нь нөлөөлдөг. Бид энд байрлалын хоёр асуудлыг авч үзсэн нь аливаа орны хөрш улсуудын байдал (газраар хиллэсэн, шууд суваг эсвэл гүүрээр холбогдсон хөрш улсууд, мөн арлын орнуудын хувьд ойролцоох улс орнууд гэж тодорхойлсон) ба далайн тээвэрт ойрхон байдал юм. Баянчинээлэг хөрш орнууд худалдаа, хөрөнгө оруулалтын таатай боломж олгодог бөгөөд өрсөлдөх чадварын тодорхой түвшинд хөгжил дэвшлийг дээшлүүлэх ёстой. Далайн тээвэрт гарцтай байх нь компаниуд дэлхий нийтийн үнэт зүйлсийн гинжин хэлхээнд илүү үр нөлөөтэй нэгдэн орох, өрсөлдөх чадварыг хөшүүрэгдэн худалдаа, хөрөнгө оруулалтыг ч бас сайжруулах боломж олгодог.

Нэг хүнд ноогдох ДНБ-ий бодит ба урьдчилан таамагласан түвшний зөрүүг тайлбарлахад хөрш орнуудын дундаж орлогын үзүүлэлт эерэг бөгөөд ач холбогдолтой хамааралтай байгааг бид олж тогтоосон. Энэ нь сайн хөрштэй бол тодорхой түвшний өрсөлдөх чадвараас бий болж буй хөгжил дэвшил дээшилдэг гэсэн тайлбартай нийцэж байна. Мөн нэг хүнд ноогдох ДНБ-ий бодит ба урьдчилан таамагласан түвшний зөрүүг тайлбарлахад ямар

нэг далай тэнгис эсвэл далайн тэнгист цутгадаг гол мөрний ай саваас 100 км дотор оршин сууж буй улс орны хүн амын нийт хүн амдаа эзлэх хувийн үзүүлэлт эерэг бөгөөд ач холбогдолтой хамааралтай байгааг олж тогтоосон²⁸. Нэг хүнд ноогдох ДНБ-ий хувьд газар зүйн байрлалынхаа үр өгөөжийг хамгийн их хүртэж буй орнуудад БН Домникан улс (АНУ-тай ойрхон учраас), Канад, Мексик, Швед, Ирланд (Хүснэгт 5-ыг үзнэ үү) улсууд орж байна. Манай регрессийн тооцоогоор газар зүйн байрлал нь хамгийн сөрөг нөлөөтэй гарсан орнууд бол Малави, Этиоп, Кени, Танзани, Нигери, Гана улсууд байна.

Өрсөлдөх чадвар хөрш орнуудын хэмжээгээр газар зүйн хувьд нэгээс нөгөөд нөлөөлөн тархаж болохыг манай өрсөлдөх чадварын хүрээ харуулж байна. Улс орнууд ба тэдгээрийн хөршүүдийн БӨЧИ-ээр хэмжсэн өрсөлдөх чадварууд хоорондоо ач холбогдолтой хамааралтай байгааг тоон үзүүлэлтүүд нотолж байна. БӨЧИ дэх нийт улс орнуудын хэмжээний ялгааны 29 орчим хувийг бүх хөршүүдийнх нь БӨЧИ-ийн дундаж оноогоор тайлбарлаж байна. Мөн бүх хөршүүдийнх нь БӨЧИ-ийн дундаж утга өндөр байх нь тухайн орны БӨЧИ-ийн өндөр байгаагийн 66 хувийг тайлбарлаж байна.

Байгалийн баялгийн хишиг

Эдийн засгийн хөгжлийн тухай сэтгэлгээнд байгалийн баялаг илт чухал үүрэг гүйцэтгэж байна. Түрүү жилийн *Дэлхийн дахины өрсөлдөх чадварын тайлан*-д микро эдийн засгийн суурь өрсөлдөх чадвар бий болгох чадварт байгалийн баялаг голдуу сөрөг нөлөө үзүүлдэг талаар дэлгэрэнгүй авч үзсэн.

Харин байгалийн нөөц баялаг шавхагдаагүй, бараа бүтээгдэхүүний үнийн түвшин хангалттай өндөр хэвээр байгаа л бол байгалийн баялгийн экспорт нь өрсөлдөх чадвараас үл хамааран хөгжил дэвшилд шууд эерэг нөлөө үзүүлдэг. Байгалийн баялгийн экспортын үнэмлэхүй дүнгээрээ түүнийхээ үр шимийг хамгийн их хүртэж байгаа орнууд бол газрын тос экспортлогч Норвеги, Кувейт улсууд, харин хамгийн бага хүртэж байгаа нь Бангладеш, Гамби, Пакистан улсууд гэдэгт гайхах зүйлгүй (Хүснэгт 5-ыг үзнэ үү). Бүдүүвч 9-д үзүүлсэнчлэн, нэг хүнд ноогдох ДНБ-д байгалийн баялгийн эзлэх хувиар Ботсвани, Нигери, Казахстан, Алжир, Кувейт, Азербайжан, Венесуэл улсууд тэргүүлж байна (Бүдүүвч 8-г үзнэ үү). Норвеги, Кувейт хоёрын


Хүснэгт 5: Дутуу ба давуулан биелүүлэлтийн үр нөлөө

Улс	Нэг хүнд ноогдох ДНБ-ийг тайлбарласан байдал					БӨЧИ-ийн зэрэглэл				
	БӨЧИ-ийн завсрын квадрат хэлбэр	Байрлал	Засаглал	Байгалийн баялаг	Тайлбарлаг-даагүй үлдэгдэл	БӨЧИ-ийн завсрын квадрат хэлбэр	Байрлал	Засаглал	Байгалийн баялаг	Тайлбарлаг-даагүй үлдэгдэл
АНУ	\$22,222	\$4,263	\$5,998	\$303	\$6,712	1	23	11	38	4
Финлянд	\$21,203	\$3,953	\$7,023	\$791	-\$3,664	2	28	3	18	93
Герман	\$20,917	\$5,272	\$5,223	\$369	-\$2,892	3	13	16	34	87
Дани	\$20,596	\$5,536	\$7,364	\$2,700	-\$3,107	4	6	2	6	90
Сингапур	\$18,686	\$1,900	\$5,229	\$426	\$558	5	61	15	32	41
Их Британи	\$18,641	\$5,393	\$6,339	\$857	-\$2,261	6	10	10	16	81
Швейцарь	\$18,509	\$4,810	\$7,466	\$302	\$603	7	18	1	39	40
Япон	\$17,855	\$4,235	\$4,262	\$20	\$3,535	8	24	20	90	9
Нидерланд	\$17,741	\$5,439	\$6,865	\$2,216	-\$3,009	9	9	5	9	89
Австри	\$17,286	\$5,016	\$5,957	\$693	\$2,454	10	16	13	21	15
Франц	\$17,057	\$5,247	\$5,126	\$535	-\$51	11	14	17	26	49
Швед	\$16,520	\$5,981	\$6,714	\$799	-\$1,809	12	4	7	17	73
Канад	\$16,174	\$6,715	\$6,617	\$3,018	\$397	13	2	9	5	44
Австрали	\$15,773	\$2,234	\$6,620	\$2,637	\$2,418	14	44	8	7	16
Бельги	\$15,743	\$5,390	\$5,975	\$4,274	-\$1,320	15	11	12	3	69
Шинэ Зеланд	\$15,151	\$5,529	\$6,957	\$2,203	-\$5,916	16	8	4	10	98
Ирланд	\$14,681	\$5,708	\$5,353	\$1,294	\$4,227	17	5	14	13	7
Гонконг	\$14,638	\$1,883	\$3,871	\$25	\$10,141	18	62	24	85	2
Норвеги	\$13,977	\$4,171	\$6,848	\$14,202	\$808	19	26	6	1	34
Израиль	\$13,654	\$1,660	\$2,991	\$3,106	\$666	20	71	31	4	36
Малайз	\$12,942	\$2,311	\$1,883	\$742	-\$7,455	21	42	39	19	100
БН Солонгос Улс	\$11,852	\$5,533	\$3,292	\$25	\$605	22	7	25	86	38
Испани	\$10,129	\$4,751	\$4,716	\$591	\$3,440	23	19	18	25	10
Эстони	\$9,618	\$3,003	\$3,940	\$685	-\$2,029	24	34	23	22	76
БН Чех Улс	\$9,539	\$4,963	\$2,937	\$294	\$625	25	17	33	40	37
Өмнөд Африк	\$8,979	\$1,208	\$2,966	\$259	-\$2,809	26	88	32	43	84
Чили	\$8,971	\$2,057	\$4,558	\$632	-\$5,295	27	55	19	23	97
Португал	\$8,825	\$4,526	\$4,020	\$166	\$1,500	28	22	21	55	22
Энэтхэг	\$8,803	\$1,201	\$277	\$22	-\$7,274	29	89	50	89	99
Словени	\$8,399	\$5,237	\$3,998	\$202	\$2,469	30	15	22	47	13
Унгар	\$8,086	\$4,189	\$3,236	\$347	-\$312	31	25	26	36	52
Тунис	\$7,833	\$2,024	-\$163	\$102	-\$2,065	32	56	54	63	77
Тайланд	\$7,444	\$1,836	\$1,245	\$173	-\$2,797	33	65	43	53	83
Итали	\$7,313	\$5,287	\$2,858	\$208	\$12,506	34	12	34	46	1
БН Словак Улс	\$6,775	\$3,799	\$3,129	\$194	\$1,169	35	29	27	50	28
Грек	\$6,740	\$2,137	\$3,035	\$252	\$8,198	36	51	28	44	3
Литва	\$6,603	\$2,511	\$3,022	\$334	\$449	37	38	29	37	43
Польш	\$6,229	\$4,668	\$2,690	\$156	-\$1,498	38	21	37	57	71
Иордан	\$6,217	\$2,499	-\$386	\$65	-\$4,012	39	39	58	73	94
Гана	\$5,940	\$653	\$130	\$14	-\$4,262	40	95	52	93	95
Кувейт	\$5,906	\$2,912	\$659	\$6,736	-\$148	41	35	46	2	50
Латви	\$5,790	\$2,064	\$2,768	\$619	\$604	42	54	35	24	39
Бразил	\$5,570	\$1,620	\$518	\$171	\$449	43	72	48	54	42
Коста Рика	\$5,498	\$1,929	\$2,711	\$478	-\$729	44	59	36	29	62
Турк	\$5,451	\$2,571	-\$183	\$77	-\$414	45	37	56	68	56
Ямайк	\$5,143	\$1,261	\$1,058	\$486	-\$3,622	46	87	44	28	92
Ботсвани	\$4,971	\$1,567	\$3,003	\$2,252	-\$1,624	47	77	30	8	72
Колумби	\$4,965	\$1,432	-\$1,082	\$198	\$1,445	48	82	67	48	23
Хятад	\$4,930	\$2,172	-\$1,862	\$23	\$379	49	48	78	88	45
Эль Сальвадор	\$4,903	\$1,590	-\$170	\$11	-\$1,955	50	74	55	94	75
Индонези	\$4,893	\$4,711	-\$1,473	\$143	-\$4,652	51	20	71	58	96
Мексик	\$4,640	\$6,303	\$449	\$369	-\$2,095	52	3	49	35	79
Панам	\$4,624	\$2,156	\$770	\$123	-\$676	53	50	45	60	61
Казакстан	\$4,565	\$1,035	-\$3,185	\$1,001	\$4,003	54	92	94	15	8
Хорват	\$4,541	\$3,218	\$1,404	\$187	\$2,217	55	33	41	51	17
Аргентин	\$4,541	\$1,610	-\$117	\$428	\$6,006	56	73	53	31	5
Тринадад Тобаго	\$4,447	\$1,874	\$1,806	\$1,884	\$2,782	57	63	40	11	12
Пакистан	\$4,357	\$865	-\$3,179	\$5	\$356	58	93	93	98	46
Румын	\$4,332	\$2,158	\$137	\$76	\$939	59	49	51	69	32
Кени	\$4,282	\$299	-\$2,416	\$29	-\$1,118	60	98	85	81	68
Филиппин	\$4,258	\$3,254	-\$525	\$20	-\$2,446	61	32	61	91	82
Уругвай	\$4,242	\$2,214	\$2,631	\$446	-\$425	62	45	38	30	57

Хүснэгт 5: Дутуу ба давуулан биелүүлэлтийн үр нөлөө /үргэлжлэл/

Улс	Нэг хүнд ноогдох ДНБ-ийг тайлбарласан байдал					БӨЧИ-ийн зэрэглэл				
	БӨЧИ-ийн завсрын квадрат хэлбэр	Байрлал	Засаглал	Байгалийн баялаг	Тайлбарлагдаагүй үлдэгдэл	БӨЧИ-ийн завсрын квадрат хэлбэр	Байрлал	Засаглал	Байгалийн баялаг	Тайлбарлагдаагүй үлдэгдэл
Египет	\$4,223	\$3,688	-\$1,917	\$28	-\$1,950	63	31	79	83	74
Шри Ланк	\$4,112	\$1,475	-\$870	\$42	-\$877	64	80	65	77	65
Намиби	\$4,099	\$1,531	\$1,346	\$278	-\$804	65	79	42	42	64
ОХУ	\$4,086	\$1,853	-\$1,623	\$716	\$5,148	66	64	74	20	6
Украин	\$4,044	\$2,425	-\$2,467	\$95	\$2,457	67	40	86	65	14
Нигери	\$4,033	\$614	-\$3,349	\$290	-\$467	68	96	97	41	58
Азербайжан	\$3,984	\$1,362	-\$3,286	\$397	\$1,510	69	84	95	33	21
Болгар	\$3,972	\$2,375	\$609	\$120	\$1,425	70	41	47	62	24
Марокко	\$3,952	\$4,044	-\$832	\$45	-\$2,984	71	27	64	76	88
Вьетнам	\$3,911	\$1,788	-\$2,872	\$90	-\$348	72	67	90	67	53
Перу	\$3,827	\$1,826	-\$1,449	\$121	\$974	73	66	70	61	31
Танзани	\$3,772	\$340	-\$1,373	\$19	-\$2,085	74	97	69	92	78
Македон	\$3,594	\$2,769	-\$436	\$127	\$1,183	75	36	59	59	27
Зимбабве	\$3,591	\$1,542	-\$4,928	\$98	\$2,006	76	78	100	64	18
Парагвай	\$3,507	\$1,946	-\$2,890	\$229	\$1,761	77	58	91	45	19
Серб ба Монтенегро	\$3,420	\$2,295	-\$339	\$50	-\$569	78	43	57	75	60
Армян	\$3,408	\$1,130	-\$1,729	\$180	\$816	79	90	77	52	33
Гамби	\$3,396	\$1,300	-\$1,993	\$2	-\$803	80	86	80	99	63
Болив	\$3,394	\$1,382	-\$1,528	\$159	-\$505	81	83	73	56	59
Албани	\$3,388	\$3,716	-\$824	\$24	-\$1,367	82	30	53	87	70
Малави	\$3,388	\$132	-\$2,637	\$40	-\$353	83	100	88	78	54
Венесуэл	\$3,368	\$2,090	-\$2,943	\$1,357	\$1,699	84	53	92	12	20
Этиоп	\$3,367	\$275	-\$3,840	\$6	\$1,007	85	99	99	95	30
Молдав	\$3,365	\$2,108	-\$2,404	\$70	-\$1,020	86	52	84	72	66
Босни Герцеговин	\$3,357	\$2,191	-\$1,491	\$72	\$1,375	87	46	72	70	25
Алжир	\$3,351	\$1,710	-\$2,362	\$1,005	\$3,018	88	70	82	14	11
Гүрж	\$3,344	\$1,717	-\$2,392	\$32	\$74	89	69	83	79	48
Мадагаскар	\$3,328	\$1,575	-\$937	\$28	-\$3,139	90	75	66	82	91
Мозамбик	\$3,323	\$1,907	-\$1,117	\$6	-\$2,871	91	60	68	97	86
Камбож	\$3,309	\$1,729	-\$3,320	\$6	\$351	92	68	96	96	47
БН Киргиз Улс	\$3,308	\$860	-\$3,459	\$30	\$1,194	93	94	98	80	26
Эквадор	\$3,308	\$1,568	-\$2,306	\$507	\$742	94	76	81	27	35
Никарагуа	\$3,304	\$1,958	-\$1,624	\$64	-\$1,026	95	57	75	74	67
Бангладеш	\$3,303	\$1,461	-\$2,683	\$1	-\$207	96	81	89	100	51
БН Доминикан Улс	\$3,300	\$7,031	-\$733	\$25	-\$2,863	97	1	62	84	85
Гватемал	\$3,297	\$2,188	-\$2,630	\$93	\$1,060	98	47	87	66	29
Монгол	\$3,295	\$1,038	-\$484	\$195	-\$2,127	99	91	60	49	80
Гондурас	\$3,292	\$1,337	-\$1,662	\$70	-\$355	100	85	76	71	55

Бүдүүвч 9: Байгалийн баялгийн экспоррт: ДНБ-д эзлэх хувь ба нэг хүнд ноогдох ДНБ (ВХАЧ-р тохируулсан)



Нэг хүнд ноогдох ДНБ (ВХАЧ-р тохируулсан)

хувьд нэг хүнд ноогдох ДНБ-ий хүртэх ашиг тус нь байгалийн баялгийн экспортын өөрийнх нь нэг хүнд ноогдох шууд утгаас нилээд дээгүүр байхад Казахстан, Ботсвани хоёрын хувьд нэг хүнд ноогдох байгалийн баялгийн экспортын үржүүлэгч итгэлцүүр нь нэгээс бага гарсан байна. Энэ нь, өрсөлдөх чадварын ерөнхий түвшин өндөр байх нь аливаа эдийн засаг тодорхой хэмжээний байгалийн баялгийн үр шимээс илүү ихээр хүртэх боломж олгодог гэсэн таамаглалтай нийцэж байна.

Хөгжил дэвшлийн тайлбарлагдаагүй ялгаа

Улс төр, засаглалын нөхцөл байдал, газар зүйн байрлал, байгалийн баялгийн хишгийг харгалзвал улс орнуудын хэмжээний нэг хүнд ноогдох ДНБ-ий ялгааны 90 гаруй хувийг өрсөлдөх чадвар (БӨЧИ)-аар тайлбарлаж байна. Харин нэг хүнд ноогдох ДНБ-ий бодит ба урьдчилан таамагласан хэмжээний хоорондын хэсэг зөрүү тайлбарлагдаагүй үлдэж байгаа бөгөөд энэ ялгаа үнэмлэхүй утгаараа өндөр орлоготой орнуудад илүү их байх, бага орлоготой орнуудын хувьд ДНБ-тэй харьцангуй өндөр хамааралтай байх хандлагатай байна.

Манай загварт санал болгосон нэг хүнд ноогдох ДНБ-ийг тусгасан үзүүлэлтийн үнэмлэхүй утгаараа хамгийн өндөр эерэг үлдэгдэлтэй гарсан орнуудад Итали, Гонконг, АНУ, Аргентин улс орж байгааг бид тогтоосон. Бид мөн үүний шалтгаануудыг эргэцүүлж үзэж болно. Италийн хувьд, тус улсын бизнесийн салбарынханы өнөөгийн гутранги байдал нь бизнесийн орчны талаар хэтэрхий сөрөг үзэл бодол үүсэхэд хүргэсэн байж болох юм. Хонг Конгийн хувьд Хятадад нэвтрэх цорын ганц боомт болсон байрлалаасаа ихийг хожсон байж болно. АНУ мөн өөрийн том хэмжээ, бизнес эхлэн эрхлэх соёлынхоо үр шимийг ихээр хүртсэн байж болзошгүй. Харин Аргентиний эзэлсэн байр суурийг дараахь хоёр арга замын алинаар нь ч тайлбарлаж болно. Энэ нь нэг бол эдийн засгийн сүйрлийн таагүй нөхцөл байдал дагасан бизнесийн салбарынханы үргэлжилсэн гутранги байдал, эсвэл тус улсын өрсөлдөх чадвараас үүдэн урт хугацаанд тогтвортой барьж чадахгүй байгаа хөгжил дэвшлийн түвшин юм. Нэг хүнд ноогдох ДНБ-ий бодит түвшин ба манай загварт санал болгосон хүрч болох түвшний хооронд хамгийн их зөрүүтэй гарсан орнуудад Энэтхэг, Шинэ Зеланд, Финлянд улсууд орж байна. Энэтхэгийн хувьд тус улсын мужуудын хэмжээнд ихээхэн олон янз байдагтай

холбоотой байж магадгүй. Магадгүй манай Судалгаанд тус улсын хамгийн их хөгжилтэй мужуудын бизнесийн нөхцөл байдлыг тусган харуулсан байж ч болох юм. Шинэ Зеландын хувьд бусад өндөр хөгжилтэй орнуудаас ихээхэн алслагдмал байдал нь нөлөөлсөн байх. Харин Финлянд улс хөдөлмөрийн зах зээлийн үр ашиггүй зохицуулалтууд²⁹ ба бизнес шинээр эрхлэх, шинийг санаачлах урам зориг бага өгдөг татварын тогтолцооныхоо нөлөөнөөс болж өөрийн чадамжаа бүрэн ашиглаж чадахгүй байж болох юм (энэхүү Тайлангийн 4.3 дугаар хэсгийн хүснэгт 6.11-ийг үзнэ үү).

Микро эдийн засгийн өрсөлдөх чадвар ба хөгжил дэвшлийн өсөлтийн уялдаа холбоо

Хэрвээ микро эдийн засгийн чадавхи хөгжил дэвшлийн үндэс суурь мөн гэж үзвэл энэ хоёрын хооронд буй ямар нэг уялдаа холбоог бид олж харах ёстой. Үүнийг судлах үүднээс бид өрсөлдөх чадварын зэрэглэлээ дээшлүүлж эсвэл доошлуулж байгаа улс орнуудын нэг хүнд ноогдох ДНБ-ий өсөлтөд холбогдох чиг хандлага гарч байгаа эсэхийг шалгасан юм. Нэг хүнд ноогдох орлогын түвшин хөгжлийн шинэ тогтвортой түвшинг даган дээш, доош өөрчлөгдөж байдгийн адилаар БӨЧИ-ийн зэрэглэлд гарсан өөрчлөлтүүд нэг хүнд ноогдох ДНБ-ий өсөлтөд нөлөөлөх ёстой. Макро эдийн засгийн зохицуулалтууд болон бусад цочролууд ч бас нэг хүнд ноогдох орлогын өсөлтөд тодорхой хугацаагаар нөлөө үзүүлж болохын зэрэгцээ дунд хугацаанд гарсан БӨЧИ-ийн зэрэглэлийн өөрчлөлт ба хөгжил дэвшлийн өсөлтийн хоорондын хамаарал нь БӨЧИ ба хөгжил дэвшлийн хоорондын хамааралд шалтгаант холбоос байгааг туршилтаар харуулж байна.

Улс орнуудын 1998-2004 оны хоорондох нэг хүнд ноогдох ДНБ ба 1999-2005 оны БӨЧИ-ийн зэрэглэлийн өөрчлөлтүүдийн хооронд регрессийн шинжилгээ хийхэд тэдгээрийн хооронд эерэг бөгөөд ач холбогдолтой хамаарал байгааг бид олж тогтоосон. Улс орнуудын хэмжээний нэг хүнд ноогдох ДНБ-ий нийт ялгааны 17 орчим хувийг БӨЧИ-ийн зэрэглэлийн өөрчлөлтөөр тайлбарлаж байна. Уг хамаарал нь статистикийн хувьд өндөр ач холбогдолтой гарч байна. Хамаарлын коэффициентоос үзэхэд, БӨЧИ-ийн зэрэглэлийн 5 жилийн хугацаанд 10 байраар ахисан өөрчлөлт нэг хүнд ноогдох ДНБ-ий 1.6 хувийн өсөлттэй холбоотой байгааг харуулж байна. Бидний тооцоолж байгаагаар

Хүснэгт 6: Бараа бүтээгдэхүүний экспортын бүлэглэлүүдийн үйл ажиллагаа (байгалийн баялгийг оруулалгүйгээр)

Улс	Бүлэглэлийн хөгжил		Бараа бүтээгдэхүүний экспортын эзлэх хувь								Ашигласан тоон үзүүлэлтийн он
	БӨЧИ-ийн оноо	БӨЧИ-ийн байр	бүлэглэлүүдээр, улсын зах зээлд эзлэх хувь				дэд бүлэглэлүүдээр, зах зээлд эзлэх хувь				
			> зах зээлд эзлэх нийт хувь	> зах зээлд эзлэх нийт хувь + 2.5%	> зах зээлд эзлэх нийт хувь + 5%	> зах зээлд эзлэх нийт хувь + 10%	> зах зээлд эзлэх нийт хувь	> зах зээлд эзлэх нийт хувь + 2.5%	> зах зээлд эзлэх нийт хувь + 5%	> зах зээлд эзлэх нийт хувь + 10%	
Япон	2.55	1	76.65%	67.22%	52.25%	8.88%	77.77%	66.45%	57.38%	14.62%	2003
Герман	2.44	2	69.18%	54.12%	31.86%	0.00%	65.57%	53.63%	38.29%	22.09%	2003
АНУ	2.34	3	44.36%	29.17%	18.98%	12.21%	55.32%	39.85%	30.44%	15.83%	2003
Дани	1.73	4	41.24%	3.49%	0.00%	0.00%	49.26%	7.79%	1.58%	0.00%	2003
Их Британи	1.72	5	36.69%	19.99%	16.58%	3.87%	47.33%	24.27%	12.28%	7.31%	2003
Франц	1.72	6	62.67%	19.10%	15.36%	8.04%	61.08%	28.38%	13.89%	11.28%	2003
Финлянд	1.70	7	55.81%	38.05%	16.23%	0.00%	59.12%	38.61%	15.73%	14.20%	2003
Австри	1.66	8	58.57%	3.14%	0.00%	0.00%	58.19%	13.75%	4.79%	3.19%	2003
Швейцарь	1.63	9	73.84%	33.57%	28.80%	9.78%	75.63%	49.12%	36.09%	10.51%	2003
Нидерланд	1.59	10	44.12%	27.74%	1.56%	1.56%	41.16%	27.09%	17.08%	3.24%	2003
Бельги	1.49	11	52.41%	24.39%	10.19%	0.00%	51.18%	30.93%	21.76%	1.43%	2003
Канад	1.48	12	36.67%	28.95%	3.61%	0.00%	38.62%	26.26%	4.91%	0.21%	2003
Швед	1.42	13	63.83%	7.68%	7.68%	0.00%	54.78%	10.16%	8.92%	0.00%	2003
Тайвань	1.33	14	Тоон үзүүлэлт байхгүй								
БН Солонгос Улс	1.22	15	76.65%	40.22%	17.54%	5.80%	71.68%	54.98%	22.20%	7.37%	2003
Австрали	1.19	16	2.45%	0.00%	0.00%	0.00%	4.12%	2.50%	2.50%	0.31%	2003
Энэтхэг	1.13	17	42.56%	16.78%	0.00%	0.00%	41.90%	23.49%	9.84%	0.00%	2003
Итали	1.02	18	62.94%	46.56%	18.33%	2.83%	64.68%	44.35%	34.29%	10.15%	2003
Испани	0.99	19	51.56%	26.66%	0.00%	0.00%	50.98%	28.35%	1.10%	0.00%	2003
Израиль	0.98	20	36.06%	0.00%	0.00%	0.00%	38.72%	2.76%	0.32%	0.32%	2003
БН Чех Улс	0.98	21	68.40%	0.00%	0.00%	0.00%	72.65%	6.81%	0.15%	0.00%	2003
Гонконг	0.96	22	54.17%	42.08%	0.00%	0.00%	63.70%	44.07%	18.28%	0.00%	2003
Шинэ Зеланд	0.95	23	11.60%	0.00%	0.00%	0.00%	14.64%	0.00%	0.00%	0.00%	2003
Малайз	0.93	24	55.98%	45.00%	38.20%	0.00%	57.92%	45.50%	30.00%	0.00%	2003
Норвеги	0.92	25	3.72%	2.93%	0.00%	0.00%	7.38%	3.28%	0.00%	0.00%	2003
Сингапур	0.89	26	64.95%	42.38%	42.38%	0.00%	66.93%	49.78%	44.90%	25.12%	2003
Ирланд	0.84	27	74.30%	50.07%	43.05%	0.00%	73.85%	67.47%	51.00%	22.15%	2003
Бразил	0.84	28	12.19%	2.22%	0.00%	0.00%	18.63%	2.14%	0.11%	0.00%	2003
Өмнөд Африк	0.78	29	21.16%	0.00%	0.00%	0.00%	28.25%	0.15%	0.00%	0.00%	2003
Исланд	0.60	30	2.65%	0.00%	0.00%	0.00%	5.95%	0.00%	0.00%	0.00%	2003
Чили	0.53	31	3.84%	0.00%	0.00%	0.00%	9.00%	3.34%	0.00%	0.00%	2003
Хятад	0.52	32	70.37%	66.05%	63.30%	24.04%	71.93%	68.67%	62.27%	51.74%	2003
Словени	0.43	33	77.67%	0.00%	0.00%	0.00%	76.90%	0.37%	0.00%	0.00%	2003
Польш	0.41	34	57.16%	15.13%	0.00%	0.00%	59.08%	14.14%	3.98%	0.00%	2003
Турк	0.39	35	70.21%	21.36%	0.00%	0.00%	67.29%	31.01%	12.66%	0.00%	2003
Литва	0.38	36	36.59%	0.00%	0.00%	0.00%	42.40%	0.00%	0.00%	0.00%	2003
Тайланд	0.36	37	51.87%	0.00%	0.00%	0.00%	55.01%	7.22%	0.59%	0.22%	2003
Эстони	0.33	38	47.81%	0.00%	0.00%	0.00%	49.74%	0.00%	0.00%	0.00%	2003
Тунис	0.23	39	62.21%	0.00%	0.00%	0.00%	70.20%	2.26%	0.00%	0.00%	2003
Аргентин	0.22	40	2.73%	0.00%	0.00%	0.00%	10.34%	0.28%	0.28%	0.00%	2003
Кипр	0.20	41	45.36%	0.00%	0.00%	0.00%	51.78%	0.00%	0.00%	0.00%	2003
ОХУ	0.20	42	9.32%	0.00%	0.00%	0.00%	9.94%	2.45%	2.45%	0.60%	2003
Португал	0.19	43	60.85%	5.11%	0.00%	0.00%	62.42%	10.47%	0.00%	0.00%	2003
БН Словак Улс	0.16	44	67.08%	0.00%	0.00%	0.00%	69.52%	0.05%	0.00%	0.00%	2003
Украин	0.16	45	33.31%	0.00%	0.00%	0.00%	36.33%	21.43%	0.00%	0.00%	2002
Кени	0.07	46	11.55%	0.00%	0.00%	0.00%	18.01%	0.00%	0.00%	0.00%	2003
Казакстан	0.01	47	8.46%	0.00%	0.00%	0.00%	9.81%	0.00%	0.00%	0.00%	2003
Унгар	0.01	48	58.78%	0.00%	0.00%	0.00%	65.66%	11.21%	1.28%	0.00%	2003
Коста Рика	0.00	49	55.00%	0.00%	0.00%	0.00%	59.85%	0.00%	0.00%	0.00%	2003
Кувейт	-0.04	50	4.32%	0.00%	0.00%	0.00%	4.70%	0.00%	0.00%	0.00%	2001
Мавритани	-0.07	51	58.86%	0.00%	0.00%	0.00%	62.44%	0.00%	0.00%	0.00%	2003
АН Эмират Улс	-0.07	52	Тоон үзүүлэлт байхгүй								
Мексик	-0.11	53	66.78%	19.06%	0.00%	0.00%	67.97%	22.28%	13.84%	8.58%	2003
Латви	-0.14	54	32.74%	0.00%	0.00%	0.00%	34.89%	0.00%	0.00%	0.00%	2003
Болгар	-0.14	55	43.49%	0.00%	0.00%	0.00%	48.37%	0.00%	0.00%	0.00%	2003
Пакистан	-0.15	56	75.91%	48.72%	0.00%	0.00%	78.55%	45.98%	25.53%	16.34%	2003
Панам	-0.16	57	3.98%	0.00%	0.00%	0.00%	5.69%	0.00%	0.00%	0.00%	2003
Шри Ланк	-0.17	58	58.66%	0.00%	0.00%	0.00%	61.74%	0.00%	0.00%	0.00%	2003
Грек	-0.22	59	46.70%	0.00%	0.00%	0.00%	49.19%	4.44%	1.91%	1.91%	2003
Иордан	-0.24	60	61.12%	0.00%	0.00%	0.00%	62.90%	0.00%	0.00%	0.00%	2003

Хүснэгт 6: Бараа бүтээгдэхүүний экспортын бүлэглэлүүдийн үйл ажиллагаа /үргэлжлэл/ (байгалийн баялгийг оруулалгүйгээр)

Улс	Бүлэглэлийн хөгжил		Бараа бүтээгдэхүүний экспортын эзлэх хувь								Ашигласан тоон үзүүлэлтийн он
	БӨЧИ-ийн оноо	БӨЧИ-ийн оноо	бүлэглэлүүдээр, улсын зах зээлд эзлэх хувь				дэд бүлэглэлүүдээр, зах зээлд эзлэх хувь				
			> зах зээлд эзлэх нийт хувь	> зах зээлд эзлэх нийт хувь + 2.5%	> зах зээлд эзлэх нийт хувь + 5%	> зах зээлд эзлэх нийт хувь + 10%	> зах зээлд эзлэх нийт хувь	> зах зээлд эзлэх нийт хувь + 2.5%	> зах зээлд эзлэх нийт хувь + 5%	> зах зээлд эзлэх нийт хувь + 10%	
Азербайжан	-0.24	61	0.00%	0.00%	0.00%	0.00%	0.63%	0.00%	0.00%	0.00%	2003
Колумби	-0.24	62	16.21%	0.00%	0.00%	0.00%	19.72%	0.00%	0.00%	0.00%	2003
Марокко	-0.27	63	51.48%	0.00%	0.00%	0.00%	59.42%	0.00%	0.00%	0.00%	2003
Индонези	-0.27	64	24.34%	0.00%	0.00%	0.00%	26.36%	5.40%	2.92%	0.88%	2003
Хорват	-0.27	65	45.56%	0.00%	0.00%	0.00%	58.49%	0.00%	0.00%	0.00%	2003
Филиппин	-0.28	66	73.48%	63.09%	0.00%	0.00%	75.59%	48.39%	44.45%	0.00%	2003
Румын	-0.29	67	63.86%	8.06%	0.00%	0.00%	62.98%	10.66%	2.71%	0.00%	2003
Эль Сальвадор	-0.31	68	65.15%	0.00%	0.00%	0.00%	65.05%	0.00%	0.00%	0.00%	2003
Египет	-0.41	69	18.73%	0.00%	0.00%	0.00%	23.26%	3.14%	0.00%	0.00%	2003
Гана	-0.42	70	2.66%	0.00%	0.00%	0.00%	4.88%	0.00%	0.00%	0.00%	2001
Тринадад Тобаго	-0.43	71	14.27%	0.00%	0.00%	0.00%	17.69%	0.00%	0.00%	0.00%	2003
Нигери	-0.45	72	1.49%	0.00%	0.00%	0.00%	1.49%	0.00%	0.00%	0.00%	2003
Вьетнам	-0.51	73	Тоон үзүүлэлт байхгүй								
Перу	-0.54	74	8.26%	0.00%	0.00%	0.00%	12.19%	0.00%	0.00%	0.00%	2003
Македон	-0.54	75	59.80%	0.00%	0.00%	0.00%	61.31%	0.00%	0.00%	0.00%	2003
Серб ба Монтенегро	-0.55	76	41.99%	0.00%	0.00%	0.00%	43.59%	0.00%	0.00%	0.00%	2002
Уругвай	-0.58	77	9.33%	0.00%	0.00%	0.00%	11.61%	0.00%	0.00%	0.00%	2003
Ямаик	-0.67	78	7.91%	0.00%	0.00%	0.00%	8.66%	0.00%	0.00%	0.00%	2002
БН Доминикан Улс	-0.68	79	15.91%	0.00%	0.00%	0.00%	19.20%	0.00%	0.00%	0.00%	2001
Гватемал	-0.71	80	29.33%	0.00%	0.00%	0.00%	37.52%	0.00%	0.00%	0.00%	2003
Армян	-0.73	81	19.16%	0.00%	0.00%	0.00%	20.88%	0.00%	0.00%	0.00%	2003
Мальт	-0.74	82	88.67%	0.00%	0.00%	0.00%	89.67%	0.00%	0.00%	0.00%	2001
Бахрейн	-0.75	83	13.63%	0.00%	0.00%	0.00%	18.75%	9.98%	9.98%	0.00%	2003
Бангладеш	-0.85	84	83.52%	0.00%	0.00%	0.00%	83.69%	30.40%	0.00%	0.00%	2003
Босни Герцеговин	-0.86	85	33.25%	0.00%	0.00%	0.00%	42.37%	0.00%	0.00%	0.00%	2003
Катар	-0.89	86	5.58%	0.00%	0.00%	0.00%	8.96%	0.00%	0.00%	0.00%	2002
Мадагскар	-0.89	87	30.89%	0.00%	0.00%	0.00%	33.63%	0.00%	0.00%	0.00%	2003
Танзани	-0.89	88	0.47%	0.00%	0.00%	0.00%	4.28%	0.00%	0.00%	0.00%	2003
Алжир	-0.92	89	0.00%	0.00%	0.00%	0.00%	0.00%	0.00%	0.00%	0.00%	2003
Ботсвани	-0.98	90	1.25%	0.00%	0.00%	0.00%	1.97%	1.08%	1.08%	0.00%	2001
Гондурас	-1.06	91	12.77%	0.00%	0.00%	0.00%	19.09%	0.00%	0.00%	0.00%	2003
Намиби	-1.08	92	25.88%	0.00%	0.00%	0.00%	28.12%	0.00%	0.00%	0.00%	2003
Эквадор	-1.09	93	0.46%	0.00%	0.00%	0.00%	1.85%	0.00%	0.00%	0.00%	2003
Молдав	-1.10	94	52.70%	0.00%	0.00%	0.00%	55.98%	0.00%	0.00%	0.00%	2003
Зимбабве	-1.11	95	15.58%	0.00%	0.00%	0.00%	20.54%	0.00%	0.00%	0.00%	2002
Тажикстан	-1.13	96	Тоон үзүүлэлт байхгүй								
Венесуэл	-1.25	97	0.50%	0.00%	0.00%	0.00%	1.58%	0.00%	0.00%	0.00%	2003
Малави	-1.25	98	8.62%	0.00%	0.00%	0.00%	9.76%	0.00%	0.00%	0.00%	2003
Гамби	-1.26	99	24.03%	0.00%	0.00%	0.00%	25.97%	0.00%	0.00%	0.00%	2003
Парагвай	-1.28	100	1.98%	0.00%	0.00%	0.00%	4.01%	0.00%	0.00%	0.00%	2003
Никарагуа	-1.28	101	6.66%	0.00%	0.00%	0.00%	7.09%	0.00%	0.00%	0.00%	2003
Гүрж	-1.33	102	36.36%	0.00%	0.00%	0.00%	36.92%	0.00%	0.00%	0.00%	2003
Гайана	-1.35	103	3.78%	0.00%	0.00%	0.00%	8.54%	0.00%	0.00%	0.00%	2003
Мозамбик	-1.41	104	14.43%	0.00%	0.00%	0.00%	15.79%	0.00%	0.00%	0.00%	2002
Монгол	-1.42	105	18.82%	0.00%	0.00%	0.00%	19.19%	0.00%	0.00%	0.00%	2003
БН Киргиз Улс	-1.45	106	10.22%	0.00%	0.00%	0.00%	15.41%	0.00%	0.00%	0.00%	2003
Болив	-1.47	107	3.78%	0.00%	0.00%	0.00%	9.42%	0.00%	0.00%	0.00%	2003
Этиоп	-1.56	108	1.19%	0.00%	0.00%	0.00%	2.24%	0.00%	0.00%	0.00%	2003
Камбож	-1.58	109	93.52%	0.00%	0.00%	0.00%	93.70%	0.00%	0.00%	0.00%	2003
Албани	-1.69	110	69.53%	0.00%	0.00%	0.00%	72.91%	0.00%	0.00%	0.00%	2003

Эх сурвалж: Олон Улсын Бүлэглэлийн Өрсөлдөх Чадварын Төсөл, Харвардын Бизнесийн Сургууль

энэ хамаарал жилээс жилд тогтвортой бөгөөд ач холбогдолтой байгаа нь нотлогдсон. Энэ хамааралд Зимбаве улс регрессийн үндсэн шугамыг тойрсон 95 хувийн ач холбогдолтой завсрын гадна үлдсэн байна. Зимбабвегийн нэг хүнд ноогдох ДНБ төсөөлж байснаас ч илүүгээр унасан бөгөөд энэ нь тус улсын улс төрийн үймээн самуунтай байдлыг харгалзвал гайхах зүйлгүй юм³⁰. БӨЧИ-ийн зэрэглэлд гарсан өөрчлөлтөөрөө төсөөлж байснаас хамаагүй бага нэг хүнд ноогдох ДНБ-ий өсөлттэй байсан бусад орнуудад Колумб, Венесуэл, Аргентин улсууд орох бөгөөд бүгд л энэ хугацаанд улс төрийн эсвэл макро эдийн засгийн хямралт байдалд орсон юм. Харин нөгөө туйлд нь, цаг хугацааны туршид гарсан БӨЧИ-ийн үр дүнтэй нь харьцуулахад төсөөлж байснаас ч илүү нэг хүнд ноогдох ДНБ-ий өсөлттэй гарсан Украин, Орос, Хятад улсууд байрлаж байна. Эдгээр орнуудын макро эдийн засгийн болон улс төрийн нөхцөл байдалд гарсан эерэг өөрчлөлтүүд нь өсөлтийг нэмэгдүүлэгч болж өгчээ.

Бүлэглэлүүд ба экспортын үйл ажиллагаа

Энэ жил бид анх удаагаа олон улсын бараа бүтээгдэхүүний экспортын тоон үзүүлэлтүүдийг бүлэглэлээр гаргаж, БӨЧИ-ийн судалгааны үзүүлэлтүүдтэйгээ холбон тайлагнаж байна. НҮБ-ын Худалдаа Хөгжлийн Бага Хурлаас салбараар гаргасан экспортын тоон үзүүлэлтүүдэд тулгуурлан Олон Улсын Бүлэглэлүүдийн Өрсөлдөх Чадварын Төслийн³¹ тоон үзүүлэлтүүдийг гаргаад байна. Өмнөх судалгаанд хэрэглэсэн арга зүйг ашиглан тодорхой бүлэглэл, дэд бүлэглэл бүрт салбарын код өгсөн байгаа. Дараа нь бид тухайн улсын дэлхийн экспортод эзлэх дундаж хувиас илүү өндөр экспортын хувь буюу харьцангуй давуу тал бүхий бүлэглэлүүд ба дэд бүлэглэлүүдэд үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний экспортын нийт хувийг улс орноор тооцоолж гаргаад байна. Бүлэглэлийн хөгжлийн тухай БӨЧИ-ийн тоон үзүүлэлтийг ганц хэмжүүрээр илэрхийлж, бүлэглэлүүдтэй холбоотой дөрвөн асуултад өгсөн Судалгааны хариултаудын нэгдүгээр үндсэн бүрэлдэхүүн хэсэг болгон тооцож гаргасан. Хүснэгт 6-д БӨЧИ-ийн Бүлэглэлийн зэрэглэлийг болон аливаа улсын дэлхийн бараа бүтээгдэхүүний экспортын зах зээлд эзлэх дундаж хувиас дээгүүр хэмжээнд дэлхийн зах зээлд байр суурь эзэлсэн бүлэглэлүүд ба дэд бүлэглэлүүдийн экспортын хувийг үзүүлэв. БӨЧИ-д бүртгэгдсэн бүлэглэлийн хүчтэй

нөхцөл байдал болон хүчтэй бүлэглэлүүдийн экспортын өндөр хувь хоёрын хооронд тодорхой харилцан уялдаа байдаг. Энд ялангуяа Япон, Герман, АНУ ялгардаг боловч Их Британи, Франц, Финлянд, Швейцарь, Солонгос, Итали зэрэг бүлэглэлийн хүчтэй нөхцөл байдал нь тэдгээрт төвлөрсөн экспорттойгоо сайтар нийцдэг орнууд бий.

Дүгнэлт

Аливаа улс үндэстний хүний, капиталын болон байгалийн баялагийн хүч нөөцөө ашиглаж буй бүтээмжээр тодорхойлогддог өрсөлдөх чадвар нь үндэстний хөгжил дэвшилд хүчтэй нөлөө үзүүлдэг. Өрсөлдөх чадвар нь аливаа үндэстний компаниудын боловсронгуй байдал ба микро эдийн засгийн бизнесийн орчны чанараар илэрдэг микро эдийн засгийн үндэс сууриудад тулгуурладаг.

Тогтвортой институциуд, сайн макро эдийн засгийн бодлого, зах зээлийн нээлттэй байдал, өмч хувьчлал зэргийг эдийн засгийн хөгжлийн тулгын чулуу гэж урт удаан хугацаагаар үзсээр ирсэн байдаг. Өнгөрсөн жилийн болон энэ жилийн үр дүнгээс үзэхэд тэдгээр нь зайлшгүй шаардлагатай боловч хангалттай бус байгаа нь харагдаж байна. Улс орнуудын хэмжээний нэг хүнд ноогдох ДНБ-ий ялгааны 80 гаруй хувийг микро эдийн засгийн үндэс сууриудаар тайлбарлаж байна. Улс төрийн засаглал, газар зүйн байрлал, байгалийн нөөц баялаг зэрэг бусад хүчин зүйлс ч үүрэг гүйцэтгэдэг бөгөөд яагаад улс орнуудын хөгжил дэвшил микро эдийн засгийн үндэс сууриудад тулгуурласан түвшнээсээ, зарим тохиолдолд урт хугацаагаар, хазайдаг болохыг тайлбарладаг. Гэхдээ эдгээр болон бусад хүчин зүйлсийн нөлөө хамаагүй бага ач холбогдолтой байдаг.

Микро эдийн засгийн шинэчлэлгүйгээр сайн макро эдийн засгийн бодлого, зах зээлийн нээлттэй байдал, өмч хувьчлалын үр дүнд бий болсон ДНБ-ий өсөлт тогтворгүй байх ба нэг хүнд ноогдох ДНБ-ий хэмжээ сайжрахгүй. Харин эсрэгээр нь, бүтээмж ба бүтээмжийн өсөлтийг дээшлүүлэхэд чиглэсэн микро түвшний зохих шинэчлэлүүд нь засгийн газар төсвийн үүргээ биелүүлэх, макро эдийн засгийн гажуудлыг багасгахад тулгарч буй сорилтыг ихээхэн хөнгөвчилж өгдөг. Микро эдийн засгийн шинэчлэлүүд нь макро эдийн засгийн тогтвортой байдал, зах зээлийн нээлтийн явцуу эрх ашгаа хамгаалахыг оролдож буй засгийн газруудад үзүүлэх улс төрийн дарамтыг ч бас

багасгаж өгдөг. Дангаар ноёрхогч монополиуд байр сууриа алдаж байгааг, бизнесүүд өөрсдөө шинэчлэгдэж байгааг, шинээр бизнес эрхлэх болон ажил эрхлэлтийн боломжууд нэмэгдэж байгааг нүдээр үзэж буй иргэд дахин хуваарилалт, засгийн газрын хөндлөнгийн оролцооны тухай худал амлалтуудад автах магадлал багатай байх болно.

Зөвхөн микро эдийн засгийн тасралтгүй сайжруулалтаар дамжуулан хөгжил дэвшлийн тогтвортой өсөлтөд хүрч болно гэдгийг яваандаа олон орон ойлгож байна. Харин Европын Холбоо болон түүний санаачлагаар 2000 онд эхлүүлсэн Лиссабоны Хэлэлцэх Асуудал нь дөнгөж эхлэж буй зарчмуудаас үйл ажиллагаанд шилжихэд ямар хэцүү болохыг харуулсан дохио юм. ЕХ-ны туршлага нь газар зүйн зохих түвшинд өрсөлдөх чадварыг авч үзэх асуудал ямар чухал болохыг харуулж байна. Хэрвээ үндэсний түвшинд хүнд хэцүү саад тотгорууд байх юм бол үндэстэн дамнанас институциудад өрсөлдөх чадварыг хариуцуулах асуудал бүтэхгүй.

Микро эдийн засгийн шинэчлэлийг зөвхөн төр засгийн гүйцэтгэх үүрэг оролцоог багасгах, зах зээлийн гажуудлыг арилгах талаас нь явцуу авч үзэх нь ухаалаг хэрэг биш гэдгийг бидний олж мэдсэн зүйлс нотолж байна. Төр засгийн зүгээс хүний нөөцөд хөрөнгө оруулах, зохих зохицуулалтын стандарт тогтоох замаар дэвшилтэт эрэлтийг урамшуулах, шинийг санаачлах чадавхийг бэхжүүлэх зэрэг хөгжил дэвшилд чухал үүрэгтэй олон янзын эерэг үүрэг гүйцэтгэдэг. Мөн хувийн салбарынхан хамтын үйл ажиллагаа, бүлэглэл хөгжүүлэх санаачлагаараа дамжуулан аливаа улс үндэстний өрсөлдөх чадварын бааз суурийг тавихад чухал үүрэгтэй байдаг.

Эцэст нь, манай шинжилгээний үр дүнд үндэсний эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүдийг хөгжлийн түвшинд нь нийцүүлэх шаардлагыг дахин цохон тэмдэглэж байна. Микро эдийн засгийн сайжруулалт бол хөгжлийн өөр шатанд яваа улс орнууд огт өөр өөр сорилтуудтай тулгарч байдаг шат дараалсан үйл явц байдгийг харуулах баттай нотолгоо байдаг. Мөн улс орнууд бусад орны бодлогыг хуулбарлан хэрэглэх биш, харин өөрийн эдийн засгийн бүтээмжид саад болж буй сул талуудаа онцлон шийдвэрлэх ёстой.

Тайлбар

- 1 Энд танилцуулсан шинжилгээнд голлох үүрэг гүйцэтгэсэн Кристиан Кетелс, Уайфенг Уэнг нарт би талархал илэрхийлмээр байна. Энэхүү бүлгийг эцэслэн гаргахад ажлыг Лин Поол чадварлагаар удирдан явуулсан болно.
- 2 2004-2005 оны Тайлан-д бид 103 орон хамруулснаас 10 орчимд нь тоон үзүүлэлтийн нийцгүй байдлын асуудал үүсч байв. Ийм учраас бид 2004 оны шинжилгээндээ 93 орныг оруулсан. Энэ жил бид нийт түүврийн хэмжээнд 116 орон оруулснаас 6-д нь тоон үзүүлэлтийн нийцгүй байдлын асуудал үүссэн учраас тэдгээрийг бүрэн шинжилгээнээс хассан болно.
- 3 Сүүлийн жилүүдэд уг загвар сайжирч байгаа учраас энэ хувь багагүй өсөөд байна.
- 4 Тухайлбал, О'Махони, ван Арк нарын 2003 оны бүтээлийг үзнэ үү.
- 5 Үүний дагуу Европын Холбоо хөдөлмөрийн оролцоог нэмэгдүүлэх асуудлыг өрсөлдөх чадварын дээшлүүлэх Лиссабоны Хэлэлцэх Асуудлынхаа нэг гол зорилго болгоод байна. Лиссабоны Европын Зөвлөл, 2000 -г үзнэ үү.
- 6 Эдийн засагчид өөр нэг ялгааг харуулдаг нь компаниуд амжилттай өрсөлдөж чадахгүй бол бизнесээс гардаг бол байрлалын хувьд тэгдэггүй явдал юм. Түүний оронд арай доогуур түвшний хөгжил дэвшилд зохицох замаар байрлалууд хариу үйлчилдэг. Компаниуд ба байрлалуудын энэхүү ялгаа нь зарим нөхцөл байдалд холбогдолтой байдаг боловч энд бол шинжилгээний гол чиглэл маань аливаа байрлалын тогтвортой барьж чадах хөгжил дэвшлийн түвшин учраас нэг их чухал биш.
- 7 Портерийн 2001 оны бүтээлийг үзнэ үү, АНУ-ын таван бүс нутгийн талаарх дэлгэрэнгүй тайлан www.compete.org вэб сайт дээр байгаа.
- 8 Харвардын Их Сургуулийн оюутан Жийн Хэйдэн, Чай МакКоннелл, Петер Тайнэн, Александра Уэст нарын бичсэн тайлан
- 9 Харвардын Их Сургуулийн оюутны багийн 2003 онд бичсэн тайлан.
- 10 Эдгээр үе шатыг анх Портерийн бүтээлд (1990) танилцуулж байсан.
- 11 Хамтын ажиллагааны институцийн тухай санааг Жоржтауны Их Сургуулийн Уиллис Эммонстой хамтарсан бүтээлд гүнзгийрүүлэн хөгжүүлээд байна. Портер, Эммонс нарын 2003 оны бүтээлийг үзнэ үү.
- 12 Бүлэглэлийн санаачилгууд буюу ямар нэг бүлэглэл өрнүүлэх, хөгжүүлэх тодорхой зорилготой тусгай төрлийн Хамтын Ажиллагааны Институцийн тухай судалгааны хувьд, Сөлвелл нарын 2003 оны бүтээлийг үзнэ үү.
- 13 Судалгаанд хамрагдсан орнуудаас энэ тооцоонд Люксембургийг оруулаагүй. Тус улсын эдийн засаг бага хэмжээтэй, цөөн хэдэн салбарт ажил үүргийн хувьд төвлөрсөн, хөрш улсуудын эдийн засагтай бараг бүрэн нэгдсэн учраас бус нутгийн эдийн засаг гэдэг талаас нь ойлгосон нь дээр.
- 14 Дэлхийн Банкны 2004 оны онлайн эх сурвалж <http://rru.worldbank.org/doingbusiness> -г үзнэ үү.
- 15 Кауфманн нарын 2004 оны бүтээлийг дараахь вэбсайтаас үзнэ үү: <http://www.worldbank.org/wbi/governance/pubs/govmat-fers4.html>
- 16 Бид энэ жил ашигласан багц асуулыг ашиглан 2004 оны БӨЧИ-г дахин тооцоолоод байна. Шинэчилсэн 2004 оны зэрэглэл ба нийтлэгдсэн 2004 оны зэрэглэл хоёрын корреляцийн хамаарал 99 хувиас дээгүүр байна.
- 17 Эдгээр шалтгаанд тухайн орнуудад буй ихээхэн олон төрөлт бодит байдал, мөн зохих олон улсын жишгүүдийн талаар хариулагчид сайн мэдэхгүй байх явдал их байгааг оруулж болно.
- 18 Улсын орнуудын хэмжээний зөрүүтэй байдлыг бодвол улсын дотоод дахь зөрүүтэй байдал багатай 57 асуултаас ядаж 40 нь Судалгааны асуулт бүхий орнууд байгаа эсэхийг бид шалгаж байна. Түүврийн дотор хамгийн их олон янзын хариулттай байсан орнуудын тоонд дөнгөж энэ жилээс эхлэн Судалгааны үйл явцад хамрагдсан зарим бага орлоготой орнууд (Бенин, Камерун, Зүүн Тимор, Тажикстан), түүнчлэн мөн л тоон

- үзүүлэлтийн нийцгүй байдлын асуудлаас болж түрүү жилийн БӨЧИ-ээс хасагдаж байсан зарим нэг Африкийн орнууд (Чад, Мали, Уганда) орж байна.
- 19 Ирландын хувьд гадаадын хөрөнгө оруулагчдад зориулан гадагш гарч буй ноогдол ашгийн хэмжээнээс болж бид нэг хүнд ноогдох ДНБ-ий оронд нэг хүнд ноогдох ҮНО-н үзүүлэлтийг ашигласан. Ирландын ДНБ нь ҮНО-оосоо 20 орчим хувь өндөр байна.
 - 20 Үг хүснэгтэд статистик ач холбогдлын 5 хувь=**, 10 хувь=* гэж (бүх хоёр салаа сорилтын хувьд) тэмдэглэсэн.
 - 21 Энэ арга нь бид уг шинжилгээнд татвар ноогдуулалтын урамшуулах нөлөөг оруулахгүй байхад хүргэсэн гэдгийг анхаарна уу. Татвар ноогдуулалт нь нэг хүнд ноогдох ДНБ-тэй шугаман бус хамааралтай байсан бөгөөд уг хамаарал бага орлоготой орнуудад бага, өндөр болон дунд орлоготой орнуудад зарим маш амжилттай хэмжээнд байна.
 - 22 Бид Дэлхий дахины өрсөлдөх чадварын тайлангаар цуглуулж авсан макро эдийн засгийн үзүүлэлтүүдийг ашиглан хоёр хувьсагчийн нэмэлт регрессүүд хийж үзсэн. Эдгээр регрессээс үзэхэд, нэг хүнд ноогдох ДНБ ба макро эдийн засгийн үзүүлэлт бүрийн хооронд ямар нэг статистик хамаарал харагдаагүй. Мөн үүнтэй төстэй үр дүн олж мэдсэн Ийстерлигийн 2001 оны бүтээлийг үзнэ үү.
 - 23 Левайс (2004) болон Портер, Сакакибара (2004) нарын бүтээлийг үзнэ үү.
 - 24 Тухайн таамаглалын бүс нь 95 хувийн дундаж итгэлцлийн бүсээс илүү өргөн хүрээтэй байна. Дундаж итгэлцлийн бүс нь өгөгдсөн өрсөлдөх чадварын түвшинд давтагдсан ажиглалтуудын итгэлцлийн завсраар хангаж өгдөг. Нөгөө талаас, таамаглалын бүсийн арга нь ганц ажиглалтыг таамаглахад угаас тодорхойгүй байдлын түвшин өндөр байдгийг тусган харуулдаг. Иймээс, тоон үзүүлэлтийн цэгүүд регрессийн шугаманд ойр байгаа байдлыг тайлбарлахдаа зохих анхааралтай хандах ёстой. Графикийн "төв"-өөс холдох тусам таамаглалын бүс бага зэрэг өргөсөж байгааг анхаар. Энэхүү төв цэг нь нэг хүнд ноогдох ДНБ-ий дундаж түвшин, хүчин зүйлсийн дундаж онооны огтолцол дээр байрлана.
 - 25 Австрали улсад саяхан аж ахуйн нэгжийн орлогын татварын хувь өөрчлөгдсөн учраас тус улсын татварын тогтолцооны урамшуулах үр нөлөө илт сайжирсанаар бүртгэгджээ. Энэ асуултын хариулууд БӨЧИ-ийн оноо ба байрыг тооцоход ороогүйг анхаарна уу. Учир нь, нийт улс орнуудыг хамарсан түүврийн хувьд энэ үзүүлэлт ба нэг хүнд ноогдох ДНБ-ий хоорондын хамаарал ач холбогдолгүй байв.
 - 26 Японы өрсөлдөөний нөхцөл байдлын тухай илүү дэлгэрэнгүй мэдээллийг Портер нарын 2000 оны судалгаанаас үзнэ үү.
 - 27 Энэ нь эдгээр үзүүлэлтүүд ба БӨЧИ-ийн хооронд өндөр хамаарал байгаа гэсэн үг бөгөөд тэдгээрийн тус бүрийн үр нөлөөг ялган тодорхойлох статистик сорилт бий болгож байна.
 - 28 Газар зүйн байрлалын тоон мэдээллийн тухай дэлгэрэнгүйг Галлап, Закс нарын 1999 оны бүтээлээс үзнэ үү.
 - 29 Дэлхийн Банкны 2004 оны мэдээллийг үзнэ үү.
 - 30 Зимбабве улс уг регрессээс хасагдах үед уг тэгшгэлийн тайлбарлах хүч 12.8 хувьтай тэнцэж байна. Энэ нь БӨЧИ-ийн зэрэглэлд таван жилийн хугацаанд 10 байраар ахихад нэг хүнд ноогдох ДНБ-ий жилийн өсөлт 1.2 хувиар нэмэгдсэнтэй тэнцүү юм.
 - 31 Энэ төслийн тухай нэмэлт мэдээллийг Стратеги ба Өрсөлдөх Чадварын Институтын www.isc.hbs.edu хаягаар үзнэ үү.

Лавлах материалууд

- Baumol, W.J. 2002. *The Free-Market Innovation Machine: Analyzing the Growth Miracle of Capitalism* /Чөлөөт зах зээлийн шинийг санаачлах машин: Капитализмийн өсөлтийн гайхамшигийг шинжлэх нь/, Princeton, NJ: Princeton University Press.
- Barro, R.J. 1991. "Economic Growth in a Cross Section of Countries." /Янз бүрийн орнуудын эдийн засгийн өсөлт/, *Quarterly Journal of Economics* /Улирал тутмын эдийн засгийн сэтгүүл/ 106 (2): 407-433.

- Easterly, W. 2001. *The Elusive Quest for Growth: Economists' Adventures and Misadventures in the Tropics* /Баригдашгүй өсөлтийн эрэлд: Халуун орны бүсэд төөрсөн эдийн засагчдын адал явдал ба азгүйдэл/. Cambridge, MA: MIT Press.
- Easterly, W. and R.Levine. 2002. "Tropics, Germs, and Crops: How Endowments Influence Economic development." /Халуун орны бүс, нянгууд ба үр жимс: Байгалийн хишиг эдийн засгийн хөгжилд хэрхэн нөлөөлдөг вэ/ NBER Working Paper 9106 /ЭЗХҮТ-ний ажлын тайлан/. Cambridge, MA: National Bureau of Economic Research /Эдийн Засгийн Судалгааны Үндэсний Товчоо/.
- Enright, M.J., A.Frances, and E.S.Saavdra. 1994. *Venezuela: El Reto de la Competividad*. /Венесуэл улс/ Caracas: Ediciones IESA.
- Fairbanks, M. and S.Lindsay. 1997. *Plowing the Sea: Challenge of Competitiveness in the Developing World* /Далайг харагах нь: Хөгжиж буй ертөнцөд тулгарч буй өрсөлдөх чадварын тулгамдсан асуудлууд/. Boston: Harvard Business School Press.
- Gallup, J.L. and J.D.Sachs. 1999. *Geography and Economic Development* /Газар зүй ба эдийн засгийн хөгжил/. Center for International Development (CID) Working Paper 1 /Олон Улсын Хөгжлийн Төвийн ажлын тайлан/. Cambridge, MA: March 1999.
- Glaeser, E., R. La Porta, F. Lopez-de-Silanes, and A Shleifer. 2004. *Do Institutions Cause Growth?* /Институциуд өсөлт бий болгодог уу?/, NBER Working Paper 10568 /ЭЗХҮТ-ний ажлын тайлан/. Cambridge, MA: National Bureau of Economic Research /Эдийн Засгийн Судалгааны Үндэсний Товчоо/.
- Hall, R.E. and C.I.Jones. 1999. "Why Do Some Countries Produce So Much More Output per Worker than Others?" /Яагаад зарим орны үйлдвэрлэсэн нэг ажилтанд ноогдох гарц бусдаасаа ийм их байдаг юм бэ?/, *Quarterly Journal of Economics* /Улирал тутмын Эдийн засгийн сэтгүүл/ 114(1): 83-116.
- Hirshman, A.O. 1958. *The Strategy of Economic Development* /Эдийн засгийн хөгжлийн стратеги/. New Haven, CT: Yale University Press.
- Kaufmann, D., A.Kraay, and M.Mastruzzi. 2005. "Governance Matters IV: Governance Indicators for 1996-2004." /Засаглалын асуудлууд IV: 1996-2004 оны засаглалын үзүүлэлтүүд/. Mimeo. Washington, D.C.: World Bank.
- Lewis, W.W. 2004. *The Power of Productivity* /Бүтээмжийн хүч чадал/. Chicago, IL: The University of Chicago Press.
- Lisbon European Council /Лиссабоны Европын Зөвлөл/. 2002. *Presidency Conclusions* /Даргын дүгнэлт/. Lisbon. 23-24 March.
- Lucas, R.E., Jr. 1988. "On Mechanics of Economic Development." /Эдийн засгийн хөгжлийн арга хөшүүргийн тухай/. *Journal of Monetary Economics* 22 /Мөнгөний эдийн засгийн сэтгүүл/. July. 3-42.
- Mankiw, N.G. 1995. "The Growth of Nations." /Үндэстнүүдийн өсөлт/. *Brooks Paper on Economic Activity* 1(1): 275-310 /Эдийн засгийн үйл ажиллагааны Брүүксийн тайлан/.
- Mankiw, N.G., D. Romer, and D.N. Weil. 1992. "A Contribution to the Empirics of Economic Growth." /Эдийн засгийн өсөлтийн тухай туршилт судалгаанд оруулах хувь нэмэр/. *Quarterly Journal of Economics* 107(2): 407-437 /Улирал тутмын Эдийн засгийн сэтгүүл/.
- Nickell, S. 1996. "Competition and Corporate Performance." /Өрсөлдөөн ба корпорацийн үйл ажиллагаа/. *Journal of Political Economy* 104:724-746 /Улс төр, эдийн засгийн сэтгүүл/.
- Northaus, W.D. 1994. "Climate and Economic Development." /Үүр амьсгал ба эдийн засгийн хөгжил/. *In Proceedings of the World Bank Annual Conference on Development Economics 1993*. /Хөгжлийн эдийн засгийн тухай Дэлхийн Банкны жил тутмын бага хурлын тэмдэглэл/. Washington D.C: The International Bank for Reconstruction and Development and World Bank /Сэргээн Босголт Хөгжлийн Олон Улсын Банк ба Дэлхийн Банк/.
- North, D.C. 1990. *Institutions, Institutional Change and Economic Performance: Political Economy of Institutions and Decisions*. /Институциуд, институцийн өөрчлөлт ба эдийн засгийн үйл ажиллагаа: Институци ба шийдвэрийн улс төр эдийн засаг/. Cambridge: Cambridge University Press.
- O'Mahony, M., D. van Ark. eds. 2003. *EU productivity and competitiveness: an industry perspective*. /ЕХ-ны бүтээмж ба өрсөлдөх чадвар: салбарын төлөв байдал/. Brussels: European Commission /Европын Холбоо/.

- Porter, M.E. 1990. *The Competitive Advantage of Nations. /Үндэстнүүдийн өрсөлдөөний давуу талууд/. New York: The Free Press.*
- _____. 1995. "Comment on 'Interaction Between Regional and Industrial Policies: Evidence From Four Countries,'" /Бүс нутгийн ба салбарын бодлогын харилцан ажиллагаа: Дөрвөн орны нотлох баримт/ by J.Markusen." *Proceedings of The World Bank Annual conference on Development Economics 1994. /Хөгжлийн эдийн засгийн тухай Дэлхийн Банкны жил тутмын бага хурлын тэмдэглэл- 1994 он/. Washington, DC: The International Bank for Restruction and Development and World Bank /Сэргээн Босголт Хөгжлийн Олон Улсын Банк ба Дэлхийн Банк/.*
- _____. 1996. "What Is Strategy?" /Стратеги гэж юу вэ?/. *Harvard Business Review 74(6):61-78 /Харвардын Бизнесийн Тойм/.*
- _____. 1998a. "Introduction." *In The Competitiveness Advantage of Nations: With a New Introduction /"Үндэстнүүдийн өрсөлдөөний давуу тал: шинэ удиртгалтай" номын Удиртгал/. New York: the Free Press.*
- _____. 1998b. "Clusters and Competition: New Agendas for Companies, Governments and Institutions." /Бүлэглэлүүд ба өрсөлдөөн: Компаниуд, засгийн газрууд, институциудийн шинэ хэлэлцэх асуудлууд/. *In On Competition /Өрсөлдөөний талаар номонд/. Boston: Harvard Business School Press.*
- _____. 2000a. "Attitudes, Values, Beliefs, and The Microeconomic of Prosperity." /Хандлага, үнэт зүйлс, итгэл үнэмшил ба хөгжил дэвшлийн микро эдийн засаг/. Harrison, L.E. and S.P. Huntington, eds. *Culture Matters /Соёлын асуудлууд/. New York: Basic Books, 2000:14-28.*
- _____. 2000b. "Locations, Clusters, and Company Strategy." /Байрлалууд, бүлэглэлүүд ба компаний стратеги/. In G.L. Clark, M.P. Feldman, and M.S. Gertler, eds. *The Oxford Handbook of Economic Geography /Эдийн засгийн газар зүйн Оксфордын гарын авлага/. New York: Oxford University Press, 2000: 253-274.*
- _____. 2001. Council on Competitiveness, and Monitor Group. *Clusters of Innovation Initiative: Regional Foundations of U.S. Competitiveness /Шинийг санаачлагч бүлэглэлүүд: АНУ-ын өрсөлдөх чадварын бүс нутгийн үндэс сууриуд/. Washington, DC: Council on Competitiveness /Өрсөлдөх Чадварын Зөвлөл/.*
- _____. 2003. "The Economic Performance of Regions." /Бүс нутгуудын эдийн засгийн гүйцэтгэл/. *Regional Studies 37(6&7): 549-678 /Бүс нутаг Судлал/.*
- Porter, M.E. and M.Sakakibara. 2004. "Competition in Japan." /Япон дахь өрсөлдөөн/. *Journal of Economic Perspective /Эдийн засгийн төлөв байдлын сэтгүүл/. Winter.*
- Porter, M.E., C.Ketels, K.Miller, and R.Bryden. 2004. *Competitiveness in Rural U.S.Regions: Learning and Research Agenda. /АНУ-ын хөдөө дэх өрсөлдөх чадвар: Суралцах болон судлах асуудлууд/. Washington, D.C.: U.S.Economic Development Administration /АНУ-ын Эдийн Засгийн Хөгжлийн Удирдах Газар/.*
- Porter, M.E. and W.Emmons. 2003. "Institutions for Collaboration: Overview". /Хамтын ажиллагааны институциуд: Ерөнхий тойм/. Harvard Business School case 9-703.436.
- Porter, M.E. and T.Hirotaka, with B.Sakakibara. 2000. *Can Japan Compete? /Япон улс өрсөлдөж чадах уу?/. Bashingstoke, England, and New York: Macmillan and Basic Books.*
- Porter, M.E. and C.Ketels. 2003. *UK Competitiveness: Moving to the Next Stage. /Их Британын өрсөлдөх чадвар: шинэ шатанд орж байна/. DTI Economics Paper 3.*
- Porter, M.E. and C. van der Linde. 1995. "Toward a New Conception of the Encironment-Competitiveness Relationship." /Байгаль орчин ба өрсөлдөх чадварын тухай шинэ үзэл баримтлалын зүг/. *Journal of Economic Perspectives 9(4): 97-118 /Эдийн засгийн төлөв байдлын сэтгүүл/.*
- Romer, P.M. 1990. "Endogenous Technological Change." /Дотооддоо бий болгох технологийн өрчлөлт/. *Journal of Political Economy 98(5):S71-S102 /Улс төр, эдийн засгийн сэтгүүл/.*
- Sachs, J.D. and A.Warner. 1995. "Economic Reform and the Process of Global Integration." /Эдийн засгийн шинэчлэл ба дэлхий нийтийн интеграцилалын үйл явц/. *Brookings Paper on Economic Activity 1(1):1-118 /Эдийн Засгийн Үйл Ажиллагааны Брүүксийн Тайлан/.*
- Sakakibara, M. and M.E.Porter. 1998. "Competing at Home to Win Abroad: Evidence from Japanese Industry." /Гадаад өрсөлдөөнд ялахын тулд дотооддоо өрсөлдөхүй: Японы аж үйлдвэрийн жишээ баримт/. Harvard Business School Working Paper 99-036 /Харвардын Бизнесийн Сургуулийн Тайлан/. Cambridge, MA: Harvard Business School Press.
- Solow, R.M. 1956. "A Contribution to the Theory of Economic Growth." /Эдийн засгийн өсөлтийн хөгжилд оруулах нэг хувь нэмэр/. *Quaterly Journal of Economics 70(1): 65-94 /Улирал тутмын Эдийн засгийн сэтгүүл/.*
- Solvell, O., G. Lindqvist, and C.Ketels. 2003. "The Cluster Initiative Greenbook." /Бүлэглэлийн санаачилгын тухай ногоон ном/. Stockholm: November.
- World Bank. 2004. *Doing Business in 2005: Removing Obstacles to Growth. /Бизнес эрхлэх нь 2005: Өсөлтийн саад бэрхшээлүүдийг арилгах нь/. New York: Oxford University Press.*

Хавсралт А: Судалгааны хариултуудын АНОВА (ANOVA) шинжилгээ

I. КОМПАНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА БА СТРАТЕГИ		R2	II. ҮНДЭСНИЙ БИЗНЕСИЙН ОРЧИН		R2
Үйлдвэрлэлийн үйл явцын боловсронгуй байдал		0.467	Б. ЭРЭЛТИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ		
Өрсөлдөөний давуу талын мөн чанар		0.392	Худалдан авагчдын боловсронгуй байдал		0.361
Ажилтнуудад зориулсан сургалтын цар хүрээ		0.362	Засгийн газрын дэвшилтэт технологийн бүтээгдэхүүний хангамж		0.186
Маркетингийн цар хүрээ		0.393	Эрэлт хэрэгцээтэй зохицуулалтын стандартууд байгаа байдал		0.440
Эрх мэдлийг төлөөлүүлэхэд бэлэн байдал		0.282	МХТ-той холбоотой хуулиуд		0.395
Шинийг санаачлах чадавхи		0.406	Байгаль орчны зохицуулалтуудын хатуу чанд байдал		0.447
Компаний судалгаа, хөгжлийн ажилд зарцуулах хөрөнгө		0.363	V. ХОЛБОГДОХ БА ДЭМЖИХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРУУД		
Үнэт зүйлийн гинжин хэлхээ байгаа байдал		0.457	Дотоодын нийлүүлэгчдийн чанар		0.382
Олон улсын зах зээлийн хамрах хүрээ		0.461	Дотоодод боловсруулах машин техник бэлэн байгаа байдал		0.327
Хэрэглэгчид хандсан байдлын түвшин		0.240	Дотоодод төрөлжсөн судалгаа, сургалтын үйлчилгээ байгаа байдал		0.330
Олон улсын түгээлтийн хяналт		0.182	Дотоодын нийлүүлэгчдийн тоо хэмжээ		0.247
Мэргэжлийн удирдлагад найдах байдал		0.311	Г.КОМПАНИЙ СТРАТЕГИ БА ӨРСӨЛДӨӨНИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ		
Идэвх санаачилгыг урамшуулах цар хүрээ		0.274	1. Урам зориг		
Бүс нутгийн борлуулалтын цар хүрээ		0.381	Төрийн албан тушаалтнуудын шийдвэрт тал тохой татах байдал		0.257
Гадаадын технологийн лицензийн эрх зонхилох байдал		0.237	Ажил эрхлэгч, ажил олгогчийн харилцааны хамтын ажиллагаа		0.205
II. ҮНДЭСНИЙ БИЗНЕСИЙН ОРЧИН	R2		Компаниудын удирдах зөвлөлийн үр ашигтай байдал		0.166
A. ХУЧИН ЗҮЙЛСИЙН НӨХЦӨЛ БАЙДЛУУД			Оюуны өмчийн хамгаалалт		0.468
1. Биет дэд бүтэц			Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийн хамгаалалт		0.277
Дэд бүтцийн ерөнхий чанар		0.594	2. Өрсөлдөөн		
Төмөр замын дэд бүтцийн хөгжил		0.622	Дотоодын өрсөлдөөний эрчим		0.228
Боомтын дэд бүтцийн чанар		0.533	Монополийн эсрэг бодлогын үр нөлөө		0.369
Агаарын тээврийн дэд бүтцийн чанар		0.402	Корпорацийн үйл ажиллагааны төвлөрлийг сааруулалт		0.314
Цахилгаан эрчим хүчний хангамжийн чанар		0.544	Авилгалаас бизнест учруулах зардал		0.314
Телефон, факсын дэд бүтцийн чанар		0.396	Худалдааны саад тотгорууд зонхилох байдал		0.208
2. Захиргааны дэд бүтэц			Эдийн засгийн бодлого боловсруулалтын төвлөрөл		0.232
Цагдаагийн үйлчилгээний найдвартай байдал		0.381	Гадаадын өмч эзэмшилд тавих хязгаарлалт		0.242
Шүүхийн хараат бус байдал		0.439			
Эрх зүйн хүрээний үр ашигтай байдал		0.409			
Хүнд суртлын зохицуулалтуудын цар хүрээ		0.088			
3. Хүний нөөц					
Менежментийн сургуулиудын чанар		0.430			
Улсын сургуулиудын чанар		0.484			
Боловсролын тогтолцооны чанар		0.310			
Математик, шинжлэх ухааны боловсролын чанар		0.374			
4. Технологийн дэд бүтэц					
Эрдэмтэд, инженерүүдийн хүрэлцээ		0.301			
Шинжлэх ухааны судалгааны институтуудийн чанар		0.376			
Их дээд сургууль ба үйлдвэрлэлийн судалгааны хамтын ажиллагаа		0.331			
5. Капиталын зах зээл					
Санхүүгийн зах зээлийн боловсронгуй байдал		0.516			
Үйлдвэрлэлийн капиталын бэлэн байдал		0.277			
Зээл авахад хялбар дөхөм байдал		0.262			
Дотоодын хөрөнгийн зах зээлд нэвтрэх боломж		0.393			

Хавсралт Б: Хоёр хувьсагчийн регрессийн дүн, хамаарах хувьсагч: 2004 оны нэг хүнд ноогдох ДНБ (ХАЧТ-гээр тохируулсан)

	Бүх орнууд (N=110)			Бага орлоготой орнууд (N=28) нэг хүнд ноогдох ДНБ < \$4,000			Дунд орлоготой орнууд (N=48) \$4,000 < нэг хүнд ноогдох ДНБ < \$17,000			Өндөр орлоготой орнууд (N=34) нэг хүнд ноогдох ДНБ > \$17,000		
	Дундаж	Ст.хазайлт	Тох. R2	Дундаж	Ст.хазайлт	Тох. R2	Дундаж	Ст.хазайлт	Тох. R2	Дундаж	Ст.хазайлт	Тох. R2
I. КОМПАНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА БА СТРАТЕГИ												
Үйлдвэрлэлийн үйл явцын боловсронгуй байдал	3.87	1.13	8704.2**	0.818	2.83	0.51	1025.7**	0.233	3.53	0.55	3851.8**	0.363
Өрсөлдөөний давуу талын мөн чанар	3.60	1.09	8269.2**	0.688	2.85	0.44	463.3	0.003	3.11	0.44	230.80	-0.021
Ажилтнуудад зориулсан сургалтын цар хүрээ	3.84	0.98	9152.0**	0.676	3.08	0.56	309.4	-0.009	3.54	0.57	2638.2**	0.174
Маркетингийн цар хүрээ	4.41	0.98	8696.6**	0.620	3.52	0.68	519.9*	0.084	4.23	0.68	2277.4**	0.184
Эрх мэдлийг төлөөлүүлэхэд бэлэн байдал	3.72	0.92	9494.0**	0.648	3.11	0.51	197.9	-0.029	3.40	0.50	3073.0**	0.184
Шиний санаачлах чардавхи	3.52	1.08	7869.1**	0.608	2.82	0.45	1050.0**	0.177	3.11	0.54	1574.6*	0.041
Компаний судалгаа, хөгжилд заруулах хөрөнгө	3.34	0.95	8568.8**	0.563	2.74	0.43	413.0	-0.007	3.02	0.47	2596.2**	0.105
Үнэт зүйлийн гинжин хэлээ байгаа байдал	3.86	1.24	6653.3**	0.571	2.96	0.65	745.1**	0.193	3.45	0.75	1273.2*	0.056
Олон улсын зах зээлийн хамрах хүрээ	3.87	1.27	6715.6**	0.621	2.88	0.73	523.9*	0.103	3.50	0.91	1578.2**	0.153
Хэрэглэгчид хандсан байдлын түвшин	4.65	0.76	10982.8**	0.583	4.09	0.54	106.2	-0.035	4.43	0.55	1843.3**	0.065
Олон улсын түгээлтийн хяналт	4.13	0.67	11432.9**	0.503	3.61	0.50	246.4	-0.024	3.98	0.48	1027.80	-0.001
Мэргэжлийн удирдлагад найдах байдал	4.56	0.91	8688.1**	0.531	4.00	0.71	-389.3	0.037	4.28	0.66	2668.5**	0.247
Ирээх санаачилгыг урамшуулах цар хүрээ	4.07	0.86	9607.9**	0.572	3.41	0.54	738.7**	0.116	3.89	0.66	2508.0**	0.209
Бус нутгийн борлуулалтын цар хүрээ	4.53	1.11	6978.1**	0.505	3.65	0.72	528.8*	0.102	4.35	0.91	1662.7**	0.173
Гадаадын технологийн лиценз зонхилох байдал	4.38	0.85	8466.9**	0.436	3.66	0.73	62.6	-0.036	4.26	0.73	1954.5**	0.151

II. ҮНДЭСНИЙ БИЗНЕСНИЙ ОРЧИН

A. ХҮЧНИЙ ЗҮЙЛСЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

1. Биет дэд бүтэц

Дэд бүтцийн ерөнхий чанар	3.93	1.37	6744.4**	0.721	2.74	0.45	759.8*	0.076	3.52	0.94	1705.7**	0.196
Төмөр замын дэд бүтцийн хөгжил	3.06	1.57	4438.8**	0.408	2.23	0.84	349.9	0.045	2.60	1.19	1155.4**	0.140
Боомтын дэд бүтцийн чанар	3.86	1.41	5946.2**	0.592	2.69	0.93	296.5	0.035	3.49	1.00	1198.3**	0.102
Агаарын тээврийн дэд бүтцийн чанар	4.65	1.06	7795.7**	0.580	3.89	0.53	377.6	0.000	4.27	0.88	1045.6*	0.051
Цахилгаан эрчим хүчний хангамжийн чанар	4.67	1.43	6331.8**	0.696	3.07	0.70	763.1**	0.238	4.54	1.01	1768.3**	0.249
Телефон, факсын дэд бүтцийн чанар	5.51	1.10	6712.3**	0.463	4.43	0.95	303.7	0.043	5.44	0.91	962.1*	0.043
100 хүнд ноогдох гар утас (2003)	41.05	33.25	283.4**	0.754	5.87	5.08	113.2**	0.284	32.52	18.56	120.8**	0.408
10,000 хүнд ноогдох интернет ашиглагч (2003)	1939.0	1920.0	5.0**	0.793	241	220	2.2**	0.187	1260	1029	2.2**	0.419

2. Захиргааны дэд бүтэц

Цагдаагийн үйлчилгээний найдвартай байдал	4.17	1.16	7128.3**	0.560	3.44	0.71	85.0	-0.035	3.71	0.94	927.3*	0.043
Шүүхийн хараат бус байдал	3.82	1.38	5874.1**	0.553	2.88	1.03	-267.2	0.035	3.37	1.08	1386.3**	0.157
Эрх зүйн хүрээний үр ашгтай байдал	3.79	1.20	7012.0**	0.597	2.95	0.73	-134.8	-0.029	3.41	0.92	1573.6**	0.157
Хүнд суртлын зохицуулалтуудын цар хүрээ	5.42	0.36	16120.8**	0.276	5.19	0.26	942.9	0.020	5.38	0.36	2462.7*	0.044

3. Хүний нөөц

Менежментийн сургуулиудын чанар	4.15	1.01	7618.8**	0.501	3.37	0.70	367.1	0.026	3.99	0.78	1751.7**	0.137
Улсын сургуулиудын чанар	3.79	1.28	7201.0**	0.725	2.61	0.50	1009.3**	0.212	3.47	0.95	2460.3**	0.449
Боловсролын тогтолцооны чанар	3.70	0.98	8509.8**	0.586	3.04	0.62	30.4	-0.038	3.38	0.72	2500.2**	0.256
Математик, шинжлэх ухааны боловсролын чанар	4.13	1.01	6373.0**	0.346	3.49	0.77	525.1**	0.121	3.95	0.96	1716.1**	0.212

Хавсралт Б: Хоёр хувьсагчийн регрессийн дүн, хамаарах хувьсагч: 2004 оны нэг хүнд ноогдох ДНБ (ХАЧТ-гээр тохируулсан) /үргэлжлэл/

	Бүх орнууд (N=110)		Бага орлоготой орнууд (N=28) нэг хүнд ноогдох ДНБ < \$4,000		Дунд орлоготой орнууд (N=48) \$4,000 < нэг хүнд ноогдох ДНБ < \$17,000		Өндөр орлоготой орнууд (N=34) нэг хүнд ноогдох ДНБ > \$17,000	
	Дундаж	Тох. R2	Дундаж	Тох. R2	Дундаж	Тох. R2	Дундаж	Тох. R2
4. Технологийн дэд бүтэц								
Сая хүнд ноогдох патентын тоо (2004)	24.44	57.40	127.2**	0.449	0.10	0.21	1410.2	0.043
Эрдэмтэд, инженерүүдийн хүрээлээ	4.58	0.90	7120.2**	0.347	4.06	0.88	412.7*	0.090
ШУ-ы судалгааны институтуудийн чанар	3.90	0.98	8039.2**	0.527	3.36	0.63	211.5	-0.021
ИДС ба үйлдвэрлэлийн хамтын ажиллагаа	3.18	0.95	8753.3**	0.588	2.54	0.41	424.7	-0.008
5. Капиталын зах зээл								
Санхүүгийн зах зээлийн боловсронгуй байдал	4.06	1.25	7003.2**	0.646	3.01	0.73	418.6	0.053
Үйлдвэрлэлийн капиталын бэлэн байдал	3.33	0.95	9306.5**	0.658	2.63	0.53	598.6	0.061
Зээл авахад хялбар дөхөм байдал	3.34	0.96	9169.3**	0.660	2.54	0.58	331.5	-0.002
Дотоодын хөрөнгийн зах зээлд нэвтрэх боломж	4.81	1.24	5265.9**	0.358	4.02	1.36	32.8	-0.037
Б. Эрэлтийн нөхцөл байдал								
Худалдан авагчдын боловсронгуй байдал	4.14	1.07	8278.3**	0.665	3.31	0.79	381.8	0.050
ЗГ-ын дэвшилтэт бүтээгдэхүүний хангамж	3.70	0.64	10206.4**	0.354	3.36	0.53	-191.2	-0.028
Эрэлт хэрэгцээтэй зохицуулалтын стандартууд	4.31	1.06	8938.0**	0.757	3.36	0.50	184.0	-0.030
МХТ-той холбоотой хуулиуд	3.81	1.09	8384.5**	0.703	2.82	0.47	518.4	0.019
Байгаль орчны зохицуулалтын хатуу чанд байдал	4.00	1.21	7672.6**	0.728	3.06	0.49	112.1	-0.036
В. Холбогдох ба дэмжих үйлдвэрлэл								
Дотоодын нийлүүлэгчдийн чанар	4.45	0.96	9605.8**	0.727	3.53	0.58	639.5*	0.097
Боловсруулах машин техникийн бэлэн байдал	2.90	1.00	6872.2**	0.395	2.30	0.63	409.8	0.026
Төрөлжсөн судалгаа, сургалт үйлчилгээний бэлэн байдал	4.05	0.96	8875.0**	0.612	3.27	0.54	799.8**	0.142
Дотоодын нийлүүлэгчдийн тоо хэмжээ	4.80	0.76	10421.7**	0.527	4.16	0.64	256.8	-0.012
Г. КОМПАНИЙ СТРАТЕГИ БА ӨРСӨЛДӨӨНИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ								
1. Урамшуулал								
Төрийн АТ-дын шийдвэрт тал тохой татах байдал	3.22	0.87	8732.2**	0.491	2.71	0.52	-178.8	-0.030
Ажил эрхлэгч, ажил олгогчдын хамтын ажиллагаа	4.52	0.70	8574.2**	0.300	4.28	0.49	255.2	-0.023
Компаний удирдах зөвлөлийн үр ашгтай байдал	4.58	0.61	12119.6**	0.455	4.25	0.43	-882.4*	0.100
Оюуны өмчийн хамгаалалт	3.70	1.23	7744.8**	0.766	2.73	0.47	134.6	-0.035
Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг	4.41	0.87	8461.1**	0.461	3.94	0.71	-202.3	-0.019
2. Өрсөлдөөн								
Дотоодын өрсөлдөөний эрчим	4.79	0.76	10190.7**	0.505	4.18	0.64	103.9	-0.034
Монголын эсрэг борлогын үр нөлөө	3.99	1.04	8150.8**	0.614	3.20	0.59	-354.0	0.004
Корпорацийн үйл ажиллагааны төвлөрлийн сааруулалт	3.91	0.98	8615.2**	0.608	3.18	0.69	43.9	-0.038
Авилгаас бизнесет учруулах зардал	4.42	1.10	8298.5**	0.707	3.59	0.53	303.6	-0.014
Хуульдааны саад тогтооруд зонхилох байдал	4.59	0.85	8490.0**	0.441	3.91	0.56	-261.7	-0.017
Эдийн засгийн борлого боловсруулалтын төвлөрөл	3.06	0.87	6942.8**	0.304	2.72	0.61	40.8	-0.038
Гадаадын өмч эзэмшилд тавих хязгаарлалт	5.01	0.73	6587.1**	0.192	4.77	0.65	71.1	-0.036

p < 0.10 бол *, p < 0.05 бол **, p < 0.01 бол *** гэж тэмдэглэв.

Өрсөлдөх чадварын
тухай сонгож авсан асуудлууд

2-р бүлэг

Засаглал, авилгал хоёрын тухай домог ба бодит байдал

ДАНИЕЛ КАУФМАНН¹, Дэлхийн Банк

Засаглал, авилгал хоёр маргаантай, үл ойлгогдох сэдвүүд хэвээр байна. Гэвч одоо хөгжлийн мөчлөгүүдийн хүрээнд энэ хоёр асуудалд илүү өндөр ач холбогдол өгөх болсон бөгөөд бизнесийн салбарынхан, түүний дотор үндэстэн дамнасан корпорацууд мөн тэгж хандах болсон байна.

Үнэн хэрэгтээ, зарим хандивлагчид, олон улсын санхүүгийн институциуд авилгалыг багасгах, иргэдийн дуу хоолой, хүйсийн тэгш байдал, хариуцлагат байдлыг нэмэгдүүлэхэд туслах талаар шинээр төрөн гарч буй эдийн засагтай орнуудтай улам бүр тулж ажиллах болжээ. 2005 оны Давосын Дэлхийн Эдийн Засгийн Чуулга Уулзалтын үеэр голлох салбаруудад ажиллаж буй 63 үндэстэн дамнасан корпораци бизнесийн авилгал хянах багц зарчмуудын хүрээнд ажиллах тохиролцоонд хүрснийг онцлон тэмдэглэжээ. Цаашлаад, дэлхийн 29 улс нэгэнт гарын үсэг зураад байгаа, мөн хэсэг хөгжиж буй орон гарын үсэг зурахын даваан дээр ирээд байгаа², бараг хоёр жилийн өмнөөс гарын үсэг зурагдаж эхэлсэн Авилгалын эсрэг НҮБ-ын конвенци хүчин төгөлдөр болох дөхөж байгаа бөгөөд энэ тохиолдолд авилгалч удирдагч нарын хууль бусаар олж гадаадад нуусан хөрөнгийг эх оронд нь буцаах зэрэг олон арга хэмжээ авахыг шаардах болно³.

Бас 2005 оны 7 дугаар сард Их Наймын бүлгийн орнууд Африкийн хамгийн ядуу орнуудад олгох тусламжаа хоёр дахин нэмэгдүүлж, өрөөс чөлөөлөх шийдвэр гаргаснаа зарласнаар засаглалын асуудал улам бүр анхаарал татах болов. Саяхан Африкийн Комисстой хамтарсан мэдэгдэлдээ илэн далангуй мэдэгдсэнчлэн, «Сайн засаглал бол амин чухал... Чадавхи, хариуцлагат байдлыг дээшлүүлж, авилгалыг багасгахгүйгээр... бусад шинэчлэлийн үр нөлөө хязгаарлагдмал байх болно.» Дэлхийн бусад бүс нутагт ч үүнтэй төстэй мэдэгдлүүд гарч байгаа төдийгүй ЭЗХАХБ-ын гишүүн орнууд ба үндэстэн дамнасан корпорациуд дахь авилгалыг улам бүр нарийвчлан шалгаж байна.

Гэвч өсөлт, хөгжил, аюулгүй байдалд сайн засаглал, авилгалын хяналт хоёр үнэхээр гол гэж үү? Сүүлийн арван жилд хийсэн олон туршилт судалгаа, улс орнуудын өөрсдийн туршлагаас олж авсан сургамж нь засаглалаас хөгжилд үзүүлэх олон тооны үр нөлөөг төдийгүй түүнийг сайжруулах стратегийн үр нөлөөтэй эсвэл дутагдалтай талыг үнэлж дүгнэх илүү баттай үндэс суурийг бидэнд өгч байна. Бид Дэлхий дахины өрсөлдөх чадварын тайланд

оруулах хувь нэмэр болгож сүүлийн жилүүдэд⁴ засаглалын талаарх хэд хэдэн сэдвийг сонгож танилцуулсан. Жил бүр Дэлхийн Эдийн Засгийн Форумас хийдэг Бизнесийн удирдлагуудын санаа бодлын Судалгааны шинжилгээнээс гарсан болон өмнөх ДДӨЧТ-ийн бүлгүүдэд оруулж танилцуулсан санаануудад засаглалын тодорхойлогч хүчнүүдийг хотын түвшинд судлах асуудал; зохисгүй нөлөөллийн анатоми; олон тооны хувийн компаниуд, үндэстэн дамнасан корпорациуд, төрийн албан тушаалтнууд оролцсон хээл хахуулийн хэрэг, тэдгээрийн илрүүлэлт; мөн засаглал, авилга болон аюулгүй байдлын аюул заналын уялдаа холбоо зэрэг асуудал орж байна.

Дуусаагүй ажлууд

Энэ чиглэлд олон зохиогч маш их хувь нэмэр оруулсныг эс тооцвол, зөвхөн засаглал ба авилгалын асуудлын ач холбогдлын талаар төдийгүй олон улсын хамтын нийгэмлэг, түүний дотор хувийн салбарын зүгээс эдгээр чиглэлд сайжруулалт хийж буй орнуудад туслахад бэлэн байдал ба туслах чадварын талаарх мэтгэлцээн ба шийдвэрлэгдээгүй ноцтой асуудлууд хөгжлийн хамтын нийгэмлэгийнхний хүрээнд байсаар байна.

Уг асуудлаарх энэ жилийн бүлэгт бид шийдвэрлэгдээгүй байгаа буюу олон түмэнд ихээхэн танил болсон гол сорилт бэрхшээлүүдийг нэгтгэн танилцуулж байна. Бидний үзэж байгаагаар тэдний зарим нь ердөө л домог юм. Хэт хялбарчлахгүй байхаас болгоомжлох, ойлгомжтой тайлбарлах, мэтгэлцээн өрнүүлэх үүднээс бид эдгээр шийдвэрлэгдээгүй, буруу ташаа ойлголт төрүүлдэг асуудлыг засаглал ба авилгын домог гэж танилцуулсан хэдий ч, илүү нарийн өнгө аястай бодитой зүйл олон байдаг гэдгийг анхнаасаа хүлээн зөвшөөрч байгаа. Жишээ болгонд бид мэдээж санал нийлэхгүй байгаа зүйлсээ «домог» хэмээн танилцуулаад, яагаад ингэж бодох нь буруу гэж үзэж байгаагаа тайлбарлан ярилцаж байна. Найман домгийн дараа бид ил тод байдлын чиглэлээр дутуу анхаарч байгаа оролцох асуудлууд дээр нэмж хэвлэлийн эрх чөлөө, хүйсийн тэгш байдлын асуудлыг хөндөж байна. Хэрвээ хэрэгжиж чадвал эдгээр шинэчлэл нь дараагийн шатанд засаглалыг болон авилгалын эсрэг тэмцлийг сайжруулахад ихээхэн нөлөө үзүүлж болох юм.

Домог №1: Тодорхойлолт: Засаглал, авилгалын эсрэг ажиллагаа хоёр бол нэг ижил зүйл

Засаглал гэдгийг бид аливаа орны эрх бүхий этгээдийн бүх нийтийн сайн сайхны төлөө ашигладаг ёс заншил ба институци гэж тодорхойлдог. Үүнд:

- Тэдгээр эрх бүхий этгээдийг сонгох, хянах, солих үйл явц (улс төрийн хэмжүүр);
- Засгийн газраас нөөц баялгаа үр нөлөөтэй удирдаж, сайн бодлого хэрэгжүүлэх чадавхи (эдийн засгийн хэмжүүр);
- Иргэдийг хүндэтгэх байдал ба тухайн улсын институциудийн байдал (институцийн хүндэтгэлийн хэмжүүр) орно.

Гэтэл нөгөө талаас, авилгалын тухайд «хувийн ашиг хонжооны төлөө төрийн албан тушаалыг буруугаар ашиглах явдал» гэсэн илүү явцуу уламжлалт тодорхойлолт байдаг. Бид өнгөрсөн жилийн ДДӨЧТ-ийн засаглалын тухай бүлэгтээ, авилгалын тухай энэ тодорхойлолт төрийн албан тушаалд болон уг хуулийн нүд хуурсан ёс төдий байдалд хэтэрхий их анхаарч байна хэмээн шүүмжилсэн билээ. Авилгал бол хувийн салбарынхан ч хариуцлагыг нь хуваалцдаг төдийгүй, бас ёс зүйгүй (улмаар авилгалч гэж үзэж болох) боловч заавал хууль бус гэж үзэх албагүй олон үйлдэл байдаг илүү өргөн хүрээтэй үзэгдэл гэдэг утгаар нь бид авилгалыг шинжилсэн. Төрийн бодлого, хууль тогтоомж, зохицуулалтыг өөрсдийн ашиг сонирхолд нийцүүлэн гаргахыг хүссэн олон хүчирхэг хувийн компаниудын энэхүү зохисгүй нөлөөлөлд оролцож буй цар хүрээг харуулсан туршилтын нотлох баримтуудыг бид гаргаж танилцуулсан. Мөн үүнтэй холбоотойгоор, кампанит ажилд зориулан өргөж байгаа хандивын хэмжээг бид онцлон авч үзсэн бөгөөд энэ нь үнэн хэрэгтээ хууль ёсны үйлдэл боловч хувийн ашиг хонжооны төлөө тоглоомын дүрмэнд зохисгүй нөлөө үзүүлж байж болно. Түүнчлэн төрийн хангамж, үйлчилгээний тендерийн болон гэрээний эрх олгохдоо тодорхой компаниудыг тал тохой татах байдал өргөн дэлгэр байгааг Судалгааны үр дүн харуулсан.

Мэтгэлцээн өрнүүлэх үүднээс бид авилгал юунаас бүтдэг тухай илүү өргөн хүрээтэй тодорхойлолтын хувилбарыг санал болгосон буюу тухайлбал «төрийн бодлогын хувьчлал» гэж нэрлэсэн бөгөөд үүнд төрийн үйлчилгээг

хүртэх боломж бол төрийн бодлогод орно гэж үзсэн. Энэхүү илүү төвийг сахисан тодорхойлолтоор бол, аливаа үйлдлийг илүү өргөн утгаар нь авилгал гэж үзэхийн тулд тэр үйлдэл заавал хууль бус байх албагүй юм. Жишээлбэл, мэдээлэл харилцаа эсвэл эрчим хүч гэх мэт ямар нэг салбарын бодлого тодорхойлоход хууль тогтоогчид саналаа өгч, гүйцэтгэх засаглалынхан шийдвэр гаргадаг бөгөөд үүнд нь хууль тогтоогчдын хувийн компанид ажилд хандив өргөх замаар юмуу эсвэл шийдвэр гаргагчдад хувийн тал засах байдлаар зохисгүй нөлөөлсөн байдаг. Энэ тохиолдолд, хэдийгээр хууль бус үйлдэл биш байсан ч гэсэн авилгал явагдсанд тооцох юм. Мөн ийм өргөн хүрээтэй тодорхойлолтоор бол *зохисгүй нөлөөлөл үзүүлж байгаа болон уг зохисгүй нөлөөнд автаж байгаа хүмүүсийн аль аль нь хариуцлага хүлээх юм*. Бид бас өнгөрсөн жилийн Судалгааны туршилтын үр дүнд тулгуурлан энэхүү өргөн хүрээтэй тодорхойлолтын хүрээнд авилгалын индексийг дүрслэн гаргасан нь хувийн салбарын үйл ажиллагаанд түлхүү анхаарал хандуулж байна. Авилгалын тухай энэхүү илүү нарийн бөгөөд цэвэр хууль ёсны чанартай бус тодорхойлолтыг шинжилгээндээ ашиглах үед ЭЗХАХБ-ын хэд хэдэн баян орон нилээд муу явж байгааг бид олж тогтоосон.

Авилгалын тодорхойлолтуудын хувилбарын тухай иймэрхүү маргааныг эс харгалзвал, засаглал хэмээх ойлголтын цар хүрээ авилгалынхаас хамаагүй өргөн болох нь тодорхой байна. Засаглал, авилгал хоёр холбоотой байж болно, гэхдээ энэ хоёр бол шал өөр ойлголтууд бөгөөд тэднийг нэг ижил зүйл мэт авч үзэх ёсгүйг бид хойно харах болно.

Домог №2: Засаглал, авилгал хоёрыг хэмжиж болохгүй

Арван хоёр жил хүрэхгүй хугацааны өмнө засаглал эсвэл авилгалыг хэмждэг харьцуулж болохуйц, дэлхий нийтийг хамарсан хэмжүүр цөөхөн байлаа. Тэгвэл сүүлийн жилүүдэд Дэлхийн Банк (Засаглалын үзүүлэлтүүд), Дэлхийн Эдийн Засгийн Форум (Бизнесийн удирдлагуудын санаа бодлын судалгаа), Транспаренси Интернэшнл (Авилгалын ухамсарын индекс), Фрийдом Хаус (Улс төр, иргэний эрх чөлөө ба хэвлэлийн эрх чөлөө) болон бусад олон байгууллагын хүчин чармайлтаар дамжуулан бид энэхүү түгээмэл ойлголтыг сөрөхийг эрмэлзэж байна.

Дэлхийн Банкинд засаглалыг илүү

нарийн тодорхойлж, хэмжих үүднээс бид эдгээр нэгдмэл Засаглалын Үзүүлэлтүүдийг боловсруулсан бөгөөд одоогоор дэлхий дээр буй хэдэн арван байгууллагаас олж авсан 350 гаруй хувьсагчид тулгуурлан 200 гаруй орныг хамруулж байгаагийн дотор энэхүү Судалгаа орж байна. Уг Засаглалын үзүүлэлтүүд нь институцийн чанар ба засаглалын зургаан гол хэмжээсийг хамруулан, дээр дурдсан засаглалын улс төр, эдийн засаг, институцийн хэмжээс бүрт хоёр үзүүлэлт хэрэглэн хэмжиж байна. Дараахь зургаан хэмжээсийн дагуу хэмжилт хийж байна:

1. *Уг хэлэх эрх ба хариуцлагатай байдал*- улс төрийн, иргэний, хүний эрхүүдийг хэмждэг.
2. *Улс төрийн тогтворгүй байдал ба хүчирхийлэл*- төр засагт учирч болох буюу төр засгийн өөрчлөлтөд хүргэж болох хүчирхийллийн аюул заналуудыг, түүний дотор терроризмыг хэмждэг.
3. *Засгийн газрын үр ашигтай байдал*- Төрийн албан хаагчдын мэдлэг чадвар, төрийн үйлчилгээний чанарыг хэмждэг.
4. *Зохицуулалтын дарамт*- зах зээлд үл нийцэх бодлогын гаралтыг хэмждэг
5. *Хуулийн хэрэгжилт*- гэрээний биелэлт, цагдаа, шүүхийн чанар болон гэмт хэрэг, хүчирхийлэл гарах магадлалыг хэмждэг.
6. *Авилгалын хяналт*- төрийн эрх мэдлийг хувийн ашиг хонжооны төлөө ашиглах явдал, түүний дотор том, жижиг авилгалын аль алиныг болон ийм хэргийн илрүүлэлтийг хэмждэг.

Засаглалын үзүүлэлтүүд бол урагшаа ахисан нэг томоохон алхам боловч энд хэмжилтийн хүндрэл бүрхшээлүүд ч бас байдаг. Алдааны хязгаарууд хэвийн бус бөгөөд үр дүнг тайлбарлах сануулгууд нь баталгаажсан байдаг. Өөрөөр хэлбэл, улс орнуудын зэрэглэлийг нарийн тодорхойлж чадахгүй гэсэн үг. Гэвч эдгээр алдааны хязгаарууд багасаж байгаа бөгөөд авилгал, засаглал, эсвэл хөрөнгө оруулалтын уур амьсгалын тухай өөр аль ч хэмжүүрийн алдаанаас бодитойгоор бага гарч байна. Иймээс засаглалын эдгээр үзүүлэлтийг дэлхийн хэмжээгээр гүйцэтгэлийн хяналт шинжилгээ, улс орны үнэлгээ, судалгааны зорилгод ашиглаж байна. Эдгээр үзүүлэлтийг 1996 оноос хойш гаргаж байгаа бөгөөд сүүлийн саруудад бид 209 орны 2004 оны жилийн эцэс

хүртэлх тоо баримтуудыг оруулан хамгийн сүүлийн үеийн үзүүлэлтүүд болгож гаргасан байгаа⁵.

Домог №3: Засаглалын ач холбогдол ба авилгалын эсрэг хүчин чармайлтын ач холбогдлыг хэт дөвийлгөсөн

Авилгалын хор холбогдлыг ойролцоогоор тооцож гаргахын тулд ‘Дэлхийн хэмжээнд авилгалын «салбар» хэр том юм бэ?’ гэж асууж болох юм. Гэхдээ, авилгал ямагт нууцлаг чанартай байдаг, авилгал, хээл хахуулийн ажиллагаа голдуу далд явагддаг учраас авилгалын салбарын хэмжээг ойролцоогоор тодорхойлоход ч маш хэцүү байдаг. Энэ нь албан ёсны тоо баримт олж авах бараг боломжгүй болгох бөгөөд байсан ч баттай бус байх нь мэдээж. Гэсэн ч, үйлдвэрийн газрын эсвэл өрхийн судалгаануудад хээл хахуулийн тоо хэмжээний талаар тодорхой асуултууд тавих явдал нэмэгдэж байгаагийн ачаар тодорхой нөхцөл байдалд тооцоо хийж, улмаар нийт хүн амын хэмжээнд экстрополяци хийж гаргах боломжтой болж байна.


Харин энэхүү дасгалын үр дүнг тайлбарлахдаа тухайн тоон мэдээллийн алдааны хязгаар, экстрополяцийн дасгалын өөрийн хийсвэр төсөөлөл, энэ аргаар улсын салбар дахь төсөв хөрөнгө шамшигдуулалт, эд хөрөнгийн хулгай гэх мэт авилгалын зарим хэлбэрийг тоогоор илэрхийлж болдоггүй байдал зэргийг харгалзан анхаарал болгоомжтой хандах ёстой. Эдгээр ноцтой сануулгуудыг анхаарч тооцоод, дэлхийн хэмжээгээр авилгалд бохирдсон нийт гүйлгээний хэмжээг тооцож үзвэл 1 триллион ам. доллар орчим болж байна. Мэдээж энэ тооцооны алдааны хязгаар их байх бөгөөд багаар тооцоход 600 тэрбум ам.доллар орчим, ихээр бодоход 1.5 триллион ам.доллараас хол давсан байна⁶.

Гэхдээ дэлхийн хэмжээний хээл хахуулийн нийт хэмжээ 1 триллион ам.доллар байгаа нь маш их биш санагдаж байсан ч энэ нь өөрөө авилгалын бодит өртөг зардлыг сайн харуулж чадахгүй. Онолын хувьд, энэ бүх хээл хахууль арилжааны хүрдийг тослох төдий бөгөөд эдийн засагт ямар нэг бүтээлч нэмүү өртгийн алдагдал учруулахгүй гэж маргаж болох юм. Иймээс авилгал болон муу засаглалын өртөг зардлын талаар нарийн ойлгохын тулд засаглалын үзүүлэлтүүдийг орлого эсвэл нялхасын эндэгдэл гэх мэт үр дүнгийн хувьсагчуудтай холбож үзэх нь чухал.

Туршилтын хэмжилтүүдэд гарч буй дэвшлүүдийн ачаар засаглалын хөгжилд үзүүлэх нөлөөг олон судлаачид судалж шинжлээд байна. Ерөнхийдөө судалгаанаас үзэхэд, илүү сайн засаглалаас урган гарах, бидний нэрлэсэн, хөгжлийн ноогдолашиг маших байх боломжтой. Үнэхээр сайн засаглал эдийн засгийн хөгжлийн үндэс сууриар хангадаг гэдэгтэй эрдэмтэн судлаачид, бодлого боловсруулагчид аль аль нь улам бүр санал нэгтэй байх болжээ. Эрдэм шинжилгээний судалгаанууд нь институцийн чанараас хөгжилд үзүүлэх маш урт хугацааны үр нөлөөнд голлон анхаарч байгаа бөгөөд дэлхийн хэмжээгээр институцийн чанараас нэг хүнд ноогдох орлогод хүчтэй учир шалтгаант нөлөө үзүүлж байгааг тэмдэглэсэн байна. Сайн засаглалаас хөгжилд өгөх ноогдол ашгийн тухай эдгээр тооцоо нь засаглалын чиглэлд хийсэн нэг стандарт хазайлттай тэнцэх хэмжээний бодитой сайжруулалт урт хугацаанд орлогыг бараг хоёроос гурав дахин нэмэгдүүлж болохыг харуулж байна⁷.

Нэг стандарт хазайлттай тэнцэх хэмжээ гэдэг бол хамгийн сайн ба хамгийн муу амжилт үзүүлсэн орнуудын хоорондын ялгааны нэг өчүүхэн хэсэг учраас засаглалыг энэ хэмжээгээр нэмэгдүүлэх боломжтой юм. Тухайлбал, энэ нь дуу хоолой ба хариуцлагат байдлын өнөөгийн түвшинд хамгийн доогуур үзүүлэлттэй байгаа Мянмарынхаас Казахстаны түвшин хүрэх, эсвэл Казахстаныхаас Гүржийн түвшинд хүрэх, эсвэл Гүржийнхээс Ботсваны түвшинд хүрэхтэй адил юм. Эрх зүйт төрийн чиглэлд гарсан сайжруулалтын хувьд, нэг стандарт хазайлттай тэнцэх хэмжээ гэдэг нь Сомалигийн түвшнээс Лаосынхад, Лаосынхаас Ливаныхад, Ливаныхаас Италийнхад, Италийнхаас Канадыхад хүрнэ гэсэн үг, харин авилгалын хяналтын хувьд гарсан сайжруулалтад Эквадорын Гвинейн хамгийн доод түвшнээс Куба, Гондурас эсвэл Угандагийн түвшинд, Угандагийнхаас Литвийн, Литвийнхээс Мавританий, Мавританийхаас Португалийн, Португалийнхаас Финлянд, Исланд, Шинэ Зеландын илүү дээд түвшинд хүрэх хэмжээнд нэг стандарт хазайлттай тэнцэх хэмжээ байна. Мөн өнгөрсөн 10 жил гэх мэт хамаагүй богино хугацаанд ч гэсэн институцийн чанар сайтай орнууд илүү хурдан өссөн байгааг бид олж тогтоосон. Түүнчлэн манай судалгаагаар, сайн засаглал бол зөвхөн нэг хүнд ноогдох илүү өндөр орлогын төлөө асуудал биш, нялхасын эндэгдэл, бичиг үсэг үл мэдэх байдлыг бодитойгоор бууруулахад чиглэсэн зүйл болохыг олж тогтоогоод байна.

Бүдүүвч 1: Улсын өрсөлдөх чадвар сайн байх нь сайн засаглалтай холбоотой




Эх сурвалж: ӨӨЧИ нь Дэлхийн Эдийн Засгийн Форумын 2005 оны тоон үзүүлэлтүүдэд тулгуурласан; авилгалын хяналтын хувьд 2004 оны үзүүлэлт бөгөөд Кауфманн нарын 2005 оны бүтээлээс авав.

Түүнчлэн засаглал бол аливаа орны өрсөлдөх чадварт нилээд ач холбогдолтой асуудал юм. Энэ жилийн ДДӨЧИ-ийн хувьд, бид нэгэн энгийн дасгал ажилласан бөгөөд үүнд саяхан гарсан Засаглалын Үзүүлэлтүүдийг (улс орнуудын 2004 оны зэрэглэлийг хэмжсэн) энэхүү *Тайланд* орсон (Хэсэг 1) 2005 оны Өсөлтийн өрсөлдөх чадварын индексийн шинэ үзүүлэлттэй холбож авч үзсэн. Энэ жилийн ӨӨЧИ-ийг тооцоход ашигласан тоон үзүүлэлтүүд нь (энэ жилийн Судалгааны томоохон хэмжүүрээс авсан) Засаглалын Үзүүлэлтүүдийн аль ч тооцоонд ороогүй бөгөөд өмнөх жилийн тоон үзүүлэлтийг ашигласан гэдгийг энд дурдах нь зүйтэй. Ийм нөхцөлд, засаглал (Засаглалын үзүүлэлтүүдээр хэмжсэн) ба өрсөлдөх чадвар (ӨӨЧИ-ээр хэмжсэн)-ын хоорондын корреляцийн хамаарал туйлын өндөр байгааг тэмдэглүүштэй. Бүдүүвч 1-ээс харахад, Засаглалын үзүүлэлтүүдийн нэг болох авилгалын хяналтын хувьд корреляцийн коэффициент 0.9 буюу маш сайн нийлж байна. Мэдээж ийм ойрхон корреляци статистикийн хувьд өндөр ач холбогдолтой байх бөгөөд тухайн орны өрсөлдөх чадварыг тайлбарладаг эконометрикийн заалтад орлогын түвшний хяналтыг оруулсан ч өндөр хэвээр байна. Дунджаар, авилгалын хяналтад гарсан нэг

стандарт хазайлтын хэмжээтэй (бодитой) сайжралт нь аливаа орон ӨӨЧИ-д бараг 30 байраар дээш үсрэх боломжтой холбоотой. Тухайн орны орлогын түвшинг хянасан дараа ч гэсэн авилгалын хяналтад гарсан сайжралт нь аливаа орны өрсөлдөх чадварт маш том үсрэлт гарах буюу 15-20 байр ахих боломж олгодог.

Засаглалын ач холбогдлыг тогтоох хамгийн шууд арга бол пүүс компаниуд болон өрхүүдээс асуух явдал юм. Үйлдвэрийн газруудын хувьд бол энэ Судалгааны төгсгөлд орсон нийлмэл асуултаар гол санааг гаргаж болох бөгөөд энэ асуулт нь 14 боломжит хүндрэл бэрхшээл бүхий урт жагсаалтыг тэдгээрийн үзүүлж буй дарамт шахалтынх нь ач холбогдолоор дараалуулахыг компаниудаас хүсэх юм. Энэ асуултын үр дүнгээс үзэхэд: ЭЗХАХБ-ын гишүүн орнуудын компаниудын бизнест хамгийн хүндрэлтэй асуудал нь хөдөлмөрийн зохицуулалтууд, хүнд суртал, татварын ачаалал байдаг бол шинээр төрөн гарч буй эдийн засагтай орнуудын компаниудад хамгийн хүндрэлтэй нь хүнд суртал ба авилгалын дарамт байдаг байна. Санхүү, дэд бүтцийн асуудал авилгал, хүнд суртал хоёрыг бодвол арай доогуур үнэлгээ авсан боловч олон үйлдвэр аж ахуйн газарт ноцтой хүндрэл учруулж байна гэж дэлхийн эргэн тойронд буй бизнесийн удирдлагууд

Бүдүүвч 2: Бизнес учирч буй гол дарамт шахалтууд, бүс нутгаар: 2005 оны Судалгаанд пүүс компаниудын өгсөн хариултууд



Эх сурвалж: Одоогийн энэ Судалгаа. Компаниудад тавьсан асуулт нь: «Дээр дурдсан 14 дарамт шахалтаас танай улсад бизнес эрхлэхэд хамгийн хүндрэлтэй байдаг таван хүчин зүйлийг сонгоно уу?»

үзсээр байна. Дээрх бэрхшээлүүд нь үзүүлж буй дарамт шахалтын хүндрэлийн хувьд бусад олон асуудлаас давамгайлж байна.

Шинээр төрөн гарч буй эдийн засагтай орнуудын дунджийн цаана нилээд ялгаатай байдал байгаа учраас бүс нутгийн болон улсын түвшинд задалж үзэх нь чухал байна. Бүдүүвч 2-т эдгээрийн заримыг харуулснаас үзэхэд зарим хүндрэл бэрхшээлийн бүс нутгийн дунджийг мөн харуулсан байна. Хүнд суртал хаа сайгүй, түүний дотор ЭЗХАХБ-ын гишүүн орнуудад хүртэл ноцтой дарамт болж байна. Авилга ч мөн адил ноцтой саад тогтор болж байгаа нь ялангуяа шинээр төрөн гарсан эдийн засагтай орнуудад тод ажиглагдаж байна. ЭЗХАХБ-ын болон социализмын дараахь шилжилтийн орнуудад хүнд бэрхшээл үүсгэж байгаа нэг асуудал бол татварын зохицуулалт бөгөөд нөгөө талаас Өмнөд Африк гэх мэт бүс нутагт энэ асуудлыг бусдыгаа бодвол саад тогтор багатай гэж үнэлжээ. Үүний нэг адилаар, дэд бүтцийн асуудал Африк ба Азийн хөгжиж буй орнуудад, Зүүн Азийн баруудын эсрэгээр гол бэрхшээл болохын зэрэгцээ Латин Америк болон шилжилтийн эдийн засагтай орнуудад ч тодорхой хэмжээгээр хүндрэлтэй байна (Бүдүүвч 2-ыг үзнэ үү). Энэ төрлийн асуулт зөвхөн улс орон бүрт янз бүр байгаа дарамт

шахалтуудын харьцангуй зэрэглэлийг харуулж байгаа учраас эдгээр орны хувьд дэд бүтцийн хөрөнгө оруулалтад анхаарах явдал чухал биш гэсэн үг биш юм. Гэхдээ дэд бүтцийн асуудалтай бөгөөд хөрөнгө оруулалт маш их хэрэгтэй байгаа Латин Америкийн, Африкийн, шилжилтийн болон бусад олон оронд дэд бүтэц тийм ч өндөр үнэлгээ аваагүй байгаа нь тэдгээрийн бизнесийн хөгжилд бусад зарим нэг хүчин зүйлс (ихэвчлэн засаглал, авилгалтай холбоотой) илүү хүнд дарамт үзүүлж байгаагийн илэрхий шинж тэмдэг юм⁸.

Бүс нутгийн дунджууд нь бүс нутаг бүрийн улс орнуудын хэмжээнд бодитой ялгаа байгааг ямагт нууж байдаг. Жишээлбэл, ЭЗХАХБ-ын гишүүн 24 орны хэмжээгээр хамгийн хүнд гурван дарамтын нэг нь авилгал гэж хариулсан компани дөнгөж 3 хувийг эзэлж байгаа (Судалгааны дүнгээр) нь маш доогуур үзүүлэлт юм. Гэтэл энэ тоо нь Финлянд, Шинэ Зеланд, Норвеги, Исланд, Австрали гэх мэт оронд тэг хувиас эхлээд (өөрөөр хэлбэл, ганц ч компани авилгалыг хүндрэл гэж үзээгүй) түүнээс хамаагүй өндөр буюу хариулагчдын 18 хувь нь авилгалыг хамгийн том бэрхшээлийн нэг гэж үзсэн Грек улс хүртэл олон янзын тоонуудын дундаж юм. Үнэн хэрэгтээ хариултын хувь нь Грекээс ч доогуур байгаа янз бүрийн бүс

нутгийн хэд хэдэн шинээр төрөн гарсан эдийн засаг бүхий орнууд байдаг бөгөөд тухайлбал, Уругвай (4 хувь), Чили (7), Словени, Өмнөд Африк хоёр (10), Ботсван, Гана хоёр (12), Эстони (13) болон бусад улс байна. Харин авилгалаас бизнест учруулж буй дарамт шахалтын үнэлгээний дундаж шинээр төрсөн эдийн засагтай орнуудад хамаагүй өндөр байгаа боловч энд хариулагчдын тал нь авилгал бол бизнест учирч буй хамгийн хүнд дарамтын нэг гэж үзсэн Армян, Азарбайжан, Бангладеш, Бенин, Камбож, Камерун, Гватемал, Казахстан, Кени, Морокко, Мозамбик, Пакистан, Парагвай, Румын, Орос, Уганда болон бусад орнууд зонхилж байгаатай холбоотой.

Муу засаглал ба авилгалын үр дагавар бизнесийн салбараар хязгаарлагдахгүй. Олон оронд авилгал бол айл өрхийн салбарт ноогдуулсан «урвуу татвар» гэж үздэг. Өндөр орлоготой бүлгүүдийг бодвол бага орлоготой өрхүүд төрийн үйлчилгээг хүртэхийн тулд орлогынхоо харьцангуй их хувийг хээл хахуульд өгдөг бөгөөд эцэст нь авилгалын уршгаар ийм үйлчилгээг хүртэх боломж нь улам багасдаг. Үүнтэй холбоотойгоор авилгал орлогын тэгш бус байдлыг нэмэгдүүлж байна гэдгийг судалгаагаар тогтоосон байдаг⁹.

Түүнчлэн зээл тусламжийн үр нөлөөтэй байдалд засаглал нилээд нөлөөлдөг. Хэдийгээр зарим хүмүүс олж мэдсэн зүйлтэй нь маргадаг ч, Бурнсайд, Доллар¹⁰ хоёр гэдгээр олны танил болсон зохиогчдын улс орнуудын хэмжээгээр нэгтгэсэн үзүүлэлтүүдэд тулгуурлан зээл тусламжийн үр нөлөөтэй байдлыг үнэлсэн бүтээлээс үзэхэд тухайн тусламжид хүлээн авагч орны бодлого ба институциудийн чанар шийдвэрлэх үүрэгтэй ажээ. Харин эдгээр уялдаа холбоог микро эдийн засгийн түвшинд судлах, тухайлбал төслийн үр нөлөөтэй байдалд институциуд ямар нөлөө үзүүлж байгааг харуулахын тулд хөрөнгө оруулалтын төслүүдийн үр нөлөөтэй байдалд чиглэсэн судалгаа хийх нь наанадаж ямар холбоо байгааг илрүүлж өгөх болно¹¹. Мөн Дэлхийн Банкны санхүүжилттэй төслүүдэд хийсэн манай тооцоогоор, хэрвээ ямар нэг хүлээн авагч оронд авилга өндөр байвал төсөл амжилт олох, институцийн хөгжилд нөлөө үзүүлэх, хөрөнгө оруулалт урт хугацаанд тогтвортой байх магадлал нь илүү сайн засаглалтай орнуудынхаас хамаагүй бага байна.

Ялангуяа эдгээр үр дүн нь түүнийг дагалдах домог болох донор байгууллагууд авилгал өндөртэй орнууд ба салбаруудад, бусад төсөл

амжилт олоогүй байсан ч өөрийн хэрэгжүүлэх төслүүдээ «тойруулан хашиж», түүний үр ашигтай хэрэгжиж, зорилгодоо хүрэх нөхцлийг хангаж болно гэсэн маргаантай ихээхэн холбоотой. Энэ бол биелэшгүй зүйл. Зарим нэг байж болох хүмүүнлэгийн тусламжааны төслүүдээс бусад тохиолдолд зээл тусламжийн хамтын нийгэмлэгийнхэн төслүүдээ ямар нэг орны авилгалын ерөнхий орчноос бүрэн тусгаарлаж чадна гэсэн нотолгоо байдаггүй. Тоон үзүүлэлтүүдээс харахад засаглал, иргэний эрх чөлөө, эрх зүйт төр, авилгалыг хянах системтэй арга байхгүй байхад зээл тусламжийн санхүүжилттэй төслүүд амжилттай хэрэгжих магадлал ихээхэн багасдаг нь харагдаж байна.

Үнэхээр засаглал, авилгал хоёроос асуудал үүсэж байна. Энэ сэдвээр бичигдсэн ном зохиолуудыг энэ бүлэгт бүрэн танилцуулахад эсвэл засаглал ба бусад чухал хүчин зүйлс, мөн гарсан үр дүнгүүдийн хоорондын бүхий л нарийн түвэгтэй уялдаа холбоог харуулах боломжийг бидэнд өгсөн номын зай талбай хязгаарлаж байна. Жишээлбэл, авилгал газар авснаас болон эрх зүйт төр байхгүйгээс дөнгөж төрсөн ардчиллыг доройтуулж болох асуудал чухал ач холбогдолтой. Үүний нэг адилаар, зохисгүй засаглал, авилгал, мөнгө угаалт гэх мэт асуудал зохион байгуулалттай гэмт хэрэг, терроризм зэрэг аюулгүй байдлын асуудалтай уялдаа холбоотой байгаа нь гүн гүнзгий задлан шинжилгээ, туршилтын судалгаанууд хийхийг шаардаж байна¹².

Засаглал бол хөгжлийн дан ганц чухал хөтлөгч биш гэсэн илэрхий санааг онцлохгүйгээр засаглал ба авилгалын эсрэг үйл ажиллагаа хоёрын ач холбогдлыг хэт дөвийлгөн үнэлж байна гэсэн домогт хариу өгөхөд хангалтгүй байх биз. Энд макро эдийн засгийн, худалдааны, салбарын бодлогууд ч чухал ач холбогдолтой. Гэвч засаглал муу байгаа үед бусад чиглэлүүдийн бодлого боловсруулалт ч бас муудах нь олонтаа байдаг.

Домог №4: Сайн засаглал, авилгалын хяналт хоёр бол зөвхөн баян орнууд л хүчрэх тансаглал мөн

Засаглал ба орлогын уялдаа холбоо нь илүү сайн засаглал орлогыг *эрс нэмэгдүүлдэг* гэсэн үг биш, харин ч үүний эсрэгээр буюу өндөр орлоготой бол автоматаар сайн засаглалтай болчихдог гэж зарим хүмүүс маргадаг. Гэвч манай судалгаа энэхүү үзлийг дэмжихгүй байна. Авилгал бол бага орлоготойгоос болж үүсдэг хэмээн үзэж,

улмаар ядуу орнууд дахь муу засаглалыг зөвтгөх арга саам хайх нь буруу юм. Үнэн хэрэгтээ, сайн засаглал бол эдийн засгийн өндөр өсөлтийн *шалтгаан* болохыг харуулах нотлох баримт бидэнд бий. Цаашилбал, Балтийн орнууд, Ботсван, Чили, Словени зэрэг хэд хэдэн шинээр төрсөн эдийн засгийн жишээгээр баян улс үндэстнүүдийн эгнээнд хараахан нэгдэж оролгүйгээр засаглалын өндөр түвшинд хүрэх боломжтойг харж болж байна.

Энэхүү олж мэдсэн зүйлс маань дэлхийн бөмбөрцгийн эргэн тойронд өргөн хэрэглэгдэхийн зэрэгцээ сүүлийн үед олон улсын хамтын нийгэмлэгийнхэн Африкт анхаарал хандуулж байгаа нь энэ асуудал ялангуяа зээл тусламжийн үр нөлөөтэй байдлын талаар болон тус тивийн зээл тусламжийн урсгалд нэмэлт болгож засаглалыг сайжруулах ажилд тэргүүлэх ач холбогдол өгөх шаардлагатай байгаа талаар хийж буй мэтгэлцээнүүдтэй холбоотой болгож байна. Үнэндээ, сүүлийн жилүүдэд Африк дахь хоцронгуй хөгжлийн асуудлуудад олон улсын хамтын нийгэмлэг зохих ёсоор анхаарал хандуулж байна. Африк тив хөгжиж байгаа ертөнцийн бусад бүс нутгуудаас ч илүү ядуу буурай төдийгүй Мянганы Хөгжлийн Зорилтуудыг хангахад гарч буй ахиц дэвшлийн хувьд бусад бүс нутгаас хол хоцорч байгаа юм. Хэрэв өнгөрсөн чиг хандлага үргэлжлэх юм бол Африкийн олон орон 2015 онд ядуурлын тэн хагасыг бууруулах зорилгод хүрэхийн тулд ирэх арван жилд нэг хүнд ноогдох орлогоо хоёр дахин нэмэгдүүлэх шаардлагатай болно. Энэ сорилтыг даван туулахын тулд зээл тусламжийн бодитой урсгалыг дотоодын бодлогуудын харилцан тохирсон хүчин чармайлттай хослуулах зайлшгүй шаардлагатай гэдэгтэй өргөн хүрээнд санал нийлж байна.

Хөгжилд засаглал хүчтэй эерэг нөлөө үзүүлдэг, зээл тусламжийг үр нөлөөтэй хүргэхэд засаглал чухал ач холбогдолтой гэдэг утгаар авч үзвэл Африкийн Сахар орчмын дэд бүс нутагт засаглалын байдал дунджаар нилээд дорой үзүүлэлттэй байгаад ихээхэн анхаарах шаардлагатай юм. Африкийн олон орон зөвхөн ядуу буурай байгаад зогсохгүй төр засгийн удирдлага муутай байна. Тус бүс нутагт орших 46 орны 36 нь бүгдээрээ дэлхийн дунджаас ядуу байхын зэрэгцээ дэлхийн дунджаас муу засаглалтай гарч байна. Эдгээр орнуудын орлогын түвшин маш доогуур, гэтэл сайн засаглалтай болохын тулд мөнгө хэрэгтэй байдаг учраас тус бүс нутагт засаглал сул дорой байгааг буруутгах ёсгүй гэж зарим ажиглагчид

маргадаг. Гэвч дээр дурдсанчлан, Африк дахь муу засаглал (эсвэл авилгал) нь Африкийн ядууралтай холбоотой гэсэн таамаглалыг нотлох баримт маш бага байгааг сүүлийн үеийн судалгаа харуулж байна. Харин ч шалтгаант холбоосын чиглэл ихээхэн эсрэг буюу хэдийчинээ сайн засаглалтай байна хөгжлийн үр дүн төдий чинээ сайн байна гэсэн дүгнэлтэд хүргэж байна¹³.

Домог №5: Засаглалыг сайжруулахад бүхэл бүтэн хэдэн үе шаардлагатай

Олон засгийн газрын шинэчлэгч үзэлтнүүд, хөрөнгө оруулагчид, иргэний нийгмийн удирдагчид, зээл тусламжийн олон улсын хамтын нийгэмлэгийнхний зүгээс засаглал бол хөгжлийн түлхүүр бөгөөд хөрөнгө оруулалтын уур амьсгалыг сайжруулах гол хэрэгсэл гэж үзэх явдал улам нэмэгдэж байна. Энэ нь эргээд, аливаа орны засаглалын чанарт цаг хугацааны турш хяналт шинжилгээ хийх шаардлагыг нэмэгдүүлж байна. Цаашилбал, институцийн чанар сайтай орнуудад зээл тусламжийн урсгалын хөгжилд үзүүлэх нөлөө хүчтэй байдаг гэж зээл тусламж хандивлагчид үздэг болоод байна. Энэ үүднээсээ засаглалын чиг хандлагыг болон түүний түвшинг цаг хугацааны турш хэмжих нь чухал юм. Засаглалын шинэ үзүүлэлтүүд маань одоогоор 1996-2004 он хүртэл найман жилийн хугацааг хамарч байгаа нь энэ чиглэлд гарч буй ач холбогдол бүхий чиг хандлагыг олж харж эхлэхэд хангалттай урт хугацаа юм. Бид өөрсдийн бүтээлдээ онцлон тэмдэглэж байсанчлан бүх төрлийн засаглалын үзүүлэлтүүдэд, түүний дотор манай үзүүлэлтүүдэд ч хэмжилтийн алдаа байгаа нь засаглалын чиг хандлагыг үнэлэхэд хүндрэлтэй болгож байгаа юм.

Саяхан гарсан «Засаглалын асуудлууд IV» (Кауфманн нар, 2005) бүтээлдээ бид албан ёсны статистик загвараас гадна статистикийн болон практикийн хувьд ач холбогдолтой байж болзошгүй засаглалын өөрчлөлтийг олж тогтооход зориулсан зарим энгийн зарчмыг боловсруулсан байгаа. Манай засаглалын үзүүлэлтүүдийн хамарсан 8 жил гаруй хугацаанд засаглал нь бодитойгоор өөрчлөгдсөн гэж нилээд баттайгаар хэлж болох (90 хувийн ач холбогдолтой түвшинд) орон 10 орчим хувийг эзэлж байхад түүнээс арай доогуур буюу 75 хувийн ач холбогдлын түвшинд нийт ажиглагдсан өөрчлөлтүүдийн 20 орчим хувь нь ач холбогдолтойд тооцогдож байна. Үүний

Хүснэгт 1: Богино хугацаанд дэлхийн хэмжээний засаглалд гарсан томоохон өөрчлөлтүүд, 1998-2004

209 орны нийт үзүүлэлтэд тулгуурлан сонгож авсан орнууд

Үг хэлэх эрх ба хариуцлагатай байдал	
Ихээхэн дордсон.....	Төв Африкийн БНУ, Непал, Зааны Ясан Эрэг, Гайти, Зимбабве, Орос, БН Киргиз Улс, Эритрей, Пакистан, Беларусь, Соломоны Арлууд, Венесуэл, Казахстан, Бангладеш, Эквадор, Иран, Габон
Ихээхэн сайжирсан.....	Чили, Кени, Бахрейн, Гамби, Алжир, Мексик, Сенегал, Перу, Турк, Словак Улс, Нигери, Индонези, Гана, Хорват, Босни Герцоговен, Сьерра Леоне, Серб
Зохицуулалтын чанар	
Ихээхэн дордсон.....	Зимбабве, Венесуэл, Зааны Ясан Эрэг, Этиоп, Бангладеш, Пакистан, Филиппин, Ливан, Египет, Замби, Мянмар, Гвиней, Эритрей, Болив, Перу, Тунис, Гондурас, Гватемал, Эквадор, Казахстан, Камерун, Куба
Ихээхэн сайжирсан.....	Капе Верде, Армян, Тажикстан, Азарбайжан, Босни Герцоговен, Серб, Эстони, Заир, БНКУ, Экваторын Гвиней, Исланд, Литва, БН Словак Улс, Ирак
Хуулийн хэрэгжилт	
Ихээхэн дордсон.....	Зимбабве, Аргентин, Зааны Ясан Эрэг, Этиоп, Молдав, Куба, Венесуэл, Непал, Гайти, Ливан, Папуа Нью Гвиней, БН Домникан Улс, Мянмар, Эритрей
Ихээхэн сайжирсан.....	Мозамбик, БН Словак Улс, Эстони, Латви, Литва, Мадагаскар
Авилгалын хяналт	
Ихээхэн дордсон.....	Зимбабве, Бангладеш, Эритрей, Зааны Ясан Эрэг, Свазиланд, Этиоп, Экваторын Гвиней, Төв Африкийн БНУ, Судан, Молдав
Ихээхэн сайжирсан.....	Танзани, Мадагаскар, Хорват, Серб, Колумби, Болгар, Эстони, Латви, БН Словак Улс

Тайлбар: Энэ хүснэгтэд үзүүлсэн орнуудын хувьд тоон үзүүлэлтийн ач холбогдлын түвшин нь 75 хувийн итгэлцлийн түвшинд тооцогдсон байгаа. Мөн засаглалын бүх бүрэлдэхүүн хэсгүүдийг тооцсон, 90 хувийн итгэлцлийн түвшин бүхий дэлгэрэнгүй жагсаалтыг Кауфманн нарын 2005 оны бүтээлээс үзнэ үү.

Эх сурвалж: Кауфманн нар, 2005 он.

нэг адилаар, түүнээс арай богино буюу 1998-2004 оны хоорондох 6 жилийн хугацаанд нилээд их өөрчлөлттэй гарсан цөөнгүй орнууд байна (Хүснэгт 1). Гол нь эдгээр оронд гарсан засаглалын өөрчлөлтийн чиглэлийн талаарх тоонмэдээллийн олон эх сурвалжууд хоорондоо ихээхэн нийцэж байгааг бид харуулж байгаа юм. Энэ бүхэн нь ерөнхийдөө, институцийн чанарын өөрчлөлтүүд аажмаар хийгдэж байгаа боловч найман жилийн хугацаанд эрс сайжирсан эсвэл огцом доройтсон орнууд ч байгааг сануулж байна. Тодорхой нэг улсад доройтол харьцангуй хурдан явагдаж болох

боловч сайжралт зайлшгүй удаан хугацаанд, бага багаар хийгддэг гэсэн нийтлэг ойлголтыг бодвол энэ олж мэдсэн зүйл маань онцгой сонирхол татаж байна.


«Институцийн гутранги үзэлтнүүд»-эд өгөх хариу болгож, 1990 оноос хойш засаглалын сонгосон хэмжээсүүдэд илт сайжирсан орнуудын жагсаалтыг Хүснэгт 1-д үзүүлэв. Түүнчлэн, Африкийн бусад орон хараахан амжилт олж чадаагүй байгаа нь үнэн боловч, хүснэгтээс харахад харьцангуй богино хугацаанд засаглалаа сайжруулаад байгаа Африкийн хэд хэдэн орон байгаа нь «Африкийн талаар гутранги үзэлтнүүд»-эд өгөх няцаалт болох юм. Ерөнхийдөө Хүснэгт 1-д үзүүлсэн члэн, сайжруулалт хийсэн орнуудтай бараг ижил тооны Африкийн орон засаглалын тодорхой хэмжээсүүдээр уруудаж байгаа нь харагдаж байна.

Хүснэгт 1-д харуулж байгаагаар, Чили, Босни Герцоговен, Хорват, Серб, Гана, Индонези, Сьерра Леоне, БН Словак Улс, Перу гэх мэт олон оронд 1998 оноос хойш *дуу хоолой ба хариуцлагат байдлын* чиглэлд ихээхэн ахиц гарсан бол Зааны Ясан Эрэг, Зимбабве, БН Киргиз Улс, Орос, Венесуэл, Пакистан, Беларусь, Непал, Гайти гэх мэт улсад ихээхэн доройтол гарсан байна. Үүнтэй төстэйгээр, энэ хугацаанд Этиоп, Намиби, Аргентин зэрэг хэд хэдэн орон *эрх зүйт төрийн* чиглэлээр доройтсон бол Өмнөд Африк, Болгар зэрэг олон оронд төр засгийн үр ашигтай байдлын чиглэлд чухал сайжралт гарчээ.

Түүнчлэн бид дэлхий нийтийн дунджаар засаглал сайжирч байгаа эсэх тухай асуултыг хөндөн авч үзсэн. Гэтэл үнэн хэрэгтээ 1996 оноос хойш (түүнээс хойшхи аль ч хугацаанд) ямар нэг сайжралт гарсан гэх нотолгоо олж чадсангүй. Ингээд эдгээр үзүүлэлтийг дахин хянаж үзсэний дараа дэлхий нийтийн хэмжээний засаглалын чанарын дундаж үзүүлэлт зогсонги байдалтай байгааг хараад нилээд тайвширсан юм. Дээр цохон тэмдэглэж байсанчлан, хэдийгээр засаглалын чиглэлд ихээхэн сайжирсан олон орон байгаа ч энэ талаар ихээхэн доройтож байгаа орнууд ч бий бөгөөд мөн олон оронд бага зэргийн өөрчлөлт гарсан байна.

Энэ үүднээс авч үзвэл бусдаасаа харьцангуй сайжирч байгаа хэсэг бүлэг орнууд байгаа нь харагдаж байна. Жишээлбэл, Латин Америкийн ихэнх орныг бодвол Карибийн тэнгисийн зарим орон хэд хэдэн чиглэлд засаглалаа сайжруулсан тухай зарим нотолгоо

Бүвүүвч 3: Шилжилтийн түүх: Дэлхийн дунджаар зогсонги байдалтай боловч хэсэг бүлэг орнуудын хэмжээнд янз бүрийн чиг хандлагатай байна



Эх сурвалж: Кауфманн нар, 2005 он

байна. Энд ялангуяа социализмын дараахь шилжилтийн үеийн орнуудын жишээг дурдаж болно. Бүдүүвч 3-т үзүүлснээр 1990-ээд оны дундуур зохих институцийн болон улс төрийн нөхцөл хангагдмагц Европын Холбоонд элсүүлэх амлалт өгөөд байсан шилжилтийн орнуудын хувьд засаглалын чиглэлд сайжирсан хандлага гарсан (эрх зүйт төрийн хувьсагчийн тодорхойлолтод үзүүлсэнчлэн) бол тийм нээлттэй цонхны боломж олдоогүй хуучин социалист байсан орнуудын хувьд зогсонги буюу доройтсон байдалд орсон байна.

Иймээс институциуд зөвхөн аажмаар өөрчлөгддөг, олон оронд богино хугацааны сайжралт бага гарсан нь үнэн боловч, зарим оронд богино хугацаанд огцом ахиц гарсныг бид бас харж болно. Энэ нь, засаглал хурдан доройтож болох боловч сайжралт ямагт удаан бөгөөд бага багаар явагддаг гэсэн үзлийг няцааж байна.

Домог №6: Авилгалтай тэмцэх замаар авилгалтай тэмц

Авилгалын эсрэг үйл ажиллагааны чиглэлд ажиллаж буй зарим хүмүүс болон олон улсын хамтын нийгэмлэгийнхний дэмжин сурталчилдаг нэг төөрөгдөл бол авилгалтай

тэмцэх хамгийн шилдэг арга бол авилгалтай тэмцэх явдал өөрөө гэж үздэгт оршино. Өөрөөр хэлбэл, өөр нэг авилгалын эсрэг кампанит ажил зохиох, авилгалын эсрэг илүү олон комисс, ёс зүйн байгууллагууд бий болгох, шинэ хууль тогтоомж, ёс зүйн дүрмийн төсөл тасралтгүй боловсруулах аргаар тэмцэнэ гэж ойлгодог. Түүнчлэн зарим нөхцөлд авилгалаас урьдчилан сэргийлэх, шударга байдлыг хөхиүлэн дэмжих ажилд голлон анхаарахын оронд шүүн яллахыг онцолж, тэгш бус байдлаар (ихэвчлэн цөөн тооны корпорациуд, хувь хүмүүсийг, мөн голдуу улс төрийн сөрөг хүчнээс) хандаж байгаагаас авилгалын эсрэг хүчин чармайлтын үр нөлөөг багасгаж байна. Ямар нэг авилгалын дуулиан дэгдсэн хүнд нөхцөлд өөрийн эрхгүй оролцож хэт их зохицуулах хандлага ч багагүй гарч байгаа нь бас сөрөг нөлөөтэй байж болно. Хэтэрхий их зохицуулалт нь авилгалын үндсэн шалтгаануудыг хөндөлдгүй орхиод зогсохгүй хээл хахуулийн цаашдын боломжуудыг бий болгох нь олонтаа. Ер нь иймэрхүү дээрээс гаргасан авилгалын эсрэг санаачилгууд үр нөлөө багатай мэт харагддаг бөгөөд авилгалын эсрэг «ямар нэг зүйл хий» гэсэн дарамт шахалтад хариу өгөх улс төрийн зорилготой арга зам болдог. Үүний улмаас илүү үндсэн бөгөөд системийн чанартай засаглалын

шинэчлэлүүдийг хайхралгүй орхих явдал олон байдаг.

Дөмөг №7: Хөгжиж байгаа орнуудад гол буруутан нь улсын салбар бөгөөд гагцхүү бизнесийн хангалтгүй орчин бүрдүүлэх үүрэгтэй

Дан ганц улсын салбарын алдаа дутагдалд голлон анхаардаг нийтлэг төөрөгдөл байдаг. Төрийн бодлого, институциуд, хууль тогтоомжийг боловсруулахад зохисгүй нөлөө үзүүлдэг хүчирхэг хувийн ашиг сонирхлууд байдаг учраас бодит байдал хамаагүй нарийн түвэгтэй байдаг. Онцгой зарим тохиолдолд төрийн байгууллагуудыг олигархууд гартаа авсан байдаг. Эдгээр нь өмнөх Тайлангийн засаглалын тухай бүлэгт бид зарим талаар дэлгэрэнгүй авч үзсэн асуудлууд бөгөөд зохисгүй нөлөөллийн хэмжээ болон төрийн байгууллагуудыг бизнест ноёрхогч хүчнүүд гартаа бүрэн оруулсан байдлын тухай өмнөх Судалгааны үр дүнг танилцуулсан байгаа. Уламжлалт сэтгэлгээний эсрэгээр авч үзвэл, аливаа улсын дотоодын пүүс компаниуд ба гадаадын хөрөнгө оруулагчдад тулгарч буй хөрөнгө оруулалтын уур амьсгалын цорын ганц бүрдүүлэгч нь улсын салбар биш бөгөөд үүний нэг адилаар хувийн салбар ч хөрөнгө оруулалтын уур амьсгалыг идэвхгүй хүлээн авагч биш юм. Бодит байдал дээр бизнесийн болон улсын салбарын засаглал ба бодлого боловсруулалтын хооронд нарийн түвэгтэй харилцан хамаарал байдаг бөгөөд түүгээрээ хувийн салбарын хүчирхэг хэсгүүд төрийн бодлого, хууль тогтоомж, зохицуулалтыг боловсруулан гаргахад маш чухал үүрэг гүйцэтгэдэг нь эргээд эдгээр компаниудын үйл ажиллагаа явуулах бизнесийн орчин ба тоглоомын дүрмийг бий болгож байдаг¹⁴.


Авилгалын уламжлалт тодорхойлолтын (төрийн албан тушаалыг хувийн ашиг хонжооны зорилгод буруугаар ашиглах гэсэн) цаана улс төрчид, өндөр албан тушаалтнууд, хүнд сурталтнуудын ашиг тусын төлөө пүүс компаниудаас авилгал нэхэж алгаа тоссон асар урт гар мэт ховдог шунахай төрийн дүр төрх оршиж байдаг. Олон пүүс компаниуд харилцан ашигтай байхын тулд улс төрчидтэй хуйвалддаг нь нотлогдсон учраас хувийн компаниудын гүйцэтгэх чухал үүргийг харгалзах замаар авилгалд тавих анхаарлыг тэнцвэржүүлэх шаардлагатай болохыг сүүлийн зургаан жилийн турш хийсэн судалгаанууд харуулж

байна. ЭЗХАХБ-ын баян гишүүн орон мэтийн хүчирхэг улсуудад хүртэл зохицуулалтын бодлогыг боловсруулахад томоохон нөлөө бүхий корпорацийн бүлгүүд ихээхэн нөлөө үзүүлж байдаг. Үүнээс улбаалан хөрөнгө оруулалтын уур амьсгалын тухай уламжлалт үзлийг ч бас эргэн харах нь туйлын чухал. Нэн ялангуяа бодлогын ба институцийн үр дүнгүүд, түүний дотор зохисгүй нөлөө үзүүлэхэд улс төрийн санхүүжилтийн гүйцэтгэх үүрэг талаас нь авч үзвэл, бизнесийн ба улсын салбаруудын хоорондын харилцааны амин судас нь улс төр дэх мөнгө болж байна.

Хувийн ба улсын салбарын хоорондын засаглалын асуудлууд зөвхөн аливаа улсын дотоодын оролцогч нараар хязгаарлагддаггүй. ЭЗХАХБ-ын Гадаад Авилгалын Эсрэг Конвенци таван жил гаруйн өмнө хүчин төгөлдөр болсныг эс тооцвол үндэстэн дамнасан олон корпорациуд гадаадад хээл хахууль өгсөөр байгаагийн хажуугаар тухайн улсын төрийн бодлогод нөлөө үзүүлж, бүр ерөнхийлвөл, шинээр төрөн гарсан эдийн засагтай орнуудын төрийн засаглалыг доройтуулж байна. Бид өмнөх Тайлангуудад орсон өгүүлэлүүддээ ЭЗХАХБ-ын гишүүн орнуудад төвтэй боловч тус байгууллагын хамрах хүрээнээс гадуур үйл ажиллагаа явуулдаг үндэстэн дамнасан корпорациуд нилээд их хэмжээний хахууль өгсөөр байгаа бодит байдлыг зарим талаар дэлгэрүүлэн харуулсан билээ. ЭЗХАХБ-ын Конвенци зарим ахиц дэвшил гаргаж байж болно (мөн ЭЗХАХБ-ын гишүүн цөөн орнуудад хийгдэж буй мөрдөн байцаалтын тоо нэмэгдэж байна) гэдгийг огт ойшоохгүй орхих ёсгүй боловч ЭЗХАХБ-ын конвенцид гарын үсэг зурсан ихэнх оронд хээл хахуулийн онц ноцтой хэргүүдийг бодитойгоор шүүн шийдвэрлэх талаар ахиц дэвшил бага гарч байна.

Үнэндээ 2004 оны Судалгаагаар авсан тоон үзүүлэлтүүдээс харахад ЭЗХАХБ-ын *хүрээнд* үйл ажиллагаа явуулж буй дотоодын ба үндэстэн дамнасан пүүс компаниуд тэнд төвтэй боловч гадаадад үйл ажиллагаа явуулж буй компаниудаасаа нилээд өөр зан байдал гаргаж байгаа нь харагдаж байна. Төрийн хангамж, үйлчилгээний гэрээг хэрэгжүүлэгч компаниудын 7 хувь нь ЭЗХАХБ-ын аль нэг гишүүн оронд төвтэй бөгөөд ЭЗХАХБ-ын өөр нэг гишүүн оронд ажиллаж буй үндэстэн дамнасан компаниас хахууль авсан байхад, ЭЗХАХБ-ын гишүүн оронд буй дотоодын компаниудийн 10 хувь нь өөрийн улсын хүрээнд хээл хахууль өгсөн тооцоо байна. Гэвч

Бүдүүвч 4: Хүйсийн тэгш байдал, хэвлэлийн эрх чөлөө, ил тод байдал нь авилгалын хяналттай холбоотой



Тайлбар: Хангалттай эрх чөлөө/эрхтэй гэдэг нь хэвлэлийн эрх чөлөө, хүйсийн тэгш байдал, ил тод байдлын зэрэглэл илүү өндөр байгааг харуулна. Эх сурвалжууд: авилгалын хяналтын хувьд: Кауфманн нар, 2005 он; хэвлэлийн эрх чөлөөний хувьд: Фрийдом Хаус, 2005, онлайн хаяг <http://www.freedomhouse.org>; хүйсийн тэгш байдлын хувьд: Дэлхийн Банк, 2004; ил тод байдлын хувьд: Беллвер, Кауфманн нар, 2005.

энэ тоог ЭЗХАХБ-ын гишүүн оронд төвтэй боловч ЭЗХАХБ-ын хамрах хүрээнээс гадуур үйл ажиллагаа явуулж буй үндэстэн дамнансан компаниудын 17-гоос доошгүй хувь нь хээл хахууль өгсөн тоотой харьцуулшгүй юм¹⁵. Яг нарийн харьцуулья гэхээр бидэнд өнгөрсөн жилүүдийн зарим төрлийн тоон үзүүлэлтүүд дутагдаж байна. Иймээс ямар нэг буурах чиг хандлага илэрч байгаа эсэхийг харуулах боломжгүй юм. Гэхдээ хээл хахуулийн хувьд ЭЗХАХБ-ын дотор ба гадна байгаа үндэстэн дамнансан корпорациудын үйл ажиллагааны практикийн хооронд ихээхэн ялгаатай байгаа нь ЭЗХАХБ-ын хэмжээгээр уг Конвенцийн хэрэгжилтэд илүү хатуу хяналт тавих, илүү үр нөлөөтэй нэмэлт арга хэмжээ авах шаардлагатай байгааг илтгэж байна.

Засаглал, авилгал хоёрт хувийн салбар ч бас гол үүрэг гүйцэтгэдэг бодит байдал нь авах арга хэмжээний хувьд арай өөр утга агуулгатай байна. Үнэн хэрэгтээ хувийн ба улсын салбарын холбоог урт удаан хугацаагаар үл ойшоож ирсэн олон улсын хамтын нийгэмлэгийнхэн ч улс орнуудын засаглалыг сайжруулахад туслах нэг гол хэрэгсэл бол уламжлалт улсын салбарын хөндлөнгийн оролцоо гэж үзэн төөрөгдөх явдал олонтаа байдаг. Шуудхан хэлэхэд уламжлалт улсын салбарын удирдлагын

оролцооны аргууд үйлчлэхгүй байна. Учир нь тэд голдуу техникийн туслалцаа, тоног төхөөрөмжийн импорт, зохион байгуулалтын загвар, баян орнуудаас «мэргэжилтнүүд» ирүүлэхэд тулгуурласан технократ бүтцийн «зохицуулалтууд»-ад чиглэсэн байдаг.

Домог №8: Засаглалыг сайжруулах талаар улс орнуудын зүгээс хийж чадах зүйл бага бөгөөд ОУСБ-ууд ба хандивлагчдын хамтлагийн хийж чадах зүйл бүр ч бага байна.

Үйлчлэхгүй байгаа хөндлөнгийн оролцоонуудын урт жагсаалт, мөн засаглалыг тайлбарлахад хамаатуулдаг түүх, соёлын хүчин зүйлсийн үүргийг авч үзэх юм бол гутранги үзэлд амархан автах болно. Гэхдээ ингэвэл алдаа болно. Нэгдүгээрт, түүх, соёлын хүчин зүйлсийг тодорхойлогч хүчин зүйл гэж үзэхэд хэцүү. Үүнийг гэрчлэх жишээ гэвэл Латин Америкийн өмнөд хязгаар, Солонгосын хойг, Зүүн Европын шилжилтийн эдийн засгууд, Африкийн өмнөд хэсэгт буй хөрш орнуудын засаглалын замнал янз бүр байгааг хэлж болно. Хоёрдугаарт, тодорхой амлалтууд өгдөг стратегиуд байдаг. Дуу хоолой, оролцоог (үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, хүйсийн үзэл баримтлал) сайжруулахад гарч буй ахиц

дэвшлийг ил тод байдлын шинэчлэлтэй хослуулах нь онцгой үр нөлөөтэй байж болохыг Бүдүүвч 4-т харуулсан байна.

Харамсалтай нь, хэвлэлийн эрх чөлөө, хүйсийн тэгш байдал, ил тод байдал гэх мэт улс төрийн болон институцийн засаглалын чиглэлд хийгдэж байгаа ахиц дэвшлүүд дэлхийн олон оронд алаг цоог байна. Энэхүү урам хугарам бодит байдал нь зөвхөн албан ёсны чанартай улс төрийн өөрчлөлтүүдэд голлон анхаарсны уршгийг тод томруун харуулж байна. Жишээлбэл, сүүлийн хорин жил гаруй хугацаанд сонгууль явуулдаг орнуудын эгнээнд хэдэн арван орон шинээр нэмэгдснээр шинээр төрөн гарсан эдийн засагтай орнуудын хэмжээнд сонгуулийн ардчилалтай орны тоо бодитойгоор өсөн нэмэгдэж байна. Гэвч албан ёсны улс төрийн байдал сайжирснаар хэвлэлийн эрх чөлөө, иргэдийн дуу хоолой, эмэгтэйчүүдэд олгох боломж тэр бүр нэмэгдээд байдаггүй. Тухайлбал, 2002 онд Фрийдом Хаус байгууллагаас сонгуулийн ардчилалтай гэж ангилсан нийт 121 орноос 49 нь үнэн хэрэгтээ чөлөөт хэвлэл бүрэн байхгүй гэсэн ангилалд орсон байна¹⁶.

Африкийн тоон үзүүлэлт ч мөн үүнийг илэрхийлж байна. Фрийдом Хаусын мэдээгээр сүүлийн хорин жилийн турш улс төрийн эрхийн чиглэлд ихээхэн ахиц дэвшил гарсан байна. Гэтэл 1995 оноос хойш тодорхойлж эхэлсэн хэвлэлийн эрх чөлөөний үзүүлэлт сайжраагүй байгаа нь Бүдүүвч 5-аас харагдаж байна. Үнэн хэрэгтээ, тус тивийн хэд хэдэн оронд сүүлийн үед зарим нэг муудсан үзүүлэлт гараад байгаа нь зөвхөн энд дүрсэлсэн Фрийдом Хаусын нотлох баримтаар ч бус, Судалгааны асуултуудад хариулсан компаниудын хариултаар нотлогдож байна. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр юу мэдээлж, нийтэлж болох талаар учирч буй саад бэрхшээлүүд нэмэгдэж байгаа тухай мэдээлсэн Африкийн үйлдвэр аж ахуйн салбарын хариулагчдын тоо сүүлийн хоёр жилийн турш өсч байна¹⁷.

Ерөнхийдөө дүгнэж хэлэхэд, дэлхийн олон оронд улс төрийн эрхийн сонгосон чиглэлүүдээр ахиц дэвшил гарч байгаа боловч энэ нь тэр бүр хэвлэлийн эрх чөлөө, хүйсийн тэгш байдал, улс төрийн болон институцийн ил тод байдал болон хувирч чадахгүй байна. Эдгээр чиглэлд ахиц дэвшил гарсан тохиолдолд авилгалын хяналтын чиглэлд мөн ахиц гарч болох учраас энэ асуудал ихээхэн хүндрэл бэрхшээл учруулж байна. Авилгалын хувьд тодорхойлогч хүчин зүйл гэж байхгүй ч, улс

төрийн болон системийн чанартай хүнд хүнд институцийн шинэчлэлүүд хийгдэх шаардлага олон байна.


Тухайн улс ирэх олон жилийн турш муу засаглалтай хэвээр үлдэх түүх, соёлын онцлогтой гэж үзэхээргүй байсан ч гэсэн, аливаа улс засаглал, авилгалын хяналтаа сайжруулахад туслах талаар олон улсын санхүүгийн байгууллагуудын зүгээс хийж чадах зүйл нэг их байхгүй гэж зарим хүмүүс маргадаг. Хөгжлийн талын зарим мэргэжилтнүүд хүртэл улс орнууд засаглалаа сайжруулахад ОУСБ-ууд болон хандивлагчдын зүгээс туслах чадварт эргэлздэг. Энэхүү эргэлзээ нь, нэг бол «макро» асуудлууд илүү нөлөөтэй гэсэн үзэл, эсвэл түүхэн учир шалтгааны тухай алдаатай итгэл үнэмшил, эсвэл засаглалыг сайжруулахад хөндлөнгөөс оролцох нь улс төрийн хувьд эмзэг учраас гадныхан үүнийг дэмжихэд хэцүү гэсэн илүү нарийн өнгө аястай үзэл бодлуудтай холбоотой.

Үнэхээр олон намын шударга сонгуулийг дэмжих гэх мэт ОУСБ-ын эрх мэдлээс гадуур асуудлууд байдаг. Гэсэн ч ил тод байдал, мэдээллийн эрх чөлөө, хараат бус хэвлэл мэдээлэл, тухайн орноос удирдан явуулах авилгалын эсрэг оролцоот хөтөлбөрүүд, хүйсийн тэгш байдал гээд өнөөг хүртэл авилгалын эсрэг тэмцэхэд дутуу анхаарч ирсэн бүх асуудлыг дэмжих санаачилгын хувьд ямар нэг зүйл хийх чадвар ОУСБ-ууд ба хандивлагчдад байж болно.

Институцийн шинэчлэлийн дараагийн үе шат: Ил тод байдлын төлөө стратеги

Зарим талаар технократ «зохицуулалтууд»-ад тааламжтай байдлын түвшин илүү өндөр байдаг учраас Улсын салбарын менежмент (тухайлбал, төрийн албаны шинэчлэл, ёс зүйн дүрэм гэх мэт) гэх мэт уламжлалт сэдвүүд зээл тусламж хандивлагчдын дунд чухал байр суурь эзэлдэг хэвээр байна. Нөгөө талаас, институцийн шинэчлэлийн хувьд дутуу анхаарал тавьдаг нэг тулгуур үзүүлэлт бол ил тод байдал болоод байна. Иргэдийн мэдэх эрх ба мэдээлэл олж авах эрхийг хөгжлийн үр дүнтэй холбосон загвар боловсруулаад байгаа Нобелийн шагналт хэд хэдэн эрдэмтдийн оруулсан үзэл баримтлалын чанартай нөлөө бүхий хувь нэмрээс үзэхэд, бодит байдал дээр энэ чиглэлд харьцангуй бага ахиц дэвшил гарсан байгаа нь харамсалтай байна¹⁸. «Нарны гэрэл бол хамгийн сайн халдваргүйжүүлэгч»

Бүдүүвч 5: Африкийн Сахар орчмын бүс нутгийн хэвлэлийн эрх чөлөөний байдал, 1995-2005



Тайлбар: Ү тэнхлэгт тус бүс нутагт чөлөөт, хагас чөлөөт, чөлөөт бус зэрэглэлтэй орнуудын эзлэх хувийг үзүүлсэн ба энэ нь хэвлэлийн эрх чөлөөний үзүүлэлтэд авсан оноотой холбоотой.

Эх сурвалжууд: Фрийдом Хаус, 2005, онлайн хаяг: <http://www.freedomhouse.org>

хэмээх хуучин зүйр цэцэн үгэнд хэлсэнчлэн ил тод байдлын ач холбогдлыг ардын уламжлалт ухаанд ч үнэлсэн байдаг.


Хэдийгээр ил тод байдалтай холбоотой шинэчлэлийн хэрэгжилт бараг газар сайгүй янз бүрийн түвшинд явагдаж байгаа боловч, эрх зүйт төр, авилгал, зохицуулалтын дарамт зэрэг засаглалын бусад хэмжээстэй харьцуулах юм бол үзэл баримтлалд оруулсан хувь нэмрийн хүрээ ба түүний хэмжилт, мөн туршилтын судалгаа шинжилгээнд гарсан ахиц дэвшлийн хооронд ихээхэн зөрүүтэй байна¹⁹.

Иймээс бид 20 гаруй бие даасан эх сурвалжид (түүний дотор манай Судалгаа орно) тулгуурлан 194 орны ил тод байдлын индексийг боловсруулан гаргах замаар ил тод байдлын янз бүрийн хэмжээсүүдийн тухай туршилт судалгаанд хувь нэмрээ оруулахыг оролдож байна. Эдийн засгийн буюу институцийн ил тод байдал ба улс төрийн ил тод байдал гэсэн хоёр дэд хэсгээс бүрдсэн нийт ил тод байдлын индексийн хувьд улс орнуудын зэрэглэл ба алдааны хязгааруудыг тооцож гаргасан байгаа. Үүний үр дүнд улс орнуудын хэмжээгээр ил тод байдлын цар хүрээ асар их ялгаатай байгаа нь харагдаж байна. Үнэн хэрэгтээ ил тод байдал өндөр түвшинд байна гэдэг бол зөвхөн тодорхой нэг бүс нутаг эсвэл баян

орнуудад тусгайлан хамаатай зүйл биш бөгөөд бүс нутаг бүрт ил тод байдалтай холбоотой хүндрэл бэрхшээлүүд байгааг Бүдүүвч 6-д үзүүллээ²⁰. Ил тод байдал нь нийгэм, эдийн засаг болон хүний хөгжлийн үзүүлэлтүүд сайн байх, түүнчлэн өрсөлдөх чадвар өндөр, авилгал бага байх явдалтай холбоотой болохыг бид олж тогтоосон. Тодорхой бодлогын санаачилгууд гаргаж тавихдаа хэт их хөрөнгө зарахгүйгээр ихээхэн ахиц дэвшил гаргаж болно гэж бид үзэж байна. Үнэндээ бол ил тод байдлын шинэчлэл нь улсын хөрөнгийг бодитойгоор цэвэр хэмнэгч байдаг бөгөөд хэт их зохицуулалт, дүрэм журмын шаардлагаас зайлсхийж болдог. Ил тод байдлын шинэчлэл нь цаашид сайхан ярианы түвшний хийсвэрлэл болон үлдэх ёсгүй. Зарим оронд сонгон хэрэглэж байгаа мөн олон орон өргөн хүрээтэй авч хэрэгжүүлж болзошгүй байгаа тодорхой шинэчлэлийн тодорхой жишээг арын хэсэгт үзүүлсэн хайрцагласан хэсэгт оруулсан байгаа.

Мэдээжийн хэрэг ил тод байдлын шинэчлэл бол институцийн шинэчлэлийн цорын ганц тэргүүлэх чиглэл биш юм. ОУСБ-ууд ба хандивлагчдын зүгээс чадавхийг бэхжүүлэх, мэдлэг туршлагаа хуваалцахад туслах замаар уламжлалт үндсэн чадварыг тасралтгүй дэмжих, шүүх, гааль, татвар, хангамжийн

Бүдүүвч 6: Ил тод байдлыг илчлэхүй: Улс орнуудын ил тод байдлын ерөнхий индексийн төлөө, сонгож авсан орнууд



Тайлбар: Сонгож авсан орнуудыг үзүүлсэн бөгөөд алдааны хязгаараас үүдэн яг нарийн зэрэглэл тогтоосон эсэх нь баталгаатай бус байна. Эх сурвалж: Беллвер, Кауфманн нар, 2005

Хайрцаг 1: Ил тод байдлын тодорхой шинэчлэл

Илүү өндөр хөгжил, эдийн засгийн хурдацтай өсөлтийн чухал бүрэлдэхүүн хэсгүүд болох засаглалыг сайжруулж, авилгалыг багасгахад ил тод байдал туслаж байгаа нь судалгаанаас тодорхой харагдаж байгаа учраас энэ асуудалд олон улсын хамтын нийгэмлэг болон улс орон бүрийн зүгээс улам нарийн анхаарал тавих ёстой. Улс орнууд ил тод байдалд чиглэсэн аливаа харилцан тохирсон, өргөн хүрээтэй, практик шинжтэй стратегийн хүрээнд өөрсөддөө үнэлэлт өгөх зорилгоор үнэлгээний хуудас болгон ашиглаж болох тодорхой шинэчлэлийн үндсэн жагсаалтад дараахь зүйл орж болох юм.

- Төрийн өндөр албан тушаалд нэр дэвшигчид, төрийн албан тушаалтнууд, улс төрчид, хууль тогтоогчид, шүүгч нар болон тэдний асран хамгаалуулагчдын хөрөнгө орлогын байдлыг нийтэд ил болгох;
- Хувь хүн, пүүс компаниудаас улс төрийн кампанит ажилд зориулж өргөсөн хандивийг болон кампанит ажлын хөрөнгийн зарцуулалтыг нийтэд ил болгох;
- Парламентын санал хураалтад өгч буй бүх санал, хуулийн төсөл, парламентийн мэтгэлцээнийг нийтэд ил болгох;
- Бизнес, улс төр, хууль тогтоох эрх мэдэл болон төрийн албыг тусгаарласан ашиг сонирхлын зөрчлийн тухай хуулийг үр нөлөөтэй хэрэгжүүлэх, лоббиг зохицуулах хууль гаргах, төрийн хангамж, үйлчилгээний үеэр хээл хахууль өгсөн нь тогтоогдсон пүүс компаниудыг хар жагсаалтад

- орүүлж нийтэд зарлах (Дэлхийн Банкнаас гаргасан шиг), мөн олборлох салбарт ажиллаж буй үндэстэн дамнасан компаниудаас «юу төлж байгаагаа нийтлэх»-ийг шаардах;
- Мэдээллийн эрх чөлөөний хуулийг үр нөлөөтэй хэрэгжүүлж, төр засгийн мэдээллийг нийтэд хүртээмжтэй байлгах ;
- Хэвлэл мэдээллийн эрх чөлөө (түүний дотор Интернет);
- Төв ба орон нутгийн төсвийн болон төрийн санхүүгийн ил тод байдлыг хангах, төсвийн ил тод байдлын Стандартууд ба Кодуудын тухай ОУВС-гийн Тайлангуудыг авч хэрэглэх, олборлох үйлдвэрлэлийн салбарын үндэстэн дамнасан компаниудаас төлж буй төлбөрүүдийг тухайн засгийн газраас дэлгэрэнгүй тайлагнах, тухайн улсын иргэдийг оролцуулсан нээлттэй үүлзалт зохион байгуулах;
- Дотоодын банкуудын өмч эзэмшлийн бүтэц, санхүүгийн байдлыг ил болгох;
- Ил тод (Вэбд тулгуурласан), өрсөлдөөнт хангамж үйлчилгээ нэвтрүүлэх;
- Дэлхийн Банкны дэмжлэгтэйгээр хийдэг судалгаанууд шиг тухай орны засаглал, авилгалын эсрэг үйл ажиллагаа, төсвийн зарцуулалтын байдлын судалгааг тогтмол хугацаагаар хийж нийтэлдэг байх;
- Хотын түвшинд ил тод байдлын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, түүний дотор төсвийг ил тод болгох, нээлттэй үүлзалт ярилцлагууд хийх.

тогтолцоо гэх мэт чиглэлээр шинээр төрөн гарсан эдийн засгуудын голлох институциудэд зорилтот шинэчлэлийг үргэлжлүүлэн хийх зэрэг нь эдгээр шинэчлэлд нэмэр болж болно. Цаашилбал, шинээр төрөн гарсан эдийн засагтай орнуудад хотын түвшинд болон төвлөрлийг сааруулах чиглэлээр институцийн чанартай ахиц дэвшил гаргах болон авилгалын эсрэг тэмцэхэд хандивлагчдын хамтын нийгэмлэг туслалцаа үзүүлж болно.

Харин ихээхэн эмзэг институциудийг дэмжихэд чиглэсэн зорилтот шинэчлэл нь тухайн орны онцлогтой бодит байдалд зохицсон байх шаардлагатай бөгөөд улмаар тэргүүлэх чиглэл, тодорхой бүтэц загварын хувьд улс орон бүрт харилцан адилгүй байж болох юм. Зарим орны нэн тэргүүний тэргүүлэх чиглэл нь бараа, үйлчилгээний хангамжийн шинэчлэлийг дэмжих, парламент дахь хариуцлагат байдлын институциудийг бэхжүүлэх, хэвлэлийн эрх чөлөөг хөгжүүлэх асуудал байхад, зарим оронд нь шүүх тогтолцоо, эмэгтэйчүүдийн эрх, гаалийн байгууллагын шинэчлэл чухал байж болно. Иймээс юуны өмнө тухайн орны дотоодын мэргэжилтнүүд, байгууллагуудтай нягт хамтран ажиллаж улс орны түвшинд засаглалын нарийвчилсан оношлогоо хийх шаардлагатай²¹. Энэ нь өөрөө бусад ийм шинэчлэлийг хошуучлах ёстой бөгөөд хандивлагчид чухал, гэхдээ дэмжлэгийн чанартай, үүрэг гүйцэтгэх боломж олгоно.

Дүгнэлт: Засаглалын тухайд дэлхий дахины багц бодлого байх уу?

Өнөөдөр дэлхий дахинд тулгарч буй засаглалд болон авилгалын эсрэг үйл ажиллагаанд тулгарч буй сорилтууд нь бидний өдөр тутам хийдэг ажил хэргээс арай өөр зүйл шаардаж байна. Илүү шийдвэртэй арга барил хэрэгтэй, дэлхий нийтийн түвшинд хамтын хариуцлага хүлээх шаардлагатай байна. Энэ бүлэгт ярилцсан домгууд нь олон улсын хамтын нийгэмлэг, тодорхой улс орны зүгээс баримтлах стратеги, арга барилаа эргэж харах шаардлагатай байж болох чиглэлийг тодотгон харуулж байна. Засаглалыг сайжруулж, авилгалыг хянах явдал хөгжилд асар их нөлөөтэй бөгөөд хэрэв зохих стратеги, улс төрийн шийдэл гаргаж чадах юм бол улс орнуудын байдал богино хугацаанд ч гэсэн бодитойгоор сайжрах боломжтой юм.

Ямар ч стратегитай байсан, олон улсын хамтын нийгэмлэгийн дэмжлэг төдийгүй хувийн салбарын оролцоо ч үр шимээ өгөх

ёстой. Үнэн хэрэгтээ засаглал ба авилгалын асуудлууд бол шинээр төрөн гарч буй эдийн засгууд (буюу ядуу буурай ертөнцийн)-ын дангаар хүлээх хариуцлага биш төдийгүй ганц буруутан нь төрийн байгууллагууд биш юм. Баян орнууд зөвхөн зээл тусламж олгож, худалдааны либеральчлалын амлалт өгөөд зогсохгүй үлгэр жишээ үзүүлэн манлайлж байх ёстой. ЭЗХАХБ-ын хоцорч яваа орнууд ч гэсэн 2003 оны Авилгалын эсрэг НҮБ-ын Конвенцид нэгдэн орж, түүнийг үр нөлөөтэй хэрэгжүүлэх, мөн Швейцарь улсын эхлүүлээд байгаа шиг авилгалч албан тушаалтнуудын хууль бусаар олж, гадаадад нуусан хөрөнгийг эх оронд нь буцаах зэрэг тодорхой алхамууд хийх ёстой²². Түүнчлэн, ЭЗХАХБ-ын гишүүн орнууд ч хил дамнасан мөнгө угаалт, зэвсгийн худалдаанаас нүүрлэн буй сорилт бэрхшээлүүдийг хөндөн авч үзэх нь чухал байна.

Үндэстэн дамнасан корпорациуд гадаадад хээл хахууль өгөхөөс жийрхдэг болох, хүлээн авагч орнуудын засаглалын практикийг сайжруулахад хувь нэмрээ оруулдаг болохын тулд хамаагүй их зүйл хийх шаардлагатай байна. Авилгалын эсрэг ерөнхий зарчмууд, сайн дурын ёс зүйн дүрэм зэргийг бизнесийн компаниудын зүгээс хөхиүлэн дэмжих нь энэ талаарх мэдлэгийг дээшлүүлэхийн зэрэгцээ багагүй нөлөө үзүүлдэг боловч хувийн салбар (түүний дотор үндэстэн дамнасан компаниуд) хээл хахуульд орооцолдохоос зайлсхийхийг дэмжсэн илүү хатуу арга хэмжээ авч, ихээхэн урам зориг өгөх шаардлагатай байна. Мөн зөрчил гаргасан компаниудыг нийтэд ил болгож, өргөн хүрээтэй тарааж танилцуулах нь ноцтой жигшүүлэх арга байж болох юм. ОУСБ-ууд ба хандивлагчдын хувьд, засаглалын чиглэлд сайжруулалт хийж байгаа улс орнуудыг шагнаж урамшуулах, ихээхэн авилгалч засгийн газруудад их хэмжээний санхүүжилт өгөх нь ядууст тустай гэсэн үзлээсээ салах зэргээр зээл тусламжийн хөтөлбөрүүдийн сонголт, үр нөлөөтэй байдлын асуудлаар уйгагүй ажиллах шаардлагатай байна. Хандивлагчид зээл тусламжийн ихэнх төслүүдээ авилгал нэлэнхүйдээ газар авсан орчноос «тойруулан хаших» буюу тусгаарлаж болно гэсэн үзлээ орхих шаардлагатай.

Нэмэлт орлогын урсгал дангаараа засаглалыг сайжруулахгүй гэдэг нь тодорхой байна. Үнэн хэрэгтээ ямар нэг улсад засаглал сайжирсны үр дүнд илүү өндөр орлого бий болдогоос биш, өндөр орлогоос сайн засаглал бий болдоггүй гэдгийг бид мэдэж авлаа. Улс

орнууд голдуу хүнд хэцүү тусдаг улс төрийн болон институцийн шинэчлэлийг хийхдээ өөрсөддөө хариуцлага үүрүүлж, өөрсдөө манлайлах ёстой.

Тайлбар

- 1 Энэхүү зохиогч нь Дэлхийн Банкны Институтын Дэлхий Нийтийн Хөтөлбөрүүдийн захирал юм. Энэ бүлэг нь Аарт Крэй, Жоэл Хеллман, Массимо Матруцци, Ана Беллвер нартай хамтарсан төслүүдэд тулгуурласан бөгөөд Августо Лопез-Кларос болон Дэлхий дахины өрсөлдөх чадварын төслийн багтай хамтран ажилласны үр дүнд бий болсон. Үнэлж баршгүй туслалцаа үзүүлсэн Массимо Матруцци, Лорена Ленхарт нарт би талархал илэрхийлж байна. Энд илэрхийлсэн үзэл бодол, гаргасан алдаанууд нь зөвхөн зохиогчийнх юм. Эдгээр алдаа төдийгүй тоон үзүүлэлтүүд (алдааны хязгаарын хүрээнд байгаа, мөн улс орнуудын зэрэглэлийг нарийн гаргасан гэсэн үг биш) нь Дэлхийн Банкны албан ёсны үзэл бодлыг илэрхийлэх албагүй болно. Энэ бүлэгт орсон зарим дэлгэрэнгүй материалын хураангуй хувилбарыг ОУВС-гаас улирал тутам гаргадаг *Санхүү ба Хөгжил* сэтгүүлийн ирэх намрын дугаарт оруулах болно.
- 2 Энэхүү өгүүллийг бичих үед уг Конвенцид нэгдэж ороод байсан орнуудын зөвхөн ганц нь ЭЗХАХБ-ын гишүүн баян орон, үлдэх 28 орон болон удахгүй нэгдэн орох гэж байгаа орнууд нь шинээр төрөн гарч буй эдийн засагтай орнууд байна. Уг Конвенцид 100 хол давсан орнууд гарын үсэг зураад байгаа бөгөөд хүчин төгөлдөр болгохын тулд нэмж 30 улс гарын үсэг зурах шаардлагатай байна. Нэгэнт уг конвенцид нэгдэн орж дууссан (энэ нь тун удахгүй) тохиолдолд түүнд улс орнуудын зүгээс үр нөлөөтэй хяналт тавьж, хэрэгжүүлэх явдал гол асуудал байх болно.
- 3 Абацагийн дэглэмийн үед хууль бусаар олж Швейцарийн банкуудад нуусан хөрөнгийг удахгүй Швейцарьас Нигерид шилжүүлэх гэж байгаагийн ачаар анхдагч жишээ үүсгэсэн нэг тодорхой хэрэг одоогоор шийдэгдэж байна.
- 4 Кауфманн, 2003, 2004 он.
- 5 Нийт засаглалын үзүүлэлтүүдийн шинэчилсэн багцыг <http://www.worldbank.org/wbi/governance> гэсэн хаягаар авч болно. Иж бүрэн арга зүй, шинээр олж мэдсэн зүйлс, тоон үзүүлэлтийг бүхэлд нь Кауфманн нарын 2005 оны бүтээлээс олж авч болно.
- 6 Эдгээр тооцоог хэрхэн хийсэн тухай арга зүйн тайлбарыг Хавсралтаас үзнэ үү.
- 7 Тооцоог Алкала, Цикконе нар (2004), Асеомглу, Жонсон, Робинсон нар (2001), Кауфманн, Крэй хоёр (2002), Родрик, Субраманиан, Требби нар (2004)-ын бүтээлүүдээс авсан.
- 8 Уг Судалгаанд зарим бүс нутаг нилээд дутуу хамрагдсан учраас, бүс нутгийн дунджуудын хооронд нарийн харьцуулалт хийхдээ болгоомжтой хандахыг сануулж байна. Судалгааны хамрах хүрээ жилээс жилд тогтвортой өсч 2005 онд 117 орныг хамруулсан нь одоогийн байдлаар улс орнуудын хэмжээнд компаниудыг хамарсан хамгийн өргөн хүрээтэй судалгаа болж байна. Харин ихэвчлэн Ойрхи Дорнод, Африк, ТУХН-ийн зарим орон эдгээр судалгаанд хамрагдаагүй бөгөөд тэд судалгаанд хамрагдсан бусад орныг бодвол бүс нутагтаа засаглалаар хамгийн доогуур үнэлгээ авах хандлагатай байна.
- 9 Алонсо-Терме нар, 1998.
- 10 Бурнсайд, Доллар хоёр, 1999.
- 11 Ишам нар, 1997 ба Доллар, Левин хоёр. 2005-г үзнэ үү.
- 12 Тухайлбал, Сул дорой улсуудын асуудлаарх Комиссийн Тайлан (2004), Кауфманн (2004)-г үзнэ үү. Эдгээр нь голдуу бие биеэс нь тусд нь авч үзэж ханддаг засаглал ба аюулгүй байдлын асуудлуудын зарим нэг сонгож авсан уялдаа холбооны талаар бичсэн байна. Мөн нэг улсын буруу засаглалаас болж өөр нэг улсад терроризмын даяаршлагдсан үр дагавар үүсч болзошгүй байгааг дахин дурдах нь зүйтэй.
- 13 Дэлгэрэнгүй Кауфманн нарын 2005 оны бүтээлээс үзнэ үү.
- 14 Хөрөнгө оруулалтын уур амьсгалыг юу бүрдүүлдэг талаарх тодорхойлолт, үзэл бодлууд хүртэл засаглалын хүчин зүйлсийн ач холбогдлыг дутуу үнэлэх хандлагатай байдаг. Тун саяхан хүртэл энд тавих анхаарал харьцангуй явцуу байж, дээд байгууллагаас гаргасан эдийн засаг, санхүү, эрх зүйн зохицуулалтуудыг гол болгосон хөрөнгө оруулалтын уур амьсгалыг бүрдүүлэгч уламжлалт багц хүчин зүйлсэд анхаарч, засаглалын улс төрийн хэмжээсүүдээс салган авч үздэг байв. Хөрөнгө оруулалтын уур амьсгалын тухай үзэл бодол, судалгаа шинжилгээнд нэг тийш хазайсан хандлага байгааг энгийн нэг Вэб хайлт харуулж байна. Фактива хайлтын систем ашиглан (онлайн хаяг <http://www.factiva.com>) нэр хүндтэй бүтээлүүдээс хайж үзэхэд 1996 оноос хойш бичигдсэн хөрөнгө оруулалтын уур амьсгалын тухай 10000 орчим өгүүлэл байгаагийн 50 гаруй хувь нь эдийн засаг буюу бодлоготой холбоотой асуудлуудыг авч үзсэн, 30 хувь нь мөнгө, санхүүгийн хүчин зүйлсийг онцолсон, 20 орчим хувь нь хууль, эрх зүйн асуудлуудыг хөндсөн, харин 10 хүрэхгүй хувь нь авилгал буюу засаглалтай холбоотой асуудлуудыг авч үзсэн байна. Энэ нь ном зохиол дээрх хөрөнгө оруулалтын уур амьсгалд хандах хандлага өөрөө судалгаагаар үйлдвэр аж ахуйн газрууд өөрсдийн үйл ажиллагаанд юу хамгийн хүндрэл бэрхшээлтэй байна гэж хариулж байгаатай нийцэхгүй байна гэсэн үг.
- 15 Эдгээр нь хуучныг баримталсан тооцоо бөгөөд Судалгаанд хамрагдсан орнуудын түүвэрт тулгуурласан болно. Нэг талаас үндэстэн дамнасан корпорациудын хээл хахууль өгөх дур сонирхол, нөгөө талаас хөрөнгө оруулалтыг хүлээн авч буй орны дотоод авилгалын ерөнхий цар хүрээ хоёрын хооронд шууд корреляцийн хамааралтай байгаа учраас уг Судалгаанд хамрагдаагүй орнуудын хувьд ийм хээл хахууль газар авсан байдал бүр ч өндөр байж болно.
- 16 Фрийдом Хаус, онлайн хаяг: <http://www.freedomhouse.org>
- 17 Жишээлбэл, Африкийн Сахар орчмын дэд бүс нутгийн 17 орны пүүс компаниудын хариуцлын 29 хувь нь тухайн оронд хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэлж болох зүйлсэд маш ноцтой дарамт учруулдаг гэж үзсэн байхад дээрх орнуудад ихээхэн сэтгэл ханамжгүй байгаа хариулагчдын эзлэх хувь 41 хувь болтол өссөн байна.
- 18 Штиглиц (1999), Сен (1981)-г үзнэ үү.
- 19 Цаашилбал, ил тод байдлын тухай тодорхой цөөн тооны ном сурах бичиг байгаа нь ил тод байдлыг хэрэглэж болохуйц бодлогын зөвлөгөө ба арга хэмжээ болохуйцаар тусгай бүрэлдэхүүн хэсгүүдэд задлан хувааж байна. Манай энэхүү байнгын судалгаа нь эдгээр туршилтын болон бодлоготой холбоотой зөрөөнүүдийг хэсэгчлэн нөхөхийг оролдож байгаа юм. Бид ил тод байдлын янз бүрийн хэмжээсээр дэлхий нийтийг хамарсан үзүүлэлтүүдийн туршилт судалгааны хүрээг гаргах үүднээс саяханы нэг бүтээлдээ одоо байгаа ном сурах бичгүүдийг тоймлон судалж ил тод байдлын янз бүрийн тодорхойлолт гаргасан байгаа. Эдгээр анхан шатны туршилтын үр дүн нь ил тод байдлын шинэчлэлтэй холбоотой тодорхой бодлого, институцийн шинэ санаачилгууд гаргахад туслах зорилготой юм. Беллвер, Кауфманн нар (2005)-ыг үзнэ үү.
- 20 Улс орнуудын дотоод дахь ил тод байдал бүр ч олон янз байна. Тухайлбал, ил тод байдлын эдийн засгийн буюу институцийн чанартай болон улс төрийн чанартай хэмжээсүүдийн байдал ялгаатай, үүнтэй холбоотойгоор аливаа улсын дотоод дахь институциудийн ил тод байдлын чиглэлд явуулж буй үйл ажиллагааны арга барил өөр өөр байна.
- 21 Тухайн улс үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулахдаа өөрөө манлайлан оролцдог оролцоот засаглалын тухай нарийвчилсан оношлогоог улс орны түвшинд хийх талаар дэлгэрэнгүй мэдээллийг <http://www.worldbank.org/wbi/governance/capacity-build> хаягаар үзнэ үү.
- 22 ЭЗХАХБ-ын гишүүн зарим баян оронд шинээр төрөн гарсан эдийн засагтай зарим улсад байдгаас ч илүү их авилгал байгааг энд тэмдэглэх ёстой. Иймээс ЭЗХАХБ гишүүн орнуудынхаа дунд тавьж буй хүчин чармайлтаа эрчимжүүлэх ёстой.

Лавлах материалууд

- Acemoglu D., S.Johnson, and J.A.Robinson. 2001. "The Colonial Origins of Comparative Development: An Empirical Investigation." /Харьцуулсан хөгжлийн колонийн гарал үүсэл: Туршилтын судалгаа шинжилгээ/ *American Economic Review* /Америкийн эдийн засгийн тойм/ 91(2):1369-1401.
- Alcala, F. and A. Ciccone. 2004. "Trade and Productivity." /Худалдаа ба бүтээмж/ *Quarterly Journal of Economics* /Улирал тутмын Эдийн засгийн сэтгүүл/ 119 (2)5 613-46.
- Alonso-Therme, R., H.Davoodi, and S.Gupta. 1988. "Does Corruption Affect Income Inequality and Poverty?" /Орлогын тэгш бус байдал ба ядууралд авилгал нөлөөлдөг үү?/ IMF Working Papers /ОУВС-ийн ажлын тайлангууд/ 98/76. Washington, DC.
- Bellver, A. and D.Kaufmann. 2005. "Transparency and Transparency: Initial Empirics and Policy Application." /Ил тод байдлыг илчлэхүй: Анхны туршилт судалгаа ба бодлогын хэрэглээ/ World Bank Policy Research Working Paper /Дэлхийн Банкны бодлогын судалгааны ажлын тайлан/. Washington, DC. Forthcoming.
- Burnside, C. and D.Dollar. 1999. "Aid, Policies and Growth." /Тусламж, бодлогууд ба өсөлт/ World Bank Policy Research Working Paper Series /Дэлхийн Банкны бодлогын судалгааны ажлын цуврал тайлан/ 1777. Washington, DC: World Bank.
- Camdessus M. 1998. "Money Laundering: the Importance of International Countermeasures." /Мөнгө угаалт: Олон улсын сөрөг арга хэмжээний ач холбогдол/ Address by Michael Camdessus at the Plenary Meeting of the Financial Action Task Force on Money Laundering. Paris. 10 February.
- Commission for Africa /Африкийн Комисс/. 2005. *Our Common Interest: Report of the Commission for Africa* /Бидний нийтлэг ашиг сонирхол: Африкийн Комиссийн тайлан/. London.
- Center for Global Development /Дэлхий нийтийн хөгжлийн төв/. 2004. "On the Brink: Weak States and US National Security." /Ангальн ирмэг дээр: Сул дорой улсууд ба АНУ-ын аюулгүй байдал/ Commission on Weak States and US National Security /Сул дорой улсууд ба АНУ-ын аюулгүй байдлын комисс/. Washington, DC.
- Dollar, D. and V.Levin. 2005. "Sowing and Reaping: Institutional Quality and Project Outcomes in Developing Countries." /Тариалалт ба ургац хураалт: Хөгжиж буй орнуудын институцийн чанар ба төслийн үр дүнгүүд/ Policy Research Working Paper Series /Бодлогын судалгааны ажлын цуврал тайлан/ 3524. Washington, DC: World Bank.
- Factiva /Фактива хайлтын систем/. Online at: <http://www.factiva.com>
- Freedom House /Фрийдом Хаус/. 2005. "Freedom of the Press Indicators." /Хэвлэлийн эрх чөлөөний үзүүлэлтүүд/ Online at: <http://www.freedomhouse.org>
- Friedman E., S.Johnson, and D.Kaufmann. 2000. "Dodging the Grabbing Hand: The Determinants of Unofficial Activity in 69 Countries." /Булаан авагч гараас бултахуй: 69 орны албан бус үйл ажиллагааны тодорхойлогч хүчнүүд/ *Journal of Public Economics* /Төрийн эдийн засгийн сэтгүүл/ 76(3): 459-493.
- Heston, A., R.Summers and B.Aten. 2002. *Penn World Table Version 6.1* /Пенн Уорлдын хүснэгтэн хувилбар/. Philadelphia: Center for International Comparisons at the University of Pennsylvania /Пеннсилвань их сургуулийн олон улсын харьцуулалтын төв/ (CICUP).
- Isham, J., D.Kaufmann, and L.Pritchett. 1997. "Civil Liberties, Democracy, and the Performance of Government Projects." /Иргэний эрх чөлөө, ардчилал ба засгийн газрын төслүүдийн гүйцэтгэл/ *World Bank Economic Review* /Дэлхийн Банкны Эдийн Засгийн Тойм/ 11(2): 219-2.
- Kaufmann, D. 2002. "Governance Crossroads." /Засаглалын замын үүлзвар/ *The Global Competitiveness Report 2002-2003*. World Economic Forum. /2002-2003 оны Дэлхий дахины өрсөлдөх чадварын тайлан, Дэлхийн Эдийн Засгийн Форум/ New York: Oxford University Press.
- _____. 2003. "Governance Redux: The Empirical Challenge." /Засаглалын редукс: Туршилт судалгааны хүндрэл бэрхшээлүүд/, *The Global Competitiveness Report 2003-2004*. /2003-2004 оны Дэлхий дахины өрсөлдөх чадварын тайлан/ New York: Oxford University Press.
- _____. 2004. "Corruption, Governance and Security: Challenges for the Rich Countries and the World." /Авилгал, засаглал ба аюулгүй байдал: Баян орнууд ба дэлхийн хэмжээнд тулгарч буй бэрхшээл сорилтууд/ *The Global Competitiveness Report 2004-2005*. World Economic Forum. /2004-2005 оны Дэлхий дахины өрсөлдөх чадварын тайлан, Дэлхийн Эдийн Засгийн Форум/ New York: Oxford University Press.
- Kaufmann, D., and A.Kraay. 2002. "Growth Without Governance." /Засаглалгүй өсөлт/ *Economia* 3(1): 169-215.
- Kaufmann, D. and M.Mastruzzi. 2005. "Corruption: A Trillion Dollar 'Industry'?" World Bank /Авилгал: Триллион долларын "салбар" үү?, Дэлхийн Банк/. Washington, DC. Forthcoming.
- Kaufmann, D., A.Kraay, M.Mastruzzi. 2005. "Governance Matters IV: Governance Indicators for 1996-2004." /Засаглалын асуудлууд IV: 1996-2004 оны засаглалын үзүүлэлтүүд/. World Bank Policy Research Working Paper /Дэлхийн Банкны бодлогын судалгааны ажлын тайлан/ 3630. Washington, DC.
- Levin, M. and G.Satarov. 2000. "Corruption and Institutions in Russia." /Орос дахь авилгал ба институцид, Улс төр, эдийн засгийн Евросын сэтгүүл/ *European Journal of Political Economy* 16:113-37.
- Organization for Economic Co-operation and Development /Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллага/. 1998. "The Size of Government Procurement Markets." /Засгийн газрын хангамж үйлчилгээний зах зээлийн хэмжээ, ЭЗХАХБ-ын Төсөвлөлтийн тухай сэтгүүл/ *OECD Journal on Budgeting* 1(4).
- Rodrik, D., A.Subramanian, and F.Trebbi. 2004. "Institutions Rule: The Primacy of Institutions over Geography and Integration in Economic Development." /Институцийн засаглал: Эдийн засгийн хөгжилд институциуд газар зүй, нэгдэлтээс илүү чухал болох нь, Эдийн засгийн өсөлтийн тухай сэтгүүл/. *Journal of Economic Growth* 9(2): 131-165.
- Satarov G. and M.Levin. 2005. "Corruption in Russia: Dynamics and Perspectives." /Орос дахь авилгал: Өсөлт хөгжил ба хэтийн төлөв байдал/. Moscow: INDEM.
- Schneider, F. and D. Enste. 2002. "Shadow Economies Around the World: Size, Causes and Consequences." /Дэлхийн эргэн тойронд буй сүүдийн эдийн засгууд: Хэмжээ, шалтгаан, үр дагаварууд/. IMF WP/00/26.
- Sen, A. 1981. *Poverty and Famines: An Essay on Entitlement and Deprivation*. /Ядуурал ба өлсгөлөн: Эрх олголт ба гачигдал зовлонгийн тухай эсээ/ Oxford: Oxford University Press.
- Stigkitz, J.E. 1999. "On Liberty, the Right to Know, and Public Disclosure: The Role of Transparency in Public Life." /Эрх чөлөө, мэдэх эрх ба олон нийтэд ил тод болгох явдлын тухай: Олон нийтийн амьдралд ил тод байдлын гүйцэтгэх үүрэг/. Oxford Amnesty Lecture.
- United States Central Agency /АНУ-ын Төв Агентлаг/. 2001. *The World Factbook* /Дэлхийн тоо баримтуудын ном/. Online at: <http://www.cia.gov/cia/publications/factbook>
- United States Census Bureau /АНУ-ын Тооллогын Товчоо/. 2002. *Economic Census, Table 1. Advance Summary Statistics for the United States*. /Эдийн засгийн тооллого, Хүснэгт 1. АНУ-ын хөгжлийн ерөнхий статистик/ Washington, DC. Online at: <http://www.census.gov/econ/census02/advance/TABLE1.HTM>
- Walker, J. 1999. "Measuring Extent of International Crime and Money Laundering." /Олон улсын гэмт хэрэг ба мөнгө угаалтын цар хүрээг хэмжих нь/. Paper prepared for KriminalExpo Conference. Budapest. /Будапештэд болсон КриминалЭкспо бага хуралд зориулсан илтгэл/. June.
- World Bank /Дэлхийн Банк/ 1997. *Governance Databank*. /Засаглалын тоон мэдээллийн сан/. Online at: http://www.worldbank.org/wbi/governance/govdata/unofficial_data.xls
- _____. 2004. *Country Policy and Institutional Assessments* /Улс орны бодлого ба институцийн үнэлгээ/. Washington, DC.
- _____. 2000. *World Business Environment Survey*. /Дэлхийн бизнесийн орчны судалгаа/. Washington, DC. Online at: http://www.worldbank.org/privatesector/ic/ic_ica_resources.htm.
- _____. 2000-2003. Various diagnostics surveys for various countries /Янз бүрийн оронд зориулсан янз бүрийн оношлогооны судалгаа/. Online at: <http://www.worldbank.org/wbi/governance/capacitybuild>

World Bank Institute /Дэлхийн Банкны Институт/. 2002. "The Right to Tell: The Role of Mass Media in Economic Development." /Хэлэх эрх: Эдийн засгийн хөгжилд олон нийтийн мэдээллийн хэрэгсэлийн гүйцэтгэх үүрэг/. World Bank. Washington, DC.

_____. Various years /янз бүрийн онууд/. Governance Databank. /Засаглалын мэдээллийн сан/ Online at: <http://www.worldbank.org/wbi/governance/data/html>

_____. 2003. Governance Survey. /Засаглалын судалгаа/ Online at: http://www.wbigf.org/hague/hague_survey.php3

World Economic Forum /Дэлхийн эдийн засгийн форум/. 2003. *The Global Competitiveness Report 2003-2004*. /2003-2004 оны Дэлхий дахины өрсөлдөх чадварын тайлан/. New York: Oxford University Press.

_____. 2004. *The Global Competitiveness Report 2004-2005* /Дэлхий дахины өрсөлдөх чадварын тайлан 2004-2005/. Hampshire: Palgrave Macmillian.

Хавсралт: 1 триллион ам. долларын хэмжээтэй дэлхийн нийтийн хээл хахууль: хэмжилтийн аргуудын нэгтгэлт¹

Бид энд дэлхий нийтийн хээл хахуулийн хэмжээний жилийн ойролцоо дүнг тооцоход хэрэглэсэн аргыг товчхон танилцуулж байна. Манай тооцооны хүрээг гаргаж буй янз бүрийн дүр төрх, төсөөллийн дагуу тооцоо хийж үзлээ. Эдгээр тооцооны дүнд гарсан нэг боломжит хэмжээ ойролцоогоор 1 триллион ам.доллар орчим байх боловч илтгэлцлийн завсар харьцангуй өргөн байгааг дараахь байдлаас харж болно. Ямар ч байсан хамгийн хуучинсаг төсөөллөөр бол энэ дүн 600 тэрбум ам.доллараас бага байх магадлал тун бага бөгөөд нөгөө талаас байж болох хэмжээний жилийн дүн 1.5 триллион ам.доллараас хол давах магадлалтай байна.

Дээр нь бид байгаа ном сурах бичгүүдийг тоймлон үзэж тооцооны аргын өөрхувилбаруудыг эрж хайсан нь өөрсдийн аргаар гаргасан ойролцоо тоог бусад эх сурвалж, судалгаануудаас авсан бие даасан итгэлцүүрүүдтэй зүгээр харьцуулж үзэх байдлаар энэхүү тооцооныхоо хүчинтэй байдлыг гаднаас нь баталгаажуулах маягийн дасгал байлаа. Уг аргыг дараахь байдлаар дүрслэн харуулав.

Хээл хахуулийн жилийн дүнг тооцох стратеги маань судалгааны бэлэн тоон үзүүлэлтүүдэд тулгуурласан бөгөөд энд пүүс компаниуд ба айл өрхүүд жилд төлж буй хээл хахуулийнхаа дундаж дүнг компанийхаа нийт борлуулалт буюу өрхийн орлогод эзлэх хувиар тодорхойлж хариулсан байгаа. Үүнээс үүдэн бид тухайн улсын нийт хүн ам түүвэр судалгаанд хамрагдсан хүн амынхтай ижил хэв шинжтэй байна гэж төсөөлөхийн зэрэгцээ эдгээр судалгаанд хамрагдаагүй орнуудын хувьд экстраполяци хийж үзсэн.

Энэ тооцоонд бид янз бүрийн үйлдвэр аж ахуйн газар, айл өрхийг хамруулсны дотор үйлдвэр аж ахуйн газрын хоёр өөр судалгааг оруулсан. 2000 онд 81 орны пүүс компаниудаас 10033 хариулт авч хийгдсэн Дэлхийн Банкны Үйлдвэрийн Газруудын Судалгаа (ДБҮГС), 104 орноос 8,729 хариулт цуглуулж судласан Дэлхий Дахины Өрсөлдөх Чадварын Судалгаа (Судалгаа 2004). Бид мөн Засаглал ба авилгалын оношлогооны 16 өөр судалгааны хүрээнд Дэлхийн Банкнаас удирдан явуулсан өрхийн судалгааны үр дүнг ашигласан. Энэ бүхнээс бид экстраполяци хийж дэлхийн хэмжээний хээл хахуулийн дүнг тооцоолон гаргасан. Дээр дурдаж байсанчлан, авилгалын чиглэлээр тоон мэдээлэл цуглуулахад зөрөө, хэмжилтийн

алдаа, хүндрэл бэрхшээл их гардаг учраас хамгийн багаас хамгийн их хуучинсаг хүртэл янз бүрийн төсөөлөл ашиглаж, бий болгосон олон дүр төрхийн дагуу тооцоо хийж үзсэн. Үнэн хэрэгтээ, энэхүү дасгалын үндсэн зорилго бол яг нарийн тоо гаргах гэж будилуулж байсны оронд уг тооцооны байж болох урьдчилсан хүрээг гаргах явдал байв.

Айл өрхүүдээс төлж буй хээл хахуулийн дүнг тооцоолохдоо, юуны өмнө 1999-2003 оны хугацаанд 16 оронд хийгдсэн оношлогооны судалгаануудаас хээл хахуулийн нийт орлогод эзлэх хувийг гаргаж авахыг зорьсон. Бид өрхийн хээл хахууль төлөлтийн эдгээр бэлэн тооцоог манай засаглалын үзүүлэлтүүдийн нэгдсэн сангаас авсан (дэс тоон хуваариар нэрлэгдсэн) авилгалын хяналтын үзүүлэлттэй харьцуулж, улмаар өрхийн судалгааны хариултуудаас тооцож гаргасан хээл хахуулийн орлогод эзлэх хувь (үр дүнгийн хувьсагч) ба авилгалын хяналтын хувьсагч хоёрын хооронд регрессийн шинжилгээ хийж үзсэн. Дараа нь үүний үр дүнд гарсан регрессийн итгэлцүүр ба авилгалын хяналтын хувьсагчийн бодит утга хоёрыг ашиглаж, аливаа улс орны оношлогооны тайлангаас шууд хэмжигддэггүй өрхийн орлогод хээл хахуулийн эзлэх хувийн үзүүлэлтийг тухайн улсын хэмжээгээр тооцоолон гаргасан. Энэ нь, бүх улс орны хэмжээгээр хувийн орлогод өрхийн хээл хахуулийн эзлэх хувийг тооцох боломжийг олгосон. Улс орон бүрийн тооцооны дүнг түүний ДНБ-ээр үржүүлж, дараа нь ДНБ-д хувийн хэрэглээний эзлэх хувийн харьцаа болох 0.7-оор үржүүлсэн.²

Бизнесийн байгууллагуудын хээл хахуулийн хэмжээг тооцохдоо ДБҮГС ба Судалгаа 2004 гэсэн хоёр өөр судалгаанд тулгуурлан, тэдгээрийг өөр өөр хувилбарын тооцооны дүр төрхүүд болгон тус тус ашигласан. Дүр төрх бүрт, захиргааны хээл хахуулийн эзлэх хувь хэмжээ (борлуулалтад) болон төрийн хангамж үйлчилгээний гэрээг найдвартай авахын тулд төлсөн хээл хахуулийн хэмжээ (гэрээний дүнд эзлэх хувь) хоёрын тухай асуултад пүүс компаниудын өгсөн тоон хариултыг үндэс болгон дэлхийн хэмжээний хээл хахуулийн хувь хэмжээг экстраполяцийн аргаар тооцон гаргасан. Хээл хахуулийн дүнгийн байж болзошгүй өргөн хүрээтэй хэмжээг тооцон гаргахын тулд өөр өөр төсөөллийн (түүний

Хавсралт: 1 триллион ам. долларын хэмжээтэй дэлхийн нийтийн хээл хахууль: хэмжилтийн аргуудын нэгтгэл¹ /Үргэлжлэл/

дотор маш хуучинсаг төсөөллүүдийн) дагуу бий болсон олон тооны дүр төрхийн мэдрэх чадварын шинжилгээг хийж гүйцэтгэсэн.

ДБҮГС-ны хувьд дэлхийн хэмжээний захиргааны хээл хахуулийн хэмжээг тооцоолохдоо, хээл хахуулийн дэлхийн хэмжээний жигнэсэн дундаж хувийн үзүүлэлт ба ДНБ-д бизнесийн салбарын оруулах хувь нэмрийг илэрхийлэх итгэлцүүр болох 0.7-оор багасгасан нийт ДНБ-ий (цэвэр хангамж) үзүүлэлт хоёрын үржвэрээр тооцсон байгаа. Харин хээл хахуулийн дундаж хувийг 2000 оны ДБҮГС-ны дүнгээс авсан бөгөөд ингэхдээ нэг хүнд ноогдох ДНБ-ий түвшингээр нь жигнэж, дараа нь дундаж цэгүүд (үндсэн дүр төрх) эсвэл эхний цэгүүд (хуучинсаг дүр төрх)-ийн аль нэгийг ашиглан хөрвүүлсэн байгаа.

Судалгаа 2004-д тулгуурласан хувилбарын хувьд захиргааны хээл хахуулийн хэмжээг тооцоолохдоо, мөн л хээл хахуулийн дэлхийн хэмжээний жигнэсэн дундаж хувь ба ДНБ-д бизнесийн салбарын оруулах хувь нэмрийг илэрхийлэх итгэлцүүр болох 0.7-оор багасгасан нийт ДНБ-ий (цэвэр хангамж) хэмжээ хоёрын үржвэрээр тооцсон. Харин дэлхийн хэмжээний хээл хахууль ба хангамжийн дундаж хувийн үзүүлэлтийг 2004 Судалгааны үр дүнгээс авсан бөгөөд ингэхдээ нэг хүнд ноогдох ДНБ-ий түвшингээр нь жигнэж тооцсон байгаа.

Олон өөр төсөөллийн дагуу бий болсон олон тооны дүр төрхөөс мөн л олон тооны үр дүн, олон янзын тоо хэмжээ гарч байлаа. Нийтдээ 138 янзын дүр төрх, түүний дотор ДБҮГС-д тулгуурласан 48, Судалгаанд тулгуурласан 90 дүр төрхийг бий болгож ашигласан бөгөөд дор бүрнээ тоон шинжилгээний «хуучинсаг байдал»-ын өөр өөр түвшин бүхий олон янзын дүр төрх, төсөөллүүд агуулж байлаа. Жишээлбэл, олон дүр төрхийн хувьд аливаа пүүс компаний төлж буй хээл хахуулийн эзлэх хувийг санал асуулгын асуултуудын дундаж цэгүүдийг ашиглан тооцоолохын оронд уг асуултад боломж болгож оруулсан завсар бүрийн эхний цэгүүдээр тооцоолж байв.

Бид өрхийн хээл хахуулийн хэмжээг ДБҮГС-ны компаниудын судалгаанд тулгуурлан тооцсон компаниудын хээл хахуулийн хэмжээн дээр нэмэх байдлаар гаргасан нийт 48 тооцоог ашиглавал хээл хахуулийн дундаж дүн 1.25

триллион ам.доллар (1.18 триллион ам.долларын голч утгатай) гарч байна. Хэрэв бид бизнесийн салбарын хээл хахуулийн тооцоонд ДБҮГС-ны оронд Судалгааны тоо баримтуудыг ашиглавал хээл хахуулийн дундаж хэмжээ арай бага буюу 830 тэрбум ам.доллар орчим (820 тэрбум ам.долларын голч утгатай) гарч байна.

Нийт 138 дүр төрхөөс хэрвээ хоёр захын «үзүүрүүд» болох тус бүр 5 хувийн хэсгийг хасвал тооцооны (боломжийн үндэслэлтэй) завсар 604 тэрбум ам.доллараас 1.76 триллион ам.долларын хооронд байх юм. Ингээд энэхүү дасгалаас дүгнэж үзэхэд, хээл хахуулийн жилийн дүнгийн үндэслэлтэй завсар жилд 0.6-1.5 триллион ам.долларын хооронд байхаар байгаа бөгөөд боломжит дундаж цэг нь 1 триллион ам.доллар орчим байна. Бид гол нь хээл хахуулийн мөнгөн гүйлгээг тооцоход анхаарсан учраас 1 триллион ам.доллар орчмын дүн нь улсын төсвөөс авилгалд зарцуулж байгаа эсвэл улсын өмч хөрөнгийг ашиглан шамшигдуулж байгаа болон хамаатан саднаа илүүд үзэх гэх мэт бусад хэлбэрийн авилгалыг оруулаагүй гэдгийг энд тэмдэглэх ёстой.

Гадаад хяналтууд ба баталгаажуулалт

Эдгээрбүдүүнтөймтооцоонуудынбодитбайдлыг шалгахын тулд энэ чиглэлийн ном зохиолын судалж байгаа тооцоонуудыг олж авахыг зорьсон. Гэтэл дэлхий нийтийн хэмжээний хээл хахуулийн тухай ямар нэг тооцоо байгаагүй учраас эрэл хайгуулаа өргөтгөж, албан бус эдийн засаг, мөнгө угаалт гэх мэт холбогдох чиглэлийн тооцоонуудыг судласан. Авилгал болон түүнтэй холбоотой бусад итгэлцүүрийн хувьд бид мөн ном зохиолын болон тоон үзүүлэлтийн судалгаа хийсэн бөгөөд албан бус эдийн засаг, мөнгө угаалт болон бусад хээл хахуулийн хэмжээний тооцоог гаргаж байна. Албан бус эдийн засгийн хэмжээний хувьд бид Шнайдер, Энште нар (2002) болон Фрийдман нарын (2000) тооцоонд тулгуурлаж байна. Мөнгө угаалтын хувьд, ОУВС-гийн судалгаа (Камдессус, 1998) болон Жонн Уолкерийн (1998) бичсэн тайланг ашиглаж байна. Эцэст нь хээл хахуулийн тухай бусад тооцоонууд хэдийгээр баттай бус ч бид онлайн судалгааны үр дүн ба саяхан хийсэн Орос дахь авилгалын судалгааны тайланг харгалзсан.

Хавсралт: 1 триллион ам. долларын хэмжээтэй дэлхийн нийтийн хээл хахууль: хэмжилтийн аргуудын нэгтгэлт¹ /Үргэлжлэл/

Дэлхийн хэмжээгээр албан бус эдийн засгийн хэмжээ 3.4-5.1 триллион ам.долларын хооронд байна

Албан бус эдийн засгийн тухай хамгийн анхны, арай бага үнэлгээг Фрийдман нарын судалгааны болон Дэлхийн банкны засаглалын мэдээллийн сангийн³ тоон үзүүлэлтүүдэд тулгуурлан 1997 оны улс орон бүрийн албан бус эдийн засгийн дүнгийн нийлбэрээр тооцоолсон бөгөөд 2002 оны ДНБ-ий хэмжээг (тогтоосон хувь хэмжээнд сүүлийн таван жилийн турш өөрчлөлт гараагүй гэж төсөөлөн) уг мэдээллийн санд хамрагдаагүй орнуудын албан бус эдийн засгийн хувь хэмжээ ижилхэн чиг хандлагатай байсан гэж үзээд 1.19 гэсэн харьцаагаар тохируулж дээрх дүнтэй холбосон байгаа. Үүнээс арай өндөр тооцоог Шнайдер, Эрнште нарын (2002) судалгаагаар гаргаж авсан бөгөөд тэд хөгжиж байгаа болон хөгжилтэй 76 орны сүүдрийн эдийн засгийн хэмжээг тооцож гаргасан байна. Тэдний хийсэн тооцооны үр дүн сүүдрийн эдийн засгийн хэмжээ их байгааг тод томруун харуулдаг. Тэдний тооцоогоор ЭЗХАХБ-ын гишүүн 21 орны далд эдийн засаг 1989 онд 2 триллион ам.доллар (ДНБ-ий 12.7 хувь) байсан бол 2001 онд 3.4 триллион ам.доллар (ДНБ-ий 16.7 хувь) болж өссөн байна. Гэхдээ албан бус эдийн засгийн олон гүйлгээ заавал авилгал байх албагүй, мөн үүний эсрэгээр, хээл хахууль, авилгалын олон гүйлгээ заавал албан бус эдийн засагт явагдах албагүй гэдгийг энд тэмдэглэх нь зүйтэй.

Дэлхийн хэмжээгээр мөнгө угаалтын хэмжээ: 600-2800 тэрбум ам.доллар

ОУВС-гийн 1998 оны нэгэн судалгаагаар, дэлхий дээрх нийт мөнгө угаалтын хэмжээ дэлхийн дотоодын нийт бүтээгдэхүүний дүнгийн 2-5 хувь орчимд буюу 600 тэрбумаас 1.5 триллион ам.доллар байж болзошгүй гэж тооцсон байна. Үүнтэй холбоогүй өөр нэг судалгаа болох Жонн Уолкерийн 1999 оны судалгаанд, зохиогч мөнгө угаалтын хэмжээ 2.8 триллион ам.доллар байна гэсэн хувилбарыг дэвшүүлжээ. Тэрээр НҮБ-ын Олон улсын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх төвд бүртгэгдсэн гэмт хэргийн статистик тоо баримтуудын сан, Гэмт хэргийн чиг хандлагын тухай НҮБ-ын судалгаа, Эрүүгийн эрх зүйн тогтолцооны үйл ажиллагаа зэргээс авсан тоо

баримтуудыг ашиглан улс орон бүрт гэмт хэргийн 11 төрөл бүрээр бүртгэгдсэн гэмт хэргийн тоог эхэлж тооцоолсон байна. Дараа нь зохиогч энэ загвараа ашиглан аливаа улсын дотоодод эсвэл аль нэг гадаад оронд (бүртгэгдсэн гэмт хэрэг бүрт) угаагдсан мөнгөний нийт хэмжээг тооцоолжээ. Энэхүү тооцоонд улс орон бүрээр авилгал болон орлогын түвшинг харгалзан экстраполяци хийсэн байна.

Хээл хахуулийн хэмжээний тухай бусад тооцоо: 1 триллион ам.доллар ба түүнээс дээш

Цаашлаад, 2003 онд Дэлхийн Банкны Институтээс⁴ хийсэн засаглалын тухай онлайн судалгаанаас «Дэлхийн хэмжээгээр бохир хангамжид хээл хахууль төлөлт»-ийн дүн тусдаа гарсан байна. Энэхүү тооцоог бүс нутгийн хэмжээний хангамжийн дүнгийн нийлбэр (1998 оны дэлхийн хэмжээний хангамжийн дүн 5.5 триллион ам.доллар байсан гэснийг ашиглаж) ба уг хангамж дахь хээл хахуулийн эзлэх хувийн холбогдох үзүүлэлтээр тооцоолон гаргажээ. Хээл хахуулийн хувийг судалгааны үр дүнгүүдийн дундаж утгыг шууд ашиглан гаргасан байна. Энэхүү бие даасан Вэб хуудаснаас гарсан дүн нь 1 триллион ам.доллар орчим болсон байна. Гэхдээ энд хээл хахуулийн зөвхөн нэг чиглэл болох хангамжид голлон анхаарч байгааг тэмдэглэх ёстой. Алдааны хязгаар ба түүврийн үнэлгээний бодит байдлыг гуйвуулах явдал (Вэб дээрх сайн дурын судалгаагаар дамжин) их байх боломжтой гэдэг үүднээс энэ дасгалд болгоомжтой хандах ёстой.

Эцэст нь Орос дахь хээл хахуулийн байдлыг судласан нэгэн шинэ судалгаа (Сатаров, Левин нар, 2005) хэрэв батлагдах юм бол, дэлхийн хэмжээгээр авилгал маш их байна гэсэн дүн гарахаар байна. Энэ тайланд жилийн нийт хээл хахуулийн хэмжээ 316 тэрбум ам.доллар буюу Оросын ДНБ-ий 73 хувиас давна гэж тооцжээ. Энэ мэтийн тоо баримт үнэн хэрэгтээ бодит байдлыг хэтрүүлэн үнэлсэн, мөн Оросын хувьд үнэн бодит хэмжээ нь хамаагүй бага байсан ч гэсэн, дэлхийн дээрх хээл хахуулийн нийт хэмжээний хувьд жилийн дүн нь 1 триллион ам.доллараас хол илүү байж болно гэсэн үг юм.

**Хавсралт: 1 триллион ам. долларын хэмжээтэй дэлхийн нийтийн хээл хахууль:
хэмжилтийн аргуудын нэгтгэл¹ /Үргэлжлэл/**

Тайлбар

- 1 Энэ талаарх илүү дэлгэрэнгүй мэдээллийг зохиогчид өөрт нь хүсэлт гарган авч болно.
- 2 Энэхүү үндсэн дүр төрхийн олон янзын хувилбарыг гаргасан бөгөөд Кауфманн, Мастрucci нарын 2005 оны бүтээлд дэлгэрэнгүй дүрсэлсэн байгаа.
- 3 Онлайн хаяг: http://www.worldbank.org/wbi/governance/govdata/unofficial_data.xls
- 4 http://www.wbigf.org/hague/hague_survey.php3-г үзнэ үү.

БҮЛЭГ 2.2

Валютын Ханшны Өрсөлдөх Чадварыг Эргэн Харахуй

КЕННЕТ РОГОФФ¹, Харвардын Их Сургууль

Ихэнх засгийн газар өөрсдийн валютын бодит ханшны талаар санаа тавьж байдаг. Өөрөөр хэлбэл, валютын бодит ханш гэдэг бол ямар нэг нийтлэг валютад хөрвүүлэх үед тухайн улсын үнийн (буюу цалин хөлсний) түвшинг дэлхийн түвшинтэй харьцуулсан утга гэсэн үг. Жишээлбэл, валютын бодит ханш өндөр байх нь гаднаас импортлосон бараа бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнээс харьцангуй хямд болгодог. Харин үүнтэй адил шинж тэмдгээр хэт өндөр үнэлэгдсэн валют экспортлогчдод хүндрэл үүсгэж, экспортын бараа бүтээгдэхүүн нь дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар муутай болдог. Экспортлогчдын энэ хэрэгцээ шаардлага импортлогчдын ашиг сонирхолыг заавал дарж байдаг уу? Хэрэв тийм бол макро эдийн засгийн бодлого энэ талаар ямар нэг зүйл хийж чадах уу? Экспортын өрсөлдөх чадвар ихэвчлэн микро эдийн засгийн хүчин зүйлсээс хамаардаг гэж үү? Эдгээр бидэнд тавигддаг үндсэн бэрхшээлтэй асуулт, хариулт нь хэзээ ч зарим ажиглагчдын итгэж болзошгүй шиг тийм энгийн хялбар байсангүй.

Миний бие энэхүү товч эсээндээ валютын ханшны ноцтой буруу хуваарилалтыг олж тогтооход тулгардаг зарим онолын болон практик асуудлыг тайлбарлахыг хичээх болно. Энэ нь ялангуяа дэлхийн улс орнуудын дийлэнх олонх нь валютын ханшны тогтолцоогоо бодитойгоор нэгтгэсэн, мөн хэн нэг нь хар захын валютын ханшны зөрүүг зүгээр нэг хараад, энэ бол валютын ханшны буруу хуваарилалтын гарцаагүй нэг шинж тэмдэг гэж хэлж чадахгүй болсон өнөөгийн нөхцөлд чухал ач холбогдолтой юм.

Тун саяханыг хүртэл валютын бодит ханш туйлын доогуур эсвэл хэт өндөр үнэлэгдсэн нөхцөл байдлыг олж тогтооход хамаагүй хялбар байсан бөгөөд тэр үед валютын ханшинд тавих хяналт хүчтэй байснаас албан ёсоор тогтоосон валютын ханш ба хар захын далд (зэрэгцэн тогтсон) ханшны хооронд ихээхэн зөрөөтэй байх явдал олонтаа байлаа. Үнэн хэрэгтээ ийм практик нь өнгөрсөн арван жил хүртэл хөгжиж буй ихэнх орны хэмжээгээр тогтсон хэм хэмжээ болоод байсан бөгөөд хар захын ханш 50-100 хувийн зөрөөтэй байх явдал гайхалтай түгээмэл байсан нь ялангуяа Африк, Латин Америкийн орнууд, саяханыг хүртэл ТУХН-ийн орнуудад нийтлэг байлаа. Харьцангуй ховор тохиолддог саяханы нэг жишээ бол Мянмар улс байв. Энд 2003 оны эхэн үед хар зах дээрээс гадаад валютыг дотоодын валютаар

худалдаж авах (идэвхтэй) үнэ ханш албан ёсны ханшаасаа 700 гаруй хувиар их байв. Иймэрхүү валютын ханшийг зах зээл дээр хэт өндөр үнэлсэн жишээнд тухайн улсад валютын ханшны зохицуулалт бага хийгдснээс болж инфляци өндөртэй байна гэх зэрэг баримтаар нотлогдсон макро эдийн засгийн нотолгоонууд олж авахад хэцүү биш гэдэгт гайхах зүйлгүй. (Мьянмарын энэ зөрүү бол орчин цагийн рекорд амжилт болж бараг чадахгүй, учир нь Ирак улсад 2002 оноос өмнө энэ зөрүү 6,000 хувьтай байсан гэсэн мэдээлэл бий (Райнхарт, Рогофф нар, 2003-г үзнэ үү)).

Зарчмын хувьд хар захын ханшны урамшуулал өөрөө түүний цаана орших эдийн засгийн хүчнүүдийг заавал илэрхийлэх албагүй бөгөөд валютын ханшны хяналтыг зөрчигсдөд хүлээлгэх шийтгэлийн хүнд ноцтой байдал гэх мэт бусад олон хүчин зүйлсийг тусган харуулж байж болно. Гэхдээ практик дээр ийм их зөрүү байна гэдэг бол түүний цаана орших дарамт шахалтыг маш сайн илэрхийлэх үзүүлэлт болоод зогсохгүй валютын ханш цаашид өөрчлөгдөх хэмжээ ба чиглэлийг хүчтэй урьдчилан таамаглагч хүчин зүйл болдог (Райнхарт, Рогофф нар, 2003-г үзнэ үү). Цаашилбал, гадаад худалдаанд нэвтрэх нэг арга болгож валютын ханшны маш хатуу хяналт тавих санааг анх сэдсэн улсууд бол хөгжиж байгаа орнууд биш байлаа. Үүнтэй ижил үзэгдэл Дэлхийн II дайны дараахь 20 орчим жилийн турш Европын орнуудад хүндрэл үүсгэж байв.

Мэдээжийн хэрэг хэрвээ засгийн газар зах зээл дээр тогтсон ханшнаас хамаагүй өндрөөр өөрсдийн валютын албан ёсны ханшийг тогтоож байгаа бол, хэдийгээр нарийн хэмжихэд хэцүү байсан ч, энэ зөрөө нь валютын ханшийг бодит ханшнаас дээгүүр тогтоосны шууд илрэл юм. Харин өнөөдөр валютын ханшны буруу хуваарилалтын иймэрхүү хар, цагаан жишээ урьд байснаасаа илүү ховорджээ. Валютын ханшны буруу хуваарилалтыг үнэлэх сонирхолтой шинжээч нар үүний оронд ерөнхийдөө янз бүрийн орнуудын хөдөлмөрийн ба бүтээгдэхүүний өртөг зардлын харьцуулалт гэх мэт бусад хүчин зүйлсэд болон худалдааны тэнцвэргүй байдалд тулгуурлан үнэлэхээс өөр аргагүй болж байна. Харамсалтай нь эдгээр арга бүхэн өөрийн гэсэн хүндрэл бэрхшээл учруулж байдаг. Хэдийгээр тэднийг зөв зохистой хэмжиж чадах байлаа ч гэсэн, зохих тоон жишгийг бий болгох маш хэцүү гэдгийг бид олж харах болно.

Өртөг зардал ба үнийг харьцуулсан олон улсын хэмжилтүүд нь техник хүндрэл бэрхшээлүүдээр дүүрэн байдаг². Нэг зүйл л гэхэд өнөөдөр маш олон оронд ҮНБ-ний ихээхэн хэсгийг арилжааны бус бараа бүтээгдэхүүнүүд эзэлж байгаа буюу ЭЗХАХБ-ын гишүүн орнуудын хувьд 75 гаруй хувь гэж тогтоосон (Обстфелд, Рогофф нар, 2001-г үзнэ үү) бөгөөд ямар нэг буруу хуваарилалтын тухай санаа агуулахгүйгээр бодоход улс орнуудын хэмжээнд үнийн өсөлт хөгжил маш олон янз байж болох юм. Мөн худалдааны тэнцэл ч буруу хуваарилалтыг тодорхой харуулах үзүүлэлт байх албагүй. Худалдааны тэнцлийн байнгын тэнцвэртэй бус байдал олон шалтгаанаар, тухайлбал шинэ хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх зорилготой зээллэгээс болж үүсч байж болох бөгөөд энд заавал урт хугацааны тогтвортой байдал дутагдаж байна гэж үзэх албагүй.

Аливаа улс орны валютын үнэ цэнийг дэмжих юмуу барих зоригор нэг чиглэлт валютын интервенц байнга хийх нь илүү утга учиртай байж болох боловч тэдгээр нь бас аливаа орны бусад капиталын хяналтад тэнцвэргүй байдал байгааг тусган харуулж байж болно. (Ийм жишээ бол өнөөгийн Хятад улс бөгөөд энд хийж буй нэг чиглэлт интервенц нь зарим талаар капиталын дотогш урсгал гадагш урсгалаасаа илүү нээлттэй байгааг харуулж байна.)

Би энэ эсээндээ эхлээд аливаа улс орны валютын бодит ханшийг хэмжих асуудалд голлон анхаарах, дараа нь бусад нотлох баримтаас илэрсэн үзэл баримтлалын шинжтэй зарим хүндрэлтэй асуудлууд руу хандах болно. Эндээс хийх үндсэн дүгнэлт маань гэвэл, валютын ханшны буруу хуваарилалтын асуудал, өөрөөр хэлбэл, хэт өрсөлдөх чадвартай эсвэл өрсөлдөх чадваргүй валютын ханштай байх нь, дэлхий нийтийн санхүүгийн тогтолцоон дахь нэг чухал практик бэрхшээлтэй асуудал хэвээр үлдэж байгаа явдал юм. Дэлхий нийтээр илүү нэгдмэл валютын ханшны тогтолцоо (валютын чөлөөтэй хөрвөх чадвар) руу чиглэсэн хандлага нь буруу хуваарилалтын хамгийн илэрхий олон жишээг байхгүй болгосон учраас эдийн засагчид, бодлого боловсруулагчдын хувьд валютын ханшны өрсөлдөх чадварын тухай ойлголтыг бүхэлд нь гүн гүнзгий эргэцүүлэн бодож үзэх ёстой болоод байна.

Хэмжилт

Валютын бодит ханш гэгчийг хэмжих явдал нь ерөнхийдөө янз бүрийн валютуудын худалдан авах чадварын хувьсал хөгжлийг харьцуулан үзэхэд чиглэж байна. Зарчмын хувьд өртөг зардал, түүний дотор тухайлбал нэгж хөдөлмөрийн зардлыг, харьцуулахын тулд авч үзэж болох олон тооны хэмжилтийн хувилбарууд байдаг. Би энд зөвхөн валютын бодит ханшны хэмжүүрүүдэд голлон анхаарах болно. Учир нь одоогийн байдлаар бидэнд энэ талаарх хамгийн сайн, хамгийн өргөн хүрээтэй тоо баримтууд байгаа нь, нэгж хөдөлмөрийн зардлын хувьд голдуу баян чинээлэг орнуудын харьцангуй хязгаарлагдмал хүрээнд харьцуулж болох тоон мэдээлэл юм. Түүнчлэн ямар ч хэмжүүр ашигласан бай, олон үндсэн асуудлууд ижилхэн байдаг.

Валютын бодит ханшийг чиг хандлагатай нь харьцуулан хэмжих нь

Валютын бодит ханшийг харьцуулахад гардаг нэг бэрхшээл бол улс орон бүр хэрэглээний (буюу үйлдвэрлэгчийн) үнийн индекс боловсруулахдаа голдуу янз бүрийн хувийн жин ашигладаг явдал юм. Иймээс бид алмсны үнийг жүржийн үнэтэй харьцуулахад хүрэх нь олонтаа учраас нийт үнийн түвшинг харьцуулах асуудал шууд бүрхэг болж ирдэг. Би одоохондоо энэ асуудлыг хойш тавьж байгаа нь чухал бус гэж үзсэндээ биш, харин илүү гүн гүнзгий бэрхшээлтэй асуудал байгаад оршино. Энэ асуудал нь харилцан тохироход хамаагүй хэцүү буюу үндэсний статистикийн газруудаас гаргасан үнийн түвшнүүд нь ямагт түвшин гэхээсээ илүү индекс байдагт оршино. Үүнийг хийж үзээгүй хүмүүст жирийн мэт санагдаж болох энэхүү ялгаа нь үнэн хэрэгтээ нилээд чухал ач холбогдолтой. Учир нь, хоёр улсын валютын бодит ханшны харьцуулалтаас цаг хугацааны хувьд гарч буй өөрчлөлтүүд харагддаг бол, стандарт тоон үзүүлэлтүүд нь түвшний талаар ямар нэг зүйл хэлэхэд хэцүү болгодог. Өөрөөр хэлбэл, бид хоёр улсын үнийн индекс ба валютын ханшийг харьцуулж үзээд, цаг хугацааны явцад бараа бүтээгдэхүүний үнэ, тухайлбал Аргентинтай харьцангуй Польшид, илүү өсч байна гэж хэлж болно. Харин үндэсний үнийн түвшний тухай тоо баримтууд нэг улсын валютын ханшаар тохируулсан үнийн түвшин нөгөө улсынхаас өндөр байна гэж хэзээ ч хэлж чадахгүй.

Хүснэгт 1: Хүчин төгөлдөр үйлчилж буй валютын бодит ханш (ХҮИ): өнөөгийн түвшин ба 1990-2004 оны дундаж

Улс	1990-2004 оны дундаж (1990–100)	2005 оны 2 дугаар сар	15 жилийн дундажтай харьцангуй өнөөгийн хэт өндөр (буюу доогуур) үнэлсэн байдал
Аргентин	147.3	77.2	-47.6%
Парагвай	108.9	77.5	-28.9%
Египет	123.9	92.7	-25.1%
Уганда	78.9	59.2	-25.0%
Алжир	62.0	46.8	-24.5%
Бразил	76.6	58.4	-23.8%
Тайвань	92.0	72.3	-21.4%
Уругвай	149.2	120.5	-19.3%
Саудын Араб	96.0	78.3	-18.5%
Малайз	95.4	78.5	-17.7%
Болив	102.6	84.8	-17.3%
Филиппин	108.6	90.9	-16.3%
Израиль	103.8	86.9	-16.3%
Пакистан	91.1	79.0	-13.3%
Индонези	84.8	73.9	-12.9%
Тайланд	92.7	80.9	-12.7%
Украин	110.4	96.6	-12.5%
Япон	118.3	106.9	-9.7%
Чили	117.1	108.4	-7.4%
Сингапур	107.9	99.9	-7.4%
Швед	88.0	82.2	-6.5%
Коста Рика	104.0	97.9	-5.9%
Нигери	116.3	109.9	-5.4%
Финлянд	79.5	76.5	-3.8%
Иордан	112.4	108.4	-3.4%
АНУ	109.0	107.5	-1.4%
Казахстан	105.6	104.1	-1.4%
Энэтхэг	75.8	75.5	-0.4%
Венесуэл	156.7	156.2	-0.3%
Марокко	112.9	112.7	-0.2%
Колумби	128.0	127.9	-0.1%
Герман	94.5	94.7	0.1%
Швейцарь	104.4	105.0	0.6%
Норвеги	95.9	96.7	0.9%
Франц	98.2	99.2	1.0%
Хятад	93.6	94.6	1.1%
Мексик	118.2	120.4	1.8%
Шри Ланк	112.9	117.0	3.7%
Испани	90.4	94.2	4.2%
Итали	88.3	91.9	4.2%
Солонгос	89.2	93.8	5.2%
Дани	100.4	105.9	5.5%
Канад	84.1	89.0	5.9%
Нидерланд	104.3	111.5	6.9%
Ирланд	94.9	104.1	9.7%
Их Британи	103.0	115.1	11.8%
Австрали	88.7	101.7	14.7%
Кени	117.2	136.2	16.2%
Литва	140.7	163.5	16.3%
Шинэ Зеланд	96.2	113.3	17.8%
Орос	106.3	126.9	19.3%
Турк	104.2	124.3	19.3%
Ботсвани	105.1	126.2	20.1%
Эстони	115.1	139.7	21.3%
Польш	208.5	272.4	30.6%
БН Чех Улс	106.9	140.4	31.3%
Унгар	138.0	188.0	36.2%
Болгар	112.8	155.1	37.6%
Румын	95.8	134.3	40.2%

Эх сурвалж: Олон Улсын Валютын Сан

Дэлхийн 59 улсад 1990-2004 оны хугацаанд «хүчин төгөлдөр» үйлчилж байсан валютын бодит ханшны дунджийг (худалдаагаар жигнэсэн) жагсаан эдгээр дундаж түвшингүүдийг 2005 оны эхэнд байсан валютын бодит ханштай харьцуулан харуулж буй Хүснэгт 1-ийг авч үзье. (Хүснэгт 1-д суурь оныг 1990 оноор авсан учраас 1990=100 байна.)

Энэхүү хэмжилтээр жагсаалтын хамгийн дээд талд бичигдсэн хамгийн их өрсөлдөх чадвартай валютын ханш бүхий улс бол Аргентин улс байна. 1990-2004 оны дундажтай харьцуулахад Аргентиний валютын бодит ханш гайхалтай доогуур буюу дунджаас бараг 50 хувь доогуур байгаа нь нэг талаар тус улс 2001 оны жилийн эцэст өр төлөх чадвараа алдаж үндэсний валютын үнэ цэнэ гүн гүнзгий алдагдсаны ужиг нөлөөтэй холбоотой байж болох юм. Мөн Тайваны валютын бодит ханш урт хугацааны дундаж үзүүлэлтээс харьцангуй бага байгаа нь сүүлийн хэд хэдэн жилд дефляци үүссэн буюу мөнгөний эргэлт буурсантай зарим талаар холбоотой³. Жагсаалтын нөгөө үзүүрт буй Зүүн Европын орнуудын валютын ханш асар их буюу 30 хувь давсан хэмжээгээр өсч чангарсан нь нэг талаас бүтээмжийн өсөлт өндөр байснаас төдийгүй тус бүс нутаг Баруун Европтой улам бүр нэгдэн нягтарч байгаагаас үүдэн асар их хэмжээний капитал урсан орж ирж байгаатай холбоотой. Сонирхолтой нь АНУ-ын долларын хүчин төгөлдөр үйлчилж буй валютын бодит ханш бүхий л өөрчлөлт хөдөлгөөнд орсны дараа 2005 оны эхэнд сүүлийн 15 жилийн дундажтайгаа маш ойролцоо ирсэн байхад, Хятад улсын хүчин төгөлдөр үйлчилж буй валютын бодит ханш дунджаасаа 13-хан хувь доогуур байлаа.

Энэ нь дэлхий дээр бизнес эрхлэхэд хамгийн хямд газар Аргентин улс, хамгийн үнэтэй нь Зүүн Европ гэсэн үг үү? Мэдээж үгүй. Энд зөвхөн эдгээр бүс нутгийн валютын бодит ханшны түвшин сүүлийн үеийн хэм хэмжээнээс хамгийн хол зөрүүтэй гарсныг харуулж байгаа юм. Гэсэн хэдий ч ямар ч байсан бид Хүснэгт 1-д үзүүлсэн тоон үзүүлэлтийг тоолгүй орхих ёсгүй. Аливаа улсын урсгал дансны байдал нилээд урт хугацаанд тогтвортой байх үндэслэлтэй нөхцөлд санхүүгийн цочрол гэх мэт түр зуурын хүчин зүйлсийн нөлөө яваандаа тогтворждог учраас тухайн улсын валютын ханшны урт хугацааны дундаж үзүүлэлт нь тэнцвэрт байдлыг хэмжих шударга хэмжүүр байж болох юм гэдэгт эдийн засагчид ерөнхийдөө итгэдэг. Зарчмын хувьд ялгавартай өсөлт эсвэл нөөц баялгийн

нөлөө гэх мэтийг харгалзан тохируулснаар валютын ханшны урт хугацааны цаад тэнцвэрт байдлыг хэмжих хэмжилтээ сайжруулж болно (Обстфелд, Рогофф нар, 1996-г үзнэ үү).

Үнэндээ Хүснэгт 1-д буй захын улсуудыг өнгөц харахад, газрын тос экспортлогч орнуудын хувьд газрын тосны үнэд томоохон өсөлт гарах гэх мэт бүтээмжийн ихээхэн цочрол гараагүй тохиолдолд валютын бодит ханш өндөр байх нь ихэвчлэн урсгал дансны сул талыг илтгэдэг болохыг нотлон харуулж байна⁴. Сүүлийн үеийн хэм хэмжээнээс маш доогуур валютын ханштай байгаа Аргентин улс үнэн хэрэгтээ их хэмжээний урсгал дансны илүүдэлтэй байна⁵. Валютын бодит ханш нь чиг хандлагаасаа доогуур байгаа Бразил улсын хувьд ч мөн ийм байдалтай байна. Валютын бодит ханш нь огцом чангарсан Зүүн Европын орнуудын хувьд урсгал дансны ужиг алдагдалтай явж байна. Харин хүснэгтийн дунд байрласан орнуудын хувьд валютын бодит ханшны барометр нь ямар нэг тодорхой дохио өгөхгүй байна. Жишээлбэл АНУ гэхэд 1990 онд тус улсын урсгал дансны тэнцэл илүүдэлтэй гарч байсантай бараг ижилхэн валютын бодит ханшны түвшинд урсгал дансны алдагдлын рекорд амжилт үзүүлжээ (Мэдээж, Францын Ерөнхийлөгч асан Шарль де Голлийн цохон тэмдэглэж байсанчлан, АНУ-ын доллар дэлхийн мөнгөн сангийн нөөцийн валют гэдэг «дэндүү том эрх ямба» эдэлж байгаа учраас магадгүй түүнийг орлуулах аргагүй байж болох юм). Валютын ханш нь 1990 оны түвшнээсээ ялимгүй илүү өрсөлдөх чадвартай байгаа Сингапур улс 2004 онд ДНБ-ийхээ 25 хувиас давсан урсгал дансны илүүдэлтэй байна.

Гэвч урсгал дансны тэнцэл нь нилээд анхаарал татдаг үзүүлэлт боловч өрсөлдөх чадварыг илэрхийлдэг цорын ганц үзүүлэлт биш юм. Бидний хожим дэлгэрэнгүй авч үзэх ёсоор аливаа нэг валютын ханш хэт өндөр эсвэл доогуур үнэлэгдсэн эсэхийг тодорхойлдог ямар нэг ганц хувьсагч хайгаад байж болохгүй. Урсгал дансны алдагдал ихтэй байх нь хүндрэл бэрхшээл: «Institutions and Public Policy». үүсэхийн шинж боловч, хэрвээ ямар нэг улс, жишээлбэл экспортын салбарт оруулах бүтээлч хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх эсвэл хөрөнгө оруулалтыг дэмжих дэд бүтцэд зориулж зээл авч байгаа тохиолдолд, хэрэглээний санхүүжилтийн зорилгоор зээл авснаас хамаагүй илүү тогтвортой байх магадлалтай юм.

Валютын бодит ханшны түвшинг хэмжих нь

Валютын бодит ханшийг харьцуулах өөр нэг арга бол үндэсний статистикийн газруудын гаргасан тоо баримтаас цааш хальж, өөр өөр орнуудад буй ижил төстэй бараа бүтээгдэхүүний сагсны үнэмлэхүй зардлын хэмжээг хэмжихэд чиглэсэн тусгайлсан тоон үзүүлэлтийг ашиглах явдал юм. (Суурь оны валютын бодит ханш нь тэнцвэрийн цэгээс хамаагүй хол байж болзошгүй учраас суурь онтой харьцуулсан үнийн түвшний өөрчлөлтийг хэмжихээсээ илүүгээр цаг хугацааны тодорхой нэг цэг дээр валютын ханшаар тохируулсан үнийн түвшинг хэмжиж байгаа гэдэг утгаараа эдгээр зардлууд нь «үнэмлэхүй» байна). Арга зүйн хувьд авч үзвэл энэ арга нь уламжлалт үнийн индексүүдээр тодорхойлдог аргаас хамаагүй илүү юм. Энд тулгардаг гол бэрхшээл нь үндэсний статистикийн газраас хамаагүй бага санхүүжилт эсвэл бага хүчтэй судалгааны жижигхэн баг эдгээр тоон үзүүлэлтүүдийн ихэнхийг боловсруулж байгаад оршино. Үнийн олон улсын харьцуулалтын хамгийн чухал эх сурвалж бол Пеннсилваны Их Сургуулиас гаргадаг, мөн Дэлхийн Банк болон Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллага (ЭЗХАХБ)-с эрхлэн гаргадаг Пенн Уорлд Тэбл (Саммерс, Хестон нар, 1991) юм. Дэлхийн Банкнаас улс орнуудын орлогыг харьцуулахад ашигладаг эдгээр тоон мэдээлэл нь үнийн индексүүд бий болгодог бөгөөд ялангуяа, АНУ-д хэрэглээний сагс хэмээн нэрлэдэг, ямар нэг тодорхой зүйлийг эсвэл хэсэг зүйлийг худалдан авахын тулд улс орон бүрт ямар зардалтай байгааг авч үздэг. Ийм харьцуулалт хийхэд маш олон нарийн зүйл (чанарын хувьд ижил төстэй бараа бүтээгдэхүүний үнийг хэмжиж буй эсэхийг батлахад хэцүү, мөн энэ арга нь олон төрөл зүйлд хангалттай ач холбогдол өгдөггүй) шаардагдахын зэрэгцээ дор хаяж өөр өөр орнуудын үнийг харьцуулахад зориулсан ойролцоо бөгөөд нийтлэг хэмжилтийн хуваариар хангаж өгдөг.

Хүснэгт 2-г, энэхүү валютын худалдан авах чадварын (ВХАЧ) хэмжүүрээр тооцоход ТУХН-ийн орнууд (Гүрж, Беларусь, Украин гэх мэт) дэлхий дээр хамгийн бага үнийн түвшинтэй буюу Африкийн орнуудынхаас ч доогуур үнэтэй байна. Гэвч эдгээр орнуудын хувьд тоо баримт харьцангуй муутай учраас энэхүү өнгө аясыг хэт их дөвийлгөж бодох ёсгүй.

Япон, Швейцарь хоёр улс дэлхийн хамгийн өндөр өртөгтэй орнууд бөгөөд Япон улс АНУ-

Хүснэгт 2: Үнийн түвшний олон улсын харьцуулалт

Улс	Үнийн түвшин (АНУ = 100)	Улс	Үнийн түвшин (АНУ = 100)
Киргизстан	8.36	Унгар	41.78
Гүрж	11.28	Польш	42.25
Украин	12.48	Чили	44.61
Казахстан	14.84	Бразил	45.13
Энэтхэг	17.07	Уругвай	58.47
Орос	17.25	Мексик	60.79
Индонези	18.06	БН Солонгос Улс	64.75
Пакистан	19.93	Аргентин	65.62
Зимбабве	21.33	Шинэ Зеланд	66.25
Шри Ланк	21.94	Венесуэл	69.05
Хятад	23.14	Испани	73.79
Болгар	23.29	Австрали	74.57
Филиппин	24.90	Канад	79.30
Уганда	24.95	Сингапур	80.12
Кени	26.32	Итали	81.32
Марокко	27.09	Нидерланд	90.11
Алжир	28.71	Франц	90.70
Тайланд	29.61	Израиль	92.48
Эстони	31.97	Ирланд	92.56
Румын	32.52	Герман	94.96
Колумби	33.10	Финлянд	95.99
БН Чех Улс	33.29	Их Британи	98.50
Болив	33.93	АНУ	100.00
Египет	34.43	Швед	104.83
Литва	36.47	Дани	106.83
Өмнөд Африк	36.70	Норвеги	112.36
Нигери	39.26	Сири	114.30
Иордан	39.85	Швейцарь	118.14
Турк	40.34	Япон	144.83
Малайз	40.86		

Эх сурвалж: Пеннсилваны Их Сургууль, 2002.
Онлайн хаяг: <http://www.pwt.econ.upenn>.

Хүснэгт 3: Валютын ханшны хэт их ба доогуур үнэлгээний тухай Экономист сэтгүүлийн Биг Макийн индекс

Швейцарь	5.05	Бразил	2.39
Дани	4.58	Япон	2.34
Швед	4.46	БН Чех Улс	2.30
Еврогийн бүс	3.58	Сингапур	2.17
Британи	3.44	Өмнөд Африк	2.10
Шинэ Зеланд	3.17	Польш	1.96
АНУ	3.06	Аргентин	1.64
Турк	2.92	Египет	1.55
Перу	2.76	Гонконг	1.54
Канад	2.63	Индонези	1.53
Унгар	2.60	Орос	1.48
Мексик	2.58	Тайланд	1.48
Чили	2.53	Филиппин	1.47
Австрали	2.50	Малайз	1.38
Өмнөд Солонгос	2.49	Хятад	1.27
Тайвань	2.41		

Эх сурвалж: The Economist /Экономист сэтгүүл/, 2005 оны 6 дугаар сар

аас бараг 50 хувь илүү өндөр үнэтэй байна. ВХАЧ-ын тоон мэдээлэлтэй холбоотой гол практик бэрхшээл бол энэхүү тоон мэдээллийн олдоч харьцангуй хомс байдаг оршино. Өргөн хүрээтэй жишиг оны судалгаанууд зөвхөн таван жилийн завсартай хийгддэгийн хамгийн сүүлийнх нь 1996 онд хийгдсэн байдаг (Үүнийг бичиж байх үед 2001 оны тоон үзүүлэлт ч гараагүй байлаа). Хүснэгт 2-т үзүүлсэн 2000 оны тоон үзүүлэлтүүдийг хамгийн сүүлийн жишиг оны⁶ үнийн өөрчлөлт хөгжилд экстраполяци хийх янз бүрийн статистик аргуудыг ашиглан гаргаж авсан.

Үнийн түвшний олон улсын харьцуулалтын өөр нэг эх сурвалж бол Экономист сэтгүүлийн «Биг Мак»-ын индекс бөгөөд янз бүрийн орнуудад байгаа Биг Мак хэмээх гамбургерийн үнийг ам.доллараар илэрхийлэн гаргадаг. Хэдийгээр энэ индекс туйлын явцуу (түргэн муудах бургерүүдийг үнэндээ худалдаалж болохгүй) төдийгүй тухайн борлуулалтын цэгийн эргэн тойронд буй ресторануудын хооронд ихээхэн ялгаатай байдаг боловч, ямар ч байсан жил бүр шинэчлэгддэг, мэдээллийн чанар гайхалтай сайтай байдаг. Хүснэгт 3-т (2005 оны 6 дугаар сард хийсэн хамгийн сүүлийн судалгаанд тулгуурласан) мөн л Швейцарь улс 5.05\$-н үнээр тэргүүлж байхад, АНУ-д харьцангуй бага буюу 3.06\$, Хятадад хамгийн хямд (түүврийн хэмжээнд) буюу 1.27\$ байна. (Хэдийгээр энэ үнэ Орост харьцангуй хямд буюу 1.48\$ байгаа ч, уг хүснэгтэд хуучин Зөвлөлтийн бүрэлдэхүүнд байсан бүх бүгд найрамдах улсуудыг оруулаагүй байна.)

Валютын бодит ханш ба өрсөлдөх чадварын индексүүдийг тайлбарлахад гардаг үзэл баримтлалын асуудал

Мэдээж хэрэг өмнөх хэсэгт ярилцсан хэмжилтийн хүндрэл бэрхшээл байсан ч валютын ханш хэт өндөр үнэлэгдсэнийг гарцаагүй нотлон харуулж чадах нөхцөл байдал байсаар байгаа юм. Бүр эхэнд дурдаж байсанчлан үүний хамгийн тодорхой жишээ бол аливаа улс валютын хяналттай байх, мөн хар захын ханшны зөрүү их хэмжээтэй байх явдал юм. Шинээр төрөн гарч буй зах зээлүүдэд тохиолддог өөр нэг жишээ бол валютын бодит ханш нь сүүлийн үеийн хэм хэмжээнээсээ харьцангуй өндөр байх, бүтээлч хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхийн оронд голдуу хэрэглээний зориулалтаар их хэмжээний зээл авах явдал байдаг. Эдгээр жишээ нь их

хэмжээний капиталын урсгалтай холбоотой байх явдал олонтаа бөгөөд хэрвээ богино хугацаат өрийн хэлбэрээр илэрвэл зөвхөн нэг түвшинд тэгшрээд зогсохгүй, огцом эргэлтэд автаж болно. Эдгээр жишээнд ямар ч загвараар тооцож үзэхэд аливаа валютын өнөөгийн үнэ цэнэ тогтвортой бус байна гэдэг утгаараа валютын ханш хэт өндөр үнэлэгдсэн байж болно. Харамсалтай нь нэгдсэн дүнэлт хийж болох жишээ харьцангуй ховор байна.

Ямар үед валютын бодит ханшны өсөлтийг бүтээмжийн өсөлтөөр зөвтгөж болдог вэ?

Валютын бодит ханшны өсөлт, ялангуяа аажмаар тогтвортой өсч байгаа өсөлт тэр болгон валютын ханш хэт өндөр үнэлэгдсэний дохио болоод байдаггүй. Бүтээмжийн түвшин огцом өсч байгаа орнуудад валютын бодит ханш өсөх явдал гарч болно. Маш хурдацтай өсч байгаа эдийн засагт ч гэсэн, бүтээмжийн өсөлт нь хааяа дэлхийн дунджаас цөөн хэдхэн хувиар илүү гардаг учраас энэ байдлаар жилд хоёроос илүү хувьтай гарсан чиг хандлагын өөрчлөлтийг зөвөөр тайлбарлахад ерөнхийдөө хэцүү байдаг. Жишээлбэл, Зүүн Европын олон орны бүтээмж Баруун Европын хөршүүдээсээ чилүү хурдацтай өсч байгаа боловч тэр хэмжээгээр валютын бодит ханш нь чангарахгүй байна. 1979 онд нээлттэй болгосноос хойш Хятадын валютын бодит ханш бодит утгаараа чангарах бус харин суларсан байгаа нь сонин. Гэвч үйлдвэрлэгчид ажил эрхлэлт багатай их хэмжээний хөдөөгийн хүн амын хүчийг ашиглаж, улмаар үнийн болон цалин хөлсний дарамтыг хязгаарлаж чадаж байгаа учраас үүний ач холбогдолыг тайлбарлах хэцүү юм. Мэдээж хотууд хүн амын бөөгнөрөл, бохирдолд улам бүр орохын хэрээр энэхүү шилжилт эцсийн эцэст тодорхой нэг цэгээс эхлэн удаашрах ёстой.

Голланд өвчин

Үүнтэй холбогдуулан авч үзэх шаардлагатай өөр нэг чухал жишээ бол газрын тос экспортлогчид болон байгалийн баялаг ихтэй бусад орнуудын жишээ юм. Нөөц баялаг ихтэй орнуудад валютын бодит ханш огцом өсч, бусад үйлдвэрлэлийн салбаруудын өрсөлдөх чадварыг бууруулах явдал нилээд түгээмэл бөгөөд энэ үзэгдлийг *Голланд өвчин* гэж нэрлэдэг. Жишээлбэл, бараа түүхий эдийн томоохон экспортлогч орнууд болох Шинэ Зеланд, Канад, Австрали улсуудын хувьд баялгийн үр нөлөө нь эдгээр орнуудад арилжааны бус

бараа бүтээгдэхүүний дотоодын эрэлтийг нэмэгдүүлдэг учраас бараа, түүхий эдийн үнэ өндөр байх нь валютын бодит ханшийг өсгөдөг (Чен, Рогофф нар, 2003). Хэдийгээр иймэрхүү үр нөлөө нь үйлдвэрлэгдсэн экспортын өрсөлдөх чадварыг бууруулдаг боловч мэдээж бараа, түүхий эдийн үйлдвэрлэл өөрөө гол салбарыг бүрдүүлдэг учраас үүнээс үүдэх валютын ханшны чангаралт нийт эдийн засгийг өрсөлдөх чадваргүй болгож байна гэж дүгнэх нь буруу болно. Харин түүний оронд, бараа, түүхий эдийн өндөр үнэ, валютын бодит өндөр ханш хоёр хослох нь валютын ханшнаас болж бусад салбарт оруулах хөрөнгө оруулалт багасах үед бараа, түүхий эд үйлдвэрлэлийн салбарт (үнэ өсөх үед) илүү их хөрөнгө оруулалт хийхийг шаардсан зах зээлийн дохио гэж үзэх ёстой. Ерөнхийдөө хөрөнгө оруулалтын шийдвэр зах зээлд тулгуурлан гардаг тохиолдолд энэ бол тун эрүүл саруул үзэгдэл бөгөөд үүнийг өрсөлдөх чадвар дутагдах явдалтай хольж хутгах ёсгүй.

Бараа түүхий эдийн үйлдвэрлэлд улсын компаниуд зонхилдог, тухайлбал энэ асуудлын талаар урт удаан түүхтэй Мексикийн «Пемекс ойл» компани шиг хөрөнгө оруулалтын шийдвэрийг зах зээлийн зарчмаар бус улс төрийн шийдлээр гаргадаг орнуудын хувьд энэ нөхцөл байдал илүү хүндрэлтэй тусах нь мэдээж. Нөгөө талаас, эдийн засгийн түүхч Дэвид Ландаугийн анх олж тогтоосон «нөөц баялгийн хяслан» гэдэг ойлголт нь улс төрийн удирдлагын завхруулагч нөлөөний улмаас аливаа орны эдийн засгийг улам бүр дордуулж байж болно. Ер нь үнийн механизм ажиллаж бараа түүхий эдийн үнийн цочролд зах зээлийн зохих ёсны хариуг өгөхөд аливаа эдийн засаг дахь засгийн газрын хэт их оролцоо саад болж байгаа нөхцөлд Голланд өвчин ноцтой гажуудал үүсгэх ихээхэн магадлалтай байдаг⁶.

Зээл тусламжийн дотогш урсгалаас үүдэн валютын бодит ханш чангарах асуудал

Валютын ханшны чангаралтыг удирдах явдал бол зөвхөн баян орнуудад байдаг асуудал биш төдийгүй зээл тусламж ихээр авдаг туйлын ядуу буурай орнуудад ч тулгардаг. Энэ асуудал хэзээ нэгэн цагт Африкийн Сахар орчмын бүс нутагт үүсч болзошгүй бөгөөд ялангуяа баян орнууд хүчин чармайлтаа нэмэгдүүлж, хамаагүй их зээл тусламж олгох амлалтандаа хүрсэн нөхцөлд үүсч болох юм. Хэрвээ үнэхээр зээл тусламж их хэмжээгээр урсан орж ирэх юм бол Африкийн орнуудын валютын

ханш мөнгө орж ирэхийн хэрээр чангарч, дотоодын бараа бүтээгдэхүүний эрэлт өсөн, экспортын үйлдвэрлэлийн өрсөлдөх чадвар буураад зогсохгүй зээл тусламжаас хараат болох эрсдэл нэмэгдэнэ. Энэ нь уг тусламжийг үгүйсгэх шалтгаан биш боловч бараа түүхий эд экспортлогч орнуудынхаас ч илүү нарийн төвөгтэй асуудал юм. Бараа түүхий эд экспортлогч орнуудын хувьд үнэ өсөх нь хөрөнгө оруулалтын таатай боломж бүрдэнэ гэсэн үг бөгөөд энэ боломжийг сайн удирдаж чадах юм бол үйлдвэрлэлийн салбарууд уналтад орж, зайлшгүй шинэчлэн зохион байгуулагдах шаардлагатай болсон ч бай, бараа түүхий эдийн салбарт тогтвортой ашиг бий болж, улмаар үндэсний эдийн засаг бүхэлдээ өсөх боломж бүрдэнэ. Африкийн орнуудын хувьд энэхүү зээл тусламж ашигтай байх боловч валютын ханшны үнэлгээ өөрчлөгдсний үр дүнд өсөлтийг алдагдуулж болох эрсдэлтэй.

Дахин хэлэхэд энэ бол зээл тусламж өгөхийн эсрэг үндэслэл биш гэдэг нь мэдээж бөгөөд гагцхүү иймэрхүү зээл тусламжийг илүү тогтвортой, илүү найдвартай болгох гэсэн үр нөлөөтэй үзэл санаа юм. Мөн ямар нэг улс экспортын өрсөлдөх чадварыг бууруулахуйц их хэмжээний зээл тусламж өгөөд, дараа нь хэзээнээс ядуу буурай байсан зээлдэгч орны экспортын салбарыг уналтад оруулсны дараа өгсөн зээлээ буцааж авахыг дэмжиж байгаа хэрэг ч огт биш юм. Голланд өвчний үед боловсрол, дэд бүтцэд хөрөнгө оруулж, улмаар валютын бодит ханш өсмөгц экспортлогчдын бүтээмж дээшилдэг байх тухай нэмэлт асуудал тавигддаг. Дээр нь мэдээжийн хэрэг ядуу буурай олон оронд авилгал өндөр түвшинд байгаа тохиолдолд өгч буй хандив нь зүгээр нэг хилийн чанад дахь банкны дансанд ороод алга болохгүй байх талаар хандивлагчид санаа тавих ёстой.

Худалдааны тэнцэл ихээхэн алдагдалтай байгаа нь валютын ханшны буруу хуваарилалтын шүүд нотолгоо мөн үү?

Худалдааны алдагдалтай байдлын хувьд яах вэ? Хэрвээ аливаа орны худалдааны тэнцэл их хэмжээний илүүдэл эсвэл алдагдалтай байх юм бол энэ улсын валютын ханш хэт өндөр эсвэл доогуур үнэлэгдсэний илэрхий нотолгоо биш гэж үү? Он жилүүдийн явцад олон улс төрчид энэ дүгнэлтэд хүрсэн байдаг. Тэдний зөв байж болох ч, үүнийг батлахад тийм ч амар биш. Улам бүр даяаршлагдсан капиталын зах

зээлтэй болж буй дэлхий дээрх улс орнууд макро эдийн засгийн шалтгаанаар алдагдалтай эсвэл илүүдэлтэй ажиллаж байгаа нь хэт их өрсөлдөх чадвартай валютын ханштай бага зэрэг эсвэл огт холбоогүй юм. Жишээлбэл, ямар нэг орны засгийн газар ихээхэн алдагдалтай ажиллаж байгаа, тухайлбал батлан хамгаалах эсвэл нийгмийн хамгааллын зардлаа санхүүжүүлэхийн тулд алдагдал хүлээж байна гэж бодъё, тэгвэл энэ нь ихэвчлэн тухайн улсын урсгал дансны ерөнхий алдагдалд нөлөөлдөг бөгөөд үүнийг ихэнх орнууд худалдааны тэнцлийн алдагдлын ерөнхийлсөн хэлбэр хэмээн хялбар бодож байж болно. Үнэн хэрэгтээ энэ бол жирийн нэг нягтлан бодох бүртгэлийн асуудал юм. Засгийн газар их хэмжээний алдагдалтай ажиллаж байвал хувийн салбарынхан хуримтлалаа нэмэгдүүлэх буюу хөрөнгө оруулалтаа багасгахгүй л бол улс орон бүхэлдээ их хэмжээний алдагдалтай (ихэнх нь худалдааны тэнцлийн алдагдлаар дамжин илэрдэг) гарах ёстой. Харин засгийн газрын төсөв ашигтай буюу илүүдэлтэй байхад үүний эсрэг зүйл тохиолддог.

Худалдааны алдагдалд макро эдийн засгийн олон хүчин зүйлс нөлөөлж болдог. Жишээлбэл, хэрвээ ямар нэг улс магадгүй өмнө нь хэт их хөрөнгө оруулалт хийсэн гэж үзээд дотоодын хөрөнгө оруулалтаа багасгах тохиолдолд хуримтлалын хувиа багасгахгүй л бол их хэмжээний худалдааны илүүдэлтэй гардаг. Энэ тохиолдолд тухайн улсын мөнгөн сан гадагшаа урсаж, дэлхийн хаа нэгтээ байгаа бүтээмж ихтэй бүс нутаг руу хөрөнгө оруулах болно. Харин энэ тохиолдолд валютын ханш маш өндөр өрсөлдөх чадвартай байснаас тухайн улсын худалдааны тэнцэл илүүдэлтэй гарлаа гэж төсөөлөх юм бол нөхцөл байдлыг буруу тайлбарлаж байна гэсэн үг. Худалдааны тэнцэл илүүдэлтэй байх нь давуу тал гэхээсээ илүү сул талтай байгаагийн шинж тэмдэг юм.

Энэ нь тодорхой нөхцөлд улс орнууд валютын ханшаа доогуур түвшинд барьснаар хожихгүй гэсэн үг биш бөгөөд энэ бодлогыг олон хүмүүс Азийн загварын амин сүнс гэж үздэг. Мөн улс орнууд хэт доогуур үнэлсэн валютын ханштай байснаар урт хугацааны өсөлтийн үр шимийг зайлшгүй хүртэнэ гэсэн үг биш. Тухайлбал, бүтээмжийн өсөлтийг дээшлүүлэхэд капиталын бүтээгдэхүүний импорт чухал үүрэгтэйг нотлох баримт нилээд байдаг (жишээ нь, ДеЛонг, Саммерс нарын 1991 онд бичсэн доорх номыг үзнэ үү). Харин валютын бодит ханшийг хэт доогуур

түвшинд барих нь капиталын бүтээгдэхүүний импортыг үнэтэй болгож, зөвхөн арилжааны бараа бүтээгдэхүүний салбарт төдийгүй байшин барилга гэх мэт арилжааны бус бараа бүтээгдэхүүнд ч нөлөө үзүүлнэ.

Бүр үндсээр нь авч үзвэл, ханш доогуур байхын нэг зорилго бол экспортын өсөлт биш. Оршил хэсэгт ярьж байсанчлан хэрэглэгчид валютын ханшийг доогуур байлгаж, өндөр үнэтэй импортын бараа хэрэглэх бус, харин уг ханшийг өндөр байлгаж импортыг хямдруулахыг илүүд үздэг. Хэрвээ Хятадын валютын ханш доогуур үнэлэгдсэн гэж үзэх юм бол тус улсын хэрэглэгчид импортын бараанд харьцангуй ихийг төлж байна гэсэн үг бөгөөд улмаар амьжиргааны түвшин доошлоход хүргэдэг. Валютын ханш доогуур үнэлэгдсэн байх нь зарим талаар илүү хялбар дөхөм бөгөөд нийгмийн тогтвортой байдлыг хангахад тустай гэсэн үзлийн эсрэгээр, олон ардчилсан оронд хэрэглээг дээшлүүлэхэд чиглэсэн ард олны шахалт нь валютын ханшийг доогуур биш, өндөр тогтооход хүргэдэг гэсэн бодит баримтыг сэргүүлэн тавих ёстой.

Дэлхийд тэргүүлдэг зээлдэгч болох АНУ валютын ханшны буруу хуваарилалтын эрсдэлд нөлөөлдөг үү?

Өнөөдрийн валютын ханшны өрсөлдөх чадварын түвшинг ажиглаж байхад заавал дурдах ёстой нэг том асуудал байдаг нь сүүлийн жилүүдэд АНУ асар их хэмжээний урсгал дансны алдагдалтай байгаад оршино. Үнэн хэрэгтээ 2004 онд ийм алдагдалтай ажилласан дэлхийн бүх улс орны урсгал дансны нийт алдагдлын 70 орчим хувийг эзэлж байгаагийн хувьд АНУ дэлхий нийтийн зээллэгийн дүнд ноёрхож байна! Энэ үзэгдлийг засья гэвэл эцэстээ долларын ханш сулрах нь бараг мэдээж бөгөөд бодит утгаараа дэлхийн ихэнх хэсэг, мөн 2004 онд нийлбэр дүнгээрээ 260 тэрбум ам.долларын урсгал дансны илүүдэлтэй байсан хөгжиж буй орны шинээр төрөн гарсан зах зээлүүдэд хүртэл өргөн хүрээнд нөлөөлөх юм. Иймээс АНУ-ын урсгал дансны болон худалдааны алдагдал арилахад хүрвэл өнөөдрийн өрсөлдөх чадварын индексэд ямар оноо авснаас үл хамааран дэлхийн ихэнх орнуудын валютын⁹ ханш цаашид ихээхэн чангарах магадлалтай. Валютын ханшны өрсөлдөх чадвар бол нэг нь хожиж, нөгөө нь хожигддог тэг нийлбэртэй тоглоом бөгөөд АНУ-ын ачаар дэлхийн эдийн засаг бүхэлдээ хөөс үүсгэж, улам олон улс орон

валютынхаа ханшийг бүр доогуур үнэлгээтэй, илүү өрсөлдөх чадвартай болгож байгаа мэт харагдаж байна.

Дүгнэлт

Улс орнууд валютын ханшийг өрсөлдөх чадвартай байлгах ёстой гэсэн санаа «Вашингтоны зөвшилцөл»-д туссан байдаг (Уиллиамсон, 1989) бөгөөд уг зөвшилцөл нь бодит ханшаас илэрхий өндөр валютын ханш барихын эсрэг хатуу анхааруулга болдог. Ямар ч сайн олон улсын макро эдийн засагчаас аливаа улсын макро эдийн засгийн ерөнхий байдлыг үнэлэхийн тулд ямар гол хувьсагчуудыг мэдэхийг хамгийн их хүсч байна вэ гэж асуугаад үз, тэгвэл валютын «бодит» ханшны үзүүлэлт голдуу уг жагсаалтын дээд тал хавьцаа байх болно. Хэдийгээр валютын бодит ханшны хэт өндөр үнэлгээг тухайн эдийн засгийн талаарх илүү өргөн хүрээтэй үнэлэлт дүгнэлтээс түсд нь хэмжих явдал ач холбогдол багатай ч, энэ нь зөн билгийн мэдрэмж төрүүлж байдаг.

Гэсэн ч дэлхийн ихэнх хэсэгт хэн нэг нь хар захын эсвэл зэргэлдээ зах зээлийн валютын ханшийн байдлыг зүгээр нэг хараад л тухайн улсын валютын ханш бодит ханшаасаа өндөр байна гэдгийг шууд мэдэрдэг цаг үе өнгөрсөн. Өнөөдөр валютын ханш зах зээлийн хүчин зүйлсээс улам бүр хамаарах болсон учраас (валютаа гадны валюттай шууд уядаг орнууд хүртэл зах зээлд тулгуурласан аргууд ашиглах нь ихэссэн) бодит ханшаас өндөр тогтоосон валютын ханшийг, мөн үүнтэй холбоотойгоор валютын ханшны өрсөлдөх чадварыг хэмжих, үнэлэх асуудал улам нарийн болоод байна. Худалдааны тэнцэл алдагдалтай эсвэл илүүдэлтэй гарах нь валютын ханшны хуваарилалт буруу хийгдсэний дан ганц нотолгоо гэж үзэх нь буруу юм. Яагаад гэвэл худалдааны тэнцвэргүй байдал нь худалдааны бодлого гэхээсээ илүү макро эдийн засгийн бусад хүчин зүйлсийг тусгах явдал олонтаа байдаг.

Тэгвэл бодлого боловсруулагчид валютын ханшны өрсөлдөх чадварыг яаж авч үзвэл зохих вэ? Үүнд өгөх товч хариулт гэвэл, ихэнх орны хувьд валютын ханшны түвшин түүхэн хэм хэмжээнээсээ илэрхий зөрж ирэх хүртэл, ялангуяа мөнгөний эсвэл төсвийн бодлого, аль эсвэл капиталын дотогш урсгалд эрс өөрчлөлт орсны улмаас ийм байдал үүсэх хүртэл энэ бол макро эдийн засгийн асуудал биш байдаг. Эсрэг тохиолдолд валютын ханшаа өрсөлдөх

чадвартай байлгах талаар санаа зовж буй орнууд ерөнхийдөө тогтвортой бөгөөд ил тод макро эдийн засгийн бодлого баримтлах, мөн микро эдийн засгийн түвшинд өрсөлдөх чадвар, уян хатан байдлыг дээшлүүлэхэд чиглэсэн бодлогоор хангагдах нь ухаалаг хэрэг болно.

Тайлбар

- 1 Эдийн засгийн ухааны профессор, мөн Томас Д.Кабот нь Харвардын Их Сургуулийн Төрийн Бодлогын ухааны профессор юм. Зохиогч тустай зөвлөгөө өгсөн Гайан Мариа, Милеси-Ферретти, Жэвүү Лий нарт болон эхний ноорог дээр чухал санал шүүмжлэл хэлж өгсөн Августо Лопез-Кларос, Еял Двир нарт талархал илэрхийлж байна.
- 2 Еврогийн бүсийн инфляцийн хувийг тогтоохын тулд Европын Холбооны гишүүн орнуудын инфляцийн хувиудыг нэгтгэх ажил ямар их хүндрэл бэрхшээлтэй байсныг энд гэрчилнэ.
- 3 Доллартай харьцуулсан валютын ханш харьцангуй тогтвортой байхад, АНУ-д инфляци, Тайваньд дефляцитай байна гэдэг нь Тайваньд АНУ-г бодвол бараа бүтээгдэхүүн илүү хямд болж байна, өөрөөр хэлбэл, тус улсын валютын бодит ханш буурч байна гэсэн үг.
- 4 Валютын бодит ханшны тухай туршилт судалгаанаас үзэхэд чиг хандлагаас хазайх хазайлт их байх тусам илүү урьдчилан таамаглаж болохоор байдгийг харуулж байна. Томоохон хазайлтуудын хувьд голч утганд буцаж ирэх нь илүү хурдан байдаг. Обстфелд, Рогофф нар, 2001-г үзнэ үү.
- 5 Мэдээж хэрэг, аливаа улс өр төлөх чадвараа алдаж буй үед алдагдалтай ажиллах нь муу сонголт юм!
- 6 Эдгээр тоон үзүүлэлтүүдийн тухай дэлгэрэнгүйг, Хестон нарын 2002 оны бүтээлээс үзнэ үү. Онлайн хаяг: <http://pwt.econ.upenn.edu/>
- 7 Экономист сэтгүүл /The Economist/, 2005 оны 6 дугаар сар.
- 8 Иймэрхүү товч өгүүлэлд авч үзэж багтахгүй нэг чухал асуудал бол нөөц баялаг ихтэй орнууд бараа, түүхий эдийн үнийн хэлбэлзлээс өөрсдийгөө хэрхэн хамгаалах вэ гэдэг асуудал юм. Зарчмын хувьд үүнийг дэлхийн хөрөнгийн зах зээлээр дамжуулан хийж болох боловч амьдрал дээр нөөцийн удирдлагыг оновчтой хийхэд улс төр, эдийн засгийн хүндрэл бэрхшээлүүд саад болж болно.
- 9 Хэрвээ нэгээс хоёр жилийн хугацаанд АНУ-ын урсгал дансны алдагдлыг ДНБ-ний 6 хувиас 3 хувь болгож тэн хагасаар багасгавал, худалдаанд эзлэх долларын хэмжээ бараг 15 хувиар буурч, Азийн валютын хэмжээ 18 хувиар, Азийн бус валютууд 10 хувиар нэмэгдэнэ гэж тооцсон Обстфелд, Рогофф нарын 2005 оны бүтээлийг үзнэ үү.

Лавлах материалууд

- Chen, Y. and K.Rogoff. 2003. "Commodity Currencies." /Бараа түүхий эдийн валютууд/. *Journal of International Economics* /Олон улсын эдийн засгийн сэтгүүл/ 60: 133-160. 2 дугаар сар.
- DeLong, B. and L.Summers. 1991. "Equipment Investment and Economic Growth." /Тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт ба эдийн засгийн өсөлт/. *Quarterly Journal of Economics* /Улирал тутмын Эдийн засгийн сэтгүүл/ 106(2): 445-502.
- The Economist* /Экономист сэтгүүл/. 2005 оны 6 дугаар сар.
- Heston, A., R.Summers, and B.Aten. 2002. Penn World Table / Пенн Уорлдны Хүснэгт/, Version 6.1. Philadelphia: Center for International Comparisons at the University of Pennsylvania / Пеннсилваны Их Сургуулийн Олон Улсын Харьцуулалтын Төв/ (CICUP). 10 дугаар сар.
- International Monetary Fund /Олон Улсын Валютын Сан/. No year. World Economic Outlook Database /Дэлхийн эдийн засгийн тоймын мэдээллийн сан/.
- Kaminsky, G., S.Lizondo, and C.Reinhart. 1988. "Leading Indicators of Currency Crises." /Валютын хямралын тэргүүлэх үзүүлэлтүүд/. *International Monetary Fund Staff Papers* /Олон Улсын Валютын Сангийн ажилтнуудын тайлан/. 3 дугаар сар. 1-48.

- Melitz, M. 2003. "The Impact of Trade on Intra-industry Reallocations and Aggregate Industry Productivity." /Салбар хоорондын дахин хуваарилалт ба нийт салбарын бүтээмжид үзүүлэх худалдааны нөлөө/. *Econometrica* /Эконометрика/ 71:1695-1725. 11 дүгээр сар.
- Obstfeld, M. and K.Rogoff. 1996. *Foundations of International Macroeconomics*. /Олон улсын макро эдийн засгийн үндсүүд/. Cambridge: MIT Press.
- _____. 2001. "The Six Major Puzzles in International Macroeconomics: Is there a Common Cause?" /Олон улсын макро эдийн засаг дахь зургаан гол оньсого: Энд нийтлэг шалтгаан байна уу?/. Bernanke B. and K.Rogoff, eds. *NBER Macroeconomics Annual 2000*. /ЭЗСҮТ Жил бүрийн макро эдийн засаг 2000/ Cambridge: MIT Press. 339-90.
- _____. 2005. "Global Current Account Imbalances and Exchange Rate Adjustments." /Дэлхий дахины урсгал дансны тэнцвэргүй байдал ба валютын ханшны тохируулга/. Forthcoming in Brainard, W. and G.Perry, eds. *Brooking Paper on Economic Activity* /Эдийн засгийн үйл ажиллагааны Брүүкингийн тайлан/. Washington: Brookings Institution Press.
- Reinhart, C. and K.Rogoff. 2004. "The Modern History of Exchange Rate Arrangements: a Reinterpretation." /Валютын ханшны зохицуулалтын орчин үеийн түүх: Дахин тайлбарласан нь/. *Quarterly Journal of Economics* /Улирал тутмын эдийн засгийн сэтгүүл/. 119(1):1-48. 2 дугаар сар.
- Rogoff, K. 1996. "Purchasing Power Parity Puzzle." /Валютын худалдан авах чадварын оньсого/. *Journal of Economic Literature* /Эдийн засгийн ном зохиолын сэтгүүл/ 34:647-68. 6 дугаар сар.
- Summers, R. and A.Heston. 1991. "The Penn World Table (Mark 5): An Expanded set of International Comparisons, 1950-1988." /Пенн Уорлдын Хүснэгт (Марк 5): Олон Улсын харьцуулалтын өргөтгөсөн багц, 1950-1988/. *Quarterly Journal of Economics* /Улирал тутмын эдийн засгийн сэтгүүл/ 106:327-68. 5 дугаар сар.
- University of Pennsylvania. 2002. Penn World Table /Пенн Уорлдын Хүснэгт/. Philadelphia: Center for International Comparisons at the University of Pennsylvania /Пеннсилваны Их Сургуулийн Олон улсын харьцуулалтын төв/ (CICUP).
- Williamson, J. 1989. "What Washington Means by Policy Reform." /Вашингтон бодлогын шинэчлэл гэдгээр юу хэлээд байна вэ/. Institute for International Economics /Олон улсын эдийн засгийн хүрээлэн/. Mimeo.

БҮЛЭГ 2.3

Байгаль Орчин Өрсөлдөөний Нэг Эх Сурвалж Болох нь

АЛЛЕН ХАММОНД¹, Дэлхийн Нөөцийн Институт

Бизнесийн хувьд байгаль орчны зохицуулалтыг хөндлөнгийн албадлага буюу эрсдэл гэж урт хугацааны туршидойлгожиржээ. Тэгвэл байгаль орчин болон нийгэм, хөгжлийн асуудлуудыг шинэ бүтээгдэхүүн, шинэ технологи, шинэ зах зээлийн таатай боломжуудын нэг эх сурвалж гэж ойлгох явдал улам бүр нэмэгдэж байна. Зөвхөн эдгээр боломж ба эрсдлийг аль алиныг нь харгалзан үзсэн цагт л бизнесийн утга агуулгыг нь бүрэн үнэлж болох юм. Энэ бүлэгт байгаль орчин, тогтвортой хөгжил хоёр бол өрсөлдөөний давуу талын нэг эх сурвалж гэсэн илүү өргөн хүрээг танилцуулах бөгөөд Дэлхийн Эдийн Засгийн Форумын 2005 оны Бизнесийн удирдлагуудын санаа бодлын Судалгаа гэх мэт олон тооны шинжилгээ, судалгаа, тайлан, жишээнүүдээс иш татах болно.

Уг Судалгаанаас гадна энэ бүлэгт дэлхий дахины байгаль орчны асуудлуудаас ялангуяа Уур амьсгалын өөрчлөлт ба экосистемийн доройтлоос, мөн дэлхий дахины нийгмийн ба тогтвортой өсөлт хөгжлийн шийдвэрлэх сорилтуудаас, ялангуяа ядуурлаас үүдэн бизнесийн өмнө тулгарч буй зарим боломж, нөхцлүүдийг авч үзэх болно. Мөн Уур амьсгалын бодлогын өрсөлдөх чадварын утга агуулгын талаар болон экосистемийн доройтлоос өрсөлдөх чадварт учруулж буй сорилтуудын цар хүрээны тухай шинжлэх ухааны шинэ нотлох баримтын талаар хийгдсэн сүүлийн үеийн шинжилгээ судлагаануудыг дэлгэрэнгүй авч үзнэ.

Дэлхийн байгаль орчны сорилтууд бизнесийн боломж болох нь

Дэлхийн эрчим хүчний эрэлтийн хурцадмал байдал эдийн засгийн хөгжилд түлхэц өгөхийн зэрэгцээ дэлхийн Уур амьсгалын байдалд аюул занал учруулж байна. Үүний нэг адилаар, дэлхийн хэмжээнд өсөн нэмэгдэж байгаа хүнс, цэвэр ус, мод, нийлэг утасны эрэлт хүний болон эдийн засгийн хэрэгцээг хангахын зэрэгцээ эдгээр болон бусад амин чухал үйлчилгээг үзүүлдэг, эцсийн эцэст түүнээс бүх хүний амьдрал хамаарч байдаг экосистемийг маань доройтуулж байна. Эдгээр зөрчлүүд бодитой оршиж байгаа бөгөөд асуудал бүхэлдээ үүгээр зогсохгүй юм.

Эдгээр шаардлагаас үүдэн том, жижиг бүх бизнесүүд шинэ бөгөөд байгаль орчинд илүү халгүй арга зам эрж олох явдал улам бүр нэмэгдэж байна. Эдгээр шинэчлэгч арга барилын тоонд үйлдвэрлэлийн илүү үр

ашигтай ажиллагаа, бага буюу тэг бохирдолтой боловсруулалт, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр зэргийг оруулж болно. Мөн эдгээрт ус бага ашигладаг ажиллагаа болон технологи, шаардлагатай үед цэвэр усаар хангадаг шинэлэг аргууд, хүнс болон нийлэг утсыг илүү тогтвортой байдлаар үйлдвэрлэх шинэ аргууд, дахин ойжуулах замаар нүүрстөрөгчийг багасгадаг экосистемийн удирдлагын арга ажиллагаа зэргийг оруулна. Гурав дахь арга нь бага орлоготой ард иргэдийн хэрэгцээг хангах, тэдний мэдээлэл авах боломж, бүтээмжийг дээшлүүлэх замаар чадавхийг нь бэхжүүлэх, улмаар тэднийг газар дэлхийн хязгаарлагдмал нөөц баялгаас бус, мэдлэгийн хязгааргүй нөөц баялгаас амьжиргаагаа тэтгэж, баялгийг бүтээж чаддаг болгоход чиглэсэн шинэ технологи, бизнесийн загваруудыг хөгжүүлэхэд голлон анхаарч байна.

Шинэ арга зам шаардлагатай гэдэгт эргэлзээд байх зүйл бараг байхгүй. 1980-2000 онд дэлхийн эрчим хүчний үйлдвэрлэл 42 хувиар өссөн бөгөөд улам хурдацтай өссөөр байна. 2005 онд газрын тосны үнэ шинэ өндөрлөгт хүрсэн нь өсөн нэмэгдэж буй эрэлт, хүчин чадлын хязгаарлалт болон улам бүр нэмэгдэж буй тодорхойгүй байдлыг тусган харуулж байна. Мөн өсөн нэмэгдэж буй эрчим хүчний үйлдвэрлэл, ашиглалтын байгаль орчинд үзүүлэх хор нөлөө, ялангуяа Уур амьсгалынхээхэн өөрчлөлт гарах эрсдэл болон Киотогийн Протокол хүчин төгөлдөр болсон явдал зэрэг нь аж үйлдвэрийн олон салбарт тодорхойгүй байдал үүсгэж байна. Эдгээр хүчин зүйлс нийлээд өрсөлдөх чадварын орчныг өөрчилж, олон салбар өөрсдийн эмзэг сул тал, бизнесийн үндсэн стратегийг эргэж харахад хүргэж, эрчим хүчний үр ашигтай байдал, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн тухайд болон ус төрөгчийн эдийн засагт шилжих боломжийн тухайд шинэ сонирхол төрүүлэх болжээ.

Маргаашийн эрчим хүчний зах зээл ямархуу байж болох вэ? Одоогоор газрын гүний дулааны, нарны, салхины, биомассын гэх мэт сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүд дэлхийн эрчим хүчний хэрэглээний 12 орчим хувийг бүрдүүлж байна. Дэлхийн хамгийн хурдан өсч буй эрчим хүчний эх үүсвэр бол салхи бөгөөд фотовольтын нарны зай борлуулж тээвэрлэх явдал ч улам хурдацтай өсч байна. Гэвч дэлхий их хэмжээний нүүрс, газрын тос, байгалийн хий ашигласаар байх нь зайлшгүй учраас тэдгээрийг илүү үр ашигтай, илүү цэвэрхэн шатааж сурах

явдал чухал болж байна. Эдгээр бүх зах зээлүүд бизнесийн ихээхэн боломж бий болгож, шинээр бизнес эрхлэгчид ба байгуулагдаад ажиллаж буй компаниудын аль алианаас нь, түүний дотор дэлхийн зарим нэг хамгийн том пүүс компаниудиаас шинэ хөрөнгө оруулалт хийх сонирхол төрүүлж байгаад гайхах зүйлгүй. Жишээлбэл, Женерал Электрик компани нэгэн томоохон шинэ санаачлага гаргаж эхлүүлээд байгаагийн дотор илүү үр ашигтай хийн турбин, нисэх онгоцны хөдөлгүүр, зүтгүүр болон бусад эрчим хүч ашигладаг техник хэрэгсэл бүтээх чиглэлээр зарцуулж буй судалгаа, хөгжлийн ажлынхаа зардлыг хоёр дахин нэмэгдүүлж, жилийн 2 тэр бум ам.долларт хүргэсэн байна. Мөн Тоёота компани өндөр үр ашигтай цэнэглүүрт хөдөлгүүрийн автомашинаар зах зээлд тэргүүлэхийн зэрэгцээ шингэн зайн технологид ихээхэн хөрөнгө оруулалт хийж байна.

Экосистемийн үйлчилгээний хувьд нөхцөл байдал мөн адил тодорхой байна. Дэлхийн 1360 эрдэмтний хамтран дөрвөн жилийн хугацаатай явуулсан Мянганы Экосистемийн Үнэлгээгээр², хүнс, цэвэр ус, гуалин, нийлэг утас, түлшний өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг хангахын тулд сүүлийн 50 жилд хүний үйл ажиллагаа экосистемийг огцом бөгөөд өргөн хүрээтэй өөрчилсөн болохыг тогтоожээ. Эдгээр үр шимийг экосистемийн үйлчилгээг улам бүр доройтуулсны үнэ цэнээр олж авсан бөгөөд институцийн томоохон өөрчлөлт хийхгүй л бол цаашид энэ доройтол улам хурдсах төлөвтэй байна. Тогтвортой Хөгжлийн Төлөө Дэлхийн Бизнесийн Зөвлөлөөс: «Экосистемүүд болон тэдгээрийн үзүүлдэг үйлчилгээнүүд болох ус, биологийн төрөл зүйл, нийлэг утас, хоол хүнс зэргийн хангамж болон цаг уур муудах буюу тэнцвэргүй болох юм бол бизнес үйл ажиллагаагаа явуулж чадахгүй»³ гэж тэмдэглэсэнчлэн эдгээр өөрчлөлт бизнест чухал ач холбогдолтой. Бизнес үйл ажиллагаа, тухайлбал усны төлөө өрсөлдөөн улам бүр нэмэгдэх, байгалийн гаралтай материал, бүтээгдэхүүний нөөц хомсдосоноос үйл ажиллагааны зардал ихсэх эсвэл уян хатан байдал багасах, мөн, ойн мод, загасны нөөц шавхагдахад эсвэл экосистемийн бусад үйлчилгээ доройтоход гүйцэтгэж буй үүргээ улам бүр нягтлан үздэг болох зэрэг асуудалтай тулгарч болно.

Үүний үр дүнд өрсөлдөөний орчин нөхцөл өөрчлөгдөж байна. Юнилевер компаний захирал Энтони Бургмансын хэлснээр,

«Дэлхий дахины өнөөгийн өөрчлөгдөж буй нөхцөл байдалд өнгөрсөн үеийн шийдлүүд олигтой сайн дүйхгүй байх нь элбэг бөгөөд тэдгээрийг эргэн харж, шинэчлэн хэрэгжүүлэх шаардлагатай.»⁴ Энэ нь компаниудын хувьд шинэ бизнесийн боломжууд нь байгалийн баялгийг илүү тогтвортой үйлдвэрлэж чаддаг байх эсвэл экосистемийн доройтлыг багасгах буюу зөөлрүүлж чаддаг байх гэсэн үг юм.

Ядуурал гэдэг бол зөвхөн хүний нөхцөл байдлын хорт хавдар, өсөн нэмэгдэж буй хөгжлийн хүчин чармайлтын анхаарал төвлөрөх гол асуудал болоод зогсохгүй экосистемийн үйлчилгээнээс тэгш бус хамаарал бүхий бага орлоготой ард иргэд эдгээр үйлчилгээг тогтвортой ашиглаж чадахгүй буюу тэгж чадах чадавхи эсвэл арга хэрэгсэл байхгүй учраас ядуурал экосистемийн доройтлыг улам нэмэгдүүлж байгаа юм. Иймээс гурав дахь сорилт бол дэлхийн хүн амын дийлэнх хэсэг болох бага орлоготой иргэдийн чадавхийг бэхжүүлэх, мэдээлэл, эрчим хүч, нийгмийн суурь үйлчилгээ, санхүүгийн үйлчилгээ хүртэх боломжоор нь дамжуулж тэдний бүтээмжийг дээшлүүлэх замаар ядуурлаас гаргах явдал юм. Профессор С.К.Прахалад өөрийн бичсэн, «Пирамидийн ёроол дахь аз завшаан»⁵ хэмээх номондоо өгүүлсэнчлэн «Хэрвээ бид ядуусыг хохирогчид эсвэл төвөг дараа мэт үзэхээ болиод түргэн засарч өөрчлөгдөх, бүтээлч сэтгэлгээтэй шинээр бизнес эрхлэгчид, үнэ цэнэтэй хэрэглэгчид гэж үзэх юм бол таатай боломжийн бүхэл бүтэн шинэ ертөнц нээгдэх болно.» Том, жижиг бүх төрлийн бизнес ядуусын үндсэн эрэлт хэрэгцээг хямд төсөр аргаар хангах, дэд бүтцийн болон санхүүгийн үйлчилгээ үзүүлэх, ядуусын бодит нөхцөл байдалд нийцсэн шинэ бүтээгдэхүүн, шинэ бизнесийн загвар бий болгох замаар ядууст үйлчлэх ихээхэн шинэ таатай боломжуудыг улам ихээр олж нээсээр байна. Үнэн хэрэгтээ бага орлоготой иргэд өнөөдөр нээгдээгүй байгаа магадгүй хамгийн том зах зээлийг бүрдүүлж байгаа нь өсөлтийн шинэ арга зам нэвтрүүлж, өрсөлдөх чадварын орчинд шинэ хүчин зүйл нэмж байна. Тухайлбал, Энэтхэгийн India Tobacco Company /Энэтхэг тамхи компани/, тус улсын хамгийн том банк ICICI зэрэг компаниуд Энэтхэгийн хөдөө дэх асар том зах зээлийг өөрсдийн ирээдүйн төв гэж үзэн гол анхаарлаа аль хэдийн тийш нь хандуулах болжээ.

Бизнесийн ухамсар: Дэлхийн Эдийн Засгийн Форумын Бизнесийн удирдлагуудын санаа бодлын судалгаа

2005 оны Судалгаанд бизнесийн ухамсартай холбоотой 19 асуултыг дөрвөн том чиглэлд хуваан оруулсан байна. Таван асуулт нь байгаль орчны асуудлыг тойрсон засаглалтай холбоотой байсны дотор байгаль орчны зохицуулалтын нарийн чанд байдал, тууштай хэрэгжилт, бохирдол үүсгэлт болон бусад бизнесийн үйл ажиллагаанд шаардагдах ил тод байдлын түвшин, зохицуулалтаас өрсөлдөх чадварт үзүүлэх нөлөөний тухай ойлгоц, өмч хувьчлалын үр нөлөөний тухай асуултууд орсон байна. Дараагийн зургаан асуулт нь дэлхий нийтийн болон дотоодын байгаль орчны бэрхшээлтэй асуудлууд ба тэдгээрийн шийдэлд хандах хандлагыг хамарсан нь Уур амьсгалын өөрчлөлт, Киотогийн Протокол, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр, цэвэр ус, экосистемтэй холбоотой бусад байгалийн баялаг, мөн байгалийн гамшгийн тухай байна. Дөрвөн асуулт нь байгаль орчин ба тогтвортой хөгжлийн практикийн талаарх бизнесийн байгууллагын нийгмийн хариуцлагын хандлагыг хөндөн авч үзсэн бөгөөд үүнд ёс зүйн дүрэм, байгаль орчны тайлагнал, байгаль орчны эрсдлийн үнэлгээ, олон талт стандартад холбоотой байдал зэрэг сэдэв орсон байна. Сүүлийн дөрвөн асуултад экологийн үр ашигтай байдалд нийцэхээс эхлээд сонирхогч талуудтай зөвлөлдөх хүртэл бизнесийн байгууллагын байгаль орчны удирдлагын практикуудын тухай асуужээ. Бүх асуултад долоон түвшин бүхий хариултын хуваарь санал болгосон байна.

Хариултуудыг улс бүрийн бизнесээр тус тусд нь ангилж, улс орнуудын хооронд зарим нэг ерөнхий харьцуулалт хийх үндэстэй болгохын зэрэгцээ дэлхийн хэмжээний бизнесийн хандлагуудыг олж харах боломж олгожээ.

Өнгөрсөн жилийн *Дэлхий дахины өрсөлдөх чадварын тайлан*-гийн Байгаль орчны тухай бүлэгт ихээхэн нийцүүлэхийн тулд улс орон бүрийн хариултыг дундажлан нийт хариултад шинжилгээ хийгээд байна. Асуулт бүрт улс орнуудыг өндөр (5-7), эерэг талдаа (4-5), сөрөг талдаа (3-4), бага (1-3) гэсэн дөрвөн ангилалын аль нэгд хуваасан. Эдгээр ангилал бүрт орсон асуултуудын тоогоор улс орнуудад оноо өгсөн бөгөөд маш өндөр буюу бага зэрэглэл нь илүү дундаж утгуудаасаа хоёр дахин их хувийн

жинтэй байхаар тооцов. Үүний үр дүнд бий болсон улс орнуудын зэрэглэлийг (Хүснэгт 1) бизнесийн удирдлагууд өөрсдийн орны байгаль орчин ба нийгмийн хариуцлагын асуудлуудаарх шийдвэр гаргалтын уур амьсгалыг хэрхэн үнэлж байгааг, улмаар байгаль орчны болон нийгмийн хариуцлагатай холбоотой засгийн газрын болон бизнесийн үйл ажиллагааны дүнг тусган харуулж байна гэж тайлбарлаж болно. Энэхүү зэрэглэл нь тухайн улсын байгаль орчны чанарыг эсвэл илүү өргөн хүрээтэй өрсөлдөх чадварын уур амьсгалыг заавал тусгах албагүй юм.

Судалгаанд хамрагдсан сэдвүүдийн дор хаяж тэн хагаст нь эерэг үнэлгээ авсан нийт 49 улс байгаа нь түрүү жилийнхээс ялимгүй өндөр үзүүлэлттэй байна. Мөн ерөнхий дүнгээрээ сөрөг оноо авсан 69 улсын гуравны нэгээс илүү хувь нь зарим чиглэлд ахиц дэвшил гаргасан байна. Судалгааны үр дүнгээс ерөнхийдөө харахад, бизнесийн удирдлагуудын үзэл бодлоор бол эдийн засгийн хөгжил, байгаль орчны болон нийгмийн хариуцлагын гүйцэтгэл хоёр харилцан уялдаа сайтай байх үндэслэлтэй байна. Баян чинээлэг орнууд илүү их байгаль орчинд чиглэсэн үйл ажиллагаа явуулах боломжтой байна. Гэсэн хэдий ч хэд хэдэн хөрөнгө чинээ муутай орон, тухайлбал эхний хэсэгт Малайз, хоёрдугаар хэсэгт Өмнөд Африк, Бразил, Гана гэх мэт, маш өндөр зэрэглэлтэй гарсан нь хөгжлийн олон янзын түвшинд эерэг уур амьсгал бий болгох боломжтойг харуулж байна. Түүнчлэн өсч хөгжиж буй, өрсөлдөх чадвартай бизнесийн салбарууд судалгааны энэ хэсэгт өгсөн эерэг хариултаудтай сайтар уялдаж байгааг харуулах зарим нэг нотлох баримт ч бий.

Сайжруулалт хийх ихээхэн орон зай байгааг уг Судалгаа тодорхой харуулж байна. Хариулт өгсөн орнуудын 42 хүрэхгүй хувь нь тухайн орнуудын байгаль орчны зохицуулалт хатуу чанд гэж үзсэн бол, дөнгөж 35 орчим хувь нь байгаль орчны зохицуулалт тогтвортой, тууштай байдлаар хэрэгждэг буюу засгийн газраас эрх олгосон байгаль орчны ил тод байдлын зохицуулалт өргөн хүрээг хамарч, үр нөлөөтэй хэрэгждэг гэж үзсэн байна. Түүний зэрэгцээ регрессийн шинжилгээ хийж үзэхэд, авилгал газар авсан байдал гэх мэт өргөн хүрээтэй сөрөг хүчин зүйлс ба байгаль орчны зохицуулалтыг тууштай сахиулж байгаа байдлын хооронд чухал ач холбогдолтой уялдаа холбоо байгааг илтгэж байна. Үнэхээр байгаль орчны ба нийгмийн хариуцлагатай байдал нь

бизнесийн ерөнхий уур амьсгалаас салангид оршдоггүйг Хүснэгт 1-д тодорхой харуулж байна.

Харин хариулт өгсөн орнуудын 70 хувьд ажиллаж буй бизнесийн удирдагч нарын дийлэнх хэсэг нь байгаль орчны стандартуудыг дагаж мөрдсөнөөр урт хугацааны өрсөлдөх чадварыг сайжруулдаг гэдэгтэй санал нэг байгаа нь анхаарал татаж байна. Бүр их анхаарал татсан зүйл бол цэвэр ус эсвэл цэвэр агаар хомсдохын хэрээр компаний үйл ажиллагаанд нөлөөлөх буюу бизнесийн өргөжилтийг боомилж байна гэдэгтэй эерэг хариулт өгсөн улсуудын 76 хувь нь санал нэгтэй байлаа. Энэхүү олж мэдсэн зүйл маань хожим авч үзэх экосистемийн доройтлын тухай шинэ нотлох баримтыг улам бататгаж байна. Үүнээс ялимгүй цөөн хувь буюу хариулагсдын 63 хувь нь байгалийн гамшгийн гаралт тэдний үйл ажиллагаа, өргөжилтөд ихээхэн нөлөө үзүүлсэн гэдэгтэй санал нэг байна. Харин улс орнуудын дөнгөж гуравны нэгд буй бизнесийн удирдлагууд Уур амьсгалын өөрчлөлт, Киотогийн Протокол, сэргээгдэх эрчим хүч, эсвэл экосистемийн доройтлыг нэг тэргүүлэх чиглэлээ гэж үзсэн байна. Экосистемийн доройтол ба усны үер, эсвэл Уур амьсгалын өөрчлөлт ба ган эсвэл хүчтэй салхи шуурга хоёрын уялдаа холбоог дийлэнх улс орны бизнесийн удирдагч нар хараахан олж хараагүй байгаа нь мэдээж.

Байгаль орчны менежментийн гүйцэтгэл ч янз бүрийн дүр зурагтай байна. Улс орнуудын дөнгөж гуравны нэг орчимд нь зохицуулалтыг үл дагаж мөрдсөний санхүүгийн үр дагаврыг чухалд тооцсон буюу байгаль орчны менежментийн тогтолцоог зохицуулалтын зайлшгүй шаардлагаас нь салгаж үнэлсэн байна. Түүнчлэн улс орнуудын 55-аас дээш хувьд ажиллаж байгаа бизнесийн удирдлагууд компаний үйл ажиллагааны нөлөөгөөр хохирч буй ард иргэдтэй зөвлөлдөх нь хөгжлийн зайлшгүй шаардлагатай нэг хэсэг гэж үзсэн байхад, 80-аас дээш хувь нь илүү цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэж, хог хаягдлыг багасгах нь тэдний компаниудад чухал ач холбогдолтой гэж үзжээ.

Уур амьсгалын бодлогын өрсөлдөх чадварын ач холбогдлыг ойлгох нь

Хүний үйл ажиллагаагаар бий болсон хүлэмжийн хийн (ХХ) ялгаралтыг зохицуулах бодлого улам ихээр боловсрогдон гарч, дэлхий дахины томоохон зах зээлүүдэд хэрэгжиж

Хүснэгт 1: Байгаль орчны ба нийгмийн хариуцлагын талаарх улс орнуудын гүйцэтгэлийг 2005 оны Бизнесийн удирдлагуудын санаа бодлын судалгаагаар үнэлсэн байдал

Өндөр гүйцэтгэлтэй	Зарим сул талуудтай	Гол сул талуудын хувьд эерэг	Сөрөг талыг тэнцвэржүүлэхэд ахиц гарсан	Зарим ахиц дэвшил байгаа ч ихэвчлэн сөрөг	Сөрөг буюу хараахан эхлээгүй
1. Финланд	21. Өмнөд Африк	32. Тайланд	49. Хятад	71. Хорват	101. Гүрж
2. Дани	22. Бельги	33. Унгар	50. Турк	72. Индонези	102. Гватемал
3. Герман	23. БН Солонгос	34. БН Словак	51. Намиби	73. Пакистан	103. Гайана
4. Норвеги	24. Словени	35. Тунис	52. Египет	74. Мали	104. Гондурас
5. Нидерланд	25. Израиль	36. Чили	53. Латви	75. Аргентин	105. ОХУ
6. Сингапур	26. Люксембург	37. Литва	54. Иордан	76. Бахрейн	106. Болив
7. Швед	27. Испани	38. Колумби	55. Польш	77. Азербайжан	107. Зүүн Тимор
8. Их Британи	28. БН Чех	39. Эстони	56. Ботсван	78. Мальт	108. Этиоп
9. Шинэ Зеланд	30. Бразил	40. Гонгконг	57. Ямайк	79. Украин	109. Никарагуа
10. Япон	31. Гана	41. АБН Эмират	58. Кени	80. Бангладеш	110. Босни Герцеговин
11. Австрали		42. Энэтхэг	59. Уругвай	81. Казахстан	111. Албани
12. Канад		43. Кипр	60. Гамби	82. Кувейт	112. БН Доминикан
13. Исланд		44. Итали	61. Филиппин	83. Малави	113. Алжир
14. Швейцарь		45. Коста Рика	62. Румын	84. Серб ба Монтенегро	114. Чад
15. Тайвань		46. Мавритани	63. Зимбабве	85. Тажикстан	115. Эквадор
16. Австри		47. Катар	64. Мексик	86. Тринадад Тобаго	116. БН Киргиз улс
17. Франц		48. Грек	65. Нигери	87. Камерун	117. Парагвай
18. Ирланд			66. Панам	88. Марокко	
19. Малайз			67. Перу	89. Вьетнам	
20. АНУ			68. Танзани	90. Шри Ланк	
			69. Уганда	91. Бенин	
			70. Эль Сальвадор	92. Болгар	
				93. Мадагаскар	
				94. Молдав	
				95. Монгол	
				96. Мозамбик	
				97. Армян	
				98. Камбож	
				99. Македон	
				100. Венесуэл	

Эх сурвалж: Дэлхийн Эдийн Засгийн Форум, 2004

байна. Эдгээр шинэ бодлого нь зардлын бүтцийг өөрчилж, шинэ зах зээл, шинэ бүтээгдэхүүний боломжууд бий болгон өрсөлдөөнд нөлөөлж, янз бүрийн үйлдвэрлэлийн салбаруудын эрэлтийн хэв шинжийг өөрчилж байна. Энэ бодлогыг зөв зохион байгуулж боловсруулснаар компаниудын өрсөлдөөний хариу үйлдлүүдийн хүрээг гаргаж, улмаар компанийн санхүүгийн байдалд үзүүлэх үр нөлөөг тодорхойлох болно.

Уур амьсгалын бодлогын өрсөлдөх чадварын ач холбогдлыг үнэлэх асуудал нь ямар компаниуд зохицуулагдах эсвэл ямар нь эс зохицуулагдах вэ гэдгийг зүгээр нэг тодорхойлохоос хальсан хэрэг юм. Уур амьсгалын бодлого нь янз бүрийн салбарт янз бүрийн хэлбэрээр өөр өөр цаг хугацааны хүрээнд нөлөө үзүүлэх болно. Жишээлбэл, цахилгаан эрчим хүчний салбарын ХХ ялгаруулалтад хязгаарлалт тавигдах магадлалтай. Мөн бусад томоохон хорт хий ялгаруулагчид, тээврийн салбар ч бас ХХ-н ялгаруулалтаа зогсооход хүрэх (ЕХ шиг) талтай.

Тодорхой нэг бодлогын хүрээнд ч гэсэн хэрэгжилт, боловсруулалттай холбоотой шийдвэрүүд хоорондоо нилээд харилцан адилгүй санхүүгийн үр нөлөө үзүүлж байж болно. Жишээлбэл, хориг ба худалдааны системд нөхөн төлбөр хуваарилах шийдвэр ихээхэн улс төрийн шинжтэй байдаг нь эдийн засгийн өөр өөр үр дагавартай байж болно. Цаашилбал, нүүрстөрөгчийн татварын хэлбэр нь ялгаруулалтыг худалдаалах тогтолцооноос өөр утга агуулгатай байж болно.

Уур амьсгалын бодлогуудын үзүүлэх нөлөө зохицуулалтын шууд зардлуудаас давж байна⁶

Компаниудад Уур амьсгалын бодлогын үзүүлэх өрсөлдөөний үр нөлөөг илүү нарийн үнэлэхийн тулд ХХ-н ялгаралтыг зүгээр нэг хэмжихээс цааш хальж, ХХ-н хязгаарлалтуудын янз бүрийн хэлбэрийг болон тэдний үнэт зүйлсийн гинжин холбоогоор дамжин үзүүлэх нөлөөг харгалзан бэлэн мөнгөний урсгалын

Хүснэгт 2: Автомашины салбарт тулгарч буй таатай боломжууд ба эрсдлүүд

Санхүүгийн хөтөлгөч	Эрсдэл	Таатай боломж
Зардлын бүтэц	Нүүрстөрөгчийн хязгаарлалт нь судалгаа, хөгжлийн ажлаас эхлээд, зохион бүтээлт, үйлдвэрлэлийн шатанд хүртэл зардлыг нэмэгдүүлж болзошгүй.	Нүүрстөрөгчийн хязгаарлалт нь судалгаа, хөгжлийн ажлаас эхлээд, зохион бүтээлт, үйлдвэрлэлийн шатанд хүртэл зардлыг нэмэгдүүлж болзошгүй.
Нэр төрөл	Цэвэр технологийн хөгжлөөр хоцрох нь бүтээгдэхүүний нэр төрөлд хор хөнөөл учруулж болзошгүй	Уур амьсгалын өөрчлөлтийн бодлогоор тэргүүлэгчид тооцогдох нь нэр төрлийн үр өгөөжийг нэмэгдүүлж болох юм
Шинэ санаачлалт	Шинийг санаачлах чадавхид нүүрстөрөгчийн хязгаарлалт дарамт учруулна	Нүүрстөрөгч багатай технологид манлайлах нь түрүүлж хөдлөсний давуу тал авчирна
Үйлдвэрлэлийн сегментчилэл	Нүүрстөрөгч ихтэй сегментээс хамааралтай ЖТТҮ-дийн борлуулалт ба ашгийн хэмжээ буурч болзошгүй.	Нүүрстөрөгч багатай автомашин үйлдвэрлэж буй ЖТТҮ-дийн борлуулалт ба ашгийн хэмжээ нэмэгдэж болзошгүй

Эх сурвалж: Дэлхийн Нөөцийн Институт, Капиталын зах зээлийн судалгаа, хэвлэгдсэн ба хэвлэгдээгүй тоон мэдээлэл.

шинжилгээ хийж үзэх ёстой. Уур амьсгалын бодлогын өрсөлдөөний болон санхүүгийн утга агуулгыг компаний түвшинд шинжлэх нь ялагч, ялагдагчдыг тодорхойлох хамгийн шилдэг арга юм. Уур амьсгалын эрсдлийн тухай ихэнх ном зохиол зохицуулалтын шууд зардалд голлон анхаардаг боловч Уур амьсгалын бодлогын хөрөнгө оруулалтад үзүүлэх нөлөөг бүрэн гаргаж харуулахын тулд дараахь зүйлсийг мөн үнэлэх шаардлагатай.

- **Уур амьсгалын эрсдлээс үнэт зүйлсийн гинжин хэлхээгээр дамжин үзүүлэх нөлөө:** зарим бүтээгдэхүүн үйлчилгээг ашиглах буюу хэрэглэхэд тэдгээрийн үйлдвэрлэлтэй холбоотойгоос гадна нэмэлт ХХ-н ялгаралт үүсч болно. ХХ-н ялгаралтыг хязгаарлах бодлого тухайн үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлтийг багасгах буюу ихэсгэх замаар эдгээр салбарт дам нөлөөлж болно. Түүгээр барахгүй Уур амьсгалын бодлогын аливаа компаний нийлүүлэлтийн сувагт нөлөөлж байгаа цар хүрээ орцын зардалд ч бас нөлөө үзүүлж болох юм.
- **Хэрэглэгчдэд өртөг зардлыг үүрүүлэх цар хүрээ:** ХХ-н ялгаралт ихтэй тодорхой бүтээгдэхүүн, үйлчилгээний зайлшгүй шаардлагатай байдал эсвэл богино хугацаанд орлуулан хэрэглэх боломж хязгаарлагдмал байдал, аль эсвэл аль шалтгаанаар дээрх бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт уян хатан бус байж болно. Иймээс Уур амьсгалын бодлогоор тодорхой салбаруудын ХХ-н ялгаралтыг

хязгаарлахыг оролдсон ч гэсэн, шууд үзүүлэх нөлөө бага байх буюу урт хугацаанд хийгдэх өөрчлөлтийн зардал хэрэглэгчдэд ачаалал болж очно.

- **Уур амьсгалын бодлогод үзүүлэх стратегийн хариу үйлдэл:** Уур амьсгалын бодлогын нөлөөнд автаж буй ихэнх үйлдвэрлэлийн салбарын хувьд ХХ-н зохицуулалтын эсрэг үзүүлэх компани бүрийн хариу үйлдэлд нүүрстөрөгч багатай технологи хэрэглэх, ялгаруулалтыг ашиглах, ХХ-г багасгах төслүүдэд хөрөнгө оруулах, ХХ-н зохицуулалтыг болиулах талаар лобби хийх буюу хууль зүйн хүчин чармайлт тавих зэрэг янз бүрийн боломж байж болохоос энд цөөн хэдийг нь дурдлаа. Эдгээр боломж нь янз бүрийн зардал, янз бүрийн санхүүгийн үр дагавар ба өрсөлдөөний асуудлуудтай байдаг.

Уур амьсгалын өрсөлдөх чадвар бизнесийн байгууллагын өрсөлдөх чадварт нөлөөлнө

Уур амьсгалын бодлого компаний ашигт ажиллагаанд хэрхэн нөлөөлдөг нь огт тодорхойгүй байж болох юм. Уур амьсгалын эрсдэл бэлэн мөнгөний урсгал ба ашигт ажиллагааг өөрчлөх боломжтой. Компаниудын зүгээс хэр их бэлэн мөнгөний урсгал нөлөөлөлд автах нь Уур амьсгалын бодлогод үзүүлэх хариу үйлдлээ зөв удирдах, шинэ бүтээгдэхүүн, шинэ зах зээлийн боломж нээх, зохицуулалтын зардлуудыг багасгах, капиталд хөрөнгө оруулах, нийлүүлэлтийн сувгаа удирдах ур чадвараас хамаарна.

Уур амьсгалын бодлого нь үйл ажиллагааны болон үйл ажиллагааны бус зардлуудын аль алинд нь нөлөөлж болно. Үнэн хэрэгтээ, Уур амьсгалын бодлогын зарим хэлбэрийн зардалд зөвхөн татварын болон капиталын зардлын хэлбэрээр илрэх үйл ажиллагааны бус зардлууд орж болно (өрийн зардалд нөлөөлөх боломжтой). Бусад бодлогын хувьд ялгавартай үнийн бүтэц эсвэл ялгаруулалтыг худалдаалах замаар үйл ажиллагааны ашгаа нэмэгдүүлэх боломж гарч болох юм. Уур амьсгалын бодлого ашигт ажиллагаанд нөлөөлж болох арга замын дараахь зарим жишээ байдаг:

- **Орлого:** эрэлтийн хэв шинж, үнийн бүтэц, шинэ бүтээгдэхүүн ба зах зээлийн боломжид гарах өөрчлөлтүүд
- **Борлуулсан бүтээгдэхүүний зардал:** нийлүүлэлтийн сувгаар дамжин үнийн бүтцэд гарах өөрчлөлтүүд
- **Үйл ажиллагааны зардлууд:** үйлдвэрлэлийн зардлын бүтэц, ялгаруулалтыг худалдаалах зардалд гарах өөрчлөлтүүд
- **Капиталын зардлууд:** ХХ ялгаруулалтыг багасгахын тулд шинэ капиталд оруулах хөрөнгө оруулалт
- **Татварууд:** татварын зардалд үзүүлэх боломжит нөлөө

Жишээ судлал: Дэлхийн автомашины салбар⁷

Автомашины салбар газрын тосны хэрэглээний хязгаарлалт ба Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнд улам бүр орж байна. Эрчим хүчний аюулгүй байдлын асуудал, Уур амьсгалын өөрчлөлтийн тухай ойлголт дээшилсний давхар нөлөөгөөр нүүрс хүчлийн давхар исэл (CO₂) ба түлшний хэмнэлтийн талаарх зохицуулалт улам чангарч, өргөн хүрээг хамардаг болоод байна. Эдгээр зохицуулалт нь уг салбарт ажиллаж буй компаниудын өрсөлдөх чадварт гүн гүнзгий нөлөө үзүүлэх болно. Эдгээр шинэ хэмжигдэхүүн нь цэвэр технологи, бага нүүрстөрөгч ялагаруулалтад хөрөнгө оруулах боломжуудыг хэрхэн бүрдүүлэх вэ гэдгийг компаниуд улам бүр анхааран авч үзэх болно.

Эрчим хүчний аюулгүй байдал ба Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлуудыг ихэвчлэн тусд нь зохицуулдаг боловч яваандаа нийлэх чиг хандлагатай байна. Хэрвээ ийм болох юм бол түүний үр нөлөө дэлхийн хамгийн том газрын тос хэрэглэгчид болох хувийн тээврийн хэрэгсэлтэй хүмүүст ойрын болон урт хугацааны турш мэдрэгдэх болно. Энэ хэсэгт

бид дэлхий дахинд хийж буй зохицуулалтууд автомашины салбар дахь өрсөлдөөнийг хэрхэн хөтлөж байгаа талаар авч үзнэ.

Хүснэгт 2-т үзүүлсэнчлэн, нүүрстөрөгчийн хязгаарлалт тавигдсанаар эрсдэл ба таатай боломжийн шинэ эх сурвалж бий болж байгааг хөрөнгө оруулагчид болон менежерүүд салбарын үндсэн асуудлынхаа хажуугаар авч үзэх шаардлагатай болно. Нэн ялангуяа, нүүрстөрөгчийн хязгаарлалт нь уг салбарын уламжлалт үнэ цэнийг хөтлөгчдөд нөлөөлөх замаар ЖТТҮ-ийн⁸ өрсөлдөх чадвар ба ашигт ажиллагаанд нөлөөлж болох юм. Иймд эдгээр шинэ дарамт шахалтыг тусгахын тулд уламжлалт үнэлгээний загваруудаа шинэчлэх шаардлагатай болно.

Автомашины салбарын уламжлалт үнийн загвар нь эрэлт, нийлүүлэлтийн хүчин зүйлсэд тулгуурлах бөгөөд тэдгээр нь эргээд борлуулалтын хэмжээ, үнэ тогтоолт, орлого, зардлын зөрүү, ашигт ажиллагааг тодорхойлж байдаг⁹. Үнэ цэнийг чиглүүлэгч эдгээр биет хүчин зүйлсээс гадна нэр төрөл, шинийг санаачлах, бүтээгдэхүүний чанар гэх мэт олон тооны биет бус хүчин зүйлсийг өрсөлдөөний давуу тал ба үнэ цэнэ бий болгох чухал эх сурвалж гэж үзэх явдал улам бүр нэмэгдэж байна. Ямар нэг автомашины компаний зах зээлийн үнэ цэнийн 50 орчим хувийг биет бус хөрөнгө бүрдүүлж байж болно¹⁰.

Тогтсон, өсөлт багатай зах зээлд компаниуд зөвхөн өөр нэг пүүс компаний зах зээлд эзлэх хувийг авах замаар борлуулалтаа нэмэгдүүлж болдог. Ийм тэг нийлбэртэй тоглоомын орчинд олж авсан өрсөлдөөний давуу тал түр зуурын шинжтэй байх хандлагатай байдаг. Богино хугацааны давуу тал олж авах нэг чухал хэрэгсэл бол шинийг санаачлах явдал юм. Шинэ загвар эсвэл технологийн хэлбэрээр шинийг амжилттай санаачлах нь үнэ тогтоох эрх мэдэл, ашгийн өндөр түвшин гэх мэт түрүүлж хөдөлсний давуу тал олгодог. Ийм учраас шинийг санаачлах чадвараа хадгалах нь автомашины салбарын өрсөлдөх чадварт онц чухал ач холбогдолтой.

ХХ-н ялгаралт, түүний дотор CO₂-г зохицуулах бодлогыг хөдөлгөх хүч дэлхий дахинд бүрэлдсээр байна. Автомашины салбар дахь компаниуд Европын Холбоо (ЕХ), Канад, Япон, Австрали болон АНУ-ын зарим бүс нутгийн зах зээлийн зохицуулалт, стандартуудад орж эхлэх болно. Мөн саяхан Хятадад шатдаг түлш хэмнэх зохицуулалтууд гараад байна. CO₂-ын ялгаралт шатдаг түлшний

хэрэглээтэй шууд пропорциональ хамааралтай учраас Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаас үүссэн бодлогыг эрчим хүчний аюулгүй байдлын үүднээс гаргасан бодлогоос ялгахад хэцүү байдаг. Ямар шалтгаантай байснаас үл хамааран эдгээр бодлого нь уг салбарт түлшний хэмнэлт өндөртэй, хорт хий ялгаруулалт багатай автомашин үйлдвэрлэх шахалт болж байна. Эдгээр шинэ хэмжигдэхүүний хүрээнд компаниуд өрсөлдөж эхэлснээр илүү цэвэр технологи ба түлшний эрэлтийг урамшуулах болно.

Түлшний хэмнэлт, ХХ-н стандартуудаас гадна, агаарын бохирдлын стандартууд цар хүрээ, хатуу чанд байдлаа нэмэгдүүлж байгаа нь ялангуяа автомашины томоохон зах зээлүүдэд мэдрэгдэж байна. Эдгээр зохицуулалт нь бензиний хөдөлгүүртэй харьцуулахад тусгай бодис (амьсгалын замын өвчин, утаа тортог үүсгэдэг), азотын хүчлүүд (утаа манан үүсгэгч) илүү ихээр ялгаруулдаг дизель хөдөлгүүрүүдэд ялангуяа хамаатай хорт утаа ялгаруулалтын стандартууд тогтоож байна. Түүхээс үзэхэд Европ тив агаарын бохирдлын доогуур стандарттай байсан нь татварын онцгой нөхцөлтэй нийлээд, уг зах зээлд дизель хөдөлгүүрүүд нэмэгдэх боломж олгосон байна. Европ дахь автомашины компаниуд дизель хөдөлгүүрийн ашигт ажиллагааг сайжруулах (түүний дотор түлшний шууд шахалтын аргаар) замаар агаарын бохирдлын зохицуулалтын (Евро 4) хамгийн сүүлийн шатыг давж чадсан байна. Хэрэв дараагийн шатны агаарын бохирдлын зохицуулалт (Евро 5) гарах юмуу эсвэл утаа шүүгч ба түүний дараахь эмчилгээ хийх зайлшгүй шаардлагатай болох юм бол зөвхөн хөдөлгүүрийн ашигт ажиллагааг сайжруулахад хангалттай эсэх нь тодорхойгүй үлдэж байна. Энэ асуултын хариулт нь мөн АНУ дахь дизель хөдөлгүүрийн өсөлтөд хариу өгөх бөгөөд энд одоо мөрдөж буй стандартууд нь 2009 он гэхэд Евро 5-тай бараг ойролцоо түвшинд хүрэх юм.

Мэдээж шатдаг түлшний шаталтаас үүсч буй нүүрс хүчлийн давхар исэл ба автомашины яндангаас гарч буй бусад хорт хийн ялгаралтыг зохицуулахад чиглэсэн мэдэгдэхүйц чиг хандлага ажиглагдаж байна. Хүний үйл ажиллагаанаас үүссэн Уур амьсгалын өөрчлөлтийн шалтгаануудыг илүү өргөнөөр ойлгож, хүлээн зөвшөөрдөг болохын хэрээр ХХ-н ялгаралтыг багасгах бодлого улам олширсоор байх болно. Газрын тосны үнийн өсөлт, эрчим хүчний аюулгүй байдлын асуудлууд нь дэлхийн

улс орны засгийн газрууд автомашины салбарт түлшний хэмнэлтийн шинэ шаардлага тавих эсвэл одоо байгаа зохицуулалтаа чангаруулахад хүргэж байна.

Экосистемийн үйлчилгээнүүд ба эдийн засгийн өрсөлдөх чадвар

Мянганы Экосистемийн Үнэлгээний Тайланд¹¹ экосистемийн дараахь үйлчилгээнд гарч буй өөрчлөлтүүд хүний сайн сайхан байдалд хэрхэн нөлөөлж байгааг шалгаж үзсэн байна: а) хүнс, ус, үйлдвэрлэлийн мод; б) цаг уур, үер, өвчин, хог хаягдал, усны чанарт нөлөөлж буй зохицуулалтын үйлчилгээнүүд; в) амралт, гоо зүй, оюун санаанд тустай соёлын үйлчилгээнүүд; г) хөрс боловсруулалт, фотосинтез, шим тэжээлийн эргэлт гэх мэт нэмэлт үйлчилгээнүүд. Уг Үнэлгээний дүнд дараахь дүгнэлт гаргасан байна:

- Сүүлийн 50 жилийн турш хүний үйл ажиллагаагаар экосистемийг асар их өөрчилсөн байна.
- Эдгээр өөрчлөлт нь хүний сайн сайхан байдал, эдийн засгийн хөгжилд ашиг тусаа олонтаа өгсөн боловч экосистемийн олон үйлчилгээг доройтуулж, ядуурлыг даамжруулан, ирээдүй хойч үед үлдэх үр шимийг бууруулах эрсдэлтэй юм.
- Ирэх 50 жилд экосистемийн доройтол Мянганы Хөгжлийн Зорилтуудыг хангахад саад болох хэмжээнд хүртэл эрчимжиж болзошгүй байна.
- Энэхүү чиг хандлагыг эргүүлэхийн тулд бодлого, институци, практик ажиллагааг ихээхэн өөрчлөх шаардлагатай болно.

Уг үнэлгээгээр баримтжуулсан экосистемийн өөрчлөлтүүд туйлын их даамжирлаа гэхэд улс орнуудын эдийн засгийг бүхэлд нь сүйтгэж, бүр дордуулах боломжтой. Мөн эдгээр өөрчлөлт нь ялангуяа хөгжиж байгаа ихэнх орнуудын байгалийн баялгаас хамааралтай эдийн засаг дах баялгийн цэвэр бууралт, үер ус болон бусад байгалийн гамшгийн өсөлт, өвчний тархалт, мөн хоол хүнс, нийлэг утас, түлээ мод, цэвэр усны хангамжийн хомсдолд хүргэж чадна. Түүнчлэн эдгээр өөрчлөлт нь бизнест ноцтой үр нөлөө үзүүлэхийн зэрэгцээ өрсөлдөх чадварын тэгштгэлд шинээр орох нэг чухал хүчин зүйл байх болно.

Загас агнуур, байгалийн зэрлэг хүнсний зүйл, түлшний мод, цэвэр усны нөөц болон биологийн төрөл зүйлээс гаралтай нөөцүүд

зэрэг үйлчилгээний хангамж өргөн хүрээтэй буурч байгааг уг Үнэлгээ тогтоосон байна. Гуалин болон нийлэг утасны хангамж янз бүр буюу зарим бүс нутагт өсч байхад бусад газар буурч байна.

Мөн агаарын бохирдлын зохицуулалт, ус цэвэршүүлэлт, хортон шавьжийн зохицуулалт, ургамлын тоос хүртээлт, байгалийн гамшгийн зохицуулалт болон бусад зохицуулах үйлчилгээ нэлэнхүйдээ буурч байгаа нь харагдаж байна. Түүнчлэн, онгон дархан ой төгөл, үржил шимтэй газрын тоо, чанар эрс буурч байгаа болон амралт сувилал, экологийн жуулчлалын хувьд сайн муу холимог дүр зурагтай байгааг уг Үнэлгээгээр тогтоожээ.

Мод бэлтгэх зорилгоор ой модыг тасалж гэмтээх, устгах, тариалангийн зорилгоор үржил шимтэй чийглэг газруудыг цэвэрлэж, хатаах зэрэг ажиллагаа нь маш харалган бизнесийн практик ажиллагаа байж болох юм. Ихэнх орнуудад гуалин болон түлшний мод бэлтгэсний үнэ цэнэ ой модны нийт үнэ цэнийн, түүний дотор голдуу зах зээлд ороогүй үйлчилгээнүүд болох нүүрстөрөгчийг шингээх, усны хагалбарыг хамгаалах, амралт сувилалын үйлчилгээний, боломжит үнэ цэнийн, гуравны нэг хүрэхгүй хувийг эзэлж байгааг мөн энэ Үнэлгээгээр тогтоосон байна. Түүнчлэн Канадын үржил шимтэй нутгууд, Тайландын мангроут намгууд, Камеруны халуун орны ой гэх мэт хүний гар хүрээгүй онгон дагшин экосистемүүдийг тогтвортой удирдан хамгаалсны үнэ цэнэ нь тэдгээр газрыг эрчимжүүлсэн хөдөө аж ахуй, сам хорхойн аж ахуй, эсвэл бага хэмжээний газар тариалангийн зорилгоор тус тус өөрчилснөөс хамаагүй өндөр байхыг тогтоожээ. Эдгээр зөрүүтэй байдал нь экосистемийн зах зээлд ороогүй байгаа үнэ цэнийг гаргах, эсвэл онгон дагшин системүүдийг тогтвортой байдлаар удирдах зэргээр үнэ цэнийг нь дээд зэргээр гаргаж ашиглах шинэ бизнесийн боломжуудыг санал болгож байна.

Ялангуяа бизнест чухал ач холбогдолтой нэг зүйл бол олон бүс нутагт цэвэр усны нөөц хомсдох аюул занал байгаа явдал бөгөөд улмаар өрсөлдөөн ба өртөг зардлыг нэмэгдүүлэх, дахин боловсруулалт хийхийг шаардах, нэгж бүтээгдэхүүнд зарцуулагдаж буй нийт усны хэрэглээг багасгахад чиглэсэн технологи, боловсруулах ажиллагаа нэвтрүүлэхийг шаардаж болох юм. Түүний зэрэгцээ, цэвэр ус эсвэл ус цэвэршүүлэх тоног төхөөрөмж борлуулах нь ирээдүйтэй бизнес болж байх шиг

байна. Үүнтэй адилаар загас агнуурын нөөцийг хэт их ашиглах нь хүнс тэжээлийн зориулалттай загасны нийлүүлэлтийг хязгаарлах, эсвэл тодорхой газар нутагт загасчлах үйл ажиллагааг хүчээр зогсоох зэрэг олон тооны бизнесийн зардлыг нэмэгдүүлэх арга хэмжээ авахад хүргэнэ. Экосистемүүд туйлдахын хэрээр Ньюфаундлэндийн сагамхай загасны аж ахуй гэнэт сүйрсэн шиг цочир өөрчлөлтүүд гарч, улмаар зарим салбарт бизнесийн стратегийн шинэ сорилт бэрхшээлүүд тулгарч, даатгалын төлбөр өндөрсөх боломжтой. Түүнчлэн эдгээр эрсдэл нь хүн амьтны тэжээлд зориулсан, загасыг орлох хоол тэжээл олох гэх мэт шинэ бизнесийн боломжууд санал болгож байна.

Энэхүү Үнэлгээгээр олж тогтоосон экосистемийн доройтлын хэв шинж нь бизнест олон талын үр нөлөө үзүүлэх боломжтой. Экосистемийн доройтлын талаар санаа тавих явдал ихсэж байгаа нь өсөн нэмэгдэж буй сонирхогч талуудын хүлээлтэд нийцээгүй бизнесийн үйл ажиллагаа явуулах эрхийг хязгаарлаж болно. Бизнесийн үйл ажиллагааны тухай энэхүү өсөн нэмэгдэж буй хүлээлт нь эргээд зохих стандартыг улам сайн дагаж мөрдөхийг шаардахын зэрэгцээ бизнесийн байгууллагын нэр хүндийг хамгаалахын тулд гуравдагч талын гэрчилгээ ашиглахыг шаардах болно. Үүний зэрэгцээ зохицуулалтыг дагаж мөрдөх зардлыг багасгахад чиглэсэн зах зээлийн механизмууд дэлгэрч байгаа нь шинэ таатай боломжууд бий болгож байна. Тухайлбал, 2003 онд нүүрстөрөгчийн нөхөн төлбөрийн худалдаа 300 сая ам.долларт хүрч, газрыг хураан авсны нөхөн төлбөр олголт нэмэгдэж байна. Амт чанар өөрчлөгдөж байгаа нь чинээлэг орнуудад органик хөдөө аж ахуйн зах зээл өргөжихөд хүргэж байгаа бөгөөд дэлхийн хэмжээнд далайн бүтээгдэхүүний эрэлт их хэвээр байгаа нь байгаль орчинд нийцсэн усан сангийн аж ахуйн томоохон боломж байна гэсэн үг байж болно. Ерөнхийдөө, экосистемийн зах зээлд ороогүй үйлчилгээнүүдийг арилжаанд оруулах явдал бол бага орлоготой ард иргэдэд төдийгүй бизнест ашиг орлого авчирч чадах асар том таатай боломж бөгөөд тогтвортой үйл ажиллагааны нэг хүчирхэг хүчин байж болно.

Дүгнэлт: Ядууст ашигтайгаар үйлчлэх нь

Бага орлоготой хэдэн тэрбум хүмүүст дэлхийн эдийн засагт гар бие оролцож, ашиг тусыг нь хүртэх боломж олгох нь хүний амьдралын нөхцлийг эрс өөрчлөн хувиргаж болох юм.

Энэхүү өөрчлөлт нь хөгжиж байгаа орнуудын ихэнх хөдөө нутагт дутагдаж буй үндсэн бараа, үйлчилгээг хангах, эрчим хүч, харилцаа холбооны болон биет дэд бүтцүүд байгуулах, зээл, даатгал, найдвартай гүйлгээ гэх мэт санхүүгийн үйлчилгээ үзүүлэх, тэр ч байтугай улсын тогтолцоо муу ажилладаг газруудад эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ үзүүлэх гэх мэт асар олон төрлийн бизнесийн таатай боломжууд нээх юм.

Ядуурлыг бууруулах, түүнтэй холбоотой нийгмийн асуудлуудыг шийдэхэд хувийн салбарын гүйцэтгэх үүрэг хамаагүй их гэдгийг харуулах жишээ хэд хэд ажиглагдлаа. Ажлын байр бий болгох, дэд бүтцээр хангах, үйлчилгээ үзүүлэхийг шаардаж байгаа цар хүрээний дэргэд ихэнх хөгжиж байгаа орнуудын иргэний нийгмийн болон засгийн газрын чадавхи багадаж байна. Ур чадвар, технологи, зах зээлийн сахилга батыг удирдах талаар хувийн салбар өөрийн гэсэн онцгой давуу талтай байдаг. Мөн хувийн салбарын хөрөнгө оруулалт хийх санхүүгийн чадавхи нь дээрх орнуудын авч байгаа буюу авч болзошгүй байгаа хөгжлийн тусламжаас хамаагүй илүү байх болно.

Бизнес яагаад хөгжиж буй орнуудын бага орлоготой зах зээлд үйлчлэхийг оролдох ёстой вэ? Яагаад гэвэл эдгээр зах зээл нь ашигтай өсөлтийн нэг хүүсвэр байж чадах бөгөөд үүнийг нотлох бизнесийн тоо өссөөр байна. Уламжлалт ухаан болон хөгжлийн агентлагуудын сайхан ярианы эсрэгээр, бага орлоготой ард иргэд бүхэлдээ маш бодитой бөгөөд өсөн нэмэгдэж буй худалдан авах чадвартай байдаг. Албан бус салбар идэвхтэй, мөнгө гуйвуулгын урсгал асар ихтэй байдаг учраас ядуус албан ёсны статистик дүнгээс хамаагүй бага ядууралтай байдаг.

Эдгээр шинэ зах зээлүүдээс бий болох сорилт, эрсдлүүд нилээд их байна. Шинэ нөхцөл байдалд тохирсон бүтээгдэхүүн, үйлчилгээг сэдэж бий болгох, шинэ бизнесийн загвар, түгээлтийн систем бий болгох, өргөн хүрээтэй зах зээл бий болгож хөгжүүлэх ёстой болно. Харин улсын ба хувийн салбарын аль алиных нь хүртэх үр өгөөж чухал ач холбогдолтой хэмжээнд байна. Бизнес их хэмжээний шинэ зах зээл олж авах бөгөөд хангагдаагүй эрэлт маш их байгаа учраас өсөлтийн хурд өндөр байна. Ийм шилжилт явагдаж байгаа орнууд илүү том, илүү өрсөлдөөнтэй дотоодын зах зээл, илүү их гадаадын шууд хөрөнгө оруулалт, илүү хурдацтай эдийн засгийн өсөлтийн үр шимийг хүртэж болохын зэрэгцээ тогтворгүй байдал үүсгэж байдаг нийгмийн ноцтой асуудлуудыг

багасгах магадлалтай. Уур амьсгалын өөрчлөлт, экосистемийн үйлчилгээний доройтол гэх мэт ядууралд хандах бизнесийн хандлагууд нь ирэх жилүүдэд өрсөлдөөний томоохон хүчин зүйлс болж болох юм гэсэн дүгнэлтээс зугтах аргагүй юм.

Тайлбар

- 1 Зохиогч Дэлхийн Нөөцийн Институтын шинэ санаачлага хариуцсан дэд ерөнхийлөгчөөр ажилладаг.
- 2 Дэлхийн Нөөцийн Институт, 2005а, 2005б.
- 3 Дэлхийн Нөөцийн Институт, 2005б, хуудас 2.
- 4 Дээрхтэй адил.
- 5 Прахалад, 2004, хуудас 1.
- 6 Уэллингтон Сауэрын 2005 оны бүтээлээс авч ашиглав. Онлайн хаяг: <http://capitalmarkets.wri.org>, 2005 оны 7 сарын 15-нд орж үзсэн.
- 7 Дэлхийн нөөцийн институтын дэргэдэх Капиталын зах зээлийн судалгааны баг, түүний түншүүд болох Тогтвортой хөрөнгийн удирдлага байгууллагын Меррилл Линч, Дэлхийн цаг уурын өөрчлөлтийн Пьюгийн төв зэргийн гаргасан тайлангуудаас энэхүү хэсгийг авч ашиглав.
- 8 ЖТҮ- Жинхэнэ /оригинал/ тоног төхөөрөмж үйлдвэрлэгч
- 9 Жинхэнэ, Deutsche Bank AG, 2002, хуудас 14-г үзнэ үү.
- 10 Калафут, 2003.
- 11 Үүнтэй холбогдох материалуудыг Дэлхийн Нөөцийн Институт, 2005а, 2005б-аас авч ашиглав.

Лавлах материалууд

- Deutsche Bank AG /Германы Банк/. 2002. *The Drivers: How to Navigate the Auto Industry /Хөтлөгч хүчнүүд: Автомашины салбарыг хэрхэн хөдөлгөх вэ?/. Frankfurt. 7 дугаар сар.*
- Kalafut, P.C. 2003. *Invisible Advantage: How Intangibles Are Driving Business Performance /Үл үзэгдэх давуу тал: Биет бус хөрөнгүүд бизнесийн үйл ажиллагааг хэрхэн хөтөлж байна вэ?/. Cambridge, MA: Perseus Publishing.*
- Parahalad, C.K. 2004. *The Fortune at the Bottom of the Pyramid. /Пирамидын ёроол дах аз завшаан/. Upper Saddle River, NJ: Wharton School Publishing.*
- Wellington, F. and A. Sauer. 2005. "Framing Climate Risk in Portfolio Management." /Портфелийн удирдлага дахь цаг уурын эрсдлийн хүрээг гаргах нь/. CERES and World Resources Institute. 5 дугаар сар.
- World Economic Forum /Дэлхийн Эдийн Засгийн Форум/. 2005. *The Global Competitiveness Report 2004-2005 /Дэлхий дахиний өрсөлдөх чадварын тайлан 2004-2005/. Hamshire: Palgrave Macmillan.*
- World Resources Institute /Дэлхийн Нөөцийн Институт/. 2005а. *Ecosystems and Human Well-Being Synthesis Report /Экосистемүүд ба хүний сайн сайхан байдлын нэгдмэл тайлан/, Millennium Ecosystems Assessment /Мянганы Экосистемийн Үнэлгээ/. Washington.*
- _____. 2005b. *Ecosystems and Human Well-Being, Opportunities and Challenges for Business and Industry /Экосистемүүд, хүний сайн сайхан байдал, бизнесийн болон үйлдвэрлэлийн салбарын таатай боломжууд ба сорилтууд/, Millennium Ecosystems Assessment /Мянганы Экосистемийн Үнэлгээ/. Washington.*

Тусгай Сэдвүүд

3-р бүлэг

Хөгжлийн асуудлаар зөвшилцөл байх ёстой юу?

ЖОНН УИЛЛИАМСОН,

Олон Улсын Эдийн Засгийн Институтын ахлах судлаач

1989 онд Берлины хана дөнгөж нуран унасны дараахан буюу түүх төгсчих шиг болох үед би нэгэн бага хуралд зориулж танилцуулга бичиж байв. Энэ нь Латин Америкийг 1980-аад оны үеийн алдагдсан арван жилд оруулсан гэж бидний заримынх нь үздэг байсан тэрхүү царцмал эдийн засгийн бодлогоос хэр салж байгааг судлаж шинжлэх зорилготой зүйл байсан юм.

Энэхүү танилцуулга өгүүлэлд би арван зүйлийн бодлого дэвшүүлэн тавьсан бөгөөд тэдгээр нь хэрвээ Латин Америкийн ихэнх орон модернизаци хийх боломжтой л юм бол тэдэнд хэрэгтэй зүйлс гэдэгт Вашингтоны ихэнх хүмүүс, ямар ч атугай, дор хаяхад эдгээр асуудлын талаар бодож байсан хүмүүс, итгэж байсан байх ёстой гэж би үзэж байв. Миний зорилго бол тухайн орны илтгэлийг бичиж буй хүмүүсийн хувьд голлон анхаарвал зохих нийтлэг багц асуултыг гаргаж тавих явдал байлаа.

Гэтэл *Вашингтоны Зөвшилцлийг* дууриалган бичсэн миний тэрхүү жагсаалтыг тус бүс нутагт, түүгээр барахгүй, ерөөсөө хөгжиж байгаа нийт оронд бүхэлд нь, зориулсан бодлогын тунхаг бичиг хэмээн өргөнөөр тайлбарлах болсон юм. Олон орон эдийн засгийн бодлогодоо болон Вашингтоны Зөвшилцлийн чиглэлд мэдэгдэхүйц томоохон өөрчлөлтүүд хийгээд байгаа бөгөөд цаашлаад бусад нэлээд улс үүнтэй төстэй бодлогын өөрчлөлтүүд хийсэн байна гэж тус бага хурал дүгнэсэн. Харин 1990-ээд онд тус бүс нутаг дахь эдийн засгийн өсөлтийн сэргэлт илт тааруу байсан учраас уг бодлогын өөрчлөлтүүд алдаатай байв уу гэж зарим эдийн засагчид асуухад хүрсэн юм.

Магадгүй энэ талаар хамгийн гүн гүнзгий шүүмжилж байсан нь Дэни Родрик (2002, 2003) байсан биз. Тэрээр Вашингтонд төвтэй олон улсын санхүүгийн байгууллагуудын (ОУСБ-ууд) 1989 оны үед дэвшүүлсэн бодлогыг миний тодорхойлж байгаа байдлаар Вашингтоны Зөвшилцөл гэж дүгнэж болохыг хүлээн зөвшөөрсөн байдаг. Гэхдээ түүнээс хойших жилүүдэд эдгээр бодлого цуврал нэмэлт бодлогуудаар баяжсан бөгөөд энэхүү шинээр нэмэгдсэн Вашингтоны Зөвшилцөл нь мэдээж анхны эх хувийнхаа нэг адил урам хугалах болно гэж тэр үзжээ. Учир нь, хөгжилд хэрэгтэй зүйл бол хоолны жорын ном биш, хөгжилтэй орнууд ямар байдаг тухай дүрслэл ч биш, харин өсөлтөд түлхэц өгөх стратеги, улмаар аливаа орон тасралтгүй өсч хөгжихөд

чиглэсэн институцийн цуврал шинэчлэлүүд байх ёстой гэжээ.

Миний хувьд Родрикийн шүүмжлэлтэй тодорхой хэмжээнд санал нийлж байна. Би түүнийг бодвол угаах юмны жагсаалт, хоолны жорын номын талаар нэг их санаа зовоогүй бөгөөд хэрвээ бид өсөлт бол зүгээр л ямар нэг дүрэм журмын жагсаалтыг ёсчлон дагах тухай асуудал гэсэн сэтгэгдэл төрүүлэх юм бол үүгээрээ хөгжиж байгаа орнуудад туслан байна гэж би үзэхгүй. Бодлого боловсруулагчид бодож сэтгэхийн төлөө томилогдсноос биш зааврын дагуу ажиллах гэж томилогдоогүйгээ мэддэг байх хэрэгтэй. Тэгэхдээ, хэрвээ бид хөгжиж байгаа орнууд ер нь ямар ямар бодлого баримтлах ёстой талаар эхэлж ярилцаагүй, түүний дараа иймэрхүү ерөнхийлөл хийх боломжтой гэж үзээгүй байсан бол бид хөгжиж байгаа орнуудыг унагаах байсан гэж би боддог. Ийм учраас миний бие зарим хамтран зүтгэгчдийнхээ хамтаар нэгэн ном бичсэн нь (Кучински, Уиллиамсон нар, 2003) зарим талаар Вашингтоны Зөвшилцлийн үргэлжлэл болж байна. Энэ бол миний энэхүү өгүүлэлээрээ дамжуулан илэрхийлэхийг оролдож буй гол санаа юм.

Хэрвээ бид Вашингтоны Зөвшилцөлд дэвшүүлсэн бодлого хүсүүштэй эсэхийг үнэлж үзье гэвэл эхлээд эдгээр бодлого ямар байж болохыг тогтоохоос эхлэх ёстой. Уг нэр томъёонд дор хаяж гурван өөр тайлбар өгөөд байгаа учраас ингэх зайлшгүй шаардлагатай. Ашиглаж буй нэр томъёоныхоо учир утгыг зааж өгөлгүйгээр хоёрдмол утгатай нэр томъёо хэрэглэх нь мэтгэлцээний ойлгомжтой байдлыг алдагдуулдаг. Одоогоор Вашингтоны Зөвшилцлийн нэг хэсэг хэмээн давхар тодорхойлоод байгаа зарим нэг үзэл санааг хамгаалах хүсэл надад байхгүй боловч миний хувьд уг зөвшилцлийн өөрийн хувилбарт агуулагдаж буй гурван үндсэн үзэл санаа, тухайлбал макро эдийн засгийн сахилга бат, зах зээлийн либеральчлал, даяаршил гурвын ач холбогдолд итгэж үнэмшсэн хэвээр байна. Эдгээр үзэл санаа ямар нэг зөвшилцлийг удирдан чиглүүлээсэй гэж би хүссээр байгаа боловч сүүлийн үед би ингэх эсэхэд нь эргэлзэж эхлээд байна. Тэдгээрийг хэрэгтэй гэж хэлэх нь нь иж бүрэн хэлэлцэх асуудал мөн гэж үзэж байгаа хэрэг биш нь мэдээж бөгөөд тэдгээр энэхүү өгүүлэлд илүү иж бүрэн хөтөлбөр болгоход чиглэсэн элементүүдийг оруулж байна.

Вашингтоны Зөвшилцлийн үтгэ санаа

Би энэ нэр томъёог хэрэглэхдээ дараахь арван шинэчлэлд хамаатуулан нэрлэсэн юм:

1. **Төсвийн сахилга бат:** бараг бүх улс нь их хэмжээний төсвийн алдагдалтай ажиллаж, улмаар төлбөрийн тэнцлийн хямрал, өндөр инфляцид ороход хүрч байсан бүс нутагт ядуу буурай нь хамгийн их хохирч зовсон байхад, баячууд нь гадаадад мөнгөө байршуулах зэргээр мөнгө хөрөнгөө хамгаалж чадсан байдаг.
2. **Улсын зардлын тэргүүлэх чиглэлүүдийг шинэчлэн журамлах:** энэ нь эрүүл мэнд, боловсролын суурь үйлчилгээ, дэд бүтцэд оруулж буй ашиггүй татаасуудаасаа салж өсөлтийг урамшуулж, ядуусыг хамгаалахад чиглэсэн зардлуудад шилжинэ гэсэн үг. Энд дан ганц төсвийн зарцуулалтыг багасгах замаар төсвийн сахилга батын сорилтуудыг даван туулах ёстой гэсэн санааг дэвшүүлсэнгүй. Харин ч үүний эсрэгээр буюу улсын салбарын хүсүүштэй хэмжээний зардлын талаар маш их төвийг сахисан байр суурьтай байх санаа юм. Учир нь, над шиг горьдлого тасарсан зөвшилцөл хайгч этгээд хүртэл капитализм, социализм хоёрын хоорондох түүхэн тэмцлийн шийдэл бол цаад утгаараа төрийн нэн зохистой хэмжээний талаарх тохиролцоо байсан гэдгийг төсөөлөөгүй явсан ажээ.
3. **Татварын шинэчлэл:** үүний зорилго бол өргөн хүрээтэй татварын бааз суурийг дунд зэргийн зөрүүтэй шатлалтай татварын хувьтай хослуулах явдал байв.
4. **Хүүгийн хувийн либеральчлал:** энэ санааг хожим нь би дахин боловсруулж илүү өргөн хүрээтэй санхүүгийн либеральчлал болгон өөрчилсөн бөгөөд үүнийг хэрхэн хурдан хийж гүйцэтгэх талаарх үзэл бодлууд зөрөөтэй байгааг онцолсон. Санхүүгийн либеральчлалыг нарийн хяналттай хийх ёстой гэдгийг онцлон тэмдэглэхийн ач холбогдлыг би анхнаасаа мэдэж байсан ч болоосой, мөн капиталын бүх хяналтыг алга болгох биш, зөвхөн дотоодын санхүүгийн либеральчлал хийгдэнэ гэдгийг тодорхой болгож өгдөг байж гэж би бодож байна.
5. **Валютын өрсөлдөөнт ханш¹:** ямар нэг завсрын журмын тухай санааг их, бага хэмжээгээр агуулж валютын өрсөлдөөнт ханштай байхад чиглэсэн

- зөвшилцөл байна гэж үзэж байх үедээ би мөрөөдөмтгий сэтгэлгээнд хэт автсан байжээ гэж айж байна. Үнэн хэрэгтээ, аливаа улс нэг бол валютын ханшаа хатуу уяж тогтоох аль эсвэл «цэвэрхэн» хөвүүлэх ёстой гэсэн хоёр салаа номлол руу Вашингтон аль хэдийн хазайж эхлээд байлаа.
6. **Худалдааны либеральчлал:** худалдааг хэр хурдан либеральчлах вэ гэдэг талаар янз бүрийн үзэл бодол байсан ч, бүгд л энэ бол зайлшгүй дагах ёстой зөв чиглэл гэдэгтэй санал нэг байсныг би бататгасан юм.
 7. **Дотогш чиглэсэн гадаадын шууд хөрөнгө оруулалтын либеральчлал:** капиталын дансны өргөн хүрээтэй либеральчлалын асуудал бүтэх буюу энэ тухайд Вашингтон зөвшилцөлд нөлөөлнө гэдэгт итгэхгүй байсан учраас би энэ асуудлыг зориуд хассан байв.
 8. **Өмч хувьчлал:** өмч хувьчлал хэрхэн явагдаж байгаагаас асуудал ихээхэн хамаарна гэдгийг түүнээс хойш бид сайн мэддэг болоод байна: энэ нь хөрөнгийг өөрийнх нь бодит үнэ цэнийн өчүүхэн хэсгээр эрх ямбатай дээдчүүлд өгөхөд хүргэсэн маш их ялзарсан үйл явц байж болох талтай. Харин өмч хувьчлалыг зөв зохистой явуулж чадвал, ялангуяа, үр ашгийг дээшлүүлэх, ахуйн үйлчилгээний хамрах хүрээ сайжрах утгаараа болон хэрвээ хувьчлагдсан үйлдвэрийн газрууд нэг бол өрсөлдөөнт зах зээлд борлуулт хийж байгаа эсвэл тэгэх боломжгүй боловч зохих ёсоор зохицуулалтанд орж байгаа тохиолдолд, үр өгөөжөө өгч чаддаг нь тодорхой байна.
 9. **Зохицуулалтыг задлах:** энд аюулгүй байдлыг хангах, байгаль орчныг хамгаалах, эсвэл өрсөлдөөнт бус салбарын үнийг зохицуулахад зориулсан зохицуулалтуудыг арилгахад бус, харин орж, гарахад учирч буй саад бэрхшээлүүдийг арилгаж хялбар дөхөм болгоход онцгой анхаарал хандуулсан билээ.
 10. **Өмчлөлийн эрхүүд:** энэ санаа нь Хернандо де Сотогийн шинжилгээнээс төрөн гарсан бөгөөд албан бус салбарын өмчлөлийн эрхийг боломжит зардлын түвшинд хангахад голлон анхаарсан болно.

Вашингтоны Зөвшилцөл гэдэг хэллэгийг ашиглахад өргөнөөр хэрэглэгддэг утга санааны нэг хувилбар нь Бреттон Вүүдсийн институциуд өөрийн үйлчлүүлэгч орнуудад хэрэглэдэг бодлоготой эсвэл магадгүй Бреттон Вүүдсийн институциуд ба АНУ-ын засгийн газрын хамтарсан хандлагатай холбоотой байдаг². Энэ нь үндэслэлтэй бөгөөд сайн тодорхойлогдсон хэрэглээ мэт надад санагддаг бөгөөд Дэни Родрикүүнийг тодорхой тайлбарлахыг хичээсэн байдаг (Хүснэгт 1-г үзнэ үү). 1989 оноос хойш эхэн үедээ миний үзэл баримтлал энэ хоёрын хооронд нэг их ялгаа байхгүй байсан боловч яваандаа зарим бодитой ялгаа гарч ирсэн юм. Жишээлбэл, валютын ханшны бодлогын хувьд Бреттон Вүүдсийн институциуд хоёр *туйлт номлол* гэгчийг, наанадаж л Аргентины эдийн засаг 2001 онд нуран унах хүртэл, улам бүр дэмжсээр ирсэн бөгөөд энэ нь бараг хямралгүй гэж үзэж болох дэглэмүүдийн нэгийг авч хэрэглэсний шууд үр дүн байлаа. Уг дэглэмийн дагуу, улс орнууд нэг бол валютын ханшаа «цэвэрхэн» хөвүүлэх, аль эсвэл валютын зөвлөл гэх мэт институцийн шинжтэй арга хэрэглэж ханшаа тогтмол барих ёстой байв. Дээр цохон тэмдэглэсэнчлэн, тогтмол буюу хөвөгч ханш нь бодит ханшнаас өндөр үнэлэгдэхдээ амархан учраас энэ нь Вашингтоны Зөвшилцлийн тухай миний хувилбар буюу *валютын өрсөлдөөнт хани* хэмээн нэрлэсэн ямар нэг дундаж дэглэмийн шууд эсрэгээр үйлчилж байна.

Дахин хэлэхэд, 1990-ээд оны дундуур Бреттон Вүүдсийн институциуд, түүний дотор ямар ч байсан ОУВС-ынхан, улс орнуудыг капиталын дансаа либеральчлахыг яаруулж байсан бол миний хувилбараар энэхүү капиталын урсгалыг либеральчлах уриалгыг зориуд ГШХО-оор хязгаарлаж байв. Миний бодлоор, анхны хувилбараас хазайсан энэ хоёр хазайлт хоёулаа сөрөг үр дагавартай байсан бөгөөд хоёр дахь нь 1997 оны Азийн хямралын гол шалтгааны нэг болсон юм.

Гэтэл энд бас зарим маш их нааштай үр нөлөө бүхий ялгаанууд байгаагийн дотор миний 1989 онд Латин Америкт тийм ч чухал биш гэж үзээд оруулаагүй институцийн чанартай тодорхой асуудлуудыг Дэлхийн Банк, ОУВС оруулан авч үзэж эхэлсэн явдал юм. Би энд засаглал ба авилгалын асуудал (Дэлхийн Банкны жишээнд), стандарт хийгээд дүрмүүдэд туссан санхүүгийн салбарын шинэчлэлийн асуудал (ОУВС-ын жишээнд) хоёрыг хэлж байна. 1990-ээд оны сүүл гэхэд энэ хоёр байгууллага хоёулаа орлогын хуваарилалтын

Хүснэгт 1: Родрикийн нэмж баяжуулсан Вашингтоны Зөвшилцөл

Вашингтоны Зөвшилцлийн анхны эх	Нэмж баяжуулсан Вашингтоны Зөвшилцөл
<ul style="list-style-type: none"> • Төсвийн сахилга бат • Улсын зардлын шинэчилсэн журамлал • Татварын шинэчлэл • Санхүүгийн либеральчлал • Валютын нэгтгэсэн өрсөлдөөнт ханш • Худалдааны либеральчлал • ГШХО-тад нээлттэй байдал • Өмч хувьчлал • Зохицуулалтын задлалт /deregulation/ • Өмчлөлийн эрхийн хамгаалалт 	<p>Анхны жагсаалт дээр нэмээд:</p> <ul style="list-style-type: none"> • Эрх зүй/ улс төрийн шинэчлэл • Зохицуулах институциуд • Авилгалын эсрэг ажиллагаа • Хөдөлмөрийн зах зээлийн уян хатан байдал • ДХБ-ын гэрээ хэлэлцээрүүд • Санхүүгийн дүрэм, стандартууд • Капиталын дансны «хянамгай» нээлт • Дундаж бус валютын ханшны журам • Нийгмийн хамгааллын сүлжээ • Ядуурлын бууралт

Эх сурвалж: Родрик, 2005

талаарх өмнө нь зөрөөтэй байсан байр сууриа өөрчилж, уг хуваарилалт нь хэн орлого олж, хэн алдаж байгаад ихээхэн нөлөөтэй гэдгийг хүлээн зөвшөөрсөн юм.

Вашингтоны Зөвшилцөл хэмээх нэр томъёоны гурав дахь тайлбар нь түүнийг неолиберализм буюу зах зээлийн фундаментализм үзэлтэй ижил утгаар хэрэглэх явдал юм³. Ингэж үзэх нь миний анх гаргасан санаанаас хамаагүй хол зөрсөн бөгөөд анхны утга санааг маш зохисгүйгээр гажуудуулсан хэрэг юм. Вашингтоны Зөвшилцөл гэдэг нэр томъёо ямар ч утгатай байсан бай, Вашингтоны зарим тодорхой сегментэд, тухайлбал, АНУ-ын засгийн газар ч юм уу, ОУСБ-ууд ч юмуу, эсвэл хоёулаа ч юм уу, аль эсвэл магадгүй хоёулаа бусад бүлгүүдтэй хамтраад ч юм уу, ямар нэг зөвшилцөлд хүргэсэн эсвэл хүрсэн багц бодлогод хамаарах ёстой нь мэдээж. Рейганы засаг захиргааны эхний жилүүд эсвэл Жорж Бушийн засаг захиргааны үед ч гэсэн нийлүүлэлтийн талын эдийн засаг, мөнгөний бодлого, төрийн оролцоог хамгийн бага болгох гэх мэт өвөрмөц неолибераль бодлогын аль нь ч ямар нэг зөвшилцөл бий болгосон гэж үзэхэд хэцүү бөгөөд ОУСБ-уудын хүрээнд ч ийм зөвшилцөл байгаагүй. Мөн эдгээр бодлогын аль нэгийг Клинтон засаг захиргаатай холбох нь зохисгүй юм. Харин Вашингтоны Зөвшилцөлийн эсрэг хамгийн хурц шүүмжлэлүүд энэхүү гурав дахь ойлголтын эсрэг байсан бөгөөд энэ байдлаар уг нэр томъёог хэрэглэж байсан хүмүүсийн хувьд үнэн хэрэгтээ тэдний өөрсдийн үзэн ядах дуртай бодлогуудыг дэмжсэн зөвшилцөл бий болгох шаардлагатай эсэх талаар бодож үзээгүй нь илэрхий байна⁴.

Тэгвэл энэ нэр томъёо яагаад ийм олон янзаар тайлбарлагдахад хүрэх болов оо? Миний хувьд хоёр дахь хэрэглээ яагаад би болсон бэ гэдгийг олж харахад хангалттай хялбар байна. Уг нэр томъёо анхнаасаа Бреттон Вүүдсийн институциудийн бодлого гэж үзэх үндэслэлтэй дүрслэл болсон бөгөөд уг жагсаалт нь тэдний номлож буй зүйлсийн мөн чанарыг харуулах нэг оролдлого болж бүтсэн байна. Ингээд эдгээр бодлого хувьсан хөгжихийн хэрээр уг нэр томъёо тухайн үед яг юуг илэрхийлж байснаа үргэлжлүүлэн хамаарах болсон байна.

Харин гурав дахь хэрэглээ яаж ийм түгээмэл болсон нь миний хувьд оньсого болж байна. Нэг байж болох таамаглал бол, хэрэгцээгүй болсон хэмээн мартвал зохих хэсэг үзэл санааг миний жагсаалтад орсон шинэчлэлийн төлөө хар ухаанаар бодож гаргасан бодлоготой нэгтгэн зангидах замаар эдийн засгийн шинэчлэлийг үгүйсгэх гэсэн оролдлого байсан байж болно. Мөн миний энэхүү жагсаалтдаа өгсөн нэр АНУ-ын засгийн газар эсвэл ОУСБ-уудын бодлого, хандлагад дургүй хэн нэгэнд тэдгээртэй холбоотой бодлогыг гуйвуулах сонирхол төрүүлсэн байж болно гэдэгт эргэлзэх зүйлгүй. Гэтэл бас нэг таамаглалын шинжтэй хувилбар бол, ОУСБ-ууд буюу ядаж ОУВС (магадгүй АНУ-ын Төрийн сан ч бас) зах зээлийн фундаментализм ба төрийн оролцоог хамгийн бага байлгах үзлийг хөхиүлэн дэмждэг гэдэгт зарим хүмүүс үнэн голоосоо итгэсэн байдаг. Штиглиц (2002) хүртэл үүнд итгэдэг юм шиг бичсэн байдаг бөгөөд ингэснээрээ хоёр дахь ба гурав дахь тайлбарт ижил утгатай мэт хандсан байдаг. Би хувьдаа үүнийг учир утгагүй зүйл гэж үзэж байгаагаа хэлэх ёстой: ОУВС-ын байр суурь миний үзэл бодлоос ч хуучинсаг

болохыг бий олонтаа олж харж байсан боловч энэ байгууллагын бодлогын байр суурь зах зээл төгс ажилладаг хэмээх бодит байдлаас хол зөрсөн хийсвэр үзэлд тулгуурладаг гэж би огт бодож байсангүй. Зөвхөн онолч эрдэмтэд л, гэхдээ тийм ч олон хүн биш, ийм зүйлд итгэдэг байх. Үүнийг ямар нэг зүйл иш таталгүйгээр илэрхийлэх цэвэр нотолгоо бол ОУВС зах зээлийн фундаменталист үзэлд итгэж биширдэг гэсэн Штиглицийн үзэл бодол юм.

Авч хэрэглэвэл зохих гурван том үзэл санаа

Миний үзэж байгаагаар, Вашингтоны Зөвшилцлийн миний хувилбарын цаана агуулагдаж байгаа гурван том түүхэн өөрчлөлт бол макро эдийн засгийн сахилга батыг чанд баримтлах, нөөцийг хуваарилах нийгмийн үндсэн арга хэрэгсэл бол зах зээлийн сонголт байх, эдийн засгийг худалдаа, ГШХО-тад нээлттэй болгох (одоо ихэвчлэн даяаршил гэж нэрлэх болсон) явдал юм. Эдгээр гурван чиглэлд Латин Америк, мөн зарим талаар хөгжиж байгаа бусад олон орон 1980-аад оны сүүл, 1990-ээд оны эхээр бодлогын үндсэн өөрчлөлтүүд хийсэн билээ.

Тогтворжуулалтын бодлого

Эдгээр чиглэлийн эхнийх нь тогтворжуулалтын бодлоготой холбоотой. Дайны дараахь эхний жилүүдэд Латин Америкийн олон эдийн засагч хуримтлалыг хүчээр бий болгож, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж болох утгаараа инфляци хүсүүштэй байж болохыг хүлээн зөвшөөрсөн байдаг. Тэр ч байтугай инфляцийг таатайгаар хүлээн авахаас татгалзаж байсан эдийн засагчид хүртэл, ямартай ч бүтцийн хүчин зүйлсээс болж инфляци үүсч байгаа учраас их, бага ямар нэгэн хэмжээгээр түүнээс зайлсхийх аргагүй гэж үзэж байв. Бүтцийн инфляцийн шавь сургуулийн монетарист шүүмжлэгчдийн урьдчилан таамаглаж байсанчлан инфляци хурдсаж, мөн төсвийн алдагдлын нэг хэсгийг гаднаас санхүүжүүлж байснаас болж өрийн хямрал үүссэнээр 1980-аад онд энэ бүх зүйл өөрчлөгдсөн юм. Өрийн хямралын хариуд төлбөрийн тэнцэлд тохируулга хийх холбоотон хоорондын хүчин чармайлтын дүнд бодит ханш буурсан нь инфляцийг улам дордуулахад хүргэсэн. Намайг Вашингтоны Зөвшилцлийг боловсруулж байх үед хамгийн гол шаардлага бол наанадаж л Латин Америкт инфляцийг тогтоон барих явдал байсан учраас үүнийг би

макро эдийн засгийн зорилт болгон цохон тэмдэглэж байлаа. Заримдаа намайг шоолж байсан шиг, миний жагсаалт хэзээ ч хамаагүй, хаана ч хамаагүй хэрэглэж болох бодлогын тунхаг бичиг байх байсан тохиолдолд, би энэ байдлаар судлах зүйлээ хязгаарласан бол харамсалтай алдаа болох байлаа. Эргэлтийн мөчлөгийн эсрэг бодлого шаардлагатай болох олон нөхцөл байдал байдаг. Капиталын дансны хямралын эрсдлийг багасгах талаар ч засгийн газрын хийж чадах олон зүйл бий. 1990-ээд онд Латин Америкийн олон засгийн газар ийм бодлого баримталж чадаагүй нь 1994 онд уг хямралт байдал тэсэрч эхлэн улмаар дараагийн хагас арван жилийн турш харанхуй бүүдгэр байсны шууд шалтгаан байлаа. Тус бүс нутагт зориулсан хөгжлийн хэлэлцэх асуудлуудын шинэчилсэн хувилбарыг гаргах зорилгоор Педро Пабло Кучински бид хоёр нэгэн ном бичсэн (2003) бөгөөд үүндээ эдийн засгийг хөл дээр нь зогсоохын тулд илүү идэвхтэй бодлого баримтлах шаардлагатай байгааг зүй ёсоор цохон тэмдэглэсэн. Гэвч ирэх жилүүдэд бодлогын хариулт өгөхийг шаардаж буй бүх нөхцөл байдлыг урьдаас төсөөлж чадна гэвэл санасны гарз байдаг. Дэлхий ертөнц бол нарийн түвэгтэй бөгөөд бодлого боловсруулагчид зөвхөн бодлогын жорын номноос томъёо авч хэрэглэх бус, тасралтгүй бодож сэтгэж байх шаардлагатай болно.

Үүгээрээ би 1980-аад оны сүүлээр макро эдийн засгийн чанд хатуу бодлого баримтлах шийдвэр гаргасан нь тус бүс нутгийн эдийн засгийн сэтгэлгээнд нэг чухал эргэлт болсон гэсэн үзлийг огт үгүйсгэх гээгүй юм. Мөн энэ нь ирээдүйн макро эдийн засгийн бодлогыг боловсруулахтай холбоотой онцын маргаантай асуудал байхгүй болно гэсэн ч үг биш. Өнөөгийн нэг жишээ бол Бразилийн хүүгийн бодлогын асуудал байна. 2004 оны сүүл хэсэг, 2005 оны эхний саруудын турш инфляцийн өсөлтийг зогсоохын тулд Бразилийн хүүгийн хувь аль хэдийн өндөр түвшинд хүрээд байсан 15.75 хувиасаа (бодит хэмжээгээр 9 орчим хувь) гэнэт 19.5 хувь болон өсч байв. Энэ бол эдийн засгийн өсөлтийг зориуд боомилж, бүтээлч ангийг (шинээр бизнес эрхлэгчид ба ажилчид) золиослон баян чинээлэг хүмүүсийн ашиг хонжоог бодсон неолибераль үзлийн нэг жишээ хэмээн энэ бодлогыг буруушаах хүмүүс гарна гэдэгт эргэлзэх зүйлгүй. Түүнчлэн, төв банкны зүгээс хэрвээ инфляцийн хөөрөгдөлийг үг дуугүй дагах юм бол банкинд итгэх итгэл алдагдаж болзошгүй гэж үзэн инфляцийг хянах

бодлогоо зөвтгөж байгаагийн илрэл гэж үзэх боломжтой. Мөн яг ингэж итгэл төрүүлэхийн тулд дараа нь хүүгийн хувийг ихээр бууруулж хамгийн их итгэл найдвар төрүүлэхүйц нөхцөл байдал үүсгэдэг гэж үзэж ч болно.

Либеральчлал

1980-аад оны үед Латин Америкт тохиолдож, Вашингтоны Зөвшилцөлд тусгагдсан хоёр дахь түүхэн хөгжил бол зах зээлийг нөөцийн хуваариалтын нийгмийн үндсэн механизм болгон ашиглах шийдвэр байв. Мэдээжийн хэрэг, тус бүс нутаг Зөвлөлтийн загварт тулгуурласан төвлөрсөн төлөвлөгөөт тогтолцоог дагнан хэрэгжүүлж байсан удаагүй. Гэсэн хэдий ч, тэдний хандах хандлагад хоёрдмол утгатай тодорхойгүй байдлын элемент агуулагдаж байсныг Жозе Антонио Окампогийн «төрөөр удирдуулсан хөгжил» гэсэн хэллэгээр сайтар дүрсэлсэн байдаг. Энд үйлдвэрлэлийн олон салбарууд хувийн өмчид байхын зэрэгцээ төрөөс импортыг орлох үйлдвэрлэлийг дэмжин хамгаалдаг, тааламжтай хандсан салбарууддаа зээл олгодог, төрөөс зайлшгүй шаардлагатай гэж үзсэн боловч хувийн бизнес эрхлэгчид шинээр орж ирэхгүй байгаа салбарт улсын үйлдвэрийн газрууд байгуулдаг, мөн улсын төлөвлөгөөнд ороогүй чиглэлд хувийн компаниуд байгуулахад зориуд хэцүү болгодог байв.

Энэ нь Латин Америкийн орнуудын уламжлалт экспортод чиглэсэн, хөдөө аж ахуй давамгайлсан эдийн засгаас салж аж үйлдвэржилтэд шилжих санаачилгын хувьд тийм ч муу систем байсангүй. Энэ систем тогтсоноор тус бүс нутагт, Аргентинаас бусдад нь, урьд хожид байгаагүй буюу 1950-1980 онд гараагүй хөгжил дэвшил гарсан юм. Тэгвэл энэ систем нь тухайн үед түүний элементүүдийг 1950-иад оны үеэр Латин Америк ба Карибын Эдийн Засгийн Комиссоос (ЛАКЭЗК) санаачлан гаргах үед хийсэн асар том түүхэн алдаа байв уу гэж асуухаасаа илүү энэ систем 1980-аад оны сүүлээр нийгэмд өгөх ашиг тусаа алдсан эсэх талаар асуух нь зүйтэй юм. Энэ үед импортыг орлуулах эхний «хялбар шат»-анд хүрснээс хойш нилээд удаад байлаа. Санхүүгийн системийн боловсронгуй байдлын хувьд дээрээс шууд олгодог зорилтот зээллэг нь өрсөлдөөнт банкны системээр олгож буй зээлээс үр ашиг багатай байх хэмжээнд хүртэл хөгжөөд байв. Зарим нэг үр ашигтай ажилладаг улсын компаниуд байсаар байсан боловч

тэдний олонх нь өрсөлдөөнт бус орчинд байдаг хялбар амьдралын толгой эргэм таатай нөхцөлд умбан бялуурч байлаа. Шинэ салбарт орох асуудал бүтэшгүй хүнд байв. Иймээс, өрийн хямрал эхэлж өсөлт унах үед аж үйлдвэржилт төлөвшсөн эдийн засагт амжилттай шилжээд байсан эдгээр орны хувьд илүү өрсөлдөх чадвартай системд шилжин орох нь жам ёсны үйл явц мэт санагдаж байв.

Миний бие ийнхүү зах зээлийн эдийн засагт эргэлт буцалтгүй шилжих шийдвэрийн таван асуудлыг Вашингтоны Зөвшилцөлд хүлээн зөвшөөрсөн нь санхүүгийн либеральчлал, худалдааны либеральчлал (дараагийн хэсэгт авч үзэх), өмч хувьчлал, зохицуулалтыг задлах, өмчлөлийн эрхүүд байв. Шүүмжлэгчдийн неолиберализм хэмээн даапаалдаг эдгээр шинэчлэлийг хийх явдлыг зарим нэг маань зүгээр л либеральчлал гэж нэрлэх байсан биз. Эдгээр нь төрийн эдийн засагт гүйцэтгэх үүргийг халах санаа агуулаагүйг ойлгох нь чухал: төрийн үүргийг орлуулна гэхээс илүү түүнийг зах зээлийг дэмждэг болгон өөрчлөнө гэсэн үг юм.

Магадгүй үүний хамгийн сайн жишээ бол санхүүгийн либеральчлал юм. Санхүүгийн либеральчлалын тухай бичсэн нэгэн судалгаандаа Молли Махар бид хоёр зургаан асуудлыг онцлон гаргаж тавьсан⁵:

1. Хэнд зээл олгохыг засгийн газар бус хувийн зээлдүүлэгчид тодорхойлдог болгох
2. Хүүгийн түвшний хяналтыг байхгүй болгох
3. Санхүүгийн салбарт ороход учирдаг саад бэршээлүүдийг арилгах
4. Хэнийг, ямар цалинтайгаар хөлслөх вэ гэх мэт арилжааны шийдвэрүүд дэх засгийн газрын хяналтыг байхгүй болгох
5. Санхүүгийн пүүс компаниудыг хувьчлах
6. Гадаад валютын зах зээл дэх хөрөнгийн хяналтыг арилгах

Вашингтоны Зөвшилцлийн тухай анхны тодорхойлолтдоо миний бие эдгээр асуудлын зөвхөн хоёрдугаар асуудалд голлон анхаарч байсан бөгөөд удалгүй алдаа гаргаснаа ойлгосон юм. Иймээс би энэ асуудлыг өргөтгөж, уг зорилтыг «санхүүгийн либеральчлал» хэмээн тодорхойлохдоо зөвхөн дотоодын либеральчлалын тухай бодоод, харин капиталын дансны либеральчлалыг оруулаагүй гэдгээ хэлэхээ мартсан байв. Энэ нь ч бас алдаа

болсон бөгөөд миний бодлоор капиталын дансны либеральчлал бол шал өөр ойлголт төдийгүй хамаагүй илүү аюултай зүйл байв.

Гэвч үндсэн үзэл санаа маань өөр юм. Засгийн газар хэнд, ямар үнээр зээл өгөхийг шийдэхээ больж, эдгээр шийдвэрийг хэн нэг нь, тухайлбал ямар нэг хувийн банк гаргадаг болгож байгаа үед банкууд найз нөхөддөө эсвэл хамгийн их хээл хахууль өгсөн хүнд зээл өгөх бус, харин эрсдэл, үр өгөөжийн харьцаа хамгийн сайтай төсөлд зээл олгохыг хичээдэг болоход чиглэсэн хангалттай хяналтын механизм бүрдүүлсэн байх ёстой. Өөрөөр хэлбэл, санхүүгийн либеральчлал хийснээр засгийн газар санхүүгийн салбарт ямар нэг үүрэг гүйцэтгэхээ больж байна гэсэн үг биш, харин өөр үүрэг гүйцэтгэх ёстой гэсэн үг. Тухайлбал, хэнд зээл олгохыг шийддэг газар байхын оронд тодорхой дүрэм, практик мөрдөгдөж байх нөхцлийг хангахыг хичээдэг байх ёстой.

Санхүүгийн либеральчлалын тухай санаа анх 1973 онд төрөн гарснаас хойш Латин Америкт төдийгүй дэлхийн хөгжиж буй ертөнцийн бусад хэсгүүдэд ч урт удаан хугацааг туулж ирээд байна. Тус бүс нутгийн ихэнх орнууд өнөөдөр идэвхтэй санхүүгийн зах зээл, арилжааны банкууд болон улсын банкуудын үлдэгдэл нийлсэн холимог системтэй байна. Үүний дагуу санхүүгийн либеральчлалын үр нөлөөний талаар хийгдсэн олон тооны судалгаа гурван үндсэн дүгнэлтэд хүрээд байна⁶:

1. Санхүүгийн системээр зуучлан дамжуулж байгаа хадгаламжийн хувь өсөх хандлагатай байдаг боловч энэ нь хуримтлалын түвшинд ямар нэг мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэггүй.
2. Энэ нь тухайн системийг хямралд илүү өртөмтгий болгодог аюултай.
3. Энэ нь хуримтлалыг нилээд сайн хуваарилахад хүргэдэг нь хөрөнгө оруулалтын бүтээмжийг нэмэгдүүлж, нэмэлт капиталын гарцын харьцааг бууруулдаг.

Эндээс үзэхэд либеральчлал нь хямралын аюул ихэссэн байдал ба хямралыг зайлуулснаар нэмэгдэх өсөлтийн боломж хоёрын оновчтой харьцааг олох явдал болж байна. Иймээс бодлогын хувьд хяналтыг сайжруулах болон хямрал гарах магадлалыг багасгах бусад арга хэмжээнд илүү их анхаарал тавих ёстой нь мэдээж байна. Вашингтоны Зөвшилцлийг эхэлж тодорхойлохдоо энэ хэрэгцээ

шаардлагыг онцлон тэмдэглээгүйдээ би зарим талаар үнэхээр гэмшиж байна. Гэхдээ өөрийгөө хамгаалахын тулд би эдийн засгийн бодлогын жорын ном гаргая гэж бодоогүй гэдгээ энд хэлэх ёстой.

Миний капиталын дансны либеральчлалд эргэлзэж байсан шалтгаан бол энэ нь хямралын аюулыг нэмэгдүүлдэг бөгөөд хариуд нь өсөлтийн хурдацын хувьд хамгийн бага тоо, магадгүй тэг, гарч болзошгүй явдал байв. Их хэмжээгээр зээл авдаг орнууд гэнэтийн зогсолтод өртөмтгий байх, ялангуяа гадаад валютаар нэрлэгдсэн богино хугацаат зээл авдаг бол улам өртөмтгий байх нь тодорхой. Хуримтлалаас хэтэрсэн дотоодын хөрөнгө оруулалтын үр өгөөж үнэхээр бодитой байх юм бол аливаа улс гадаадаас зээл авахад капиталын хяналт саад болж чадахгүй. Мөн капиталын чөлөөт урсгалтай үед өсөлт илүү хурдан байдгийг нотлох ямар ч үнэмшилтэй нотолгоо туршилтын судалгаануудаас гараагүй байна. (Дотогш чиглэсэн ГШХО, үнэт цаасны портфелийн хөрөнгө оруулалт хоёр өсөлтийг нэмэгдүүлдэг гэсэн нотолгоо байдаг ч, богино хугацаат зээлийн орж, гарах чөлөөт урсгал гэх мэт бүрэн нээлттэй байдал өсөлтийг хурдасгадаг гэсэн нотолгоо байдаггүй.) Эцэст нь аливаа эдийн засаг дэлхийн эдийн засагтай нэгдэн нягтрах үед капиталын хяналт үргэлжлүүлэн тавьсаар байх нь үр нөлөөгүй болох цаг ирэх бөгөөд тэр цагт ямар нэг эдийн засаг хүнд хэцүү үеүдэд ч гаднаас зээл авах боломжтой (шинээр төрөн гарсан эдийн засагтай орнуудын хувьд өнөөдөр тийм биш байгаа) болох төдийгүй ийм гэнэтийн зогсолтууд түүх болон хоцрох болно. Тэр цаг ирмэгц капиталын дансаа либеральчлах нь ухаалаг хэрэг байх болно. Харин энэ үйл явцыг хэт яаравчлах нь аюултай байж болох юм.

Магадгүй өмч хувьчлал бол санхүүгийн либеральчлалаас бүр илүү маргаантай зөвлөмж байж болох юм. Үнэхээр энэ нь Латинбарометрийн олж тогтоосон шиг Латин Америкт тун нэр хүнд муутай байдаг онцлогтой бодлого юм. Түүний үр нөлөө бүхэлдээ нилээд зөөлөн байдаг нь ихэнх судалгаагаар харагдаад байхад яагаад ийм нэр хүнд муутай байдгийг эдийн засагчид өөрсдөөсөө асуудаг. Жишээлбэл, туршилтын судалгаагаар ихэвчлэн өмч хувьчлал үр ашигтай байдал, ашигт ажиллагааг дээшлүүлдэг, мөн ахуйн үйлчилгээнүүд хувьчлагдснаар үйлчилгээний хүртээмж дээшлэхийн зэрэгцээ түүний үнэ, ажил эрхлэлт, орлогын хуваарилалтад үзүүлэх

нөлөө газар бүр туйлын харилцан адилгүй байдаг болохыг тогтоосон байдаг⁷. Энэхүү нэр хүнд муутай байдлын хамгийн үнэмшилтэй тайлбар бол өмч хувьчлалын үйл явцыг заримдаа авилгалтай холбож ойлгодог бөгөөд авилгал газар авч хувь хүн түүний уршгаар зовж байгаагаар ч мэдэхгүй хэмжээнд хүртэл тархсан байдаг явдал юм. Энэ нь Орост хийгдсэн «хувьцааны зээл» хэмээх өмч хувьчлалын хор хөнөөлтэй схемийн туршлагаас ихээхэн тодорхой харагдаж байна. Хэрэв энэ тайлбар зөв байх юм бол цаашид өмч хувьчлалыг гялалзтал цэвэрхэн хийх нь маш чухал.

Латин Америкт хийсэн хувьчлалын хөтөлбөрүүдийн бусад гол дутагдал гэвэл зарим үед хувьчлагдсан компаниуд өрсөлдөөнт зах зээлд борлуулалт хийхгүйгээр харилцан уялдаа бүхий зохицуулалтын системээс зайлсхийх боломжтой байдаг явдал юм. Улсын монополийн монопольт байдлыг хэвээр үлдээн хувьчилсан хувьчлалын үр дүнд хэрэглэгчдийн сайн сайхан байдал дээшлэнэ гэж төсөөлөхөд олон эдийн засагчид эргэлзэх биз: компаний удирдлага нэг талаас гол зорилтдоо анхаарлаа улам нарийн төвлөрүүлж ажиллах замаар үр ашгийг дээшлүүлж болох боловч нөгөө талаас өмчийн эзний хувьд үнээ нэмэх сонирхолтой, тэгэх ч чадвартай байдаг. Энэ нь дээр дурдсан үзэгдлийн өөр нэг жишээ юм: засгийн газрыг өмчлөгчийн байр сууринаас буулгах нь түүнийг ямар нэг бодлогын үүрэг гүйцэтгэхээс бүрмөсөн чөлөөлөх албагүй. Энэ үүрэг нь зах зээлийн эдийн засагт нийцсэн байх ёстой бөгөөд дээрх жишээний хувьд бүх үүргээсээ татгалзах бус, харин зохих түвшинд зохицуулагчийн үүрэг гүйцэтгэдэг болгож өөрчлөх хэрэгтэй.

Өнөөдөр Латин Америкт өмч хувьчлал нэр хүндгүй болоод байгаа боловч уг үйл явцыг зогсоох онц шалтгаан байхгүй байна. Энэ нь нэг талаас холбоо харилцаа, худалдаа арилжаа, уул уурхай зэрэг наад захын чухал салбарууд хувьчлагдаж дууссантай холбоотой. Мөн нийтийн аж ахуйд хөрөнгө оруулагчид Аргентинд болсон үйл явдлаас болж итгэл алдарсантай холбоотой. Иймэрхүү улс төрийн эмх замбараагүй байдал болон тус тивийн бусад орны нөхцөл байдал хоорондоо эрс ялгаатай гэдгийг сайн мэддэг хүмүүс хүртэл энэ явдал бусдадаа халдварлах боломжид санаа зовох нь гарцаагүй. Эцэст нь, өмч хувьчлал ийм нэр хүндгүй болсон юм бол түүнийг цааш хөдөлгөх зоригтой улс төрч хэрэгтэй нь тодорхой. Гэвч ихэнх оронд төрийн өмчит салбарууд бодитойгоор оршсоор байгаагийн

дотор ихэвчлэн банкны системийн томоохон хэсэг, эрчим хүчний зарим үйлдвэр, ихэнх нийтийн ахуйн үйлчилгээний байгууллага, хэд хэдэн үндэсний аварга компани орж байна. Өнөөгийн нөхцөл байдалд, ялангуяа үндэсний аваргуудын жишээнд, өмч хувьчлалд нилээд хэмжээний улс төрийн хөрөнгө оруулалт хийх нь ухаалаг хэрэг эсэхэд эргэлзэж байж болох авч Бразилийн олон нийт нэг л өдөр Эмбраер компани хувьчлагдснаасаа хойш хамаагүй дээр ажиллаж байгааг ойлгож мэдэх болно. Гэвч ирээдүйд нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдөж болохыг хэн мэдэх билээ.

Өрсөлдөөнт зах зээлийн эдийн засаг байгуулах хөтөлбөрийн өөр нэг элемент бол зохицуулалтыг задлах явдал юм. Дээр дурдсанчлан энэ бол аюулгүй байдал, чанарыг сахин хамгаалахад шаардлагатай зохицуулалтад гэхээсээ илүү орж, гарахад саад болж буй зохицуулалтуудад хамаатай зүйл юм. Олон оронд, ялангуяа Латин Америкийн орнуудад тохиолддог энэ талын шилдэг жишээ бол хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалттай холбоотой асуудлууд юм. Хөдөлмөрийн зах зээлийн талаар хийсэн ихэнх эконометрикийн судалгаанд, ажлаас халахад тавьдаг хязгаарлалтууд нь хүн ажилд авах урам зоригийг хугалж, улмаар наанадаж албан салбарт ажил эрхлэж буй хүмүүсийн тоог хязгаарлаж байна гэж дүгнэсэн байдаг. Түүнчлэн, албан ёсны хөдөлмөрийн гэрээ нь урт амралт эдлэх гэх мэт янз бүрийн нэмэлт урамшуулал олгодог бөгөөд ажиллах хүчний ихээхэн хэсэг нь түүнийг өндөр цалинтай харьцуулах хэмжээнд үнэлэхгүй байгаа нь харагдаж байна. Харин эдгээр хууль ёсны шаардлагыг хангахад өртөг зардал ихтэй тусч байгаа нь олон ажил олгогчдыг тухайн эдийн засгийн албан ёсны салбарт ажиллах сонирхолгүй болгодог. Үүний улмаас зарим ажилчид нийгмийн халамжийн нэмэлт үр шимийг ихээр хүртэж байхад, зарим нь эрүүл мэндийн эрх, тэтгэвэр авах эрх, ажилгүйдлийн тэтгэмж гэх мэт нийгмийн хамгааллын хамгийн энгийн үндсэн үйлчилгээг ч тэвчин өнгөрөөхөд хүрч байна. Кучински, Уиллиамсон нарын 2003 оны бүтээлд, дээрх нийгмийн шаардлагуудыг үндсэн шаардлагын хэмжээнд хүртэл бууруулах, тэдгээрийг өргөнөөр хүртэх боломжтой болгох, улмаар бараг бүх ажилчид энэхүү үнэхээр чухал нэмэлт урамшууллуудыг хүртдэг болгох нь зүйтэй гэж үзсэн байгаа.

Вашингтоны Зөвшилцлийн миний хувилбарын сүүлчийн нэг элемент бол зах зээлийн эдийн засгийг байгуулахад дэмжлэг

үзүүлэх үүднээс (Хернандо де Сотогийн хийсэн шинжилгээний дагуу, 1989, 2000) албан бус салбарт өмчлөлийн эрхийг хялбар дөхөм, хямд төсөр эдлэх боломжоор хангах асуудал юм. Аливаа хөрөнгө оруулагч өөрийн тавьсан хүчин чармайлтынхаа үр шимийг хүртдэг байх нь хөрөнгө оруулахад бэлэн байдлын үндэс суурь учраас зах зээлийн эдийн засгийн үйл ажиллагааны бас нэг үндэс суурь бол өмчлөлийн эрхийн аюулгүй байдал юм. Латин Америкт чинээлэг дээдсийн өмчлөлийн эрхийг сайтар хамгаалсан байдаг учраас энэ талаар санаа зовоод байх бараг шаардлагагүй. Гол санаа зовох зүйл бол албан бус салбарт өнөөг хүртэл ажиллаж ирсэн асар олон тооны бизнес эрхлэхээр эхлэн сонирхогчдод албан ёсны өмчлөлийн эрх гээд байх юм бараг байхгүй буюу огт байхгүй байгаа явдал юм. Энэ байдал нь тэдний бодитойгоор эзэмшиж буй өмчийн үнэ цэнийг ихээр алдагдуулж байгаа юм. Хууль ёсны өмчийн эрх авахгүй бол өмчөө хамгаалахад үнэтэй байдаг, өмч хөрөнгөө зээлийн барьцаа болгон ашиглаж болдоггүй, даатгуулж болохгүй гэх мэт олон бэрхшээл бий. Иймээс өмчлөлийн эрх олгох хөтөлбөрүүд чухал ач холбогдолтой байна.

Даяаршил

Вашингтоны Зөвшилцөл бий болсноос хойш урт удаан хугацааны турш түүний гурав дахь томоохон сэдэв бол эдийн засгийг нээлттэй болгох явдал гэж би бодож байлаа. Үүнийг өнөө үед даяаршил хэмээн нэрлэх болжээ. Улс орнуудыг дэлхийн эдийн засагт хэрхэн *хавчуулж оруулах* вэ гэсэн хуучин Латин маягийн үзэл санаанаас энэ ойлголтыг ялгаж ойлгох шаардлагатай. Орчин үеийн ойлголтоор, засгийн газрууд улс орноо дэлхийн эдийн засагт *хавчуулж оруулдаггүй*, тэд үүнээс холуур байдаг, харин иргэд өөрсдөө дэлхийн эдийн засагт *хавчуулагсадынхаа* үр шимийг хүртэж байдаг.

Вашингтоны Зөвшилцлийн анхны хувилбартаа би худалдаа ба дотогш чиглэсэн ГШХО-ын либеральчлалд голлон анхаарсан нь хоёулаа асар их хүсүүштэй зүйл юм. Энэ нь тэд бүх бэрхшээлтэй асуудлыг шийдчихнэ гэсэн үг биш: ялангуяа нэгэн үе итгэж байсан шиг худалдаа чөлөөтэй болох тусам орлогын хуваарилалтын төвлөрлийн асуудлыг шийдэхэд тусладаггүй. Үүний шалтгаан гэвэл Өмнөд Америк бол дэлхийн стандартаар ажиллах хүч элбэгтэй тивд тооцогдохгүй бөгөөд нэн ялангуяа тус тивийн дэлхийд өрсөлдөх гол харьцангуй

давуу талыг бүрдүүлж байдаг олборлох үйлдвэрлэлийн салбаруудад ажиллах хүчний нягтрал багатай байдаг оршино. Үүний нэг адилаар, засгийн газрын эргэлзээтэй бодлогууд худалдааны либеральчлалын үр өгөөжийг хэрхэн алдагдуулдаг болохыг бид харсан. Капиталын дотогш урсгалыг их хэмжээгээр оруулснаар валютын ханш бодит түвшнээсээ хэт өндөр үнэлэгддэг. Үүний улмаас ажилчид импортыг орлох үйлдвэрлэлийн салбаруудаас шахагдаж, арилжааны бус салбаруудад хүчээр шилжихэд хүрдэг. Үүнээс дор зүйл бол тэдний олонх нь огт ажилгүй болдогт оршино.

Гэвч хэрвээ макро эдийн засгийн бодлогоор энэхүү валютын ханшны өөрчлөлтөөс зайлсхийж чадвал худалдааны либеральчлал үр ашигтай байна гэж таамагладаг. Үүнтэй адилаар, хэт их хамгаалалт бий болгосны улмаас үр ашиг муутай импортыг орлуулах салбаруудад гадаадын капитал орж ирэх сонирхол төрүүлэхгүй байгаа нөхцөлд ГШХО орж ирвэл цэвэр үр ашиг авчрах магадлалтай.

Миний хувийн үзэл бодлоор бол, улс орнууд гадаадын портфелийн хөрөнгө оруулалтад чөлөөтэй нэвтрэх боломж олгосноор хожихгүй, харин тэтгэврийн сангаа олон улсын хэмжээнд төрөлжүүлэн байршуулах боломж олгосноор хожиж болно. Мөн гадаадаас урт хугацаат зээл авах нь ашиг тустай байж болох боловч богино хугацаат зээлийн хөрөнгө чөлөөтэй орж гарах боломж олгосны давуу талын тухай бага ч болов үнэмшилтэй яриа дууддаг байсангүй. Цаашилбал, үндэсний санхүүгийн болон гадаад валютын зах зээлийг хөрөнгө оруулалтын банкуудын мөрийтэй тоглоомын казино болгон хувиргах нь мэдээж хэрэг аюултай. Магадгүй хэзээ нэгэн цагт капиталын дотогш урсгал гэнэт зогсоно гэсэн ойлголт байхгүй болох хэмжээнд хүртэл шинээр төрөн гарсан эдийн засгууд дэлхийн эдийн засагт нэгдэн нягтарчээ гэсэн итгэл үнэмшил зах зээл дээр нэгэнт төрөөд ирэхийн цагт эдгээр хүчинд чөлөөтэй ноёлох боломж олгосноор алдах зүйлгүй байх биз. Тэр үед хязгаарлалт тогтоогоод байхын учир утга үгүй болох юм. Угаасаа хязгаарлалт байна гэдэг бол эцсийн эцэст авилгалын аюулд хөтлөхийн зэрэгцээ үүнээс болж бодлого боловсруулагчид боломжгүй зүйлийг ч хийж үзэх гэж оролдтол толгой нь эргэх болно. Гэвч ихэнх шинээр төрөн гарч буй зах зээлүүдийн хувьд ийм цаг үе иртэл бас ч гэж урт хугацаа туулна гэж эргэлзэж байгаа бол тэр хүртэл богино хугацаат капиталын урсгалыг хязгаарлахад бэлэн байх нь ухаалаг хэрэг байх юм шиг байна.

Зөвшилцөлд орвол зохих бусад үзэл санаанууд

Иймээс Вашингтоны Зөвшилцлийн анхны тодорхойлолтод маань агуулагдаж буй санаанууд сэтгэгдэл төрүүлсэн хэвээр байгаа гэдэгт би итгэж байна. Гэвч эдгээр нь иж бүрэн хөтөлбөрийн хэмжээнд хүрэх болоогүй байна. Олон Улсын Эдийн Засгийн Институтээс гаргасан саяханы нэг нийтлэлд, голдуу Латин Америк гаралтай хэсэг эдийн засагчид хамтран ирэх жилүүдэд тус бүс нутгийн эдийн засгийн бодлогыг удирдан залах ёстой гэж бидний бодож байсан (Кучински, Уиллиамсон нар, 2003) багц санааг тоймлон гаргах гэж оролдсон байна. Бид аливаа бодлогод баримтлах ёстой дөрвөн гол чиглэлийг олж тогтоосон юм.

Нэгдүгээрт, тус бүс нутгийн байдал таван жилийн турш баргар байхад хүргэсэн гол зүйл бол 1990-ээд оны хоёрдугаар хагаст дэгдсэн хямрал учраас макро эдийн засгийн бодлогоор хямралаас зайлсхийхэд урд өмнөхөөсөө илүү анхаарал тавих ёстой. Хямралаас зайсхийх эсвэл хямрал гарлаа ч гэсэн ядаж зөөлрүүлж өгөхөд тустай олон янзын бодлогыг бид товч тодорхойлсон байгаа. Эдгээрийн дотор, мөчлөгийн эсрэг төсвийн бодлого буюу экспортын мөчлөг хүчтэй үед тогтворжуулалтын сан хуримтлуулах, капитал бэлэн байхад гаднаас их хэмжээний хөрөнгө орж ирэхээс зайсхийх, валютын ханшны тохиргоо алдагдахаас сэргийлэх бодлогуудыг оруулж болох юм.

Хоёрдугаарт, микро эдийн засгийн либеральчлалыг хойшлуулж цаг алдах буюу эсвэл бүр дордуулж эсрэгээр нь эргүүлэхийн оронд үргэлжлүүлэн явуулахыг бид шаардсан. Мөн дээр дурдаж байсанчлан, ихэнх орны гол тэргүүлэх чиглэл бол хөдөлмөрийн зах зээлийн либеральчлал байх ёстой гэж бид үзсэн билээ.

Гуравдугаарт, зүгээр нэг сайн бодлогод найдаж сууснаас институцидийг бэхжүүлэх нь зүйтэйгэсэн өнөөгийн зонхилох чиг хандлагатай бид санал нэг байсан. Энэ санаа бол үнэндээ харьцангуй ойлгомжтой: жишээлбэл, хэрвээ татварын эрх бүхий байгуулагууд найдахын аргагүй авилгалд идэгдсэн тохиолдолд татварын хууль дүрэм сайн байгаад ч татварын дэглэм хангалттай байх баталгаа болохгүй. Ямар нэг ухаалаг бодлого, уг бодлогыг хэрэгжүүлэх үр ашигтай институцийн механизм хоёр нийлж байж сайн үр дүн гарна. Энэ бол нэг улсаас нөгөөд харилцан адилгүй байдаг асуудал гэж үзсэн учраас бид энэ талаар гүнзгий авч үзэж,

цаашид чухам ямар институцийг бэхжүүлэх шаардлагатай гэж үзэж байгаа тухай нарийвчлан ярихыг оролдоогүй юм.

Дөрөвдүгээрт, эдийн засгийн хэлэлцэх асуудлууд нь орлогын хуваарилалтыг сайжруулахад төдийгүй эдийн засгийн өсөлтийн хурдыг хурдасгахад голлон анхаарах ёстой гэж бид үзсэн. Уламжлал ёсоор үүнийг төсвийн тогтолцоогоор дамжуулан, ядуус үр шимийг нь тэгш бус хүртдэг зардлуудыг санхүүжүүлэхийн тулд харьцангуй баян чинээлэг хэсгийн голлон төлж буй татварыг нэмэгдүүлэх замаар хийж гүйцэтгэдэг байв. Татварыг нэмэгдүүлэх хүрээ Латин Америкт нилээд хязгаарлагдмал буюу мөнгөө гадаад руу шилжүүлэх боломж хялбар учраас ядууст хөрөнгө мөнгө олж авах чадвараа дээшлүүлэх боломж олгохуйц зардлуудад, тухайлбал боловсролын тогтолцоог сайжруулах замаар, онцгой анхаарал тавих нь зүйтэй гэж бид үзсэн юм. Энэ нь, орлогын хуваарилалтад хийгдэх сайжруулалт зөвхөн аажмаар хийгдэх болно, гэхдээ уламжлалт популист бодлогыг бодвол урт хугацаанд биелэгдэх магадлал нь хамаагүй илүү байна гэсэн үг юм.

Дүгнэлт

Дээр товч дурдсан хэлэлцэх асуудлууд ямар нэг угаах юмны жагсаалтын тухай сэтгэгдэл төрүүлээгүй буюу хэрвээ эдгээр арга хэмжээг авах юм бол гэнэт хөгжин цэцэглэнэ гэсэн худал амлалт агуулаагүй гэдэгт би найдаж байна. Ертөнц бол тийм биш. Тодорхой нэг улс орны тэргүүлэх чиглэлүүдийг түүхийн өгөгдсөн цаг мөчтэй уялдуулан тооцож үзэх, тухайн тодорхой нөхцөл байдалд тохируулан хийвэл зохих, шаардлагатай зохицуулалтуудыг олж тогтоох зайлшгүй шаардлага ямагт гардаг. Бодлого боловсруулагчид нь тухайн бодлогыг дотоодын нөхцөл байдлын онцлогт тохируулан авч хэрэглэх талаар бодож үзэхгүйгээр, шууд ямар нэг жагсаалт хараад авах арга хэмжээгээ тодорхойлдог тийм нэг хэвийн ажиллагаатай улс орон гэж байхгүй. Үүний нэг адилаар бусдын туршлагаас суралцаж болдоггүй гаж улс гэж байхгүй нь бас үнэн. Би энэ өгүүлэлдээ, хөгжил дэвшлийг хөхиүлэн дэмждэг бодлогын ерөнхий санааг олж авахын тулд бусдын туршлагыг ашиглах нь зүйтэй гэж үзэж байгаа юм. Хэрвээ Родрик, өсөлтөд хүрч чадахгүй байгаа улс оронд өсөлтийг хэрхэн эхлүүлэх вэ гэх мэт зарим нэг шийдвэрлэх ач холбогдолтой асуудлыг энэхүү хэлэлцэх асуудалдаа хангалттай анхаарч үзээгүй гэж маргасан бол тэр нэг оноо авч болох байлаа.

Гэхдээ туршлагаар олж авсан сургамжууд оролдохын үнэ цэнийг үгүйсгэснээрээ итгэл үнэмшил төрүүлж чадахгүй.

Тайлбар

- 1 Валютын өрсөлдөөнт ханш бол бодит ханшнаас доогуур үнэлэгдсэн ханштай адил зүйл хэмээн нотолж ирсэн байдаг. Тэгвэл тийм биш. Валютын өрсөлдөөнт ханш гэдэг бол бодит ханшнаас өндөр үнэлэгдээгүй, өөрөөр хэлбэл нэг бол доогуур үнэлэгдсэн эсвэл зөв үнэлэгдсэн ханш гэсэн үг. Энэхүү тав дахь санаанд бодит ханшнаас өндөр үнэлэгдсэн ханш доогуур үнэлэгдсэнээс дор гэсэн үзлийг тусган харуулж байна. Гэхдээ бодит ханшнаас доогуур ч биш, дээгүүр ч биш үнэлэгдсэн байх нь дээр хэвээр байна.
- 2 Олон жилийн турш энэхүү илэрхий тайлбарын талаар мартаж явсан бөгөөд намайг гэгээрүүлж өгсөн Дэлхийн Банкны Яау Ансуд талархах учиртай. Ийм санаа өргөн дэлгэрсэн байсан нь намайг үзэл бодлоо цэгцлэн 2004 онд Гаванад болсон нэгэн бага хуралд оролцоход хүргэсэн бөгөөд тэнд би өөрийн анхны хувилбар болон дээр дурдсан хоёр хувилбар гэсэн гурван ойлголтын ялгааг нилээд сайн гаргасан илтгэл тавьсан юм. Фидель Кастро миний илтгэлийг дүгнэж тэнд цугласан олонд хандаж хэлэхдээ миний санаа Вашингтоны Зөвшилцлөөс хоёр зүйлээр зөрж байгааг хэлсэн нь валютын ханшны бодлого, капиталын дансны либеральчлал хоёр байсан юм. Яг энэ хоёр чиглэлд Вашингтоны Зөвшилцлийн ОУСБ-уудын хувилбар минийхээс муу байна гэж би үздэг.
- 3 Жишээлбэл, Штиглиц 2002 онд бичсэн номынхоо 74 дүгээр хуудсанд: "Вашингтоны Зөвшилцлийн бодлого нь... зах зээлийн эдийн засгийн хялбарчилсан хувилбар болох өрсөлдөөнт тэнцвэрийн загварт тулгуурласан бөгөөд энд Адам Смитийн үл үзэгдэгч гар ажилладаг, ажиллахдаа төгс ажилладаг юм. Энэ загварт төр засгийн ямар ч хэрэг байхгүй, өөрөөр хэлбэл чөлөөт, дөнгө тушаагүй, "либераль" зах зээлүүд төгс ажилладаг, учраас заримдаа Вашингтоны Зөвшилцлийн бодлогыг "зах зээлийн фундаменталист үзэл"-д тулгуурласан "неолибераль" бодлого гэж үздэг..." гэж бичжээ.
- 4 Ерөнхийлөгч Клинтон Эдийн Засгийн Зөвлөхүүдийн Зөвлөлийн дарга энэ хэрэглээг авч ашигласан байх ёстой гэж бодохоор надад тун егөөтэй санагддаг. Учир нь, түүний АНУ-ын Эдийн Засгийн Зөвлөхүүдийн Зөвлөлийн дарга эсвэл Дэлхийн Банкны тэргүүлэх эдийн засагчаар ажиллаж байх үедээ сүрхий эсэргүүцэж байсан ямар нэг үзэл бодолд Вашингтоны зөвшилцөл тулгуурлах болоход зөвшилцөл гэдэг үгийн тодорхойлолт саад болж байгаа нь мэдээж.
- 5 Уиллиамсон, Махар нар, 1998.
- 6 Тухайлбал, Каприо, Хонохан нар (2001), Ражан Зингалес нар (2003), Уиллиамсон, Махар нар (1998)-ын бүтээлийг үзнэ үү.
- 7 Жишээлбэл, Бёрдсалл, Невайс нарын (2002)-н бүтээлийг үзнэ үү.

Лавлах материалууд

- Birdsall, N. and J. Nevis. 2002. *Winners and Losers: Assessing the Distributional Impacts of Privatisation /Ялагчид ба ялагдагчид: Өмч хувьчлалын хуваарилалтын үр нөлөөг үнэлэх нь/*. VGD Working Paper 6. Washington: Center for Global Development /Дэлхий дахины хөгжлийн төв/.
- Carpio, G. and P. Honohan. 2001. *Finance for Growth: Policy Choices in a Volatile World /Өсөлтийн хөрөнгө санхүү: Хувирамтгай ертөнц дээрх бодлогын сонголтууд/*. Washington: World Bank.
- De Soto, H. 1989. *The Other Path: The Invisible Revolution in the Third World /Өөр зам: Гуравдагч ертөнцөд гарсан үл үзэгдэх хувьсгал/*. New York: Harper and Row.
- _____. 2000. *The Mystery of Capital: Why Capitalism Triumphs in the West and Fails Everywhere Else /Капиталын нууц: Капитализм яагаад Баруунд ялан мандаад, бусад газарт бүтэлгүйтэж унаад байна вэ/*. London: Black Swan.

Kuczynski, P. P. and J. Williamson, eds. 2003. *After the Washington Consensus: Restarting Growth and Reform in Latin America /Вашингтоны зөвшилцлийн дараа: Латин Америкт өсөлт, шинэчлэлийг дахин эхлүүлэх нь/*. Washington: Institute for International Economics /Олон улсын эдийн засгийн институт/.

Rajan, R. G. L. Zingales. 2003. *Saving Capitalism from the Capitalists /Капитализмыг капиталистуудаас аврах нь/*. New York: Crown Business.

Rodrik, D. 2002. "After Neoliberalism, What? Remark at the BNDES Seminar on New Paths of Development." /Неолиберализмийн дараа юу байна? Хөгжлийн шинэ арга замын тухай семинар дээр онцолж хөндсөн асуудлууд/. Rio de Janeiro, September 12-13.

_____. 2003. *Growth Strategies /Өсөлтийн стратегиуд/*. Harvard University. processed.

Stiglitz, J. E. 2002. *Globalization and its Discontents /Даяаршил ба түүнд сэтгэл ханамжгүй байдал/*. New York: Norton.

Williamson, J. and M. Mahar. 1998. *A Survey on Financial Liberalization /Санхүүгийн либеральчлалын тухай судалгаа/*. Princeton: Essays in International Finance /Олон улсын санхүүгийн тухай эсээнүүд/ (211).

Бага орлоготой орнууд дахь насжилт: 2025 онд

НИКОЛАС ЭБЕРШТАДТ¹,
Америкийн Үйлдвэрийн Газруудын Институт

Дэлхий дахины насжилтийн бусад хямрал

ЭЗХАХБ-ын орнуудад аль хэдийн илрээд байгаа хүн амын насжилтын үзэгдэл сүүлийн арван таван жилд бодлогын шинжилгээний байнгын сэдэв, санаа зовоосон асуудлын нэг болоод байна². Ийнхүү улам бүр анхаарал татаж, айдас төрүүлэх болсон шалтгаан хангалттай тодорхой юм.

Голч нас эсвэл 65-аас дээш настны хүн амд эзлэх хувь гэх мэт хэмжүүрээр бол өнөөдрийн бараг бүх хөгжилтэй орны нийгэм 1950 оноос өмнө судалгаанд хамрагдсан аль ч нийгмийнхээс илүү насжсан байна. Мөн өнөөгийн хөгжилтэй орнуудын нийгэм бүр ойрын хэдэн арван жилд улам их хүн амын насжилттай тулгарах юм. Насжилтад нэрвэгдсэн ЭЗХАХБ-ын бүх нийгэмд тэтгэврийн насны хүн ам гэж нэрлэж заншсан хүн амын эзлэх хувь тогтмол нэмэгдэх бөгөөд 80 буюу түүнээс дээш настай хүмүүсийн эзлэх хувь хамгийн хурдан өсөх юм. Үүнтэй зэрэгцээд хөдөлмөрийн насны хүн амыг (тохиолдлын чанартай боловч тийм ч үндэслэлгүй биш тогтсон заншлаар бол 15-64 нас гэж тогтоосон байдаг) тэтгэврийн насныхантай харьцуулсан харьцаа зогсолтгүй буурах болно. Хөдөлмөрийн насны ангилал дотроо арай залуу насанд хүрэгчдийн нийт ажиллах хүчинд эзлэх хувь тотвортой буурах юм.

Онцлон хэлэхэд, үндэсний хүн амын бүтцэд заналхийлж буй эдгээр эргэлтийн чанартай шилжилтүүд аж үйлдвэржсэн орнуудын эдийн засаг, нийгэмд хямрал авчрах эсэх нь маргаантай асуудал хэвээр байна. Мэдээжийн хэрэг, энэхүү бидний сайн мэдэх хүн амын пирамид буюу дөнгөж өчигдөрхөн хүртэл бүх хүн төрөлхтөний насны бүтцийг илэрхийлдэг байсан хэлбэр маань уруугаа харан байрлах болсон нь дэлхийн дээрх насжилтад илүүтэй нэрвэгдсэн нийгмүүдийн эдийн засгийн институциуд ба бүтцэд шууд үр дагавар авчрах нь тодорхой төдийгүй макро эдийн засгийн үйл ажиллагааны үр дүнд томоохон нөлөө үзүүлэх боломжтой байж болох юм.

Хэрвээ энэ асуудлыг онцлон авч үзэхгүй орхивол өнөөдөр нэрвэгдээд байгаа ЭЗХАХБ-ын орнууд дахь хүн амын насжилтаас тэтгэврийн зардал, эрүүл мэндийн үйлчилгээний зардал, төсвийн сахилга бат, хуримтлалын түвшин, ажиллах хүчний хангамж, ур чадварт үзүүлэх нэмэлт дарамтууд нь, түүний дэлхий нийтийн шинийг санаачлах, шинээр бизнес эрхлэх, өрсөлдөх чадварын хэтийн төлөвт үзүүлэх сөрөг

нөлөөний талаар огт дурсахгүй өнгөрлөө гэхэд, дотоодын бүтээмж, эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөөтэй байх болно. Гэвч, олон тооны боломжит бодлогын арга хэмжээ болон одоо байгаа институцийн зохицуулалтад хийгдэх цэгцтэй өөрчлөлтүүд нь өнөөдрийн баян орнууд «насжиж буй нийгмийнхээ хөгжил дэвшлийг хэвээр хадгалах» (ЭЗХАХБ-аас иш татсан хэллэг), тэр ч байтугай хөгширч бууралтсан хүн амынхаа хөгжил дэвшлийг тогтвортой дээшлүүлэх боломж олгож байна. Өнөөгийн баян орнууд айсуу яваа бэрхшээл сорилтод зохистой хариу өгөх, хүн амын насжилтаас урган гарах бүхий л таатай боломжуудыг шуурхай авч ашиглах тал дээр амжилт олж болно. Гэтэл тэд бас ингэж чадахгүй алдаж ч болно. Энд гол нь, насжилтийн хямрал бол тэдний урьдчилан сэргийлж зайлуулах ёстой зүйл бөгөөд тэд ч ингэж чадах ихээхэн боломжтой.

Нөгөө талаас, одоогийн байдлаар хөгжилтэй орнууд хүн амын насжилтын асуудалд маш их анхаарал хандуулж байгаа бол бага орлоготой орнуудад насжилтын сэдэв харьцангуй бага анхаарал татаж байна. Ойрын хэдэн арван жилд гуравдагч ертөнцийн ихэнх хэсэгт үүнтэй зэрэгцсэн эрс хөгшрөлт явагдах гэж байхад ингэж үл ойшоож байгаа нь зарим талаар гайхалтай юм. Цаашилбал, албан ёсоор зарласан хүн амын насжилтын ачааллыг ядуу буурай орнууд баян орнууд шиг хялбар дааж чадах магадлал багатай. Энгийнээр хэлэхэд, орлогын түвшин багатай үед нийгэм ба засгийн газруудад хүн амын насжилтаас үүдсэн бэрхшээлтэй асуудлуудыг авч шийдвэрлэх боломж бага байдаг бөгөөд тэрхүү байгаа цөөхөн боломжийн сонирхол татах чадвар орлогын түвшин өндөр байсан тохиолдлынхоос илт бага байдаг онцлогтой.

Дараагийн нэгэн үеийнхний турш, голдуу шинээр төрж байгаа зах зээлийн эдийн засагтай хэмээн нэрлэдэг хөгжиж буй орнуудын хүн амын үлэмж хувь нь хүн ам насжилтын үзэгдэлтэй тулгарах бөгөөд ингэхдээ насжилтийн харьцуулж болох ижил түвшинд яваа аль ч нийгмийнхээс хамаагүй доогуур түвшний орлоготой байх магадлалтай буюу үнэндээ бол ингэх нь бараг зайлшгүй болоод байна. Ийм орнуудын хувьд, насжилтын нийгэм, эдийн засгийн үр дагавар хатуу ширүүн байхын зэрэгцээ хүн амын насжилтын сөрөг нөлөөг зөөллөх боломж хязгаарлагдмал байж болно. Эдгээр орны заримд нь, тодорхой нөхцөл байдалд насжилтын асуудал урт хугацааны өсөлт хөгжилтөд улам бүр дарамт учруулах

нэг хүчин зүйл болон гарч ирж болзошгүй байна. Бид хожим дэлгэрэнгүй харуулах, хүн амын насжилт хурдацтай, илт мэдрэгдэхүйц хэмжээнд явагдаж байгаа нь дэлхийн шинээр төрж байгаа зах зээлүүдийн хувьд маш тэгш бус, ихээхэн тааламжгүй байхын зэрэгцээ түүний урт хугацааны эрсдлийг бараг бүхэлд нь тооцоолохгүй байна.


Бага орлоготой газрууд дахь 2025 он хүртэлх хүн амын насжилт: Хөдөлгөгч хүч ба хэмжээсүүд

Одоогоос 20 жилийн дараахь дэлхийн төлөв байдлыг урьдчилан таамаглана гэдэг бол осолтой ажил. Гэсэн хэдий ч, одооноос 2025 он хүртэлх хугацаанд хөгжиж байгаа бүс нутгуудын хэмжээгээр хүн амын насжилтын асар том давалгаа нөмрөх нь бараг тодорхой гэдгийг, мөн ирэх хэдэн арван жилд ийм их өргөн хүрээтэй явагдах хүн амын насжилтаас зөвхөн библьчилсэн сударт заасан шиг зохист харьцааны аргаар сэргийлж болно гэдгийг яг энэ цаг мөчид бид нилээн итгэлтэйгээр хэлж чадахаар байна.

Хараахан өрнөж эхлээгүй байгаа үйл явдлын талаар бид яаж ийм зоригтой, түс тас хэлж чадаж байна вэ? Энэ асуултын хариултыг хүн ам зүйн хэтийн төлвийг тодорхойлох энгийн арифметик үйлдэл, насжилтын демографийн өршөөлгүй дүр зургаас харж болно.

Аливаа улсын эдийн засаг, улс төрийн нөхцөл байдал хорин жилийн турш асар их өөрчлөгдөж болох учраас ирээдүйд байж болох улс төр, эдийн засгийн дүр төрх маш олон янз байх болно. Нөгөө талаас, хүн ам зүйн хувьсал өмнөх хөгжлөөсөө хамааран аажмаар явагдах бөгөөд нийгмийн өнөөгийн чиг хандлагад хатуу баригдах төлөвтэй байна. Ийм учраас, хүн амын өөрчлөлтийн дуулгаваргүй хөшүүн байдлыг харгалзвал одоогоос 20 жилийн дараахь хүн ам зүйн боломжит дүр төрхүүдийн хооронд угаасаа бага зөрүү гарах болно. Үнэн хэрэгтээ, нийтийг хамарсан гамшиг сүйрлээс сэргийлж чадвал бид 2025 онд бага орлоготой бүс нутгуудад хүн амын байдал ямар байх талаар нилээн сайн дүр зургийг хэдийнээ гаргаж авсан байх болно. Өнөөдөр нэн буурай хөгжилтэй бүс нутагт амьдарч байгаа барагцаагаар 5.3 тэрбум хүний зургааны тав орчим нь 2025 оны үед амьд сэрүүн байх магадлалтай. 2025 оны үед эдгээр газар нутаг 6.7 тэрбум хүн амтай болно гэж өсгөн тооцвол түүний гуравны хоёр хувь нь өнөөдөр амьд сэрүүн байгаа хүмүүс байх болно.

Бүдүүвч 1: 65-аас дээш настай хүн амын эзлэх хувь ба нэг хүнд ноогдох ДНБ-ий харьцуулалт: Хөгжилтэй орнууд 1950-2000 онд.



Эх сурвалж: НҮБ, 2004; Мэддисон, 2003, 65, 89, 101, 111, 144, 184, 187-р хуудас, онлайн хаяг: <http://www.un.org/esa>

Маргаашийн өндөр настнууд өнөөдөр бидэнтэй хамт амьдарч байгаа учраас бид нэг их таагаад байлгүйгээр тэдний ирээдүйн тоо хэмжээг урьдчилан хэлж чадна. Өнөөгийн төсөөллөөр 2005-2025 оны хооронд буурай хөгжилтэй бүс нутгуудын хүн ам дөрөвний нэг орчим хувиар өсөх төлөвтэй байна. Харин энэ хүн амын дотор хамгийн хурдан өсч буй бүлэг нь 65-аас дээш насны хүмүүс байх юм. Иймээс зөвхөн гамшиг сүйрлийг эс тооцвол энэ хугацаанд гуравдагч ертөнцийн өндөр настай иргэдийн тоо бараг хоёр дахин нэмэгдэх буюу 570 сая хүн болж, 2025 оны нийт хүн амын 8.5 орчим хувийг эзлэх болно.

65-аас дээш насны хүн ам нийт хүн амын 7 хувиас илүүг эзэлж байвал насжиж буй хүн амд тооцно гэсэн НҮБ-ын тодорхойлолтыг 2025 он гэхэд буурай хөгжилтэй бүс нутгууд хангах бөгөөд гэсэн хэдий ч нийт хүн амын бүтцийн хувьд 1950-иад оны сүүл үеийн Европ, эсвэл 1970-аад оны дунд үеийн Японы хүн амынх шиг залуу байж чадахгүй. Гэхдээ буурай хөгжилтэй бүс нутгуудын хүрээнд хүн амын насжилтын цар хүрээ, явц асар их ялгаатай байна: зарим нэг газар нутагт ирэх хорин жилд хүн амын насжилт бараг явагдахгүй бол бусад газарт нь насжилт илэрхий явагдах болно. Энэ ялгааг насжилтын демографээр тайлбарладаг.

Цэвэр арифметик чанартай (магадгүй зарим талаар зөн совингийн таамаглалын эсрэг байдлаар) нэг зүйл бол, жирийн нэг хүний нийгэм дэх хүн амын насжилтын далайц, цар хүрээг голдуу нас баралтын түвшний өөрчлөлтөөр бус төрөлтийн түвшний өөрчлөлтөөр тодорхойлдог⁴. Хүн амын насжилтад хүргэдэг хүчин зүйл бол урт наслалт гэхээсээ илүү төрөлтийн хувь бага байх явдал бөгөөд гуравдагч ертөнцийн нилээд хэсэгт төрөлтийн түвшин маш бага байна. Үнэн хэрэгтээ өнөөдөр хүн төрөлхтний дийлэнх хэсэг нь магадгүй нөхөн үржих чадвар муутай (нэг эмэгтэй дунджаар 2.1-ээс цөөн хүүхэд төрүүлэх) төрөлтийн дэглэм бүхий орнуудад амьдарч байж болох юм. Өөрөөр хэлбэл, цагаачлал байхгүй тохиолдолд хүүхэд төрүүлэх ийм хэв маяг хэвээр үргэлжилсээр байх юм бол эцэстээ тодорхойгүй хэмжээний хүн амын бууралт гарч болох юм⁵.

Мэдээж, одоогоос хорь орчим жилийн дараа голч нас нь дөнгөж 20 нас хэвээр байх магадлалтай байгаа Африкийн Сахар орчмын дэд бүс нутаг, мөн Йемен, Оман, Афганистан шиг нийт төрөлтийн хувь нь эмэгтэй хүн бүр амьдралдаа таван удаа хүүхэд төрүүлэх үзүүлэлтээс илт илүү байгаа Араб, Исламын ертөнцийн хувьд ийм зүйл болохгүй нь

ойлгомжтой. Харин одоо Зүүн Азийн нилээд хэсэг, Өмнөд Ази, Ойрхи Дорнод, Зүүн Европ⁶, Латин Америкт нөхөн үржих чадвар муутай төрөлтийн хэв маяг тогтоод байна. Өөрөөр хэлбэл, хүн амын огцом насжилтын замд одоогоор ороод байгаа хөгжиж байгаа ертөнцийн орнууд бол өнөөдрийн хамгийн ирээдүйтэй шинээр төрөн гарч буй зах зээлийн эдийн засагтай орнууд мөн гэсэн үг.

Хүн амын насжилт ба эдийн засгийн өсөлтийн дэлхийн хэмжээний төлөв байдал

Олон улсын эдийн засгийн төлөв байдал дахь бага орлоготой бүс нутгуудын хүн амын насжилтын үзэгдлийг олж харахын тулд эхлээд бид өнөөдрийн шинээр төрөн гарсан эдийн засагтай орнуудын насжилт ба орлогын түвшингийн холбогдох харьцааг барууны томоохон улсуудын дайны дараахь үеийн өндөр нас ба орлогын өсөлтийн даялалтай харьцуулж үзэх ёстой.

Бүдүүвч 1-д харагдаж байгаачлан, шинээр төрөнгарсанэдийнзасгуудынөнөөгийндүртөрх маш олон янз байна. Нэг талаас, өнөөдөр зарим хөгжиж байгаа орон Баруун Европ, АНУ, эсвэл Японы нэг хүнд ноогдох орлогын түвшинтэй харьцуулж болох үеийнхээс хамаагүй залуу харагдаж байна. Жишээлбэл, одоогоор Турк, Бразил, Мексик улсууд тухайн үеийн Баруун Европын нэг хүнд ноогдох орлогын ижил түвшинд тэтгэж байсан өндөр настай иргэдийн бараг тал хувьтай тэнцэх хэмжээний өндөр настнуудтай байна. Энэхүү эсрэг тэсрэг байдлыг тайлбарлах нэг үндэслэлтэй тайлбар бол Бразил, Мексик, Турк улсууд бүгд нэг хүнд ноогдох ДНБ-ий 5000 ам.долларын босгонд ойртож байх үедээ барууны орнуудынхаас хамаагүй өндөр төрөлтийн хувьтай байсан явдал юм.

Өөр бусад шинээр төрөн гарч буй зах зээлийн эдийн засагтай орнуудын зарим нь барууны орнуудын эдийн засгийн мандан бадралтын үеийнхтэй бараг адилхан насжилт болон орлогын харьцаатай гарсан байна: жишээлбэл Энэтхэг, Тайланд хоёр улс Япон улсын дайны дараахь үеийн насжилт ба өсөлтийн даялалыг дагасан цэгт байрлажээ.

Гэтэл зарим шинээр төрөн гарч буй зах зээлийн эдийн засагтай орнууд тэдэнтэй ижил хөгжлийн шатанд барууны орнуудын үүрч байснаас онцгой өндөр насжилтын ачаалал үүрч байна. 2000 оны байдлаар Хятадад 65-аас дээш настай хүн амын эзлэх хувь 1970 оны

Японы хүн амынхтай ижил байгаа боловч 1970 оны Японы нэг хүнд ноогдох орлого 2000 оны Хятадын үзүүлэлтээс 3 дахин их байв. Үүний нэг адилаар, Баруун Европ ба АНУ-ын нийт хүн амд өндөр настнуудын эзлэх хувь 2000 оны Оросынх шиг байх үедээ нэг хүнд ноогдох орлого нь Оросын өнөөгийн түвшнээс тус тус гурав ба зургаа дахин өндөр байжээ.

Дөнгөж саяхан өнгөрсөн үе бас ойрын ирээдүйн хооронд харьцуулж үзвэл, эдгээр хамгийн том шинээр төрж буй зах зээлийн эдийн засагтай есөн орон хүн амын насжилтын давалгаанд өртөх төлөвтэй байгааг Хүснэгт 1 харуулж байна.

НҮБ-ын шалгуураар эдгээр есөн орон бүгд 2025 он гэхэд насжиж буй нийгэмд тооцогдох боловч хүн амын насжилтийн түвшин нэгээс нөгөөд маш их харилцан адилгүй байгаад гайхах зүйлгүй. Жишээлбэл, Энэтхэг, Индонези, Мексик улсууд 2025 он гэхэд АНУ-ын 2003 оны түвшнээс илүү залуу хүн амын бүтэцтэй байх төлөвтэй байна. Нөгөө талаас, 2025 он гэхэд Турк, Бразил улсуудын хүн ам бараг өнөөдрийн АНУ-ынх шиг хэмжээнд, гэхдээ арай өнөөдрийн Япон, Баруун Европынход хүрэхээргүй хэмжээнд хөгширсөн байх болно. 2025 он гэхэд Хятад, Тайланд улсуудын хүн ам ЕХ-ны анхны 15 орныхтой бараг адил хэмжээний насжилттай байх төлөвтэй байна. Харин Орос, Польш хоёрын хувьд 2025 онд өнөөгийн Японы түвшинд хүрэхүйц насжсан хүн амтай байх магадлалтай нь хүн төрөлхтний түүхэнд аль ч хүн амд гарч байснаас илүү өндөр насжилт юм.

Хэдийгээр эдгээр шинээр төрөн гарч буй зах зээлийн эдийн засагтай орнуудын ихэнх нь өнөөгийн хөгжилтэй орнуудынхтай бараг ижил, зарим тохиолдолд бүр ч илүү насны онцлогтой байх боловч тэдний орлогын түвшин өнөөдрийн насжилтад нэрвэгдсэн ЭЗХАХБ-ын орнуудынхаас хамаагүй доогуур байна. Одоогоос хорин жилийн дараа, бараг бүх тохиолдолд тэдний орлогын түвшин өнөөдрийн ЭЗХАХБ-ын түвшнээс доогуур хэвээр байх нь бараг тодорхой байна.

22 жилийн хугацаанд (өөрөөр хэлбэл 2003-2025 он) Польш улс хэрвээ нэг хүнд ноогдох орлогоо жилд 4 хувиар тогтвортой өсгөлөө гэхэд (нилээд хүч чармайлт шаардах боловч огт бүтэхгүй мөрөөдөл биш) нэг хүнд ноогдох бүтээгдэхүүний түвшнээр тохируулж тооцсон Валютын Худалдан Авах Чадвар (ВХАЧ буюу PPP) нь өнөөгийн ЕХ-ны 15 орны түвшинд хүрч болох юм. Гэтэл Японы орлогын түвшнээр

Хүснэгт 1: Хөгжилтэй орнуудын өнөөдрийн хүн амын насжилтын түвшин ба шинээр төрөн гарч буй зах зээлийн эдийн засагтай орнуудын маргаашийн насжилтын харьцуулалт

Улс/Бүс нутаг	Голч нас (2003)	65-аас дээш настны хүн амд эзлэх хувь (2003)	Нэг хүнд ноогдох ДНБ, ВХАЧ-аар, ам.дол (2003)	Нэг хүнд ноогдох ДНБ, валютын ханшаар, ам.дол (2003)
АНУ	35.8	12.4	37,562	37,648
Япон	42.0	18.5	27,967	33,713
ЕХ-ны 15	39.5	16.9	26,640	26,710 ¹

Улс/Бүс нутаг	Голч нас (2003)	65-аас дээш настны хүн амд эзлэх хувь (2003)	Нэг хүнд ноогдох ДНБ, ВХАЧ-аар, ам.дол (2003)	Нэг хүнд ноогдох ДНБ, валютын ханшаар, ам.дол (2003)
Польш	44.2	21.6	11,379	5,280
Орос	43.4	19.8	9,230	2,120
Мексик	32.1	9.8	9,168	6,230
Бразил	36.1	11.0	7,790	2,670
Тайланд	39.7	14.6	7,595	2,190
Түрк	36.4	10.8	6,772	2,800
Хятад	39.1	13.7	5,003	1,100
Индонези	32.8	9.2	3,361	810
Энэтхэг	30.8	7.8	2,892	540

¹ зөвхөн Европын Валютын Холбоо
Эх сурвалж: Дэлхийн Эдийн Засгийн Форум, 2004, Хавсралт хүснэгтүүд 1.01-1.03; Дэлхийн Банк; АНУ-ын Тооллогын Товчоо, 2004.

тохируулсан ВХАЧ-ын өнөөгийн түвшинд хүрэхийн тулд Орос улс нэг хүнд ноогдох орлогын өсөлтөө бараг хорин таван жилийн турш жил бүр 5 хувьд барьж байх шаардлагатай болно. Мөн 2025 он гэхэд ЕХ-ны орлогын түвшнээр тохируулсан ВХАЧ-ын өнөөгийн түвшинд хүрэхийн тулд Хятад улсын нэг хүнд ноогдох орлого жил бүр 8 хувиар, Энэтхэг улсынх 10 гаруй хувиар өсөх шаардлагатай болно. Магадгүй ийм өндөр хурдацтай өсөлтөд хүрэх боломжгүй гэж хэлсэн хүн Орос, Хятад, эсвэл Энэтхэгийн талаар гутранги үзэлтэн байх албагүй⁷.

Хятад, Орос, Энэтхэг улсуудын насжилтын асуудлыг нарийвчлан шалгаж үзсэн дараахь судалгаанд ирэх хэдэн арван жилд эдгээр орнуудын тус бүрийн эдийн засагт учрах дарамт шахалтыг тодорхой дүрслэн харуулж байна.

Хятад улс: Улам чангарч буй гурван давхар хүлээс

Хятад улсад нүүрлэж буй насжилтын давалгааг Бүдүүвч 1-д үзүүлсэн бөгөөд энд тус улсын хүн амын 2000 оны бодит бүтцийг 2025 оны хэтийн тооцоотой харьцуулж байна.

Хятад улс 1990-ээд оноос хойш төрөлтийн нөхөн үржвэрийн түвшин муутай байгаа нь илт байна⁸. Үүнээс болж, магадгүй эдгээр хэтийн


тооцооноос харагдаж болохоор байгаачлан, 2025 онд 35-аас доош насны бүлэг бүр 2000 оны хэмжээнээсээ багасаж, харин түүнээс дээш насны бүх бүлгүүдийн хэмжээ өсөх болно. Хятад улсын хүн амын албадан хянах хөтөлбөр амжилттай хэрэгжиж залуу хүмүүсийн тооны гэнэтийн өсөлтийг хязгаарлаж чадсан боловч ирэх жилүүдэд өндөр настай хүмүүсийн тоо огцом нэмэгдэж, жилд дунджаар 3.5 орчим хувиар өсөх болно. 2005-2025 оны хооронд Хятадын хүн амын нийт өсөлтийн ойролцоогоор гуравны хоёр орчим нь 65-аас дээш насны ангилалд явагдах юм. Энэ насны хүмүүсийн тоо магадгүй хоёр дахин нэмэгдэж бараг 200 саяд хүрэх талтай. НҮБ-ын Хүн Амын Хэлтэс (НҮБХАХ), АНУ-ын Тооллогын Товчооны (АНУТТ) хэтийн тооцоогоор, 2025 он гэхэд Хятадын хүн ам дэлхийн хүн амын тавны нэгээс бага хэмжээнд хүрэх боловч, дэлхийн өндөр настай иргэдийн дөрөвний нэг нь Хятадад байх ажээ.

Хятад бол асар том газар нутагтай, бүс нутгийн ялгаатай байдал ихтэй орон. Насжилт ба эдийн засгийн хөгжлийн хувьд ч, тус улсын мужуудын хүн ам зүйн байдал мэдэгдэхүйц ялгаатай бөгөөд нэг хүнд ноогдох бүтээгдэхүүний түвшин нь асар их зөрүүтэй байдаг онцлогтой. Жишээлбэл, 2001 онд хөл үймээн ихтэй Шанхайн орон нутгийн нэг хүнд ноогдох ДНБ-ий хэмжээ алсмагдмал Гүйжоугийнхаас 13 дахин өндөр байв. Өнөөдөр Хятадын мужуудад насжилт ба орлогын түвшний хоорондын корреляцийн хамаарал ихтэй байдаг боловч энэ хамаарал тийм ч нягт бус байна. Ирэх хорин жилд Хятадын хамгийн эрс өөрчлөлт гарах насжилтын хандлагуудын зарим нь одоогоор хамгийн ядуу буурай байгаа газруудад илрэх юм.

Одоогийн байдлаар (2005 онд), 65 буюу түүнээс дээш настай хүмүүсийн эзлэх хувийн үзүүлэлтээр дэлхийд хамгийн өндөр нь Япон улс буюу нийт хүн амынх нь 19.5 орчим хувь байна. Гэтэл 2025 он гэхэд Хятадын нэг хэсгийн нийт хүн амын 21 хувь нь 65-аас дээш насныхан байх төлөвтэй байна. Энэ хэсэг бол харьцангуй чинээлэг Бээжин эсвэл хөгжин дэвжиж буй Шанхай биш, харин хятадын Манжуурын тойрогт орших Хэйлунжиан бөгөөд энэ мужийн нэг хүнд ноогдох бүтээгдэхүүн 2001 онд (одоогийн валютын ханшаар) дөнгөж 1100 ам.доллар гаруй байлаа.

Одоогоор дэлхийн хамгийн өндөр голч насны үзүүлэлттэй орон мөн л Япон улс буюу энэ нас 42.5 орчим байна. Гэтэл 2025 он гэхэд

Бүдүүвч 2: Хятадын хүн амын бүтцийн одоогийн ба хэтийн тооцоо: 2000 ба 2025 он



Хятадын 31 муж, томоохон хотуудын ес нь орчин үеийн Японыхоос өндөр голч настай байх хэтийн тооцоо гарчээ: үүнд Ляонин (валютын ханшид суурилсан нэг хүнд ноогдох ДНБ нь 2001 онд 1450 ам.доллар орчим байсан), Жилин (925 ам.доллар орчим), Чонжин (690 ам.доллараас доош) орж байна. (Хэйлунжиан мужын хувьд 2025 он гэхэд маш хөгшин харагдаж байгаа бөгөөд голч нас нь 51 байх хэтийн тооцоотой байна.) Эдгээр валютын ханшид суурилсан тооцоог ВХАЧ-аар тохируулснаар үндсэн дүр зураг өөрчлөгдөхгүй: дөнгөж хорьхон жилийн дотор Хятадын томоохон хэсгүүд дундаж орлогын ийм бага түвшинд маш их насжилттай хүн амаа тэтгэх шаардлагатай болно.

Энэ хорин жилд Хятад улс өндөр настай хүн амаа хэрхэн тэжээж тэтгэх вэ? Ирээдүйн тухай бүх тодорхойгүй байдлыг эс тооцвол, эдгээр ирээдүйн тэтгэвэр авагчдыг тус улсад одоо байгаа улсын тэтгэврийн зохицуулалтаар тэтгэж чадахгүй хэмээн бид нилээн итгэлтэй таамаглаж болно. Хятадын нийт ажиллах хүчний зургааны нэгийг хамарсан энэхүү хэсэгт олгох санхүүжигдээгүй өр төлбөрийн өнөөгийн цэвэр үнэ цэнэ тус улсын одоогийн ДНБ-ий дүнгээс давах, магадгүй бодитойгоор хэтрэх тооцоо гарсан байна. Хятадын тэтгэврийн тогтолцоо тогтворгүй нь тодорхой бөгөөд үндэсний тэтгэврийн бэрхшээлтэй асуудлуудын талаар сүүлийн арван жилийн

Хүснэгт 2: Улсын тэтгэврийн өнөөгийн тогтолцоонуудын хамрах хүрээ ба ирээдүйн төлбөрийн тэнцлүүд: АНУ, Япон, Хятад (хувиар)

	Хамрах хүрээ	Санхүүжигдээгүй зардлын өнөөгийн цэвэр үнэ цэнийн ДНБ-д эзлэх хувь
АНУ 2004	87% ¹	32%
Япон 2001	тооллогоор 100% ²	60-70% ³
Хятад 2003	тооллогоор 16%	125-150%

¹ 20-иос дээш насны бүрэн даатгагдсан хүмүүсийн эзлэх хувь, OASDI, 2003.

² үндсэн төлөвлөгөөнд орсон заавал оролцох 20-иос дээш насны хүмүүс.

³ 2000 оны шинэчлэлийн үеийн дараахь ачааллын тооцоо

Эх сурвалж: Хятадын хувьд: West and Goodkind, 2003; Японы хувьд: Faruque and Muehleiser, 2001, онлайн хаяг: <http://www.imf.org/external/pubs/ft/wp/2001/wp0140.pdf>; АНУ-ын хувьд: United States Social Security Administration /АНУ-ын Нийгмийн Хамгааллын Удирдах Газар/, 2004a, Table 4.c5, онлайн хаяг: <http://www.ssa.gov/policy/docs/statcomps/supplement/2003/4c.pdf>, United States Social Security Administration, 2004b, Table VI.F5 Chapter II.D, онлайн хаяг: <http://www.ssa.gov/OACT/TR/TR04/>

ихэнх хугацаанд Бээжинд дээд хэмжээний бодлогын хэлэлцүүлэг өрнөснийг (уг асуудлыг 1997 оноос хойш засгийн газрын дээд түвшний заавар удирдамжуудад хөндөн авч үзэж байна) эс тооцвол ямар нэг томъёоны хувилбар албан ёсоор хараахан гараагүй байна⁹. Түүнчлэн Хятад улсын бодлогын түвшинд шинэ бөгөөд нэгдсэн нийгмийн хамгаалалын тогтолцооны тухай хууль тогтоомж боловсруулан гаргаснаа

зарласан тохиолдол одоогоор хаа ч гараагүй байна¹⁰.

Иймээс өнөөдрийн байдлаар Хятад улсын 2025 оны үндэсний тэтгэврийн тогтолцоо тус улсын хөгшдөө тэтгэж байсан уламжлалт хэлбэр болох гэр бүлийн хүрээний аргатай их, бага ямар нэг хэмжээгээр адилхан байх хандлагатай байна. Гэвч энд бас нэг асуудал байна: Хүн амын өсөлтийг төрөхөөс нь өмнө зогсоож байгаа Хятадын засгийн газрын «амжилт» нь ирэх арван жилд ажиллах насны хүүхдүүд ба тэдний эцэг эхийн тооны харьцаа огцом унахад хүргэх нь гарцаагүй. 1990-ээд оны эхээр 60 насны ойгоо тэмдэглэж байгаа дундаж хятад эмэгтэй амьдралынхаа туршид таван хүүхэд төрүүлчихээд байсан бол 2025 оны дундаж хятад эмэгтэй хоёр хүрэхгүй хүүхэд төрүүлсэн байх юм. Бас нэг чухал зүйл бол ирэх хорин жилийн турш Хятадад өсөн нэмэгдэж байгаа ирээдүйн тэтгэврийн хөгшдийн бүлгийн хувьд «хүүгийн хомсдол» гэгч асуудал улам ихээр тулгарах болно. Хятадын ёс заншлаар хөвгүүд нь өндөр настай эцэг эхээ асарч тэтгэх үндсэн үүрэгтэй байдаг бол охидууд нь нөхрийнхөө болон өөрийн эцэг эхийг асрах үүрэгтэй байдаг. 1990-ээд оны эхээр Хятадын 60 настай эмэгтэйчүүдийн 7 хувь нь огт хүү төрүүлээгүй байсан байна. Өнөөдөр энэ тоо 10 орчим хувь болжээ. 2025 он гэхэд энэ тоо бараг 30 хувь болж огцом өсөх болно.

Цаашилбал, зарим эрэгтэй хүүхэд эцэг эхээ тэтгэж туслах хэмжээний насанд хүртлээ эрүүл саруул өсч том болж чадахгүй. Төрөлтийн болон наслалтын чиг хандлагаас харахад одоогоос хорин жилийн дараа тэтгэврийн насанд хүрэх хятад эмэгтэйчүүдийн гуравны нэг буюу түүнээс илүү хувь нь амьд сэрүүн эрэгтэй хүүхэдгүй байх магадлалтай мэт санагдаж байна. Хятадын урт удаан хугацааны соёлын хэм хэмжээ болох бараг бүх эмэгтэйчүүд гэрлэдэг байдал үргэлжиллээ гэхэд, одоогоос хорин жилийн дараа хэдэн арван сая өндөр настай хятад иргэд хүүхдүүдээсээ санхүүгийн болон эд материалын тусламж эрэх үедээ хүргэн хүүгийнхээ эцэг эхтэй давхар өрсөлдөх шаардлагатай болно. Нийгмийн экологийн хэтийн төлвөөс үзэхэд энэхүү хэрэгцээг амжилттай хангахуйц таатай нөхцөл бүрдэх найдвар алга байна.

Төрийн тэтгэврийн тогтолцоо нь албан ёсны бодлогоор хүсч болох хэмжээнээс шал өөр хязгаарлагдмал хүрээний хүнд нөхцөл байдалд байх, мөн гэр бүлийн гэдгээр танил болсон уламжлалт нийгмийн хамгааллын тогтолцоо

нь урьд хожид байгаагүй хэврэг болсноор ирэх хэдэн арван жилд Хятадын асар олон эрэгтэй, эмэгтэй өндөр настан өөрсдийгөө тэжээхийн тулд хүссэн хүсээгүй үргэлжлүүлэн ажил хийхэд хүрэх хэцүүхэн бодит байдал тулгарч болох юм. 1975 оноос эхлэсэн сүүлийн хагас зуунд Хятад улс асар их материаллаг хөгжил дэвшил гаргасныг эс тооцвол, тус үндэстний өндөр настнууд өөрсдийн хөдөлмөрөөр үлдсэн амьдралаа тэтгэх шаардлага хэвээр байх (энэ нь бүр өсөн нэмэгдэх хэрэгцээ байх нилээн боломжтой) өвөрмөц онцлогтой байна. Асуудлыг бүр хурцатгахад, Хятадын өндөр настай хүн ам улсынхаа хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөхүйц зохистой байр суурь эзлэх боломж өнөөдөр ч, маргааш ч байхгүй байна. Эндээс Хятадад чангарч буй гурван давхар хүлээсийн хоёр дахь дарамт гарч ирж байна.

Өнөөдөр Хятадын өндөр настай ажилчид тус улсын хөдөлмөрийн зах зээл дээр туйлын тааламжгүй байр суурь эзэлж байгаа нь тодорхой байна. Шинэ зууны эхэнд Хятадын нийт ажиллах хүчтэй харьцуулахад 65 буюу түүнээс дээш настай хүмүүс бичиг үсэггүй буюу хагас бичиг үсэгтэй байх магадлал зургаа дахин их, тэдний дөнгөж аравны нэг нь ахлах сургууль эсвэл коллежийн дипломтой байв. Мөн тэд хөдөө аж ахуйн салбарт хөдөлмөрлөж байх магадлал хамаагүй их бөгөөд 2000 онд Хятадын өндөр настай ажилчдын 87 хувь нь, харин нийт ажиллах хүчний 66 хувь нь хөдөө аж ахуй эрхэлж байв¹¹. Тус улсын эдийн засгийн бага орлоготой салбаруудад ажиллах үүрэгтэй, хүний нөөцийн чадавхийн доогуур түвшинд хөдөлмөр эрхэлж буй Хятадын өндөр настай ажиллах хүчин нь сурах бичигт заадаг ядуу тарчиг ажиллагсад хэмээх тодорхойлолтын бодит жишээ болж байна.

Одоогоос хорин жилийн дараа Хятадын өндөр настны бүлгийг бүрдүүлэх хүмүүсийн боловсрол эзэмшилтийн байдлын тухай одоо байгаа тоон мэдээллээс харахад, Хятадын боловсролын салбарт гарч буй ахиц дэвшлийг эс тооцвол, 2025 онд өндөр настай байх хүн амын хувьд ноцтой хүндрэл учрахаар байна.

Бауман, Граф (2003) нарын судалгаанд 2000 оны насны бүлгүүдийн байдлыг үзүүлсэн нь 2025 оны ирээдүйн өндөр настнуудын бүлэгт хамаатай буюу өөрөөр хэлбэл, 2000 онд 35 настай байгаа хүмүүсийн тоо 2025 онд 60-тай хүмүүсийн тоо болно гэсэн үг. Эдгээр тоо баримтаас үзэхэд, 2025 онд Хятадын өндөр настай иргэдийн тавны хоёр нь бага сургуулийн буюу түүнээс доош боловсролтой байна. Энэ байдал нь өнөөдрийн

өндөр хөгжилтэй орнуудын хэтийн төлвөөс эрс ялгаатай байна: жишээлбэл, 2025 онд Япон, АНУ хоёрт хоёуланд нь 65-аас дээш насны хүн амын зургааны тав орчим нь дор хаяж ахлах сургуулийн дипломтой байх юм.

2025 онд Хятадын эдийн засагт бүтцийн эрс өөрчлөлт гарахгүй бол хөдөө аж ахуйн салбар Хятадын ажил эрхлэлтийн цорын ганц томоохон эх сурвалж хэвээр байж, тариалангийн талбай дээр тус улсын боловсрол муутай, ур чадвар багатай өндөр настай ажилчид илүү их ажиллах, тэнд ажиллах гол үүрэгтэй байх магадлалтай байна.

Хятадад хөдөө аж ахуй эрхлэнэ гэдэг бол цалин хөлс багатай төдийгүй эцэс төгсгөлгүй, биеийн хүч шаардсан, хүнд хүчир ажил байдгийг санах хэрэгтэй. Барууны хүмүүсийн хувьд биеийн хүч хөдөлмөр шаарддаггүй ажил мэргэжлийг хүртэл Хятадад хийж гүйцэтгэхэд тэсвэр тэвчээр, булчингийн хүч чадал байнга шаарддаг байна. Үүнийг учрыг олоход амархан, яагаад гэвэл үйлдвэрлэлийн явц дахь хүн хүчний зарцуулалтыг хэмнэж, хөдөлмөр хөнгөвчилсөн хувилбараар хангахад чиглэсэн нэг ажилчинд ноогдох капиталын хөрөнгө оруулалт Хятадад дутагдалтай хэвээр байна. Барууны орнуудыг бодвол Хятадад механикжуулалт хамаагүй хязгаарлагдмал явагдсан учраас өнөөдрийн Хятадын эдийн засгийг хөдөлгөж байгаа машинууд бол хүний бие махбодь бөгөөд ирэх хорин жилд энэ байдалд мэдэгдэхүйц өөрчлөгдөх магадлал багатай байна.

Яах ч аргагүй Хятадын өндөр настай ажилчид нийт ажиллах хүчнээ бодвол боловсрол, сургалт муутайгаас хохирч байгаа учраас шууд биеийн хүчний хөдөлмөрт найдаж амьдрахаас өөр аргагүй хэсэгт орж байна. Энэ байдал өнөөдөр ч, маргааш ч бодитой хэвээр байх болно.

Энэ нь биднийг Хятадад нүүрлэж буй насжилтын асуудлын нэг онцлог болсон өнөөх гурван давхар хүлээсийн гурав дахь уяанд авчирч байна: ирэх жилүүдэд Хятадын өндөр настай иргэд хөлсний ажил, ялангуяа бага хөлстэй, биеийн хүч хөдөлмөр шаардсан ажил хийх замаар амьдралаа залгуулах бодитой бөгөөд магадгүй улам бүр өсөн нэмэгдэх дарамт шахалттай тулгарах магадлалтай төдийгүй хөгшин, залуу ялгаагүй биеийн хүч шаардсан ажил эрхлэх шаардлага хамаагүй бага байдаг бусад орны өндөр настнуудтай харьцуулахад тэд илүү эрүүл мэнд муутай, сул дорой байх талтай байна.

Эндээс үүдэн Хятадын өндөр настай иргэдийн эрүүл мэнд барууны орнуудын өндөр настай хүн амынхаас илүү сул дорой байна гэж батлахад бид гайхах шаардлагагүй. Эцсийн эцэст, бусад насжилтад нэрвэгдсэн орнуудыг бодвол Хятадын өндөр настай иргэд дунджаар бодоход амьдралынхаа туршид эрүүл мэнд, хоол тэжээлийн дутагдлын эрсдэлд илүү их өртсөн, тэдэнд өвчин зовлон, гэмтэл бэртлээс өөрсдийгөө хамгаалах буюу илаарших боломж харьцангуй бага байна. Ерөнхийдөө, эрүүл мэндийн байдалд нөлөөлдөг олон хүчин зүйлсийг дурдахгүйгээр, зөвхөн Хятад дахь хоол хүнс, орон байр, сургууль, эмнэлгийн үйчилгээний хангамж, чанарын үзүүлэлтийг авч үзэхэд л ЭЗХАХБ-ын түвшинтэй огт харьцуулшгүй байна. Үүний уршгаар, Хятадын өндөр настай иргэд ЭЗХАХБ-ын орнуудын настай хүмүүсээс богино насалдаг бөгөөд үлдэх амьдралын хугацаанд нь эрүүл мэндийн ноцтой асуудлууд хүнд дарамт учруулж аргагүй аюул занал болдог байна.

Энэ байдлыг Хятад, Япон улсуудад 65 насандаа хөгжлийн бэрхшээлгүйгээр цаашид амьдрах боломжийн тухай тооцоо харуулж байна.

Хүснэгт 3: 65 наснаас цааших дундаж наслалт ба хөгжлийн бэрхшээлгүй дундаж наслалт: Японы 1990 оны үзүүлэлтийг Хятадын 1987 оны үзүүлэлттэй харьцуулсан байдал

	ДН (жил)	ХБДН (жил)	Зөрүү (жил)	ХБДН/ДН (хувь)
Эр, Хятад 1987	12.5	8.9	3.6	71
Эр, Япон 1990	16.2	13.8	3.4	85
Эм, Хятад 1987	14.6	9.9	4.7	68
Эм, Япон 1990	20.0	15.9	4.1	80

Эх сурвалж: Сайто нар, 2003, хуудас 289-317.

Хэдийгээр эдгээр тоо баримтыг 1990 оны тооллогоос авсан боловч хэв шинж нь одоо ч хэвээр хадгалагдаж байна. Эрэгтэй, эмэгтэй хүмүүс ялгаагүй Японы 65 настангуудын дундаж наслалт Хятадынхаас 50 гаруй хувь илүү байна. Хятадын эрэгтэйчүүд үлдсэн амьдралынхаа бараг гуравны нэгтэй тэнцэх хугацаанд хөгжлийн бэрхшээлд орох төлөвтэй байгаа нь япон эрэгтэйчүүдийнхээс хоёр дахин их байна. Үүний нэг адилаар, Хятадын эмэгтэйчүүд амьдралынхаа сүүлийн жилүүдийн гуравны нэгд нь хөгжлийн бэрхшээлтэй болох төлөвтэй байхад Японы эмэгтэйчүүдийн хувьд энэ хугацаа

тавны нэг орчим байна. Цаашилбал, юуны өмнө, Хүснэгт 3-т зөвхөн хөгжлийн бэрхшээлд орох асуудлыг авч үзээд эрүүл мэндийн бусад өргөн хүрээтэй ноцтой асуудлуудыг хамруулаагүй, хоёрдугаарт, энд орсон хөгжлийн бэрхшээлийн тухай тоон мэдээлэл өөрийгөө үнэлэх үнэлгээнд тулгуурласан бөгөөд орлогын болон боловсролын түвшин доогуур хүн амын эрүүл мэндээ үнэлсэн субъектив үнэлгээ доогуур байх хандлагатай байдаг зэргийг харгалзан үзвэл Хятадын өндөр настнуудын өглөхдөө эрүүл мэндээр доройтох байдлыг Хүснэгт 3-т нилээд дутуу үнэлсэн байж болно.

Дүгнэж хэлэхэд, Хятад улсын хүн амын насжилтын дүр төрхийг зарим талаар аль хэдийн эхэлчихээд алгуур нүүрлэж буй хүмүүнлэгийн эмгэнэлтэй адилтгаж болох юм. Одоогийн энэ байдлаараа, улам бүр амжилттай гарч ирж буй шинэ зах зээлийг эс тооцвол, Хятад дахь хөгшрөлт нь, гуйлын ядуу, дутагдаж гачигдсан амьдралтай, биеийн хүчний хүнд хөдөлмөр, өвчин зовлон, хөгжлийн бэрхшээлд орохоос өөр аргагүй байгаа хэдэн арван сая ирээдүйн өндөр настанд заналхийлж байна. Өнөөгийн чиг хандлагын дагуу хувь хүмүүст тохиолдож буй золгүй явдлууд хангалттай их газар авсан байгаа нь насжилтын ядуурал ирэх жилүүдэд Хятадын нийгмийн нэг гол асуудал болон гарч ирж болохоор байна. Цаашилбал, нүүрлэн буй насжилтын ядуурлын согогтой байдал нь Хятадад хэдийн тэмцэж эхлээд байгаа нийгмийн тэгш бус байдлыг улам гүнзгийрүүлэх төлөвтэй байна.

Ийнхүү насжилтын ядуурлаас үүдсэн нийгэм, улс төрийн хурцадмал байдлыг тус улс хэрхэн авч шийдвэрлэхийг харах л үлдэж байна. 1997 оноос хойш Бээжингийн бодлого боловсруулагчид энэ асуудлыг хүлээн зөвшөөрч байгаа боловч хариу арга хэмжээ авалгүй хойш тавьсаар байна. Ийнхүү асуудлыг шийдэлгүй хойш тавьж байгаа жилүүдэд байж болох бодлогын сонголтуудын хүрээ хумигдаж, үлдэж байгаа хувилбарууд нь цаашид улам бүр өндөр үнэ өртөгтэй тусах нь нилээн тодорхой болоод байна.

Оросын Холбооны Улс: Эрүүл бус насжилттай хөгшрөлт

Зарим талаар Оросын хүн амын насжилтын дүр төрхийг Европын жирийн нэг үлгэр түүх мэт үзэж болох бөгөөд ирээдүйд тус улсын хүн амын бүтцэд гарч болох өөрчлөлтүүд өөрөө ийм сэтгэгдэл төрүүлж байна.

2000-2025 онд Оросын нийт хүн амын тоо буурах төлөвтэй бөгөөд 65 ба түүнээс дээш настай иргэдийн тоо бодитойгоор өсөх хандлагатай байна (Бүдүүвч 3). Үүний үр дүнд Оросын хүн амаа тэтгэх харьцаа (ХАТХ)-ны үзүүлэлт буюу ажиллах насны (15-64 нас) хүн амыг тэтгэврийн насны (65-аас дээш) хүн амьтай харьцуулсан харьцаа энэ 25 жилийн турш 5.5:1-ээс 3.3:1 болж буурна гэсэн АНУ-ын Тоооллогын Товчооны хэтийн тооцоо гарчээ.


Тодруулбал, 2025 оны Оросын ажиллах хүчинд тэтгэврийн настнуудын үзүүлэх боломжит ачаалал орчин үеийн стандартаар өндөр боловч ийм харьцаа нь 2025 оны босгон дээр ирж буй Европын хувьд жирийн зүйл байх болно. Тооллогын Товчооны хэтийн тооцоогоор, 2025 онд нийт Европын хэмжээгээр ХАТХ 3.0:1 орчим байх бөгөөд энэ нь Орос улс тус тивийн бусад хэсгийг бодвол ажиллах насны ба тэтгэврийн насны хүн амын харьцаагаараа арай өндөр байхыг харуулж байна. Үнэн хэрэгтээ, 2025 онд Оросын 65 ба түүнээс дээш настай хүн амын эзлэх хувь Америкийнхаас арай өндөр, Баруун Европынхоос арай доогуур байх төлөвтэй байна (Бүдүүвч 4).

Иймээс Оросын ирээдүйн насжилтын онцлогыг хөгжилтэй орнуудынхтай адил хэмжээнд дүрсэлж, тус улсын насжилтын хүндрэл бэрхшээлийг ЭЗХАХБ-ын гишүүн Европын орнуудынхтай төстэйгээр төсөөлөх сонирхол төрөх биз. Гэвч, ирэх жилүүдэд Оросын нийгмийн үүрэх насжилтын ачааллын хэмжээг дан ганц хүн амын пирамид эсвэл хүн амаа тэтгэх харьцаагаар хангалттай хэмжиж чадахгүй. Орос улс хүн амын насжилтад онцгой эмзэг өртөмтгий байгаа нь үндэсний хэмжээний нийт ирээдүйн өндөр настнуудын тооноос тийм ч их хамаарахгүй, харин тэднийг тэжээн тэтгэх ажиллах хүчин онцгой сул дорой байгаад оршино.

Энхийн цагт аливаа аж үйлдвэржсэн нийгэмд нийтийн эрүүл мэнд урт удаан хугацаагаар илт *доройтно* гэдэг бол орчин үеийн хандлагаар авч үзвэл маш гаж буруу буюу үнэн хэрэгтээ төсөөлж байснаас ч эсрэг зүйл юм. Гэсэн хэдий ч, 1961-1962 оноос 2000 оныг хүртэлх дөчин жилийн хугацаанд Орост дундаж наслалт эрэгтэйчүүдийн хувьд бараг таван жилээр буурсан, мөн эмэгтэйчүүдийн хувьд бага зэрэг буурсан нь сүүлийн дөчин жилд дундаж наслалтын ерөнхий түвшин гурав орчим жилээр буурахад хүргэсэн байна.


1960-аад оны дунд үе ба 21 дүгээр зууны эхэн үеийн хооронд Орост насаар стандартчилсан

Бүдүүвч 3: Оросын хүн амын бүтцийн одоогийн байдал ба хэтийн тооцоо: 2000 он ба 2025 оны харьцуулалт




Эх сурвалж: Нэгдсэн Үндэсний Байгууллага, 2004, онлайн хаяг: <http://esa.un.org/unpp/index.asp?panel=2>, 2005 оны 3 дугаар сарын 4-нд хандсан.

Бүдүүвч 4: 65-аас дээш настай хүн амын эзлэх хувийн одоогийн байдал ба хэтийн тооцоо: АНУ, Орос, Баруун Европ, 1975-2025.



Эх сурвалж: АНУ-ын Тооллогын Товчоо, 2004, онлайн хаяг: <http://census.gov/ipc/www/idbnew.html>, 2005 оны 5 дугаар сарын 10-нд хандсан.

Бүдүүвч 5: Эрэгтэйчүүдийн дундаж насалт: Орос ба Энэтхэгийн дэд тивийн харьцуулалт, 1989-2025.



Эх сурвалж: АНУ-ын Тооллогын Товчоо, 2004, онлайн хаяг: <http://census.gov/ipc/www/idbnew.html>, 2005 оны 1 дүгээр сарын 19-нд хандсан.

нас баралтын хувь эмэгтэйчүүдийн хувьд 15 хувиар, эрэгтэйчүүдийн хувьд цочирдмоор их буюу 40 хувиар нэмэгдсэн байна. Нас баралт ийнхүү нэмэгдэх явдал нэн ялангуяа ажиллах насны хүн амын бүлэгт төвлөрч байсан бөгөөд энд нас баралтын өсөлт ер бусын өндөр байв. Жишээлбэл, 1970-1971 ба 2003 оны хооронд 25-59 насны эмэгтэйчүүдийн бүлэг бүрт нас баралтын хувь дор хаяж 40 хувиар өссөн байхад, 30-64 насны эрэгтэйчүүдийн хувьд энэ тоо жигд 50 хувьд хүрснээс зарим тохиолдолд 80 хувиас давсан байна¹².

Оросын насанд хүрэгчдийн хувьд өнөөгийн эрүүл мэнд ба нас баралтын байдал хэр муу байгааг харуулах үүднээс Хүний нас баралтын мэдээллийн санд¹³ нэгтгэгдсэн мэдээллийн ачаар Швейцарийн эрэгтэйчүүдийн амьдрах магадлалыг 1999 оны Оросын холбогдох үзүүлэлттэй харьцуулж үзэж болох юм. Швейцарт 20 настай эрэгтэй хүмүүсийн 6 хүний 5 нь 65 хүртэл наслах магадлалтай байхад Орост ийм магадлал тавиас доош хувьтай байна¹⁴.

Хэрвээ Оросын насанд хүрэгчдийн нас баралтын түвшин өнөөдөр ийм хэвийн бус өндөр байгаа юм бол ирэх хэдэн арван жилд их бага ямар нэг хэмжээгээр илүү хэвийн түвшинд дахин хүрэхгүй гэж үү? Үүнд өгөх урам хугалам хариулт гэвэл: Оросын хүн ам зүйн хувьд ийм гаж байдал шинэ норм болоод

тогтчихсон мэт байгаа учраас заавал ийм байх албагүй. Аж үйлдвэржсэн ертөнцийн бусад хэсэгтэй адилгүй нь Оросын эрүүл мэндийн чиг хандлага сөрөг хөдөлгөөн гэж хэлж болохоор хүнд хэмжүүрээр тодорхойлогдож байна. Өөрөөр хэлбэл, өнөөгийн насанд хүрсэн хүн амд тэдний эцэг эхийн үетэй харьцуулахад илүү тааламжгүй байдлаар дархлаажуулалтын хомсдол, эрүүл мэндийн эрсдэл хуримтлагдаад байна. Нас баралтын хувь нь эрүүл мэндийн ерөнхий нөхцөл байдлыг нотлон харуулахын хэрээр, шинээр бий болж буй хүн амын бүлэг бүр өмнөх үеийнхээсээ сул дорой болж байгааг орчин үеийн Оросын нас баралтын тоо баримтууд тод харуулж байна.

Дайны дараахь үеийн барууны аж үйлдвэржсэн бусад оронд залуу хойч үеийнхэн өмнөх үеийнхээ бодвол амьдрах магадлал тогтмол өндөртэй байдаг болоод байна. Жишээлбэл, 1950 онд төрсөн орчин үеийн япон хүн насанд хүрсэн амьдралынхаа туршид 30 хувиас 80 хувь хүртэл насны онцлогтой нас баралтын хувийг туулж өнгөрөөсөн байгаа нь тэднээс 20 жилийн өмнө төрсөн насны бүлгийнхний үзүүлэлтээс доогуур байна.

Үүний эсрэгээр, 1920-иод оны сүүл үе ба 1970 онд төрсөн орос эрэгтэйчүүдийн хоёр үеийн хоорондын амьдрах магадлалын хуваарьт ямар нэг сайжралт гараагүй байна. Нөгөө

талаас, Оросын эрэгтэйчүүдийн насны бүлэг бүр амьдралынхаа туршид түүний яг өмнөх үеийнхнээ бодвол нас баралтын хувьд арай хар бараан зам туулсан дүр зураг гарч байгаа бөгөөд энэ хэв шинж Оросын эмэгтэйчүүдийн дунд ч илэрсэн байна.

Энэхүү сөрөг хөдөлгөөн нь ялангуяа нийтийн эрүүл мэндэд томоохон, тогтвортой сайжруулалт хийх зорилтыг улам хүндрүүлж байна. Энэ шалтгаанаас зарим талаар хамаарч, хүн ам зүйчдийн хувьд ойрын жилүүдэд Оросын эрүүл мэндийн байдалд ахиц дэвшил гарна гэсэн хүлээлт ерөнхийдөө бага болсон байна. Тухайлбал, АНУ-ын ТТ-ны тооцоогоор, 2025 он хүртэлх хугацаанд Орос дахь эрэгтэйчүүдийн дундаж наслалт тууштай буурч, Энэтхэг, Пакистан, тэр ч байтугай Бангладешийнхээс бага байх ажээ (Бүдүүвч 5)¹⁵.

Орост эрүүл мэнд, нас баралтын хямрал ужгирч байгаа нь эдийн засгийн хурдацтай хөгжилд ихээхэн саад тоггор учруулж, улмаар хурдтай, тогтвортой материаллаг хөгжил дэвшлийн замаар замнах гэсэн тус улсын хүчин чармайлтыг боож хааж байна. Хэрэв Оросын ажиллах хүчин Энэтхэгийн хэмжээний эсвэл түүнээс дор амьдрах магадлалтай хэвээр байх юм бол ирээдүйд хэзээ нэгэн цагт Ирландын хэмжээний амьжиргааны түвшинд хүрнэ гэж төсөөлөхөд хэцүү юм. Хөдөлмөрийн насны бүлгүүдийн дотор сул дорой байдал, цаг бус нас баралт газар авах нь эдийн засгийн чадамжийг шууд тэр дор нь доройтуулахын зэрэгцээ урт хугацааны бүтээмжид сөрөг бөгөөд алс хэтийн уршигтай нөлөө үзүүлдэг. Хөдөлмөрийн насны амьдрал ноцтойгоор багасах тухай хүлээлт нь хүний нөөцөд оруулах хөрөнгө оруулалтыг багасгаж, дээд боловсрол, техник мэргэжлийн сургалтын зардал-үр ашгийн тооцоог өөрчилдөг. Тэгвэл Оросын хөдөлмөрийн насны насанд хүрэгчид барууны орнуудын үе чацуутнуудаас хамаагүй хөгшин харагдах учраас¹⁶ эдийн засгийн хувьд идэвхтэй насжилтын энэхүү өргөн цар хүрээ нь (өөрөөр хэлбэл, дунд ба түүнээс дээш насны хүмүүсийн ажиллах хүчний тоонд орж, эдийн засагт хувь нэмэр оруулах талаасаа) Орос улсад ЭЗХАХБ-ын гишүүн Европын орнуудынхаас хамаагүй илүү дарамт учруулах болно.

Эрүүл бус наслалтын нөхцөл дэх хүн амын насжилт нь Оросын хувьд тодорхой нийгэм, эдийн засгийн нэмэлт сорилт бэрхшээлүүд авчирч байна. Өнөөдөр тус улсын насны онцлогтой эрүүл мэндийн байдал огцом бөгөөд аюултай хазайлттай, ирэх хорин жилд

эрүүл мэндийн байдал сайжрах хэтийн төлөв хязгаарлагдмал, Оросын хөдөлмөрийн насны хүн ам насжих төлөвтэй байна (2025 онд 15-64 насны бүлгийн хүн амын голч нас 42 орчим байх нь өнөөдрийнхөөс 3.5 жилээр их байна) гэдэг бол үнэндээ Оросын хүн хүчний эрүүл мэнд, нас баралтын дүр зураг өнөөдрийнхөөс тааламжгүй, магадгүй бүр илүү дор байх боломжтой гэсэн үг. Хоёрдугаарт, өндөр настай тэтгэврийн насны хүн амын хүрээ өргөжиж¹⁷, тэд эрүүл бус бөгөөд улам бүр цөөрч буй бага орлоготой ажилчдын дэмжлэгт найдан амьдарна гэдэг нь сайн сайхан байдал ба өсөлтийн хооронд зарим нэн тааламжгүй харьцаа байгааг харуулж байна.


Энэхүү ирээдүй муутай дүр төрх нь, Оросын нөөц баялгийг капитал хуримтуулахад сайтар хуваарилан зарцуулах уу, эсвэл бүтээлч бус өндөр настнуудын хэрэглээнд зориулах уу? гэсэн нэгэн муу ёрлосон асуулт тавихад хүргэж байна. Оросын хүн амын бүтцийн байдлаас үзэх юм бол энэ асуултыг амархан шийдэж чадахгүй. 2002 оны байдлаар Орос улсын нэг тэтгэвэр авагч тутамд 1.7-хон ажилчин ноогдож байсан¹⁸ бол энэ харьцаа ирэх жилүүдэд улам буурах болно. Нэг талаас, хөрөнгө оруулалтын сангийн бэлэн байдлын хувьд, нөгөө талаас Орост тогтмол өсөн нэмэгдэж буй өндөр настан, хөгшдийн амжиргааны нөхцөл байдлын хувьд эцэстээ ямар арга хэмжээ авагдах нь одоогоор нээлттэй асуулт хэвээр үлдэж байна.

Энэтхэг дэх насжилт: Хоёр улсын нэг түүх

Энэтхэгийн хүн амын байдал ирэх хорин жилд насжих боловч ямар ч байсан харьцангуй залуу хэвээр байх болно. Энэ байдал нийт мэдээлэлтэй уншигчид, бодлого боловсруулагчдад ойлгогддог бөгөөд тус улсын хүн амын бүтцэд гарах цаашдын өөрчлөлтүүдээр батжиж байна. Хэдийгээр Энэтхэгийн 65-аас дээш насны бүлэг 2005-2025 онд хэмжээгээрээ хоёр дахин нэмэгдэх хэтийн тооцоотой байгаа ч эдгээр өндөр настан 20 жилийн дараахь нийт хүн амын 8 хүрэхгүй хувийг эзлэх юм. Түүнчлэн тус улсын голч нас дөнгөж 30 гаруй, ХАТХ нь бараг 9:1 байгаа нь өнөөдрийн өндөр хөгжилтэй орнуудад хамгийн сүүлд Дэлхийн II дайны өмнө гарч байсан түвшин юм (Бүдүүвч 6).

Гэвч Энэтхэг орон бол олон талаар түүний асар том нутаг дэвсгэрийн маш олон янзын хэсгүүдийн нийлбэрийг дундажласан арифметик илэрхийлэл байдаг шиг хүн амын насжилт нь ч бас тийм байдаг. Нарийн судалж

Бүдүүвч 6: Энэтхэгийн хүн амын бүтцийн одоогийн байдал ба хэтийн тооцоо: 2000 ба 2025 он



Эх сурвалж: АНУТТ, 2004, онлайн хаяг: <http://www.census.gov/ipc/www/>

үзвэл, хүн амын насжилтын хувьд бодит байдал дээр шал өөр насжилтын хэтийн төлөв, сорилт бэрхшээл бүхий хоёр Энэтхэг улс байна: нэг нь ирэх 20 жилд гайхалтай залуу хэвээр үлдэх хэсэг, нөгөө нь маш хурдан хөгширч эхэлсэн хэсэг байна.

Дээр дурдаж байсанчлан, ирээдүйн насжилтын явц, цар хүрээ нь дотоодын төрөлтийн өнөөгийн түвшнээс ихээхэн хамаардаг. Сүүлийн гучин жилд Энэтхэгийн төрөлтийн нийт хувь тавны хоёр хувиас илүүгээр унаж, 1970-аад оны эхээр нэг эмэгтэй амьдралынхаа туршид дунджаар 5.4 удаа төрдөг байсан бол өнөөдөр ойролцоогоор 3.1 болсон байна. Гэвч өөрчлөлтийн явц нэг мужаас нөгөө мужид, нэг орчноос нөгөө орчинд гайхмаар харилцан адилгүй байна. Өнөөдөр Шинэ Дели, Мамбай (Бомбей), Калката (Калкутта), Ченнай (Мадрас) зэрэг Энэтхэгийн олон томоохон хотод нөхөн үржвэр муутай төрөлт давамгайлж байгааг зарим уншигчид мэдээд гайхах болно¹⁹. Бүр гайхалтай нэг зүйл бол өнөөдөр Энэтхэгийн хөдөөгийн нилээд нутгийн хэмжээгээр, ялангуяа өмнөд Энэтхэгийн хөдөөд, төрөлтийн түвшин нөхөн үржих хэмжээний орчим буюу түүнээс доогуур хэмжээнд хэдийн оржээ.

Мужийн хил хязгаараас давсан өргөн хүрээтэй бүс нутгууд дахь ирээдүйн насжилтын эдгээр ялгавартай хэв шинжүүдийн утга

агуулгыг Делигийн Их сургуулийн Эдийн засгийн өсөлтийн институтын доктор П.Н.Мэри Бхат «хойд» Энэтхэг, «өмнөд» Энэтхэг хоёр хэмээн нэрлэсэн байна²⁰. Энэхүү хойд талын бүс нутгийн бараг хагас тэрбум орчим хүний төрөлтийн өнөөгийн (2005) түвшин өмнөд бүс нутгийн 250 сая орчим хүнийхээс бараг хоёр дахин өндөр байна²¹. 2025 он гэхэд хойд Энэтхэгийн хүн ам залуу хэвээр байх юм.

Энэтхэгийн голч насны хэтийн тооцоо дөнгөж 26 нас байх, 65-аас дээш насны бүлгийн эзлэх хувь нийт хүн амын 6 хүрэхгүй хувь байх төлөвтэй байна. Нөгөө талаас, 2025 онд өмнөд Энэтхэгийн хүн амын бүтцэд насжилтын гарцаагүй шинж тэмдгүүд илрэх болно.

Өмнөд хэсэгт, голч нас 34 орчим байх нь 1980-аад оны Европын түвшинтэй ойролцоо, 65 буюу түүнээс дээш настай хүн амын эзлэх хувь 9 хувь байх нь 1980 оны Японы түвшинтэй бараг ижил байна.

Мэри Бхат 2025 он хүртэлх хэтийн тооцоогоо мужийн түвшинд задалж гаргаагүй боловч Лондоны Эдийн засгийн сургуулийн профессор Тим Дайсон Энэтхэгийн энэ тооцоог 2026 оны байдлаар хийсэн байна²². Түүний хийсэн хэтийн тооцоо зарим нарийн ширийн зүйлээрээ Мэри Бхатынхаас ялгаатай байгаагийн хамгийн чухал нь дараагийн үеийн турш төрөлт арай илүү хурдан буурна гэж

үзсэн явдал юм. Гэвч түүний тооцоонд хойд ба өмнөд Энэтхэгийн хоорондын насжилтын зөрүү нэмэгдэж байгааг Бхатынхтай ижил төстэй байдлаар харуулсан бөгөөд 2026 он гэхэд өмнөдийн олон мужид нилээд насжилт явагдсан байх ажээ. Энэтхэгийн хамгийн өмнөд захын дөрвөн мужид голч нас 35 гаруй байх бөгөөд Керала, Тамил Наду хоёр мужид хоёуланд нь 37-гоос дээш байх юм. (Эдгээр тоо нь 1990-өөд оны үеийн Баруун Европынхтой ойролцоо байна.) Эдгээр хэтийн тооцоонд, 2025 он гэхэд 65 ба түүнээс дээш настай хүмүүсийн эзлэх хувь Керала, Тамил Наду хоёрт хоёуланд нь 10 хувиас дээш байна. (Энэ тоо 1980-аад оны дунд үеийн Японыхтой харьцуулагдахаар байна.)

Гэхдээ голч нас нь 35 хүрэхээс нэг үеийн өмнө Баруун Европын нэг хүнд ноогдох ДНБ 6000-8000 ам.долларын хооронд (2000 оны үнэ, валютын ханшаар), үүний нэг адил Японы 65-аас дээш настнуудын нийт хүн амд эзлэх хувь 10 хувьд хүрэхээс нэг үеийн өмнө тус улсын нэг хүнд ноогдох ДНБ (2000 оны тогтмол валютын ханш ба үнээр) 7000 ам.доллар орчим байсан гэдгийг энд анхаарах хэрэгтэй²³. 2001 онд, өөрөөр хэлбэл дээрх хэтийн тооцоонд адилхан хүн ам зүйн онцлогтой байхаар орсон хоёр мужийн хувьд 25 жилийн өмнө, Керала, Тамил Наду мужуудад хоёуланд нь валютын ханшид тулгуурласан нэг хүнд ноогдох ДНБ-ний жилийн дүн 450 ам.доллараас бага байсан байна. Үнэн хэрэгтээ ямар ч олон улсын буюу түүхэн харьцуулалт хийсэн бай, Энэтхэгийн олон газар нэг хүнд ноогдох бүтээгдэхүүний сэтгэл түгшим доогуур түвшинд хүн амын огцом насжилтын үйл явцтай тулгарч байна.

Яг одоогоор Энэтхэгт нийгмийг хамарсан өндөр насны тэтгэврийн тогтолцоо гэгчихээр юм алга байна. Харин үүний эсрэгээр, Энэтхэгийн ажиллах хүчний дөнгөж 11 хувь нь ямар нэг төрлийн баталгаат тэтгэврийн орлогын системд хамрагджээ. (Энэтхэгт 60-аас дээш настай хүмүүст зориулсан онцгой нөхцөл байдлын, зайлшгүй хэрэгцээнд тулгуурласан сар тутмын нийтийн тэтгэлэг байдаг боловч энэ механизм нь тэтгэлэг хүртэгчид сард 2 ам.доллар хүрэхгүй хэмжээний мөнгө олгодог бөгөөд өргөдөл гаргаж, хүнд хэцүү шалгаруулалтыг давсан хүн бүрт олгогдох баталгаа бас байдаггүй.) Хэдийгээр Энэтхэгийн бодлого боловсруулагчид, эрдэм шинжилгээнийхэн сүүлийн жилүүдэд ноцтой байдлын нилээд өндөр түвшинд хүрээд байгаа бүх нийтийг хамарсан өндөр насны орлогын хамгаалалтын талаарх боломжит арга замуудын хувилбарыг

хэлэлцэж байгаа боловч үндэсний бодлогын хэлэлцэх асуудлын хэмжээнд тавигдахуйц бүх нийтийг хамарсан төлөвлөгөө байхгүй байна²⁴. Үндэсний хэмжээний өргөн хүрээтэй өндөр насны тэтгэврийн бодитой бодлого дутагдаж буй Энэтхэг улсын хувьд нүүрлэн буй насжилтын сорилт бэрхшээлүүдтэй тулгарах далд стратеги болядаж одоохондоо, үр нөлөөтэй арга хэмжээ авч чадахгүй ч түүнийг даван тулах зорилт тавих явдал юм. Хэлэхгүйгээр, улмаар харуулахгүйгээр хийдэг олон янзын тоглоомын төлөвлөгөөний нэг адилаар энэ арга тун ээдрээтэй байдаг. Тэр ч байтугай Япон улс нэг үе хөгжсөн шиг Энэтхэг улс нэг хүнд ноогдох орлого жилд 5.5 хувиар тогтвортой өсөөд байсан ч гэсэн, Энэтхэг улсын хүн амын ихээхэн хэсэг нь 1980-аад оны дунд үеийн Японыхоос бараг доогуур хэмжээний орлогын түвшинтэйгээр насжсан нийгмийн босгонд дөхөж ирэх юм.

Цаашилбал, Энэтхэг улс дараагийн үед нэг хүнд ноогдох өсөлтийн түвшинг 5.5 хувьд тогтвортой барьж чадна гэж хэлэхэд одоохондоо тун хэцүү байна. 1991 оны эдийн засгийн хямралын үеэс хойших хугацаанд Энэтхэг улсын нэг хүнд ноогдох орлогын жилийн өсөлт нилээд өндөр буюу дунджаар 4.0 байсан бөгөөд Банглог зэрэг газарт тусгай бүс байгуулах замаар дэлхийн МТ-ийн эдийн засагт гарч ирээд байв. Гэвч Банглог бол Энэтхэгийн өмнөд хэсгийн бусад газрын нэг адил удахгүй «хөгшин» Энэтхэг гэдгээр танил болох хэсэг юм. Өөрөөр хэлбэл, харьцангуй ур чадвартай боловч нас ахисан хүн хүчтэй байгаа нь удахгүй оргил үедээ ороод дараа нь буурах болно. Нөгөө талаас, Энэтхэгийн бусад хэсгүүд хүн хүчний элбэг дэлбэг, өсөн нэмэгдэх нөөцтэй байх боловч тэдний багагүй хувь нь нэг бол огт сургуульд хамрагдаагүй эсвэл дөнгөж бичиг үсэгтэй төдий байна.

Хүн ам зүйн Венагийн Институтын профессор Анне Гоужон, Оксфордын Киртси МакНэй нар Энэтхэгийн Керала, Бихар хоёр мужийн нас, хүйс, боловсролын пирамидын 2026 оны хэтийн тооцоог харьцуулж үзжээ²⁵. Тэд огт эсрэг тэсрэг байгааг харуулахыг зорьж байв. Керала Энэтхэгийн хамгийн боловсролтой муж бол Бихар сургуульд хамгийн бага хамрагдалттай муж. 2026 он гэхэд Кералад хөдөлмөрийн насны (15-64) бараг бүх хүн ямар нэг сургуульд хамрагдсан байх бөгөөд эдийн засгийн хувьд идэвхтэй хүн амын дийлэнх нь ахлах сургуулийн дипломтой буюу түүнээс дээр боловсролтой байх юм. Хүн амын

хамгийн том бүлэг нь 40-өөд насны хүмүүс, түүний дараахь бүлгүүд арай бага хэмжээтэй байна. Нөгөө талаас, 2026 онд Бихарт ажиллах хүчний санд орж буй шинээр төрсөн бүлэг бүр түүний өмнөх бүлгээс том байх боловч эдийн засгийн хувьд идэвхтэй хүн амын (15-64 нас) гуравны нэгд хүрэхгүй хувь нь дунд сургууль төгссөн байх юм. Түүнчлэн эдийн засгийн хувьд идэвхтэй хүн амын тавны хоёроос илүү хувь нь бичиг үсэггүй буюу ямар нэг сургуульд хамрагдаагүй байна. (Эдгээр хэтийн тооцоо нь Энэтхэг дэх боловсролын хамрах хүрээг өргөжүүлэх талаар 1990-өөд оны үед гаргасан ахиц дэвшлүүд ирээдүйд үргэлжлэн явагдана гэж төсөөлж байгаа гэдгийг энд тэмдэглэх нь зүйтэй.)

Одоогоос нэг үеийн дараа Энэтхэг улс боловсролын хувьд хэрхэн ноцтой дутагдалд орохыг харуулах үүднээс бид Гоужон, МакНэй нарын хэтийн тооцоог дэлхийн хэмжээний боловсрол эзэмшилтийн байдлын түүхэн хэв шинжийн тухай Роберт Ж.Барро, Жонг-Уха Лий нарын дээхэн үеийн бүтээлтэй харьцуулж болно²⁶. Гоужон, МакНэй нарын хэтийн тооцоогоор, 2026 онд Энэтхэгийн 25 ба түүнээс дээш настнуудын ойролцоогоор гуравны нэг (32 хувь) нь бичиг үсэггүй буюу ямар нэг албан ёсны сургуульд хамрагдаагүй байна. Гэтэл нөгөө талаас, 1960 оны байдлаар, өөрөөр хэлбэл өдгөөгөөс бараг гурван үеийн өмнө, ЭЗХАХБ-ын гишүүн 23 оронд 25-аас дээш насны бүлгийн бичиг үсэггүй байдлын түвшин 6 хувь орчим байв. Магадгүй бусад хөгжиж буй бүс нутгуудын боловсролын түвшинтэй харьцуулвал бүр их зүйл хэлж өгөх байх. Гоужон, МакНэй нарын хэтийн тооцоо, Барро, Лий нарийн тооцоогоор, 2026 оны Энэтхэгийн 25-аас дээш настнуудын бичиг үсэггүй байдлын хувь Латин Америк, Карибийн бүс нутаг эсвэл Зүүн Азийн 1970 он орчмын (тус тус 35 ба 31 хувь байсан) буюу бараг хоёр үеийн өмнөх түвшинтэй ерөнхийдөө ойролцоо байх юм. Үнэндээ, Энэтхэгийн насанд хүрэгчдийн бичиг үсэггүй байдлын хувь Африкийн Сахар орчмын дэд бүсэд зонхилж буй өнөөгийн (2000 он) түвшинээс (43 хувь) нэг их доогуур биш байж магадгүй гэвэл нэг их гайхмаар сонсогдохгүй байх.

Боловсролтой бөгөөд насжилттай, аль эсвэл боловсролгүй бөгөөд төрөлт сайтай гэсэн хоёр эрс тэс байдал ойрын ирээдүйд Энэтхэгийн хөгжлийн онцлог байх бололтой байна. Ирэх зууны эдийн засгийн хөгжлийн үндэс бол хүний нөөц байх боловч Оросын эмзэг сул тал нь хүний нөөцийн бааз суурийн эрүүл мэндийн

доройтол байхад, Энэтхэгийн хувьд тус улсын хүн амын нэг томоохон хэсэгт нийтээр боловсрол эзэмших боломж хангалтгүй байгаа явдал юм.

Хүн ам зүйн ноогдол ашиг хүлээгээд байна уу, эсвэл Годотыг хүлээсээр байна уу?


Ямар ч урьдын түүхэн туршлагагүйгээр орлогын ийм доогуур түвшинд тулгуурлан насжсан хүн амаа тэжээн тэтгэхээс өөр аргагүй болж байгаа ийм орнуудын жишээнд бүх шинээр төрөн гарч буй зах зээлтэй орнууд орохгүй нь мэдээж юм. Мексик, Бразил, Турк зэрэг дунд орлоготой орнууд шиг бусад олон орон 2025 он гэхэд харьцангуй залуу хүн амтай байх төлөвтэй байна.

Түүнчлэн, бүтээмжийн өнөөгийн түвшин, ирээдүйн эдийн засгийн хэтийн төлвийн боломжийн байдлыг харгалзвал, иймэрхүү олон орон ирэх хэдэн арван жилд хөгжиж дэвших явцдаа барууны орнуудын туулсан нас ба орлогын харьцааны хүрээнд багтах төлөвтэй байна. Тэд нэг хүнд ноогдох орлогын ижил түвшинд барууны орнуудын хүрч байсан насжилтын түвшинээс ч илүү залуу хэвээр үлдэж болно.

Харьцангуй залуу хүн амтай хөгжих тухайд эдийн засгийн онцгой үр ашиг гэж байна уу? Бараг хагас зуун жилийн өмнөөс эдийн засгийн ном сурах бичигт баттай байр суурь эзэлж ирсэн нэг үзлээр бол энэ асуултын хариулт зөвхөн насжилтаас бус, бас хөгшин, залуу бүх асран хамгаалуулагчдын тоо ба эдийн засгийн хувьд бүтээлч ажилчдын тооны харьцаанаас хамаардаг байна.


Энэ үзлийн дагуу, хүүхэд, хөгшдийн хөдөлмөрийн насны хүмүүсээс хамаарах харьцаа бага байх тусам капиталын хуримтлал ба өсөлтийн хувь өндөр байдаг байна. Хүн ам зүйн шилжилтэд нэгэн онцгой цаг мөч байдаг буюу тухайлбал, төрөлтийн хувь бага бөгөөд өндөр настнуудын тоо хараахан өсч эхлээгүй байх үед эдийн засаг маш хурдацтай өсч хөгжих тохиромжтой нөхцөл бүрддэг гэж орчин үеийн зарим эдийн засагчид үздэг. Энэ үзэл бодлоор бол, олон төрөлтөөс цөөн төрөлтөд дөнгөж шилжээд байгаа, хараахан их хэмжээний насжилттай тулгараагүй байгаа нийгмийн хувьд хүн ам зүйн ноогдол ашиг хүртэх байр суурь эзэлдэг байна. Энэ утгаараа, хүн ам зүйн бүтцэд гарсан чухал шилжилтүүд нь орчин үеийн асар их амжилттай хөгжлийн түүхүүдийн нэг салшгүй хэсэг болж байгаа

Бүдүүвч 7: Насны хамааралтай байдлын харьцаа*: Зүүн Ази, Номхон далайн бүс ба Латин Америк, Карибын бүс, 1960-2000 он



* Насны хамааралтай байдлын харьцаа бол 15-аас доош ба 65-аас дээш насны хүн амын тоог 15-64 насны хүн амын тоонд харьцуулсан харьцаа байдаг. Энд зөвхөн хөгжиж буй орнуудын тоон үзүүлэлтийг харуулав.
Эх сурвалж: Дэлхийн Банк, 2003.

Бүдүүвч 8: Хүн ам зүйн ноогдол ашиг уу? Нэг хүнд ноогдох ДНБ (ВХАЧ): Зүүн Ази, Номхон далайн бүс ба Латин Америк, Карибын бүс, 1975-2003 он



Эх сурвалж: Дэлхийн Банк, 2003.

жишээнд өнгөрсөн бүтэн хагас үеийн турш эдийн засгийн гайхамшигтай ахиц дэвшил гаргасан Зүүн Азиас эхлээд саяхан Европын бар болсон Ирланд улсын шилжилтийг дурдаж болно²⁷.

Хүн ам зүйн ноогдол ашгийн дүр зураг мэдээж үнэмшилтэй нь тодорхой. Энэ нь, хамааралтай байдлын харьцаа урт хугацаагаар буурч эхлэх гэж байгаа бага орлоготой нийгмүүдийн хувьд урам зориг өгч байж болно. Гэвч энэ явдал үнэн үү? Үнэн хэрэгтээ, хамааралтай байдлын түвшин нь тухайн хүн амын тогтвортой, хурдацтай материаллаг өсөлтөд шийдвэрлэх үүрэгтэй гэж үү?

Хөдөлмөрийн насны хүмүүсийн нийт хүн амд эзлэх хувь илүү их байгаа нийгэмд нэг хүнд ноогдох бүтээгдэхүүн өндөр байна гэсэн үүнтэй төстэй үзэл ч бас маргаангүй нь мэдээж юм. Хамааралтай байдлын түвшин янз бүр байх нь хуримтлалын харьцаа, эсвэл шулуухан хэлэхэд хүн амын хуримтлуулах сонирхлын ялгаатай байдал ба хуримтлал үүсгэхийг хичээхэд хялбар дөхөм байдалтай холбоотой байх үндэслэлтэй. Гэвч жинхэнэ дэлхий нийтийн капиталын зах зээлийн эрин үед тодорхой нэг газар хуримтлалын хувь харьцангуй доогуур байх нь тухайн газрын хөгжилд зайлшгүй дарамт үзүүлээд байх албагүй. Улам бүр даяаршиж байгаа манай үед буюу дэлхийн хоёр том бүс нутгийн хөгжлийн түүхэнд (нэг талаас Зүүн Ази, нөгөө талаас Латин Америк, Карибын бүс нутаг) хамааралтай байдлын харьцаанууд урт хугацааны эдийн засгийн байдалд шийдвэрлэх нөлөө үзүүлээгүй болохыг дайны дараахь үеийн эдийн засгийн хөгжлийн түүх харуулж байна. Үүнийг Бүдүүвч 8 ба 9-д нотлон харуулж байна.

1960-2000 оны хоорондын 40 жилийн турш Зүүн Ази, Латин Америк, Карибын бүс нутгийн бага орлоготой орнуудын хамааралтай байдлын харьцаа нилээд төстэй даялалаар өөрчлөгдсөн боловч Зүүн Азид энэ харьцаа ямагт ямар нэг байдлаар доогуур байлаа. Сүүлийн дөчин жилийн турш дээрх хоёр бүс нутгийн үзүүлэлтүүдийн хооронд ямагт ойролцоо харьцаатай байсныг эс тооцвол эдийн засгийн үр дүнгийн хувьд ижил төстэй байгаагүй нь тодорхой: нэг хүнд ноогдох бүтээгдэхүүн Зүүн Азид долоо дахин нэмэгдсэн бол Латин Америк, Карибын бүсэд 85 орчим хувиар өссөн байна. Түүнчлэн, хоёр бүс нутагт хоёуланд нь хамааралтай байдлын харьцаа 1975 оны үеэс хойш тогтмол буурч эхэлжээ. Энэхүү бууралтын дараахь 25 жилийн турш Зүүн Азийн

өсөлтийн хурд хурдассан бол Латин Америкийн өсөлт удааширсан байна. Хамааралтай байдлын харьцаа өндөр байх үед (1960-1975) Латин Америкийн нэг хүнд ноогдох бүтээгдэхүүний дундаж жилд бараг 3 хувь орчим байсан бол энэ харьцаа тогтвортой буурсан жилүүдэд (1975-2003) нэг хүнд ноогдох жилийн өсөлт 1 хувь ч хүрэхгүй байлаа. Иймээс бусад хүчин зүйлс, түүний дотор засгийн газрын бодлого, материаллаг хөгжил дэвшлийн ирээдүйг тодорхойлоход илүү чухал нь тодорхой байна.

Энэтхэгийн эдийн засгийн өсөлтөд хүн ам зүйн ноогдол ашиг нөлөө үзүүлсэн байх боломжийг нарийвчлан үнэлсэн Мэри Бхатын үнэлгээг бусад бага орлоготой газруудад ч хамааруулж болох юм:

... дараагийн 10-20 жилд хүн ам зүйн нөхцөл байдал өсөлтөд таатай нөлөө үзүүлж болно... Гэхдээ, Блүүм, Уиллиамсон нарын тэмдэглэсэнчлэн зайлшгүй нөлөө үзүүлэх албагүй. Үр нөлөөг нь гаргахын тулд зохих эдийн засаг, нийгэм, улс төрийн институциуд болон бодлогуудаар дэмжих зайлшгүй шаардлагатай. Эс тэгвэл зөвхөн ажилгүйдлын түвшин нэмэгдэхэд хүргэнэ²⁸.

Хамааралтай байдлын харьцаа буурч байгаа орнууд зохих соёлын, институцийн болон бодлогын нөхцөл байдалд эдийн засгийн давуу тал эдлэх боломжтой байж болно. Гэвч хүн ам зүйн ноогдол ашиг бол найдах зүйл огт биш юм.

Дэлхий дахины хэмжээний утга агуулга

Бусад бүх зүйл хэвээрээ байхад буюу ямар нэг идэвхтэй бодлогын болон институцийн зохицуулалт хийгдэхгүй бол, дараагийн үед ЭЗХАХБ-ын холбогдох орнуудыг хүлээж байгаа нь тодорхой болсон хүн амын насжилтын асуудал дотоодын хуримтлалын хувь төдийгүй эдийн засгийн өсөлтийн хурдцад хүнд дарамт үзүүлэх төлөвтэй байна. Мөн дараагийн хэдхэн арван жилийн дотор шинээр төрөн гарч буй томоохон зах зээлүүдийн заримд нь ноцтой нөлөө үзүүлэх төлөвтэй байгаа насжилтын чиг хандлагын хувьд ч мөн иймэрхүү зүйл нилээд ярьж болох байна. Дэлхийн өндөр хөгжилтэй орнууд ба хөгжиж буй ертөнцийн чухал чухал хэсэгт ийнхүү хүн амын насжилт давхцаж байгаа нь түүний дэлхий дахины хэмжээнд үзүүлж болох боломжит нөлөөний талаар өөрийн эрхгүй асуухад хүргэдэг. Дэлхийн капиталын зах зээлүүд нь ирээдүйтэй улс

орнууд, корпорациуд, төслүүдэд хөрөнгө оруулах тал дээр үр ашигтай байж болох боловч капитал бэлэн байх явдал нь капиталын зардалд нөлөөлж, улмаар дэлхий нийтийн хэмжээнд үйлдвэр аж ахуйн газрын ашигт ажиллагааны буюу сонирхол татах түвшинд нөлөөлөх болно. Үүний нэг адилаар, дэлхийн нийтээр худалдааг либеральчилсан нөхцөлд нэг томоохон бүс нутагт гарсан эдийн засгийн зогсонги байдал бусад бүс нутгийн өсөлтөд дам нөлөөлөх хандлагатай байж болно.

Гуравдагч ертөнцөд явагдах насжилт дэлхийн эдийн засагт тийм их гэнэтийн нөлөө үзүүлэх болов уу? Энэ асуултын хариулт хараахан тодорхойгүй байгаа боловч уг асуултыг асууж эхлэхэд эртдэхгүй болжээ.

Тайлбар

- Энэ бүлэгт орсон бүдүүвч зураг, хүснэгтүүдийг хийхэд туслалцаа үзүүлсэн Америкийн үйлдвэрийн газрын институтын хатагтай Кортний Ричард, Асси Доссева нарт тусгайлан талархал илэрхийж байна. Мөн Энэтхэгийн бүс нутгийн хүн амын чиг хандлага, боловсролын байдал болон Хятадын хүн амын талаарх нарийвчилсан хэтийн тооцоонуудаа харамгүй өгсөн Лондоны эдийн засгийн сургуулийн профессор Тим Дайсон, Венийн Хүн ам зүйн институтын доктор Анне Гоужон, АНУ-ын Тоологын Товчооны доктор Лорайне Уэст, Даниел Гүүдкайн нарт тусгайлан талархал илэрхийлэе. Түүнчлэн хүн ам зүйн хэтийн тооцоонуудын дутагдалтай талуудын талаар гүн гүнзгий анхааруулга өгч байсан АНУТТ-ны Деннис Ж.Донахьюд талархах учиртай. Өөр ямар нэг алдаа байвал зохиогчийн алдаа болно.
- Асар их хэмжээний, олон янзын шинжилгээний ном сурах бичгүүд дотроос дараахь номыг төлөөлүүлэн дурдаж болох юм: Auerbach et al., 1989; Cutler et al., 1990, pp.1-56; Disney, 1996; OECD, 1998; United Nations Population Division, 2000; Heller, 2003; MacKellar et al., 2004; Poterba, 2004; International Monetary Fund, 2004; popularised presentations include Peterson, 1999; England, 2002; Longman; Kotlikoff and Burns, 2004.
- Өнөөдөр хүн ам зүйчид ерөнхийдөө НҮБ-ын Хүн амын хэлтэс (UNPD), АНУ-ын Тоологын Товчоо (USCB)-ны хэтийн тооцоог лавлах стандарт болгон ашиглах болжээ. НҮБ-ын Хүн амын хэлтсийн Дэлхийн хүн амын хэтийн төлөв номыг <http://www.un.org/News/Press/docs/2005/pop918.doc.html> гэсэн онлайн хаягаар, АНУ-ын Тоологын Товчооны "Олон улсын мэдээллийн сан"-г <http://www.census.gov/ipc/www/idbnew.html> гэсэн хаягаар авч болох бөгөөд эдгээр хэтийн тооцооны алийг нь ч дээрх тооцоог дэмжихэд ашиглаж болно.
- Дараахь зүйлийг жишээгээр харуулж байна: эмэгтэйчүүдийн дундаж наслалт ямагт 50 байдаг, эмэгтэй хүн бүр амьдралдаа дунджаар 6 удаа төрдөг, нас баралт өндөртэй нийгэмд голч нас яваандаа 16 насны орчимд тогтворжих болно. Нөгөө талаас, хэрвээ эмэгтэйчүүдийн дундаж наслалт 50, харин дунджаар амьдралдаа зургаа биш, хоёр төрдөг байсан бол голч нас нь 40 нас орчимд тогтворжих болно! Иймээс эмэгтэйчүүд дунджаар хоёр хүүхэдтэй, дундаж наслалт нь дөнгөж 50 байхад 65-аас дээш насны бүлэг яваандаа нийт хүн амын 15 гаруй хувийг эзлэх бөгөөд энэ нь өнөөгийн ЭЗХАХБ-ын гишүүн орнуудын түвшинтэй бараг ойролцоо байна.
- Уилсон, Пайсон нар, 2004.
- Техникийн хувьд НҮБ-ын дэлхий нийтийн ангилалд Зүүн Европыг "буурай хөгжилтэй" гэхээс илүү "илүү хөгжилтэй" гэж тодорхойлдог. Гэвч ямартай ч эдгээр "илүү хөгжилтэй" орнууд харьцангуй бага орлоготой улсууд байдаг учраас бид тэднийг энэ бүлэгт авч үзэхээр оруулсан юм.
- Энэ хүснэгтэд Орос, Хятад, Энэтхэг улсуудын бүгдэд нь туйлын сайн ВХАЧ-ын тохируулалт хийгдсэн буюу тухайн улсын бодит валютын ханшид тулгуурласан нэг хүнд ноогдох бүтээгдэхүүний түвшинг дөрөв дахин буюу түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлсэн учраас энэ тоонуудаас харахад өнөөдрийн ЭЗХАХБ-ын нэг хүнд ноогдох орлогын түвшинд хүрэх зорилт бүр ч сүрдмээр байгааг тэмдэглэн хэлэх ёстой.
- НҮБХХ-ийн одоогоор санал болгож байгаагаар, Хятадын нийт төрөлтийн хувь (НТХ) 1990-1995 онд 1.92 орчим буюу урт хугацааны хүн амын нөхөн үржвэрт шаардагдах хэмжээнээс 16 орчим хувь доогуур байсан бөгөөд өнөөдөр Хятадын НТХ арай буурч 1.7 болсон байна. АНУТТ-ны мэдээ ч нилээд төстэй буюу 2005 онд Хятадын НТХ 1.72 байхаар тооцжээ. Хятадын хувьд жил бүрийн иж бүрэн тоо бүртгэлийн мэдээлэл дутагдалтай байдаг, тус улсын тоолого, хүн ам зүйн судалгаанд нялхас, хүүхдүүдийн тоог дарж мэдээлж байгаа түвшин мэдэгдэхгүй байгаа учраас эдгээр тооцоо зарим талаар баттай бус байж болно гэдгийг анхаарах хэрэгтэй. Энэ тухай үндсэн мэдээллийг Гүүдкайн, 2004, х.281-295, Зян, Зяо нар, 2005 нарын бүтээлээс үзнэ үү.
- Үндсэн мэдээллийг, Дэлхийн Банк, 1997, Сонг, 2001, Хуанг, 2003, х.171-198, Ванг, 2004, х.3-16 зэргээс үзнэ үү.
- Лоуренсийн Их сургуулийн профессор Марк У.Фрэзиер энэхүү хойшуулалтын нэг гол хүчин зүйлийг зааж өгсөн байж болох юм: "Тэтгэвэр тэтгэмжийн үндсэн үйлчилгээг баталгаатай үзүүлэх талаар төр иргэдийнхээ өмнө ямар үүрэг хүлээх вэ гэдэг үндсэн асуултын хариуг шийдэх хүртэл одоо байгаа үндэсний ба орон нутгийн зохицуулалтын хяналтыг шахан гаргах тэтгэврийн хууль зайлшгүй шаардлагатай байгаа тухай мэтгэлцээн ихэвчлэн онолын түвшинд явагдана", Фрэзиер, 2005, х.108-130-г үзнэ үү.
- Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас авсан тоо баримтууд, 20026, Хүснэгтүүд 1-43, 1-51; Бүгд Найрамдах Хятад Ард Улс, 2000, Хүснэгтүүд, 4-4, 4-4в.
- Орчин үеийн Оросын эрүүл мэндийн аймшигтай эмгэнэлт байдлыг бид хэрхэн тайлбарлах вэ? Энэхүү аймшигтай статистик тоо баримтын цаана буй шалтгаануудыг хүн ам зүйчид болон нийтийн эрүүл мэндийн мэргэжилтнүүд бүрэн ойлгодоггүй. Хоолны дэглэм, тамхи таталт, суурин амьдралын хэв маяг, эрүүл мэндийн үйлчилгээ мүү байдал гээд бүгд л үүрэг гүйцэтгэдэг. Оросуудын архинд дуртай байдал ч энд гүнзгий учир холбогдолтой нь мэдээж. Харин Оросын эрүүл мэндийн гамшгийн нэг нууц бол асуудал бүхэлдээ түүний жижиг хэсгүүдийн нийлбэрээс ч дор байгаа явдал юм. Өөрөөр хэлбэл, эрсдлийн хүчин зүйлсэд дангаар нь ажиглалт хийж таамаглал дэвшүүлсэн дүнгээс нас баралтын хувь илүү өндөр байна.
- Онлайн хаяг: <http://www.mortality.org>, 2005 оны 1 сарын 14-нд уг сайтad хандсан.
- 1999 оны Оросын насанд хүрэгчдийн амьдрах магадлалын хуваарь өнөөдрийнхөөс арай дээр байсныг энд тэмдэглэх ёстой.
- Цаашилбал, АНУТТ-ны эдгээр хэтийн тооцоо нь ОХУ-д нэмэлт, магадгүй бүр хүнд эрүүл мэндийн хүндрэл бэрхшээл учрах боломжийг тооцоогүй болно. Гэхдээ ийм бэрхшээлтэй асуудлууд гарах нь өнөөдөр бараг тодорхой болчихоод байгаа бөгөөд тус улсад ДОХ өвчин болон эмэнд тэсвэртэй сүрьеэгийн халдвар сүрхий нүүрлэж байгааг тооцож үзэх шаардлагатай.
- Ганц жишээ татахад: 1999 онд (гэхдээ коммунизмын дараахь Оросын хувьд хамгийн муу байсан жил огт биш) 40 настай оросуудын нас баралтын хувь Итали дахь 55 настай эмэгтэйчүүд, 60 настай эрэгтэйчүүдийнхтэй тус тус адил байлаа. Хүний нас баралтын мэдээллийн сангийн (Human Mortality Database, онлайн хаяг: www.mortality.org) тоо баримтаар.
- Оросын эрүүл мэндийн ноцтой асуудлуудаас үзэхэд тус улсын хүн ам ийм хурдан насжиж байгаа нь гаж үзэгдэл мэт санагдаж болох юм. Гэвч, хүн амын насжилт нас баралтаас бус төрөлтөөс илүү их шалтгаалдаг гэж бид үүний өмнө ярьж байсныг эргэн санах хэрэгтэй бөгөөд өнөөдөр Орост төрөлтийн түвшин эргэн нөхөгдөх түвшнээс хамаагүй доогуур байна.
- Арон, 2004, х.2, Орос улсын тэтгэврийн нөхцөл байдлын гүнзгий тойм ба шинжилгээнээс үзнэ үү.
- Кф. Гүйлмото, Ражан нар, 2002.х. 665-672. Хүснэгт А-1-н тоон үзүүлэлт. Илүү дэлгэрэнгүй Гүйлмото, Ражан нар, 2005-с үзнэ үү.

- 20 Мэри Бхат, 2003, онлайн хаяг: <http://planningcommission.nic.in/reports/serereport/er/vision2025/demogra.pdf>, 2005 оны 5 дугаар сарын 1-нд уг сайтад хандсан.
- 21 Энэтхэгийн үлдэж байгаа 350 сая хүн Мэри Бхатын хойд-өмнөдийн шинжилгээнд ороогүй мужууд, холбооны нутаг дэвсгэрт амьдардаг.
- 22 Дайсон, 2004, х.74-107. онлайн хаяг: <http://indiabudget.nic.in/es2004-05/chap12005/tab18.pdf>, 2005 оны 5 дугаар сарын 1-нд уг сайтад хандсан. Мөн профессор Дайсон үүнтэй ижил цуврал хэтийн тооцоонуудынхаа зарим хэвлэгдээгүй нэмэлт мэдээллээс надад харамгүй өгсөн юм.
- 23 Дэлхийн Хөгжлийн Үзүүлэлтүүд /World Development Indicators CD-ROM/-с авав. Баруун Европын тооцоонууд нь Европын Валютын Холбооны 12 орны 1960-1965 оны тоо баримтууд, Японы тооцоонууд 1960 оных байгаа.
- 24 Үндсэн материалыг, India, Ministry of Social Justice and Empowerment /Энэтхэгийн Нийгмийн шударга ёс, эрх мэдлийн яам/, 1999; World Bank /Дэлхийн Банк/, 2001; Purohil, 2003, pp. 49-79; Palacous, 2004, pp. 282-300 зэргээс үзнэ үү.
- 25 Гоужон, МакНэй, 2003, х. 25-35. Дор авч үзэх зүйлсийг доктор Гоужоны надад харамгүй өгсөн хэвлэгдээгүй байгаа нэмэлт хэтийн тооцоонуудаас авч ашигласан. Энэ нь Гоужон, МакНэй нарын "Нэгдүгээр дүр төрх" хэмээх хэтийн тооцоотой холбоотой.
- 26 Барро, Лий нар, 2000.
- 27 Тухайлбал дараахь материалуудыг үзнэ үү: Coale and Hoover, 1958; Enke, 1966; Bloom and Williamson, 1998; Bloom et al., 2003.
- 28 Мэри Бхат, 2003, х. 9.
- Disney R. 1996. *Can We Afford to Grow Older? A Perspective on the Economics of Aging /Бид хөгшрөлтөө дийлж чадах уу? Насжилтын эдийн засгийн хэтийн төлөв/*. Cambridge, MA: MIT Press.
- Dyson, T. 2004. "India's Population-The Future." /Энэтхэгийн хүн ам ба ирээдүй/. T.Dyson, Robert Casses and Leela Visaria, eds. *Twenty-First Century India: Population, Economy, Human Development, and the Environment /21 дүгээр зууны Энэтхэг: Хүн ам, эдийн засаг, хүний хөгжил, байгаль орчин/*. New York: Oxford University Press. 74-107.
- England, R.S. 2002. *Global Aging and Financial Markets: Hard Landings Ahead? /Дэлхий нийтийн насжилт ба санхүүгийн зах зээлүүд: Хатуу газардалт хүлээж байна уу?/* Washington, DC: CSIS Press.
- Enke, S. 1966. "The Economic Aspects of Slowing Population Growth." /Удааширч буй хүн амын өсөлтийн эдийн засгийн талууд/. *Economic Journal* 76:44-56 /Эдийн засгийн сэтгүүл/.
- Faruqee H. and M. Muehleiser. 2001. "Population Aging in Japan: Demographic and Fiscal Sustainability." /Япон дахь хүн амын насжилт: Хүн ам зүйн ба төсвийн тогтвортой байдал/. *IMF Working Paper WP/01/40 /ОУВС-гийн ажлын тайлан/*. 4 дүгээр сар.
- Feeney, G., N.Y. Luther, Q.Meng, and Y.Sun. 1993. "Recent Fertility Trends for China: Results from the 1990 Census." /Хятадын сүүлийн үеийн төрөлтийн чиг хандлагууд: 1990 оны тоололын үр дүн/. 1990 Population Census of China: Proceedings of International Seminar /Хятад улсын 1990 оны хүн амын тооллого/. Beijing: State Statistical Bureau /Улсын статистикийн товчоо/. Online at: <http://www.gfeeney.com/pubs/1992-rft-china/1992-rft-china.pdf>.
- Frazier, M.W. 2005. "What's in a Law? China Pension Reform and its Discontents." /Хуульд юу гэж байна? Хятадын тэтгэврийн шинэчлэл ба түүнд сэтгэл ханамжгүй байдал/. N.J. Diamant, S.j. Lubman, and K.J. O'Brien, eds. *Engaging the Law in China: State, Society and Possibilities for Justice /Хятадын хуульд оролцохуй: Төр, нийгэм ба хууль зүйн боломжууд/*. Stanford, CA: Stanford University Press. 108-30.
- Goodkind, D. 2004. "China's Missing Children: The 2000 Census Underreporting Surprise." /Хятадын алга болсон хүүхдүүд: 2000 оны тооллогоор дутуу мэдээлсэн сонин явдал/. *Population Studies* 58(3): 281-95 /Хүн ам судлал/.
- Goujon A. and K. MacNay. 2003. "Projecting the Educational Composition of the Population of India: Selected State-Level Perspectives." /Энэтхэгийн хүн амын боловсролын байдлын хэтийн тооцоо: сонгож авсан мужийн түвшний хэтийн төлвүүд/. *Applied Population and Policy* 1(1): 25-35 /Хэрэглээний хүн ба бодлого зүй/.
- Guilmoto, C.Z. and S,I Rajan. 2002. "District Level Estimates of Fertility from India's 2001 Census." /Энэтхэгийн 2001 оны тооллогын дүүргийн түвшний төрөлтийн тооцоо/. *Economic and Political Weekly* /Долоо хоног тутмын эдийн засаг, улс төрийн сэтгүүл/. 2 сарын 16. 665-72.
- Guilmoto, C.Z. and S,I Rajan, eds. 2005. *Fertility Transition in South India /Өмнөд Энэтхэг дэх төрөлтийн шилжилт/*. New Delhi: Sage Publications.
- Heller P. 2003. *Who Will Pay? Coping with Aging Societies, Climate Change and Other Long-Term Fiscal Challenges /Хэн санхүүжүүлэх вэ? Хүн амын насжилт, цаг уурын өөрчлөлт, урт хугацааны төсвийн бусад сорилтуудтай тэмцэх нь/*. Washington, DC: IMF.
- Huang, J. 2003. "Economic Restructuring, Social Safety-Net and Old-Age Pension Reform in China." /Хятад дахь эдийн засгийн бүтцийн өөрчлөлт, нийгмийн халамжийн сүлжээ, өндөр насны тэтгэврийн шинэчлэл/. *American Asian Review* 21(2): 171-98 /Америкийн Азийн тойм/.
- Human Mortality Database /Хүний нас баралтын мэдээллийн сан/. 2005. Online at: www.mortality.org.
- India Ministry of Social Justice and Empowerment /Энэтхэгийн Нийгмийн шударга ёс ба эрх мэдэлжүүлэлтийн яам/. 1999. *First Report of Project OASIS (Old Age Social and Income Security) /Өндөр насны нийгмийн болон орлогын хамгаалалтын төслийн эхний тайлан/*. 2 сарын 1. Online at: http://seniourindian.com/oasis_.htm, 2005 оны 5 сарын 1-нд уг сайтад хандсан..

Лавлах материалууд

- Aron, L. 2004. "Privatising Pensions." /Тэтгэврийн хувьчлал/. *AEI Russian Outlook*. Summer.
- Auerbach A., J. Auerbach, L.G. Kotlikoff, and R.Hageman. 1989. "The Dynamics of an Aging Population: The case of Four OECD Countries." /Насжилттай хүн амын хувьсал хөгжил: ЭЗХАХБ-ын дөрвөн орны жишээ/. *NBER Working papers 2797 /ЭЗСҮТ-ийн ажлын тайлан/*.
- Barro, R.J. and J.W.Lee. 2000. "International Data on Educational Attainment: Updates and Implications." /Боловсрол эзэмшилтийн тухай олон улсын тоон үзүүлэлтүүд: шинэчлэл ба хэрэглээ/. *Harvard University Center for International Development Working Papers 42 /Харвардын Их сургуулийн Олон Улсын Хөгжлийн төвийн ажлын тайлан/*. 4 дүгээр сар.
- Baurman, K.J. and N.L.Graf. 2003. "Education Attainment, 2000." /Боловсрол эзэмшилт, 2000/. *Census 2000 Brief, August*. United States Department of Commerce and United States Census Bureau /АНУ-ын худалдааны Департамент, АНУ-ын Тооллогын Товчоо/.
- Bloom, D. and J.Williamson. 1998. "Demographic Transitions and Economic Miracles in Emerging Asia." /Шинээр төрөн гарч буй Ази дахь ардчилсан шилжилтүүд ба эдийн засгийн гайхамшигууд/. *World Bank Economic Review* 12:419-56 /Дэлхийн Банкны Эдийн засгийн тойм/.
- Bloom, D., D.Canning, and J.Sevilla. 2003. *The Demographic Dividend: A New Perspective on the Economic Consequences of Population Change /Хүн ам зүйн ноогдол ашиг: Хүн амын өөрчлөлтийн эдийн засгийн үр дагаврын шинэ хэтийн төлөв/*. Santa Monica, CA: Rand.
- Coale, A.J., P.Demeny, and V. Vaughan. 1983. *Regional Model Life Tables and Stable Populations /Бүс нутгийн загварт амьдралын хүснэгтүүд ба тогтвортой хүн ам/*. New York: Academic Press.
- Cutler, D., J.M.Poterba, L.M. Sheiner, and L.H. Summers. 1990. "An Aging Society: Opportunity or Challenge?" /Насжиж буй хүн ам: Таатай боломж уу, сорилт бэрхшээл үү?/. *Brookings Paper on Economic Activity* 1:1-56 /Эдийн засгийн үйл ажиллагааны Брүүкингийн тайлан/.

- International Monetary Fund /Олон Улсын Валютын Сан/. 2004. *World Economic Outlook: The Global Democratic Transition /Дэлхийн эдийн засгийн тойм: Дэлхий нийтийн ардчилсан шилжилт/*. Washington, DC: IMF /ОУВС/, 9 сар.
- Japan Ministry of International Affairs and Communications /Японы улсын Олон улсын хэргийн ба харилцааны яам/. 2004. *Japan Statistical Yearbook 2004 /Японы статистикийн жилийн ном 2004/*. ed. Statistical Training Institute /Статистикийн сургалтын институт/. Tokyo: Statistics Bureau /Статистикийн товчоо/.
- Kotlikoff, L.J. and S.Burns. 2004. *The Coming Generational Storm: What You Need to Know About America's Economic Future /Ирж буй шинэ үеийн шүүргэ: Америкийн эдийн засгийн ирээдүйн талаар юу мэдэх хэрэгтэй вэ/*. Cambridge, MA: MIT Press.
- Longman, P. 2004. *The Empty Cradle: How Falling Birth Rates Threaten World Prosperity and What to Do About It /Хоосон өлгий: Төрөлтийн хувь буурах нь дэлхийн хөгжил дэвшилд хэрхэн заналхийлж байна вэ, энэ талаар юу хийвэл зохих вэ/*. New York: Basic Books.
- MacKellar L., T. Ermolieva, D.Horlacher, and L.Mayhew. 2004. *The Economic Impacts of Population Ageing in Japan /Япон дахь хүн амын насжилтын эдийн засгийн үр нөлөө/*. Northampton, MA: Elgar.
- Maddison, A. 2003. *The World Economy: Historical Statistics /Дэлхийн эдийн засаг: Түүхэн статистик/*. Paris: OECD Development Centre Studies /ЭЗХАХБ-ын Хөгжил судлалын төв/.
- Mari Bhat, B.N. 2003. "Demographic Scenario, 2025." /Хүн ам зүйн дүр зураг 2025/. Study #S-15, Research Projects on India- 2025. New Delhi: Centre for Policy Research /Бодлогын судалгааны төв/. July.
- Organisation for Economic Co-operation and Development /ЭЗХАХБ/. 1998. *Maintaining Prosperity in an Ageing Society /Насжиж буй нийгэмд хөгжил дэвшлийг хадгалах нь/*. Paris: OECD.
- Palacios, R. 2004. "The Challenge of Pension Reform in India." /Энэтхэг дэх тэтгэврийн шинэчлэлийн хүндрэл бэрхшээлүүд/. E. M. Favaro and A. K. Lahiri, eds. *Fiscal Policies and Sustainable Growth in India /Энэтхэгийн төсвийн бодлого ба тогтвортой өсөлт/*. New Delhi: Oxford Univeristy Press. 282-300.
- People's Republic of China /Бүгд Найрамдах Хятад Ард Улс/. 2000. *Tabulation of the 2000 Population Census of the People's Republic of China Vol. 2 /БНХАУ-ын 2000 оны хүн амын тооллогын хүснэгт Боть 2/*. National Bureau of Statistics /Үндэсний статистикийн товчоо/.
- _____. 2002a. *China Statistical Yearbook /Хятадын статистикийн жилийн ном/*.
- _____. 2002b. *Tabulation of the 2000 Population Census of the People's Republic of China 2 /БНХАУ-ын 2000 оны хүн амын тооллогын хүснэгт 2/ (Хүснэгтүүд 4-4, 4-4с)*.
- _____. 2002c. *Tabulation of the 2000 Population Census of the People's Republic of China 3. /БНХАУ-ын 2000 оны хүн амын тооллогын хүснэгт 3/*. Beijing: National Bureau of Statistics /Үндэсний статистикийн товчоо/.
- _____. 2003. *China Labour Statistical Yearbook 2003 /Хятадын хөдөлмөрийн статистикийн жилийн ном/*. Beijing: Ministry of Labor and Social Security /Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам/.
- Peterson, P.G. 1999. *Gray Dawn: How the Coming Age Wave Will Transform America-and the World /Ирж буй насжилтийн давалгаа Америкийг болон дэлхийг хэрхэн өөрчлөх вэ/*. New York: Times Books.
- Poterba, J. 2004. "The Impact of Population Aging on Financial Markets." /Хүн ам насжилтаас санхүүгийн зах зээлд үзүүлэх нөлөө/. *NBER Working Papers 10851 /ЭЗСҮТ-ний ажлын тайлан/*.
- Purohil, B.C. 2003. "Policymaking for Diversity among the Aged in India." /Энэтхэг дэх настнуудын олон янзын байдалд зориулсан бодлого боловсруулалт/ *Journal of Aging and Social Policy 15(4): 49-79 /Насжилт ба нийгмийн бодлогын сэтгүүл/*.
- Saito Y., X. Qiao, and S.Jitarpunkul. 2003. "Health Expectancy in Asian Countries." /Азийн орнууд дахь эрүүл мэндийн төлөв/. J.M. Robine, C.Jagger, C.D. Mathers, E.M. Crimmins, and R.M. Suzman, eds. *Determining Health Expectancies /Эрүүл мэндийн төлвийг тодорхойлох нь/*. Chichester: John Wiley & Sons. 289-317.
- Song Xiaowu, ed. 2001. *Perfect the Pension System /Тэтгэврийн системийг төгөлдөржүүлэе/*. Beijing: Enterprise Management Publishing House. [хятад хэлээр]
- United Nations /НҮБ/. 2000. *Replacement Migration: Is It a Solution to Declining and Aging Populations? /Нөхөн орлох нүүдэл: Хүн амын бууралт, насжилтын асуудлын шийдэл мөн үү?/* New York: ECOSOC Population Division. 3 дугаар сар.
- _____. 2003. *World Population Prospects: the 2003 Revision and World Utilization Prospects /Дэлхийн хүн амын хэтийн төлөв: 2003 оны шинэчилсэн найруулга ба дэлхийн хэрэглээний хэтийн төлөв/*. New York: ECOSOC Population Division. Online at: <http://esa.un.org/unpp>, 2005 оны 4 сарын 19-нд үг сайтад хандсан.
- _____. 2004. *World Population Prospects: the 2004 Revision and World Utilization Prospects /Дэлхийн хүн амын хэтийн төлөв: 2003 оны шинэчилсэн найруулга ба дэлхийн хэрэглээний хэтийн төлөв/*. New York: ECOSOC Population Division.
- United States Social Security Administration /АНУ-ын Нийгмийн Хамгааллын Удирдах Газар/. 2004a. *Annual Statistical Supplement 2003 /Жил бүрийн статистикийн нэмэлт мэдээлэл/*. 3 сарын 24.
- Wang, X. 2004. "China's Pension Reform and Capital Market Development." /Хятадын тэтгэврийн шинэчлэл ба капиталын зах зээлийн хөгжил/. *China and World Economy 12(3): 3-16 /Хятад улс ба дэлхийн эдийн засаг/*.
- West, L.A. and D.Goodkind. 2003. "Population Aging and Social Safety Nets in China: Factors and trends Affecting Policy Trade-Offs." /Хятад дахь хүн амын насжилт ба нийгмийн хамгааллын сүлжээ: Бодлогын сонголтод нөлөөлж буй хүчин зүйлс ба чиг хандлагууд/. Unpublished paper. USCB, International Programs Center /АНУТТ, Олон Улсын Хөтөлбөрийн Төв/. 4 дүгээр сар.
- Wilson, C. and G.Pison. 2004. "La majorite de l'humanite vit dans un pays ou la fecondite est basse." *Population et Societes* 405. 10 дугаар сар.
- World Bank /Дэлхийн Банк/. 1997. *Old Age Security: Pension Reform in China /Өндөр настны хамгаалалт: Хятад дахь тэтгэврийн шинэчлэл/*. Washington.
- _____. 2001. *India: The Challenge of Old Age Insurance Security /Энэтхэг: Өндөр насны даатгалын хамгаалалтын сорилтууд/*. Report 22034-IN. 4 сарын 5.
- _____. 2003. *World Development Indicators 2003 CD-ROM /Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүд 2003/*. Washington.
- _____. 2004. *World Development Indicators 2004 CD-ROM /Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүд 2004/*. Washington.
- World Economic Forum /Дэлхийн Эдийн Засгийн Форум/. 2004. *The Global Competitiveness Report 2004-2005 /Дэлхий дахины өрсөлдөх чадварын тайлан 2004-2005/*. Hamshire: Palgrave Macmillan.
- Zhang, G. and Z.Zhao. 2005. "China's Fertility Puzzle: Data Collection and Data Use in the Last Two Decades." /Хятад улсын төрөлтийн байдлын оньсого: Сүүлийн хорин жилийн тоон үзүүлэлт цуглуулалт ба ашиглалт/. Paper Presented at Annual Meeting of Population Association of America /Америкийн Хүн Амын Холбооны жил тутмын хуралд тавьсан илтгэл/. Philadelphia, PA. 4 сарын 1.

Шинээр төрөн гарч буй зах зээлийн хямрал, түүний шийдлүүд: Арван жилийн туршлага

НОУРИЕЛ РОУБИНИ, Нью Йоркийн Их сургуулийн Штернийн Бизнесийн сургууль болон Рубиний Дэлхий Дахины Эдийн засгийн байгууллага

БРЭД СЕЦЕР, Оксфордын Их сургуулийн Дэлхий дахины эдийн засгийн засаглалын хөтөлбөр

Удирдтгал

Шинээр төрөн гарч буй зах зээлийн эдийн засгуудад хүнд хямрал дахин давтагдан гарч байсан явдал сүүлийн арван жилийн нэг онцлог байлаа. Энэ үйл явц 1994 оны сүүлээр Мексикт эхэлж 2002 онд Бразилд төгссөн бөгөөд замдаа Тайланд, Солонгос, Индонези, Малайз, Орос, Бразил, Турк, Аргентин зэрэг улсыг дайран өнгөрсөн юм. Харин энэ жагсаалтад Эквадор, Украин, Уругвай, БН Домникан Улс гэх мэт арай жижиг эдийн засагтай орнуудад гарсан хямралыг оруулаагүй юм.

Хөрвөх валют гэдэг бол хямралаас сэргийлэх баталгаа биш. Энэ талаар 2002 онд Бразилд байсан хэнээс ч хамаагүй асуугаарай. Гэвч хамгийн сүүлийн үед гарсан хямралууд нь зөөлөн холболт ч бай, валютын зөвлөл ч бай, валютын ханшийг уях тогтолцооны сүйрлээр илрэх онцлогтой байсан нь үнэн. Аж үйлдвэржсэн орнууд энэхүү уях тогтолцооноос шахагдан гарснаас хойш цаашид валютын ханшаа хөвүүлэх, дотоодын хүүгийн хувийг багасгах боломжтой болоод байна. Их Британий фунт Европын валютын хашны механизмаас шахагдан гарсны дараах 1992 оны туршлагыг авч үзээрэй. Шинээр төрөн гарч буй зах зээлийн эдийн засгууд дахь валютын хямрал ихэвчлэн банкны, бизнесийн эсвэл хуримтлагдсан өрийн хүнд хямралуудтай холбоотой байсан учраас тэд тийм ч азтай байсангүй.

Өндөр хөгжилтэй орнуудын стандартаар бол эдгээр хямралыг ихэвчлэн дагаж илэрдэг бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн уналт ер бусын огцом байлаа. ДНБ-ий 5 хувьтай тэнцэх уналтууд нийтлэг байсан бөгөөд хамгийн хүнд хямралуудад ДНБ-ий уналт 10 хувь ба түүнээс дээш гарч байв. Санхүүгийн хямрал ба бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн огцом уналт давтан гарах явдал бол тогтвортой эдийн засгийн өсөлтийн эсрэг асуудал юм. Мөн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтэд их хэмжээний уналт гарах нь ядуурал огцом нэмэгдэхэд хүргэдэг. Зарим тохиолдолд дэлхийн бусад хэсэгтэй тогтоосон санхүүгийн хэлхээ холбоо тасарч, тухайн улс орны цаашдын хөгжлөө санхүүжүүлэхэд нь шаардлагатай гадаадын капитал татах чадварт нь удаан хугацаагаар сөрөг нөлөө үзүүлдэг. Бусад тохиолдолд дотоодын санхүүгийн тогтолцоо түр хаагддаг нь асар их хор хөнөөл учруулдаг. Улс орнууд дотоодын санхүүгийн тогтолцооны сүйрлээс голдуу зөвхөн төр засгаас ихээхэн өндөр өртөгтэй аврах ажиллагаа явуулах замаар зайлсхийдэг нь тухайн улсын төрийн

мөнгө санхүүд бодитой хохирол учруулдаг. Ийм ч учраас улс орнууд санхүүгийн хямралын эрсдлийг нэмэгдүүлэх бодлогоос зайлсхийх нь чухал байдаг бөгөөд олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс ч улс орнууд гэнэтийн цочролыг зөөлрүүлэн шингээхүйц хангалттай их хэмжээний санхүүгийн нөөцтэй байхыг дэмжиж ажиллах ёстой байдаг.

Гэвч хямрал зүгээр нэг арилчихна гэж хүлээх нь бодит байдалд үл нийцнэ. Богино хугацаат өр төлбөр, гадаад валютын өр, гадаад өрөөс хамааралтай эсвэл гурвуулангаас нь хамааралтай байсан ч гэсэн шинээр төрөн гарч буй эдийн засгууд байнгын хямралын эрсдэл үүсгэсэн арга замаар өөрсдийгөө санхүүжүүлэх явдал олон байдаг гэвэл бараг оносон тодорхойлолт болно. Хөгжилтэй орнуудын эдийн засаг шиг хариуцлагагүй бодлого хэсэг хугацаанд баримтласныхаа дараа гүнзгий хямралд оролгүйгээр аажмаар шаардлагатай тохируулга хийх боломжтой бодлого, итгэл хүлээх чадварын гүн гүнзгий нөөц тэдэнд дутагддаг. Иймээс, олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс ямар нэг хямрал үүсэх үед үр нөлөөтэй хариу өгөхөд бэлэн байх ёстой.

Аливаа улс олон улсын капиталын зах зээлд нэвтрэх боломжоо алдах, мөн зарим тохиолдолд гадаад валютын нөөц нь шавхагдах үед санхүүгийн нөөцийнхөө дийлэнх хувийг Их 7-гийн орнуудаас бүрдүүлдэг. Олон Улсын Валютын Сан (ОУВС)-д хоёр өргөн сонголт тулгардаг. Нэгдүгээрт, тухайн улсад ядаж ойрын хугацаанд төлөх ёстой хатуу валютын өрөө дарах боломж олгож, улмаар макро эдийн засгийн цаад хүндрэлтэй асуудлуудаа засах алхмууд хийхэд ашиглана гэж найдсаны үндсэн дээр ОУВС-гаас олгодог аврах зээлийн хэлбэр байна. Хэрэв бүх зүйл сайнаар эргэвэл тухайн оронд дахин мөнгө урсан орж ирж валютын нөөцөө бүрдүүлээд зогсохгүй ОУВС-д төлөх өрөө түргэн эргүүлэн төлөх боломжтой болох юм. Хоёрдугаар сонголт бол тухайн улс зээлдүүлэгчиддээ өрийг багасгах, хугацаа дуусч буй нэхэмжлэлүүдийг хойшлуулах хүсэлт тавихыг дэмжих замаар тухайн улсын гадаад валютын нөөцөд үзүүлэх дарамт шахалтыг багасгах явдал юм. Хугацаа дуусч буй нэхэмжлэлүүд нь засгийн газрын өрийн бичгүүд (өөрөөр хэлбэл, их хэмжээний бонд) эсвэл тухайн хямралт оронд буй хувийн зээлдэгч нарын (ихэвчлэн банкууд) авсан хил дамнасан зээл байж болно. Аль ч тохиолдолд, хувийн зээлдүүлэгчдийг төлбөрөө

хойшлуулахыг ятгахын тулд дор хаяж өр төлөх чадваргүй болох аюултай гэсэн цаад санааг ер нь ойлгуулах шаардлагатай болдог¹.

Шидэт сум гэж байдаггүй. Аливаа улсад онцгой байдлын санхүүжилт олгохын зэрэгцээ бэрхшээлт байдлаа засах алхмыг өөрөө хийхээс илүү сайхан боломж гэж үгүй. Шүүмжлэгчдийн гаднаас аврах ажиллагаа хэмээн нэрлэдэг ОУВС-гийн зээлийг улс орнууд өрөө төлөх гэрээний үүргээ хүндэтгэн биелүүлэхэд туслах зорилгоор олгодог. Тэр нь тухайн оронд мөнгө зээлдүүлэгчдэд, нэн ялангуяа тус улсыг аврах зээл авсны дараахан ирж өрөө нэхэж байгаа азтай зээлдүүлэгчдэд туслаж байдаг. Сангийн сайд байсан Роберт Рабин хэлэхдээ, би байсан бол хувийн зээлдүүлэгч нарт тавтын зоос ч (АНУ-ын таван цент) зээлдүүлэхгүй байх байсан гэжээ. Бас аливаа улсад зээл олгогчдод давхар туслахгүйгээр дан ганц тухайн улсад туслах буюу улмаар төлбөрийн чадваргүй байдал нь бусад улсад нөлөөлж, давхар хохирол учруулахаас зайлсхийхэд хэцүү байдаг гэж тэр хэлсэн байдаг. Рабин Мексикт зээл олгох шийдвэрийн талаар өөрийн дурдатгалд бичихдээ, «Алан [Грийнспан], Ларри [Саммерс] бид гурав гурвуулаа тесобоно²-г бүхэлд нь эзэмшихийн эсрэг байлаа. Гэвч бид зарим хөрөнгө оруулагч нарт туслах давхар арга хэмжээ авалгүйгээр Мексикийг аварч чадахгүй гэж дүгнэсэн маань зөв байсан гэж би боддог.³»

Нэг бол зээлдүүлэгчтэй богино хугацааны нэхэмжлэлийг хойшлуулахаар тохирох эсвэл албан ёсоор өрийн бүтцийг өөрчлөхөд чиглэсэн дотоод аврах ажиллагаа ч аливаа улс асуудлыг өөрөө засах хугацаа олгож болно. Гэвч үүний тулд тухайн улс цаагуураа ОУВС-гийн дэмжлэгтэйгээр, зээлдэгчдэд төлөх өрөө хугацаанд нь бүрэн төлөх гэрээний үүргээ зөрчихөд хүргэдэг. Гэхдээ тухайн улс шууд төлбөрийн чадваргүй болохоос зайлсхийхийн тулд гэрээний нөхцлийг эсвэл өрийн бүтцийг өөрчлөх талаар зээлдэгчидтэй тохиролцоонд хүрч чадна гэсэн баталгаа байхгүй. Тэр ч байтугай өрийн бүтцийг амжилттай өөрчиллөө ч гэсэн тухайн улсын валют эсвэл банкны тогтолцоонд итгэх итгэл ихээр алдагдах эрсдэлтэй. Мөн ямар нэг албан ёсны хөндлөнгийн оролцоог эсэргүүцдэг хүмүүсийн хувьд, ОУВС эсвэл Их 7-гийн зүгээс өрийн бүтцийг харилцан зөвшилцсөний үр дүнд өөрчлөхийг дэмжсэн хүчин чармайлт гаргаж байгаа нь зах зээлийн оролцооны нэг хэлбэр мөн бөгөөд их хэмжээний гадны аврах ажиллагаанаас дор биш юмаа гэхэд түүнтэй

адил хэмжээний нөлөө үзүүлэхүйц гэдгийг санаж байх хэрэгтэй.

Олон хүмүүс бизнесийн салбарын бондын зах зээлийг хараад, тусгаар улсын төр засгийн газар буюу тэр утгаараа шинээр төрөн гарч буй зах зээлийн эдийн засгуудын банкны тогтолцоонууд өөрсдөө тухайн улсын төлбөрийн чадваргүй байдал эсвэл түүнийг дагасан өрийн бүтцийн өөрчлөлтийн эмх замбараагүй үйл явцын тухай шийдвэр гаргахдаа ОУВС-гаас тусламж авахгүйгээр явж болдог байхыг мөрөөддөг. Мөн ОУВС-гийн их хэмжээний аврах багц ба ОУВС-гийн дэмжлэгтэй дотоодын хүчин чармайлт хоёрын аль алиныг орлох нэг хувилбар бол үйл явцыг зөнд нь орхих явдал юм.

Гэвч ийм арга бодит байдалд хэрэгжих үндэслэл багатай. Дэлхий нийтийн санхүүгийн ач холбогдолтой (Бразил гэх мэт) эсвэл Их 7-гийн орнуудад стратегийн ач холбогдолтой (Турк гэх мэт) томоохон улс орнуудад муу юм тохиолдоход бэлэн байгаа бол ОУВС-гаас санхүүжилт авах боломжийг хязгаарлахад хэцүү байдаг. Хүснэгт 1-д үзүүлсэнчлэн албан салбарын хувьд ОУВС-гаас их хэмжээгээр санхүүжилт авах боломжийг хязгаарлахыг эрмэлзэж байна гэж хэлэх нь хямралд автсан бүх оронд ОУВС-гаас томоохон зээл олгохоо зогсоохыг уриалах замаар хямралыг давна гэж хэлэхээс хамаагүй хялбар болох нь нотлогдоод байна. ОУВС-гийн зээл нь Азийн хямралын дараа бус, харин Бушийн засаг захиргаа Аргентин, Турк, Бразил, Уругвай улсуудад томоохон зээл олгохоор батласны дараа буюу 2003 онд оргил цэгтээ хүрсэн юм (Бүдүүвч 1-ийг үзнэ үү).

Хямралаас урьдчилан сэргийлнэ гэдэг бол эх хүн, алимны бялуу хоёртой бага зэрэг адилхан зүйл. Энэ бол дурлахгүй байхад хэцүү зүйл. Харин хямралыг тасралтгүй шийдэх ямар нэг бодитой хувилбар гаргах магадлал тун бага байдаг. Шинээр төрөн гарч буй зах зээлийн хямралууд нь өсөлтийн эхэн үеийн зовиурын бодитой бөгөөд жирийн нэг үр дүн биш л бол (орчин үеийн дэлхийн санхүүгийн зах зээлд санхүүгийн хувьд нэгдэн орох анхны үе шаттай холбоотой), ОУВС, Их 7 болон дэлхийн санхүүгийн системийн эрүүл байдалд санаа тавьдаг бусад байгууллагын хувьд шинээр төрөн гарч буй эдийн засгууд бэрхшээлтэй асуудалд үргэлжлэн орж, тусламж хүснэ, тэд бидний заасан ёсоор төлөвлөж, ирээдүйд гарах хямралыг зохицуулах зохих ёсны бодлого, институциуд байна уу гэж байнга асуух болно хэмээн хүлээх нь зохисгүй юм.

Одоогийн бодлогын арга барилыг шүүмжилж буй бидний шүүмжлэл, сайжруулах тухай саналууд маань яагаад шинээр төрөн гарч буй эдийн засгууд бэрхшээлтэй асуудалд ороод байгаа, мөн яагаад ОУВС-гийн зарим аврах арга хэмжээ бусдаасаа илүү үйлчилээд байгаа тухай шалтгаануудыг үнэлсэн үнэлгээнд тулгуурлаж байна. Иймээс одоо энэ туршлагынхаа талаар авч үзье.

Шинээр төрөн гарч буй эдийн засгууд хямралын ард гарсан үү?

Цөөн тооны шинээр төрж буй эдийн засгууд 1995-2002 оны үеийнхээ тухай дурсах дуртай байдаг. Тэр үед шинээр төрөн гарч байсан томоохон эдийн засгууд бараг бүгдээрээ ОУВС-гаас тусламж хүсч хандсан билээ. Олон улсын бонд гаргагч хоёр томоохон улс болох Аргентин, Орос улсууд олон улсын өрийнхөө ядаж зарим хэсгийг төлөх чадваргүй болж байв. Мексик, Солонгос, Бразил, Турк улсууд дотоодын доллараар нэрлэгдсэн бонд, олон улсын бонд, ОУВС-гийн их хэмжээний зээлээр дамжуулж авсан хил дамнасан банкны зээлүүдээ төлөх чадваргүй болсон бөгөөд дээр нь Мексик улс АНУ-ын засгийн газраас бас зээл авсан байлаа. Эдгээр санхүүгийн хямрал эдийн засгийн ноцтой үр дагавартай байсан. Хүснэгт 2-оос үзэхэд, дөнгөж хоёрхон улс, 1998 онд Орос, 1999 онд Бразил, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн уналтыг зайлуулж чадсан нь харагдаж байна⁴.

Шинээр төрөн гарч буй ихэнх эдийн засгууд хямралд орсон. Гэвч энэ нь улс орон бүр яг ижил төрлийн хямралд орсон гэсэн үг биш юм. Тайланд, Солонгос, Индонезид хямрал нүүрлэх үед хувийн банк, санхүүгийн институци, корпорациудад хамгийн ноцтой төлбөрийн хүндрэл учирч байв. Энэ нь хямралын өмнө Азид урсгал дансны алдагдлыг засгийн газар бус, хувийн банкууд, пүүс компаниудын гадаад зээллэгээр санхүүжүүлж байсны шууд тусгал болсон юм. Мексик, Орос, Бразил, Эквадор, Аргентин, Турк улсуудад засгийн газрын авсан зээллэг (голддуу валютын уян ханш нь бодит ханшаасаа өндөр үнэлэгдсэнээс үүссэн урсгал дансны алдагдалтай холбоотойгоор) өөрөө санхүүгийн хүндрэлүүдийн нэг чухал элемент байв. Зарим тохиолдолд, тухайн улс дотоод өрөө төлөхөд хүндрэл учирч байсан нь үндсэндээ дотоодын банкны системд төлөх өр байв. Бусад тохиолдолд бэрхшээлтэй асуудал нь тухайн улсын олон улсын бонд байв. Харин Уругвай улсад хил дамнасан гадаад, дотоодын

Хүснэгт 1: ОУВС-гийн санхүүжилт¹

	Хэлэлцэн тохирсон хэмжээ			Нийт ашиглалт			Эхний жилд ашигласан		
	Квотын хувь	Тэрбум АНУ \$	ДНБ-д эзлэх хувь	Квотын хувь	Тэрбум АНУ \$	ДНБ-д эзлэх хувь	Квотын хувь	Тэрбум АНУ \$	ДНБ-д эзлэх хувь
Мексик	688	18.0	4.4	500	13.1	3.2	500	13.1	3.2
Тайланд	505	3.9	2.2	470	3.7	2.0	366	2.8	1.6
Индонези	557	11.3	5.0	555	11.3	5.0	245	5.0	2.2
Солонгос ²	1938	20.8	4.0	1802	19.4	3.7	1757	18.9	3.6
Бразил 1998	600	18.4	2.3	436	13.4	1.7	363	11.1	1.4
Орос	186	15.1	3.5	63	5.1	1.2	63	5.1	1.2
Аргентин	800	22.1	7.8	461	12.7	4.5	461	12.7	4.5
Бразил 2001	400	15.6	3.1	375	14.6	2.9	261	10.2	2.0
Бразил 2002	752	29.3	5.7	567	22.1	4.3	566	22.1	4.3
Бразил нийлээд ³	900	35.1	6.9	770	30.1	5.9	340	13.3	2.3
Уругвай	694	2.7	14.5	560	2.2	11.7	434	1.7	9.1
Турк 1999-2001	1560	20.7	10.4	1218	16.2	8.1	900	11.9	6.0
Турк 2002	1330	17.6	8.9	1154	14.8	7.7	1030	13.7	6.9
Турк нийлээд ³	2548	33.8	17.0	1709	23.1	11.4	900	11.9	6.0

Тайлбар:


1 Тусгай зээлжих эрхийг (ТЗЭ) хөтөлбөр эзлэх үеийн ТЗЭ/АНУ\$ ханшаар тооцож долларт хөрвүүлсэн

2 Солонгосын зээлийн квот нь түүний ДНБ-тэй харьцуулахад ер бусын бага байв

3 Нэгдсэн хөтөлбөрүүд = ашиглалтын үлдэгдэл дээр нэмэх нь шинээр авсан үүрэг амлалтууд, гэхдээ шинэ хөтөлбөрийн зарим нь ОУВС-гийн одоогийн зарцуулалтыг эргэн санхүүжүүлэх зорилготой байв.

Эх сурвалж: ОУВС, 2005, онлайн хаяг: <http://www.imf.org/external/fin.htm>

Бүдүүвч 1: ОУВС-гийн зээлийн үлдэгдэл, тэр бум ам.доллараар



Эх сурвалж: ОУВС, 2005, онлайн хаяг: <http://www.imf.org/external/fin.htm> ба <http://www.imf.org/external/np/tre/tad/extcred1.cfm>

Хүснэгт 2: Санхүүгийн хямралын үеэр бүтээгдэхүүн үйлдвэрлэл буурсан байдал

Улс	Хямрал эхэлсэн он сар	Бодит ДНБ-ий өөрчлөлт (хувиар)
Аргентин	2001 оны 12 сар	-12.8
Бразил	1999 оны 1 сар	3.8
Эквадор	1998 оны 9 сар	-6.9
Индонези	1997 оны 8 сар	-16.5
Солонгос	1997 оны 11 сар	-8.4
Малайз	1997 оны 8 сар	-8.9
Мексик	1994 оны 12 сар	-8.0
Орос	1998 оны 8 сар	-2.3
Тайланд	1997 оны 7 сар	-13.4
Түрк	2001 оны 2 сар	-7.4

Тайлбар: Бодит ДНБ-ий өөрчлөлтийн тодорхойлолт: а) Бүтээгдэхүүний бууралттай гарсан орнуудын хувьд, хямралын өмнөх үеэс хямралын дараахь хоёр жил хүртэлх хугацаанд гарсан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хамгийн бага түвшний өөрчлөлтийн хувь; б) Хямралын дараа бүтээгдэхүүний бууралт гараагүй орнуудын хувьд, хямралын өмнөх үеэс хямралын дараахь нэг жил хүртэлх хугацаанд гарсан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн түвшний өсөлтийн хувь.

Эх сурвалж: Дата Ресурсес нэгтгэл (2005); OYVC (2005), онлайн хаяг: <http://www.imf.org/external/fin.htm>

гүйлгээнд эмзэг өртөмтгий банкны тогтолцоо, ихээхэн өрөнд орсон засгийн газар хоёр хосолж байв.

Аль ч стандартаар авч үзсэн, ялангуяа өмнөх тав, зургаан жилийнхтэй харьцуулж үзэхэд ихэнх шинээр төрөн гарч буй эдийн засгуудын хувьд сүүлийн хоёр жилийн байдал маш сайн байв. Бүгд Найрамдах Домникан Улсаас өөр ямар ч улс хямралд орсонгүй. Олон тохиолдолд шинээр төрөн гарч буй эдийн засгууд нилээд огцом хурдтай өсч байгаа нь урт хугацааны дараа анх удаа гарч буй тохиолдол юм. Хувийн капиталууд ч шинээр төрөн гарч буй эдийн засгуудаас таатай боломж дахин эрж хайсаар байна. 2005 оны хаврын байдлаар шинээр төрөн гарч буй зах зээлүүдэд өрийн тархалт маш бага байгаа нь санхүүгийн зах зээлийн хувьд өр төлөх чадвараа алдах эрсдэл бага байгааг харуулж байна.

Олон орон хямралаас сургамж авч, санхүүгийн эмзэг байдлаа багасгахад чиглэсэн чухал алхмууд хийсэн нь эргэлзээгүй:

- Одоогоор Төв Европоос бусад ихэнх шинээр төрөн гарч буй эдийн засгууд урсгал дансны илүүдэлтэй байна. Их хэмжээний өртэй шинээр төрөн гарч буй эдийн засгуудын хувьд ерөнхийдөө тодорхой хэмжээний үндсэн илүүдэлтэй ажиллаж, төсвийн нийт алдагдал нь буурч эхлээд байна.
- Шинээр төрөн гарч буй эдийн засгууд

хэт бага нөөцтэй байхын эрсдлийг сайн мэддэг болоод байна. Тэд бараг бүгдээрээ богино хугацаат гадаад өрөөсөө давсан валютын нөөцтэй байна. Богино хугацаат гадаад зээлээр урсгал дансны байнгын алдагдлаа нөхөхийг оролдож Тайландын алдаг давтаж болзошгүй цөөн тооны улсууд байна. Өөр дутагдал гэвэл, шинээр төрөн гарч буй олон эдийн засгууд өнөөдөр хэдийн бодитой хэмжээнд хүрээд байгаа валютын нөөцөө хэтэрхий огцом хурдацтайгаар нэмэгдүүлж байна⁵. Ийнхүү нөөцийн хэмжээ огцом нэмэгдсэнээр дотоод зээлдүүлэг огцом нэмэгдэж, эцэст нь дотоодын санхүүгийн хямралд хүргэх эрсдэлтэй.

- Гадаад капиталын зах зээлд нэвтрэх боломж бол цаанаасаа өгөгдсөн эсвэл тогтмол байдаг зүйл биш болохыг ихэнх шинээр төрөн гарч буй эдийн засгууд хүлээн зөвшөөрч байна. Тэдний хувьд цаг муу байхад бус, цаг сайхан байгаа дээр гадаад санхүүжилт авах магадлал илүүтэй байна. Ер нь тэд эрсдэл бага байгааг далимдуулан шинээр богино хугацааны зээл авч тансаглах гэсэнгүй. Жишээлбэл, Латин Америк гэхэд дотоодын хуримтлалын хомсдолтой учраас гаднаас хуримтлал импортлож, урсгал дансны ужиг алдагдалтай ажиллаж ирсэн түүхтэй. Сайхан цаг үе ч санхүүжилтийн хялбар боломжтой давхцаж байна. Гэтэл өнөөдөр Латин Америк бүхэлдээ урсгал дансны бодитой илүүдэлтэй ажиллаж байгаа нь бараа түүхий эдийн үнийн хэлбэлзлээс хамгаалахад багагүй тусалж байна. Яг одоогоор ганцхан төв Европын шинээр төрөн гарч буй эдийн засгууд л их хэмжээний урсгал дансны алдагдалтай ажиллаж байна. Зарим тохиолдолд, эдгээр алдагдлыг Европын бусад хэсгээс орж ирж буй шууд хөрөнгө оруулалтаар ихээхэн нөхөж байгаа боловч шилжилтийн бусад эдийн засгууд ч мөн төсвийн алдагдал ихтэй байгаа нь тэдний энэ «давхар алдагдал»-ын тогтвортой байдалд санаа зовоход хүргэж байна.
- Тогтмол валютын ханш эрсдэлтэй гэдгийг шинээр төрөн гарч буй олон эдийн засгууд хүлээн зөвшөөрөөд байгаа нь наанадаж л валютын ханшийг өөрчлөгдөхгүй хэмээн үзэж гадаад валютаар нэрлэгдсэн өрөнд хэт найдахад

хүргэхгүй гэж үзсэнтэй холбоотой. Эсвэл тэд хэт өндөр үнэлэгдсэн тогтмол валютын ханш эрсдэлтэй гэж дүгнэсэн байж болно. Одоо гадаад валютын зах зээлд их хэмжээгээр оролцож байгаа шинээр төрөн гарч буй эдийн засгууд ерөнхийдөө урсгал дансны алдагдалтай бус, илүүдэлтэй байгаа бөгөөд тэд валютын ханшаа чангаруулахгүйн тулд гадаад валют худалдан авч байна.

- Хөгжиж буй зах зээлүүд дотоодын валютаар нэрлэгдсэн өрөнд илүү их анхаарал тавих болсон байна. Богино хугацаат гадаад зээлийн аюулыг Тайланд улс жишээгээр харуулсан шиг, дотоодын долларжилтын аюулыг харуулсан нэг чухал анхааруулах жишээ бол Аргентин улс болж байна.

Нөгөө талаас, дэлхий нийтийн хүчтэй өсөлт, зөвхөн газрын тосны ч бус нийт бараа түүхий эдийн өндөр үнэ, Америк, Европ, Японы маш бага хүүгийн хувь хосолсон ийм тааламжтай орчинд аливаа шинээр төрөн гарч буй эдийн засаг хүндрэлд орно гэхэд хэцүү. Гэхдээ сүүлийн хэдэн жилийн турш бодитой сайжралт гарсаар байгаа ч бодитой эрсдэл байсан хэвээр байна.

Одоо шинээр төрөн гарч буй эдийн засгууд бүхэлдээ өөрт хэрэгцээтэйгээс илүү их нөөцтэй байгаа нь тодорхой. Гэхдээ улс орон бүрт бүхий л хэрэгцээтэй нөөц байна гэж хэлж болохгүй. Гадаад өр багатай, дотоодын долларжсан өр төлбөр багатай зарим орон нөөц ихтэй байхад гадаад өр ихтэй, тодорхой хэмжээний долларжсан өр төлбөртэй бусад орон харьцангуй бага нөөцтэй байна. Жишээ нь, Бразил, Турк хоёр улс валютын нөөцөөсөө харьцангуй их гадаад өртэй байгаа нь тэдгээрийн зарлагдсан нөөцийн тодорхой хувь нь ОУВС-гаас авсан зээлээс бүрдэж байгаатай холбоотой. Мөн Ливан, Филиппин гэх мэт зарим арай бага эдийн засгийн гадаад өр нөөцтэйгээ харьцуулахад нилээд их байна.

Бүр илүү чухал нь хэдийгээр шинээр төрөн гарч буй эдийн засгууд гадаад өрийн ачааллаа багасгаад байгаа боловч дотоод өрийн хувьд мөн адил гэж хэлж болохгүй. Шинээр төрөн гарч буй эдийн засгуудын дотоод өр нэлэнхүйдээ өндөр хэвээр байна. Үнэн хэрэгтээ, Бразил, Турк, Аргентин, Уругвай зэрэг хямралд өртөмтгий эдийн засгуудад дотоод өрийн түвшин хэт өндөр хэвээр байгаа бөгөөд бусад газарт ч өсч байна. Бразил, Турк улсууд их хэмжээний

богино хугацаат дотоод өртэй байгаа учраас байнга хойшлуулан зохицуулж байх ёстой болж байна.

Саяхан ОУВС-гаас гаргасан ноцтой анхаарал татам нэгэн бүтээлд, шинээр төрөн гарч буй эдийн засгууд өндөр хөгжилтэй аж үйлдвэржсэн орнуудын тогтвортой барьж чадах хэмжээнээс нилээд доогуур түвшинд өр төлөх чадвараа алдах буюу өрийн бүтцээ өөрчлөх арга зам хайж байгааг харуулжээ. Энэ нь *өрийн үл хуцлийн* талаар Рогофф, Райнхардт, Сэвастано нарын бичсэн бүтээлийн үндсэн дүгнэлт юм⁶. Зээлдэгчийн өр төлөх чадвар ба төлөхөд бэлэн байдлын талаарх эргэлзээ өөрөө улам лавшрах шинжтэй байж болно. Хөрөнгө оруулагчид өндөр хэмжээний бодит хүү шаардаж, богино хугацаагаар эсвэл гадаад валютаар зээлдүүлдэг. Үүний хариуд өндөр бодит хүү нь өрийн бодит дарамтыг нэмэгдүүлж, улмаар төлбөрөө бүрэн төлөхөд шаардлагатай зохицуулатад улс төрийн дэмжлэг тогтвортой авахад улам хэцүү болгодог. Олон голлох эдийн засгуудын эдгээр өрийн түвшинг хяналтын жагсаалтаас хасч болохоор хэмжээнд хүртэл улам багасгах шаардлагатай болно.

Банкны системээ засгийн газрын өрийн бичгээр дүүргэх аюултай гэдгээс бүх шинээр төрөн гарч буй эдийн засгууд бүрэн сургамж авсангүй. Жишээ нь, Энэтхэг улсын засгийн газар нилээд их хэмжээний өрөө дотоодын банкуудад худалдах замаар төсвийн ихээхэн алдагдлаа (сүүлийн жилүүдэд ДНБ-ий 10 орчим хувь байгаа) нөхсөөр байна. Турк, Ливан зэрэг улсын засгийн газрын их хэмжээний өрийг банкны систем эзэмшиж байгаагийн эрсдэл нь илэрхий бөгөөд тодорхой харагдаж байгаа орнуудын хувьд засгийн газрын зээлдүүлэгчийн бааз суурийг өөрчлөхөд хугацаа шаардагдах болно.

Ямар ч зүйл тохиолдсон хамгаалж чадах буюу ОУВС-гийн ахлах эдийн засагчийн хэлсэнчлэн «ертөнцийн төгсгөлөөс ч аврагдах⁷» нөөцтэй орнуудад хүртэл бусад төрлийн бэрхшээлтэй асуудлууд байх нь олонтаа. Жишээлбэл, Хятадын засгийн газар тус улсын төрийн өмчийн банкуудад 1990-ээд онд гарсан найдваргүй зээлийн үлдэгдлийг цэвэрлэх хууль хараахан гаргаж чадаагүй байна. Үүний өртөг зардал асар их байж болох юм. Стандарт & Поорсын саяханы тооцоогоор, хамгийн том дөрвийн хоёрыг нь буюу мэдээж хамгийн хүнд байдалд байгаа хоёрыг нь ийнхүү цэвэрлэх зардал нийтдээ 190 тэрбум ам.доллар хүрч болохоор байна⁸. Бүр ч илүү чухал зүйл гэвэл,

уг тооцоо зөвхөн хуучирсан найдваргүй зээлүүдийг цэвэрлэх зардлыг голлон анхаарсан байгаа. Хэрвээ 2003-2004 оны зээллэгийн оргил үеэр олгосон зээлүүдийн тодорхой хувь нь найдваргүй зээлд нэмэгдэж ороход хүрэх юм бол эдгээр хоёр банкны системийг ерөнхийд нь цэвэрлэх зардал хамаагүй их байх магадлалтай түүх харуулж байна⁹.

Хятад улсын их хэмжээний гадаад валютын нөөц нь банкны системийг цэвэрлэхэд шаардлагатай татвар төлөгчдийн төлөх мөнгийг багасгахад нэг их нэмэр болохгүй. Үнэн хэрэгтээ Хятад улс их хэмжээний гадаад валютын нөөцтэй байгаа нь тус улсын татвар төлөгчдийн хувьд нэмэлт алдагдал авчрах эх сурвалж байж болох юм. Нөөцийн хэмжээ нэмэгдэж мөнгөний бааз сууриа бүр ч илүү хурдтай тэлэхэд хүрэхээс сэргийлэхийн тулд Хятадын төв банк болох Хятадын Ардын Банкнаас ренминбигээр нэрлэгдсэн их хэмжээний дотоод өрөө худалдах шаардлагатай болно. Энэ үйл явцыг стерилизази буюу өр хөнгөлөлт гэж нэрлэдэг. Гэвч энэ ч бас өөрийн өртөг зардалтай. Хэрвээ ренминбигийн ханшийг дахин үнэлсэн тохиолдолд төв банкны долларын эзэмшил ренминбид¹⁰ шилжүүлсэн утгаараа үнэ цэнээ алдахаас гадна ренминбигээр тооцсон өр төлбөр хэвээр үлдэх болно. Хятад улсын валютын нөөц түүний ДНБ-тэй харьцуулахад нилээд их, ялангуяа одоогоор Хятад улс жил бүр ДНБ-ийхээ 10-аас дээш хувийг нөөцдөө нэмж оруулж байгаа учраас болзошгүй алдагдлын хэмжээ нилээд их байна.

Энэ бол эрсдэл хэрхэн цаг хугацааны явцад хувьсан өөрчлөгддөгийн нэг жишээ юм. 1997 оноос өмнө Азийн хаа сайгүй илэрч байсан шиг асар их хэмжээний зээллэг, үл хөдлөх хөрөнгийн гэнэтийн их өсөлт, хэт их хөрөнгө оруулалт зэрэг олон эмзэг сул талууд Хятадын дотоодын санхүүгийн тогтолцоонд байдаг. Гэвч 1997 онд хямралд орсон Азийн орнуудаас ялгаатай нь Хятад улс их хэмжээний валютын нөөцтэй, гадаад валютын богино хугацаат өр, капиталын хяналт харьцангуй багатай байна. 1997-1998 оны үеийн Зүүн Азитай адилгүй нь Хятадад санхүүгийн хямрал гарлаа ч гадаад өрийн төлбөрийн хямрал хэлбэртэй байхгүй биз. Хятадад орж ирж буй капиталын урсгалыг урсгалдансны алдагдлыг нөхөхөдашигласангүй, харин валютын нөөцийг ер бусын хурдтай өсгөх зорилгод илүүтэй ашиглаж байна. Гэхдээ хямралд орсон Азийн эдийн засгуудын нэг адилаар Хятад улсад дотоодод зээллэгийн гэнэтийн их өсөлт гараад байна. Тус улс Азийн

олон хямралт эдийн засгуудынх шиг дотоод эмзэг талыг агуулдаг ч гадаад эмзэг тал байхгүй юм.

Үүний нэг адилаар шинээр төрөн гарч буй эдийн засгууд бүхэлдээ 1990-ээд оны дунд үеийн тайван сайхан үеийнхээс шал өөр төрлийн эрсдлүүдтэй учирч байна. Нэг талаас үзэхэд тэд дэлхий нийтийн капиталын зах зээлийн нөлөөнд шууд автах нь багасчээ. Нөгөө талаас тэд дэлхийн эдийн засгийн мөчлөгийн өөрчлөлтүүд болон бараа түүхий эдийн үнийн огцом хэлбэлзэлд үргэлжлэн автсаар байна. Дэлхий нийтийн зогсонги байдал нь дотоод өрийн өндөр түвшин нэмэгдэж улам их дарамт үүсгэхэд хүргэж болзошгүй бөгөөд ингэснээр өндөр үр өгөөжтэй их хэмжээний өр зээлээ барагдуулахад шаардлагатай тогтвортой зохицуулалт бий болгоход чиглэсэн тухайн улсын дотоод улс төрийн идэвх чармайлтыг сорьж байж болох юм. Түүнчлэн эмзэг бөгөөд хэврэг хэвээр байгаа банкны системүүдийг ч хайхралгүй орхиж болохгүй.

Шударга ч бай, шударга бус ч бай, шинээр төрөн гарч буй эдийн засгууд өндөр хөгжилтэй орнуудынхаас илүү өндөр стандартын эдийн засгийн бодлоготой байж, дор хаяж институциудээ төлөвшүүлж, тэдэнд итгэх итгэлийг бэхжүүлж ийм бодлого баримтлах шаардлагатай болж байна. Тэд дэлхий нийтийн гэнэтийн цочролуудад улам бүр өртөж байна. Гэвч энэ нь олон талаар сайн эдийн засгийн удирдлагатай байхын үр өгөөжийг нэмэгдүүлж байна. Чили улс төсвийн ихээхэн алдагдлаа тодорхой удирдаж, гадаад өрийнхөө бүтцэд анхаарал тавьж, хэт их хэмжээний богино хугацаат өрөөс зайлсхийж, гол экспортын бүтээгдэхүүн болох зэсийн үнийн огцом өсч буурах мөчлөгийг удирдахад туслах институциудийг хөгжүүлсэн байна. Иймээс Азийн хямралын уршгаар зэсийн үнэ унаж, Чилийг зогсонги байдалд оруулахад хүргэсэн боловч тус улсад онц ноцтой хямрал авчраагүй юм.

21 дүгээр зууны санхүүгийн хямралуудаас авсан сургамжууд

Ларри Саммерс Мексикийг анхны «XXI зууны санхүүгийн хямрал» гэж нэрлэх дуртай байв¹¹. Тэрээр Ньют Гингричийн анх хэрэглэсэн хэллэгийг сонгон авч ашигласан нь шинэ үзэгдэлд тохирох зөв нэр гэж үзсэн тохиолдолд АНУ-д байгуулсан хоёр талын гэрээний харьцангуй ховор нэгэн тохиолдлыг

онцолсон байв. Саммерсын хувьд «XXI зууны хямрал» гэдэг нэр томъёо нь Мексик улсын нийт банкны зээл гэхээсээ илүү арилжааны үнэт цааснуудынхаа (тесобоно) төлбөрийг барагдуулахад учирсан хүндрэлтэй байдал болон хөрөнгө оруулагчдын сэтгэл санаа гэнэт хувирвал тус улсад итгэх итгэл шат дараалан алдагдаж болзошгүй байсан эрсдэлтэй холбоотой байв. Энэ хямралаас өмнө Мексик улс хувийн хөрөнгө оруулагчдаас их хэмжээний капитал татан оруулж, урсгал дансны томоохон бөгөөд улам өсөн нэмэгдэж буй алдагдлаа санхүүжүүлж байв. Харин 1994 оны сүүл, 1995 оны эхээр тус улсын валютын нөөцөөс ч давсан асар их хэмжээний капитал гадагш урсан гарсан нь тус улс өр төлөх чадвараа асар ихээр алдаж АНУ-ын тэргүүлсэн аврах зээлд хандахад хүргэсэн юм.

Мексикийн хямрал тэрүүхэн тэндээ болоод өнгөрөх тусгаарлагдсан үйл явдал байсангүй. Үүний дараа Ази, Орос, Бразилийн хямралууд дараалан гарсан юм. Улмаар өмнө нь өндөр авч байсан Азийн эдийн засгуудад гэнэтийн томоохон сүйрэл гарсан нь олон улсын санхүүгийн бүтэц зохион байгуулалтыг зохих ёсоор шинэчлэхэд хүргэсэн. Орос улс төлбөрийн чадвараа алдсан явдал зах зээлийн хариу үйлдлийн гинжин хэлхээг хөдөлгөж, Урт Хугацааны Капиталын Менежмент хэмээх асар том хамгаалалтын санг гутаан доромжилсон бөгөөд наанадаж богино хугацаанд бараг бүх томоохон санхүүгийн зах зээлүүдийн үндсэн тогтвортой байдалд аюул занал учруулахуйц болж ирсний дараа л шинээр төрөн гарч буй зах зээлийн хямралд тавих анхаарал эрчимжиж эхэлсэн юм.

Үнэндээ XXI-д гарсан анхны санхүүгийн хямралууд буюу 2000 оны сүүлээр Аргентин, Турк улсуудад хэрэгжсэн ОУВС-гийн хөтөлбөрөөс эхлэж, 2002 онд Бразил, Уругвай улсуудад үргэлжилсэн хямралууд хамаагүй бага анхаарал татаж байв. Клинтоныхоос ялгаатай нь, Бушийн засгийн газар санхүүгийн хямралуудыг шийдвэрлэх асуудлыг гадаад бодлогын залгамж чанарынхаа төвд тавиагүй юм. Гэвч энэ нь их хэмжээний аврах арга хэмжээний эрин үе дууссан гэсэн үг биш юм. Тодруулбал 2001 оноос хойш хүндрэлд орсон орнууд түүнээс өмнө хямралд орсон орнуудыг бодвол ОУВС-гаас илүү их мөнгө авах хандлагатай болоод байна. Бүдүүвч 1-д үзүүлсэнчлэн, ОУВС-гийн нийт зээлдүүлэг 2003 онд оргил цэгтээ хүрсэн юм.

XXI зууны санхүүгийн хямралуудыг удирдах талаар олон улсын хамтын нийгэмлэгийн туулсан туршлагаас хэд хэдэн сургамж авах

боломжтой гэж бид үздэг.

- Их хэмжээний аврах багц нь зөв нөхцөл байдалд үйлчилж болно.
- Өрийн анхны түвшин гайгүй үед амжилт олох магадлал илүү их байна.
- Заримдаа өрийн бүтцийг өөрчлөхтэй холбоотой цохилтыг зөөлрүүлэхийн тулд ОУВС-гаас зээлсэн мөнгийг ашиглах нь энэ өөрчлөлтөөс бүрмөсөн зайлсхийхийг хичээснээс дээр байдаг.
- Хямралын шийдэл нь дандаа гаднаас нь аврах ажиллагаа байгаад дотоодын аврах хүчин чармайлт огт байгаагүй хэрэг биш юм.

Их хэмжээний аврах багц нь зөвхөн зөв нөхцөл байдалд л үйлчилж болно

Энэ бол өмнө нь тогтсон хэм хэмжээ болоод байснаас ч их хэмжээний мөнгө авсан Мексикийн сургамж юм. Мексик улс валютын ханшийг уяж тогтоох хэврэг системээ хамгаалах гэсээр валютын нөөцөө шавхсан, асар их хэмжээний доллартай холбосон өрөө төлөх хугацаа дөхөж байсан учраас энэ мөнгө хэрэгтэй байлаа. Тус улс өрийн бүтцээ өөрчилж хойшлуулахын оронд уг өрийг төлөхөд ОУВС-гийн санхүүжилтийг авч ашигласан юм. Энэ стратеги ч үйлчилсэн. Мексик улс ямар нэг уналтанд оролгүй, харин ч тэр чигтээ төлбөрийн чадвараа алдсан бол бүр ч их уналтад орж, дотоодын санхүүгийн шат дараалсан сүйрэлд орох байлаа. Удалгүй капиталын урсгал эргэн ирж Мексик улс их хэмжээний өрөө нилээд хурдан төлөх чадвартай болсон. Тэгвэл ямар байх ёстой вэ гэвэл бүх аргаа барсны дараа сүүлчийн мөчид ханддаг ОУВС-гийн зээлийн цаад үндсэн онол бол улс орнуудад итгэх итгэлийн хямралт байдал нүүрлэх үед богино хугацаанд өмнөхөөсөө илүү их хэмжээний мөнгө шаардлагатай байдагт оршино.

Мексик, Солонгос, Бразил улсууд бүгд л ОУВС-гаас харьцангуй их хэмжээний зээл буюу аврах багц хүлээж аваад байна. Тэд бүгд л дотоод ба гадаад өр харьцангуй багатай байсан. Тэд валютын ханшаа хэт удаан тогтмол барьсан, энэ явцад валютын нөөцийн хомсдолд орсон, улмаар доллараар нэрлэгдсэн өрийн үлдэгдлээсээ харьцангуй бага нөөцтэй үлдсэн зэргээсээ болж бүгд хүнд байдалд орсон билээ. Тэдний санхүүгийн үндсэн асуудал бол хэтэрхий их өртэй биш, хэтэрхий бага нөөцтэй байсан явдал юм. Харин Бразил улсын хувьд 1998 онд ч гэсэн бусдаасаа арай илүү өртэй

Хүснэгт 3: ОУВС-гийн (эхний зэлжинд хоёр талт) зээлүүд хэр хурдан ашиглагдаж, эргэн төлөгдсөн бэ

	Оргил үеийн ашиглалт, тэрбум АНУ\$ (ДНБ-ий хувь)	Оргил үед хүрэхэд зарцуулсан улирал	Оргил ашиглалтын хагасыг буцааж төлөхөд зарцуулсан улирал	Хямралын өмнөх гадаад өр (ДНБ-ий хувь)	Хямралын өмнөх төсвийн өр (ДНБ-ий хувь)
Мексик	27.6 (6.8)	4	9	34	31
Тайланд	11.2 (6.2)	12	17*	30	5
Индонези	10.8 (4.7)	13	-	43	24
Солонгос	19.4 (3.7)	4	8	32	12
Орос	5.1 (1.2)	2	4	35	52
Бразил (1998-99)	17.5 (2.2)	3	7	25	40
Турк (2000-02)	23.1 (11.6)	13	-	57	56
Аргентин	13.7 (4.8)	4	-	51	45
Уругвай	2.1 (11.3)	8	-	81	38
Бразил (2001-02)	30.1 (5.9)	9	-	44	65

* Тайландад олгосон ОУВС-гийн санхүүжилт 9 улирлын дараа оргил цэгтээ хүрсэн бөгөөд 17 улирлын дараа гэхэд уг хөрөнгийн талыг буцаан төлсөн бөгөөд энэ үед хоёр талт зээлийнхээ хагасыг төлж чадаагүй байсан. Бидэнд 2001 оны сүүлээс хойш Тайланд улс хоёр талт зээлээ хэрхэн төлсөн талаарх мэдээлэл байхгүй байна.

Тайлбар: Бразилийн өрийн тухай Мүүдийсийн тоо баримтууд бусад их сурвалжийнхаас өндөр байдаг. Бразилийн 1997 оны өр ба ДНБ-ий харьцаа 40 биш 35 хувь, 2000 оны буюу хямралын өмнөх үеийн өр ба ДНБ-ий харьцаа 65 биш, 49 хувь байсныг ОУВС харуулж байна.

Эх сурвалж: ОУВС, 2005, онлайн хаяг: <http://www.imf.org/external/fin.htm>; АНУ-ын Төрийн сан /United States Treasury/, янз бүрийн жилүүд; Мүүдийс /Moody's/, 2004.

байлаа. Тэд бүгдээрээ ОУВС-гийн зээлийг харьцангуй хурдан буцааж төлсөн юм.

Аврах багц хүлээн авч буй орнуудын өрийн анхны түвшин гайгүй бол амжилт олох магадлал илүү их байдаг

Хүснэгт 3-аас үзэхэд 2001-2002 оны Аргентин, Бразил улсууд, мөн Турк, Уругвай улсууд бүгд 1998 оны Мексик, Солонгос, тэр ч байтугай 1998 оны Бразилийг бодвол хамаагүй их өртэй байлаа. Эдгээр оронд тулгарсан хүндрэл нь зүгээр нэг богино хугацаанд хөрвөх чадвараа алдахаас давсан буюу богино хугацаат өртэйгээ харьцуулахад хэтэрхий бага нөөцтэй болсон байлаа. Тэд дөрвүүлээ өрөө төлөхөд шаардлагатай зохицуулалтын бодлого баримтлах чадвараасаа хэтэрсэн хэт их өртэй байсан нь нилээд эрсдэлтэй байв. Мөн ямар нэг гадаад валют даруйхан цутгаж оруулахгүй бол богино хугацаанд төлбөрийн чадваргүй болохын зэрэгцээ тогтвортой зохицуулалтаар хангахгүй бол төлбөрийн чадвараа бүрмөсөн алдах боломжтой байв. Эдгээр тохиолдолд ОУВС-гийн их хэмжээний зээл зөвхөн түр зуурын хөрвөх чадварын хомсдолыг арилгахад төдийгүй тухайн улс өрийн хүндрэлээс гарахын тулд цаг хугацаа хожиход ашиглагддаг.

Одоогийн байдлаар энэ стратеги зарим тохиолдолд, жишээ нь Бразил, Турк хоёрын жишээнд, сайн үйлчилсэн бол бусад тохиолдолд, тухайлбал Аргентинд үйлчлээгүй байна. Аргентинд амжилт олоогүйн шалтгаан

бол зарим талаар тус улс валютын ханшны зохицуулалт хийхээс гадна төлбөрийн чадвараа давхар алдахаас зайлсхийхийг хичээж байсан бол Бразил, Турк улсууд валютын ханшны зохицуулалтаас бус зөвхөн төлбөрийн чадвар алдахаас зайлсхийхийг хичээж байсантай холбоотой. Цаашилбал Аргентиний өр бараг бүгдээрээ доллараар илэрхийлэгдсэн, валютын ханш нь бодит ханшаас нилээд өндөр үнэлэгдсэн байсан учраас олон хүн зөвхөн тус улсын 2000 эсвэл 2001 оны өр ба ДНБ-ий харьцааг хараад төсөөлж байснаас ч илүү гүнзгий хямралд орох байв. Гэвч уг стратеги үйлчилсэн орнуудад хүртэл ерөнхийдөө их хэмжээний хөрөнгө шаардлагатай байгаа бөгөөд тэд ОУВС-гаас авсан зээлээ хурдан эргүүлэн төлж чадаагүй л байна. Турк улсын ОУВС-гаас авсан мөнгө Мексик улс ОУВС, АНУ хоёрын хоёулангаас нь авсан мөнгөний нийлбэр дүнгээс (ДНБ-тэй нь харьцуулахад) хамаагүй их байв. Мөн Бүдүүвч 2-т үзүүлсэнчлэн тус улс энэ санхүүжилтийг хамаагүй удаан эргүүлэн төлж байна. ОУВС-гаас анх их хэмжээний дэмжлэг авснаас хойш 4.5 жилийн дараа гэхэд Турк улс ОУВС-д 20 тэрбум орчим ам.долларын (хямралын өмнөх ДНБ-ийхээ бараг 10 хувьтай тэнцэх) өртэй хэвээр байна. Бодитойгоор авч үзвэл Турк улс ОУВС-д төлөх өрөө 2009 оноос өмнө бүрэн барагдуулж чадахгүй. Турк улс маш их хэмжээний богино хугацаат зээл авахын оронд маш их хэмжээний дундаас урт хугацааны зээл аваад байна.

Зарим тохиолдолд ОУВС өрийн бүтцийг өөрчлөхөөс бүрмөсөн зайлсхийхийн оронд энэ өөрчлөлттэй холбоотойгоор үүсэх цохилтыг зөвлүүлэхийг хичээх ёстой

Хямралд орсон ихэнх орон ОУВС-гийн зээлийг нилээд их хэмжээгээр буюу бусад орноос илүү бодитойгоор авсан байдаг бөгөөд мөнгөний ба эдийн засгийн бодлогыг хослуулснаар тухайн улс томоохон хэмжээний, магадгүй хор хөнөөлтэй байж болох, өрийн бүтцийн өөрчлөлт хийхээс зайлсхийх боломж олгосон эсэхийг харах бололцоо олгосон байдаг. Үнэн хэрэгтээ бүх биш ч олон тохиолдолд албан салбарын зүгээс эхний хөтөлбөр нуран унасны дараа хоёр дахь удаагаа илүү их санхүүжилт авах хариу арга хэмжээ авсан байдаг. Зарим тохиолдолд бодлогын зохицуулалтыг ОУВС-гийн санхүүжилттэй хослуулах явдал үр дүнгээ өгч, тухайн улс өрийн бүтцийн өөрчлөлт хийхээс зайлсхийж чадаж байв. Гэвч бусад тохиолдолд тухайлбал Аргентин, Орос хоёрын жишээнд ийнхүү үйлчилсэнгүй.

Гэхдээ 1998 оны Орос улс, 2001 оны Аргентин хоёрын хооронд нэг чухал ялгаа бий. Оросын хувьд 1998 онд тус улсад олгох зээлдүүлэг харьцангуй хурдан буюу ОУВС-гийн санхүүжилтын ихэнхийг бодитойгоор ашиглаж эхлэхээс нилээд өмнө тасарсан байв. Харин Аргентинд албан салбар нь зээлийн урсгалыг таслах эсэхэд эргэлзэж байв. Ингээд эхний арга үйлчлэхгүй нь тодорхой болсноос нилээн хойно ОУВС-гийн мөнгө орж ирж эхэлсэн юм. ОУВС-гаас Аргентинд анх олгосон 15 тэрбум ам.долларын зээл дээр нэмж 2001 оны зуны сүүлээр дахин 8 тэрбум ам.долларын зээл олгох шийдвэр нь илэрхий алдаа байлаа¹². 2001 оны зуны энэхүү бага хэмжээний нэмэлт санхүүжилт үйлчлэх боломж байгаагүй бөгөөд Аргентиний эдийн засаг сүйрснээр ОУВС нэмэлт алдагдал хүлээхэд хүргэсэн төдийгүй ОУВС-гийн үргэлжилсэн бодлогын дэмжлэг бүтэлгүйтсэн дохиог өгснөөр Аргентин дахь ОУВС-д итгэх итгэлийг алдагдуулсан юм.

Үнэн хэрэгтээ ямар нэг валютын ханшны зохицуулалт байхгүй байхад Аргентинд зээл олгох анхны шийдвэр зөв байсан эсэх талаар асуудал үүсэх нь мэдээж. Анхнаасаа Аргентин улсыг валютын зөвлөлөөсөө салахыг шаардах нь улс төрийн хувьд боломжгүй байсан байж магадгүй. Тэгэхдээ анх зээл олгохдоо зээлийн урсгалыг таслаад дараа нь нэгэнт Аргентин улс эдийн засгийн гүнзгий хямралд орсон нь тодорхой болсны дараа буюу 2001 оны хавраас


өөр стратеги хэрэглэсэн бол дээр байх байсан нь бараг тодорхой юм. ОУВС-д стратегиа өөрчлөхгүйгээр зээл олголтоо зогсоох хангалттай их боломж байсан. Аргентин улс 2001 оны хавраас эхлэн төсвийн зорилтуудаа тууштай хангаж чадахаа больсон билээ.

2000 онд Аргентинд бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн ихээхэн уналтаас зайлсхийх ямар ч боломж байсангүй. Ямартай ч зовиуртай байсан бодит байдлыг хүлээн зөвшөөрч валютын ханшны тохируулга хийхээс аргагүй байлаа. Аргентины валютын ханш хэт өндөр тогтсон байсан нь өрийн жинхэнэ дарамтаар халхлагдаж ирсэн байлаа. Гэтэл үнэн хэрэгтээ Аргентин улс өрийн бүтцийн бодит өөрчлөлт, ямар нэг валютын ханшны тохируулгаас аль алинаас нь зайлсхийхийг оролдсон их хэмжээний зээл авснаар төгсгөл болгоод ямар нэг тогтвортой бодит валютын ханш, илүү тогтвортой өрийн бүтцэд шилжих талаар юу ч хийсэнгүй. Одоо байгаа валютын зөвлөлөөс болон өрийн бүтцийн зайлшгүй шинэчлэлээс үүсч болох сөрөг уналтыг хязгаарлахад ОУВС-гийн зээлийн боломжийг ашигласан бол арай дээр бодлого байх байлаа. ОУВС-гийн санхүүжилтийг Аргентины өөрийн үлдэгдэл нөөцийн хамтаар хүмүүс банкнаас мөнгөө татахаас сэргийлэх, песогийн хэт хөөрөгдлийг хязгаарлах зорилгод ашиглаж болохоор байв.

Мөн ийм арга хэрэглэсэн бол Аргентин улс төлбөрийн чадваргүй болсныхоо дараа хэрэглэх макро эдийн засгийн бодлогыг залж удирдах, тус улсад өөрчлөн байгуулалтын төлөвлөгөө яаралтай боловсруулан гаргахад түлхэц өгөх хүрээг хэлэлцэн тохирох зэрэг илүү хүчтэй байр сууринд ОУВС үлдэх байв. Гэтэл түүний оронд ОУВС 2002, 2003 зээлийн нөхцөл болзлуудаа уялдуулахыг хичээхээс өөр аргагүй болсон нь Аргентин улсыг ОУВС, Дэлхийн Банк, Америк Хоорондын Хөгжлийн Банкнаас авсан зээлээ хугацаа хоцорч төлөхөөс сэргийлснээс өөр үр дүн гарсангүй. Ингээд нэг талаар үүний үр дүнд ОУВС хөтөлбөрөө засч янзалсаар хоцорсон бөгөөд уг хөтөлбөр нь дараа дараагийн өрийн бүтцийн өөрчлөлтийн ажилд удирдамж болох төсвийн бодлогын зам мөрийг тогтоож чадаагүй билээ.

Энэ бол цорын ганц онолын боломж биш юм. Итгэх итгэлийг сэргээж чадаагүй хэд хэдэн жижиг зээлийн дараа Уругвай улс ОУВС-гаас их хэмжээний зээл авсан нь тус улсын төв банк дотоодын банкны тогтолцоондоо сүүлчийн ганц доллараар зээлдүүлэгчийн үүрэг гүйцэтгэх боломж олгосон юм. Улмаар энэ нь Уругвай

Бүдүүвч 2: ОУВС, АНУ-ын 2 талын зээлийн үлдэгдэл: Мексик, Турк



Эх сурвалж: IMF (2005), online at: <http://www.imf.org/external/np/tre/tad/exfin1.cfm>; United States Treasury, various dates, including 1997, online at: <http://www.federalreserve.gov/pubs/bulletin/1997/1997032.pdf> and <http://www.federalreserve.gov/pubs/bulletin/1998/199803forex.pdf>.

улсад дотоодын болон гадаадын банкуудын үйл ажиллагаа зогсохоос сэргийлэхэд тусласан. Банкуудын үйл ажиллагаанд татаас олгосны дараа засгийн газар өөрийн өрийнхөө бүтцийг хугацаа сунгах бондын арилжаагаар дамжуулан өөрчилсөн байна. Гэхдээ нэг чухал анхаарах зүйл бол Уругвай улс ДНБ-ийхээ 15 орчим хувьтай тэнцэх зээл авсан явдал юм. Энэ нь шинээр төрөн гарч буй томоохон эдийн засгуудад ОУВС-гийн өгч чадахаас хамаагүй их тоо юм. Мөн энэ нь ОУВС-аас Уругвай шиг өртэй орнуудад өгөх ёстой хэмжээнээс хамаагүй их байлаа.

Хямралын шийдэл бол дандаа гаднаас нь аврах ажиллагаа байгаад дотооддоо аврах хүчин чармайлт огт тавиагүй гэсэн хэрэг биш юм.

Банкаар дамжуулсан зээлээс нээлттэй зах зээл дээр арилжаалагддаг үнэт цаасанд шилжсэн явдал нь өрийн бүтцийг өөрчлөхөд саад бэрхшээл учруулсангүй. Хямралд орсон ихэнх орон эхэндээ гэнэтийн их мөнгө авч байгаа нь эхлээд мөнгөө нэхсэн азтай зээлдүүлэгч нар цагаа олж орж ирэн мөнгөө аваад хохирол амсалгүйгээр буцах боломж олгодог. Гэхдээ албан салбарын хувьд бүх хувийн зээлдүүлэгч нар мөнгөө аван зугтах боломж олгохуйц хангалттай их мөнгө хэзээ ч гаргадаггүй нь

ихэвчлэн хямралт орны иргэдийн тухайн улсдаа оруулсан хөрөнгө оруулалт гадаадын хөрөнгө оруулагчдынхаас хамаагүй их байдгийг мэдсэн хэрэг юм.

Солонгос улсад хэрэгжүүлсэн ОУВС-гийн эхний хөтөлбөр банкууд зээллэгээ үргэлжлүүлэн татан авахаас сэргийлж чадаагүй юм. Харин Солонгост илүү их мөнгө зээлдүүлэхийн оронд ОУВС, Их 7 хоёр хамтран шинэ арга боловсруулж, Солонгос улс зохицуулалттайгаар зээлийн төлбөрийг хойшлуулах буюу богино хугацаат өрийг төлөх ажиллагааг зохион байгуулахад тусалсан байна. Дараа нь тэд төлбөрийн хуваарийг шинэчлэх албан ёсны төлөвлөгөө гаргасан нь Солонгос улсын өр төлөх хугацааг бүхэлд нь сунгасан юм. Солонгосынх шиг жишээнд бол ОУВС-гийн эхний хөтөлбөр ямар ч дотоод хүчин чармайлтгүйгээр бүхэлд нь гаднаас аврах ажиллагаа байсан боловч тун удалгүй эхний хөтөлбөрөө шинэ хөтөлбөрөөр сольсон нь өрийн бүтцийг өөрчлөх хүрээнд хийгдсэн байв. ОУВС-гийн эхний хөтөлбөр бүтэлгүйтсэн бусад тохиолдолд өрийн бүтцийг өөрчлөхөд чиглэсэн ОУВС-гийн шинэ хөтөлбөрөөр орлуулах зайлшгүй шаардлага гарч байгаагүй юм. Гэвч ОУВС-гаас өгч чадах санхүүжилтын хэмжээ нь бүх хувийн зээлдүүлэгч нарын

өрийг барагдуулахад шаардагдаж болох хэмжээнээс хол дутаж байсан учраас ОУВС-гийн хөтөлбөр нурж бүтэлгүйтсэн тохиолдолд хувийн зээлдүүлэгчид тухайн улсын хямралд өртсөн хэвээр байв. Эдгээр тохиолдолд ч бас хувийн зээлдүүлэгчид ба хөрөнгө оруулагчид нэхэмжилсэн өрийнхөө бүтцийг голдуу их хэмжээний алдагдалтай нөхцлүүдээр өөрчлөхөөс аргагүй болж байв.

Жишээ нь, Аргентин улс 2001 оны турш олон улсын баталгаат бондын үндсэн төлбөрт 6 тэрбум ам.доллар төлөхөд нэмэр болгож ОУВС-гийн санхүүжилтийг өөрийн валютын нөөцийн хамт ашигласан байна¹³. Гэтэл жилийн эцэст бараг 90 тэрбум ам.доллар орчмын бондын төлбөрийн үлдэгдэлтэй хэвээр байсан бөгөөд хэрвээ Аргентиний дотоодын банкны системийн эзэмшилд байсан зарим бондыг зээл болгож хөрвүүлээгүй бол тэр хэмжээний үлдэгдэлтэй байх байлаа. Эдгээр зээлийн нилээд хэсгийг песод хөрвүүлсэн бөгөөд төлбөрийн чадваргүй болсны дараахан түүний бүтцийг даруй үр нөлөөтэйгээр өөрчилсөн юм. Харин Аргентин улс 2002 оны арилжаагаар бүтцийг нь өөрчлөх 80 тэрбум ам.долларын бондтой хэвээр байв. Эндээс үзэхэд ОУВС-гийн санхүүжилт нь ихэнх хөрөнгө оруулагчдад алдагдал амсахгүйгээр Аргентинаас гарч явах боломж олгоогүй байна.

Банкаар дамжуулсан зээл нь бусад хэлбэрийн хил дамнасан санхүүжилтээс чухал хэвээр байгаа боловч шинээр төрөн гарч буй зах зээлүүдийн хуримтлагдсан өрүүдэд баталгаагүй санхүүжүүлэх зонхилох хэрэгслийн хувьд бондууд давамгайлж байна. Аз болоход бондын бүтцийг өөрчлөх нь олон хүний бодож байснаас ч илүү хялбар болох нь нотлогдсон. Тарж бутарсан бонд эзэмшигчид хууль ёсны нэхэмжлэлдээ буулт хийх ятгалганд хэзээ ч орохгүй болов уу, тэд урт удаан үргэлжлэх шүүхийн маргаанаар дамжуулж хуримтлагдсан өрийн бүтцийг өөрчлөх явдлаар өөрсдийгөө хязгаарлахгүй байх гэсэн айдас ёсоор болсонгүй¹⁴. Пакистан, Эквадор, Украин, Уругвай улсууд бүгд бонд эзэмшигчдийнхээ 90 хувийг өрийн бүтцийг өөрчлөхөд оролцохыг ятгаж чадсан бөгөөд Уругвайгаас бусад нь бүгд 95 хувийн оролцоог хангаж чадсан юм. Аргентин улс эхэндээ бонд эзэмшигчдийнхээ дөнгөж 75 орчим хувийг тохиролцоонд татан оруулсан байснаас энэ талаар сайн зөвлөгөө аваагүй Италийн жижиглэн худалдааны хөрөнгө оруулагчид, цөөн хэдэн «бусдын зовлонгоос олз ашиг хайгч» боловсронгуй хөрөнгө оруулагч нар нийлсэн хэсэг хойш суугчид үлдсэн байв.

Гэвч шүүхийн системийг сорих зорилготой үлдсэн тэдгээр хойш суугчдын өрийн бүтцийг өөрчлөхийг болиулах талаар тавьсан анхны хүчин чармайлтыг АНУ-ын шүүхүүд хүлээж авахаас татгалзсан учраас тэдэнд шинэ бондын төлбөрийг зогсооход бэрхшээл учрах болно.

Дууссан, дууссан гэж хэлснээр бүх юм болчихгүй

Сүүлийн үеийн хямралууд нь ОУВС шинэ үүрэг гүйцэтгэж, урьд өмнө тохиолддог байснаас ч илүү их өрөнд орсон (ДНБ-тэй нь харьцуулахад) орнуудад их хэмжээний хөрөнгө мөнгө зарцуулахад хүргэж байна. Гэвч бид Их 7 буюу ОУВС-гийн албан ёсны бодлого боловсруулагч байгууллага болох Олон Улсын Мөнгө, Санхүүгийн Хорооны сүүлийн үеийн бодлогын мэдэгдлүүдээс харахад олон улсын санхүүгийн бодлого боловсруулагч дээдсийн дунд цаашид ийм хямралтай хэрхэн тэмцэхийг харуулсан ямар нэг бодитой яриа хэлэлцүүлэг харагдахгүй байна.

Их 7-гийн хувьд өөрийн мэдэгдэлдээ томоохон зээлдүүлгийн эрин үе дууссан гэсэн дохио өгөхийг илүүд үзэж байна. Бразил улсын хувьд түүхэн амжилт байж болох боловч түүнийг дахин давтах санаа Их 7-д байсангүй. Харин тэд ОУВС-д зээлдүүлгийн хуучин хязгаарлалтандаа эргэж орохыг хүссэн хүсэлт тавиад байна. Эдгээр хязгаарлалт нь Мексик юм уу Бразилийн хэмжээтэй аврах багцыг танаж, зөвхөн Туркийнх шиг хэмжээтэй аврах багцыг зөвшөөрөх юм. 2002 оны Их 7-гийн мэдэгдэл жирийн л нэг мэдэгдэл байв: «Бид онцгой нөхцөл байдалд зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд албан ёсны зээлдүүлгийг хэвийн хэмжээнд барьж хязгаарлахаар бэлтгэж байна... албан салбараас үзүүлэх дэмжлэг хязгаарлагдмал болж байгаа нь улам бүр тодорхой болж байна. Албан салбарын зээлдүүлгийг хязгаарлаж, хувийн салбарын зээлдүүлгийг хөгжүүлэх явдал бол манай үйл ажиллагааны төлөвлөгөөний нэг чухал хэсэг юм¹⁵». Энд «онцгой нөхцөл» гэсэн цоорхойг тааруухан тодорхойлсон ч гэсэн цаад санаа нь нилээд тодорхой байна. Мөн Их 7-гийн бодлогын мэдэгдэл нь АНУ-ын сангийн сайдын орлогч байсан Жонн Тэйлорийн хамгийн хүчтэйгээр илэрхийлдэг байсан нэгэн итгэл үнэмшлийг тусгасан байдаг¹⁶. Тэр нь олон улсын бондуудад заасан хамтарсан арга хэмжээний нөхцлүүд нь ОУВС-гийн их хэмжээний аврах ажиллагааг хэрэгцээгүй болгоход туслаад

зогсохгүй ОУВС баталгаат өрийн бүтцийн томоохон өөрчлөлтөөр дамжуулан аливаа улс орныг удирдан залах хэрэгцээг багасгахад туслана гэсэн итгэл үнэмшил юм.

Харамсалтай нь уламжлалт зээлдүүлгийн хязгаарт эргэж орох уриалга, мөн бондын нөхцлүүд албан салбарын оролцоог улсын өрийн бүтцийг өөрчлөлтөөс амжилттай гаргана гэсэн итгэл үнэмшил хоёр хоёулаа бодит байдлаас зайлсхийх оролдлогууд юм. Бондын нөхцлүүд ОУВС-гийн аврах ажиллагааны эрэлт хэрэгцээг багасгахгүй. Тэгвэл яагаад? Яагаад гэвэл, томоохон аврах ажиллагааны санхүүгийн дарамт үзүүлэгч гол эх сурвалж нь бондын төлбөрүүд биш байсан. ОУВС-гийн «онцгой» зээл олгоход хүрч байсан найман жишээний дөнгөж ганцынх нь төвд бондууд тавигдаж байв. Бондын хямрал онцгой нүүрлэсэн Аргентинд хүртэл дотоодын банкуудын нөөц хомсдсон нь хугацаа дууссан урт хугацаат бондын төлбөрөөс ч илүү дарамтыг тус улсын валютын нөөцөд үзүүлж байв. Ихэнх тохиолдолд богино хугацаат өр илүү их асуудал үүсгэдэг. Бондын нөхцлүүд улсын өрийн бүтцийн өөрчлөлтийг зөөлрүүлэхгүй төдийгүй санхүүгийн хувьд сонирхолтой бус байдаг. Ийм нөхцлүүд нь өрийн бүтцийн өөрчлөлтөөс болж банкуудын эсвэл валютын гэнэтийн эрэлт хэрэгцээнд учруулах эрсдлийг ид шидтэй мэт арилгахгүй бөгөөд тухайн улс бондын хүүгээ төлөхийн тулд хэр их төсвийн хүчин чармайлт тавих ёстой талаар зээлдэгч улс ба түүний зээлдүүлэгчдийн хооронд тохиролцоонд хүрэхэд нэмэр болохгүй.

ОУВС-гийн гүйцэтгэх үүргийг хязгаарлах шаардлагатай тухай бусад бүх яриануудын хувьд гадаад зээлдүүлгээ татан авснаас үүссэн богино хугацаат хөрвөх чадварын хэрэгцээнээс хол давсан олон янзын бэрхшээлтэй асуудлыг хөндөн авч үзэж шийдвэрлэхэд ОУВС-гийн аврах ажиллагааг ашигладаг учраас практик дээр түүний гүйцэтгэх үүрэг улам бүр өргөжиж байна. ОУВС-гийн аврах ажиллагаа нь өрөнд орсон эдийн засгуудыг ямар нэг засгийн газрын өрийн шинэчлэл хийх зовлонгоос ангижруулж шуудхан хэлэхэд голдуу төсвийн ихээхэн хүчин чармайлтын үр дүнд аврах зорилгод улам ихээр ашиглагдаж байна. Зөвхөн тухайн орны гадаад өрийн санхүүгийн хүндрэлийг шийдвэрлэхэд төдийгүй их хэмжээний дотоод өрөөс үүссэн дарамт шахалтыг зохицуулахад ОУВС-г улам ихээр ашиглах болсон байна. Турк, Бразил хоёр хоёулаа олон улсын бондоос хамаагүй их хэмжээний засгийн газрын дотоод өртэй байна. Мөн олон улсын бондыг тэр

бүр гадаадын хөрөнгө оруулагчид эзэмшээд байдаггүй. 2001 оны жилийн эцсийн байдлаар дотоодын аргентинчууд тус улсын олон улсын бондын 50 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байв. Туркт ОУВС тус улсын банкинд хадгаламж эзэмшигчдийн болон олон улсын хөрөнгө оруулагчдын хөрөнгийг үр нөлөөтэй аварч байна. Аргентин, Уругвай улсуудыг тухайн улс долларжсан банкны системийнхээ сүүлийн ганц дотоодын зээлдүүлэгч болж ажиллахад шаардлагатай хатуу валютаар ОУВС хангаж өгсөн. Дотоодын өрийн зах зээлд дэмжлэг үзүүлэх, түүнчлэн шинээр төрөн гарч буй зах зээлтэй орнуудын дотоодын санхүүгийн системд дэмжлэг үзүүлэхэд ОУВС-г ашиглах нь түүний өргөн хүрээтэй бүрэн эрхэд нийцэхгүй. Нэгдэн нягтарсан капиталын зах зээл, нээлттэй капиталын дансуудтай ертөнц дээр дотоодын бүтцийн өөрчлөлт буюу дотоод төлбөрийн чадвараа алдалт нь дангаараа гадаад төлбөрийн хямралд маш хурдан оруулж болох юм. Гэхдээ энэ нь ОУВС-гийн одоогийн үүрэг хувьсан хөгжиж байна гэсэн санааг бодитойгоор агуулж байгаа юм.

ОУВС-гийн санхүүжилтийг хязгаарлах хэвийн хэмжээний хязгаарлалтад эргэж орох тухай яриа бол олон янзын санхүүгийн хямралуудад ОУВС-гийн гүйцэтгэвэл зохих үүргийн тухай ширүүн мэтгэлцээнээс зайсхийх нэг арга болоод байна. Албан салбарын хувьд ОУВС-гийн санхүүгийн чадавхийг хэрхэн ашиглах боломжуудыг үнэлэхийн оронд ОУВС-гийн санхүүгийн чадавхийг багасгасан дүр үзүүлэхийг илүүд үзэж байна. 1995 онд Клинтонь засаг захиргаа ОУВС-г Мексикт сүүлчийн цорын ганц зээлдүүлэгчийн үүргийг орлон гүйцэтгэгчээр ажиллахыг дэмжсэн шийдвэр гаргасан шиг, сүүлийн үед гаргасан зээл олгох шийдвэрүүд нь шинээр төрөн гарч буй зах зээлүүдийн хямралд хариу үзүүлэх чиглэлд ОУВС-гийн гүйцэтгэх үүргийг өргөжүүлж байгаагаараа ач холбогдолтой. Гэхдээ бусад хямралын үед ОУВС энэ үүргээ гүйцэтгэх ёстой эсэхийг тодорхойлох ямар нэг хүчин чармайлт тавигдаагүй байна.

Энэ бол харамсалтай хэрэг. ОУВС Мексикт шинэ чиглэлээр ажилласныхаа дараа ОУВС-гийн хэвийнхээс их хэмжээний зээл олголт хэзээ тохиромжтой болохыг ойлгуулахаар АНУ Их 7-гийн бусад оронтой ажилласан. Үүний үр дүнд энэ төрлийн зээлдүүлэгт тохирсон шинэ арга хэрэгсэл бий болж, ОУВС-гийн нөөц хөрөнгө нэмэгдсэн бөгөөд улмаар ирээдүйн хямралуудын үед энэ үүргээ гүйцэтгэх

боломжтой болсон юм. Харин Турк, Уругвай зэрэг оронд ОУВС-г ийнхүү шинээр ашиглах болсон нь бодлогын ерөнхий хүрээнд хэр нийцэж байгаа эсэх, эсвэл бусад оронд үүнтэй адилхан хүндрэл гарлаа гэхэд эдгээр хямралд ОУВС-гаас үзүүлсэн хариу үйлдлүүдийг дахин давтах ёстой эсэх талаар тодорхой ойлгуулахад чиглэсэн үүнтэй төстэй өөр ямар нэг хүчин чармайлт дахиж гарсангүй.

Бидэнд хуурамч биш, жинхэнэ шийдэл хэрэгтэй байна

Санхүүгийн хямралд хандах дэлхийн хандлагыг чиглүүлж өгөх ёстой гэж бидний үзэж буй зарчмуудыг дэвшүүлэн тавихын өмнө үлгэрт гардаг дууч эмсийн ховсдох дуу мэт цөөн хэдэн толгой эргүүлэм асуудлыг тоолгүй орхих ёстой.

ОУВС-гийн санхүүжилтийг сайн бодлого баримталсан учраас урьдчилан шалгарсан орнуудаар хязгаарлах

Хэрвээ ОУВС-гаас санхүүжилт авах шалгуурыг хэт өндөр тогтоох юм бол тэндээс шалгарсан орнууд ОУВС-гийн дэмжлэг авахыг хүсэхгүй буюу тэдэнд энэ дэмжлэг хэрэггүй байх болно. Хэрэв уг хязгаарлалтыг хэт доогуур тогтоох юм бол ОУВС хямралд орсон орнуудад бараг ямар ч болзолгүйгээр санхүүжилт олгохоос аргагүй болно. Гэхдээ санхүүгийн эмзэг байдлын эх сурвалжийн талаарх бидний мэдлэг хараахан төгс болоогүй байна. Аргентин улс дөнгөж саяхан буюу 1999 онд биш юмаа гэхэд 1998 онд, шинэчлэлийн загвар болох хэмжээнд яригдаж байсан гэдгийг санацгаая. Асуудалд орсон ихэнх орнууд түүнээс гарахын тулд гол бодлогынхоо заримыг өөрчлөх ёстой байдаг. Урьдчилан шалгаруулалтад үүсэх хоёр дахь бэрхшээлтэй асуудал бол энд хэрвээ ОУВС улс орнуудыг сайн, муугаар нь ялгаж урьдчилсан жагсаалт гаргах юм бол ОУВС болон түүний улс төрийн удирдагчид болох Их 7-гийн орнууд «муу» гэсэн орнуудаас нүүрээ буруулж болно гэсэн төсөөлөл үүсч байгаад оршино. Энэ бол боломжгүй зүйл, бидний мэдэж байгаагаар энэ шалгаруулалтад унахаар хэт том эсвэл хэт жижиг улс гэж байхгүй: Аргентин улс хэнээс ч илүү их бондтой байсан боловч төлбөрийн чадваргүй болж байсан, Орос улс хэнээс ч илүү их тэсрэх бөмбөгтэй боловч мөн төлбөрийн чадвараа алдаж байсан. Гэвч ядаж туслахыг хичээхээр зогсохгүй дэндүү их ач холбогдолтой олон орон байдаг.

Улс орнуудаас илүү бондын зах зээлийг аврах бодлого баримтлах

Зах зээлийн үнийн хэлбэлзлийг хязгаарлахын тулд хоёрдогч зах зээл дээрээс бонд худалдан авах боломжийг ОУВС юмуу эсвэл өөр нэг байгууллагад олгох ёстой гэсэн саналыг зарим хүмүүс дэвшүүлдэг. Цөөн тооны нөлөө бүхий эдийн засагчид хүртэл 2001 онд Аргентины бондыг нэг долларыг нь 60 центээр худалдаж авахыг санал болгож байв¹⁷. Энэ бол тийм сайхан санаа биш.

Хямралд орсон орнуудад урт хугацааны өрийг нь үнэлэх доод үнэ бус, бэлнээр тооцоо хийх мөнгө хэрэгтэй байдаг. Хүндрэл бэрхшээлтэй байгаа орнууд урт хугацаат өрийнхөө үнийн дүнгийн талаар ихээр санаа зовохоос илүү гадаад валютын зах зээлээ тогтворжуулах, дотоод банкны тогтолцоогоо дэмжиж тулах, хугацаа нь тулсан богино хугацаат өрөө төлөх шаардлагатай байдаг. Бондын хоёрдогч зах зээлийн үнэ огцом унах нь уг өрийг худалдан авсан хөрөнгө оруулагчдад хүндрэл учруулдаг. Гэвч бондын төлбөрийн хугацаа ойртож ирэх хүртэл тухайн улсад тулгамдсан бэрхшээлтэй асуудал үүсгэхгүй. 2002 онд Бразилийн урт хугацаат бондыг нэг долларыг нь 50 центээр арилжаалжээ. Ингээд Бразил улс сэргэх үед тэдгээр бондын үнийг нөхөн төлсөн байна. Гадаадын хөрөнгө оруулагчдаас бонд худалдан авахад мөнгө зарцуулж, тэднийг алдагдал багатайгаар гарч явах боломж олгож байгаа нь тухайн хямралт оронд нэг их тус болдоггүй. Харин энэ нь уг бондыг худалдан авч буй байгууллага буюу ОУВС эсвэл бусад байгууллагыг асар их эрсдэлд оруулдаг. Зарим хүмүүсийн санал болгосноор Аргентиний 90 тэрбум ам.долларын олон улсын бондыг нэг долларыг нь 60 центээр худалдаж авсан бол 54 тэрбум ам.доллар болох байсан бөгөөд үнэн хэрэгтээ ОУВС-гаас Аргентинд зээлдүүлсэн 15 тэрбум (цэврээр 10 тэрбум \$) ам.долараас хамаагүй их байх байв.

Үүний зэрэгцээ зүгээр нэг одоо хэрэглэж байгаа аргыг үргэлжлүүлэн хэрэглэж, валютын ханшны зохицуулалт, өрийн бүтцийн өөрчлөлтөөс эсвэл аль алианаас нь зайлсхийхийн тулд орон бүрт их хэмжээний мөнгө өгөх бодлогыг институцижүүлэх нь хямралд хандах зөв арга биш. Бодлогын ийм хандлага нь Аргентинд гарсан шиг алдаанд хүргэх болно. Валютын зөвлөлийг аврахыг оролдож хэт их мөнгө үрсэн, мөн өрийн бүтцийг өөрчлөхөөс зайлсхийхийн тулд зайлшгүй шаардлагатай

байгаа мөнгөний ханшны бууралт ба өрийн бүтцийн өөрчлөлтөөс ирсэн цохилтыг, ялангуяа дотоодын санхүүгийн системд өгөх цохилтыг зөөлрүүлэх мөнгө үлдээгээгүй байна.

Хямралыг шийдвэрлэхэд чиглэсэн илүү ухаалаг аргын үндэс сууриуд

Шинээр гарч буй зах зээлийн хямралыг шийдвэрлэх илүү сайн аргад ямар зарчмуудыг удирдлага болгох вэ? Бидний үзэж байгаагаар гол асуудлууд уг системийн бүтцэд бус арга барилд байна. Энэ бол сайн мэдээ. Шинэ бүтэц тогтолцоо бий болгоход шаардлагатай улс төрийн дэмжлэгийг бүрдүүлэхээс илүү олон улсын системийн арга барилыг сайжруулах нь хамаагүй хялбар байх юм. Ер нь олон янзын хямралд хариу үйлчлэх үндсэн арга хэрэгслүүд хэрэгтэй байна. Гол сорилт бол эдгээр арга хэрэгслийг илүү сайн ашиглах, байгаа хэрэгслүүдээ төрөл бүрийн хямралд тохируулан хэрэглэх талаар илүү сайн ажиллах явдал юм.

Одоогийн бүтэц тогтолцоог онц байдлын санхүүжилт олгох тогтолцоо, өрийн бүтцийг өөрчлөх тогтолцоо гэсэн хоёр төрөлд хувааж болно. Санхүүгийн дэмжлэг үзүүлэх тогтолцооны гол төв нь ОУВС бол байна. 1998 онд ОУВС-гийн нөөц хөрөнгө нэмэгдснээс хойш Их 7-гийн орнуудын хоёр талт санхүүжилт дагаж буурсан байна. Онц байдлын санхүүжилтын хувийн эх үүсвэрүүд байхгүй байгаа нь нилээд ойлгомжтой. Хувийн зээлдүүлэгчид тухайн хямралт оронд учрах эрсдлээ багасгахыг хүсдэг учраас албан ёсны санхүүжилт л улс орнуудад хэрэгтэй болдог. ОУВС одоогийн байдлаар (2005) Бразил гэх мэт шинээр төрж буй томоохон эдийн засагтай орнуудад ДНБ-ий 5 орчим хувьтай тэнцэх хэмжээний аврах зээл олгоход шаардагдах хэмжээний нөөц хөрөнгөтэй байна. Улс орнуудын ар талд санхүүгийн түшиг тулгуур байх хэрэгтэй, гэхдээ улс орнууд ба хөрөнгө оруулагчдыг бүх эрсдлээс хамгаалах тийм их хэмжээтэй байх шаардлагагүй учраас энэ нь ч бараг зөв юм.

Өрийн бүтцийг өөрчлөн шинэчлэх тогтолцооны хувьд Британийн үндсэн хуультай бага зэрэг төстэй. Энэ тогтолцоо нэг газар эсвэл нэг баримт бичгээр тогтохгүй. Гэвч тэнд шаардлагатай институциуд бий. Өрийн бүтцийг шинэчлэх тогтолцооны төвд олон арга хэрэгсэл бүхий өрийн арилжаа байдаг. Энэхүү арилжаа нь олон янзын арга хэрэгслээр өрийн бүтцийг өөрчлөх

ажлыг удирдан зохицуулах гол үүрэгтэй: бонд эзэмшигч бүр арилжаанд оролцож буй бусад бонд эзэмшигчдэд санал болгосон нөхцлүүдийг мэдэж байдаг бөгөөд үүнд хуримтлагдсан өрийн бондыг баримтжуулах ашигладаг эрх зүйн хэм хэмжээнүүд хувьсан хөгжиж байгаа явдал тус дэм болдог. Бонд болон бусад арилжаалагддаг үнэт цаасны бүтцийг өөрчлөх үүрэгтэй институциуд дээр тухайн албан салбарын чадавхи нэмэлт үүрэг гүйцэтгэдэг. Саяхан хүртэл дутуу ашиглаж байсан энэ чадавхи бол аливаа хямралт орон хил дамнасан банкны зээлдүүлэгчдээс өрийн нэхэмжлэлийнхээ хугацааг хойшлуулахыг шахааж шаардах чадавхи юм. Албан салбар тэдний хүлээсэн үүрэг амлалтыг хянаж байна гэдгийг банкууд мэдэх тохиолдолд ийм тохиролцоо маш сайн. Ялангуяа аливаа улс улс орноо эмхэлж цэгцэлж эхэлтэл хангалттай хугацаа хожиж авах зорилготой байгаа тохиолдолд богино хугацаат гадаад өрийн хугацааг хойшлуулах чадвар хямралын гол шийдэл байж болно.

Тэгвэл арга барилын хувьд яах вэ? ОУВС-гийн зүгээс бүх улс оронд их хэмжээний онц байдлын санхүүжилт авах боломжийг үгүйсгэх эсвэл сонгосон валютын ханшны дэглэмээ тогтоон барихыг оролдож буй бүх улс оронд их хэмжээний санхүүжилт олгох, мөн тэдний өрийг бүрэн төлөх гэх мэтээр бүх улс оронд адилхан хандаж болохгүй. Харин түүний оронд ижил нөхцөл байдалд буй улс орнуудад ижил байдлаар хандахыг бодлого боловсруулагчид эрмэлзэх ёстой.

Үүнтэй холбогдуулан орчин үеийн шинээр төрөн гарч буй зах зээлүүдийн хямралыг шийдэх хүрээ болсон дараахь зургаан үндэс суурийг бид зөвлөмж болгож байна:

1. *Шинээр төрөн гарч буй зах зээлийн бүх хямрал, тэр ч байтугай капиталын урсгалын гэнэтийн хэлбэлзлээс үүссэн бүх хямрал хүртэл харилцан адилгүй гэдгийг хүлээн зөвшөөрөх.* Тогтмол валютын ханшаа хамгаалахын төлөө хамаг нөөцөө бараад дууссан өрийн түвшний хувьд гайгүй (Мексик шиг) орнуудыг аврах, өрийн гүн хямралын эргүүлэгт орох нь холгүй байгаа ихээхэн өрийн дарамттай (Турк шиг) орнуудыг аврах хоёрын хооронд асар их ялгаа бий. Бүх юм сайнаар эргэвэл харьцангуй хүчтэй байр сууринаас эхэлж байгаа Мексик шиг орнууд ОУВС-гаас авсан зээлээ харьцангуй хурдан эргүүлэн төлж

болно. Харин бүх юм сайнаар эргэлээ ч их хэмжээний өртэйгээр хямралд орсон Турк шиг улсууд ОУВС-гаас авсан зээлээ харьцангуй хурдан хугацаанд эргүүлэн төлж чадахгүй.

2. *Шинээр төрөн гарч буй зах зээлийн санхүүгийн хямралын хамгийн том бэрхшээлүүд гадны зээлдүүлэгчид зарга мэдүүлснээс бус, харин гадна талын санхүүгийн дарамт ба дотоодын санхүүгийн тогтолцооны хоорондын эргүүлгээс болж үүсдэг.* Өрийн бүтцийг шинэчлэх үеэр олон улсын өрийн бонд эзэмшигчдийн нэхэмжлэлийг багасгахад тавьж буй анхаарлын хэмжээ эдгээр нэхэмжлэлийн учруулж буй бодит аюул заналаас харьцангуй зөрөөтэй байна¹⁸.
3. *Ямар нэг хэлбэрийн өрийн бүтцийн өөрчлөлтийн цаана агуулагдаж буй эрсдлээс зайлсхийхийг оролдож буй дунд зэргийн өртэй орнуудад туслахыг хичээх, өрийн бүтцийн өөрчлөлт зайлшгүй хийхээс аргагүй тохиолдолд түүнтэй холбоотой цохилтыг зөөлрүүлэхэд туслах аль ч зорилгын хувьд олон улсын хамтын нийгэмлэгийн гарын дор буй хамгийн хүчирхэг хэрэгсэл бол бэлэн мөнгө буюу ОУВС-гаас зээлсэн гадаад валют хэвээр байна.* Дараагийн удаа ямар нэг шинээр төрөн гарч буй томоохон эдийн засаг хямралд орох үед ОУВС уламжлалт зээлдүүлгийн хязгаарлалтандаа эргэж орох гээгүй байна. Тусбайгууллага бодлогын хүрээгээ үүнд нийцүүлэн тохируулах ёстой. Гэхдээ тухайн хямралт орон зайлшгүй шаардлагатай бодлогын өөрчлөлт хийх бодитой үүрэг хүлээн дэмжиж байгаа тохиолдолд л ОУВС-гийн бэлэн мөнгө жинхэнэ ёсоор үйлчилдэг. Эдгээр зайлшгүй шаардлагатай өөрчлөлтийн дотор валютын ханшны дэглэмийн өөрчлөлт орох нь олонтаа байдаг.
4. *Заримдаа улс орнуудыг ямар нэг хэлбэрийн өрийн бүтцийн өөрчлөлтөөс зайлсхийхэд туслахад ОУВС-гийн мөнгө хамгийн сайн ашиглагддаг боловч заримдаа өрийн бүтцийн өөрчлөлтийг орлуулах биш, түүнд нэмэлт болгож ашигласан нь дээр байдаг.*

ОУВС дараахь гурван өөр хариу үйлдлээс сонгож авах хэрэгтэй:

- Аливаа хэлбэрийн өрийн бүтцийн өөрчлөлтөөс зайлсхийхийн тулд цорын ганц сүүлчийн зээлдүүлэгчийн үүрэг гүйцэтгэх. ОУВС өөрөө жинхэнэ цорын ганц сүүлчийн зээлдүүлэгч биш боловч түүний үүргийг орлон гүйцэтгэж болно. Зарим өрийг хугацаа дуусмагц нь төлж барагдуулснаар тухайн улс зах зээлийн итгэх итгэл буюу «өөрчлөлтийг түргэтгэгч» санхүүжилт гэгчийг хурдан эргүүлжавахадвартай болно гэж найддаг. Аливаа улсын хүндрэл бэрхшээл голдуу нөөц хөрөнгийн хомсдлоос үүссэн, өрийн түвшин доогуур байгаа, удирдлагууд нь (магадгүй оройтсон ч) шаардлагатай бодлогын зохицуулалтуудыг хийхэд бэлэн байгаа тохиолдолд энэ төрлийн санхүүжилт хамгийн тохиромжтой.
- Төлбөрийн хугацааг сунгахад чиглэсэн өрийн бүтцийн өөрчлөлтөд санхүүжилтийн дэмжлэг үзүүлэх. Энэхүү бүтцийн өөрчлөлт нь тухайн улс зээлдүүлэгчдийг хүндрэлээс зугтаалгалгүйгээр цаг хожих зорилготой. Ийм санхүүжилт нь бүтцийн өөрчлөлтөөс болж дотоодын банкны систем ба дотоод валютын нөөц шавхагдахаас урьдчилан сэргийлэхэд тусалдаг. Тухайн улс хүнд байдлаас гарахын тулд нилээд хэдэн жил шаардагдах нь тодорхой байгаа тохиолдолд энэ арга хамгийн тохиромжтой. Одоогийн нэг жишээ гэвэл Уругвай улс байна. Тус улс ОУВС-д хандаж дотоодын банкны системдээ найдвартай түшиг тулгуур олж авч чадах эсэхээс хуримтлагдсан өрийн шинэчлэлийг амжилттай явуулж чадах эсэх нь хамаарч байна.
- Санхүүгийн хувьд эрүүл саруул болгохын тулд өрийн бүтцийг өөрчлөх шаардлагатай нь анхнаасаа бараг тодорхой байгаа үед өрийн бүтцийн гүн гүнзгий өөрчлөлт шинэчлэлийг дэмжсэн санхүүжилт олгох. Энэ нь 2001 оны эхээр Аргентинд авч хэрэглэх ёстой байсан гэж бидний үзэж байгаа арга юм.

Мэдээжийн хэрэг эдгээр боломжийн дундаас сонголт хийхийн тулд шийдэмгий шулуухан дүгнэлт хийх шаардлагатай. Энэ нь зарим оронд хандаж, та нар өрийн бүтцийн өөрчлөлт хийхэд бэлэн байгаа тохиолдолд л

ОУВС туслана гэж хэлнэ гэсэн үг. Одоогийн байдлаар ОУВС ихэвчлэн цорын ганц сүүлчийн зээлдүүлэгч маягаар санхүүжилт олгох хандлагатай байна. Өөрөөр хэлбэл, аливаа оронд богино хугацаат өрөө төлөх боломж олгож, энэ нь хөрвөх чадваргүй болох асуудлын нэг байсан болох нь нотлогдоно гэж найддаг. Энэ нь үйлчилж байвал сайн хэрэг. Гэхдээ бас зарим нэг зайлшгүй бүтцийн өөрчлөлтөөс зайлсхийхийг оролдвол ОУВС өөрөө зээл олгох чадавхиа алдаж, улмаар өрийн бүтцийг шинэчлэх үйл явцад үзүүлэх нөлөөгөө хязгаарлахад хүргэнэ гэсэн үг.

5. **Өрийн бүтцийн өөрчлөлт хямралаас гарах зөв арга мөн байх тохиолдолд ОУВС хойш суух ёсгүй.** Өрийн бүтцийн өөрчлөлтийн явцад ОУВС-гаас зээл олгох нь бонд эзэмшигчдэд өгөх бэлэг болох албагүй. Өрийн бүтцийн өөрчлөлтийн явцад ОУВС-гийн санхүүжилтийг ашиглах бусад олон янзын боломж байдаг. Зохих хамгаалалттай хэрэглэсэн ОУВС-гийн зээлийг Уругвайд тохиолдсон шиг дотоодын банкны системд дэмжлэг туслалцаа үзүүлэхэд ашиглаж болно, эсвэл валютын ханш хэт их унахаас сэргийлж гадаад валютын зах зээлд хийх бага хэмжээний интервенцийг санхүүжүүлэхэд ашиглаж болно. АНУ-ын бизнесийн салбарт хэрэглэдэг «өртэй этгээдийг мэдэлдээ оруулах санхүүжилт» гэдэг хэллэгтэй адил утгаар, ОУВС тухайн улсад шаардлагатай мөнгийг гаргаж өгснөөрөө тэр улсаа макро эдийн засгийн үйл явцыг тодорхойлоход нь туслах болон төлбөрийн хүндрэлээ хурдан шийдвэрлэх шахалт үзүүлэхэд хэрэгтэй хөшүүргийг олж авах юм. Өрийн бүтцийн өөрчлөлт хийх гэж байгаа ихэнх орны хувьд Эверестийн оргилд авирагчдын нэг адил Шерпа буюу хөтөч хэрэгтэй байна.
6. **ОУВС бол Их 7-гийн геополитикийн ашиг сонирхлыг хамгаалвал зохих хэрэгсэл биш гэдгийг ОУВС-гийн улс төрийн зөвлөхүүд мартаж ёсгүй.** Хэрвээ Турк улс дампуурах нь стратегийн хувьд хэтэрхий ач холбогдолтой биш юм бол, ядаж түүнд туслахыг хичээхгүй байх нь стартегийн хувьд хэтэрхий ач холбогдолтой байна. Гэвч дан ганц энэ шалтгаан түүнийг ОУВС-гаас их хэмжээний зээл авах сайн нэр дэвшигч болгочихгүй. Одоогийн байдлаар өр ба ДНБ-ий харьцаа нь 80

орчим хувьтай, ДНБ-ийхээ 10 хувьтай тэнцэх төсвийн алдагдалтай улс бүрт ДНБ-ий 10 хувь буюу түүнээс их хэмжээний зээлийг 5 буюу түүнээс дээш жилээр олгох энгийн боломж ОУВС-д байхгүй. Хэрвээ ямар нэг улсад 2001 оны Туркийнх шиг дундаас урт хугацаатай их хэмжээний мөнгө шаардагдлаа гэхэд тэр мөнгөний ихэнх нь ОУВС-гаас бус Их 7-гоос гарах ёстой болно.

Дүгнэлт

Уотергейтийн дуулиант хэргийн үеэр Дийп Троэтийн хэлсэн алдарт хэллэгийг бага зэрэг өөрчилсхийж хэлвэл¹⁹, ОУВС-д тулгарч буй гол асуудлуудыг ойлгохын тулд бид «мөнгийг мөшгих» ёстой. ОУВС ч өөрөө улс орнууд гадаад итгэл хүлээх чадвараа удирдахад туслах явдлаас хальж гараад байна. Одоо тус байгууллага дотоодын банкны системийг дэмжиж тулах, дотоодын төсвийн алдагдлыг санхүүжүүлэхэд туслахын зэрэгцээ шинээр төрөн гарч буй эдийн засгууд зөвхөн богино хугацаат санхүүжилтээр зогсохгүй дунд ба урт хугацааны төсвийн зохицуулалтын хөтөлбөр хэрэгжүүлж байгаа учраас тэдэнд дундаас урт хугацааны санхүүжилт олгох туслалцаа үзүүлж байна. Эдгээр үүрэг нь гэнэт тохиолдлоор бий болчихоогүй, бодит хэрэгцээнд хариу өгөх үүднээс үүссэн юм.

Ирээдүйд ОУВС дотоод итгэх итгэлийн хямралтай улам ихээр тулгарна гэж төсөөлөхөд буруудахгүй. Шинээр төрөн гарч буй олон эдийн засагт дотоод өрийн түвшин өндөр хэвээр байна. Капиталын зах зээл нээлттэй болсноор хямралт үед зөвхөн гадаадын хөрөнгө оруулагчид санхүүжилтээ татажавахад төдийгүй дотоодын оршин суугчид ч хадгаламжаа гадаад руу шилжүүлэхэд хялбар болгож байна.

Цаашилбал ОУВС санхүүгийн нөөцөө хэрхэн хамгийн үр ашигтай зарцуулах вэ гэдэг талаар хүнд хэцүү сорилтуудтай тулгарах шаардлага үргэлжлэн гарах магадлалтай байна. Өр ихтэй байна гэдэг бол ихэвчлэн шууд эсвэл шууд бус утгаараа онцгой байдлын санхүүжилт их хэмжээгээр хэрэгтэй байна гэсэн үг болж байна. Аливаа улсын өр ба ДНБ-ий харьцаа 60, 70 эсвэл 80 хувь орчим байсан үеэ бодвол 30 орчим хувь байх юм бол тухайн улсын ДНБ-ий 5 хувь, бүр 10 хувьтай тэнцэх хэмжээний хүсэлтэд ОУВС-гаас олгосон зээл санхүүгийн хувьд илүү хүчтэй тусах юм. Их хэмжээгээр зээл олгох, их хэмжээгээр зээл олгохгүй байхын

аль аль нь эрсдэлтэй. Хангалттай хэмжээний мөнгө гаргаж өгөхгүй байх нь зах зээлийн мэдрэмжид тодорхой өөрчлөлт үүсгэхгүйгээр ОУВС-гийн зээл олгох чадавхийг хязгаарлах эрсдэлтэй. Гэхдээ өсөн нэмэгдэж буй санхүүгийн хэрэгцээг даган ОУВС-гийн зээл олголтыг нэмэгдүүлж тодорхой цэгт хүргээд зогсоох нь ухаалаг сонголт байх болно. Энэ нь ОУВС-д учрах эрсдлээс гадна ёс суртахууны эрсдэл үүсгэж болдог. Өөрөөр хэлбэл ОУВС түшиж тулснаар тухайн улсыг төдийгүй түүний зээлдүүлэгчдийг тааруу бодлого, муу хөрөнгө оруулалтаас хамгаална гэсэн хүлээлт үүсгэдэг.

Олон улсын капиталын урсгалын хувьд ороо бусгаа дэлхий ертөнц дээрх шинээр төрөн гарч буй зах зээлийн эдийн засгуудын тогтвортой, хэвийн өсөлт юуны түрүүнд тэдгээр орон дэлхийн зах зээлийн гэнэтийн өөрчлөлтүүдээс өөрсдийгөө хамгаалах сайн макро эдийн засгийн бодлого, өрийн бүтэцтэй байж чадах чадвараас хамаарч байна. Гэвч олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс ч улс орнууд тохиолдлын чанартай хямралуудыг гэтлэхэд туслахад бэлэн байж, тэдэнд учирсан хямралаас үүдсэн нийгэм, эдийн засгийн зардлыг багасгахад туслахыг хичээх ёстой.

Мөн хэтэрхий их зээл олгох, хэтэрхий бага зээл олгох хоёрын зөв тэнцвэрийг олох явдал ч ямагт шийдвэрлэх асуудал байдаг. ОУВС улс орон бүрт өрийн бүтцийн өөрчлөлтөөс зайлсхийх боломж олгохыг хичээх үедээ арай хэтэрхий их зээл олгох, тодорхой орнуудад өрийн бүтцийн өөрчлөлтөөр дамжуулан туслахдаа арай хэтэрхий бага зээл өгөх хандлагатай болоод байна уу гэж бид сэжиглэж байна. Гэхдээ ОУВС уламжлалт зээлдүүлгийн хязгаартаа эргэж орохыг уриалсан улигт уриалга (аливаа хямралын үед ямагт мартагддаг нэг уриалга) энэ талаарх мэтгэлцээнийг урагш ахиулахгүй байна гэдэгт бид итгэлтэй байна. Харин түүний оронд өнөөгийн макро эдийн засгийн болон санхүүгийн тааламжтай нөхцөл байдлаас үүссэн нам жим байдал нь ОУВС-гийн их хэмжээний зээллэгт онцлон авч үзэх ёстой ба авч үзэх ёсгүй багц асуудлыг шийдвэртэй авч хэлэлцэх боломж олгож байгаа юм.

Тайлбар

- 1 Энэхүү өгүүлэлийг зохиогчийн саяхан нийтлүүлсэн Bailouts or Bail-ins? Responding to Financial Crises in Emerging Economies /Гаднаас эсвэл дотроос аврах арга хэмжээ юу? Шинээр төрөн гарч буй эдийн засгууд дахь санхүүгийн хямралд хариу өгөхүй/, 2004 номонд ихээхэн тулгуурласан болно.
- 2 Мексикийн долларар нэрлэгдсэн бондууд.
- 3 Рубин, Вайсберг нар, 2003 болон Рубин, 1998.

- 4 Шинээр төрөн гарч буй олон эдийн засгууд 1997 оноос өмнөх үед гэнэтийн өндөр өсөлттэй байсан бол Оросын эдийн засаг шилжилтийн эхний жилүүдэд тогтмол буурсаар байв. Орос улсын бүтээгдэхүүн үйлдвэрлэл 1997 онд тогтворжсоны дараа 1998 онд дахин буурсан. Харин рублийн ханш унасан нь газрын тосны үнийн өсөлттэй нийлэн Оросын эдийн засагт хүч өгсөн болох нь нотлогдсон. Тус улс 1999 онд тогтвортой өсөлтийн үед орсон. 1999 онд Бразил улс ОУВС-гийн тусламжтайгаар улсын болон хувийн салбарын төлбөрийн чадварын хямрал үүсгэлгүйгээр валютын ханшаа бууруулж, эцэстээ бодит ханшаа хөвүүлж чадсан. Өсөлт нилээд буурсан боловч Бразил улс дор хаяж бүтээгдэхүүний уналтаас зайлсхийж чадсан юм.
- 5 Тэд энэ явцад АНУ-ыг бодитой хэжээний санхүүжилтээр хангаж байгаа нь одоо урсгал дансны алдагдал бодитойгоор гарахад хүргэж байгаа бөгөөд дэлхийн төв банкуудын долларын эзэмшлийн өсөлтөөс ихээр санхүүжигдэж байна.
- 6 Шинээр төрөн гарч буй зах зээлийн эдийн засгууд өндөр хөгжилтэй орнуудынхаас нилээд доогуур түвшний өртэйгээр төлбөрийн чадваргүй байдалд орох эрсдэлтэй байгааг олж тогтоосон Рогофф нар, 2003, Манасе, Роубини, Шиммелпфеннинг (2003) нарын бүтээлийг үзнэ үү.
- 7 Рагхаран Ражан, Боллсын номонд иш татсан, 2005, онлайн хаяг: <http://news.ft.com/cms/s/b64d1dda-ac36-11d9-bb67-00000e2511c8.html>
- 8 Стандарт энд Поорс /Standard & Poors/, 2005, Ассошиэтед Прессийн мэдээлснээр.
- 9 Голдштайн, 2004 болон Роубин, Сецер нар, 2005.
- 10 Ренминби гэдэг нь "ардын валют" гэсэн үг.
- 11 АНУ-ын Төлөөлөгчдийн Танхимийн дарга асан.
- 12 Мусса, 2002.
- 13 2001 оны турших дотоодын банкны нөөцийн хомсдол нь олон улсын баталгаат бондуудын төлбөрөөс илүү дарамт шахалтыг Аргентиний валютын нөөцөд үзүүлсэн. 2001 оны турш дотоодын хадгаламж эзэмшигчид ба гадаадын зээлдүүлэгчид Аргентиний банкны системээс 24 тэрбум ам.долларыг татан авсан байна.
- 14 Үлдэж буй янз бүрийн зээлдүүлэгчид шүүхээр Аргентин улсын асуудлыг шийдвэрлүүлэх хүртэл тодорхой дүгнэлт хийхэд хэцүү юм.
- 15 Долоогийн Бүлэг, 2002, онлайн хаяг: www.treas.gov/press/releases/po3015.htm
- 16 Тэйлор, 2002. Онлайн хаяг: www.treas.gov/press/releases/po2056.htm
- 17 Леррик, Мелцер хоёр, 2001.
- 18 Хамтын үйл ажиллагааны заалтуудыг өргөтгөн ашиглаж байгаа нь, өөрөөр хэлбэл бүх бонд эзэмшигчдийн заавал биелүүлвэл зохих бүтцийн өөрчлөлтийг хийхийн тулд бонд эзэмшигчдийн үнэмлэхүй дийлэнх олонхийн саналаар шийдэхийг зөвшөөрсөн заалт үнэхээр сайн зүйл. Гэвч энэ заалтууд дангаараа өрийн бүтцийн өөрчлөлтийг хялбар эсвэл зовлонгүй болгож чадахгүй төдийгүй өрийн бүтцийн өөрчлөлтөөс болж банкны буюу валютын нөөц хомсдоход хүрэх эрсдлийг нэг их багасгаж чадахгүй.
- 19 Анх энэ хэллэгийг энэ утгаар нь ОУВС-гийн ахлах эдийн засагч асан Майкл Мусса хэрэглэсэн.

Лавлах материалууд

- Balls A. 2005. "IMF Takes Rich Nations to Task on Imbalances." /ОУВС баян орнуудад тэнцвэргүй байдлын талаарх үүрэг хүлээлгэж байна/. *Financial Times* /Файнаншиал Таймс сэтгүүл/. 4 дүгээр сар.
- Data Resources Inc. 2005. Macroeconomic Data Base /Макро эдийн засгийн мэдээллийн сан/. Stern Business School library /Штернийн Бизнесийн сургуулийн номын сан/.
- Dornbusch, R. 2001. "A Premier on Emerging Market Crises." /Шинээр төрөн гарч буй зах зээлийн хямралуудад тэргүүлэгч/. NBER Working Paper 8326 /ЭЗСҮТ-ны ажлын тайлан/. Cambridge: National Bureau of Economic Research /Эдийн засгийн судалгааны үндэсний товчоо/.

- Goldstein, M. 2004. "Adjusting China's Exchange Rate Policies." /Хятадын валютын ханшны бодлогын зохицуулалт/. Institute for International Economics Working Paper 04-1 /Олон улсын эдийн засгийн институтын ажлын тайлан/. Washington. 6 дугаар сар.
- Goldstein, M. and N.Lardy. 2004. "What Kind of Landing for the Chinese Economy?" /Хятадын эдийн засаг ямар хөрсөн дээр газардах вэ?/. Institute for International Economics Policy Brief 04-7 /Олон улсын эдийн засгийн институтын бодлогын товчоон/. Washington. 11 дүгээр сар.
- Group of Seven /Долоогийн бүлэг/. 2002. Statement of G7 Finance Ministers and Central Bank Governors and Action Plan /Их 7-гийн сангийн сайд нар ба төв банкны захирлуудын мэдэгдэл ба үйл ажиллагааны төлөвлөгөө/. Washington. 4 дүгээр сарын 20.
- International Monetary Fund /Олон Улсын Валютын Сан/. 2004. Debt-related Vulnerabilities and Financial Crises: An Application of the Balance Sheet Approach to Emerging Market Economies /Өртэй холбоотой эмзэг талууд ба санхүүгийн хямралууд: Шинээр төрөн гарч буй зах зээлийн эдийн засгуудад тайлан тэнцлийн арга хэрэглэх нь/. Washington. 7 дугаар сар.
- International Monetary Fund /ОУВС/. 2005. *International Financial Statistics* /Олон улсын санхүүгийн статистик/. Washington.
- Lerrick, A. and A. Meltzer. 2001. "Blueprint for an International Lender of Last Resort." /Олон улсын цорын ганц сүүлчийн зээлдүүлэгчийн нарийвчилсан төлөвлөгөө/. Photocopy. Carnegie Mellon University. 10 дугаар сар.
- Manasse, P., N. Roubini, and A. Schimmpfenning. 2003. "Predicting Sovereign Debt Crises." /Улсын өрийн хямралыг урьдчилан таамаглах нь/. Working Paper 03/221. Washington: International Monetary Fund /ОУВС/. 11 дүгээр сар.
- Moody's. 2004. Annual statistical publication /Жил бүрийн статистикийн нийтлэл/.
- Mussa, M. 2002. "Argentina and the Fund: From Triumph to Tragedy." /Аргентин улс ба сан хөмрөг: Их ялалтаас эмгэнэлд/. Policy Analyses in International Economics 67 /Олон улсын эдийн засгийн бодлогын шинжилгээ/. Washington: Institute for International Economics /Олон улсын эдийн засгийн институт/.
- Pettis, M. 2000. *The Volatility Machine* /Хувьсал өөрчлөлтийн машин/. Oxford: Oxford University Press.
- Rogoff, K., C. Reinhart, and M.Savastano. 2003. "Debt Intolerance." /Өрийн үл хүлцэл/. Brookings Papers on Economic Activity 1:1-74 /Эдийн засгийн үйл ажиллагааны Брүүкингийн тайлан/. Washington. 8 дугаар сар.
- Roubini, N. and B. Setser. 2004. "Bailouts or Bail-ins? Responding to Financial Crises in Emerging Economies." /Гаднаас эсвэл дотроос аврах ажиллагаа юу? Шинээр төрөн гарч буй эдийн засгуудын санхүүгийн хямралд өгөх хариу үйлдэл/. Institute for International Economics /Олон улсын эдийн засгийн институт/. Washington. 8 дугаар сар.
- Roubini, N. and B. Setser. 2005. China Trip Report /Хятадад аялсан тайлан/. Unpublished manuscript /хэвлэгдээгүй гар бичмэл/. Online at: www.rgemonitor.com
- Rubin, R. E. 1998. Statement at the Special Meeting of Finance Ministers and Central Bank Governors /Сангийн сайд нар, Төв банкны захирлуудын тусгай уулзалт дээр хэлсэн үг/, 4 дүгээр сар. Washington: United States Treasury /АНУ-ын Төрийн сан/.
- Rubin, R. E. and J. Weisberg. 2003. *In an Uncertain World: Tough Choices from Wall Street to Washington* /Тодорхойгүй ертөнцөд: Уолл Стрийтээс Вашингтон хүртэлх хүнд бэрх сонголтууд/. New York: Random House.
- Standard and Poor's /Стандарт энд Поорс/. 2005.
- Taylor, J. 2002. "Sovereign Debt Restructuring: A US Perspective." Remarks at a Conference on Sovereign Debt Workouts: Hopes and Hazards /Хуримтлагдсан өрийн бүтцийн өөрчлөлт: АНУ-ын хэтийн төлөв/. Institute for International Economics /Олон улсын эдийн засгийн институт/, Washington. 4 дүгээр сарын 1.
- United States Treasury /АНУ-ын Төрийн сан/. Various dates, including 1997. *Federal Reserve Bulletin* /Холбооны нөөцийн бюллетень/. Washington.

Даяаршил хөгжил цэцэглэлийн нэг арга болох нь

ЖАГДИШ БХАГВАТИ¹, Колумбийн Их сургууль

Улс үндэстнүүдийн дунд хамгийн өрсөлдөх чадвартайг шалгаруулах уралдаанд эдийн засгийн даяаршил ялагч болох нь тодорхой. Аливаа улс үндэстнийг улам хөгжин цэцэглэхэд хүргэдэг эдийн засгийн нарийн түвэгтэй бодлогын нэг хэсэг нь даяаршлыг дэмжсэн бодлого байдаг. Яагаад гэдгийг тайлбарлахын өмнө хоёр сэрэмжлүүлэг өгөхийг хүсч байна.

Нэгдүгээрт, соёлын даяаршлыг, түүнээс хоёрхоныг нэрлэхэд оюутан сурагчдын урсгал, кино, хөгжмийн экспорт нэмэгдэх гэх мэтийг эс харгалзан, зөвхөн эдийн засгийн даяаршилд анхаарал хандуулсан ч гэсэн хэт ерөнхийлсний алдаанд орох болно гэдгийг санаж байх нь чухал. Эдийн засгийн даяаршилд худалдаа, үндэстэн дамнасан компаниуд, гадаадын шууд хөрөнгө оруулалт, богино хугацаат капиталын урсгал, хүмүүнлэгийн олон улсын урсгал, технологийн тархалт, түүний дотор патентын эрх гэх мэт олон янзын хэлбэр багтдаг. Эдгээрээс худалдаа, гадаадын хөрөнгө хоёр тэргүүлдэг нь мэдээж.

Гэхдээ капиталын урсгалын илүү чөлөөтэй байдал бол цаг агаар тааламжтай үеийн давуу тал болдог нь тодорхой боловч капиталын чөлөөт урсгалаас үүсэх эрсдэл нилээд эрс тэс байдгийн жишээг 1997 онд эхэлсэн Азийн санхүүгийн хямрал харуулж байна. Эндээс олж авсан туршлага, анхдагч зарчмууд ч үүнийг нилээд сайн илтгэн харуулдаг. 1998 онд *Форин Эффайрс*²/*Foreign Affairs*/сэтгүүлд миний бичсэн нэгэн нийтлэлд тэмдэглэсэнчлэн, чөлөөт худалдаа ба капиталын урсгал хоёрын ижил төстэй бус байдал дэлхий нийтийн анхаарлыг татаж байна. Энэ нь зүгээр л чөлөөт худалдаа эрхлэгч нь зайлшгүй капиталын чөлөөт урсгалыг дэмжигчдийн нэг байх ёстой гэж олон хүмүүс ташаа төсөөлж байсантай холбоотой. ОУВС ч энэ алдааг яаран сандран хүлээн зөвшөөрсөн бөгөөд улс орнуудад капиталын дансны хөрвөх чадварын хэлбэрээр капиталын чөлөөт урсгалд оруулах шахалт үзүүлэх тухайд улам бүр болгоомжтой хандах болжээ. Тэр ч байтугай *Экономист* (*The Economist*) сэтгүүл ч энэ үзэл бодолтой санал нэг байна³.

Хоёрдугаарт, хөгжил дэвшлийг бий болгож байгаа бодлого түүнийг тогтвортой байдлаар бий болгох ёстой. Мэдээж хэрэг «тогтвортой хөгжил» гэдэг хэллэгийг хүссэн зүйлээ тодорхойлоход ялгаваргүйгээр хэрэглэдэг. Миний хувьд «Тогтвортой бизнес»-ийн асуудлаарх НҮБ-ын Хорооны тухай уншихад инээдтэй санагдаж байлаа. Яагаад гэвэл бизнесийн амьдралд үр ашигтай байхын утга агуулга бол үр ашиггүй байдал өөрөө тогтвортой

бус бөгөөд арилах боломжтой байдагт оршино. Гэхдээ үүнийг энэхүү сэдвийн хүрээнд оруулж үзэхэд хялбар байх болно. Жишээлбэл, арван жилийн турш өндөр өсөлттэй гарч байсан Зөвлөлт Холбоот Улс ба бусад «социалист» орнууд эцэстээ өсөлт нь удааширч, тэр ч байтугай нуран унасан. Надад нэгэн түүх санаанд орлоо. Кэмбрижийн их сургуулийн тэрс үзэлт Жоан Робинсон багш маань нэг удаа Йелийн их сургуулийн «неолибераль» эдийн засагч Гусь Ранистай Солонгос улс гайхалтай сайн явж байгаа талаар санал нэгдсэн тухай яриа чих дэлссэн юм. Гэхдээ тэд ийнхүү «санал нэгдсэн»-ийголучирнь нэг нь Хойд Солонгосын тухай, нөгөө нь Өмнөд Солонгосын тухай ярьж байсанд оршино! Мэдээжийн хэрэг, аль улс нь тогтвортой гайхамшиг үзүүлснийг бид тун сайн мэдэх билээ.

Энэхүү өгүүлэлдээ худалдаа ба гадаадын шууд хөрөнгө оруулалтын үзүүлэлтээр дэлхийн эдийн засагт нэгдэн орох явдал хэмээн тодорхойлсон даяаршил гэдэг маань эдийн засгийн ч талаасаа, нийгмийн ч талаасаа хорт муу биш, эерэг зөөлөн хүч гэдэгт би итгэдэг. Даяаршил эдийн засгийн хөгжил дэвшилд шууд нөлөө үзүүлдэг төдийгүй өнөөдөр даяаршлыг эсэргүүцэн шүүмжлэгчдийн онцгой анхаарал хандуулдаг нийгмийн асуудлууд ч бас сайжирдаг учраас хааяа гардаг нийгмийн зөрчилдөөнийг ч ялгаагүй даяаршилд оруулж болох ёстой. Би өөрийн бичсэн *Даяаршлыг өмгөөлөх тухайд* хэмээх номондоо тогтвортой хөгжлийг хөхиүлэн дэмжихэд даяаршил туслах ёстой гэж мэтгэсэн байгаа. Харин даяаршлын нийгэм, эдийн засгийн хоёр хэмжээсийг нэг бүрчлэн авч үзэхийн өмнө даяаршлын эсрэг сэтгэлгээний үүслийн талаар цөөн үг хэлье.

Даяаршлын эсрэг сэтгэлгээний эх сурвалжууд

Даяаршлыг шүүмжлэгчид яагаад тэвдэж сандраад байна? Тэдэнд юу нь төвөгтэй байна вэ? Гэхдээ хооронд нь ялгавал зохих хоёр үндсэн бүлэг энд байна. Нэгдүгээрт, үнэн голоосоо зөвүүцдэг, янз бүрийн оюуны болон үзэл суртлын чиглэл баримталдаг, бүгд өөр өөр үзэл бодол, санаа сэтгэлтэй тууштай эсэргүүцэгчид байдаг. Гэхдээ тэдний дотроос олонхүн капитализмын эсрэг, даяаршлын эсрэг, корпорацийн эсрэг сэтгэлгээний онцлогоор тодорхойлогдох харилцан уялдаатай гурвалсан бүлэгт хамаардаг. Тэдний хувьд даяаршил бол капитализм дэлхий даяар тархаж байгаа хэрэг бөгөөд түүнийг тараан хүргэгч В-52 онгоцууд

нь үндэстэн дамнасан компаниуд гэж үздэг. Энэ бүлгийнхэнтэй юм яриад ч нэмэргүй.

Хоёрдугаарт, сэтгэл ханамжгүй байдал нь голдуу үндсэн санал зөрөлдөх, улиг болтол ярих хүрээнд үүссэн даяаршлыг шүүмжлэгчид байдаг. Тэдний шүүмжлэл ядуу орнууд дахь ядуурал, байгаль орчны доройтол гэх мэт нийгмийн өвчнүүдийн шалтгаан бол даяаршил гэдэг үүднээс ханддаг. Хэдийгээр тэдний маргаан үндэслэл муутай буюу эсэргүүцэл нь эвлэршгүй чанартай боловч ямар ч байсан учрыг нь гаргаж тайлбарлахад хүлээн авах чадвартай бөгөөд шүүмжлэлд нь дэлгэрэнгүй, анхаарал болгоомжтой хариу өгөх шаардлагатай. Энэ ангилалд олон ТББ-ууд ордог.

Залуучуудын дунд маш олон хүн капитализм бол нийгмийн шударга ёсны асуултуудыг утга төгөлдөр шийдэж чадахгүй тогтолцоо гэж үздэг. Харин түүний оронд капитализм бол эрх ямбыг гайхалтай устгаж, олон хүнд эдийн засгийн таатай боломж олгодог тогтолцоо гэж үзэж болно гэсэн сэтгэлгээ нийтлэг бус хэвээр байна. Тэгш бус байдалд өгөх хариу бол хяналт ба шууд хуваарилалт мөн гэсэн алдаатай үзэл бодолтой зууралдсан хэвээр байгаа үзэл баримтлалын үндэслэл сайтай, биширмээр социалист үзэлтэй хүн үгүй болж байна. Дерридагийн деконстракционист буюу ялгааг задлан шинжлэх үзэл, Майкл Фоукаултын рационализмын эсрэг буюу шалтгаанд тулгуурлахын эсрэг үзэл, Эдвард Сайд гэх мэт колонийн дараахь үеийн онолчид нийлээд барууны эрдэмтдийн эрдэм мэдлэгт гүнзгий эргэлздэг хэсгийг бүрдүүлдэг бөгөөд тэд барууны мэдлэг бол Европын өргөжин тэлэлтээс үүссэн дэлхий нийтийн улс төрийн бодлогын нэг хэсэг байсан колонийн нийгмийн талаар тайлбарлаж, ойлголт төрүүлэх гэсэн объектив эх сурвалж гэж үздэг байна. Энэхүү сэжиг эргэлзээ нь эдийн засаг гэх мэт шинжлэх ухааны салбаруудад төдийгүй тэдгээрээс болж колонийн дэглэмийн үед амжилттай хөгжиж байсан улс үндэстэн, хамтын нийгэмлэгүүдийн соёлд учруулсан аюул заналд дайсагнаж хандахад хүргэж байна.

Нилээд их дайсагнал үндэстэн дамнасан корпорациудын эсрэг чиглэдэг бөгөөд тэднийг голдуу тухайн асуудлын төвд байгаа мэт үзэх буюу заримдаа шууд тэдэнд чиглэсэн байдаг. Тэд бол дотооддоо капитализмын мөхлийн өдрийг хойшлуулж, гадаадад хор хөнөөл учруулж байгаа мөлжигч хүчин, түүнчлэн тэд даяаршлын гол ашиг тусыг хүртэгчид учраас даяаршлын муу муухай бүхнийг агуулдаг

хүчин мөн гэж үздэг байна. Дэлхий нийтийн нэгдсэн зохицуулалтгүйгээр дэлхий дахины интеграцчилалд орох нь үндэстэн дамнасан корпорациудад ашигтай тоглолтын талбар зайлшгүй бий болгох ёстой нь мэдээж учраас тэд заавал дэлхий нийтийн эдийн засагт муу нөлөөтэй байх албагүй. Яагаад гэвэл үндэстэн дамнасан корпорациуд ажиллах хүч ба улс үндэстнийг нь ашиглах хамгийн боломжтой газруудыг эрж хайж, улмаар тэдний эзэн улсууд ашиг орлогоо орхиж, нийгмийн хууль тогтоомжоороо «сүүл барих уралдаан»-д орох тэвчишгүй дарамт шахалт үзүүлэх замаар өөрсөддөө олз ашиг хайж байдаг.

Мөн залуучуудыг капитализмын эсрэг хандлагад түлхэж буй хүчин зүйл бол хаа нэгтээ зовлон гачаалд унасан бусдыгаа ойлгох сэтгэл ба энэ зовлон зүдүүрийг нимгэлэхийн тулд юу хийж болох вэ гэдгийг олж сэтгэх оюуны чадвар хангалтгүй байдал хоёрын санал зөрөлдөөн (егөөтэй нь, орчин үеийн харилцаа холбооны технологиос бий болсон хэллэг) юм. Үүнээс үүдсэн хурцадмал байдал нь тэд өөрсдийн амьдарч буй капиталист системд сэтгэл дундуур байхад, улмаар энэхүү хүйтэн цэвдэг байдалд илт бухимдахад хүргэж байна. Өнөөдөр бид философич Хьюмийн үнэнч байдал ба бусдыг ойлгох чадварыг багасгаж буй нэг төвт тойргуудын тухай онолын эсрэг байдалтай байна. Бид гэр бүлийн цөмөөс эхлээд өргөтгөсөн гэр бүл, нутгийн ард иргэд, муж, улс, дэлхийн хэмжээнд очих тусам бусдыг ойлгох чадвар багасаж байгааг мэдэрч байна. Интернэт, CNN хоёрын хийж буй зүйл бол Хьюмийн тодорхойлсон хамгийн гадна талын тойргийг авч түүнийг дотогш нь эргүүлэх явдал юм. Иймд дэлхийн алс хол газруудад гарч буй ядуурал, иргэний дайн, өлсгөлөн гуйланчлалыг харж суугаа, мөн тэдгээрээс болж зовж шаналж буй залуучуудын хувьд эдгээр зовлон зүдүүрийг даван туулах, зохих арга хэмжээг оновчтой авч хэрэгжүүлэх оюуны бэлтгэлгүй байх нь олонтаа байна.

Энэхүү хөнгөн хуумгай хандлагаас гадна үүнд оролцож буй капитализмыг талархан дэмжигчдийн ерөнхий төсөөлөл тос нэмдэг. Эдвард Сайдын үзэж байгааг члан, «бизнесийн ашиг олох өршөөлгүй сэтгэлгээ ба улс төрийн эрх мэдэл хоёрыг жирийн нэг нөхцөл байдал мэт ярих явдал давамгайлж байна [түүний зорилго]⁵». Гэвч «хуучинсаг» ба «тэрс» үзлийн тухай будлиантай мэтгэлцээнүүд гол асуудлаа онож ярихгүй байгаа нь хуучинсаг үзлийн сөрөг хувьсгал эсвэл өнгөрсөн дэглэмийн гэгээрсэн

хэлбэр биш юм. Харин гол асуудал бол олон нийтийн анхаарлын төвийг зах зээлийг ашиглах явдалд илүү хандуулж, диригизм буюу төрийн хэт их оролцоонд бага хандуулах явдал юм. Энэ нь «зах зээл байх эсэх» тухай биш, харин «зах зээлийн хязгаарлалтууд»-ыг хаана тавих ёстой тухай асуудал юм. Өнөөдөр хөгжиж буй орнууд шинэчлэлд чиглэж байгаа нь хэт их бөгөөд автоматаар үйлчилдэг диригзмээс болж байна. Тэд ийнхүү эдийн засгийн шинэчлэлд чиглэж байгаа нь «хуучинсаг үзэл»-ийн өсч өндийхөд огт хамаагүй, харин бидний нэгэнтээ «дэвшилтэт» бодлого гэж үзэж байсан, биднийг ядуурал, бичиг үсэггүй байдал, шударга бус байдлаас гаргах зорилготой олон бодлого амжилт олоогүйтэй холбоотойгоор үүссэн прагматик хариу үйлдэл юм.

Иймээс даяаршлыг дэмжигчдийн гол үүрэгт ажил бол, бялууны хэмжээ нэмэгдэж байна гэдэг утгаараа даяаршил эдийн засгийн хувьд тааламжтай боловч нийгмийн хувьд хор хөнөөлтэй гэсэн айдастай тэмцэх явдал юм. Эдгээр айдас нь хэд хэдэн чиглэлтэй холбоотойн дотор ядуурлыг баян, ядуу орнуудад хоёулаа онцлон авч үзэж байгаа явдал, эвлэлдэн нэгдэх болон хөдөлмөрийн бусад эрх доройтох, ардчилалын хомсдол үүсэх, эмэгтэйчүүдийг хохироох, нутгийн үндсэн соёл ба уугуул иргэдийн соёлыг аюулд учруулах, байгаль орчинд хор хохирол учруулах зэрэг асуудлыг хэлж болно. Анхандаа эдгээр айдас үндэслэлтэй мэт харагдах нь олонтаа. Тэгвэл гол ажил бол нарийвчилсан шинжилгээ, туршилт судалгаагаар эдгээр айдас үндэслэлтэй эсэхийг авч хэлэлцэх явдал юм.

Нийгмийн хэмжээсүүд: Даяаршил яагаад хүнлэг царайтай байна

Нийгмийн хэмжээсүүдийн тааламжтай үр нөлөө нь нэг талаас эдийн засгийн хөгжил дэвшлийн эерэг зөөлөн нөлөөнд тулгуурладаг (гадаад зах зээл нээгдсэний ачаар тариачид илүү их орлого олох болсноор илүү олон хүүхэд энэ ажлаас салж, оронд нь сургуульд явах боломжтой болдог) боловч нийгмийн асуудлууд хамгийн их хэл амтай, хамгийн хорлонтой эсэргүүцэгчдийг төрүүдэг учраас эхлээд нийгмийн хэмжээсүүдийг авч үзье.

Үнэн хэрэгтээ, асар олон тооны даяаршлыг эсэргүүцэгчдийн хэрүүл шуугианаас үүдэн үнэхээр бидний үнэ цэнэтэй гэж үздэг нийгмийн асуудлуудыг аюулд учруулж мэдэх үзэгдэл байна гэж үзэх юм бол ихэнх улс

төрчдийг уучилж болох юм. Иймээс, Ерөнхий сайд Тони Блэйр, Ерөнхийлөгч асан Билл Клинтон, Канцлер Герхард Шрёдер нар болон «Гуравдагч зам»-ыг дэмжигч социалдемократууд хэдийгээр өөрсдөө эдийн засгийн даяаршлыг дагаж яваа ч гэсэн уг үзэгдэлд харамсан, түүнд «хүнлэг царай хэрэгтэй байна» гэж хэлж байна. Логикийн хувьд, хэрвээ тэр зүйл хэрэгтэй байгаа л юм бол түүгээр дутагдаж байна гэсэн үг. Ирландын Ерөнхий сайд асан Мэри Робинсон НҮБ-ын Хүний эрхийн комиссараар ажиллаж дууссаныхаа дараа «ёс зүйтэй даяаршил» хэрэгтэй гэж байгаа нь цаанаа байдал тийм биш байгааг хэлж байгаа үг юм.

Үнэндээ ч даяаршлыг эсэргүүцэгч хүрээнийхэн нийгмийн асуудлуудын бүх дутагдлыг даяаршил руу чихэх ерөнхий хандлагатай байна. Ер нь олон улсын байгууллагуудын олон тооны тайланд даяаршил ихсэж байна, ядуурал гэх мэт нийгмийн өвчин эмгэгүүд оршиж байна эсвэл нэмэгдэж байна гэдгийг тэмдэглэх болсон бөгөөд улмаар эхнийх нь дараагийнхыгаа үүсгэж байна гэх болжээ. Харин бид Тина Тернерийн алдарт дуунд «Үнд чинь хайр ямар хамаатай юм бэ?» гэж дуулдаг шиг «Энэнд чинь даяаршил ямар хамаатай юм бэ?» гэж асуух ёстой.

Миний өөрийн номондоо боловсруулж, хамгаалж бичсэн эсрэг үзэл бодол бол даяаршилд хүнлэг царай бий гэсэн үзэл юм. Үнэндээ, даяаршил нь хүйсийн тэгш байдлыг хөхиүлэн дэмжих, ядуу буурай орнуудын ядуурлыг бууруулах, хүүхдийг хөдөлмөрөөс сургуульд шилжүүлэх, ардчилалыг түгээн дэлгэрүүлэх гэх мэт олон янзын нийгмийн асуудлуудын ололт амжилтад саад болох бус, урагш ахиулдаг билээ.

Эдийн засгийн даяаршлын тухай зөрчилтэй хоёр үнэлгээний аль нэгийг сонгох явдал бол маш чухал асуудлын нэг. Мөн энэ нь миний «зохистой засаглал» гэж нэрлэсэн зүйлийн ч шууд утгыг агуулдаг. Жишээлбэл, хэрвээ та нар даяаршилд хүнлэг царай дутаж байна гэж итгэж байвал зохистой засаглал нь даяаршлыг хязгаарлах бодлогын арга хэмжээ авахыг дэмжих болно. Харин та нар над шиг даяаршилд хүнлэг царай бий гэдэгт итгэдэг бол даяаршлын тохиолдлын чанартай дутагдлуудыг анхаарч, ерөнхийдөө түүний авчирч буй сайн сайхан үр нөлөөг хадгалах, ёслон тэмдэглэх, дээшлүүлэхэд чиглэсэн шал өөр бодлогын арга хэмжээ авахыг хүсэх болно. Жишээ нь, хэрвээ та нар үндэстэн дамнасан компаниуд нийгэмд хор хөнөөл учруулж, хилийн чанад дахь

ажилчдыг мөлжиж байна гэдэгт итгэж байвал хэдийгээр тухайн орны эдийн засгийн хөгжилд ашиг тустай байсан ч гэсэн энэ хор хөнөөлийг багасгахын тулд корпорацийн нийгмийн хариуцлагын асуудал заавал биелүүлэх, нэгэн жигд, зохицуулалтын чанартай байхыг хүсэх болно. Харин хэрвээ та нар над шиг үнэндээ үндэстэн дамнасан компаниуд нийгмийн асуудалд ахиц дэвшил гаргадаг (тухайлбал, дотоодын ажиллах хүчний эрэлтийг нэмэгдүүлснээр цалин хөлс илүү өндөр болж, ажилчид үр шимийг нь бодитойгоор хүртэхэд тусалдаг) гэж үзэж байгаа бол корпорацийн нийгмийн хариуцлагын тухай асуудлыг сайн дурын үйл ажиллагааны үндсэн дээр илүү сайн сайхан зүйл хийх талаас нь тодорхойлох бөгөөд энэ нь янз бүрийн бодол санаа, итгэл үнэмшил бүхий өөр өөр хүмүүсийн бусдын хэрэгцээ шаардлагыг өөрийнхөөс дээгүүр тавьсан буяны ажиллагаатай нилээд төстэй байна. Тэр тохиолдолд корпорацийн нийгмийн хариуцлага нь сайн дурын, олон талт, зохицуулалтын бус шинжтэй байх юм.

Зохистой засаглалын шинж чанарын хоорондын энэхүү зөрөөтэй байдал нь даяаршилд хүнлэг царай дутагдаж байна, даяаршилд хүнлэг царай бий гэсэн эсрэг үзлээс урган гардаг. Хүнлэг царай бий гэдгийг ядуу буурай орнууд дахь хүүхдийн хөдөлмөрт үзүүлэх нөлөөтэй холбож үзвэл илүү сайн харагдана. Хэрвээ даяаршил эцэг эхчүүдийн орлогыг нэмэгдүүлж байвал эцэг эхчүүд орлогоо улам нэмэгдүүлэхийн тулд хүүхдээрээ ажил хийлгэх илүү дуртай байх уу, аль эсвэл тэдэнд хүүхдийн хөдөлмөрөөс олох орлого хэрэггүй, түүний оронд тэднийг сургуульд явуулж болох учраас хүүхдүүдээ ажлаас гаргаж сургуульд явуулах илүү дуртай байх уу? Хэрвээ хүүхдүүдээ ажил хийлгэх илүү дуртай байвал, даяаршил хөгжил дэвшил дээшлэх, хүүхдийн хөдөлмөр буурах хоёрын аль нэгийг сонгох сонголт бий болгож байгаа нь тодорхой бөгөөд даяаршлыг хязгаарлах бодлого баримтлах нь ухаалаг хэрэг байх болно. Хэрвээ хүүхдүүдээ сургуульд явуулах илүү дуртай байвал, даяаршлын үр дүнд буурч байгаа хүүхдийн хөдөлмөрийн бууралтыг хурдасгахын тулд бид юу хийж чадах вэ гэж асуух биз.

Тэгвэл даяаршлаас хүйсийн тэгш байдал ба хүүхдийн хөдөлмөрт үзүүлэх нөлөөний тухай хоёрхон жишээг авч үзье. Аль ч тохиолдолд үр нөлөө нь хор хөнөөлтэй гэхээсээ илүү эерэг байна гэж маргаж болно.

Хүйсийн тэгш байдал

Ядуус, эмзэг дорой бүлгүүдэд туслахад чиглэсэн нийгмийн хууль ёсыг амьдралд авчирдаг нэг хүчирхэг механизм бол өсөлт юм. Иймээс, инж өгөхийг хориглох, олон эхнэртэй байхыг хориглох, бага сургуульд суралцах эрхийг бүх хүүхдэд (түүний дотор охидод) олгох гэх мэт олон хууль тогтоомжоор эмэгтэйчүүдийн эрх, тэдний хүртэх үр шимийг баталгаажуулж болно. Гэвч эдийн засгийн өсөлтийн үр дүнд эмэгтэйчүүд дорд байдлаас гарч, тэр ч байтугай хөсөр хаягдах эрсдэлтэй үед шүүхэд хандах эдийн засгийн бие даасан байдал олж авахгүй бол энэ өсөлт хэсэг буурцагны төдий үнэтэй байх болно. Шинэ ажил олж чадахгүй байгаа зодуулсан эхнэр хүн л гэхэд нөхөр нь эхнэрээ зодож болохгүй гэсэн хуулийн үр шимийг хүртэх магадлал багатай юм. Мөн хуульд юу ч гэж заасан бай, хэрвээ эдийн засаг тогтворгүй, ажил олж хийх боломж маш бага байгаа тохиолдолд ядуу тарчиг эцэг эхчүүд хүүхдээ сургуульд явуулах нь юу л бол. Товчхондоо, хөгжлийн эдийн засагчид бидний урт удаан хугацааны турш ойлгож, бичиж ирсэн орчин цагийн чамин үг болох эрх мэдэлжүүлэх гэдэг үг ядууст тусламж үзүүлэх гол хэрэгслүүд болох улс төрийн ардчилал, эдийн засгийн хөгжил дэвшлээс үүдэлтэй байдаг.

Эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс бага хөлс авдаг цалингийн тэгш бус байдлын тухай асуудлыг авч үзье. Хүйсийн ялгавартай цалин хөлсийг тодорхойлж болох хэд хэдэн арга байдаг. Эмэгтэй хүн яг ижил компанид ижилхэн ажил эрхэлж байгаа адилхан мэдлэг боловсролтой эрэгтэй хүний цалингийн нэг хэсэгтэй тэнцэх цалин авдаг байж болно. Үүний оронд, цалингийн комиссууд (зарим Европын оронд байдаг шиг) янз бүрийн ажил мэргэжлийн цалингийн хооронд харьцуулж үзэж байж болно. Ph.D цолтой эдийн засгийн ухааны профессор багшийг зөвлөгөө өгөх компаний эдийн засагчтай эсвэл бүр өөр салбарын эдийн засагчтай харьцуулж болно. Ийм харьцуулалтаас цалин хөлсний хүйсийн ялгавартай байдлын тухай дүгнэлт гаргах үндэслэлгүй бөгөөд товчоор хэлэхэд ингэх нь утгагүй юм. Аль эсвэл, бид илүү том «мега» арга хэрэглэж, хэдийгээр тодорхой ажил мэргэжлийн хүрээнд хүйсийн ялгавартай цалин хөлсний ялгаа нэг их байхгүй гэж болох боловч эрэгтэйчүүд голдуу өндөр цалинтай ажил мэргэжилд ажиллаж байхад эмэгтэйчүүд нарийн бичгийн, багшийн, сувилагчийн гэх

мэт бага хөлстэй ажлууд хийхээр бэлтгэгдсэн байдаг эсвэл тийм заншил тогтсон байдаг гэж хэлж болно.

Ямар нэг үйлдвэрлэлийн салбар даяаршсан салбарын нэг хэсэг болж байгаа үед компаний түвшний тэгш бус байдал *илүү хурдан* багасаж байгаа бөгөөд энэ нь арилжааны бус салбаруудынхаас онцлогтой байгааг зарим хүн олж мэдээд гайхаж магадгүй. Элизабет Брайнерд, Сандра Блэк нарын хоёр гялалзсан эдийн засагч Харвардын их сургуульд цол хамгаалах диссертацийн ажилдаа, хэрвээ өрсөлдөөн ширүүсвэл эрэгтэйчүүдэд түүнтэй адилхан бүтээмжтэй ажиллаж байгаа эмэгтэй хүнээс илүү цалин хөлс өгөх дэмий заншлыг өөгшүүлэхэд улам бүр хэцүү болох учраас цалингийн ялгавартай байдал илүү хурдан багасана гэсэн таамаглал дэвшүүлжээ. Үнэн хэрэгтээ тэд АНУ дахь цалин хөлсний тэгш бус байдлын сүүлийн үеийн тоон үзүүлэлтийг шинжилж үзээд, сүүлийн хорин жилд худалдаагаар дамжсан өрсөлдөөн ширүүссэн нь өрсөлдөөнт, арилжааны салбарууд дахь эмэгтэйчүүдийн цалин хөлс харьцангуй дээшлэхэд хүргэснийг тогтоож, худалдаа нь пүүс компаниудын ялгаварлан гадуурхах чадварыг багасгах замаар эмэгтэйчүүдэд ашиг тустай байж болно гэж дүгнэжээ. Иймээс эмэгтэйчүүдийн асуудалд даяаршил хор хохирол учруулаагүй, харин ч тус болсон байна⁶.

Түүнчлэн даяаршил нь өөр өөр орны янз бүрийн туршлагатай үндэстэн дамнасан компаниудыг татан оруулах замаар туслаж байж болно. Иймээс хүлээн авагч орны ТББ-ууд, иргэд, улс төрчид, пүүс компаниуд олон талт үзлийн нөлөөнд автах бөгөөд хоцролгүй дагаж чадвал тухайн улс оронд эмэгтэйчүүд өндөр цалинтай ажил эрхлэхэд саад болж байсан ёс заншлыг аажмаар эвдэн хаях болно. Жишээлбэл, 1980-аад онд Япон улс асар амжилттай хөгжиж байх үед тус улсын үндэстэн дамнасан корпорациуд гадаадад гарч ажиллах болсноор Япон улсын хүйсийн тэгш байдалд ахиц дэвшил гарсан гэж би үзэж байна. Ихэвчлэн Японоос гадаадад ажиллаж буй гүйцэтгэх ажилтнуудын дийлэнх нь эрчүүд байсан боловч тэд эхнэр, хүүхдүүдээ дагуулан явдаг байв. Ингээд гадаадад эмэгтэйчүүдэд хэр өөр ханддаг, тэндэхийн эмэгтэйчүүд Японы эмэгтэйчүүдээс илүү эдийн засгийн таатай боломжтой байгааг харсан япон эмэгтэйчүүд эргэж ирээд улс орондоо өөрчлөлтийг авчирсан. Тэдний хүүхдүүд ч бас сургуульд шал

өөр үнэт зүйлс буюу барууны үнэт зүйлсээс суралцаж ирсэн нь хэдий барууны орнууд, тэр ч байтугай зарим хөгжиж буй орнууд хүртэл эмэгтэйчүүдийн эрхээр хол түрүүлээд байсан ч гэсэн бүгд л Япон улс эмэгтэйчүүдийн эрхийн чиглэлд ахиц дэвшил гаргахад тусласан билээ.

Тэгвэл нийгмийн бодлогын үүрэг юу вэ? Зарим нэг уламжлалт нийгэмд эмэгтэйчүүд өрх гэрийн хэрэгцээнийхээ тариа ногоо тарьж байхад эрэгтэйчүүд бэлэн мөнгөний төлөө ажиллаж байгаа нь хүчирхийлэл гэж даяаршлын эсрэг бүлгүүд үзсэн байдаг. Тухайлбал, ингэж маргахдаа «Африкийн Сахар орчмын бүс нутагт... экспортыг дэмжих тариаланд шилжсэн нь... дотоодын хэрэгцээний нөөцийг гажуудуулах нь олонтаа байна. Энэ стратегиас олсон нэмэлт орлогыг эрэгтэйчүүд захиран зарцуулж байхад эмэгтэйчүүд, хүүхдүүдийн хоол тэжээлийн хангамж багасаж байна⁷» гэжээ. Зохиогчийн хэлж байгаагаар гэр бүлийн доторх шийдвэр гаргалт нь нэмэгдэл орлогыг хоол хүнснээс илүү гоёж гангалахад зарцуулагдахад хүргэж болохоор байна. Үнэхээр тийм байж болно. Гэтэл, нэмэлт орлого авчрах таатай боломжийг алдахын оронд (улмаар өсөн нэмэгдэж буй чинээлэг эдийн засгийн таатай боломжуудыг эмэгтэйчүүдэд олгож тэднийг эрх мэдэлжүүлэхийн оронд) нийгмийн бодлогын гол асуудал бол өсөн нэмэгдэж буй чинээлэг байдлыг дагаж эмэгтэйчүүд, хүүхдийн хоол тэжээл, эрүүл мэндэд үзүүлж буй эрэгтэйчүүдийн зан байдлын буруу нөлөөтэй тэмцэх явдал юм.

Эцэст нь, олон тооны эмэгтэйчүүдийн бүлгүүд экспортын боловсруулалтын бүсийг (ЭББ) даяаршлын харгис хэрцгий нүүр царай, ядуу буурай орнуудын эмэгтэйчүүдэд учирч буй гай зовлонгийн эх үүсвэр гэсэн үзэлд автаад байна. Нэгдүгээрт, ЭББ-үүд нь хэд хэдэн орны гадагшаа чиглэсэн стратегийн нэг хэсэг болоод байгаа боловч шүүмжлэгчдийн төсөөлж байгаа шиг голлох нөлөө үзүүлэх нь ховор гэдгийг санах ёстой. Үнэндээ бол ЭББ-үүдээс үүсч буй давуу талууд үндэсний хэмжээг хамардаг учраас нийт экспортод үзүүлэх харьцангуй ач холбогдол нь яваандаа буурдаг. Ийм ч учраас 1960-аад оны үед Тайваны нийт экспортын 10-аас илүүгүй хувийг түүний гурван ЭББ-ийн экспорт эзэлдэг байсан бол 1980-аад он гэхэд 6 хувь болж буурсан байдаг. Гэвч энэхүү нарийн төвөгтэй асуудлын⁸ эсрэг сөрөг маргааны хамгийн ноцтой нь Нью Йорк Таймсийн сэтгүүлч Николас Кристоф, Шерил Ву Дүнн нарийн хийсэн судалгааны үр дүн бөгөөд тэд

ЭББ-үүд ихэвчлэн эмэгтэй ажилчдын хүчийг ашиглаж байгааг судлаж илрүүлэх зорилгоор Хятадын олон газарт очиж үзсэн байна. Тэдэнтэй ярилцсан залуу эмэгтэйчүүд мөнгө хуримтлуулахыг хүсч, *өөрсдийн сонголтоор* уртасгасан цагаар (заримдаа долоо хоногт долоон өдөр) нөр их хөдөлмөрлөдөг, мөн *өөрсдийн сонголтоор⁹ гэртээ харьдаг гэж* хариулсныг мэдээлжээ. Үнэн хэрэгтээ, тэдний зарим нь илүү их мөнгө олох боломж санал болгосон үйлдвэрүүдэд орохыг хүсч байсан бөгөөд эзэн нь харуул хамгаалалтын талаар нэмэлт анхаарал тавьж, дэргэд нь байнга хянагчтай байлгах хүртэл тийм их ажиллахыг хүсч байсан гэж үү гэж нэгэн үйлдвэрийн менежер халаглаж байсан байна!

Хүүхдийн хөдөлмөр

Энэ дүгнэлт хүүхдийн хөдөлмөрт ч мөн адил хамаатай. Ер нь ядуу эцэг эхчүүд баячуудаас дутуугүй үр хүүхэддээ сайн сайхныг хүсч байдаг. Олон хүмүүс хүүхдээ сургуульд явуулахаас илүү ажил хийлгэхэд хүргэж байгаа зүйл бол ядуурал юм. Хэрвээ аль нэгийг сонго гэж албадвал эцэг эхчүүд хүүхдүүдээ сургуульд явуулснаас хоолтой байсан нь дээр гэж үзнэ. Ухаан муутай эцэг эхчүүд орлого нэмэгдэх тусам хүүхдээ сургуулиас гаргаж ажилд оруулна гэж зарим ТББ-ууд маргадаг. Гэтэл бас сайн санаат эцэг эхийн тухай буюу илүү их мөнгө олж байгаа эцэг эхчүүд илүү олон хүүхдээ сургуульд явуулахыг хичээнэ гэсэн таамаглал байдаг. Эдийн засаг ч мөн энэхүү таамаглалыг бататгаж байдаг. Яагаад тэр вэ? Яагаад гэвэл суурь боловсрол эзэмшсэний үр өгөөж ихэвчлэн өндөр байдаг боловч өр зээлд баригдсан эцэг эхчүүд энэхүү хүлээгдэж буй өндөр үр өгөөжийн төлөө зээл авч чадахгүй учраас хүүхдээ сургуульд явуулж чаддаггүй гэдгийг олон судалгаа харуулж байна. Харин эцэг эхчүүд илүү их мөнгө олоод ирэх үед зээлийн дарамт багасдаг нь мэдээж хэрэг. Прия Ранжан, Жан-Мэрий Баланд, Жеймс Робинсон нарын эдийн засагчид¹⁰ хүүхдийн хөдөлмөрийн түвшин өндөртэй олон ядуу оронд суурь боловсролын үр өгөөж маш их сонирхол татаж байна, яагаад хүүхдүүдээ сургуульд явуулахгүй байгааг тайлбарлах хамгийн үндэслэлтэй таамаглал бол ядуу эцэг эхчүүд хүүхдээ сургуульд явуулах мөнгө зээлж чаддаггүй, дараа нь зээлсэн мөнгөө эргүүлэн төлж чаддаггүй явдал юм гэж үзжээ. Товчоор хэлбэл, зээллэгийн зах зээл төгс бус байна гэсэн үг. Иймээс эцэг эхчүүдийн орлого

нэмэгдэх, улмаар зээлийн дарамт багасах нь (энэ нь мэдээж даяаршлыг дагасан орлогын өсөлтөөс үүсэн бий болох нь тодорхой) сургуульд хамрагдалт нэмэгдэх, хүүхдийн хөдөлмөр багасахад хүргэх ёстой. Ийм ч учраас, одоогийн байдлаар, даяаршлын ачаар (бусад хүчин зүйлсийн дотроос) орлого нэмэгдэхэд сургуульд хамрагдалт мөн нэмэгдэж, хүүхдийн хөдөлмөр буурдаг болохыг харуулсан улам олон судалгаа бидэнд байна.

Ялангуяа энэ талаар нилээд сонирхол татсан анхдагч судалгааг Дартмоутийн Коллежийн эхнэр, нөхөр хоёр эдийн засагч хийсэн¹¹ бөгөөд Вьетнамд будааны экспортыг либеральчилсны дараа тариачдын орлого 30 хувиар нэмэгдэхэд тариачид хэрхэн хариу үйлдэл хийсэн тухай судалгаа юм. Вьетнамын засгийн газар экспортын дэглэмээ аажмаар либеральчилж, будааны экспортыг хоёр гаруй дахин буюу 1996 онд 3 сая тонн орчим хүртэл нэмэгдүүлэх боломж олгожээ. 1997 он гэхэд Вьетнамын экспортын квот үйлчилэхээ больж тус улс олон улсын будааны үнэд бүрэн шилжсэн байна. Вьетнам улс 6-15 насны хүүхдүүдийн 26 хувь нь хөдөө аж ахуйд мөн 7 орчим хувь нь өөр хаа нэгтээ хөдөлмөр эрхэлдэг улс болж таарсан нь хүүхдийн хөдөлмөр ашиглалтад даяаршил хэрхэн нөлөөлж байгааг судлахтаатай боломжийг бүрдүүлж байв. Судалгааны үр дүнд айл өрхүүд будааны өндөр үнээс олсон нэмэлт орлогоороо хүүхдүүдийнхээ ажил хийж олох байсан мөнгийг нөхөж, харин хүүхдүүдээ сургуульд оруулсан болох нь тогтоогджээ. Сонирхолтой нь хүүхдийн хөдөлмөрийг хамгийн их бууруулж, сургуульд хамрагдалтыг хамгийн их нэмэгдүүлсэн хэсэг нь арай эгчмэд насны охидууд байсан бөгөөд тэд энэхүү нэмэлт орлогын үр шимийг хүртсэн мэт харагдаж байна.

Мөн хэн нэг нь даяаршлаас нийгмийн асуудлуудад үзүүлж буй сөрөг нөлөөний талаар даяаршлын эсрэг үзэлтнүүдийн санаа зовж буй зүйлсийг судалж шалгаж болно. Түүний үзүүлэх нөлөө хор хөнөөлтэй бус, эерэг зөөлөн байгааг бид улам бүр олж мэдсээр байна. Үүнд санаа зовсон даяаршлын эсрэг үзэлтнүүдийн дотор олон залуу хүн байдаг. Би тэдэнтэй уулзаж ярилцаж явахдаа тэд даяаршлын эсрэг дүгнэлтүүдийг лекцээр сонсож байхын оронд уг асуудлын талаар эргэцүүлэн бодож сурах чин эрмэлзэлтэй байгааг олж хардаг юм. Хэдийгээр миний ном даяаршлын эсрэг уур хүргэм нотолгоонууд гаргаж тавиагүй ч гэсэн англи хэлээр хатуу хавтастайгаар 50,000 хувь хэвлэгдсэн ном маань бараг нэг

жилийн дотор борлогдож дууссан нь хэн нэг нь номоо асар ихээр борлуулахын тулд даяаршлын эсрэг утга учиргүй зүйлс бичих шаардлагагүй болохыг нотлон харуулж байна! Мөн би Колумбийн их сургуульд ноднин жил заалгүй орхисон даяаршлын тухай хичээлээ дахин заахаар саяхан шийдээд байна. Учир нь олон оюутан манай Олон улсын харилцааны сургуульд заахаар санал болгосон худалдаа болон даяаршлын эсрэг суртал нэвтрүүлгийн шинжтэй хичээлүүдэд сэтгэл ханамжгүй байгаагаа илэрхийлсэн байсан.

Зохистой засаглал

Хэрвээ эдийн засгийн даяаршлаас нийгмийн хэд хэдэн хэмжээст үзүүлэх нөлөө нийлбэр дүнгээрээ хор хохиролтой бус эерэг зөөлөн байгаа юм бол, даяаршлаас бий болсон эерэг үр дүнд тулгуурлан институцийн болон бодлогын ямар хүрээг зайлшгүй *сайжруулах* шаардлагатай вэ гэж бид асуух ёстой.

Энд гурван төрлийн асуудал тавигдаж байгаа нь тодорхой байна. Нэгдүгээрт, хэдийгээр эерэг үр нөлөөтэй байсан ч дандаа тийм байхгүй. Иймээс сөрөг талууд үүсэх үед тэдгээрийг авч шийдвэрлэдэг институциудийг сэдэж олох хэрэгтэй. Хөгжилтэй орнуудад яваандаа үүсэж хөгжсөн шиг зохицуулалтын туслалцааны хөтөлбөрүүд хөгжиж байгаа орнуудад голдуу дутагдаж байна гэж би үзэж ирсэн¹². Гэвч ядуу орнууд ийм хөтөлбөрийг яаж санхүүжүүлж чадах билээ? Мэдээж, Дэлхийн Банк гэх мэт зээл тусламжийн байгууллагуудыг худалдааны либеральчлалыг дэмжих санхүүжилтээр хангах ажилд дайчилж болох юм.

Хоёрдугаарт, цочроох эмчилгээ хийж үзээд бүтэлгүйтсэн Оросын шинэчлэгчдийн хийсэн алдааг бид дахин давтахгүй байх нөхцлөөр хангаж өгөх шаардлагатай. Эдийн засгийн болон улс төрийн ухаанд зохицуулалтыг анхаарал болгоомжтой хийхийг шаарддаг учраас дээд хурд заавал оновчтой хурд байх албагүй. Тэргүүлэх эдийн засагчид «аливаа ангальг хоёр харайлтаар давж чадахгүй» гэсэн зүйрлэлийг ашиглан Орост цочроох эмчилгээ хийхийг шаардах үед Зөвлөлтөөр мэргэжсэн шинжээч Падма Десай: «Та нар Индиан Жонс л биш бол ганц харайлтаар ч байсан ангальг давж чадахгүй, тэгснээс гүүр тавьсан нь дээр» гэж хариулсан байдаг. Түүний зөв байсныг үйл явдлын өрнөл нотлон харуулсан билээ.

Эцэст нь нийгмийн тулгамдсан асуудлуудад ахиц дэвшил гаргах алхмыг хурдасгах нэмэлт

бодлого шаардлагатай байна. Даяаршлаас үүссэн хөгжил дэвшлийн үр дүнд хүүхдийн хөдөлмөр эрхлэлт багасдаг нь үнэн юм бол түүнийг улам багасгахын тулд бид юу хийж болох вэ? Энд баян орнуудын холбоодын зүгээс зөвхөн худалдааны хориг арга хэмжээ л «хутга» болно гэсэн үзэл баримталж байна. Энэ бол харалган бөгөөд эсрэг үр нөлөөтэй үзэл бодол. Хөгжиж байгаа орнуудын олон сэхээтний үзэж байгаагчлан өнөөдөр бид ёс суртахууны ятгалга ашигласан нь хамаагүй дээр байх болно. Эцсийн эцэст бурхан бидэнд хэл заяасан, өнөөгийн дэлхий ертөнц дээр дэлхийн хэмжээгээр ардчилсан дэглэм тогтсон, CNN-тэй, сайн ажилладаг хариуцлагатай ТББ-уудтай, зөвлөлдөөнтэй, мэтгэлцээнтэй байгаа нөхцөлд хэл бол өөрсдөө ч тэр бүр өө сэвгүй байж чаддаггүй засгийн газруудын тавьсан хориг арга хэмжээнээс хамаагүй илүү хүчирхэг хэрэгсэл юм.

Эдийн засгийн хөгжил дэвшил ба даяаршил

Илүү чөлөөт худалдааг дагасан эдийн засгийн үр өгөөжийг гадаадын шууд хөрөнгө оруулалтын дотогш урсгалд чиглэсэн эерэг зөөлөн бодлоготой хослуулсан үзлийг би энд товч дүгнэж танилцуулах ёстой.

Харин нэгдүгээрт, илүү чөлөөт худалдааг эсэргүүцэгчид ихэвчлэн энэ талын мэдлэг мэдээлэл муутай байдаг, ялангуяа огт мэдэхгүй чиглэлээрээ хэзээ нэгэн цагт өргөжих «бодлогын зах зээлүүд» хайн тэнүүчилж явдаг Оксфам мэтийн ихээхэн хөрөнгө мөнгөтэй, хэвлэл мэдээлэлтэй холбоотой ТББ-уудаас ийм эсэргүүцэл гардаг.

Иймээс тэд ядуу буурай орнуудаас худалдааны саад тогтоороо багасгахыг шаардах бус, харин баян орнууд багасгах ёстой гэж маргадаг. Энэ нь үл харилцан солилцоо буюу хамгийн онцгой эрхтэй үндэстний (ХОЭҮ) статусыг тэлж, хөгжиж байгаа орнуудыг автоматаар хамруулах талаар бидний хэдэн арван жилийн турш олж авсан практик сургамжийг үлөйшоож байгаа юм. Аливаа улсын засаг захиргаа экспортод чиглэсэн бодлогын хүчин чармайлтаа сэргүүлэн тавих замаар импорттой өрсөлдөх бодлогоо орхих боломж олгодгоороо харилцан солилцоо өөрийн гэсэн ашигтай байдаг. Тэгтэл бас эдгээр төөрөлдсөн шүүмжлэгчид ядуу орнуудын засгийн газарт хандан үйлдвэрлэл дөнгөж хөгжих шатанд өндөр тариф тогтоох нь зүйтэй хэмээн зөвлөж зүрхэлдэг байна. Үнэн хэрэгтээ ихэнх ядуу

орнууд эдгээр тариф ба бусад худалдааны саад тогторыг сүүлийн жаран жил нилээд чөлөөтэй хэрэглэж байгаа боловч үр дүн багатай байна! Тэр ч байтугай гадаадын зах зээлд нэвтрэхийн тулд үйлдвэрлэгчид нь ч бас ашигтай байна гэж үзэх нь чухал гэдгийг тэд мартжээ. Баян орны гадаад тариф, татаасууд буурах үед буюу зүйрлэвэл гадаад хаалга нээгдэх үед ядуу орнууд экспортлогчдоо тэр хаалгаар орох нь битгий хэл өөрийн хаалгаар гарч чадахгүй байгааг олж мэдэх болно. Яагаад гэвэл, тэдний өөрсдийнх нь тариф дотоодын зах зээлээ дэмжихэд чиглэгдсэн буюу «экспортлогчдын эсрэг хандлага»-ын нөгөө тал байх болно. Энэ бол 1960, 1970-аад оны сүүлээр Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллага, Эдийн Засгийн Судалгааны Үндэсний Товчоо, Дэлхийн Банкнд хийсэн дайны дараахь үеийн худалдаа, хөгжлийн бодлогын олон судалгаанаас гарсан гарцаагүй дүгнэлт юм.

«Бүгдэд таарах ганц размер (гутлын) гэж байхгүй» гэдэг үг моодонд ороод байгаа шиг аливаа улсад хэрэгтэй үедээ ивээх үзэл баримтлахыг зөвшөөрөх ёстой. Мөн энэхүү утгагүй хэлц үгийг батжуулдаг өөр нэг үзэл бол ядуу орнууд өөрсдийн худалдаа, хөгжлийн хөтөлбөрүүдийг «өмчлөх» буюу өөрийн болгох ёстой гэсэн үзэл юм. Гэхдээ мэдээж бид хөл нүцгэн явах уу эсвэл гутал өмсөх үү гэдгээ шийдэх ёстой! Өөрөөр хэлбэл бид чөлөөт худалдаанд шилжих үү эсвэл ивээх үзэл буюу хамгаалалтад шилжих үү гэсэн үг. Нэгэнт гутал өмсөхөөр шийдсэн бол гутлын хэмжээ янз бүр байх нь мэдээж. Иймээс ДХБ-ын хэлэлцээнд¹³ орж буй улс бүр тодорхой салбарыг чөлөөлөхгүй гэж хэлж болно. Худалдаа, Үйлчилгээний тухай Ерөнхий Хэлэлцээрийн (GATS) тохиролцоонд хүртэл ингэж хэлж болох бөгөөд тэр ч байтугай хэлэлцээний үед бүгд буулт хийх шахалтанд орж байсан ч гэсэн аж үйлдвэр, хөдөө аж ахуйн салбараа чөлөөлөхгүй гэж хэлэх эрхтэй. Түүнчлэн ОУВС, Дэлхийн Банкнаас тавьсан нөхцөл болзлуудын хувьд ч тэдгээрийн үл хэрэгсэх, бүр засч өөрчлөх явдал олонтаа тохиолддогийг мэдэхгүй байх нь хэтэрхий гэнэн хэрэг болно. Иймээс голдуу гутлын хэмжээг таны хөлд тааруулах болдог тул огт айх хэрэггүй!

Худалдаа өсөлтийг нэмэгдүүлж, өсөлт ядуурлыг бууруулдаг

Худалдаа ба өсөлтийн хамаарлын талаарх нотлох баримтууд юу харуулж байна вэ? Би

бусад хүмүүсийн нэг адилаар, өнөөдөр бараг 3 тэрбум хүн амтай болоод байгаа Энэтхэг, Хятад хоёр том гүрэн 1980 оны дунд үе хүртэл урам хугарам өсөлттэй байсан гэж үзэж байна. Тэр үед энэ хоёр аварк¹⁴ бодлого баримталж байсан нь Энэтхэгт эдийн засгийн үзэл баримтлал муутайгаас, Хятадад коммунист үзэл суртал, улс төрийн бодит байдлаас болсон байна. Түүнээс хойш хоёр орон хоёулаа даяаршилд хамрагдаж, өсөлтийн хурд нь эрс нэмэгдээд байна. Хамгийн гол нь тэд хоёулаа ядуурлыг эрс бууруулсанд оршино. Энэ нь миний 1960-аад оны эхээр дэвшүүлж байсан үзлийн гол санаа бөгөөд тэр үед би өсөлтийг «баячуудаар дамжин ядууст хүрэх» идэвхгүй стратеги биш, харин олон тооны ядуусыг ашигтай хөдөлмөр эрхлүүлж «өөд татах» идэвхтэй стратеги хэмээн тодорхойлж байсан. Гол хүндрэлтэй асуудал бол 1980-аад он хүртэл Энэтхэг улсад худалдаа, гадаадын хөрөнгө оруулалтад аварк бодлого ноёрхохоос гадна бусад муу бодлого баримталж байсан нь тус улсыг ёроолгүй ангалд унагасан явдал юм!

Дэлхийн ядуурлын хамгийн том цөөрөм Энэтхэг, Хятад хоёрт бий. Хоёр улс хоёулаа бараг хорин жилийн өмнөөс гадагшаа чиглэсэн чиг баримжаанд шилжсэний ачаар 1980, 1990-ээд онд илүү өндөр өсөлттэй гарсан юм. Хятад улс 1978 онд гадагшаа чиглэсэн эдийн засгийн бодлогыг эрчимтэй авч хэрэглэсэн. Энэтхэг улс ч бас 1980-аад онд тусгаарлагдмал эдийн засгаа бага зэрэг нээж эхлээд, 1990-ээд онд системтэйгээр зоримог нээж эхэлсэн. Дэлхийн Банкны тооцоогоор, 2000 он хүртэлх хорин жилийн турш Хятад улсын бодит орлого (ДНБ) жилд дунджаар 10 хувиар өссөн бол Энэтхэгийнх 6 хувиар өссөн байна. Хятад шиг огцом хурдтай өссөн улс дэлхий дээр байхгүй бөгөөд Хятадаас бусад ядуурлын түвшин, хүн амаараа Энэтхэгтэй харьцуулшгүй арав хүрэхгүй улс эдгээр он жилүүдэд Энэтхэгээс илүү хурдан өссөн байна. Тэгвэл тэдний ядуурал яасан бэ? Хар ухаанаар бодоход л ядуурал буурсан байгаа. Азийн Хөгжлийн Банкны мэдээгээр Хятадад ядуурал 1978 онд 28 хувьтай гарч байсан бол 1998 онд 9 хувь болж буурсан байна. Энэтхэгийн албан ёсны тооцоогоор ядуурлын түвшин 1977-1978 оны үед 51 хувь байсан бол 1999-2000 онд 26 хувь болж буурчээ.

Иймээс бид даяаршлын эсрэг хоосон ярианаас салж, одоо байгаа туршилтын нотлох баримтуудад тулгуурлан айдсаа, тэр ч бүү хэл итгэл үнэмшлээ тайвнаар харах юм

бол худалдаа ба шууд хөрөнгө оруулалтын хэлбэртэй даяаршил нь ядуу буурай орнуудын ядуурлыг бууруулах хор хөнөөлтэй бус, *тусгай шалтгаан гэдгийг дүгнэн харж болно.*

Шведийн сэтгүүлч Томас Ларссон өөрийн шинээр бичсэн Оргилд хүрэх уралдаан: Даяаршлын бодит түүх¹⁵ хэмээх номондоо Азид очиж өөрийн нүдээр үзсэн зүйлээ бичиж, ядуурал хэрхэн даяаршилд цохигдож байгаа тухай газар дээрх түүх, дүр зургийг харуулжээ. Ялангуяа энэ номыг уншсаны дараа нэгэн тод жишээ миний сэтгэлд удаан хугацаанд хоногшин үлдсэн юм.

Бангконгийн хойд захад орших аж үйлдвэрийн бүс, Наванакорнд намайг очиход миний бодож байсан шиг азарган тахианы зодоонд мөрий тавьж тоглодог газар биш байв. Би үдээс хойш нь UNCTAD (НҮБХХБХ)-ын бага хурлаас гарч даяаршлыг ойрхоноос харахад ямар байхыг үзэхээр явлаа. Тахианы аж ахуй, мөрийтэй тоглоом хоёр нийлсэн газар цахим техникийн эд ангиуд үйлдвэрлэдэг Люсентийн үйлдвэрийн яг хажууд байх бөгөөд энд үйлдвэрт өргөн нэвтрүүлгийн хувьсгал, мэдлэгийн эдийн засгийн үйл ажиллагаа явагдаж байна ажээ.

Уг ажил асар том ёотон хэлбэрийн том дөрвөлжин байшингуудад явагддаг байна. Орох хаалганы дэргэд шар цэцгэн хэлхээ, жижиг модон заан бүхий Брахмаг тахисан шүтээн тавьжээ... Дотор талд нь мянга мянган тай ажилчид байна.

«Эдний ажилчид анх ажиллаж эхлэх үедээ явган ирдэг байсан. Дараа нь тэд мотоцикл унацгаадаг болсон. Одоо тэд машин унаж байна» гэж тахиа маллагч хэлээд, «Хүн бүр л тэнд ажиллахыг хүсдэг, гэхдээ тэнд ажилд ороход хэцүү» гэлээ.

... Хот руу буцах замдаа би унаа хайж үйлдвэрийн бүс дундуур алхав. Үйлдвэрийн нэг ээлжийнхэн тарж байгаа бололтой, мянга мянган эмэгтэйчүүд (гадаадын электроникийн үйлдвэрүүдэд ихэвчлэн эмэгтэйчүүд ажилладаг учраас) үйлдвэрийн хаалгаар түрэн гарч байв. Замд маань ресторан, эмийн сан, супермаркет, гоёл чимэглэлийн дэлгүүр, оёдолчны газар, киноны хуурцагны мухлаг, автомат угаалгын газрууд тааралдаж байв¹⁶.

Оксфамын сайн бодож боловсруулаагүй долигнолт, цөөн тооны популист (жирийн ард иргэдийн нэр барьсан) улс төрчдийг эс тооцвол, ядуу буурай орнуудын ихэнх бодлого боловсруулагчид даяаршлын ашиг тусыг сайн

ойлгож байна. Тэдний даяаршилд нэгдэн орж, түүний үр шимийг нь хүртэх хүсэл зоригийг мохооход чиглэсэн аюултай буруу ташаа мэдээллүүд эдгээр оронд газар авч байгааг болиулахын тулд тэдний олонх нь энэ талаар идэвхтэй бичиж эхлээд байна.

Одоогоор тулгарч буй нэг бодит хүндрэл бэрхшээл ивээх үзэлд оршиж байгаа нь зарим нэг тэргүүлэх баян оронд хүндрэл учруулж байх шиг байна. Үүний нэг жишээ бол гаднаас авах санхүүжилтийн тухай айдас юм. Бодлогын хувьд зөрөлдөх нь олонтаа байдаг АНУ, Франц хоёр хоёулаа нэг ижил айдсын хохирогчид байдаг. Эдийн засгийн загвар нь бүтэлгүйтэж, улмаар даяаршлаас ирэх эрсдлийг асар их нэмэгдүүлж, түүнийн үр шимийг хүртэх боломжийг сулруулж байгаад АНУ тэнэг юм шиг хандаж, Франц улс ухаалгаар хандсандаа айж байна. Тэд бас хоёулаа «шар аюул» дээр Энэтхэгийн «бор аюул»-ыг нэмсэн байна. Аль нь ч утгагүй зүйл бөгөөд эдгээр айдас огт үндэслэлгүй болж таарах боломжтой¹⁷. Тэгтэл бас Оросын зүйр үгт гардаг шиг, айхад нүд бүлтийнэ. Тэгвэл би үүн дээр нэмж, айхад бас заримдаа чих дүлийрдэг гэж хэлмээр байна.

Даяаршлыг шүүмжлэгчид өөрсдийгөө бидний бардам зангаар харж байгаа зүйлээс сэрээж байна, даяаршлын үйл явц бидний тухыг алдагдуулж байна гэж боддог. Гэхдээ хүсэл сонирхлыг төдийгүй шалтгааныг тусгахгүйгээр аливаа олон нийтийн үйл ажиллагаа амжилт олохгүй. Шалтгаан ба задлан шинжилгээнээс үзэхэд, даяаршилд хүнлэг царай дутаж байна гэсэн итгэл үнэмшлээ орхиж, түүний оронд хүнлэг царай бий гэдгийг хүлээн зөвшөөрч улам сайжруулахыг шаардаж байна. Ингэж ч болно.

Тайлбар

- 1 Жагдш Бхагвати бол Колумбийн Их сургуулийн профессор, Нью Йорк дахь Гадаад харилцааны зөвлөлийн ахлах судлаач, Даяаршлыг өмгөөлөх тухайд, 2004 номын зохиогч юм.
- 2 Бхагвати /Bhagwati, J/, 1998.
- 3 Экономист сэтгүүл, 2003; мөн Бхагвати, 2004. Бүлэг 13-г үзнэ үү.
- 4 Хьюм /Hume, D/, 1983, х.49.
- 5 Сайд /Said, E/, 2001.
- 6 Брайнерд, Блэк нар /Brainerd, E. and S. Black/, 2000, онлайн хаяг: <http://econpapers.repec.org/paper/izaizadps/dp556.htm>; илүү дэлгэрэнгүй нэмэлт мэдээллийг Бхагвати, 2004, Бүлэг 7-гоос үзнэ үү.
- 7 Уайт /White, M/, 1999.
- 8 Бхагвати, 2004, х. 83-86-г үзнэ үү.
- 9 Тэдний тайлан Нью Йорк Таймс сэтгүүлд “Хөлсний газруудын хоёр магтаал” гэсэн ёхтой нэрээр нийтлэгдсэн, мөн тэдний Дорноос ирэх аянга (2000) номонд орсон.
- 10 Ранжан /Ranjana, P/, 2001.

- 11 Эдмондс, Павкник нар /Edmonds, E. and N.Pavcnik/, 2002, онлайн хаяг: <http://www.nber.org/papers/w8760>
- 12 Худалдаан дахь “давхар стандарт”-ын тухай Оксфамын мэдээлэл муутай ярианы эсрэгээр, өндөр хөгжилтэй орнууд хүмүүсийн бодож байснаас хамаагүй ихээр худалдаагаа либеральчлаад байна.
- 13 Худалдааг илүү чөлөөтэй болгохын эсрэг хамгийн их анхаарал татсан эсэргүүцлийг няцаасан илүү их нотолгоог өнөөдөр Дэлхийн Худалдааны Системийн Ирээдүй гэсэн тайланд бичсэн байгаа. Уг тайланг энэ жил Петер Сютерланд тэргүүтэй мэргэжилтнүүдийн бүлэг, түүний дотор би оролцон бэлтгэж ДХБ-ын Ерөнхий захиралд илгээсэн. Өнөөдөр ДХБ-ын үйл ажиллагаа, түүнийг их хэмжээний лоббигоор гажуудуулж байгаа явдал ихээхэн санаа зовоож байна. Тухайлбал, олон эдийн засагчид (түүний дотор миний бие) патентийн хүчинтэй байх оновчтой хугацаа тэг бус байхын зэрэгцээ оюуны өмчийн (ОӨ) хамгаалалтыг дэмжсэн аж үйлдвэрийн лоббинууд патентийн эрхийг дэндүү хэтэрхий олон жилээр олгуулах тал дээр амжилт олж байна гэж үзэж байна. Түүнчлэн эдгээр лоббинууд нь TRIPs буюу олон улсын өмчийн эрхийн худалдаатай холбоотой асуудлын тухай гэрээнүүд-ээр дамжуулан ДХБ-д ОӨ-ийн хамгаалалтыг оруулж чадаад байгааг олон худалдааны эдийн засагчид эсэргүүцэж байна. Тэдний хувь, ДХБ бол худалдааны байгууллага, төлбөр хураах асуудал бол түүнд хамаагүй, ОӨ-ийн хамгаалалт гэх мэт огт хамаагүй асуудлыг ДХБ-д оруулж байгаа нь хөдөлмөрийн болон байгаль орчны лоббинууд гэх мэт бусад чиглэлийнхэн олноор даган орж ирэх боломж олгож байгаа (ойрын ирээдүйд бусад олон чиглэлийнхэн орж ирэх нь эргэлзээгүй) нь тэд ДХБ-ын хэрэгт дураараа оролцож, үндсэн үйл ажиллагаа, мөн чанарыг нь алдагдуулах болно гэж үзэж байна.
- 14 Үндэсний болон эдийн засгийн өөрийгөө хангах чадвар, бие даасан байдлыг хөгжүүлэх бодлогууд.
- 15 Ларссон /Larsson, T/, 2001.
- 16 Дээрхтэй адил, х. 133-134.
- 17 Тухайлбал, Бхагвати нар, 2005-г үзнэ үү.

Лавлах материалууд

- Bhagwati, J. 2004. *In Defense of Globalization /Даяаршлыг өмгөөлөх тухайд/*. New York: Oxford University Press.
- _____. 1998. “The Capital Myth: The Difference Between Trade in Widgets and Dollars.” /Капиталын домго: Уайджет ба Долларын худалдааны ялгаа/. *Foreign Affairs /Гадаад хэрэг/*. 5-6 сар.
- Bhagwati, J., A. Panagariya, and T.N. Srinivasan. 2005. “Muddles Over Outsourcing.” /Гадаад санхүүжилтийн талаарх будиан/*Journal of Economic Perspectives /Эдийн засгийн хэтийн төлвийн тухай сэтгүүл/18(4). American Economic Association /Америкийн Эдийн засгийн Холбоо/*. Winter.
- Brainerd, E. and S. Black. 2000. “Importing Equality? The Impact of Globalization on Gender Discrimination.” /Эрх тэгш байдлыг импортлох үү? Хүйсийн ялгаварлан гадуурхалтад даяаршлын үзүүлэх нөлөө/. *Econpapers 556*. Institute for the Study and Labor /Судалгаа, хөдөлмөрийн институт/.
- The Economist /Экономист сэтгүүл/. 2003. “A Place for Capital Controls.” /Капиталын хяналтад зориулсан газар/. Editorial. 5 сарын 3.
- Edmonds, E. and N.Pavcnik. 2002. “Does Globalization Increase Child Labor? Evidence from Vietnam.” /Даяаршил хүүхдийн хөдөлмөрийг нэмэгдүүлдэг үү? Вьетнамын баримт/. National Bureau of Economic Research Working Paper 8760 /Эдийн засгийн судалгааны үндэсний товчооны ажлын тайлан/. Cambridge.
- Hume, D. 1983. *An Enquiry Concerning the Principles of Morals /Эц суртахууны зарчмуудын талаарх лавлагаа/*. J.B. Schneewind, ed. Indianapolis: Hackett.
- Kristof, N., and S. WuDunn. 2000. *Thunder from the East: Portrait of a Rising Asia /Дорноос ирэх аянга: Өсч өндийж буй Азийн дүр зураг/*. New York: Alfred Knopf.

-
- Larsson, T. 2001. *The Race to the Top: The Real Story of Globalization* /Оргилд хүрэх уралдаан: Даяаршлын тухай бодит түүх/. Washington, D.C.: Cato Institute.
- Oxfam. 2002. *Rigged Rules and Double Standards: Trade, Globalization and Fight Against Poverty* /Будлиантай дүрмүүд ба давхар стандартууд: Худалдаа, даяаршил, ядуурлын эсрэг тэмцэл/. Oxford: Oxfam.
- Ranjan, P. 2001. "Credit Constraints and the Phenomenon of Child Labour." /Зээлийн дарамтууд ба хүүхдийн хөдөлмөрийн үзэгдэл/. *Journal of Development Economics* /Хөгжлийн эдийн засгийн сэтгүүл/ 64: 81-102.
- Said, E. 2001. "The Public Role of Writers and Intellectuals." /Зохиолч, сэхээтнүүдийн олон нийтийн үүрэг/. *The Nation* 8(273): 27 /Үндэстэн/. 9 дүгээр сар.
- White, M. 1999. "Women and Trade." /Эмэгтэйчүүд ба худалдаа/. Testimony for Hill Briefing on Women and the WTO /Эмэгтэйчүүд ба ДХБ-ын талаарх Хиллийн товч мэдээллийн нотолгоо/. *Women's Edge*. 6 сарын 28.
- World Trade Organisation /Дэлхийн Худалдааны Байгууллага/. 2005. *Future of the World Trading System*. /Дэлхийн худалдааны системийн ирээдүй/ Geneva.

Сонгосон орнуудын өгөгдөл мэдээлэл

4-р бүлэг

БҮЛЭГ 4.1

Бизнесийн удирдлагуудын санаа бодлын судалгаа: Улс орны өрсөлдөх чадварыг хэмжих зайлшгүй чухал хэрэгсэл болох нь

ЖЕННИФЕР БЛАНКЕ
ЭММА ЛОАДЕС¹
Дэлхийн Эдийн Засгийн Форум

Өнөөгийн дэлхийн ертөнц дээр төрийн бодлого боловсруулах, хөрөнгө оруулалт болон бизнестэй холбоотой бусад шийдвэрийг чиглүүлэхэд шийдвэрлэх ач холбогдолтой нэг хүчин зүйл бол олон нийтийн санаа бодол болоод байна. Тэгвэл аливаа эдийн засгийн дотоод ажиллагааг газар дээр нь үзэж туулж байгаа хүмүүсийн үзэл бодол, мэдрэмж нь түүнийг сайжруулахад шаардлагатай стратегиудыг тодорхойлж, боловсронгуй болгоход үнэлж баршгүй хувь нэмэр оруулдаг нь батлагдаад байна. Хүмүүс чухал ач холбогдолтой асуудлуудаар үзэл бодлоо илэрхийлэх боломжтой байх үед тэдний үүрэг хариуцлагын ухамсар, тухайн өөрчлөлтийн үйл явцад оролцох оролцоо нэмэгдсэнээр, бодлогын шинэчлэлийг хөнгөвчилж өгдөг. Сайтар тодорхойлж, хүлээн зөвшөөрөгдсөн арга зүй ашиглан хариуцлагатайгаар цуглуулж нэгтгэсэн ийм үзэл бодлын жинхэнэ үнэ цэнийг стратеги төлөвлөлтийн нэг гол элемент гэдэг үүднээс төр засгийн газрууд, бизнесийн салбарынхан ялгаагүй улам бүр хүлээн зөвшөөрсөөр байна.

Дэлхийн Эдийн Засгийн Форум байгууллага улс үндэстнүүдийн өсөлтийн чадамжийг хэмжих хэрэгсэл бий болгож хөгжүүлэх зорилгоор 1979 онд анхны Бизнесийн удирдлагуудын санаа бодлын судалгаагаар (Судалгаа) явуулсан. Одоо дэлхийн эргэн тойронд байгаа янз бүрийн пүүс компаниудын удирдах дээд ажилтан мянга мянган хүмүүсийг хамруулан жил бүр явуулж байгаа энэ Судалгаа нь бизнесийн үйл ажиллагааны орчинд нөлөөлж буй хамгийн чухал асуудлуудын талаар сайн мэдэх бизнесийн удирдлагуудын мэргэжлийн үзэл бодлыг олж мэдэх зорилготой боловсруулагдсан. Уг санал асуулгыг тогтсон тоон үзүүлэлт ховор буюу огт байдаггүй янз бүрийн үзүүлэлтээр мэдээлэл цуглуулж авах үүднээс нарийвчлан боловсруулсан байгаа. Жишээлбэл, Өсөлтийн өрсөлдөх чадварын индексийн (энэхүү Тайлангийн Бүлэг 1.1-д үзүүлсэн) гурван үндсэн бүрэлдэхүүн хэсгийн нэг нь аливаа улс үндэстний эдийн засгийн тогтвортой өсөлтийн суурь хүчин зүйлсийн нэг болох үндэстний төрийн институциудийн чанарыг хэмжиж байна. Шүүхийн хараат бус байдал, улсын эсвэл хувийн ажил гүйлгээнд хээл хахууль зонхилох байдал, улсын хөрөнгийн ашиглалт дахь үр ашиггүй байдал гэх мэт чухал ойлголтуудын тоон хэмжүүрийг олж авахад хэцүү байдаг. Иймээс уг Судалгаа нь нарийвчилсан судалгаа, шинжилгээнд чухал

ач холбогдолтой *чанарын* үзүүлэлтүүдийг цуглуулах нэг хэрэгсэл болж байна.

Судалгааны санал асуулгад өгсөн хариултуудаас олж авсан тоо баримтууд нь аливаа улс үндэстний эдийн засгийн орчны чанарбатогтвортой өсөлтөд хүрэх чадварыг жил бүр хэмжих үүрэгтэй Дэлхий дахины өрсөлдөх чадварын тайлангийн нэг гол бүрэлдэхүүн хэсгийг бүрдүүлж байна. Магадгүй үүний үр дүн нь аливаа улс үндэстний эдийн засаг, бизнесийн орчны одоогийн ба ирээдүйн эрүүл саруул байдал болон түүний дэлхий нийтийн эдийн засагтай хэрхэн холбогдож байгааг хамгийн нарийн дүрслэн харуулдаг байж болох юм. Энэ бүлэгт, Бизнесийн удирдлагуудын санаа бодлын судалгааны үйл явцыг болон уг тайланд хамрагдсан улс орон бүрт ажиллаж буй манай Түнш Институтүүдийн гүйцэтгэдэг өсөн нэмэгдэж буй голлох үүргийг харуулж байна. Мөн түүнчлэн энэ жилийн Судалгаанд оролцож хариулагчдын онцлогийн тухай дэлгэрэнгүй мэдээлэл, цуглуулсан мэдээллийн тоо хэмжээ, чанарыг сайжруулах үүднээс сүүлийн үед нэвтрүүлсэн зарим арга, уг Судалгааны тоон үзүүлэлтүүдийн өөрийн үнэн зөв, найдвартай байдлыг шалгасан хэд хэдэн сорилтын үр дүнг энд оруулсан байгаа.

Бизнесийн удирдлагуудын санаа бодлын судалгааны санал асуулгууд

Санал асуулгыг 11 асуудлын хүрээнд ангилсан нь дор бүрнээ аливаа эдийн засгийн бизнесийн

орчны одоогийн байдалтай холбоотой бөгөөд оролцогчид өөрсдийн бизнесийн туршлагад тулгуурлан 150 асуултад хариулахыг хүссэн байгаа. Санал асуулгад хамрагдсан чиглэлүүдэд эдийн засгийн ерөнхий байдал, хувь хүмүүс, бизнес, засгийн газрын технологи ашиглалтын түвшин ба цар хүрээ, төр засгийн болон улсын салбарын үр нөлөөтэй байдал, төрийн институциудийн чанар, ерөнхий дэд бүтэц, хүний нөөц, санхүү ба нээлттэй байдал, дотоодын өрсөлдөөн, компаниудын үйл ажиллагаа ба стратеги, эцэст нь буюу тийм ч ач холбогдол багатай биш чиглэл болох байгаль орчин ба нийгмийн хариуцлагын цар хүрээг оруулсан. Хувьсагч бүрийн үр дүнг энэхүү *Тайлан*-гийн тоон үзүүлэлтүүдийн хүснэгтийн хэсэгт үзүүлсэн бөгөөд асуудлын чиглэл бүрээр ангилсан байгаа. Уг Судалгааны сүүлчийн асуултад, оролцогчдод 14 асуудал бүхий жагсаалт өгч, түүнээс өөрсдийн улс оронд бизнес эрхлэхэд хамгийн хүндрэл бэрхшээлтэй байгаа таван асуудлыг сонгохыг хүссэн байгаа. Энэхүү тусгай асуултын үр дүнг энэ *Тайлан*-гийн улс орны онцлогтой мэдээллийн хэсэгт оруулсан байна.

Тоон үзүүлэлтүүдийг харьцуулах зорилгоор задлан шинжлэхэд хялбар дөхөм болгох үүднээс уг Судалгааны ихэнх асуултын бүтцийг ижил болгосон байгаа. Асуулт бүрт тухайн оролцогч бизнесийн орчныхоо нөхцөл байдалд үнэлэлт өгч, түүнийгээ 1-ээс 7 хүртэлх тоогоор дүгнэх бөгөөд энд 1 гэсэн оноо нь хамгийн муу, 7 гэсэн оноо нь хамгийн сайн байдлыг илэрхийлнэ. Хайрцаг 1-т Судалгааны нэг энгийн асуултын жишээг үзүүлж байна.

Судалгааны санал асуулгыг *Тайланд* хамрагдсан бүхий л улс орны хэмжээнд хэрэглэж болохоор байх нөхцлийг бүрдүүлэх нь чухал. Энэ шаардлагыг хангахын тулд асуултуудын үг хэллэгийг нарийвчлан хянаад зогсохгүй 30 гаруй хэлний хувилбараар оролцогчдод танилцуулсан байгаа. Хэдийгээр ихэнх оролцогчид англи хэл дээрх хувилбарыг ашигладаг боловч араб, франц, герман, испани гэсэн бусад дөрвөн үндсэн хэлний хувилбарыг бэлтгэсэн. Бусад Түншлэгч Институтүүд (дор үзнэ үү) уг судалгааны үйл явцыг үндэсний хэмжээнд хөтлөн явуулж байна. Тэдэнд уг санал асуулгыг өөрийн орны хэл дээр орчуулах боломж олгосон байгаа. Энэ жил уг боломжийг сонгосон Албани, Ангол, Армян, Азарбайжан, Босни Герцоговен, Бразил, Хятад, Хорват, Кипр, БН Чех Улс, Эстони, Итали, Япон, Латви, Литва, Македон, Молдав, Монгол, Мозамбик,

Хайрцаг 1: Судалгааны нэг энгийн асуултын жишээ

Танай улсын оюуны өмчийн хамгаалалт:

Сул эсвэл 1 2 3 4 5 6 7 Дэлхийн хамгийн
огт байхгүй юу хатуу чандад орох үү

- 1 –ийг дугуйлвал.....** Та зүүн гар талын хариулттай бүрэн санал нэг байна гэсэн үг
- 2–ыг дугуйлвал.....** Та зүүн гар талын хариулттай ихээхэн санал нэг байна гэсэн үг
- 3 –ыг дугуйлвал.....** Та зүүн гар талын хариулттай зарим талаар санал нэг байна гэсэн үг
- 4–ийг дугуйлвал.....** Та энэ хоёр хариултын аль алинтай нь адилхан санал нэг байна гэсэн үг
- 5–ыг дугуйлвал.....** Та баруун гар талын хариулттай зарим талаар санал нэг байна гэсэн үг
- 6–г дугуйлвал.....** Та баруун гар талын хариулттай ихээхэн санал нэг байна гэсэн үг
- 7 –г дугуйлвал.....** Та баруун гар талын хариулттай бүрэн санал нэг байна гэсэн үг

Португаль, Румын, Орос, Серб ба Монтенегро, Словак, Словени, Тажикистан, Украин зэрэг орнууд байна. Судалгааны ямар нэг асуултын утгыг гажуудуулахаас зайлсхийх үүднээс холбогдох Түнш Институтүүд (дор үзнэ үү) орчуулгыг нягтлан хянаж байгаа.

Энэ жилийн Судалгааг өргөн хүрээнд хүртээмжтэй байлгах зорилгоор тус Форумас уг санал асуулгын онлайн хувилбарыг хэрэглэгчдэд тохиромжтой, харилцан ажиллагаатай байдлаар боловсруулсан нь оролцогчид уг Судалгаанд хариулах нэг боломж болж байна. Дэлхий нийтийн хэмжээгээр Интернэтийн хэрэглээ нэмэгдэж байгаан өхцөлд хүмүүсэнэ санаачилгыг маш сайн хүлээн хүлээж авсан бөгөөд бид одоо байгаа англи, испани хэл дээрх хувилбаруудыг өргөтгөж франц хэл дээрх хувилбарыг нэмж оруулахаар шийдээд байна. Хэдийгээр хэвлэмэл хувилбарыг илүү өргөн хэрэглэсээр байгаа боловч энэ жил уг Судалгааны онлайн хувилбарын хэрэглээ 17.7 хувиар өссөн байна. Сонирхолтой нь, нийт онлайн хариулалтын (1,011) 83.3 хувь нь англи хэл ашигласан байна. Энэ жил манай Финлянд дахь Түнш Институт болох Финляндын Эдийн Засгийн Судалгааны Институт (ETLA) бүхэлдээ онлайн хувилбарт шилжсэн байна. Бид энэхүү өртөг зардал багатай, байгаль орчинд халгүй хувилбарыг дэмжихийн зэрэгцээ бусад олон орон энэ жишгийг дагана гэдэгт итгэж байна. Бүрэн бөглөсөн санал асуулгын үр дүнг мэдээллийн сангийн системд автоматаар цуглуулдаг учраас энэ үйл явцын үеэр явцын тайланг тухай бүрт нь гарган үзэж болдог.

Арга зүй

Бизнесийн удирдлагуудын санаа бодлын судалгааг Дэлхийн Эдийн Засгийн Форумын Дэлхий дахины өрсөлдөх чадварын хөтөлбөр удирдан явуулдаг бөгөөд дэлхий дахинд тус Форумын гишүүдийн хамтын нийгэмлэг, түншлэгч компаниудыг төлөөлөн ажиллаж буй ойролцоогоор 8000 орчим бизнесийн удирдах ажилтанд энэ асуулгыг түгээдэг. Судалгаа явуулахад ашиглаж буй аргууд *Тайлан*-д хамрагдсан бүх улс орны хэмжээнд нийцтэй байх нөхцлийг хангахын тулд тус Форумас уг Судалгааг газар дээр нь удирдан явуулж байгаа Түнш Институтүүдэд зориулсан дэлгэрэнгүй заавар удирдамжийг боловсруулан гаргаад байна. Түнш Институтүүд уг Судалгааг хэрхэн явуулах талаар заавар удирдамж авах бөгөөд тэднээс санал асуулгад оролцох бизнесийн

удирдах ажилтнуудын түүврийг сонгон бүрдүүлэхийг (зарим олон улсын мэдлэг туршлагатай хүмүүсийг сонгож авахыг илүүд үзнэ) хүсэх болно. Сонгосон удирдах ажилтан нь тухайн компанидаа гүйцэтгэх захирал буюу түүнтэй адилтгах албан тушаалтай байх ёстой бөгөөд хэрэв тухайн компани 500-гаас дээш тооны ажилтантай бол санал асуулгад оролцогч нь тус компаний удирдах дээд таван албан тушаалын аль нэгийг хашдаг байж болно. Түүвэрт сонгож авах компаниуд тухайн эдийн засгийн үндсэн салбаруудыг төлөөлөх ба эдгээр салбарууд нь тухайн улсын ДНБ-д эзлэх хувийн жингийн харьцаагаар тодорхойлогдоно. Энэ ажиллагааны үед Түнш Институтүүдэд заавар удирдамж болгох үүднээс тус Форум Дэлхийн Банкны 2004 оны *Дэлхийн Хөгжлийн Үзүүлэлтүүд* номноос ДНБ-д эзлэх хувийг салбар бүрээр задласан дэлгэрэнгүй задаргааг тэдэнд гаргаж өгдөг. Олон тохиолдолд ямар нэг улсын үйлдвэр аж ахуйн газруудын тархалтын тухай илүү дэлгэрэнгүй мэдээллийг үндэсний эх сурвалжуудаас авч нэмэлт болгодог.

Дараа нь үндсэн жагсаалтаасаа ярилцлагад хамрагдах компаниудын түүврийг ангилан гаргах бөгөөд тухайн улсын компаниудын олон янзын хүрээг хамгийн сайн төлөөлөхүйц компаниуд байна. Заримдаа үндсэн жагсаалт гаргахдаа утсан холбоо эсвэл бусад өргөнөөр хэрэглэдэг нийтийн үйлчилгээнд бүртгэлтэй компаниудын жагсаалтаас түүвэрлэн гаргаж болно. Өөрнэг хувилбар болсон голтыг үндэсний статистикийн газар эсвэл татварын газруудад бүртгэлтэй бүх компаний жагсаалтаас эхлэж болно. Дараа нь улс орон бүрийн компаниудын үндсэн жагсаалтыг эдийн засгийн салбар, газар зүйн бүс, хэмжээгээр нь ангилна. Цаашлаад эдгээр бүлгүүдийн дотроос тухайн улсын пүүс компаниудын үндэсний хэмжээний тархалтыг илэрхийлэх эцсийн түүврийг гаргаж авахыг бид зөвлөмж болгодог. Бүлэглэл бүрээс ярилцлага хийхээр сонгож авах пүүс компаниудын сонголт тэр чигтээ санамсаргүй сонголт байж болохгүй. Яагаад гэвэл, нэг талаас олон улсын хэтийн төлвийн талаар сайн мэдэх бизнесийн удирдлагуудтай ярилцахыг илүүд үзэх бөгөөд энэ нь харьцангуй том компаниудыг сонгож авахад хүргэх нь олонтаа. Гэхдээ энэ асуудалтай холбогдуулан бид Түнш Институтүүдээ аль болох тэгш төлөөлөлтэй түүвэр сонгож авах удирдамж баримтлахыг хүсдэг.

Хариулагчдын түүвэрт дор хаяж дараахь онцлогтой компаниудын заримаас оруулах шаардлагатай:

- Гадаадын зах зээлд бүтээгдэхүүнээ борлуулдаг дотоодын пүүс компаниуд
- Дотоодын зах зээлд ажиллаж буй гадаадын пүүс компаниудын салбар нэгжүүд
- Их хэмжээний төрийн өмчит үйлдвэр аж ахуйн газрууд (байдаг бол)

Түнш Институтүүд уг Судалгаанд оролцох үйлдвэр аж ахуйн газруудын 50-иас дээш хувьд очиж судалгаа авахыг зөвлөдөг. Ингэж очих боломжгүй тохиолдолд шууд захидал явуулсны дараа утсаар холбоо барьж хариу авахыг илүүд үздэг. Судалгаа явуулах энэ аргыг Түнш Институтүүд бүгд сонгож ашигладаггүй боловч өөрсдийн аргыг холбогдох бизнесийн салбаруудын хэмжээ, бүтэц, нөхцөл байдалд тохируулан хэрэглэдэг.

Түнш Институтүүдийн үүрэг²

Дэлхий дахины өрсөлдөх чадварын хөтөлбөр нь энэ жилийн *Тайлан*-д хамрагдсан дэлхийн 117 оронд байрладаг 122 Түнш Институтийн сүлжээг бий болгоод байна. Эдгээр нь ихэвчлэн эдийн засгийнхаа өрсөлдөх чадварын нөхцөл байдлыг сайжруулах эрмэлзэлтэй тэргүүлэх судалгааны буюу эрдэм шинжилгээний институтүүд, бизнесийн байгууллагууд, үндэсний өрсөлдөх чадварын зөвлөлүүд, эсвэл бусад нэр хүндтэй мэргэжлийн байгууллагууд байдаг. Манай *Тайлан*-д орсон зарим томоохон орнуудад нэгээс дээш тооны институттэй түншийн харилцаа тогтоох зайлшгүй шаардлагатай болоод байна. Тухайлбал, Орост бид гурван институттэй хамтран ажилладаг бөгөөд эдгээр нь Москвад төвтэй хоёр байгууллага болох Оросын Холбооны Улсын Засгийн газрын дэргэдэх Үндэсний эдийн засгийн академи, Хувийн салбарын хөгжил ба нийгэм, эдийн засгийн шинжилгээний институт (IPSSA), Санкт Петербургт төвтэй Стокгольмийн эдийн засгийн сургууль гурав юм.

Түнш Институтүүдийн үндсэн үүрэг бол Дэлхийн Эдийн Засгийн Форумас тогтоосон заавар удирдамжийн дагуу Бизнесийн удирдлагуудын санаа бодлын судалгааг явуулах явдал юм. Судалгаанд хариулалтын хувь өндөр байх, хариултын ерөнхий чанар сайн байх нь манай Түншүүдийн тавьсан хүчин чармайлт, тэдний дотооддоо тогтоосон харилцаа холбооны хүчийг нотлон харуулж байдаг. Түнш Институтүүд ба Форумын хоорондын харилцаа хүчтэй бөгөөд харилцан ашигтай байхыг зорьж

байгаа нь Түнш Институтүүд үндэсний өрсөлдөх чадварын дэлхийн хамгийн өргөн дэлгэр үнэлгээнүүдийн нэгтэй холбогдоод зогсохгүй өөрсдийн судалгааны төслүүдтэй холбоотой тоон мэдээллүүдийг авах онцгой эрхээр хангагдах боломж олгож байна. Мөн хамрах хүрээгээ дээд цэгт хүртэл өргөжүүлэхийн тулд тус Форумас үндэсний хэмжээнд уг *Тайлан*-гийн үр дүнг түгээн дэлгэрүүлэхэд Түнш Институтүүд туслалцаа үзүүлэхийг дэмжиж байгаа нь бодлогын мэтгэлцээнд болон тухайн улсын ерөнхий хөгжилд эерэг хувь нэмэр оруулах цаад зорилготой юм.

Газар зүйн хамралт ба судалгааны хариулалтын хувь

Энэ жилийн *Тайлан*-д Албани, Армян, Азарбайжан, Бенин, Камбож, Камерун, Зүүн Тимор, Гайана, Казахстан, Кувейт, Киргизстан, Молдав, Монгол, Катар, Тажикистан зэрэг 15 шинэ орныг оруулж тодорхойлсноор түрүү жил нийт 104 орон хамрагдсныг 117 болгож нэмэгдүүлсэн байна. Харамсалтай нь, дотоодын нөхцөл байдал хүнд байснаас болж Ангол, Замби хоёр улсад энэ жил уг Судалгааг явуулж чадаагүй учраас энэ удаагийн номонд оруулсангүй. Нийт улс орны хамралт дэлхийн Дотоодын Нийт Бүтээгдэхүүний 98.2 хувьтай тэнцүү байна. Бүдүүвч 1-д үзүүлсэн газрын зурагт улс орнуудын хамрагдалтын цар хүрээг харуулж байна. Уг газрын зураг дээр хар хөхөөр тэмдэглэсэн газрууд бол энэ жил анх удаагаа орж байгаа орнууд, саарлаар тэмдэглэсэн газрууд нь одоогоор хамрагдаад байгаа газрууд, цагаан хэсгүүд нь ирэх жилүүдэд уг *Тайлан*-д оруулж чадах байх гэж найдаж байгаа улс орнуудыг харуулж байна.

Энэ жил Судалгаанд хариулалтын хувь хамгийн өндөр түвшинд хүрсэн бөгөөд түрүү жил 8729 байсан бол энэ жил 10993 болж 26 хувиар өссөн байна. Энэ нь нэг улсаас дунджаар 94 хариулт авсан дүнтэй байна. Форумын зүгээс Судалгаанд хариулалтын хувь, тоон үзүүлэлтийн чанараа жил бүр дээшлүүлэх хүчин чармайлт тавьсаар байна. Энэ жилийн Судалгааны явцад олон тооны сайжруулалт (дор үзнэ үү) гараад байгаа нь цуглуулсан хариултуудын тоо нэмэгдсэнээр тодорхой илэрч байна.


Хүснэгт 1: Хариулагчдын тархалт, салбараар

Улс	Түүврийн хэмжээ	Хөдөө аж ахуй (%)	Аж үйлдвэр (%)	Үйлчилгээ (%)	Ангилал боломжгүй (%)	Хөдөө аж ахуй (%)
Албани	93	4	51	37	5	3
Алжир	64	8	34	22	6	30
Аргентин	97	6	41	38	10	4
Армян	102	23	33	35	5	4
Австрали	91	2	44	41	8	5
Австри	117	2	38	37	18	5
Азербайжан	66	3	42	48	5	2
Бахрейн	38	0	8	42	16	34
Бангладеш	96	4	43	25	15	14
Бельги	62	3	37	50	8	2
Бенин	143	8	27	63	2	0
Болив	79	0	29	43	16	11
Босни Герцеговин	75	7	41	28	13	11
Ботсвани	62	2	31	56	5	6
Бразил	212	2	36	45	14	3
Болгар	156	8	41	50	1	0
Камбож	95	6	41	53	0	0
Камерун	90	31	21	28	10	10
Канад	126	2	43	40	10	4
Чад	216	6	13	70	9	2
Чили	164	6	41	38	9	6
Хятад	299	7	40	47	5	1
Колумби	53	11	64	21	4	0
Коста Рика	81	12	36	42	10	0
Хорват	103	8	36	50	7	0
Кипр	78	3	35	59	4	0
БН Чех Улс	99	0	22	54	18	6
Дани	50	0	36	54	10	0
БН Доминикан Улс	70	1	30	54	3	11
Зүүн Тимор	61	5	31	57	7	0
Эквадор	87	3	22	59	13	3
Египет	119	13	28	35	13	1
Эль Сальвадор	49	2	29	47	8	14
Эстони	88	1	35	53	10	0
Этиоп	89	9	24	39	18	10
Финлянд	36	0	72	25	0	3
Франц	163	2	25	48	17	9
Гамби	80	0	26	60	11	3
Гүрж	77	18	21	53	8	0
Герман	78	0	40	40	15	5
Гана	83	17	36	36	6	5
Грек	73	3	40	32	11	15
Гватемал	261	7	23	52	12	7
Гайана	49	12	37	47	2	2
Гондурас	82	10	23	49	11	7
Гонконг	56	0	27	55	11	7
Унгар	59	0	69	27	3	0
Исланд	30	10	40	43	3	3
Энэтхэг	100	2	53	23	17	5
Индонези	93	8	69	16	8	0
Ирланд	38	5	50	42	3	0
Израиль	37	3	68	22	5	3
Итали	141	1	35	35	13	16
Ямайк	70	4	23	54	17	1
Япон	75	0	51	37	12	0
Иордан	88	1	18	41	14	26
Казакстан	82	5	45	45	4	1
Кени	101	11	22	62	4	1
БН Солонгос Улс	190	1	47	48	2	2
Кувейт	62	0	2	23	6	69
БН Киргиз Улс	100	26	38	35	0	1

Улс	Түүврийн хэмжээ	Хөдөө аж ахуй (%)	Аж үйлдвэр (%)	Үйлчилгээ (%)	Ангилал боломжгүй (%)	Хөдөө аж ахуй (%)
Латви	170	4	29	51	11	5
Литва	135	10	38	50	1	1
Люксембург	32	0	38	50	9	3
Македон	87	10	37	49	3	0
Мадагаскар	83	37	18	29	8	7
Малави	43	16	23	44	0	16
Малайз	85	1	38	49	8	4
Мали	63	21	29	16	3	32
Мальт	53	2	21	55	8	15
Мавритани	22	9	18	68	5	0
Мексик	135	4	39	33	16	7
Молдав	91	22	27	44	7	0
Монгол	103	11	37	45	4	4
Марокко	73	7	30	55	8	0
Мозамбик	70	6	13	64	9	9
Намби	39	8	15	59	8	10
Нидерланд	87	2	18	64	10	5
Шинэ Зеланд	47	23	38	32	6	0
Никарагуа	66	8	20	47	9	17
Нигери	153	1	42	48	7	2
Норвеги	63	0	54	35	10	2
Пакистан	55	9	51	25	11	4
Панам	62	0	11	69	16	3
Парагвай	91	5	16	52	15	11
Перу	71	4	56	27	8	4
Филиппин	43	7	26	37	21	9
Польш	109	2	20	66	8	4
Португал	42	0	45	43	7	5
Катар	63	0	19	33	13	35
Румын	107	7	42	36	15	0
ОХУ	473	6	47	42	3	3
Серб ба Монтенегро	98	17	36	39	7	1
Сингапур	151	0	50	36	11	3
БН Словак Улс	69	4	57	23	9	7
Словени	128	0	53	39	0	8
Өмнөд Африк	96	2	40	44	13	2
Испани	82	4	37	41	15	4
Шри Ланк	90	19	28	52	1	0
Швед	44	0	34	45	11	9
Швейцарь	101	1	41	39	14	6
Тайвань	82	0	61	30	6	2
Тажикстан	90	20	36	41	0	3
Танзани	102	40	15	39	5	1
Тайланд	64	3	42	39	9	6
Тринадад Тобаго	108	6	24	52	11	7
Тунис	74	22	31	26	14	8
Турк	125	2	57	28	10	3
Уганда	90	31	20	48	1	0
Украин	101	4	54	38	4	0
АН Эмират Улс	54	0	52	37	4	7
Их Британи	97	0	28	54	16	2
АНУ	158	0	39	42	16	3
Уругвай	79	8	27	48	14	4
Венесуэл	35	0	26	49	26	0
Вьетнам	157	7	20	35	22	16
Зимбабве	28	11	54	32	4	0
Нийт	10.993					

Тайлбар: Ангилалуудыг Дэлхийн Банкнаас (2004) авсан. Хариулаагүй гэдэг нь уг Судалгааны яг энэ асуултад хариулаагүй хариулагчдын эзлэх хувийг илэрхийлнэ.

Бүдүүвч 1: Улс орнуудын Бизнесийн удирдлагуудын санаа бодлын судалгаанд хамрагдсан байдал



Хариулагчдын шинж байдал

Хүснэгт 1-д хариулагчдын бодит тархалтыг үйлдвэрлэлийн салбаруудаар (хөдөө аж ахуй, аж үйлдвэр, үйлчилгээ гэх мэт) үзүүлэхийн зэрэгцээ улс бүрийн түүврийн хэмжээг харуулав.

Ихэнх хариултын салбаруудаар гаргасан бодит тархалт холбогдох бизнесийн салбарын бодит бүтцийг боломжийн сайн тусган харуулсан байна. Хүснэгт 2-т Хорват улсын ДНБ-ий салбаруудад хуваасан бодит тархалтыг тэдгээр салбар бүрээс Судалгаанд оролцож хариулагсдын хувьтай харьцуулсан нь Хорватын бизнесийн салбарын дүр зургийг боломжийн тодорхой гаргаж байна.

Хүснэгт 3-д энэ жил улс орон бүрээс судалгаанд хамрагдсан хариулагчдын онцлог шинжүүдийг дэлгэрэнгүй харуулж байна. Хүснэгтийн зүүн хэсэгт хариулагчдын тархалтыг компанийх нь хэмжээгээр (ажиллагсдын тоогоор) задлан шинжилсэн бол хүснэгтийн баруун хэсэгт түүврийн бүтцийг пүүс компаний төрлөөр (дотоодын, гадаадын, төрийн өмчит, эсвэл холимог) нь судалж үзсэн байна.

Энэ жилийн Бизнесийн удирдлагуудын санаа бодлын судалгааг 2005 оны 1 дүгээр

сараас 5 дугаар сарын хооронд явуулсан. Дуусгасан судалгаануудыг Дэлхийн Эдийн Засгийн Форумаар хянуулан засуулж, тоон үзүүлэлтүүдийг боловсруулах ажлыг Женевт төвтэй мэргэжлийн өгөгдөл боловсруулах компаниар гүйцэтгүүлсэн.

Хүснэгт 2: Судалгааны хариултын түүврийг цаад эдийн засгийн бүтэцтэй нь харьцуулсан байдал

Салбар	ДНБ-д эзлэх бодит хувь	Хариулагчдын эзлэх хувь
Хөдөө аж ахуй (хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас агнуур)	8	8
Аж үйлдвэр (үйлдвэрлэл, уул уурхай, барилга, цахилгаан, ус, хий)	30	36
Үйлчилгээ (тээвэр, холбоо, жижиглэн худалдаа, зочид буудал, санхүүгийн үйлчилгээ, үл хөдлөх хөрөнгийн болон бусад үйлчилгээ)	62	50
Ангилал боломжгүй	-	7

Хүснэгт 3: Хариулагчдын тархалт, пүүс компаний хэмжээ (ажиллагсдын тоо), төрлөөр

Улс	Түүврийн хэмжээ (хариулагчдын тоо)	Хариулагчдын тархалт, пүүс компаний хэмжээгээр (тухайн орон дахь ажиллагсдын тоо)					Хариула- гуй (%)	Хариулагчдын тархалт, пүүс компаний хэмжээгээр				
		< 101 (%)	101-500 (%)	501-5000 (%)	5001- 20000 (%)	> 20000 (%)		Дот ¹ > 50%	Төр ² > 50%	Гад ³ > 50%	Д, Т, Г ⁴ > 50%	Хариула- гуй (%)
Албани	93	66	26	8	1	0	0	66	3	24	5	2
Алжир	64	58	14	14	6	3	5	47	33	2	8	11
Аргентин	97	26	31	34	3	0	3	61	2	34	0	3
Армян	102	58	25	15	2	0	1	59	3	24	6	9
Австрали	91	21	19	45	9	7	0	53	10	30	4	3
Австри	117	5	42	44	7	2	0	65	3	25	6	1
Азербайжан	66	65	21	11	0	0	3	67	18	8	0	8
Бахрейн	38	39	37	21	0	0	3	47	5	24	11	13
Бангладеш	96	21	34	34	4	3	3	77	1	13	1	8
Бельги	62	52	18	16	6	6	2	68	5	16	5	6
Бенин	143	87	8	3	0	0	1	78	5	12	0	6
Болив	79	75	20	4	0	0	1	75	5	15	1	4
Босни Герцеговин	75	35	35	27	0	1	3	59	21	16	0	4
Ботсвани	62	65	27	8	0	0	0	45	10	34	2	10
Бразил	212	32	13	36	13	5	0	71	5	17	1	6
Болгар	156	73	15	8	2	0	2	73	10	8	0	10
Камбож	95	31	36	26	4	0	3	37	0	59	4	0
Камерун	90	54	38	7	1	0	0	54	11	18	2	14
Канад	126	19	44	30	5	2	0	65	14	17	1	3
Чад	216	93	6	1	0	0	1	76	3	8	1	11
Чили	164	27	30	33	7	0	2	60	8	26	2	4
Хятад	299	8	22	57	9	4	0	41	48	7	2	2
Колумби	53	25	34	30	9	2	0	60	6	30	0	4
Коста Рика	81	38	42	17	2	0	0	60	7	30	1	1
Хорват	103	44	35	16	4	2	0	53	22	17	1	6
Кипр	78	51	36	12	1	0	0	88	5	1	1	4
БН Чех Улс	99	48	18	24	5	0	4	37	16	28	3	15
Дани	50	38	20	30	10	2	0	62	4	28	0	6
БН Доминикан Улс	70	49	26	26	0	0	0	70	0	17	3	10
Зүүн Тимор	61	90	8	2	0	0	0	44	2	34	11	8
Эквадор	87	36	43	17	2	0	2	75	7	15	0	3
Египет	119	38	35	24	1	0	2	64	11	21	2	3
Эль Сальвадор	49	20	37	41	0	0	2	73	6	12	0	8
Эстони	88	78	17	3	0	1	0	60	7	31	1	1
Этиоп	89	52	26	18	1	1	2	62	22	4	0	11
Финлянд	36	3	53	36	6	3	0	50	11	28	8	3
Франц	163	23	21	29	10	17	0	50	9	31	6	4
Гамби	80	79	13	3	0	0	6	70	4	18	1	8
Гүрж	77	53	30	14	0	0	3	58	1	32	4	4
Герман	78	13	15	21	27	24	0	64	6	15	5	9
Гана	83	36	49	11	1	1	1	53	4	33	0	11
Грек	73	18	25	45	10	0	3	63	5	21	3	8
Гватемал	261	65	20	11	2	1	2	78	2	10	3	7
Гайана	49	63	18	14	2	0	2	61	12	14	2	10
Гондурас	82	50	28	17	4	0	1	89	5	2	0	4
Гонконг	56	34	18	30	9	9	0	43	5	43	4	5
Унгар	59	24	41	29	7	0	0	53	3	39	0	5
Исланд	30	50	43	7	0	0	0	77	17	7	0	0
Энэтхэг	100	9	16	47	19	8	1	65	2	18	4	11
Индонези	93	39	38	15	4	4	0	65	9	16	3	8
Ирланд	38	24	26	37	11	3	0	45	11	39	0	5
Израиль	37	35	46	14	5	0	0	76	0	16	3	5
Итали	141	37	24	19	11	9	0	52	1	32	5	10
Ямайк	70	61	19	16	1	0	3	69	0	26	1	4
Япон	75	11	12	35	23	19	1	73	3	11	0	13
Иордан	88	43	31	22	0	0	5	60	15	11	1	13
Казакстан	82	44	39	12	2	2	0	80	17	2	0	0
Кени	101	54	30	13	1	0	2	71	5	12	1	11
БН Солонгос Улс	190	14	29	41	10	6	1	78	4	13	2	4
Кувейт	62	48	26	23	3	0	0	65	11	0	2	23
БН Киргиз Улс	100	51	38	10	0	0	1	73	14	7	3	3
Латви	170	69	17	9	2	0	2	66	8	20	2	4

Хүснэгт 3: Хариулагчдын тархалт, пүүс компаний хэмжээ (ажиллагсдын тоо), төрлөөр /үргэлжлэл/

Улс	Түүврийн хэмжээ (хариулагчдын тоо)	Хариулагчдын тархалт, пүүс компаний хэмжээгээр (тухайн орон дахь ажиллагсдын тоо)					Хариулаа- гүй (%)	Хариулагчдын тархалт, пүүс компаний хэмжээгээр				
		< 101 (%)	101-500 (%)	501-5000 (%)	5001- 20000 (%)	> 20000 (%)		Дот ¹ > 50%	Төр ² > 50%	Гад ³ > 50%	Д, Т, Г ⁴ > 50%	Хариулаа- гүй (%)
Литва	135	10	57	30	2	0	1	50	32	16	1	0
Люксембург	32	34	22	38	6	0	0	56	3	38	0	3
Македон	87	61	24	11	3	0	0	77	13	9	0	1
Мадагаскар	83	76	18	5	0	0	1	70	2	11	0	17
Малави	43	44	28	16	5	0	7	44	7	30	9	9
Малайз	85	25	27	38	6	4	1	58	13	15	1	13
Мали	63	54	33	8	0	0	5	56	14	16	5	10
Мальт	53	57	26	15	0	0	2	60	6	28	2	4
Мавритани	22	36	18	45	0	0	0	73	9	14	5	0
Мексик	135	27	19	29	16	7	2	63	6	22	4	5
Молдав	91	32	37	29	2	0	0	59	21	19	1	0
Монгол	103	53	28	17	1	0	1	69	8	16	3	5
Марокко	73	67	22	8	3	0	0	85	3	5	1	5
Мозамбик	70	61	29	7	0	0	3	61	4	27	1	6
Намиби	39	49	21	23	0	3	5	56	13	21	5	5
Нидерланд	87	20	17	36	15	13	0	46	13	31	1	9
Шинэ Зеланд	47	11	45	36	6	2	0	47	13	36	2	2
Никарагуа	66	58	27	12	0	0	3	58	15	15	5	8
Нигери	153	46	26	25	2	0	1	82	0	15	1	3
Норвеги	63	19	43	27	10	0	2	29	2	60	6	3
Пакистан	55	33	25	29	9	2	2	78	7	7	2	5
Панам	62	58	23	11	3	0	5	74	3	10	0	13
Парагвай	91	62	26	9	0	0	3	85	0	9	1	5
Перу	71	20	44	31	4	0	1	59	7	30	1	3
Филиппин	43	16	28	40	12	0	5	65	5	21	0	9
Польш	109	39	20	19	4	6	12	39	4	46	1	11
Португаль	42	12	26	52	10	0	0	40	31	14	5	10
Катар	63	38	22	33	2	0	5	62	8	8	6	16
Румын	107	56	24	20	0	0	0	84	1	14	0	1
Оросын Холбооны Улс	473	32	29	27	5	3	3	70	18	6	2	4
Серб ба Монтенегро	98	44	29	23	2	1	1	61	16	19	1	2
Сингапур	151	30	32	32	5	1	1	13	7	69	4	7
БН Словак Улс	69	23	23	41	10	0	3	54	6	36	1	3
Словени	128	37	34	24	2	0	3	61	9	23	4	2
Өмнөд Африк	96	20	20	29	22	9	0	58	5	29	3	4
Испани	82	24	17	35	11	12	0	65	5	24	6	0
Шри Ланк	90	46	33	17	4	0	0	78	6	13	2	1
Швед	44	41	20	14	18	7	0	61	7	30	2	0
Швейцарь	101	38	24	24	10	4	1	63	8	24	2	3
Тайвань	82	6	24	54	12	4	0	62	10	23	1	4
Тажикстан	90	61	23	12	0	0	3	62	24	7	7	0
Танзани	102	63	21	15	0	0	2	61	6	26	4	3
Тайланд	64	3	25	38	23	9	2	56	22	9	6	6
Тринадад Тобаго	108	44	28	23	1	1	4	62	19	14	0	6
Тунис	74	69	18	11	0	0	3	77	3	8	3	9
Түрк	125	33	3	43	7	13	1	71	6	14	6	2
Уганда	90	68	19	10	1	1	1	82	2	12	2	1
Украин	101	40	42	14	1	3	1	65	21	5	1	8
АН Эмират Улс	54	17	30	39	9	2	4	57	20	17	0	6
Их Британи	97	27	15	29	19	10	0	57	2	27	5	9
АНУ	158	30	8	27	19	16	0	83	2	8	3	5
Уругвай	79	59	37	4	0	0	0	61	8	24	3	5
Венесуэл	35	46	20	26	6	3	0	77	0	23	0	0
Вьетнам	157	43	26	23	4	3	1	41	26	22	4	6
Зимбабве	28	11	7	64	18	0	0	54	18	21	0	4
Нийт	10.993											

Тайлбар:

¹ Өмчийнх нь дийлэнх хувийг дотоодын хувийн салбарууд эзэмшдэг компаниуд (50-иас дээш %)² Өмчийнх нь дийлэнх хувийг төр эзэмшдэг компаниуд (50-иас дээш %)³ Өмчийнх нь дийлэнх хувийг гадаадын бүлгүүд эзэмшдэг компаниуд (50-иас дээш %)⁴ Холимог өмчит компаниуд (дээрх гурван салбарын аль нь ч 50-иас дээш % эзэмшдэггүй)

Хариулаагүй гэдэг нь уг Судалгааны яг энэ асуултад хариулаагүй хариулагчдын эзлэх хувийг илэрхийлнэ.

Сайжиралт, шинэ санаачлага ба чанарын хяналт

Судалгаа хийх олон нийтийн санал асуулга явуулах чиглэлд тэргүүлэгч Галлап Интернэшнл байгууллага манай хөтөлбөрийн бүр эхнээс зөвлөхөөр ажилласан. Тэд уг Судалгаанд зориулж өргөн хүрээтэй арга зүйн болон техникийн дүгнэлт гаргаж өгсний үр дүнд энэ жилийн цуглуулсан тоон мэдээллийн чанар, тоо хэмжээнд олон сайжиралт гарсан юм. Галлапын өгсөн санал зөвлөмжүүдийн дийлэхийг хэрэгжүүлсний дотор өгөгдлийг алдаагүй оруулах нөхцлийг хангах үүднээс мэргэжлийн байгууллага авч ашигласан. Судалгааг удирдан явуулах заавар, журмын талаарх тодорхой заавар бүхий шинэ багц баримт бичгүүдийг Түнш Институтүүдэд зориулан боловсруулж гаргасан. Энэ жил Судалгааны агуулгыг гуравны нэгээр багасгасан нь хариулагчид бүрэн гүйцэд бөглөхөд хамаагүй төвөг багатай болсон. Судалгааны бүртгэлийн хуудас шинээр гаргаж, Түнш Институт бүрийн ашиглаж буй аргыг хянах эргэх холбоог нэвтрүүлсэн. Эдгээрт нарийвчилсан үнэлгээ хийснээр ирэх жилийн Судалгааг улам сайжруулах арга замуудыг олж тогтооход туслах юм.

Мөн Дэлхий дахины өрсөлдөх чадварын хөтөлбөрийн багийн гишүүд энэ жил шинээр орсон орнуудын заримд газар дээр нь очиж үзэх аялалыг хэд хэд зохион байгуулсан. Энэ аялалууд нь уг Судалгааг анх явуулахад тулгарч буй бэрхшээлүүдийн талаар Түнш Институтүүдтэй ярилцах, ирээдүйд тэдгээрийг даван туулах арга замыг судлахад чиглэсэн лавлах уулзалтуудаас бүрдэж байв. Эдгээр аялал тухайн эдийн засгийн ерөнхий нөхцөл байдалтай газар дээр нь танилцах байдлаар мэдлэгээ дээшлүүлэх боломжийг бидэнд олгосон.

Судалгааны үр дүн

Өмнө тайлбарлаж байсанчлан энэхүү Судалгааны тоон үзүүлэлтүүд нь өгөгдсөн эдийн засагт бизнес эрхлэж буй дундаж хүний харж байгаа олон янзын асуудлын хэтийн төлвийн талаар төсөөлөл өгөх зорилготой. Тийм учраас эдийн засаг бүрийн хүрээнд хариулагчид эдгээр асуудлаар хэр санал нэгтэй байгаа түвшинг анхаарч үзэх нь чухал. Энэ зорилгоор Бүдүүвч 2-т улс орон бүрээс Судалгааны тоон үзүүлэлтүүдийн хүснэгтийн хүрээнд тавигдсан асуулт бүрт өгсөн хариултын стандарт хазайлтыг дүрслэн


үзүүлснийг улс орнуудын хариултын дунджийг харуулсан баганын баруун талаас үзэж болно. Уг стандарт хазайлтууд нь асуулт бүрт улс орон бүрийн хариулагчдын дунд санал нэгтэй байсан түвшинг хэмжих бөгөөд хариулагчдын хэмжээгээр хүн бүрийн өгсөн хариулт хэр ойр эсвэл хол зөрж байгааг харуулна.

Бүдүүвч 2-т Бизнесийн удирдлагуудын санаа бодлын судалгааны жирийн нэг асуулт (8.23) буюу аудитын болон нягтлан бодох бүртгэлийн стандартын тухай асуултад өгсөн хариултуудын голч утга ба стандарт хазайлтуудын хамаарлыг графикаар дүрслэн харуулж байна. Энэ асуултад улс орон бүрийн авсан дундаж оноог бүдүүн баганаар дүрсэлсэн бол багана бүрийн баруун талд байгаа нарийхан хар зураасаар стандарт хазайлтын хэмжээг дүрсэлж байна. Бид энэ бүдүүвч зургийг тоон үзүүлэлтүүдийн хүснэгтэд орсон дарааллын дагуу буюу хамгийн сайн үнэлгээ бүхий хариултуудыг (хамгийн өндөр оноотой) дээд талд нь хамгийн бага үнэлгээтэй (хамгийн бага оноотой) хариултуудыг доод талд нь байрлуулсан. Бүдүүвч зурагт үзүүлсэнчлэн, хамгийн дээгүүр байр эзэлсэн (өндөр оноотой) орнууд харьцангуй бага стандарт хазайлттай байна. Эхний 10 хувьд орох дээгүүр байр эзэлсэн орнуудын хувьд стандарт хазайлт нь ерөнхийдөө 1-ээс нилээд доогуур байна. Энэ нь, хариулагчдын дунд санал нэгтэй байдлын түвшин харьцангуй өндөр буюу аудитын болон нягтлан бодох бүртгэлийн стандартууд тэдгээр улсад хүчтэй байгааг харуулж байна. Төсөөлж байсан ч байж магадгүй ёсоор, энэ асуултад доогуур байр эзэлсэн орнуудын хариулагчдын санал нэгтэй байдал доогуур байгаа нь нягтлан бодох бүртгэлийн стандартын чанар муудах тусам санал нэгтэй хариулт авахад хэцүү гэдгийг харуулж байна.



Голдуу Судалгааны үр дүнтэй холбогдон гардаг өөр нэг асуулт бол ерөнхийдөө Судалгаанд оролцогчид «ойлголтын хэлбийлт» гэгчид орж байгаа цар хүрээ юм. Өөрөөр хэлбэл, өгөгдсөн нэг орны бүх хариулагчдын дунд системтэй эерэг эсвэл сөрөг хэлбийлт байна гэсэн үг. Тухайлбал, тодорхой нэг улс орны хүмүүс өөрсдийн эдийн засгийн орчны талаар өөр бусад орны хүмүүстэй харьцуулахад ерөнхийдөө илүү эерэг үзэл бодолтой байхад өөр орны хүмүүсийн хувьд илүү гутранги үзэлтэй байж болно. Хэрвээ яг ийм тохиолдол байх юм бол Судалгааны үр дүн бүхэлдээ илүү эерэг ерөнхий дүр төрхтэй улсад тааламжтай байдлаар хэлбийж болзошгүй байна.

Бүдүүвч 2: Бизнесийн удирдлагуудын санаа бодлын судалгааны жирийн нэг асуултын хувьд улс орнуудын хариултын дундаж ба стандарт хазайлтууд:

«Танай улсын компаниудын санхүүгийн байдалтай холбоотой санхүүгийн аудитын ба тайлагналын стандартууд ямар вэ? (1 = маш сул, 7 = маш хүчтэй буюу дэлхийн шилдэгт орно)»



Тайлбар: Бүүгүн багануудаар оноог, нарийн зураасаар стандарт хазайлтыг харуулж байна.

Бүдүүвч 3: Сүрьеэгийн талаарх тогтсон үзүүлэлт ба Судалгааны тоон үзүүлэлт**Бүдүүвч 4: Бизнесийнхний Интернет ашиглалтын тухай тогтсон үзүүлэлт ба Судалгааны тоон үзүүлэлтүүд**

Тодорхой хэмжээний хэлбийлт гарах нь зайлшгүй боловч бид хариулагчдаас өөрсдийн орчныг үндэснийхээ хэмжээнд бодож үнэлэх биш, дэлхийн стандарттай харьцуулж хариулахыг хүсэх байдлаар Судалгааны үг хэллэгүүдээ засч боловсруулан энэ хэлбийлтийг багасгах талаар ихээхэн хүчин чармайлт тавиад байна. Ойлголтын хэлбийлтийг шалгахад хэцүү байдаг ч ийм хэлбийлт оршин байгаа хүрээг хэмжих нэг арга бол Судалгааны тоон үзүүлэлтүүдийн үр дүнг түүнтэй адил төстэй тогтсон тоон үзүүлэлтүүдтэй харьцуулах явдал юм. Судалгааны ихэнх асуултуудын хувьд харьцуулж болохоор, голчлон чанарын шинжтэй тогтсон тоон үзүүлэлт байхгүй боловч илүү техникийн болон шинжлэх ухааны онцлогтой цөөн тооны асуултын хувьд ийм харьцуулалт хийх боломжтой. Бүдүүвч 3-т тогтсон тоон үзүүлэлтийн хувьсагч 4.12 ба Судалгааны асуулт 4.05 хоёрын харьцуулалтыг үзүүлж байна. Улс орон бүрийн сүрьеэ өвчний гаралтын тоог хэвтээ тэнхлэгт түлхүүр утга болгон харуулж, халдварт өвчнөөс бизнест үзүүлэх боломжит нөлөөний тухай асуултыг босоо тэнхлэгт харуулав.

Бүдүүвч зургаас үзэхэд энэ хоёр хувьсагчийн хоорондоо маш хүчтэй хамааралтай буюу уг өвчний тархалт их байх тусам бизнест учруулж болзошгүй зардлын дундаж илүү өндөр байна.

